

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ

ТӨСВИЙН БАРИМТ БИЧИГ

Улаанбаатар хот
2017 он



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.09.28 № 4-1/5880

танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.МӨНХБАТ ТАНАА

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон дагалдах хууль, тогтоомжийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу хуулийн төслүүдийн үзэл баримтлал, өргөн мэдүүлэх зөвшөөрөл болон холбогдох бусад материалын хамт хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-т заасны дагуу хуулийн төслийг өргөн мэдүүлж өгнө үү.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЧОЙЖИЛСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С. Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.09.28 № 4-1/5881
танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.МӨНХБАТ ТАНАА

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон дагалдах хууль, тогтоомжийн төслүүдийг холбогдох бусад материалын хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



В.ЧОЙЖИЛСҮРЭН



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2017.9.28 № 7-1/3650.
Танай 2017.9.24 ны № 7-1/3650 -Т

**САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЧОЙЖИЛСҮРЭН
ТАНАА**

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.8-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



С.БЯМБАЦОГТ

08 2364


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд:

“ҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙГ
ӨРГӨН МЭДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ТОВЬОЁГ**

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2019-2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
- 1.2. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- 1.3. Монгол улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

2. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

- 2.1. Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
- 2.2. Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөл
- 2.3. Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийн хавсралт
 - 2.3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт
 - 2.3.2. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
 - 2.3.3. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
 - 2.3.4. Концессын тухай хуулийн 4.1.2-т заасан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт
 - 2.3.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2018 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг

2.4. Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга


2.5. Монгол улсын 2018 оны төсвийн тухай хуулийг дагалдах хууль, тогтоомжийн өөрчлөлтүүд

3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

- 3.1. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
- 3.2. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн төсөл
- 3.3. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга
- 3.4. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийг дагалдах хууль, тогтоомжийн өөрчлөлтүүд

4. ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД

**1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2019-2020 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2019-2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

2018 оны төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу дараахь зарчмыг баримтална:

- 1/ нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх;
- 2/ нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2018 онд тухайн жилийн ДНБ-ий 9.5 хувиас илүүгүй байх;
- 3/ тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;
- 4/ Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь 2018 онд ДНБ-ий 80.0 хувиас хэтрэхгүй байх.

1.2. Практик шаардлага

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрэн сэргэж, нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалуудын үнэ харьцангуй өндөр түвшинд байгаа болон уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлтөөс үүдэн бизнесийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ онд төвлөрүүлэхээр төлөвлөсөн төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давахаар байна.

Олон улсын валютын сан болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээг 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 2-ны өдрийн

хооронд ажлын хэсгийн түвшинд хийсэн. Олон улсын валютын сангийн ажлын хэсгийн зүгээс хөтөлбөр сайн хэрэгжиж, бүх тоон зорилтууд хангагдсан болохыг мэдэгдсэн.

Давсан орлогын тодорхой хэсгийг нэг удаагийн шинж чанартай, ирэх жилүүдэд төсөвт ачаалал үүсгэхгүй байх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, болзошгүй өр төлбөрийг барагдуулах болон цаг үеийн нөхцөл байдал, үүссэн бодит хэрэгцээ, шаардлагыг харгалзан зайлшгүй нэмэгдүүлэх чиглэлээр төсвийн зарлагад зарим өөрчлөлтүүдийг тусган төсөвт тодотгол хийх талаар Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсон болно.

Хөтөлбөрийн эхний үнэлгээтэй холбоотойгоор дунд хугацааны макро эдийн засгийн тооцоолол, төсвийн орлого, зарлагын төсөөлөл зэрэг үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр байна. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тоон үзүүлэлтүүдийг хүснэгтээр батлах тухай гэсэн нэг зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн тохирсон зарим арга хэмжээ, 2017 оны төсөв батлагдсанаас хойш хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой болох юм. Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд хангагдана.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжид нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль, тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2019-2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл.	
		2018 он	2019 он	2020 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	4.0	6.6	4.6
2	Хэрэглээний үнийн индексийн түвшин	8.6	8.0	8.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,218.0	8,217.5	9,110.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	23.8	24.1	24.2
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	9,828.8	10,323.3	10,790.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.4	30.3	28.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	580.2	494.6	467.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.9	1.5	1.2
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,610.8	-2,105.8	-1,680.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-8.6	-6.2	-4.5
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	2,102.3	1,979.4	2,290.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	6.9	5.8	6.1
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	24,272.8	25,556.3	26,400.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	80.0	75.0	70.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	606.7	648.6	690.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	1.9	1.8

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2019-2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хууль Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн хуралдаанаар батлагдсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг **6,808.4 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **24.6 хувь**, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг **9,451.0 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **34.1 хувь**, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл **-2,642.6 тэрбум төгрөг**ийн алдагдалтай буюу ДНБ-ий **-9.5** хувьтай байхаар тусгагдсан.

Мөн 2017 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсөөллийн тухай хуулийг баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолд “Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” болон ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн эдийн засаг, санхүү, төсвийн бодлогын арга хэмжээний хүрээнд эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, төсвийн орлого нэмэгдэх нөхцөл байдал үүсэх тохиолдолд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсөөллийн тухай хуулиар батлагдсан үндсэн үзүүлэлтүүдийг 2018 оны төсвийн тухай хуулийг боловсруулах үед дахин авч үзэж, холбогдох өөрчлөлтийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд оруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай” гэж заасны дагуу холбогдох өөрчлөлтийг хуульд оруулахаар хуулийн төслийг боловсруулаад байна.

ОУВС болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээг 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 2-ны өдрийн хооронд ажлын хэсгийн түвшинд хийсэн. ОУВС-ийн ажлын хэсгийн зүгээс хөтөлбөр сайн хэрэгжиж, бүх тоон зорилтууд хангагдсан болохыг мэдэгдсэн.

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрэн сэргэж, нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалуудын үнэ харьцангуй өндөр түвшинд байгаа болон уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлтөөс үүдэн бизнесийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ онд төвлөрүүлэхээр төлөвлөсөн төсвийн давахаар байна.

Давсан орлогын тодорхой хэсгийг нэг удаагийн шинж чанартай, ирэх жилүүдэд төсөвт ачаалал үүсгэхгүй байх ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, болзошгүй өр төлбөрийг барагдуулах болон цаг үеийн нөхцөл байдал, үүссэн

бодит хэрэгцээ, шаардлагыг харгалзан зайлшгүй нэмэгдүүлэх чиглэлээр төсвийн зарлагад зарим өөрчлөлтүүдийг тусган төсөвт тодотгол хийх талаар ОУВС-ын хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсон болно.

Хөтөлбөрийн эхний үнэлгээ болон Монгол Улсын 2018 оны төсвийн төсөлтэй холбоотойгоор дунд хугацааны макро эдийн засгийн тооцоолол, төсвийн орлого, зарлагын төсөөлөл зэрэг үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдөхөөр байна. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

**2. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**



МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4-д санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх;” гэж, 8.4.5-д “Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн зүйлийн 8.4.8-д “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан төсвийн дараахь үзүүлэлтийг төсөвт тусгах зарчим баримтална:

- 1/ нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх;
- 2/ нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2018 онд тухайн жилийн ДНБ-ий 9.5 хувиас илүүгүй байх;
- 3/ тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;
- 4/ Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь 2018 онд ДНБ-ий 80.0 хувиас хэтрэхгүй байх.

1.2. Практик шаардлага

Эдийн засгийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд 2017 он гарсаар эдийн засгийн өсөлт эрчимжиж, эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрээд байна. Ирэх 2018 онд эдийн засаг өмнө тооцоноос илүүтэйгээр өсөж, нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалуудын үнэ харьцангуй өндөр түвшинд байхаар байгаа болон уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлтөөс үүдэн бизнесийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа

нэмэгдэхээр байгаатай холбоотойгоор төсвийн орлого төсвийн хүрээний мэдэгдэлд тооцсон хэмжээнээс нэмэгдэхээр байна.

Олон улсын валютын сан (ОУВС)-тай хамтран 2017 оны 5 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т төсвийн сахилга батыг сайжруулж, нэгдмэл байдлыг хангах, өрийн дарамтыг бууруулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг багасгах зорилго тавьсан. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг ОУВС-тай харилцан тохирч, улмаар 2018-2020 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүд (нийт орлого, зарлага, төсвийн тэнцэл, өрийн хэмжээ г.м)-ийг тогтоосон болно.

Монгол Улсын Засгийн газар болон ОУВС хооронд тохиролцсон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт тохирсны дагуу дараахь арга хэмжээг төсөвт тусгах шаардлагатай байна:

1/ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/ төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, статистик, хүн ам зүйн өөрчлөлтөөс шалтгаалан нэмэгдэх нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн зардлыг төсөвт тусгах, инфляц, валютын ханшны өөрчлөлтөөс нэмэгдэх бараа үйлчилгээний зардлыг төсөвт тусгах;

3/ шинэ хөрөнгө оруулалт болон үйлчилгээний цар хүрээ нь өргөжиж байгаа зарим салбарт нэмж шаардагдах урсгал зардлыг төсөвт тусгах;

4/ хууль тогтоомжийн биелэлтийг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хууль сахиулах, эдийн засгийг идэвхжүүлэх чиглэсэн зарим арга хэмжээнд шаардагдах зардлыг төсөвт тусгах;

5/ он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн санхүүжүүлэх;

6/ салбарын хэмжээнд хийгдэх их засварын ажлын болон тоног төхөөрөмжийн санхүүжилтийг тусгах, “Барих-шилжүүлэх” концессын гэрээгээр хэрэгжиж буй барилга угсралтын ажил дууссан төслүүдийн 2018 онд төлөгдөх эргэн төлөлтийн төлбөрийг тусгах;

7/ гадаадын зээл, тусламжийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашигтай төслүүдэд санхүүжилт хийх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор гаргах дотоод бондын хэмжээг бууруулах, гадаад бондын эргэн төлөлтийн хуваарийг жигдлэх, өрийн удирдлагын оновчтой арга хэрэгслийг хэрэгжүүлэх замаар хүүгийн зардлыг өмнөх оны түвшнээс бууруулах.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслөөр Монгол Улсын 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарлагын хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох

санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, төсвийн тогтворжуулалтын сан болон ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлттэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана.

Хуулийн төсөл 4 бүлэг, 23 зүйл, 5 хавсралттай байх бөгөөд дор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт: Монгол Улсын 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын доод хэмжээ, зарцуулах зарлагын дээд хэмжээг, мөн төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харьяа байгууллагууд, бусад байгууллагуудын төвлөрүүлэх орлогын хэмжээг, 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын хэмжээ, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн дүн, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2018 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, тус сангаас улсын төсөвт олгох шилжүүлэг болон улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээ, Засгийн газрын 2018 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээ, Засгийн газрын өрийн хязгаарт багтаан өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт зөвшөөрөх талаар;

Гуравдугаар бүлэгт: Орон нутгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээний талаар;

Дөрөвдүгээр бүлэгт: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар батлах тухай, улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хавсралтаар батлах тухай, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хавсралтаар батлах тухай, Концессын тухай хуулийн 4.1.2-т заасан төрийн өмчийн

концессын зүйлийн жагсаалтыг хавсралтаар батлах тухай, Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2018 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Түүнчлэн Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох тусгай шаардлагыг баримтлан, уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогыг төлөвлөхдөө төсвийн орлогод ихээхэн нөлөө үзүүлдэг гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг олон жилийн дундаж үнэ болох тэнцвэржүүлсэн үнээр тооцож, тэнцвэржүүлсэн үнээс давсан хэсгийг Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх болон төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр арга хэмжээг жигд санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зарчим баримтална.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар 2018 оны төсвийн жилд Засгийн газраас чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр бий болж, зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Монгол Улсын төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд төсөв, татварын орлогыг тогтвортой байлгах, төсвийн санхүүжилтийг найдвартай эх үүсвэрээр хангахын тулд 2018 оны төсвийн төсөлд улсын төсвийн орлогыг бодитой төлөвлөх, төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг бий болгох, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн дагуу төсвийн сахилга бат хяналтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, Ирээдүйн өв сангаас улсын төсөвт олгох шилжүүлэг болон улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Их Хурлын дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,684.9 2,684.9
2	Монгол Улсын Ерөнхий аудитор Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	87.6 87.6
3	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	60.0 60.0
4	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	822.4 822.4
5	Үндэсний статистикийн хорооны дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	24.4 24.4 0.0
6	Монгол Улсын Ерөнхий сайд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар үүнээс: Ирээдүйн өв санд Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	95,872.7 3,000.0 89,395.9 47,842.5 3,476.8
7	Улсын ерөнхий прокурор Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	300.2 300.2
8	Монгол Улсын Шадар сайд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Стандарт, хэмжил зүйн газар Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	12,129.7 2,600.0 2,734.6 2,006.0 4,789.1
9	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	407.7 265.2 142.5
10	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	10,274.9 9,979.4 295.5
11	Гадаад харилцааны сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	19,550.0 0.0 18,000.0 1,550.0
12	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Ирээдүйн өв санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,607,151.2 2,352,403.7 64,816.3 477,817.9 2,200,468.3 13,229.3 26,559.7 10,916.7 3,573.5
13	Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар	63,695.9 18,000.0 3,487.5

	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	20,600.7
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	625.5
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	5,481.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	15,500.8
14	Батлан хамгаалахын сайд	51,794.1
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	6,593.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	45,200.7
15	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	61,695.6
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	56,969.1
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,726.6
16	Зам, тээврийн хөгжлийн сайд	170,952.2
	Иргэний нисэхийн ерөнхий газар	167,672.8
	Зам, тээврийн хөгжлийн яам	209.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	920.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,150.0
17	Барилга, хот байгуулалтын сайд	2,158.4
	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	1,815.2
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	343.2
18	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	283,676.4
	Ашигт малтмал, газрын тосны газар	276,198.1
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	7,478.3
19	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	192,003.8
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	115,491.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,414.6
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	75,098.2
20	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	63,435.8
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	550.0
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	631.1
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	9,513.7
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	52,741.0
21	Эрүүл мэндийн сайд	239,438.9
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	201,802.1
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	8,269.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	29,367.3
22	Эрчим хүчний сайд	4,016.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	4,016.0

4 дүгээр зүйл. Монгол Улсын төсөвт 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 5,206,762.7 сая төгрөгөөр баталсугай.

5 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	5,226.3
	Урсгал зардал	4,455.6
	Хөрөнгийн зардал	770.7
2	Монгол Улсын Их Хурлын дарга	32,553.9
	Урсгал зардал	27,955.6
	Хөрөнгийн зардал	1,913.3
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	2,684.9
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	2,023.4
	Урсгал зардал	1,683.4
	Хөрөнгийн зардал	340.0
4	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	4,074.9
	Урсгал зардал	3,974.9
	Хөрөнгийн зардал	100.0
5	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	51,422.4
	Урсгал зардал	50,672.4
	Хөрөнгийн зардал	750.0
6	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	826.8
	Урсгал зардал	826.8
7	Улсын ерөнхий прокурор	28,839.8
	Урсгал зардал	28,377.6
	Хөрөнгийн зардал	162.0
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	300.2
8	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	2,027.7
	Урсгал зардал	2,027.7
9	Монгол Улсын Ерөнхий аудитор	11,187.6
	Урсгал зардал	10,600.0
	Хөрөнгийн зардал	500.0
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	87.6
10	Авлигатай тэмцэх газрын дарга	14,793.9
	Урсгал зардал	14,598.3

	Хөрөнгийн зардал	195.6
11	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	3,792.4
	Урсгал зардал	3,792.4
12	Төрийн албаны зөвлөлийн дарга	726.0
	Урсгал зардал	726.0
13	Үндэсний статистикийн хорооны дарга	9,392.3
	Урсгал зардал	9,367.9
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	24.4
14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	1,130.6
	Урсгал зардал	1,130.6
15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	644.3
	Урсгал зардал	644.3
16	Монгол Улсын Ерөнхий сайд	259,622.8
	Урсгал зардал	103,916.8
	Хөрөнгийн зардал	139,944.5
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	15,761.4
17	Монгол Улсын Шадар сайд	133,304.1
	Урсгал зардал	110,488.0
	Хөрөнгийн зардал	13,376.4
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	9,439.7
18	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	40,312.5
	Урсгал зардал	13,470.0
	Хөрөнгийн зардал	18,814.8
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	8,027.7
19	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	88,442.8
	Урсгал зардал	56,356.4
	Хөрөнгийн зардал	22,019.5
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	10,067.0
20	Гадаад харилцааны сайд	69,259.3
	Урсгал зардал	68,109.3
	Хөрөнгийн зардал	1,150.0
21	Сангийн сайд	7,694,935.8
	Урсгал зардал	1,617,899.4
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	140,360.0
	Хөрөнгийн зардал	50,676.7
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	212,020.5
	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт	5,414,170.3
22	Хууль зүй, дотоод хэргийн сайд	484,618.9
	Урсгал зардал	420,357.9
	Хөрөнгийн зардал	37,990.0
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	26,270.9
23	Зам, тээврийн хөгжлийн сайд	378,203.7
	Урсгал зардал	9,152.4
	Хөрөнгийн зардал	89,957.4
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	279,093.9
24	Батлан хамгаалахын сайд	225,618.9
	Урсгал зардал	221,719.4
	Хөрөнгийн зардал	3,899.5
25	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	1,617,678.1
	Урсгал зардал	1,128,765.1
	Үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	295,924.2
	Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	613,052.2
	Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	45,512.0
	Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг	12,847.9
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	97,126.9
	Хөрөнгийн зардал	255,499.7
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	136,286.4	
26	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	26,918.8
	Урсгал зардал	9,002.9
	Хөрөнгийн зардал	17,915.9
27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	239,656.8
	Урсгал зардал	114,666.4
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	30,578.7
	Хөрөнгийн зардал	53,991.0
28	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	40,420.7
	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,159,013.4
	Урсгал зардал	1,095,805.7
	Үүнээс: Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	6,250.0
	Хөрөнгийн зардал	14,660.0
Дотоод эх үүсвэрээс олгох зээл	22,900.0	
Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	25,647.8	
	Эрүүл мэндийн сайд	770,708.7

29	Урсгал зардал	621,683.9
	Үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	111,498.1
	Хөрөнгийн зардал	60,190.2
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	88,834.6
30	Эрчим хүчний сайд	184,058.5
	Урсгал зардал	19,470.1
	Хөрөнгийн зардал	40,701.9
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	123,886.4
31	Барилга, хот байгуулалтын сайд	138,022.5
	Урсгал зардал	14,739.4
	Үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг	10,306.2
	Хөрөнгийн зардал	81,519.5
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	41,763.6

6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2018 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 7,842,407.1 сая төгрөгөөр баталсугай.

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн дүнг 719,570.3 сая төгрөгөөр баталсугай.

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн дүнг 126,513.5 сая төгрөгөөр баталсугай.

9 дүгээр зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2018 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээг 64,816.3 сая төгрөгөөр баталсугай.

10 дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2018 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээг 525,660.4 сая төгрөгөөр баталсугай.

11 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн эх үүсвэрээс улсын төсөвт олгох шилжүүлгийн хэмжээг 100,000.0 сая төгрөгөөр баталсугай.

12 дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн эх үүсвэрээс улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээг 425,660.4 сая төгрөгөөр баталсугай.

13 дугаар зүйл. Засгийн газрын 2018 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээг 2,037,661.1 сая төгрөгөөр баталсугай.

14 дүгээр зүйл. Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3 дахь хэсэгт заасан Засгийн газрын өрийн хязгаарт багтаан өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ

15 дугаар зүйл. Монгол Улсын 2018 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	11,473.2
2	Баян-Өлгий	11,614.1
3	Баянхонгор	10,853.5
4	Говь-Алтай	8,135.9
5	Дорнод	1,008.8
6	Дундговь	5,298.6
7	Завхан	9,683.6
8	Өвөрхангай	9,736.0
9	Сүхбаатар	4,437.5
10	Сэлэнгэ	2,999.1
11	Төв	6,615.1
12	Увс	11,830.3
13	Ховд	7,848.3
14	Хөвсгөл	15,732.6
15	Хэнтий	8,706.4
Нийт дүн		125,973.2

16 дугаар зүйл. 2018 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Булган	1,058.7
2	Дорноговь	3,907.0
3	Өмнөговь	69,312.9
4	Дархан-Уул	2,360.4
5	Улаанбаатар	211,784.3
6	Орхон	17,020.0

7	Говьсүмбэр	375.2
Нийт дүн		305,818.5

17 дугаар зүйл. 2018 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	3,599.4
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	554.7
2	Баян-Өлгий	4,943.1
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	370.9
3	Баянхонгор	3,797.6
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	636.2
4	Булган	2,313.3
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	503.0
5	Говь-Алтай	3,401.0
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	488.2
6	Дорноговь	3,277.2
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	280.0
7	Дорнод	3,652.2
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	554.0
8	Дундговь	2,076.2
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	313.9
9	Завхан	3,472.9
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	320.8
10	Өвөрхангай	4,376.4
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	536.4
11	Өмнөговь	3,389.3
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	365.0
12	Сүхбаатар	2,667.4
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	500.4
13	Сэлэнгэ	3,840.5
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	473.8
14	Төв	3,213.4
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	593.5
15	Увс	4,229.8
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	464.1
16	Ховд	4,425.3
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	602.1
17	Хөвсгөл	5,458.0
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	921.8
18	Хэнтий	3,112.1
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	617.4
19	Дархан-Уул	2,934.6
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	737.6
20	Улаанбаатар	16,268.8
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	301.0
21	Орхон	3,506.6
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	423.7
22	Говь-Сүмбэр	644.9
	Үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	93.1
Нийт дүн		88,600.0

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл. "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаархи чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт"-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

19 дүгээр зүйл. "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

20 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

21 дүгээр зүйл. Концессын тухай хуулийн 4.1.2-т заасан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

22 дугаар зүйл. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2018 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэгийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

23 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2018 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ
ҮР ДҮНГИЙН ТАЛААРХИ ЧАНАРЫН БОЛОН ТОО
ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2018 оны зорилтот түвшин	
1	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА			
	1.1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа		
		1.1.1	Төрийн байгуулал, улс орны удирдлагын талаар Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүх эрх мэдлийн байгууллагуудтай хамтарч ажиллана	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
		1.1.2	Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах чиглэлд хэрэгжиж байгаа хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санаачилга гарган ажиллана	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
		1.1.3	Гадаад харилцаанд Монгол улсыг бүрэн эрхтэй төлөөлж, гадаад бодлого, олон улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
	1.1.4	Хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	
	1.2	Монгол Улсын Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын судалгаа, шинжилгээ		
1.2.1		Монгол хэлний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа эрхлэх	судалгааны тайлан гаргах	
2	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА			
	2.1	Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих		
		2.1.1	Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	120-оос доошгүй ажлын өдөр хуралдаж, батлах
		2.1.2	Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгах, холбогдох тайлан, мэдээллийг хэлэлцэх, сонсох	10-аас доошгүй удаа хяналт шалгалт хийх, 6-аас доошгүй удаа тайлан хэлэлцэх, 12-оос доошгүй удаа мэдээлэл сонсох
2.1.3	Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах	Бүрэн хангагдсан байх		
3	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА			
	3.1	Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих		
		3.1.1	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн барагдуулалт	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх
		3.1.2	Бага суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн маргаантай асуудал	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх
3.1.3	Дунд, Их суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн маргаантай асуудал	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх		

4	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ			
	4.1	Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа		
		4.1.1	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх эрүүгийн хэргийн тоо	671
		4.1.2	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх иргэний хэргийн тоо	1200
	4.1.3	Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх захиргааны хэргийн тоо	450	
5	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА			
	5.1	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах		
		5.1.1	Хуулийн хугацаанд шийдвэрлэх хэрэг /хувиар/	93.0
6	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА			
	6.1	Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих		
		6.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи илтгэл	1
		6.1.2	Хяналт, шалгалт, судалгаа, дүн шинжилгээ	Хяналт, шалгалт 10, судалгаа мониторинг 5, хууль тогтоомжийн дүн шинжилгээ, санал гаргах 20
		6.1.3	Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудлаар гаргасан гомдлыг шийдвэрлэх	700
		6.1.4	Хүний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх	Төлөөлөн нэхэмжлэл 3, шаардлага 20, зөвлөмж 20
6.1.5		Хүний эрх, эрх чөлөөний асуудлаар боловсрол дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа	200 цагийн сургалт, 3000 хүн	
7	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР			
	7.1	Прокурорын хяналт		
		7.1.1	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих /хувиар/	100.0
		7.1.2	Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих /хорих анги, цагдан хорих байрнуудын үйл ажиллагаанд хяналт тавих тоо/	6,845
7.1.3		Зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих /Улсын хэмжээнд шийдвэрлэсэн зөрчлийн тоо/	800000	
8	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА			
	8.1	Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах		
		8.1.1	Бодлогын зөвлөгөө /тоогоор/	80
8.1.2		Эрдэм шинжилгээ, судалгаа /тоогоор/	90	
9	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР			
	9.1	Төрийн аудитын үйлчилгээ		
		9.1.1	Санхүүгийн тайлангийн аудит /тоогоор/	4140
		9.1.2	Гүйцэтгэлийн аудит /тоогоор/	252
9.1.3		Нийцлийн аудит /тоогоор/	168	
10	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА			
	10.1	Авлигатай тэмцэх		
		10.1.1	Мэдүүлгийн бүрдүүлэлтэд хянагдсан хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тоо	3200
		10.1.2	Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааны тоо	6
		10.1.3	Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухай сургалтад хамрагдах хүний тоо /мянган хүн/	15.0
		10.1.4	Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа	1
		10.1.5	Хүүхдийн шударга байдлын судалгаа	1
10.1.6		Шударга байдлын үнэлгээ	1	

		10.1.7	“Шударга ёс” эмхэтгэл	2
		10.1.8	Иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь	96.0
		10.1.9	Авлигатай тэмцэх газарт хүлээн авсан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шинжилгээ	12
		10.1.10	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх багц ажил, арга хэмжээ	17
11	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА			
	11.1	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт		
		11.1.1	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах /шинээр боловсруулах хуулийн төсөл/	7
		11.1.2	Шинэ буюу шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудад нийцүүлэн банкнаас бусад санхүүгийн байгууллагад мөрдөх дүрэм журамд өөрчлөлт оруулах	183
		11.1.3	Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх /хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын тоо/	43
		11.1.4	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, санхүүгийн салбарын цахим мэдээллийн системийг шинэчлэх	1
12	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА			
	12.1	Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт		
		12.1.1	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах /хуулийн төслийн тоо/	15
		12.1.2	Салбар зөвлөлүүд шинэчлэн байгуулагдаж, сургалтад хамрагдан, чадавхижсан байх	50 салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдаж, сургалтад бүрэн хамрагдах
		12.1.3	Төрийн албан хаагчийн хүний нөөцийн удирдлагын шинэ программ боловсруулан нэвтрүүлэх, бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим тогтолцоо хэрэгжиж эхлэх	Цахим бүртгэлийн иж бүрэн программыг нэвтрүүлнэ
		12.1.4	Гүйцэтгэлийн үнэлгээний стандарт, дүрэм журам шинэчлэгдсэн, хяналт үнэлгээ хийгдсэн байна.	10-аас доошгүй дүрэм журам шинээр батлах, төрийн захиргааны төв байгууллагад шалган зааварлах, хяналт үнэлгээ хийнэ. /13 яам/
13	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА			
	13.1	Албан ёсны статистикийг хөгжүүлэх		
		13.1.1	Албан ёсны статистикийн мэдээллийн тайлангийн нэр төрөл	290
		13.1.2	Албан ёсны статистикийн мэдээлэл, тайлангийн тоо /мянгаар/	112.1
		13.1.3	Албан ёсны статистикийн мэдээлэл, тайлангийн тархаалт	45
		13.1.4	Шинэ болон шинэчлэн сайжруулсан аргачлал, ангилал, статистикийн мэдээллийн санд суурилж эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгааны тоо	20
		13.1.5	Нийгэм эдийн засгийн судалгаа	1
		13.1.6	Статистикийн тухай хуулийн дагуу улсын хэмжээнд хийх статистик судалгааны тоо	21
14	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА			
	14.1	Бүх шатны сонгууль зохион байгуулах		

		14.1.1	Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, заавар, маягт /тоогоор/	20
		14.1.2	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарын тоо	3
		14.1.3	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсөх хувь/	5.0
		14.1.4	Сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын тоо	10
		14.1.5	Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагаа, санал хураах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах /тоогоор/	5000
		14.1.6	Программ хангамжийн аюулгүй ажиллагааг хангах	бүрэн хамгаалагдсан байх
15	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД			
	15.1	Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт		
	15.1.1	Монгол Улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн төлөв байдлын талаархи лавлагаа бэлтгэн, зөвлөмж боловсруулж, Ерөнхий сайдыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллах		Тухай бүрд
	15.1.2	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн болон улсын хөрөнгө оруулалтын статистикийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх /хувиар/		100.0
	15.1.3	Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах /богино болон дунд хугацааны/		2-3
	15.1.4	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн цахим мэдээллийн нэгдсэн сан, аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх /хувиар/		100.0
	15.1.5	Хөгжлийн томоохон төслүүдийн санал, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг боловсруулах, саналыг нэгтгэн судалгааг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, баталгаажуулах, хянах, батлуулах		1
	15.1.6	Хөрөнгө оруулалтын бизнес форум зохион байгуулах /тоогоор/		5-8
	15.2	Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа		
	15.2.1	Дотоод үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянгаар/		240.4
	15.2.2	Гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянгаар/		209.3
	15.2.3	Хэвлэмэл бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх /хувиар/		3.0
	15.2.4	Хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх /хувиар/		5.0
	15.3	Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц хөтөлбөр		
	15.3.1	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /төрийн албан хаагчийн тоо, мянгаар/		11.0
	15.3.2	Монгол Улсын иргэн бүрт цахим гарын үсэг олгох /иргэний тоо, мянган хүн/		100.0
	15.3.3	Төрөөс цахим хэлбэрээр шинээр хүргэх үйлчилгээний тоо		17
	15.3.4	Шуудангийн хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх сумдын тоо		214
	15.3.5	Орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах сумдын тоо		5
	15.3.6	Алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх багийн тоо		20
	15.3.7	Алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернетийн үйлчилгээ хүргэх сумдын тоо		5
	15.3.8	Тоон телевизийн тасралтгүй байнгын ажиллагаа, хамрах хүрээг сайжруулах сумдын тоо		40
	15.3.9	Мэдээллийн сангаа шилжүүлэн байршуулах байгууллагын тоо		11
20	Эрдэнэцогт сум	28,182.0		28,182.0	
4	Булган		532,341.7	47,790.5	580,132.2
	1	Баян-Агт сум	32,821.5	3,853.0	36,674.5
	2	Баяннуур сум	18,546.5	2,858.4	21,404.9
	3	Бугат сум	20,566.9		20,566.9
	4	Булган сум	43,736.7	5,051.4	48,788.2
	5	Бүрэгхангай сум	26,833.1	3,210.3	30,043.4
	6	Гурванбулаг сум	31,318.7	3,641.3	34,960.1
	7	Дашинчилэн сум	28,469.4	3,462.1	31,931.5
	8	Могод сум	27,261.0	3,346.8	30,607.8
	9	Орхон сум	28,209.6		28,209.6
	10	Рашаант сум	32,377.5	3,772.2	36,149.7
	11	Сайхан сум	31,164.3		31,164.3
	12	Сэлэнгэ сум	38,486.3		38,486.3
	13	Тэшиг сум	60,079.7	6,714.9	66,794.6
	14	Хангал сум	34,900.8	3,572.0	38,472.8
	15	Хишиг-Өндөр сум	24,826.0	2,874.7	27,700.7
	16	Хутаг-Өндөр сум	52,743.5	5,433.4	58,177.0
5	Говь-Алтай		726,762.8	32,021.1	758,783.9
	1	Алтай сум	42,213.6	9,250.0	51,463.6
	2	Баян-уул сум	41,549.7		41,549.7
	3	Бигэр сум	25,803.5		25,803.5
	4	Бугат сум	45,392.6	3,500.0	48,892.6
	5	Дарив сум	29,978.3		29,978.3
	6	Дэлгэр сум	36,322.1		36,322.1
	7	Есөнбулаг сум	95,714.4	17,521.1	113,235.5
	8	Жаргалан сум	21,770.3	1,750.0	23,520.3
	9	Тайшир сум	16,136.6		16,136.6
	10	Тонхил сум	40,696.7		40,696.7
	11	Төгрөг сум	30,365.4		30,365.4
	12	Халиун сум	28,388.4		28,388.4
	13	Хөхморьт сум	41,477.6		41,477.6
	14	Цогт сум	69,583.4		69,583.4
	15	Цээл сум	33,329.2		33,329.2
	16	Чандмана сум	34,540.2		34,540.2

Д/д	Аймаг,	сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
	17	Шарга сум	24,908.4		24,908.4
	18	Эрдэнэ сум	68,592.5		68,592.5
		Дорноговь	706,813.7	104,554.5	811,368.2
6	1	Айраг сум	45,139.7	8,043.8	53,183.5
	2	Алтанширээ сум	23,397.3	5,426.5	28,823.8
	3	Даланжаргалан сум	32,896.5	6,662.5	39,559.1
	4	Дэлгэрэх сум	25,569.0	5,340.2	30,909.2
	5	Замын-Үүд сум	175,143.1	14,445.1	189,588.2
	6	Иххэт сум	28,587.1	4,401.4	32,988.5
	7	Мандах сум	40,319.1	9,206.7	49,525.8
	8	Өргөн сум	29,146.0	5,816.2	34,962.2
	9	Сайншанд сум	108,326.3	13,294.5	121,620.8
	10	Сайхандулаан сум	28,290.6		28,290.6
	11	Улаанбадрах сум	34,764.1	7,894.3	42,658.4
	12	Хатанбулаг сум	67,883.6	13,171.6	81,055.2
	13	Хөвсгөл сум	31,007.8	7,472.4	38,480.2
	14	Эрдэнэ сум	36,343.6	3,379.1	39,722.7
		Дорнод	817,966.9	28,202.0	846,168.9
7	1	Баяндун сум	54,076.2		54,076.2
	2	Баянтүмэн сум	27,755.7		27,755.7
	3	Баян-уул сум	71,622.3		71,622.3
	4	Булган сум	26,243.1		26,243.1
	5	Гурванзагал сум	25,284.2		25,284.2
	6	Дашбалбар сум	60,083.6		60,083.6
	7	Матад сум	74,615.9		74,615.9
	8	Сэргэлэн сум	23,048.2	2,721.1	25,769.2
	9	Халхгол сум	116,721.0		116,721.0
	10	Хөлөнбуйр сум	25,682.6		25,682.6
	11	Хэрлэн сум	186,830.8	19,897.7	206,728.5
	12	Цагаан-овоо сум	47,515.0		47,515.0
	13	Чойбалсан сум	37,965.6		37,965.6
	14	Чулуунхороот сум	40,522.8	5,583.2	46,106.0
		Дундговь	457,890.3	70,311.5	528,201.8
8	1	Адаацаг сум	30,033.6	4,468.3	34,501.9
	2	Баянжаргалан сум	18,130.5	3,727.0	21,857.5
	3	Говь-Угтаал сум	18,108.5		18,108.5
	4	Гурвансайхан сум	24,740.0		24,740.0
	5	Дэлгэрхангай сум	32,026.1	5,651.9	37,678.0
	6	Дэлгэрцогт сум	13,913.0	3,103.7	17,016.7
	7	Дэрэн сум	20,646.5	3,935.6	24,582.1
	8	Луус сум	16,907.7	3,892.0	20,799.6
	9	Өлзийт сум	47,442.8	8,709.6	56,152.4
	10	Өндөршил сум	25,621.8	4,858.6	30,480.4
	11	Сайнцагаан сум	65,793.4	12,899.0	78,692.3
	12	Сайхан-Овоо сум	35,407.0	5,412.1	40,819.1
	13	Хулд сум	28,608.9	5,486.3	34,095.2
	14	Цагаандэлгэр сум	16,684.5		16,684.5
	15	Эрдэнэдалай сум	63,826.0	8,167.6	71,993.6

Д/д	Аймаг,	сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
9	Завхан		770,952.4	20,166.2	791,118.6
	1	Алдархаан сум	34,440.6		34,440.6
	2	Асгат сум	11,605.0	1,840.5	13,445.6
	3	Баянтэс сум	35,116.5		35,116.5
	4	Баянхайрхан сум	26,982.9	2,919.5	29,902.5
	5	Дөрвөлжин сум	37,179.9		37,179.9
	6	Завханмандал сум	19,168.0	3,568.3	22,736.2
	7	Идэр сум	25,546.7	2,461.0	28,007.6
	8	Их-Уул сум	70,387.1		70,387.1
	9	Нөмрөг сум	24,012.3		24,012.3
	10	Отгон сум	36,356.9	3,643.7	40,000.6
	11	Сантмаргаз сум	23,615.8		23,615.8
	12	Сонгино сум	22,906.7		22,906.7
	13	Тосонцэнгэл сум	84,916.3		84,916.3
	14	Түдэвтэй сум	26,317.2		26,317.2
	15	Тэс сум	44,041.4	3,589.8	47,631.2
	16	Тэлмэн сум	34,423.0		34,423.0
	17	Ургамал сум	22,265.6		22,265.6
	18	Улиастай сум	68,656.3		68,656.3
	19	Цагаанхайрхан сум	14,297.1		14,297.1
	20	Цагаанчулуут сум	15,180.5	2,143.5	17,324.0
	21	Цэцэн-Уул сум	23,804.2		23,804.2
	22	Шилүүстэй сум	21,191.8		21,191.8
	23	Эрдэнэхайрхан сум	23,198.1		23,198.1
24	Яруу сум	25,342.3		25,342.3	
10	Өвөрхангай		1,026,934.5	33,674.8	1,060,609.3
	1	Арвайхээр сум	111,529.3	3,489.7	115,019.0
	2	Бат-Өлзий сум	70,068.1	5,884.8	75,952.9
	3	Баянгол сум	42,067.0	2,079.6	44,146.6
	4	Баян-өндөр сум	45,712.4		45,712.4
	5	Баруунбаян-Улаан сум	46,074.3	2,208.6	48,282.9
	6	Богд сум	107,520.0	4,128.7	111,648.6
	7	Бүрд сум	36,779.9	4,540.2	41,320.2
	8	Гучин-Ус сум	39,028.5	814.6	39,843.1
	9	Есөнзүйл сум	32,538.6	596.2	33,134.8
	10	Зүүнбаян-Улаан сум	34,287.7		34,287.7
	11	Нарийнтээл сум	42,723.1	4,821.8	47,544.9
	12	Өлзийт сум	24,961.7		24,961.7
	13	Сант сум	37,763.4	640.0	38,403.4
	14	Тарагт сум	32,632.2		32,632.2
	15	Төгрөг сум	45,621.0		45,621.0
	16	Уянга сум	69,574.6		69,574.6
	17	Хайрхандулаан сум	41,416.5	1,239.2	42,655.7
	18	Хархорин сум	114,870.9	1,787.5	116,658.4
19	Хужирт сум	51,765.3	1,443.9	53,209.2	
	Өмнөговь		724,998.2	137,331.5	862,329.7
	1	Баяндалай сум	29,476.9	6,118.0	35,594.9
	2	Баян-Овоо сум	31,124.8	7,268.6	38,393.4

Д/д	Аймаг,	сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт	
11	3	Булган сум	25,913.6	5,551.6	31,465.1	
	4	Гурвантэс сум	107,960.4	17,254.8	125,215.3	
	5	Даланзадгад сум	110,282.8	20,890.1	131,173.0	
	6	Мандал-Овоо сум	23,352.5	5,723.0	29,075.5	
	7	Манлай сум	46,076.7	9,594.9	55,671.6	
	8	Ноён сум	29,670.9	7,988.9	37,659.8	
	9	Номгон сум	46,222.2	9,121.0	55,343.2	
	10	Сэврэй сум	34,433.7	7,941.1	42,374.8	
	11	Ханбогд сум	101,397.5	14,135.2	115,532.7	
	12	Ханхонгор сум	23,768.5	4,677.8	28,446.4	
	13	Хүрмэн сум	26,723.1	5,642.6	32,365.6	
	14	Цогт-Овоо сум	23,875.4	5,588.7	29,464.1	
	15	Цогтцэций сум	64,719.0	9,835.2	74,554.2	
	12	Сүхбаатар		574,732.6	49,080.4	623,813.0
		1	Асгат сум	24,427.3		24,427.3
2		Баруун-Урт сум	78,143.2	9,869.8	88,013.0	
3		Баяндэлгэр сум	56,403.9	6,494.5	62,898.4	
4		Дарьганга сум	37,946.9	7,258.3	45,205.1	
5		Мөнххаан сум	47,985.9	5,759.4	53,745.2	
6		Наран сум	24,325.4	4,820.3	29,145.6	
7		Онгон сум	47,202.5		47,202.5	
8		Сүхбаатар сум	43,943.1		43,943.1	
9		Түвшинширээ сум	36,162.5		36,162.5	
10		Түмэнцогт сум	24,996.7		24,996.7	
11		Уулбаян сум	28,747.9	3,926.7	32,674.6	
12		Халзан сум	17,785.1		17,785.1	
13	Эрдэнэцагаан сум	106,662.3	10,951.6	117,613.9		
13	Сэлэнгэ		894,616.2	31,109.5	925,725.7	
	1	Алтанбулаг сум	32,186.0	2,442.6	34,628.5	
	2	Баруунбүрэн сум	43,032.7	4,227.5	47,260.2	
	3	Баянгол сум	50,756.9		50,756.9	
	4	Ерөө сум	87,154.6		87,154.6	
	5	Жавхлант сум	17,137.5	1,690.0	18,827.4	
	6	Зүүнбүрэн сум	19,595.0	1,693.7	21,288.7	
	7	Мандал сум	248,047.5		248,047.5	
	8	Орхон сум	24,681.4	2,868.6	27,550.0	
	9	Орхонтуул сум	49,388.2	4,606.7	53,994.9	
	10	Сайхан сум	69,734.6		69,734.6	
	11	Сант сум	23,393.4	2,961.7	26,355.1	
	12	Сүхбаатар сум	76,283.6		76,283.6	
	13	Түшиг сум	26,739.3	2,910.3	29,649.6	
	14	Хушаат сум	22,748.6	2,286.8	25,035.4	
	15	Хүдэр сум	34,488.0		34,488.0	
	16	Цагааннуур сум	49,551.5	3,884.6	53,436.1	
17	Шаамар сум	19,697.5	1,537.0	21,234.4		
	Төв		756,996.0	37,248.4	794,244.4	
	1	Алтанбулаг сум	30,473.6		30,473.6	
	2	Аргалант сум	13,530.3		13,530.3	

Д/д	Аймаг,	сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт	
14	3	Архуст сум	9,537.5	1,392.1	10,929.6	
	4	Батсүмбэр сум	47,098.4	3,950.4	51,048.8	
	5	Баян сум	19,192.6		19,192.6	
	6	Баяндэлгэр сум	14,211.3	1,835.6	16,046.9	
	7	Баянжаргалан сум	16,938.6		16,938.6	
	8	Баян-Өнжүүл сум	27,032.4	3,070.2	30,102.6	
	9	Баянхангай сум	12,495.3		12,495.3	
	10	Баянцагаан сум	29,919.4	3,403.4	33,322.8	
	11	Баянцогт сум	15,674.7	1,956.6	17,631.3	
	12	Баянчандмань сум	24,368.6		24,368.6	
	13	Борнуур сум	35,217.1		35,217.1	
	14	Бүрэн сум	32,916.9	3,429.2	36,346.2	
	15	Дэлгэрхаан сум	20,235.9		20,235.9	
	16	Жаргалант сум	48,682.5		48,682.5	
	17	Заамар сум	51,205.5		51,205.5	
	18	Зуунмод сум	54,648.1		54,648.1	
	19	Лүн сум	24,906.9	2,762.4	27,669.3	
	20	Мөнгөнморьт сум	34,839.8	4,039.1	38,878.9	
	21	Өндөрширээт сум	23,352.9		23,352.9	
	22	Сүмбэр сум	15,218.8		15,218.8	
	23	Сэргэлэн сум	18,383.6	1,966.1	20,349.7	
	24	Угтаалцайдам сум	24,007.4	2,635.2	26,642.6	
	25	Цээл сум	24,231.8	2,749.3	26,981.1	
	26	Эрдэнэ сум	43,112.5		43,112.5	
	27	Эрдэнэсант сум	45,563.3	4,058.8	49,622.1	
		Увс		927,049.0	17,472.4	944,521.4
	15	1	Баруунтуруун сум	44,973.6		44,973.6
2		Бөхмөрөн сум	39,196.3		39,196.3	
3		Давст сум	40,604.5		40,604.5	
4		Завхан сум	46,597.5		46,597.5	
5		Зүүнговь сум	42,857.9		42,857.9	
6		Зүүнхангай сум	51,352.8		51,352.8	
7		Малчин сум	36,871.9	3,154.7	40,026.6	
8		Наранбулаг сум	53,757.2		53,757.2	
9		Өлгий сум	30,172.3		30,172.3	
10		Өмнөговь сум	51,889.1	3,732.5	55,621.7	
11		Өндөрхангай сум	68,236.1		68,236.1	
12		Сагил сум	31,460.2		31,460.2	
13		Тариалан сум	37,377.8	3,021.5	40,399.3	
14		Түргэн сум	21,942.7		21,942.7	
15		Тэс сум	67,434.7		67,434.7	
16		Улаангом сум	140,102.0		140,102.0	
17		Ховд сум	39,224.1		39,224.1	
18		Хяргас сум	40,440.5	3,500.8	43,941.3	
19		Цагаанхайрхан сум	42,557.7	4,062.8	46,620.5	
	Ховд		978,607.1	16,846.9	995,454.0	
	1	Алтай сум	91,807.1		91,807.1	
	2	Булган сум	186,052.0		186,052.0	

Д/д	Аймаг,	сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт	
16	3	Буянт сум	32,781.3		32,781.3	
	4	Дарви сум	50,567.7		50,567.7	
	5	Дуут сум	21,613.9		21,613.9	
	6	Дөргөн сум	38,002.7	3,209.2	41,211.9	
	7	Зэрэг сум	35,546.1	3,324.5	38,870.6	
	8	Манхан сум	45,440.8		45,440.8	
	9	Мянгад сум	33,473.1		33,473.1	
	10	Мөст сум	44,161.4		44,161.4	
	11	Мөнххайрхан сум	29,359.5		29,359.5	
	12	Үенч сум	86,136.0		86,136.0	
	13	Ховд сум	29,806.0		29,806.0	
	14	Цэцэг сум	46,027.6		46,027.6	
	15	Чандмань сум	48,986.3		48,986.3	
	16	Эрдэнэбүрэн сум	25,420.5		25,420.5	
	17	Жаргалант сум	133,425.1	10,313.3	143,738.3	
	17	Хөвсгөл		1,243,972.2	45,110.0	1,289,082.2
		1	Алаг-Эрдэнэ сум	52,643.8		52,643.8
2		Арбулаг сум	36,543.7		36,543.7	
3		Баянзүрх сум	45,997.9		45,997.9	
4		Бүрэнтогтох сум	36,818.9	2,006.2	38,825.1	
5		Галт сум	59,300.7	2,915.1	62,215.8	
6		Жаргалант сум	57,028.2	2,775.5	59,803.7	
7		Их-Уул сум	36,117.7	1,976.6	38,094.3	
8		Рашаант сум	38,109.7	2,170.6	40,280.3	
9		Рэнчинлхүмбэ сум	85,389.7	4,338.1	89,727.8	
10		Тариалан сум	62,773.3	2,974.9	65,748.2	
11		Тосонцэнгэл сум	31,496.7	1,713.8	33,210.6	
12		Төмөрбулаг сум	34,632.9	1,878.1	36,511.0	
13		Түнэл сум	34,454.7		34,454.7	
14		Улаан-Уул сум	75,554.5		75,554.5	
15		Ханх сум	52,796.7		52,796.7	
16		Цагаан-Уул сум	64,959.5	3,246.3	68,205.8	
17		Цагааннуур сум	41,602.2		41,602.2	
18		Цагаан-Үүр сум	55,320.8	3,425.8	58,746.7	
19		Цэцэрлэг сум	72,546.2		72,546.2	
20		Чандмань-Өндөр сум	40,717.2	2,442.2	43,159.4	
21		Шинэ-Идэр сум	33,023.1	1,982.9	35,006.0	
22		Эрдэнэбулган сум	47,825.3	3,064.8	50,890.1	
23		Мөрөн сум	148,318.8	8,199.0	156,517.8	
	Хэнтий		703,211.8	53,718.8	756,930.6	
	1	Батноров сум	50,685.5		50,685.5	
	2	Батширээт сум	40,510.9	4,887.5	45,398.4	
	3	Баян-Адрага сум	28,695.9	3,481.3	32,177.1	
	4	Баянмөнх сум	17,954.1	2,400.0	20,354.1	
	5	Баян-Овоо сум	22,071.6	2,987.5	25,059.1	
	6	Баянхутаг сум	26,370.1	2,850.0	29,220.1	
	7	Биндэр сум	50,858.3	5,031.3	55,889.6	
	8	Бор-Өндөр сум	80,802.5		80,802.5	

Д/д	Аймаг,	сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
18	9	Галшар сум	34,603.9	4,131.3	38,735.1
	10	Дадал сум	45,450.7	5,175.0	50,625.7
	11	Дархан сум	26,553.4	3,412.5	29,965.9
	12	Дэлгэрхаан сум	24,573.5	3,350.0	27,923.5
	13	Жаргалтхаан сум	21,614.9	2,650.0	24,264.9
	14	Мөрөн сум	14,581.6		14,581.6
	15	Норовлин сум	36,999.6		36,999.6
	16	Өмнөдэлгэр сум	67,158.8		67,158.8
	17	Хэрлэн сум	90,231.8	10,275.0	100,506.8
	18	Цэнхэрмандал сум	23,494.9	3,087.5	26,582.4
	Дархан-Уул		710,155.0	8,884.6	719,039.6
19	1	Дархан сум	240,810.5	3,012.7	243,823.2
	2	Орхон сум	74,612.7	1,353.1	75,965.8
	3	Хонгор сум	213,583.7	2,678.7	216,262.4
	4	Шарын Гол сум	181,148.2	1,840.0	182,988.2
	Орхон		824,853.4	49,067.8	873,921.2
20	1	Баян-Өндөр сум	390,514.8	23,230.4	413,745.2
	2	Жаргалант сум	434,338.6	25,837.4	460,176.0
	Говьсүмбэр		140,458.6	60,750.3	201,208.9
21	1	Баянтал сум	19,510.9		19,510.9
	2	Сүмбэр сум	69,632.7	43,922.1	113,554.8
	3	Шивээговь сум	51,315.0	16,828.2	68,143.1
	НИЙТ		16,262,999.9	903,680.3	17,166,680.2

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

2017 он

МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

АГУУЛГА

- 1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ**
 - 1.1 Дэлхийн эдийн засаг.....
 - 1.2 Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага
 - 1.3 Макро эдийн засгийн 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл
 - 1.4 Макро эдийн засгийн 2018 оны хандлага, 2019-2020 оны төсөөлөл
- 2. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ**
 - 2.1. Монгол улсын 2017 оны нэгдсэн төсвийн 8 дугаар сарын орлогын гүйцэтгэл
 - 2.2. Монгол улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлого, хүлээгдэж буй гүйцэтгэл
 - 2.3. Төсвийн зарлага.....
 - 2.4. Монгол улсын 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаар
- 3. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСӨВТ БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ОНЦЛОГ, НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**
 - 3.1 2018 оны төсвийн онцлог.....
 - 3.2 Төсвийн тусгай шаардлага
 - 3.3 Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- 4. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН**
 - 4.1. Төсвийн орлогыг төлөвлөхөд баримталсан зарчим
 - 4.2. Эдийн засаг дахь татварын ачаалал.....
 - 4.3. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого
 - 4.4. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого
 - 4.5. Уул уурхайн салбарын орлого
 - 4.6. Татварын орлого
 - 4.7. Татварын бус орлого
 - 4.8. Тусламжийн орлого
 - 4.9. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт
 - 4.10. Монгол Улсын 2017 оны төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэл
- 5. ТӨСВИЙН ЗАРДАЛ**
 - 5.1 2018 оны нэгдсэн төсвийн зарлага.....
 - 5.2 Төсвийн урсгал зарлага.....
- 6. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ**
 - 6.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, цаашдын төсөөлөл
 - 6.2. Монгол улсын 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтад баримталж буй бодлого
 - 6.3. Салбарын хөрөнгө оруулалт
- 7. ТУСГАЙ САНГУУД**

- 7.1. Засгийн газрын тусгай сангууд
- 8. ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН БОЛОН ИРЭЭДҮЙН ӨВ САН**
 - 8.1. Тогтворжуулалтын сан
 - 8.2. Ирээдүйн өв сан
- 9. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ**
 - 9.1. Нийгмийн даатгалын сангийн орлого
 - 9.2. Нийгмийн даатгалын сангийн зарлага
- 10. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТУХАЙ**
- 11. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР САНХҮҮЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД**
 - 11.1. Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаар ерөнхий танилцуулга
 - 11.2. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй болон шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй танилцуулга
- 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА**
 - 12.1. Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2018-2020 оны төсөөллийн талаар
 - 12.2. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээл
 - 12.3. Засгийн газрын өрийн баталгаа
- 13. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨСВИЙН ТЭНЦЭЛ**
- 14. ТӨСВИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ӨӨРЧЛӨЛТҮҮД**
.....

1. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2019-2020 ОНЫ ТӨСӨӨЛЛИЙН ТАНИЛЦУУЛГА: МАКРО ЭДИЙН ЗАСАГ

1.1. Дэлхийн эдийн засаг

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2017 онд сэргэж эхлээд байна. Энэ нь Канад, Франц, Герман, Итали, Испани зэрэг өндөр хөгжилтэй орнуудаас гадна хөгжиж байгаа томоохон эдийн засагтай орнууд болох Бразил, БНХАУ, Мексик зэрэг орнуудын эдийн засагт эерэг өөрчлөлт гарч байгаатай холбоотой байна.

Хүснэгт № 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт

	2012	2013	2014	2015	2016	2017*	2018**
Дэлхий	3.4	3.3	3.4	3.4	3.2	3.5	3.6
Өндөр хөгжилтэй орнууд	1.2	1.4	1.8	2.1	1.7	2	1.9
АНУ	2.3	2.2	2.4	2.6	1.6	2.1	2.1
Евро бүс	-0.8	-0.5	0.9	2	1.8	1.9	1.7
Япон	1.8	1.6	-0.1	1.1	1	1.3	0.6
Хөгжиж буй орнууд	5.2	5.0	4.6	4.3	4.3	4.6	4.8
Хөгжиж байгаа азийн орон	6.8	7.0	6.8	6.8	6.4	6.5	6.5
ОХУ	3.4	1.3	0.6	-2.8	-0.2	1.4	1.4
БНХАУ	7.8	7.8	7.4	6.9	6.7	6.7	6.4

Эх үүсвэр: ОУВС-гийн 2017 оны 7 дугаар сард нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төсөөлөл” тайлан.

Дэлхийн эдийн засаг 2016 онд 3.2 хувиар өсөж байсан бол 2017 онд өсөлт нэмэгдэж 3.5 хувь, 2018 онд 3.6 хувьд хүрэхээр байна гэж ОУВС-гийн 2017 оны 7 дугаар сард гаргасан төсөөлөлд дурджээ.

АНУ-ын эдийн засгийн өсөлтийг 2018 онд 2.1 хувь байна гэж ОУВС төсөөлж байна. Энэ оны эхний улиралд тус улсын эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас доогуур гарсан ч АНУ-ын ажилгүйдлийн хэмжээ зорилтот түвшинд хүрч буурсан, инфляц нам, тогтвортой түвшинд байгаа зэрэг нь АНУ-ын эдийн засаг сэргэснийг харуулна. Харин тус улсын ерөнхийлөгч Дональд Трампын зарласан төсвийн тэлэх бодлогын хэрэгжилт төсөөлж байснаас сул байгаа тул 2018 онд АНУ-ын эдийн засгийн өсөлт 2.1 хувь байна гэж шинжээчид таамаглаж байна.

АНУ-ын Засгийн газрын баримталж байгаа эдийн засгийн бодлогууд нь дэлхийн эдийн засгийн сэргэлт, түүхий эдийн үнэ ханшид чухал нөлөө үзүүлэх юм. Тухайлбал, АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трампын хэрэгжүүлж буй ажлын байрыг олноор нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх бодлого нь уул уурхайн голлох түүхий эдийн үнэ өндөр хэвээр байхад эергээр нөлөөлөхөөр байна.

БНХАУ-ын тогтвортой өсөлтөд чиглэсэн бодлогын шинэчлэл үргэлжлэн хийгдэнэ. Тус улсын эдийн засгийн өсөлт 2016 онд удааширч 6.7 хувьд хүрч байсан бол дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, өрхийн хэрэглээ өсөж эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлсэн тул энэ оны эхний хагас жилд БНХАУ-ын эдийн засаг 6.9 хувиар өссөн байна. Цаашид аж үйлдвэрийн салбар дахь илүүдэл хүчин чадлыг багасгах, санхүүгийн

салбарын нөхцөлийг чангаруулах зэрэг бодлогын шинэчлэл хийж байгаатай холбоотойгоор 2018 онд эдийн засгийн өсөлт нь саарч, 6.4 хувьд хүрэх төлөвтэй байна.

Япон улс эдийн засгийн тэлэх бодлогоо хэвээр үргэлжлүүлнэ. Үл хөдлөх хөрөнгийн үнэ өндөр байгаагаас иргэдийн хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэж, хэрэглэх хандлага өссөн байна. Дотоодын хэрэглээ өссөнтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлт эрчимжиж, 2017 оны эхний хагас жилд дараалсан дөрвөн улирлаар тооцсон ДНБ-ий өсөлт 4 хувьд хүрчээ. Тус улсын эдийн засаг 2006 оноос хойш анх удаа 6 улирал дараалан эерэг өсөлттэй гарсан бол ажилгүйдлийн түвшин нь сүүлийн 25 жилийн түүхэнд хамгийн доод түвшинд хүрээд байна. Шинжээчид 2016 оны сүүлээс хэрэгжүүлж эхэлсэн өгөөжийн муруйгаар дамжуулан эдийн засгийг удирдах бодлого нь амжилттай хэрэгжиж байна гэж дүгнэж байна.

АНУ болон ЕХ-ны төв банкнууд эдийн засгаа дэмжих зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн тэлэх бодлогоосоо аажим “гарах” стратеги баримтлахаа илэрхийлээд байгаа бол Япон улсын хувьд эдийн засгийн тэлэх бодлогоо хэвээр үргэлжлүүлнэ гэдгээ зарлаад байна.

Евро бүсийн 2018 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 1.7 хувь болгож өсгөсөн байна. Эдийн засгийн өсөлтийн таамаглал нэмэгдсэн гол хүчин зүйл нь Франц, Герман, Итали, Испани зэрэг улсуудын 2017 оны эхний улирлын эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас өндөр гарсантай холбоотой юм.

Европын холбооны голлох орнуудын эдийн засгийн өсөлт тогтвортой байхаар төсөөлөгдсөн нь түүхий эдийн үнэ тогтвортой байх нэг чухал нөхцөл болж байна. Европын холбооноос гарах шийдвэртэй холбоотойгоор үүссэн тодорхой бус байдлууд нь Их Британи Улсын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг бууруулж байна. Хэрэв Их Британи улс Европын холбооноос гарвал тус бүсийн эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн зах зээл дэх голлох түүхий эдийн үнэ, ханшид сөргөөр нөлөөлж болзошгүй хэмээн олон улсын шинжээчид үзэж байна.

Энэтхэг улсын эдийн засаг 2018 онд 7.8 хувиар өсөхөөр байна. Бэлэн мөнгөний хомсдолоос үүдэлтэйгээр буураад байсан өрхийн хэрэглээ нь 2017 оноос эхлэн аажмаар сэргэж байна. ОУВС-гийн судалгаанаас үзвэл, дотоод эрэлт нэмэгдэж байгаа, дэлхийн зах зээл сэргэж байгаа зэргээс 2018 онд Энэтхэг улсын эдийн засгийн өсөлт нь нэмэгдэхээр байна.

1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс. Дэлхийн зэсийн нийт хэрэглээ 2016 онд 2.3 хувиар өссөн бол 2017-2018 онд 2.4 хувиар өснө гэж шинжээчид төсөөлж байна.

Хүснэгт № 2. Цэвэршүүлсэн зэсийн эрэлт, нийлүүлэлт, мян.тн

	2014	2015	2016	2017*	2018**
Үйлдвэрлэл	22,469.0	23,017.0	23,339.0	23,871.0	24,480.0
Хэрэглээ	22,747.0	22,879.0	23,411.0	23,968.0	24,555.0
Баланс	(278.0)	138.0	(72.0)	(97.0)	(75.0)

Эх үүсвэр: Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

**Хүлээгдэж буй гүйцэтгэл*

**Төсөөлөл

Зэсийн нийт хэрэглээний тэн хагасыг эзэлдэг БНХАУ-ын эрчим хүч, барилгын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтуудтай холбоотойгоор зэсийн эрэлт нэмэгдэхээр байгаа нь ийнхүү таамаглахад хүргэжээ.

Хүснэгт № 3. Дэлхийн зэсийн хэрэглээ, мян.тн

	2014	2015	2016	2017*	2018**
БНХАУ	11,303	11,353	11,642	12,166	12,482
Европын холбоо	3,228	3,338	3,357	3,391	3,435
АНУ	1,767	1,796	1,778	1,821	1,875
Япон	1,072	997	973	1,012	1,022
Өмнөд Солонгос	759	705	759	791	821
Латин Америк	571	622	680	712	733
Энэтхэг	434	491	499	524	562
Тайван	465	471	507	522	538
Бусад	3,147	3,106	3,216	3,029	3,087
Нийт	22,746	22,879	23,411	23,968	24,555
Өөрчлөлт	7.8%	0.6%	2.3%	2.4%	2.4%

Эх үүсвэр: Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

**Төсөөлөл

Хүснэгт № 4. Дэлхийн зэсийн нийлүүлэлт, мян.тн

	2014	2015	2016	2017*	2018**
Уурхайн үйлдвэрлэлт:					
Чили	5,750	5,764	5,552	5,363	5,428
Перу	1,380	1,705	2,366	2,503	2,741
БНХАУ	1,741	1,667	1,851	1,925	1,944
АНУ	1,383	1,410	1,431	1,359	1,361
Конго	996	1,039	1,024	1,024	1,073
Бусад	7,299	7,807	8,526	8,807	8,974
Цэвэршүүлсэн:					
БНХАУ	7,649	7,964	8,436	8,942	9,497
Европын холбоо	2,750	2,744	2,681	2,700	2,727
Чили	2,729	2,688	2,613	2,508	2,488
Япон	1,554	1,483	1,553	1,561	1,569
АНУ	1,095	1,141	1,221	1,197	1,197
Орос	894	876	876	885	876
Бусад	5,798	6,120	5,959	6,079	6,127
Нийт	22,469	23,016	23,339	23,872	24,481
Өөрчлөлт	6.6%	2.4%	1.4%	2.3%	2.6%

Эх үүсвэр: Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

**Төсөөлөл

Алт.

Дэлхийн хамгийн том алт олборлогч БНХАУ-ын Засгийн газраас алтны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үр ашиг багатай, жижиг уурхайнуудыг хаах шийдвэр гаргаад байгаа нь алтны нийлүүлэлтийн өсөлт саарахад хүргэж байна.

Хүснэгт № 5. Алтны эрэлт, нийлүүлэлт, тн

	2014	2015	2016	2017	2018
Нийлүүлэлт	4,404	4,251	4,563	4,563	4,620
Эрэлт	4,273	4,850	4,315	4,083	4,333
Баланс	131	(599)	248	480	287

Эх үүсвэр: Дэлхийн алтны зөвлөл (WGC), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

**Төсөөлөл

Төв банкнуудын худалдан авах алтны хэмжээ болон хөрөнгө оруулалтын сангаар арилжигддаг алтны хэмжээ өсөх төлөвтэй байгаа, мөн алт, үнэт эдлэлийн худалдан авалт өсөхөөр байгаа нь 2018 онд алтны нийт эрэлтийг 6.1 хувиар өсгөхөөр байна. Нөгөө талаар дэлхийн улс төрд тодорхой бус байдлууд нэмэгдэж байгаагаас хөрөнгө оруулагчид алтанд хөрөнгөө байршуулах сонирхол нэмэгдэж байна.

Хүснэгт № 6. Алтны хэрэглээ, тн

	2014	2015	2016	2017*	2018**
Үнэт эдлэлийн эрэлт	2,486	2,400	2,040	2,111	2,132
БНХАУ	807	753	629	633	640
Энэтхэг	628	662	505	580	595
АНУ	117	120	119	118	115
Саудын араб	68	70	49	58	60
Арабын Нэгдсэн Эмират	56	51	41	38	42
Турк	68	49	43	45	46
Орос	67	38	34	35	36
Индонези	37	39	38	38	38
Итали	20	19	19	19	19
Япон	16	17	17	17	16
Төв банкуудын худалдан авалт	584	1,181	377	300	400
Цэвэр жижиглэнгийн хөрөнгө оруулалт	1,039	1,066	1,042	1,060	1,050
Алтны хөрөнгө оруулалтын сан	(184)	(128)	532	300	450
Аж үйлдвэрийн болон шүдний	348	332	323	312	301
Нийт	4,273	4,850	4,315	4,083	4,333
Өөрчлөлт %	-3.7%	13.5%	-11.0%	-5.4%	6.1%

Эх үүсвэр: Дэлхийн алтны зөвлөл (WGC), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

**Төсөөлөл

Нүүрс.

Дэлхийн дийлэнх орнууд уурын амьсгалын өөрчлөлттэй тэмцэх Парисын хэлэлцээрт нэгдэн орж байгаа бөгөөд энэ нь цаашид дэлхийн нүүрсний хэрэглээ бууруулах хандлагатай байна.

Манай нүүрсний гол худалдан авагч БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 2017-2018 онд бага зэрэг буурахаар байна. БНХАУ агаарын бохирдолтой тэмцэх зорилгоор хүнд үйлдвэрүүдийн үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээ авч эхлээд байгаа билээ. Тухайлбал, тус улсын Хүрээлэн буй орчныг хамгаалах яамнаас боловсруулсан төмөрлөгийн салбарт баримтлах бодлогод жил бүрийн 11 дүгээр сараас дараа оны 2 дугаар сар дуустал хугацаанд төмөрлөгийн үйлдвэрүүдийн гуравны нэгийг хааж байхаар тусгажээ. Мөн БНХАУ-ын таван бүс нутаг болох Тьянжин, Хэбэй, Шаньдун, Шаньси, Хэнань мужийн 28 хотын ган болоод хөнгөн цагаан боловсруулах үйлдвэрүүдийн 30 хувийг өвлийн улиралд түр зогсоохоор болсон нь төмөрлөгийн үйлдвэрлэлийн гол орц болох коксжих нүүрсний эрэлтийг аажим буурахад хүргэнэ гэж судлаачид үзэж байна.

БНХАУ 2017 оны 5 дугаар сард 32 мужид нүүрсээр ажилладаг станц шинээр барих зөвшөөрлийг цуцалсан бөгөөд 2020 он гэхэд нүүрс шатаах хүчин чадлынхаа хэмжээг ойролцоогоор 1000 гВт-аас хэтрүүлэхгүй байхаа зарлаад байна. Иймд БНХАУ-ын нүүрсний хэрэглээ цаашид буурч болзошгүй байна.

Хүснэгт № 7. Нүүрсний хэрэглээ, сая тн

	2014	2015	2016	2017*	2018**
БНХАУ	3,733	3,658	3,600	3,546	3,503
Энэтхэг	910	931	965	999	1,039

АНУ	835	727	664	672	674
ОХУ	226	237	224	229	233
ХБНГУ	237	234	224	217	213
Япон	189	190	190	188	187
Өмнөд Африк	188	175	178	182	187
Өмнөд Солонгос	132	133	127	130	133
Польш	135	134	134	134	134
Австрали	128	132	131	131	131
Бусад	1,100	1,057	1,051	1,059	1,070
Нийт	7,813	7,608	7,488	7,487	7,504
Өөрчлөлт %	0.0%	-2.6%	-1.6%	0.0%	0.2%

Эх үүсвэр: Эрчим хүчний мэдээллийн алба (EIA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)

*Хүлээгдэж буй гүйцэтгэл

**Төсөөлөл

БНХАУ-ын коксжих нүүрсний импортын хэмжээ 2017 оны эхний 7 сарын байдлаар 41.6 сая тн-д хүрсэн бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 32 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт № 8. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт, мян тонн.

	2012	2013	2014	2015	2016	2017 оны 1-7 сар
Австрали	13,949	30,178	31,278	25,870	26,819	18,241
Монгол*	19,060	15,441	14,787	12,680	23,562	16,170
Канад	7,246	11,087	7,204	5,711	5,188	2,329
Орос	4,798	8,441	5,760	3,228	2,620	2,637
Индонез	2,914	2,673	657	231	574	681
Америк	4,483	6,066	2,090	115		1,401
Бусад	1,160	1,535	664	287	544	119
Нийт	53,610	75,421	62,440	48,122	59,307	41,578

Эх үүсвэр: sxcoal.com

БНХАУ 2016 онд нийт 59.3 сая тн коксжих нүүрс импортлосон бөгөөд үүний 45 хувийг Австрали, 40 хувийг Монгол, 9 хувийг Канад, 4 хувийг Орос, 1 хувийг Индонез, 1 хувийг бусад улс орнуудаас тус тус импортлосон бол 2017 оны эхний 7 сарын байдлаар импортлосон 41.6 сая тн коксжих нүүрсний 44 хувийг Австрали, 39 хувийг Монгол, 6 хувийг Канад, 6 хувийг Орос, 2 хувийг Индонези, 3 хувийг бусад улс орноос импортлосон байна.

Хүснэгт № 9. БНХАУ-ын коксжих нүүрсний баланс /мян.тн/

	Хэрэглээ	Цэвэр импорт	Нийлүүлэлт	Илүүдэл/Хомсдол
2016	533,906.0	58,108.4	444,378.3	(31,419.3)
2017.1-8 сар	350,306.8	45,234.0	296,573.5	(8,499.3)

2017 оны эхний 8 сарын байдлаар нийт 350.3 сая тн коксжих нүүрсний хэрэглээ үүссэн бол үүний 341.8 сая тонны дотоодын олборлолт болон импортоор нийлүүлж 8.5 сая тн коксжих нүүрсний хомсдолтой байна.

Газрын тос.

АНУ-ын газрын тосны олборлолт тогтвортой өсөх төлөвтэй байгаа, Нигери, Ливи зэрэг улсуудын олборлолт өссөөр байгаа зэргээс газрын тосны олборлолт 2018 онд 1.8%-иар өсөж, өдөрт олборлох хэмжээ 99.7 сая баррельд хүрэхээр байна.

Хүснэгт № 10. Газрын тосны эрэлт, нийлүүлэлт, сая баррел/өдөр

	2014	2015	2016	2017*	2018**
Үйлдвэрлэл	93.8	96.6	97.0	97.9	99.7
Хэрэглээ	93.0	95.0	96.6	98.0	99.3
Баланс	0.8	1.6	0.4	-0.1	0.4

Эх үүсвэр: Олон улсын энергийн агентлаг (IEA), Эдийн засгийн тандалт судалгааны нэгж (EIU)


*Хүлээгдэж буй гүйцэтгэл

**Төсөөлөл

Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ.

2017 оны эхний хагас жилийн байдлаар БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өндөр гарсан болон дэлхийн эдийн засаг сэргэж байгаатай холбоотойгоор зэс, төмрийн хүдэр, цайр, хөнгөн цагаан зэрэг аж үйлдвэрийн голлох металлуудын үнэ өсөлттэй байлаа. Харин ОПЕК-ын орнууд газрын тосны нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн болон АНУ-ын газрын тосны олборлолт өссөнтэй холбоотойгоор газрын тосны үнэ бууралттай байв.

График № 1. Түүхий эдийн үнийн индекс



Эх үүсвэр. ОУВС

ОУВС-гийн гаргасан түүхий эдийн үнийн төсөөллөөс харахад зэсийн баяжмалын үнэ цаашид өсөх, төмрийн хүдэр, нүүрсний үнэ бага зэрэг буурах, газрын тосны үнэ тогтвортой түвшинд хадгалагдах төлөвтэй байна. Зэсийн үнэ цаашид өсөх хандлагатай байгаа нь Дэлхийн эдийн засгийн өсөлт нэмэгдэхээр байгаа болон нийлүүлэлтээс давсан эрэлт үүсээд байгаа зэрэгтэй холбоотой бол БНХАУ болон зарим хөгжингүй орнууд нүүрсний хэрэглээнээс татгалзах бодлого баримталж, хэрэглээгээ бууруулж байгаа нь нүүрсний үнэ 2018 онд буурах нөхцөл бүрдүүлж байна. Харин газрын тосны эрэлт, нийлүүлэлт тэнцвэртэй байх төлөвтэй байгаагаас үнэ нь харьцангуй тогтвортой байхаар байна.

Хүснэгт № 11. Түүхий эдийн үнийн төсөөлөл /жилийн дундаж үнэ/

Түүхий эд	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
	Гүйцэтгэл				Төсөөлөл			
Зэс, (ам.доллар/тн)	7,331.5	6,863.4	5,510.5	4,867.9	6030.2	6429.9	6461.5	6470.9
Чулуун нүүрс, (ам.доллар/тн)	176.86	150.67	123.54	138.36	180.1	170.1	158.8	150.5

Төмрийн хүдэр, (ам.доллар/тн)	135.4	97.4	56.1	58.6	71.7	62.0	57.1	54.6
Газрын тос*, (ам.доллар/бар)	104.1	96.2	50.8	42.8	50.3	50.2	50.5	51.1

Эх үүсвэр: ОУВС, 2017.09 сар

* UK, Brent, Dubai, West Texas газрын тосны дундаж спот үнэ

1.3. Макро эдийн засгийн 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл


1.3.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Эдийн засагт үүссэн хүндрэлүүдийг арилгах, төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах замаар эдийн засгийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд 2017 он гарсаар эдийн засгийн өсөлт эрчимжиж, эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрээд байна. Засгийн газрын хэрэгжүүлж байгаа бодлого болон Дэлхийн эдийн засагт гарч байгаа эерэг өөрчлөлтүүд нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлжээ.

ДНБ-ий эрэлт талаас авч үзвэл 2017 оны эхний хагас жилийн байдлаар экспортын өсөлтөөс гадна бодит хөрөнгө оруулалтын өсөлт 30 хувьд хүрсэн нь эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлөв. Дэлхийн эдийн засаг сэргэж, уул уурхайн бүтээгдэхүүний гадаад зах зээлийн эрэлт нэмэгдэж, түүхий эдийн үнэ өссөний зэрэгцээ хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлсэн зэрэг нь экспорт өсөхөд эергээр нөлөөлөв. Мөн уул уурхайн компаниуд олборлолт, тээвэрлэлтийн хүчин чадлаа нэмэгдүүлэхэд зориулж хөрөнгө оруулалт хийж байгаагаас энэ оны эхний 8 сарын байдлаар экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний экспортын орлого дөрөв дахин, төмрийн хүдрийн экспортын орлого 1.4 дахин нэмэгдээд байна.

Уул уурхайн салбарын дийлэнх бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж байгаа боловч Оюутолгойн зэсийн баяжмалын хэмжээ, түүнд агуулагдах алтны агууламж буурснаар уул уурхайн салбарын нэмэгдэл өртөг эхний хагас жилд 6.1 хувиар буурлаа. Экспорт болон хөрөнгө оруулалтын өсөлт нь импортыг дэмжиж, худалдаа, шууд бус татварын орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тээврийн салбарыг дэмжиж байна. Үүний үр дүнд уул уурхайн бус салбарын өсөлт эхний хагас жилийн байдлаар 9 орчим хувиар өсөөд байна. Түүнчлэн, барилгын салбар ихээхэн хэмжээний уналттай байгаа хэдий ч уналтын хурдац саарч байна.

График № 2. Салбаруудын өсөлт, хувиар



Эх сурвалж: ҮСХ, СЯ


Энэ оны сүүлийн хагаст эдийн засагт гарч байгаа эерэг өөрчлөлтүүд хадгалагдах бөгөөд 2016 оны сүүлчийн улирлын ДНБ-ий өндөр өсөлтөөс тооцож үзэхэд уул уурхайн бус ДНБ-ий хэмжээ 6.6 хувиар өсөж, эдийн засгийн бодит өсөлт 3.3 хувьд хүрэхээр хүлээгдэж байна. Харин зэсийн баяжмал болон газрын тосны үйлдвэрлэл буурч байгаатай холбогдуулан уул уурхайн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 7 хувиар буурахаар байна.

Түүнчлэн, энэ зун хур тунадас бага унаснаас үүдэн Ургацын урьдчилсан балансын дүнгээр хураан авах үр тарианы хэмжээ 2017 оныг өмнөх онтой харьцуулахад 40 орчим хувиар буурах буурах эрсдэлтэй байна. Эдгээр эдийн засгийн дотоод нөхцөл байдал болон экспортын гол нэр төрлийн барааны үнийн хандлагыг тооцож үзэхэд нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 2017 онд 27.4 их наяд төгрөгт хүрэхээр байна.

1.3.2. Төлбөрийн тэнцэл

Өмнөх жилүүдэд төлбөрийн тэнцлийн урсгал данс их хэмжээний алдагдалтай гарч үүнийг гадаад зах зээлээс санхүүжилт босгох замаар шийдвэрлэж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 4 дүгээр сард 500.0 сая ам.долларын бонд гаргасан, Кредит Свисс банкнаас 250.0 сая ам.долларын арилжааны зээл авснаар 2016 онд төлбөрийн тэнцэл 18.2 сая ам.долларын алдагдалтай болж буурсан.

График № 3. Монгол Улсын Төлбөрийн тэнцэл



ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсанаар манай улсад олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 тэрбум орчим ам.долларын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн бөгөөд эдгээр эх үүсвэрүүд нь төсвийн нөхцөл байдлыг сайжруулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад чиглэгдэж байна.

Хөтөлбөрийн хүрээнд Монголбанк Хятадын Ардын банк хооронд байгуулсан юанийн своп хэлцлийн хугацааг 3 жилээр сунгасан бөгөөд Засгийн газрын зүгээс 2017 онд төлөгдөх байсан Хөгжлийн банкны бондыг /580 сая ам.доллар/ 7 жилийн хугацаатай үнэт цаасаар солих ажиллагааг 2017 оны 3 дугаар сард амжилттай хийсэн ба 2017 оны 5 дугаар сарын

24-нд хөтөлбөр батлагдсанаар эхний санхүүжилт болох 38.4 сая ам.доллар, АХБ-ны 100 сая ам.доллар орж ирж гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлээд байна.

Түүнчлэн Худалдаа Хөгжлийн банкны 2014 онд олон улсын зах зээлд арилжаалсан 117.0 сая ам.долларын үнэт цаасны эргэн төлөлт төлөвлөгөөний дагуу 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хийгдсэн ба Энержи Ресурс ХХК-ний 2010 онд олон улсад арилжаалсан 600.0 сая ам.долларын үнэт цаасны /senior notes/ үндсэн төлөлт 2017 онд хийгдэх хуваарьтай байсан ба хувьцаа эзэмшигчид өрийн бүтцийг дахин шинэчлэх гэрээг хүлээн зөвшөөрсний дагуу өрийн бүтцийг амжилттай шинэчилж чадсан тул санхүүгийн дансанд учрах эрсдэлийг бууруулсан байна.

ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдсанаар хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, худалдааны нөхцөл мөн сайжирсны нөлөөгөөр 2017 онд төлбөрийн тэнцэлд хувийн хэвшлийн оролцоо өндөр байв.

2017 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар өсөж, 48.8 сая ам.долларын алдагдалтай гарсан. Данснуудаар авч үзвэл Урсгал данс 392.4 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс алдагдал 37.2 хувиар буурсан бол хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 50.4 хувиар буурч 346.5 сая ам.долларт хүрэв.


Урсгал тэнцлийн алдагдал ийнхүү буурахад экспорт /ф.о.б/ өмнөх оны мөн үеэс 30 хувиар, импорт /ф.о.б/ өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөний улмаас барааны дэд данс 49 хувийн өсөлттэй байв. Түүнчлэн аялал, жуулчлалын орлого өмнөх оны мөн үеэс 46 хувиар өсөж, санхүүгийн үйлчилгээний алдагдал өмнөх оны мөн үеэс 87 хувиар, бизнесийн бусад үйлчилгээний алдагдал 19 хувиар буурсан нь үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 20 хувиар буурахад голлон нөлөөлсөн байна.

Харин хөрөнгө ба санхүүгийн дансны хувьд эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 346.5 сая ам.долларын ашигтай гарсан байна. Тайлант хугацаанд Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 643.4 сая ам.долларт хүрсэн ба эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээний бусад үйл ажиллагаа дийлэнх хувийг бүрдүүлж байна.

1.3.3. Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2017 оны эхний 8 дугаар сарын байдлаар 6.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 33 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 64.5 хувиар өссөн байна.

График № 4. Гадаад худалдаа, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: УСХ

Энэ оны эхний 8 сарын байдлаар 4.1 тэрбум ам.долларын бараа, түүхий эд экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 37.1 хувиар өссөн байна. Экспортын өсөлтөд эрдэс бүтээгдэхүүний нэгж үнийн өсөлт болон чулуун нүүрсний биет хэмжээ 1.7 дахин, үнийн дүн 3.7 дахин, төмрийн хүдрийн үнийн дүн 41.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Импортоор 2.8 тэрбум ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 26.7 хувиар өссөн байна. Импортын өсөлтөд автобензин, дизелийн түлш, машин, механик тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашины өсөлт голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт № 12. Импортын бүтээгдэхүүн, төрлөөр /2016 оны гүйцэтгэл, 2017 оны ХБГ/

Төрөл	2016	2017*	Өсөлт
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,159	1,1328	15%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,152	1,697	47%
Аж үйлдвэрийн орц	508	438	-14%
Газрын тосны бүтээгдэхүүн	533	737	38%
Бусад	6	8	33%
Нийт	3,358	4,209	25%

Эх үүсвэр: СЯ, ОУВС

2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.3 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 1.8 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна.

Экспортын хэмжээ 2017 онд 23 хувиар өсөж, 6 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Харин Оюу Толгойн далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажил хийгдэхээр байгаа нь тоног төхөөрөмж, барилгын материал, машин тоног төхөөрөмжийн импортын хэмжээ

өсөхөд голлон нөлөөлөхөөр байгаа тул импортын хэмжээ 4.2 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Шигтгээ. Экспортыг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

1. Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлсэн нь экспортын өсөлтөд эергээр нөлөөлж байна. Үүнд:
2. Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч Гашуунсухайт-Ганц мод боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүллээ. Хүнд даацын автомашины хилээр орох гарах урсгалын тоог нэмэгдүүлж, хил нэвтрэх баримт бичиг шалгагчийн 14 кабиныг байгуулав.
3. Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн авто замын хөдөлгөөнийг бүр хаахгүйгээр хэсэгчлэн шуурхай засварлах чиглэлийг Засгийн газраас өгсний дагуу замын засвар, арчлалтын ажлыг амжилттай хийж байна. Засварын ажил 10 дугаар сард бүрэн дуусна. Мөн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай автозамыг говийн бүсийн экосистемийг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, автотээврийг сайжруулах зорилгоор 2017-2019 онд шинэчлэх юм.
4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 5 дугаар сард БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр хилийн зарим боомтын хүчин чадлыг нэмэгдүүлж олон улсын статустай болгох, Монгол Улс-БНХАУ хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, Махан бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх талаар ярилцсан.
5. ОХУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр мал эрүүлжүүлэх хоёрдох шатны төслийг хэрэгжүүлэхээр болов.
6. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” зорилтыг дэвшүүлж, энэ зорилтын хүрээнд Мах, сүүний анхдугаар аяныг улсын хэмжээнд зарлан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд Монгол Улсаас Иран улс руу хонины мах экспортолж эхэллээ. 2017 оны эхний 8 сарын байдлаар Иран улс руу 555.5 тн хонь, ямааны мах экспортлоод байна.
7. 2017 онд Монголын таван компани туршилтын журмаар 20 тонн ямааны мах БНСВУ-д нийлүүлэхээр болов. Туршилт амжилттай болбол 200 гаруй тоннд хүргэх боломжтой юм.

1.3.4. Инфляц

Улсын инфляцын түвшин 2014 онд 11.0 хувь байсан бол 2015 онд 1.9 хувь 2016 онд 1.1 хувь болж буурсан байна. Инфляцын түвшин буурч нам түвшинд хүрэхэд эдийн засгийн өсөлт саарч, дотоодын эрэлт хумигдсан нь голлон нөлөөлөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өсөхөд тээврийн бүлгийн үнэ 9.4 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 5.5 хувь, хүнс бараа, ундаа ус бүлгийн үнэ 6.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн ба инфляцын түвшин оны эцэст зорилтот түвшинд байхаар байна.

1.3.5. Мөнгөний салбарын үзүүлэлт

2017 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт мөнгөний нийлүүлэлт 14.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 27.6 хувь, өмнөх сараас 3.7 хувиар тус тус өссөн байна. Үүнд, төгрөгийн харилцах өмнөх онтой харьцуулахад 51.5 хувиар өссөн, төгрөгийн хадгаламж 34.0 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлөв.

2017 оны 8 дугаар сарын байдлаар нийт мөнгөний нийлүүлэлтийн 51.4 хувийг төгрөгийн хадгаламж, 16.6 хувийг гадаад валютын хадгаламж, 14.6 хувийг төгрөгийн харилцах, 12.9 хувийг гадаад валютын харилцах, үлдсэн 4.5 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө эзэлж байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.7 хувиар өсөж, 13.5 их наяд төгрөг боллоо. Нийт зээлийн өрийн үлдэгдлийг бүтцээр нь авч үзвэл хэвийн зээл 84.1 хувь, хугацаа хэтэрсэн зээл 7.1 хувь, чанаргүй зээл 8.8 хувийг тус тус бүрдүүлж байна.

1.4. Макро эдийн засгийн 2018 оны хандлага, 2019-2020 оны төсөөлөл

Монгол Улсын эдийн засагт сэргэлт гарч байгаа хэдий ч уул уурхайн бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэд түшиглэсэн өсөлт цаашид хэр удаан хадгалагдах болон тогтвортой үргэлжлэх эсэх нь тодорхойгүй байна. Гадаад зах зээл дэх тодорхой бус байдал, улсын нэгдсэн төсөв болон төлбөрийн тэнцлийн хос алдагдал, зээлийн үйлчилгээний төлбөрийн дарамт зэргээс шалтгаалан Монгол Улсын эдийн засаг эмзэг хэвээр байна. Цаашид төсөв болон эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлогыг үргэлжлүүлэх шаардлагатай байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” -ийн хүрээнд төсвийн сахилга батыг сайжруулж, нэгдмэл байдлыг хангах, өрийн дарамтыг бууруулж, төлбөрийн тэнцлийн алдагдлыг багасгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Хүснэгт № 13. ДНБ-ий хэмжээ болон өсөлт

	Гүйцэтгэл		Урьд	ХБГ	Төсөөлөл		
	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	22,227.0	23,150.4	23,935.8	27,438.0	30,341.0	34,075.0	37,715.0
ДНБ-ий бодит өсөлт (хувиар)	7.9	2.4	1.2	3.3	4.0	6.6	4.6
Уул уурхайн ДНБ-ий бодит өсөлт	19.4	14.1	0.2	-7.0	4.1	8.7	14.7
Уул уурхайн бус ДНБ-ий бодит өсөлт	5.0	-1.0	1.6	6.6	3.9	6	1.6

Эх үүсвэр: СЯ, ОУВС

Дунд хугацаанд эдийн засгийн өсөлт харьцангуй сэргэж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байна. Үүнээс гадна уул уурхайн томоохон төслүүдийн бүтээн байгуулалт 2018-2020 онд үргэлжлэн хэрэгжсэнээр уул уурхайн салбарын өсөлт 2018 онд 4.1 хувь, 2019 онд 8.7 хувь, 2020 онд 15 хувьд тус тус хүрэхээр төсөөлөгдөж байна. Уул уурхайн салбарын өсөлтийн нөлөөгөөр уул уурхайн бус ДНБ-ий хэмжээ 2018 онд 3.9 хувиар, 2019 онд 6.1 хувиар, 2020 онд 1.6 хувиар тус тус өсөхөөр байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд харьцангуй тогтвортой байх хандлагатай байгаа нь эрдэс бүтээгдэхүүний үнэ тогтвортой байх боломжийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч БНХАУ болон зарим хөгжингүй орнууд нүүрсний хэрэглээнээс татгалзаж, хэрэглээгээ бууруулах бодлого баримталж байгаа нь нүүрсний үнэ 2018-2020 онд 2017 оны түвшингээс буурч болзошгүй байна.

1.4.1. Төлбөрийн тэнцэл

ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд манай улсад олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 тэрбум орчим ам.долларын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн бөгөөд уг эх үүсвэрийг төсвийн нөхцөл байдлыг сайжруулахаас гадна төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад зарцуулна. Тус хөтөлбөрийг цаашид тууштай хэрэгжүүлж, макро эдийн засгийн эдийн засгийн орчноо тогтворжуулснаар, дунд хугацаанд төлбөрийн тэнцэл сайжирна гэж үзэж байна.

Дунд хугацаанд зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэхээр хүлээгдэж байгаа, түүнчлэн уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор импортын хэмжээ өсөхөөр байгаа нь урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлэхээр байна.

Гэсэн хэдий ч “Оюу Толгой” ХХК гүний уурхайн бүтээн байгуулалт, Тавантолгой зэрэг уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, хөрөнгө санхүүгийн дансны ашиг нэмэгдэхээр төсөөлж байна.

2018 онд хийгдэх Чингис бонд /500 сая ам.доллар/, Дим Сам бонд /1 тэрбум юань буюу 161.2 сая ам.доллар, 2019 онд Кредит Свиссээс авсан зээл /300 сая ам.доллар/ зэрэг зээлүүдийн үндсэн төлбөрийг төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө багатайгаар шийдвэрлэх шаардлагатай байна.

1.4.2. Гадаад худалдаа

Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ 2018 онд буурах хандлагатай байгаагаас нүүрсний экспортын орлого бага зэрэг буурахаар байна. Харин Оюутолгой ордын баяжмал дахь алтны агууламж нэмэгдэж нийт экспортын хэмжээ 2018 онд 2.4 хувиар өсөж 6.2 тэрбум ам.доллар болохоор байна. Харин уул уурхайн томоохон үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажил үргэлжлэн явагдахтай холбоотойгоор импортын хэмжээ өсөж, 2018 онд 4.6 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Хүснэгт № 14. Импортын бүтээгдэхүүн, төрлөөр /2018-2020 он/


Төрөл	2018 төс.	2019 төс.	2020 төс.
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,289	1,333	1,380
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	2,047	2,175	2,335
Аж үйлдвэрийн орц	454	471	482
Нефтийн бүтээгдэхүүн	782	825	847

Бусад	8	8	8
Нийт	4,580	4,812	5,053

Эх үүсвэр: СЯ, ОУВС

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 онд 10.8 тэрбум ам.долларт хүрэхээр байгаа бол гадаад худалдааны тэнцэл 1.6 тэрбум ам.доллар болохоор байна.

График № 5. Гадаад худалдаа, 2017 оны ХБГ, 2018-2020 оны төсөөлөл, сая ам.доллар



Эх үүсвэр: СЯ, ОУВС

* Хүлээгдэж буй гүйцэтгэл

** Төсөөлөл

1.4.3. Инфляци

ОУВС-тай хамтран баталсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хүрээнд төсөв, мөнгөний уялдаатай, зохистой бодлого хэрэгжүүлснээр макро эдийн засгийн үндсэн тэнцвэрүүд хангагдаж, инфляц зорилтот түвшинд хангагдахаар байна. Дунд хугацаанд эдийн засгийн өсөлт нэмэгдэж, цаашид хадгалагдахаар байгаа нь эрэлтийн гаралтай инфляцыг дэмжих, нөгөө талаар байгаль цаг уурын таагүй байдлаас үүдэлтэй нийлүүлэлтийн гаралтай эрсдэлүүд инфляцыг өсгөж болзошгүй байна. Эдгээр эрсдэлүүд байгаа хэдий ч Засгийн газар, Монголбанк төсөв, мөнгөний зохистой бодлого хэрэгжүүлэн инфляцыг нэг оронтой тоонд барихаар зорьж байна.

Учирч болзошгүй эрсдэл

Нэг. Дэлхийн эдийн засагт болон манай худалдааны гол түнш орон болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд учирч болох тодорхой бус хүчин зүйлүүд нь түүхий эдийн үнэ, экспортын бүтээгдэхүүний эрэлтээр дамжин Монгол Улсын эдийн засагт хүчтэй нөлөөлөх эрсдэл байсаар байна. Тухайлбал, томоохон эдийн засагтай ихэнх орнууд нүүрсний хэрэглээг бууруулах бодлого баримталж байгаа нь дунд хугацаанд манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний үнэ буурах, экспортын орлого төлөвлөсөн хэмжээнээс буурахад хүргэж болзошгүй эрсдэл байна. Нөгөө талаар, БНХАУ

хилийн боомтууд дээрх нүүрсний хяналт, шалгалт, тавигдах стандартаа дээшлүүлж байгаа нь нүүрсний экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Хоёр. 2018 онд Чингис бонд /500 сая ам.доллар/, Дим Сам бонд /1 тэрбум юань буюу 161.2 сая ам.доллар, 2019 онд Кредит Свиссээс авсан зээл /300 сая ам.доллар/ болон ММС-ийн давуу эрхт хувьцааны төлбөр /600 сая ам.доллар/ зэрэг зээлүүдийн үндсэн төлбөрийг хийхэд хүндрэл учирвал хөрөнгө оруулагчид болон санхүүгийн салбарт тодорхой бус байдал үүсэж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулж, улмаар төгрөгийн ханшид нөлөөлөх эрсдэлтэй байна.

Гурав. Зарим нутгаар 2017 оны зун хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас бага унасан нь мал аж ахуйн салбарын өвөлжилт болон газар тариалангийн гарцад сөргөөр нөлөөлж, 2017-2018 оны өвөл малын хорогдол өндөр байх, үр тарианы нийлүүлэлт, үнэд нөлөөлж болзошгүй байна.

2. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Монгол улсын 2017 оны нэгдсэн төсвийн 8 дугаар сарын орлогын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2017 оны эхний 8 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнээс 9.8 хувь буюу 433.9 тэрбум төгрөгөөр, тэнцвэржүүлсэн нийт орлого 9.3 хувь буюу 379.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Энэ нь жилийн нийт төлөвлөгөөний 75 орчим хувьтай тэнцэж байна.

Хүснэгт № 15. 2017 оны эхний 8 сарын төсвийн орлогын гүйцэтгэл

Үзүүлэлт	2016 он	2017 он			
	Өмнөх оны мөн үе	Жилийн төлөвлөгөө	Эхний 8 сарын төлөвлөгөө	Эхний 8 сарын гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,562.4	6,511.3	4,444.2	4,878.2	433.9
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	0.0	208.8	146.3	175.6	29.3
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0.0	266.8	210.2	235.4	25.1
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,562.4	6,035.7	4,087.7	4,467.2	379.5
Татварын орлого	3,119.4	5,049.6	3,321.1	3,883.1	562.1
Орлогын албан татвар	647.0	1,097.6	783.6	986.0	202.4
Нийгмийн даатгалын орлого	761.4	1,194.5	692.9	813.2	120.3
Хөрөнгийн албан татвар	68.1	98.6	75.0	80.7	5.7
Нэмэгдсэн өртгийн албан татвар	687.2	1,284.7	840.0	996.7	156.7
Онцгой албан татвар	426.6	490.8	320.9	295.6	-25.3
Тусгай зориулалтын орлого	6.7	11.9	7.1	7.2	0.1
Гадаад үйл ажиллагааны орлого	200.0	413.8	267.2	334.4	67.2
Бусад татвар, төлбөр, хураамж	322.4	457.7	334.3	369.3	35.1
Татварын бус орлого	443.1	986.2	766.7	584.0	-182.6
Нийтлэг татварын бус орлого	388.6	832.1	643.9	566.3	-77.5
Хөрөнгийн орлого	0.6	0.4	0.7	0.5	-0.2
Тусламжийн орлого	53.8	153.7	122.1	17.2	-104.8

2.2. Монгол улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлого, хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2017 оны 2 дахь тодотголоор 7,112.9 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан хэмжээнээс 601.5 тэрбум төгрөгөөр буюу 9.2 хувиар өсөхөөр байна.

Хүснэгт № 16. Төсвийн орлогын 2017 оны ХБГ

ҮЗҮҮЛЭЛТ	2016	2017		
	Гүйц	Төл	ХБГ	ЗӨРҮҮ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,835.0	6,511.3	7,112.9	601.5
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	0.0	208.8	242.4	33.6
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0.0	266.8	333.3	66.5
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,835.0	6,035.7	6,537.1	501.4
Татварын орлого	4,951.0	5,049.6	5,661.3	611.8
Орлогын албан татвар	1,043.4	1,097.6	1,330.8	233.2
Нийгмийн даатгалын орлого	1,109.8	1,194.5	1,248.5	54.0
Хөрөнгийн албан татвар	104.7	98.6	98.6	0.0

Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,140.7	1,284.7	1,448.5	163.8
Онцгой албан татвар	630.1	490.8	511.6	20.8
Тусгай зориулалтын орлого	10.8	11.9	11.9	0.1
Гадаад үйл ажиллагааны орлого	328.5	413.8	489.8	76.0
Бусад татвар (Төлбөр, хураамж)	583.1	457.7	521.6	63.9
Татварын бус орлого	884.1	986.2	875.8	-110.4
Нийтлэг бус татварын орлого	805.4	832.1	799.7	-32.4
Хөрөнгийн орлого	1.5	0.4	0.4	0.0
Тусламжийн орлого	77.2	153.7	75.7	-78.0

Энэ оны эцсээр татварын орлого 5,661.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 611.8 тэрбум төгрөг буюу 12.1 хувиар өсөх бол татварын бус орлого 986.2 тэрбум төгрөгөөс 875.8 тэрбум төгрөгт болж 110.4 тэрбум төгрөгөөр буюу 11.2 хувиар буурахаар байна. Харин эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс хамаарч Тогтворжуулалтын сангийн орлого батлагдсан хэмжээнээс 33.6 тэрбум төгрөгөөр, Ирээдүйн өв сангийн орлого 66.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

2.3. Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын эхний 8 сарын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2017 оны эхний 8 сарын байдлаар 6,279.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 5,044.8 тэрбум төгрөгийн буюу 80.3 хувийн, улсын төсвийн зарлага 4,752.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 4,021.1 тэрбум төгрөгийн буюу 84.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт № 17. Нэгдсэн төсвийн нийт зардлын эхний 8 сарын гүйцэтгэл, төсвийн бүрэлдэхүүнээр /тэрбум төгрөг/

	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	ОН-ын төсөв	НДС-ийн төсөв
Жилийн төлөвлөгөө	9,083.0	6,959.7	2,659.5	1,891.7
ӨО-ы мөн үе	5,371.4	4,014.1	1,399.7	1,112.6
Төлөвлөгөө	6,279.1	4,752.9	1,829.2	1,262.8
Гүйцэтгэл	5,044.8	4,021.1	1,350.0	1,220.4
Хувь	80.3	84.6	73.8	96.6

Орон нутгийн төсвийн зарлага 1,350.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 73.8 хувийн гүйцэтгэлтэй, Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 96.6 хувийн буюу 1,220.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт № 18. Нэгдсэн төсвийн нийт зардлын эхний 8 сарын гүйцэтгэл, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	ӨО-ы мөн үе		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		ӨО-ы мөн үетэй харьцуулсан зөрүү	
	.1.	.2.	.3.	4=3/2	тэрб.төг	%	5=3-1	6=5/1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,371.4	6,279.1	5,044.8	80.3%	-326.6	-6.1%		
Нийт зарлага	4,883.6	6,055.6	4,919.3	81.2%	35.7	0.7%		
Урсгал зардал	4,131.4	4,822.1	4,261.9	88.4%	130.5	3.2%		
Хөрөнгийн зардал	752.2	1,233.4	657.4	53.3%	-94.8	-12.6%		
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	487.8	223.6	125.5	56.1%	-362.3	-74.3%		

Нэгдсэн төсвийн 2017 оны урсгал зардлыг 7,076.1 тэрбум төгрөг байхаар баталсан ба оны эхний 8 сард өссөн дүнгээр 4,822.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 4,261.9 тэрбум төгрөгт хүрч 88.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт № 19. Нэгдсэн төсвийн урсгал зардлын эхний 8 сарын гүйцэтгэл, зардлын ангиллаар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	ӨО-ы мөн үе	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		ӨО-ы мөн үетэй харьцуулсан зөрүү	
			тэрб.төг	%	тэрб.төг	%
	.1.	.2.	.3.	4=3/2	5=3-1	6=5/1
Урсгал зардал	4,131.5	4,822.1	4,261.9	88.4%	130.5	3.2%
Цалин хөлс ба НДШ	1,236.1	1,300.4	1,256.6	96.7%	40.2	1.7%
Бараа үйлчилгээний бусад зардал	908.7	1,037.7	726.6	70.3%	-205.9	-13.7%
Хүүгийн зардал	465.8	715.1	654.4	91.5%	188.6	40.5%
Татаас	129.2	199.9	162.1	81.1%	32.9	25.5%
Урсгал шилжүүлэг	1,494.0	1,677.6	1,565.5	93.3%	71.5	4.8%

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал урсгал зардал нийт 130.5 тэрбум төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн гүйцэтгэлтэй гарахад зээлийн хүүгийн зардал 188.6 тэрбум төгрөг, татаас болон урсгал шилжүүлгийн зардал 32.9 тэрбум төгрөгөөр, цалин НДШ 40.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол бараа үйлчилгээний бусад зардал 205.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

2.4. Монгол улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл оны эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 9,248.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 33.7 хувьд хүрэхээр байгаа нь 2016 оны төсвийн гүйцэтгэлээс 246.7 тэрбум төгрөгөөр буурахаар, харин 2017 оны 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан тодотголын түвшнээс 498.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна¹.

Хүснэгт № 7. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл, /тэрбум төгрөг/

	2016 Гүйц	2017 Бат	2017 Тод 1	2017 Тод 2 санал*	Зөрүү (2017 Тод2-2017 тод 1)	
					тэрб.төг	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,519.9	8,569.1	8,750.2	9,248.6	498.5	5.7%
А. УРСГАЛ ЗАРЛАГА	6,613.8	6,948.0	6,843.6	6,948.8	105.2	1.5%
1. Бараа, үйлчилгээний зардал	3,133.3	3,045.1	3,075.9	3,091.2	15.3	0.5%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	986.1	1,345.7	1,201.8	1,156.7	-45.1	-3.8%
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,494.4	2,557.2	2,566.0	2,700.9	135.0	5.3%
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,360.2	1,483.9	1,579.8	1,887.8	308.1	19.5%
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	521.3	137.2	326.7	411.9	85.2	26.1%

Монгол Улсын 2017 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 498.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд хөрөнгийн зардал 308.1 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 85.2 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардал 15.3 тэрбум төгрөгөөр, татаас шилжүүлгийн зардал 135.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, зээлийн хүүгийн зардал 45.1 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

¹ Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн төслийг боловсруулах хугацаанд 2017 оны төсвийн 2 дахь тодотголын төслийн санал боловсруулах үйл явц давхцаж байгаа бөгөөд хоёрдох тодотголын дүнг 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл (ХБГ) гэж тооцсон болно.

Төсвийн орлого 2017 оны эхний хагас жилд төлөвлөснөөс давж биелсэн, оны эцэст орлогын гүйцэтгэл давж биелэх хандлагатай байгааг харгалзан ОУВС-ын хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсоны дагуу давсан орлогын тодорхой хэсгийг тухайн жилдээ өр барагдуулах, нэг удаагийн шинжтэй тулгамдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх, цаашид алдаглыг бууруулахад ашиглахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний хүрээнд тохирсон өөрчлөлтүүдийг төсөвт тусгах;
2. Хууль тогтоомжийн өөрчлөлт, нийгмийн хамгааллын бодлогод орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах зардлыг төсөвт тусгах.
3. Өсөн нэмэгдэж байгаа эрэлт, хэрэгцээнд нийцүүлж төрийн үйлчилгээний хүртээмж, хамрагдах хүрээг нэмэгдүүлэх;
4. Төсөвт ирэх жилүүдэд дарамт үзүүлэхгүй бөгөөд нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой дор дурьдсан зориулалт бүхий нэг удаагийн шинжтэй зардлыг тусган хэрэгжүүлэх. Үүнд:
 - i. Өвөлжилт, цаг агаарын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгах;
 - ii. 2015-2017 оны эхний хагас жилд тохиолдсон байгалын аюулт үзэгдэл, мал, амьтны гоц халдварт өвчний улмаас учирсан хохиролыг барагдуулах;
 - iii. Орон нутаг болон улсын төсвийн байгууллагуудад хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх;
 - iv. Шүүхийн шийдвэрийн дагуу төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгох төлбөрийг барагдуулах;
 - v. ЖДҮ-ийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд төсвөөс дэмжлэг үзүүлэх;
5. Төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл, хэрэгцээнд нийцүүлэн төсөвт нэмэлт дарамт үүсгэхгүй байх зарим зохицуулалтыг хийх зэрэг болно.

2.5. Монгол улсын 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаар

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад нийт 18 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад 492.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 333 төсөл, арга хэмжээ, мөн хуулийн 2 дугаар хавсралтаар “барих-шилжүүлэх” концессын гэрээгээр хэрэгжүүлсэн 12 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтэд 70.9 тэрбум төгрөгийг тус тус баталсан.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан санхүүжилтийн гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчдаар дараах байдлаар үзүүллээ.

Хүснэгт № 20. МУ-ын Төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн 2017.08.31-ний байдлаарх гүйцэтгэл /сая төгрөг/

Д/д	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	Нийт батлагдсан /сая төг/	Нийт санхүүжсэн /сая төг/	Гүйцэтгэлийн хувь	Үлдэгдэл санхүүжилт /сая төг/
1	Монгол Улсын Их Хурлын дарга	1,688.0	1,634.4	97%	53.6
2	Монгол улсын Ерөнхий сайд	73,711.7	34,553.2	47%	39,158.5
	<i>Концесс</i>	70,933.7	33,800.0	48%	37,133.7
	<i>Улсын төсөв</i>	2,778.0	753.2	27%	2,024.8
3	Монгол улсын Шадар сайд	5,287.3	3,219.7	61%	2,067.6
4	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	3,857.9	1,781.3	46%	2,076.6
5	Гадаад харилцааны сайд	700.0	637.6	91%	62.4
6	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	824.3	231.6	28%	592.7
7	Сангийн сайд	10,481.7	1,272.9	12%	9,208.8
8	Хууль зүй, дотоод хэргийн сайд	27,663.2	18,591.7	67%	9,071.6
9	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	7,679.1	2,321.9	30%	5,357.2
10	Батлан хамгаалахын сайд	2,693.1	1,107.0	41%	1,586.1
11	Барилга, хот байгуулалтын сайд	81,294.1	15,474.2	19%	65,819.9
12	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	104,136.2	27,320.1	26%	76,816.1
13	Зам, тээврийн хөгжлийн сайд	133,982.5	49,079.4	37%	84,903.1
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	26,984.6	2,237.4	8%	24,747.2
15	Эрүүл мэндийн сайд	49,422.1	25,777.5	52%	23,644.6
16	Эрчим хүчний сайд	32,439.0	11,471.1	35%	20,967.9
17	Авлигатай тэмцэх газар	851.4	851.4	100%	-
18	Улсын ерөнхий прокурор	88.3	88.3	100%	-
	ДҮН	563,784.5	197,650.7	35%	366,133.8

3. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСӨВТ БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ОНЦЛОГ, НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.1. 2018 оны төсвийн онцлог

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмуудыг мөрдлөг болгон боловсрууллаа.

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” болон ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн төсвийн нэгдмэл, тэнцвэртэй байдлыг хангах, сахилга батыг сайжруулах, төсвийн алдагдлыг үе шаттай бууруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд дараах зарчмуудыг баримтлан 2018 оны төсвийн төслийг боловсруулав. Үүнд:

Төсвийн орлогын чиглэлээр:

1. УИХ-аас баталсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, ОУВС-тай тохирсон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт тусгасны дагуу татварын 2 дахь шатны шинэчлэлийн ажлыг эрчимжүүлнэ.
2. Төсвийн орлогод учирч болзошгүй эрсдэлийг тооцон, төсвийн орлогыг бодитойгоор төсөөлж, боломжит эх үүсвэрийг дайчлан бааз суурийг нэмэгдүүлнэ.

Төсвийн зарлагын чиглэлээр:

1. Төсвийн урсгал зардлыг тооцоолохдоо ОУВС-тай тохирсон зарлагын чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэх, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, статистик, хүн ам зүйн өөрчлөлтөөс шалтгаалан нэмэгдэх нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн зардлыг төсөвт тусгах, инфляц, валютын ханшны өөрчлөлтөөс нэмэгдэх бараа үйлчилгээний зардлыг төсөвт тусгана. Үүнд:

1.1. ОУВС-тай тохирсон зарлагын чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ:

- i. **Нэн ядуу, эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийг нэмэгдүүлнэ.** "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн эхний шатны үнэлгээний хүрээнд 2017 оны 3 дугаар улирлаас эхлэн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээг 2 дахин, хүнсний талоны хэмжээг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэхээр тохирсны дагуу нэмж шаардагдах 24.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хэмнэлтээс шилжүүлэхээр тооцож төсөлд тусгалаа.
- ii. **Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай нэн ядуу иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн нөхцөлт халамжийн үйлчилгээг үзүүлнэ.** Нийгмийн халамжийн тухай хуульд заасан халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу иргэдэд нөхцөлт тэтгэмж олгох, тэнэмэл орон гэргүй

иргэдэд халуун хоол, цайгаар үйлчлэх зардалд нийт 17.8 тэрбум төгрөгийн зардлыг тусгав. Ингэхдээ олон улсын нийтлэг жишгээр энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны иргэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан байх, сургуулийн насны хүүхдүүдээ сургуульд бүрэн хамруулсан байх нөхцөлийг тавьж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- iii. **Эмзэг бүлгийн өрхийн гишүүн-иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцна.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.7-д нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний шимтгэлийг улсын төсвөөс сар бүр санхүүжүүлэхээр заасны дагуу 2018 онд нийт 260.4 мянган иргэний ЭМД-ийн шимтгэлийг төрөөс санхүүжүүлэхэд 9.2 тэрбум төгрөг нэмж зарцуулж, тэднийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
- iv. **Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг зорилтод бүлэгт чиглүүлнэ.** Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний хүрээнд 2018 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 60 хувийг хамруулахаар тохирсны дагуу ирэх жилд нийт 684.0 мянган хүүхдэд олгохоор тооцож 164.2 тэрбум төгрөг тусгав.
- v. **Гол нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоог хэрэгжүүлж эхэлнэ.** Эмийн төвлөрсөн худалдан авалт, ханган нийлүүлэлтийн үр ашигтай үндэсний тогтолцоо бий болгосноор эрүүл мэндийн салбарт зайлшгүй нийтлэг хэрэглэгддэг эм, эмнэлгийн хэрэгслийг чанартай, олон улсын зах зээлийн жишиг үнэд нийцсэн худалдан авалтыг ил тодоор хийх, үр ашиг нэмэгдэх, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах нөхцөл боломж бүрдэнэ.
- vi. **Сул орон тоонд нөхөн томилгоо хийхэд баримтлах горимыг үргэлжлүүлнэ.** Зөвхөн эрүүл мэнд, боловсрол, онцгой, цагдаагийн албанаас хоёр албан хаагч чөлөөлөгдсөн тохиолдолд нэг албан хаагчийг (2:1) нөхөн томилох, бусад бүх салбарт нөхөн томилгоо хийхгүй байх зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- vii. **Төсвийн зөвлөл байгуулж, төсвийн хяналтыг эрчимжүүлнэ.** Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөл, түүний тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон бусад хууль, тогтоомжийн төслийн төсөвт нөлөөлөх байдалд хараат бус, бие даасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дэргэд байгуулна.
- viii. **Төсөв хэлэлцэн батлах тогтолцоог боловсронгуй болгоно.** Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа тодорхой төсөл хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэх бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх зарчмын өөрчлөлтийг холбогдох хуулиудад нэмэлт оруулж шийдвэрлэнэ.
- ix. **Төсвийн зарлагыг их хэмжээгээр нэмэгдүүлэх зарим хуулийг хүчингүй болгоно.** УИХ-аас 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр нийгмийн хамгааллын

салбарын 2 хуулийг шинээр баталж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Эдгээр хуулиуд нь богино болон дунд хугацаанд төсөвт ихээхэн хэмжээний дарамт учруулах, ОУВС-тай тохирсон зардлын зорилгод түвшнийг алдагдуулахаар байгаа тул энэхүү 2 хуулийг эргэн авч үзэж хүчингүй болгоно.

1.2.Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан онцлох арга хэмжээ:

- i. **Өмнөх жилүүдэд эхлүүлсэн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан онцлох арга хэмжээг тогтвортой үргэлжлүүлнэ.** Иргэдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллыг хангах, эдийн засгийг сэргээх чиглэлээр 2016-2017 онуудад эхлүүлсэн Элэн бүтэн Монгол, Боловсролын зээлийн сан, Насны хишиг, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зэрэг тодорхой төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг 2018 онд тогтвортой үргэлжлүүлэх зарчим баримталж байна.
- ii. **Тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан индексжүүлж нэмэгдүүлнэ.** Нийгмийн даатгалын сангаас олгож буй бүх төрлийн тэтгэврийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд нийт 393.6 мянган хүний авч байгаа тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд нийт 119.5 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авдаг 62.7 мянган хүний авч байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд 17.4 тэрбум төгрөг тус тус нэмж зарцуулна.
- iii. **“Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.** Холбогдох хуулийн дагуу 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр, түүнчлэн гурав болон түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр тэтгэмж олгох ба тэтгэмжийн хэмжээг хүүхдээ асарч байгаа эхэд сарын 50.0 мянган төгрөг буюу улиралд 150.0 мянган төгрөг, өрх толгойлсон эх/эцэгт улиралд 240.0 мянган төгрөгөөр буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нийт 72.8 тэрбум төгрөг олгохоор байна.
- iv. **Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардлыг нэмэгдүүлэв.** Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг тэлэх, цахилгааны шөнийн үнийн тарифыг өвөл, хаврын улиралд хөнгөлөх арга хэмжээнд илүү олон өрх хамруулах зорилгоор шөнийн цахилгааны үнийн урамшуулалд Улаанбаатар хотын гэр хорооллын 110 мянган өрхийг хамруулах, агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот айл өрхөд цахилгаан халаагуур, сайжруулсан зуух, хагас боловсруулсан түлш олгох зэрэг ажлуудыг санхүүжүүлнэ.

Мөн төв суурин газрын агаарын бохирдол нь нэн түрүүнд хүүхдийн эрүүл мэндэд уушгины хатгалаа өвчнөөр илэрч байгаа тул нийслэлийн 9 дүүргийн шинэ төрсөн 35.0 мянган хүүхдийг дархлаажуулалтын вакцинд хамруулахад шаардагдах зардлыг төсөвт тусган санхүүжүүлнэ.
- v. **Шинжлэх ухааны эрдэм, шинжилгээний зардлыг нэмэгдүүлнэ.** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Шинжлэх ухааны эрдэм, шинжилгээнд төсвөөс зарцуулж байгаа зардлыг 3 дахин нэмэгдүүлнэ гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны төсвийн тодотголын түвшингээс 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тусгав.

- vi. **Өрсөлдөөнт тэтгэлэг хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлнэ.** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон НББСШУ-ны Байнгын хорооны 2017 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор энэ төрлийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхэд зориулж 1.5 тэрбум төгрөг тусгалаа.
- vii. **Дотоодын их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа оюутанд олгох санхүүгийн дэмжлэгийн хамрах хүрээг нэмэгдүүлнэ.** Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.2.21-д заасаны дагуу өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол нэг хүүхдэд нь санхүүгийн буцалтгүй дэмжлэг олгох, түүнчлэн их дээд сургуульд суралцаж байгаа нийгмийн халамж, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн суралцагчдаас санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт нэмэгдэж байгаа зэргийг харгалзан нийт 4.0 тэрбум төгрөг төсөвлөв.
- viii. **Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн салбарын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.** Хот суурин газрын хүн амын өсөлт, нягтаршил, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ жил бүр өсөн нэмэгдэж байна. Иймд эрүүл мэндийн салбарт улсын төсвөөс санхүүжих урсгал зардлыг өмнөх оны түвшинтэй харьцуулахад 51.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байна.
- ix. **Өндөр өртөгтэй мэс заслын эмчилгээний хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.** Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 3.1.17-д заасан зорилтын хүрээнд өндөр өртөгтэй мэс заслын эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, даатгуулагч иргэдийн хамрагдах боломжоор тэгш хангахад зориулж 14.9 тэрбум төгрөгөөр зардлыг нэмэгдүүллээ. Энэ нь иргэдэд учирч байгаа санхүү, төлбөрийн дарамтыг бууруулах, гадагш чиглэж байгаа эрүүл мэндийн төлбөрийн урсгалыг бууруулах, улмаар дотоодын эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх ач холбогдолтой байна.
- x. **Өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвөөс иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлнэ.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх ажлыг 2018 оноос зохион байгуулж эхлэх ба уг арга хэмжээнд 5.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно.
- xi. **Зарим хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг сайжруулж экспортыг дэмжинэ.** Хөшигтийн хөндий дахь Улаанбаатар хотын шинэ нисэх буудал ашиглалтад орсноор агаарын шинэ боомтын үйл ажиллагааг эхлүүлэх, мөн Гашуун сухайт боомтыг уртасгасан цагаар ажиллуулах, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, Шивээ хүрэн, Бургастай зэрэг боомтын үйл ажиллагаанд шаардлагатай урсгал зардал, хүний нөөцийн асуудлыг төсөвт тусган шийдвэрлэхээр тооцлоо.
- xii. **Үндэсний брэндийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.** Дэлхийд Монгол Улсын үнэлэмж, байр суурь, монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг таниулах бодлогыг зохицуулах, төрөөс баримтлах бодлогын талаар

санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгч зөвлөмж гаргах үүрэг бүхий Үндэсний брэндийн зөвлөл түүний ажлын албаны зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

- xiii. **Гал унтраах ангиудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.** Засгийн газрын 2017 оны 192 дугаар тогтоолоор Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл, Ховд, Дундговь аймгуудад гал унтраах 4 дүгээр зэрэглэлийн 6 анги, эрэн хайх, аврах 3 бүлэг байгуулах зардалд зориулж 4.9 тэрбум төгрөг төсөвлөв.
2. Хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой, үр ашигтай болгох, салбарын тэргүүлэх чиглэлийн төсөл, арга хэмжээнд санхүүжилтийг хуваарилах, хөгжлийн бодлого, стратегитай уялдуулан ач холбогдлын эрэмбийг харгалзах, өмнөх онуудад эхлүүлсэн төсөл, арга хэмжээг дуусгах, хэрэгжиж буй төслийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг оновчтой удирдах, концессын гэрээгээр хэрэгжиж буй төслүүдийн эргэн төлөлтийг төсөвт тусгах зарчмыг баримталсан.
- i. **2018-2019 оны хичээлийн жилд ачаалал ихтэй ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлыг шийднэ.** 2018 оны улсын төсвөөс боловсролын салбарт нийт 255.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ. Төсвийн хөрөнгөөр улсын хэмжээнд 2018 онд 41 сургуулийн барилгыг шинээр эхлүүлж, 12 сургууль ашиглалтад оруулна. Мөн концессын гэрээгээр 50 гаруй сургууль, цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна. Түүнчлэн, боловсролын салбарт сургууль, цэцэрлэгийн зориулалт бүхий үл хөдлөх хөрөнгө худалдан авахад 32.0 тэрбум төгрөг төсөвлөж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг хангана.
- ii. **Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авна.** 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд нийт 62.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээр агаарын бохирдлыг үе шаттайгаар бууруулах зорилтод хүрнэ. Тухайлбал, нийслэлд одоо ажиллаж байгаа 68 ширхэг халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг дулааны төвлөрсөн системд холбох ажлыг 22.9 тэрбум төгрөгөөр эхлүүлсэн. Нийслэлийн гэр хорооллын өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдуулан гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд 39.5 тэрбум төгрөг тусгалаа.
- iii. **Атрын 3 дугаар аян, Мах, сүүний анхдугаар аяныг үргэлжлүүлнэ.** Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөлд 4.7 тэрбум төгрөг, төрийн болон орон нутгийн өмчийн тариалангийн талбайн усалтын системийг сэргээн засварлах, шинээр барихад 2.1 тэрбум төгрөг, үрийн болон хүнсний ногоо, өвс тэжээлийн агуулах, хашаа саравч барихад 4.1 тэрбум төгрөг, ахуй үйлчилгээний төв, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга барихад 4.4 тэрбум төгрөг, хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэлгийн салбарын тоног төхөөрөмжийн шинэчлэлд 4.8 тэрбум төгрөгийг тус тус тусгалаа.
- iv. **Өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.** 2018 онд эрүүл мэндийн салбарт 60.2 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардал тусгалаа. Үүнээс 42.6 тэрбум төгрөгийг эмнэлгийн барилга

байгууламж, 5.7 тэрбум төгрөгийг их засварт, 11.9 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулна. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дэргэдэх эмнэлэг, Үндэсний оношилгоо эмчилгээний төв, Дорноговь аймгийн Сайншанд сумын 50 ортой төрөх эмнэлэг болон Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Говь-Алтай, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймгийн сумын Эрүүл мэндийн төв болон нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдийн эрүүл мэндийн төв ашиглалтад орно. Түүнчлэн, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн төв, Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг, Говийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн барилгын ажлууд үргэлжилнэ. Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт Эрүүл мэндийн төвийн амбулаторийг Эмчилгээ, оношилгооны төв болгон шинэчлэх ажлыг эхлүүлнэ. Мөн Дархан-Уул аймгийн Төрөх эмнэлгийн барилгын өргөтгөл, Булган аймгийн Халдварт, сүрьеэгийн эмнэлэг, Баянхонгор аймгийн Хүүхдийн эмнэлэг, Өвөрхангай аймгийн Зооноз өвчин судлалын төвийн барилгыг шинээр эхлүүлнэ.

- v. **2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн ажлыг санхүүжүүлэхэд нийт 106.8 тэрбум төгрөг тусгалаа.** Өмнөх онуудын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, барилга байгууламжийн насжилтыг уртасгах, төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор улсын хэмжээнд улсын чанартай авто зам, гүүрний засвар арчилгаа, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд болон бусад төсөвт байгууллагуудын их засварын ажилд нийт 74.9 тэрбум төгрөг тусгалаа. Мөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа боловсруулах, ирэх онуудад гадаад болон дотоод эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах, салбаруудын хөрөнгө оруулалтын төслийн зураг төсөв боловсруулах ажилд 31.9 тэрбум төгрөгийг төсөвлөлөө.
3. Хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрийг түлхүү ашиглаж, эдийн засгийн үр ашигтай төслүүд болох эрчим хүч, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн салбарын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, экспортыг дэмжих, мөн нийгмийн нэн тэргүүний ач холбогдолтой боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник эдийн засгийн судалгааг 2017, 2018 оны төсвийн жилд багтаан эхлүүлж, зураг төсвийг боловсруулах, төслийг эхлүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, гадаадын зээл, тусламжийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
 4. Хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрийг түлхүү авч ашигласнаар төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргах дотоод бондын хэмжээг бууруулах, гадаад бондын эргэн төлөлтийн хуваарийг жигдлэх, өрийн удирдлагын оновчтой арга хэрэгслийг хэрэгжүүлнэ.
 5. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор Улсын төсвөөс аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 2017 оны түвшнээс 35.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж нийтдээ 88.6 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөөд байна.

3.2. Төсвийн тусгай шаардлага

Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх гол шалгуур нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан дараах 4 тусгай шаардлагыг хэрхэн хангаж байгаа үзүүлэлтүүд юм. Үүнд:

1. **Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх.** Ирэх 2018 онд зэсийн баяжмалын экспортоос төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын **16.0** хувиас давахаар байгаа тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу зэсийн үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон. Ирэх оны төсөвт 1 тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг **5,106.9** ам.доллар, зах зээлийн үнийг **6,430.0** ам.доллар байхаар тооцож, Тогтворжуулалтын санд **64.8** тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцлоо.
2. **Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2018 онд тухайн жилийн ДНБ-ий 9.5 хувиас илүүгүй байх.** Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн төслийг тооцоход нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого **7,218.0** тэрбум төгрөг буюу ДНБ-ий **23.8** хувь, нэгдсэн төсвийн нийт зарлага **9,828.8** тэрбум төгрөг буюу ДНБ-ий **32.4** хувь, нэгдсэн төсвийн нийт алдагдал **2,610.8** тэрбум төгрөг буюу ДНБ-ий **8.6** хувь болохоор байна.
3. **Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх.** Монгол Улсын 2018 оны эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт **10.9** хувьтай, 2006-2017 оны эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж **21.3** хувьтай тус тус тэнцэж байна. 2018 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг **9,828.8** тэрбум төгрөгөөр тооцож, нийт зарлагын өсөлт **6.3** хувь буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан тусгай шаардлагыг хангаж байна.
4. **Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасан Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь 2018 онд ДНБ-ий 80.0 хувиас хэтрэхгүй байх.** Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн төсөлд туссан Засгийн газрын шинээр авах зээл, гаргах үнэт цаас, өрийн баталгаа, тэдгээрийн эргэн төлөлт болон Засгийн газрын өрийн удирдлагын бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээг оруулан тооцсоноор 2018 оны эцэст Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь **77.4** хувьд хүрэх төлөвтэй байгаа нь Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

3.3. Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

Төсвийн зарчмуудыг баримтлан, дээр дурдсан голлох өөрчлөлтүүдийг оруулан тооцоход Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого **7,218.0 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **23.8 хувь**, нэгдсэн төсвийн нийт зарлага **9,828.8 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **32.4 хувь**, нэгдсэн төсвийн нийт алдагдал **2,610.8 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **8.6 хувь** болж нийт алдагдал 2017 оноос ДНБ-ий 1.3 хувиар буурахаар байна.

2018 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлын хэмжээ ДНБ-ий 9.5 хувиас хэтрэхгүй байх шаардлагатай бөгөөд төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг ДНБ-ий 8.6 хувьд хүргэн бууруулж, төсвийн тэнцлийг тусгай шаардлагаас ДНБ-ийн 0.9 хувиар сайжруулж байна.

Түүнчлэн 2018-2020 онд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон хязгаарт багтаж, ирэх 3 жилд төсвийн тэнцлийг илүү эрчимтэй бууруулах боломжийг олгож байна.

Хүснэгт № 21 . Төсвийн тэнцлийн тусгай шаардлагыг хангаж буй байдал

Төсвийн тэнцлийн тусгай шаардлага	2018	2019	2020
Хуулийн хязгаар	-9.5%	-6.9%	-5.1%
Төсөөлөл	-8.6%	-6.2%	-4.5%

4. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН

4.1. Төсвийн орлогыг төлөвлөхөд баримталсан зарчим

Монгол Улсын 2018 оны төсвийн орлогын төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан макро эдийн засгийн болон төсвийн үзүүлэлтүүдэд үндэслэн боловсруулав. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс төсөвт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор гол нэр төрлийн эрдэс баялаг болох зэсийн тэнцвэржүүлсэн үнэ, зах зээлийн үнийн зөрүүгээс бий болох орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцлоо. Түүнчлэн, 2018 оны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газар болон Олон Улсын Валютын Сан хооронд тохиролцсон Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг харгалзан үзсэн бөгөөд орлогыг бодитойгоор төсөөлж, боломжит эх үүсвэрийг дайчилсан болно. Мөн 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжих татварын хуулийн өөрчлөлтийг төсвийн орлогын төсөөлөлд тусгалаа.

Ирэх 2018 онд татварын ачааллыг нэмэгдүүлэхгүй, тогтвортой байлгах бодлогыг баримтлах бөгөөд шинэ төрлийн татвар бий болгохгүй. Монгол Улсын Их Хурлаас баталсан Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, ОУВС-тай тохирсон Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрт тусгасны дагуу татварын 2 дахь шатны шинэчлэлийн ажлыг эрчимжүүлнэ. Энэ хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. Эдгээр хуулийн төслийг боловсруулахдаа татварын тэгш, шударга зарчмыг бэхжүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх, татвар хураалтыг сайжруулах, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай тэмцэх, татварын албаны боловсон хүчний нөөцийг илүү оновчтой удирдах, татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардлыг бууруулах чиглэлийг баримтлан ажиллах болно.

Голлох татварын орлогын нэр төрөл тус бүрээр мэдрэмжийн шинжилгээ хийсэн ба олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын нийтэлсэн ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний үнийн таамаглал зэргийг нарийвчлан судалж, төсвийн орлогын тооцоололд ашиглалаа. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тооцлоо.

4.2. Эдийн засаг дахь татварын ачаалал

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын орлогын хувиар эдийн засаг дахь татварын ачааллыг хэмжсэн. Монгол Улсын хувьд эдийн засаг дахь татварын ачаалал 2018 онд 22.5 хувь байхаар байна.

График № 6. Эдийн засаг дахь татварын ачаалал



Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ 2016 онд 5,000.0 ам.доллараас бага байсан тул зэсийн үнийн өсөлтөд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрөөр төсөвт орлого төвлөрөөгүй. Ингэснээр 2016 онд эдийн засаг дахь татварын ачаалал буурах суурь нөхцөлийг бүрдүүлжээ. Харин, 2017-2018 онд зэсийн дундаж үнэ 5,000.0 ам.доллараас дээш байх төлөвтэй байгаа тул зэсийн үнийн өсөлтөд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн орлого төсөвт төвлөрөхөөр байна.

Дээрх хүчин зүйлсээс хамаарч эдийн засаг дахь татварын ачаалал 2016 оноос 1.8 пунктээр нэмэгдэхээр байна.

4.3. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 16 дугаар зүйлийн 16.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9¹.2.1 дэх заалтын дагуу төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан төсвийн орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцсон.

Ирэх онд зэсийн баяжмалын экспортоос төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын 3 хувиас давахаар байгаа тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу зэсийн үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д “тухайн төсвийн жилийн дараах жилийн төсвийн төсөлд баримтлах, түүний дараагийн хоёр, гурав дахь жилийн төсвийн төсөөлөлд тусгах гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сангаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараах гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцно” гэж заасны дагуу нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнэ 5,106.9 ам.доллар байна.

Хүснэгт № 22. Төсвийн тогтворжуулалтын санд 2018 онд зэсээс төвлөрөх орлого /тэрбум төгрөг/


Үзүүлэлт	Цэвэр зэс
Тэнцвэржүүлсэн үнэ, ам.доллар/тн	5,106.9
Зах зээлийн үнэ, ам.доллар/тн	6,429.9
Тогтворжуулалтын санд төвлөрөх орлогын дүн /тэрбум төг/	64.8

Зэсийн зах зээлийн үнэ, тэнцвэржүүлсэн үнийн зөрүүгээс 64.8 тэрбум төгрөгийн орлого Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрөхөөр байна.

4.4. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого


Энэ оны төсвийн орлогын гүйцэтгэлийн түвшин, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчны хүрээнд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газрын баримталж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн өсөлт, гадаад, дотоод орчны нөлөөлөл зэргийг харгалзан үзэж, 2018 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 7,218.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

График № 7. Тэнцвэржүүлсэн нийт орлого



Ирэх онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 680.9 тэрбум төгрөгөөр буюу 10.4 хувиар өсөхөөр байна.

График № 8. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг эдийн засгийн ангиллаар үзүүлбэл дараах байдалтай байна:

Хүснэгт № 23. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /тэрбум төгрөг/

ОРЛОГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	2015	2016	2017	2018
	Гүйц	Гүйц	ХБГ	Төс
	.1.	.2.	.3.	.4.
1 НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,983.4	5,835.0	7,112.9	7,808.5
Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого	2.3	0.0	242.4	64.8
Ирээдүйн өв сангийн орлого	0.0	0.0	333.3	525.7
2 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ОРЛОГО	5,981.1	5,835.0	6,537.1	7,218.0
2.1 ТАТВАРЫН ОРЛОГО	5,119.0	4,951.0	5,661.3	6,295.0
Орлогын албан татвар	1,170.8	1,043.4	1,330.8	1,400.5
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,018.2	1,109.8	1,248.5	1,443.2
Хөрөнгийн албан татвар	86.6	104.7	98.6	111.2
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,049.6	1,140.7	1,448.5	1,517.3
Онцгой албан татвар	592.3	630.1	511.6	684.3
Тусгай зориулалтын орлого	11.8	10.8	11.9	12.1
Гадаад үйл ажиллагааны орлого	320.6	328.5	489.8	536.9
Бусад татвар, төлбөр, хураамж	869.1	583.1	521.6	589.6
2.2 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	862.1	884.1	875.8	922.9
Нийтлэг татварын бус орлого	753.5	805.4	799.7	812.5
Хөрөнгийн орлого	55.1	1.5	0.4	0.5
Тусламжийн орлого	53.4	77.2	75.7	110.0

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 87.2 хувь буюу 6,295.0 тэрбум төгрөгийг татварын орлого, үлдэх 12.8 хувь буюу 922.9 тэрбум төгрөгийг татварын бус орлого бүрдүүлэхээр байна.

Төсвийн орлого төвлөрүүлдэг гол байгууллагууд болох Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар нь улсын төсвийн нийт орлогын 60 орчим хувийг бүрдүүлдэг. Эдгээр байгууллагуудын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт № 24. Төсвийн орлого төвлөрүүлэгч томоохон байгууллагууд /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 ГҮЙЦ	2016 ГҮЙЦ	2017 ХБГ	2018 ТӨС
Татварын ерөнхий газар	1,981.5	1,630.0	2,318.5	2,352.4
Гаалийн ерөнхий газар	1,462.3	1,521.3	1,897.2	2,200.5

4.5. Уул уурхайн салбарын орлого

График № 9. Уул уурхайн салбарын орлогын нийт орлогод эзлэх хувь

Манай улс зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг 20 гаруй нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн экспортолдог. Эдгээр бүтээгдэхүүний экспортоос төсөвт төвлөрүүлсэн орлого нь сүүлийн 5 жилд нэгдсэн төсвийн орлогын 19 орчим хувийг эзэлж ирсэн. Дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрсний үнийн өсөлтөөс шалтгаалж энэ үзүүлэлт 2018 онд 23 орчим хувьд хүрэх хандлагатай байна.





График № 10. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ



Уул уурхайн салбараас 2018 онд нийт 1,757.2 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна. Ирэх оны уул уурхайн салбарын орлогын тооцоог хийхдээ нүүрсний экспортын хэмжээг 32.2 сая тонн, Монголбанканд тушаах алтны хэмжээг 21.0 тонн байна гэж төсөөлсөн. Уул уурхайн салбараас 2018 онд төвлөрөх нийт орлогын 92 хувийг алт, зэс, нүүрсний орлого бүрдүүлэхээр байна. Үүнээс: 30 хувийг буюу 535.1 тэрбум төгрөгийг нүүрс, 57 хувийг буюу 1,004.6

тэрбум төгрөгийг зэс, зэсийн баяжмалын экспортоос төвлөрүүлэхээр байна.

Хүснэгт № 25 Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Биет хэмжээ	2018 оны төлөвлөгөө /тэрбум төгрөгөөр/					Нийт
			ААНОАТ	АМНАТ	Ногдол ашиг	Бусад татвар*	Гаалийн хураамж /экспортын/	
1	Алт /тн/, дотоодын	21	14.0	51.8	-	14.6	-	80.4
2	Нүүрс /сая тн/, экспортын нүүрс 32.2	41.6	155.3	245.3	-	86.2	48.3	535.1

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Биет хэмжээ	2018 оны төлөвлөгөө /тэрбум төгрөгөөр/					Нийт
			ААНОАТ	АМНАТ	Ногдол ашиг	Бусад татвар*	Гаалийн хураамж /экспортын/	
	сая.тн, дотоодын нүүрс 9.4 сая.тн							
3	Зэсийн баяжмал /мян.тонн/, дагалдах эрдсүүд (Оюу Толгой ХХК-ийн баяжмалд агуулагдах алт орсон)	1,366.0	222.3	436.4	47.8	296.0	2.0	1,004.6
4	Цайрын баяжмал /мян.тонн/	106.6	24.2	16.6	-	1.6	0.1	42.6
5	Төмрийн хүдэр /сая.тонн/	7.5	2.4	39.5	-	3.3	11.3	56.5
6	Бусад		1.9	17.5	-	18.1	0.43	37.9
НИЙТ ДҮН			420.1	807.3	47.8	419.9	62.2	1,757.2

Тайлбар: *- Бусад татвар хэсэгт импортын гаалийн албан татвар, НӨАТ, ХХОАТ, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, ус ашигласны төлбөр зэрэг бусад татварууд багтсан болно.

“Оюу толгой” ХХК 2018 онд 764.8 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж 423.0 тэрбум төгрөгийг, “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 601.2 мянган тонн зэсийн баяжмал, 4.1 мянган тонн молибдений баяжмал экспортолж, 509.0 тэрбум төгрөгийг, зэсийн үүсмэл ордод үйл ажиллагаа явуулдаг бусад компаниас 72.6 тэрбум төгрөгийн татварыг тус тус төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.



4.6. Татварын орлого

Татварын орлого 2018 онд 6,295.0 тэрбум төгрөгт хүрнэ гэж тооцлоо. Үүнээс орлогын албан татвараар 1,400.5 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 1,443.2 тэрбум төгрөг, хөрөнгийн албан татварын орлогоор 111.2 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор 1,517.3 тэрбум төгрөг, онцгой албан татварын орлогоор 684.3 тэрбум төгрөг, тусгай зориулалтын орлогоор 12.1 тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлогоор 536.9 тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлогоор 589.6 тэрбум төгрөг тус тус төсөвт төвлөрөхөөр байна.

Ирэх онд татварын орлого энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 633.7 тэрбум төгрөг буюу 11.2 хувиар өсөж байгаа нь орлогын албан татварын орлого, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого, онцгой албан татварын орлого болон гадаад үйл ажиллагааны орлогын өсөлтөөс хамаарахаар байна.

4.6.1. Орлогын албан татвар

Ирэх 2018 онд төсөвт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг татварын ногдол, төлөлтийн судалгаанд үндэслэн тооцлоо.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн сүүлийн 10 жилийн судалгаагаар нийт тайлан ирүүлсэн татвар төлөгчийн тоо жилд дунджаар 8.5 хувиар өссөн байна. Судалгаанаас харахад 2006 онд тайлан ирүүлсэн аж ахуйн нэгжийн тоо 34.5 мянга байсан бол 2017 оны хагас жилийн байдлаар 83.4 мянгад хүрч, 2.4 дахин өссөн байна.



Эдийн засгийн өсөлт, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн таамаглал, биет хэмжээний төлөвлөлт, татвар төлөгчдийн татварын тайланд хамрагдах байдал, компаниудын ашигт ажиллагааны түвшин зэрэгт үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоор 2018 онд 688.3 тэрбум төгрөг төсөвт төвлөрнө гэж тооцлоо.

4.6.2. Хувь хүний орлогын албан татвар

График № 14 . Хувь хүний орлогын албан татвар



Хувь хүний орлогын албан татварын орлого нь орон нутгийн төсвийн гол эх үүсвэрийг бүрдүүлдэг болно. Ирэх онд хувь хүний орлогын татвараар 758.8 тэрбум төгрөг төвлөрөхөөр тооцлоо.

ОУВС-ийн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд татвар төлөгчдөд ирэх татварын дарамт, ачааллыг жигд хуваарилах, татварын шударга тогтолцоог бий болгох шаардлага байна

гэж үзэж “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуульд цалин болон түүнтэй адилтгах орлогод татварын шатлал бий болгох, иргэдэд үзүүлэх татварын хөнгөлөлтийг үе шаттай нэмэгдүүлэх зэрэг өөрчлөлтийг оруулсан.

4.6.2.1. Цалин болон түүнтэй адилтгах орлого

Хуулийн өөрчлөлтийн хүрээнд Хувь хүний орлогын албан татварын цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 10-25 хувиар татвар ногдуулна. Нөгөө талаас, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, үнийн өсөлтийн түвшин зэрэгтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан. Тухайлбал, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт одоогийн хуулиар 84.0 мянган төгрөг байгааг 2018 онд 120.0 мянган төгрөг, 2019 онд 160.0 мянган төгрөг, 2020 онд 200.0 мянган төгрөг, 2021 онд 240.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлнэ.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байгаа иргэд татвар төлөхгүй, мөн түүнчлэн дунджаар сарын 1.8 сая төгрөг хүртэлх цалин болон түүнтэй адилтгах орлоготой иргэдийн татварын ачаалал буурч байна.

Харин өндөр орлоготой иргэдийн татварын ачаалал нэмэгдэхээр байна. Тухайлбал, сарын 2.5 сая төгрөгийн орлогод 10.0 хувиар, сарын 4.0 сая төгрөгийн орлогод 13.7 хувиар татвар ногдохоор байна. Татварын ачаалал хэрхэн өөрчлөгдөж байгааг дараах графикаар харуулав:

График № 15. Цалингийн татварын ачаалал /2018 он/



Одоогоор 900 мянга орчим татвар төлөгч бүртгэлтэй байгаа бөгөөд ирэх онд нийт татвар төлөгчдийн 95 орчим хувь нь 10 хувиас бага татвар төлөхөөр, үлдэх 5 орчим хувь нь 10 хувиас их татвар төлөхөөр байна.

4.6.2.2. Хөрөнгийн орлого

УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулахаар шийдсэн. Энэ татварын арга хэмжээний үр дүнд хувь хүний хөрөнгийн орлогод ногдуулах татварын орлого 2017 онд 46.0 тэрбум төгрөг, 2018 онд 67.0 тэрбум төгрөг болохоор байна.

4.6.3. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 2018 онд нийт 1,443.2 тэрбум төгрөг, үүнээс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогоор 284.2 тэрбум төгрөг, бусад даатгалын шимтгэлийн орлогоор 1,159.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрөхөөр тооцлоо.


4.6.4. Хөрөнгийн албан татвар

Ирэх онд хөрөнгийн албан татварын орлогоор 111.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

4.6.4.1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулиар хөрөнгийн үнэлгээнээс хамаарч 0.6-1.0 хувийн албан татвар ногдуулдаг. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 2015 онд 57.5 тэрбум төгрөг, 2016 онд 71.7 тэрбум төгрөг тус тус орон нутгийн төсөвт төвлөрч байсан бол ирэх онд 73.6 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.


График № 16. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар



4.6.4.2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн дагуу 10 төрлийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд жилд 1.8-720 мянган төгрөгийн албан татвар ногдуулж байна. Тээврийн хэрэгслийн тооноос хамаарч автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого сүүлийн 10 жилд тогтмол өссөн байна.

График № 17. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тоо болон албан татварын орлого



УИХ-ын 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор энэ татварын орлого 2011 оноос хойш тогтмол өссөн байна. Ирэх онд тус орлогоор 36.3 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

4.6.5. Дотоодын бараа, үйлчилгээний татвар


4.6.5.1. Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар

Ирэх онд төвлөрүүлэх нэмэгдсэн өртгийн албан татварын орлогыг одоо хэрэгжиж буй хуулийн нөлөөлөл болон макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд үндэслэн тооцлоо.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн сүүлийн 14 жилийн судалгаагаар нийт тайлан ирүүлбэл зохих татвар төлөгчийн тоо жилд дунджаар 16 хувиар өссөн. Тайлан ирүүлбэл зохих аж ахуйн нэгжийн тоо 2003 онд 4.7 мянга байсан бол 2016 онд 32.9 мянгад хүрч 7 дахин өссөн байна. Гэвч, уг хугацаанд татварын бааз суурь өргөжихтэй зэрэгцэн НӨАТ-ын тайлан ирүүлээгүй аж ахуйн нэгжийн тоо 0.1 мянгаас 6.3 мянгад хүрч, 41 дахин өссөн. Энэ нь татварын үндсэн бааз суурь болох татвар төлөгчийн тоо нэмэгдэж байгаа ч тайлан ирүүлж, татвар төлөх идэвхтэй татвар төлөгчийн тоо жигд бус өсөлттэй байсныг харуулж байна.


НӨАТ төлөгчдийн борлуулалт 2003 онд 1.5 их наяд төгрөг байсан бол 2016 онд 27.7 их наяд төгрөгт хүрч, 18.5 дахин өссөн байна.

График № 18. НӨАТ-ын тайлангийн нэгтгэл




Харин НӨАТ-тай худалдан авалт 2003 онд 1.2 их наяд төгрөг байсан бол 2016 онд 17.5 их наяд төгрөгт хүрч 14 дахин өссөн байна. НӨАТ-ын худалдан авалт нь импортын болон дотоодын худалдан авалтад хуваагдах бөгөөд импортын худалдан авалтын өсөлт нийт худалдан авалтын өсөлттэй шууд хамааралтай байна.

График № 19. НӨАТ-тай худалдан авалт ба импорт



Барилга, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ эрчимжсэнээс үүдэн 2014 оныг хүртэл нийт худалдан авалтын хэмжээ өсөлттэй байсан. Харин бизнесийн салбар дахь хөрөнгө оруулалт буурсны улмаас сүүлийн жилүүдэд импортын өсөлт саарсан байна.

График № 20 НӨАТ-ын орлого



Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хууль батлагдсанаар эцсийн хэрэглэгч буюу худалдан авагчийг урамшуулах замаар албан татвар суутган төлөгчийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг бүртгэх эрх зүйн орчин бүрдсэн. Албан татвар төлөгчийн худалдан авалтыг бүртгэлжүүлж, бүртгэгдсэн эцсийн хэрэглээнд төлсөн албан татварын 20 хувийг буцаан олгож байгаа нь далд эдийн засгийг татварт хамруулахаас гадна тухайн иргэнд мөнгөн урамшуулал хэлбэрээр орлого олгож буй эерэг нөлөөтэй арга хэмжээ болж байна. Гүйлгээний баримтуудыг бүртгэлжүүлж, нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэлийн системд холбосноор дотоодын НӨАТ-ын орлого 2016 онд 558.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15 хувиар өссөн байна.

Орлогын өсөлт нь бүртгэл сайжирсантай холбоотойгоос гадна 2016 онд шинээр хэрэгжиж эхэлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн

найруулгын хүрээнд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх бие даасан 10 орчим хуулийг хүчингүй болгож, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнг бууруулсантай холбоотой байна.

Энэ 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр дотоодын НӨАТ-ын орлогыг 600.7 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оны гүйцэтгэлээс 7.6 хувийн өсөлттэй, 2018 оны дотоодын НӨАТ-ын орлогыг 620 тэрбум төгрөг буюу 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 3.2 хувийн өсөлттэй байхаар төсвийн төсөлд тусгалаа.

4.6.5.2. Дотоодын архи, дарс, тамхи, пивоны онцгой албан татвар

Архи, дарсны онцгой албан татварын орлогоор 2018 онд улсын төсөвт 142.6 тэрбум төгрөг, пивоны онцгой татварын орлогоор 23.7 тэрбум төгрөг, тамхины онцгой татварын орлогоор 36.2 тэрбум төгрөг, нийт 202.5 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэхээр тооцлоо.

Хүснэгт № 26. Улсын төсөвт төвлөрүүлсэн дотоодын барааны онцгой албан татварын хэмжээ /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017 ХБГ	2018 ТӨЛ
Дотоодын архи, дарс	92.7	148.2	160.4	129.0	138.4	136.1	142.6
Дотоодын пиво	17.6	21.8	27.9	23.7	22.4	22.0	23.7
Дотоодын тамхи	15.7	39.6	45.7	31.8	32.8	34.5	36.2
НИЙТ	125.9	209.6	234.0	184.6	193.6	192.6	202.5


Монгол Улсын хэмжээнд архи, дарс, пиво үйлдвэрлэгч 85 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа боловч 41.2 хувь буюу 35 үйлдвэр тогтмол, 8.2 хувь буюу 7 үйлдвэр тогтмол бус, 50.6 буюу 43 үйлдвэр үйл ажиллагаа явуулахгүй байна.

Хүснэгт № 27. Сogтууруулах ундаа, тамхи, үйлдвэрлэгч ААН-үүдийн үйл ажиллагаа

Үзүүлэлт	ААН-ийн тоо	Тогтмол	Тогтмол бус	Үйл ажиллагаа явуулаагүй
Орон нутаг	39	11	5	23
Улаанбаатар	46	24	2	20
НИЙТ	85	35	7	43

Дотоодын архи, дарсны онцгой албан татвар


Манай улсын нийт архи, дарсны хэрэглээний 99 орчим хувийг дотоодод үйлдвэрлэдэг. Үүний дийлэнхи буюу 98 орчим хувийг “АПУ” ХК, “Спирт Бал Бурам” ХК, “Жем Интернэшнл” ХХК-иуд үйлдвэрлэж байна.



Энэ оны эхний 8 сарын байдлаар онцгой албан татвараар 95.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөн бөгөөд энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 136.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрнө гэж тооцож байна.

Харин 2018 онд архи, дарсны онцгой албан татварын орлогоор 142.6 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлнэ гэж тооцлоо.

Дотоодын тамхины онцгой албан татвар



Манай улс нийт тамхины хэрэглээнийхээ 30 гаруй хувийг дотоодоос, үлдэх хэсгийг импортоор худалдан авч байна. Энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр дотоодын тамхины онцгой албан татвараар 34.5 тэрбум

төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэх бол 2018 онд 36.2 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлнэ гэж төсөөлж байна.

Дотоодын пивоны онцгой албан татвар

Дотоодын пивоны үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд тогтмол өсөж байгаа бөгөөд энэ оны эхний 8 сарын гүйцэтгэлээр онцгой албан татварын орлогоор 16.2 тэрбум төгрөг




төвлөрсөн байна. Пивоны үйлдвэрлэл, борлуулалт энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 77.3 сая литрт хүрч, төсөвт 22.0 тэрбум төгрөг төвлөрүүлнэ гэж тооцсон.

Ирэх онд дотоодын пивоны үйлдвэрлэлийг энэ жилтэй ижил төвшинд байхаар тооцсон. Харин онцгой албан татварын хуулийн өөрчлөлтөөс хамаарч төсөвт төвлөрөх татварын орлогыг 23.7 тэрбум төгрөгөөр тооцлоо.

4.6.6. Импортын барааны татвар

Манай улсын импортын хэмжээ зарим томоохон төсөл болон барилга, уул уурхайн салбараас үүдэлтэй гадаадын шууд хөрөнгө оруулалт эрчимжсэнээс үүдэн нийт импорт 2011 онд 6.6 тэрбум ам.долларт хүрч, 2010 онтой харьцуулахад 2.1 дахин өссөн. Харин сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын өсөлт саарч, түүнийг дагасан хөрөнгө оруулалт буурсны улмаас манай улсын нийт импортын өсөлт 2016 оныг хүртэл тогтмол буурсаар ирсэн.

График № 21. Нийт импортын задаргаа (2006-2018 /тэрбум ам.доллар/)




Харин 2017 онд эдийн засаг сэргэж, уул уурхайн салбар идэвхжиж, түүнийг дагасан бусад салбарын үйл ажиллагаа өссөнтэй холбогдуулан 2018 оны төсвийн жилд нийт импортын хэмжээг 4.6 орчим тэрбум ам.доллар байхаар төсөөллөө.

Импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар

Төсөвт төвлөрөх импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 2017 оны эхний 8 сарын орлогын гүйцэтгэл, өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ зэрэг тоон мэдээлэлд үндэслэн тооцлоо.

График № 22. Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар (2006-2018/тэрбум төгрөг/)



Ирэх 2018 онд нийт импортын хэмжээг 4.6 тэрбум ам.доллар байхаар төсөөлж, гаалийн албан татвараар 536.9 тэрбум төгрөг, импортын нэмэгдсэн өртгийн албан татвараар 1,095.0 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлнэ гэж тооцлоо.

Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар

Монгол Улс жилд дунджаар 1.0 сая тонн автобензин, дизелийн түлш импортолж байсан бөгөөд уул уурхайн томоохон төслүүдийн хэрэгцээ, шаардлагын улмаас шатахууны импортын дийлэнх хэсгийг буюу 50-60 хувийг дизелийн түлш эзэлж байсан болно.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн бүтээн байгуулалтын ажил удааширсантай холбогдуулан шатахууны импортын биет хэмжээ хумигдсан бөгөөд 2016 оны сүүлийн хагас жилээс эхлэн ам.доллартай харьцах төгрөгийн ханш суларч, газрын тосны бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн зардал өсөж, улмаар нефтийн бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалтын үнэ өсөх нөхцөл байдал үүссэн билээ. Үүнтэй холбогдуулан Засгийн газар жижиглэн борлуулалтын үнийг тогтворжуулах зорилгоор яаралтай арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 109 дүгээр тогтоол, 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 166 дугаар тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор онцгой албан татварын хувь хэмжээг 3 удаа бууруулсан.

Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Валютын Сантай хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд сүүлийн 11 сарын хугацаанд 3 удаа бууруулсан автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хувь хэмжээг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар буцаан нэмэгдүүлэх төлөвлөгөө гаргаж, Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголд тусгасан. Тухайлбал, автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Засгийн газрын 2016 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан хэмжээнд, 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Засгийн газрын 2016 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан хэмжээнд хүргэхээр тохиролцсон.

Дээрх шийдвэрийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 207 дугаар тогтоолоор автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг Засгийн газрын 2016 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан хэмжээнд хүргэсэн билээ.


Энэ онд эдийн засаг сэргэж, уул уурхайн салбар идэвхжиж, түүнийг дагасан бусад салбарын үйл ажиллагаа өссөнтэй холбогдуулан Монгол Улс 2017 оны эхний 8 сарын байдлаар нийт 896.1 мянган тонн шатахуун импортолсон байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 65 хувиар буюу 354.1 мянган тонноор нэмэгдсэн байна. Энэхүү нэмэгдлийн дийлэнх хэсгийг дизелийн түлш эзэлж байгаа болно.

Ирэх 2018 онд ДНБ-ний өсөлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ, нийт импортын хэмжээ зэргийг харгалзан шатахууны импортыг энэ оны түвшинд хүрнэ гэж

төсөөлөн автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлогоор нийт 295.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлнэ гэж тооцлоо.

Суудлын автомашины онцгой албан татвар

График № 23. Импортын суудлын автомашины тоо, хэмжээ



Суудлын автомашины онцгой албан татварын хувьд Олон Улсын Валютын Сантай хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд автомашины хөдөлгүүрийн багтаамж, үйлдвэрлэсэн оноос хамааруулж онцгой албан татварыг нэмэгдүүлэх, мөн хос

тэжээлт, цахилгаан тэжээлт, хийгээр ажилладаг суудлын автомашины онцгой албан татварын хөнгөлөлтийг 50 хувиар бууруулахаар шийдвэрлэсэн.

Ирэх 2018 онд суудлын автомашины онцгой албан татварын орлогыг 2017 оны эхний 8 сарын орлогын гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэл, өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэл болон импортын тоо хэмжээ зэрэг тоон мэдээлэлд үндэслэн улсын төсөвт нийт 96.2 тэрбум төгрөг төвлөрнө гэж тооцлоо.

Импортын архи, дарс, тамхи, пивоны онцгой албан татвар

Олон Улсын Валютын Сантай хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд архи, тамхины онцгой албан татварын хувь хэмжээг 2018 оноос эхлэн үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн хүрээнд ирэх онд архи, тамхины онцгой албан татварыг 10 хувиар нэмэгдүүлэн тооцож нийт 0.4 сая литр архи, 2.0 сая литр дарс, 2,063.3 сая ширхэг янжуур тамхи, 7.4 сая литр шар айраг импортлоход, улсын төсөвт нийт 90.1 тэрбум төгрөг төвлөрүүлнэ гэж тооцлоо.

Хүснэгт № 28. Импортын архи, дарс, тамхины онцгой албан татвар (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017 ХБГ	2018 ТӨЛ
Импортын архи, дарсны	4.8	7.0	8.4	2.9	12.7	7.4	5.7	5.7	6.6
Импортын тамхины	20.1	27.9	46.1	68.1	87.6	73.0	78.1	74.5	81.2
Импортын пивоны	5.1	5.7	7.4	10.1	7.9	4.7	4.9	2.0	2.4

4.6.7. Автобензин, дизелийн түлшний албан татвар

Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу автобензин, дизелийн түлшний тонн тутамд татвар ногдуулдаг бөгөөд тус татварын орлого импортын хэмжээтэй шууд хамааралтай байдаг. Ирэх онд уг татварын орлогоор 12.1 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.



4.6.8. Бусад Татвар

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр

Ашигт малтмалын тухай хуульд 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг шинэчилж, тусгай зөвшөөрөл олголтыг дахин эхлүүлсэн. Ирэх онд нийт 10.3 сая га талбайг хамарсан 3,695 ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлд 37.0 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулна гэж тооцлоо.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Ирэх оны төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг олон улсын томоохон банк, санхүүгийн байгууллагаас хийсэн эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөлөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, эрдэс бүтээгдэхүүн олборлогч томоохон аж ахуйн нэгжүүдийн 2018 оны олборлолтын төлөвлөгөө, өмнөх онуудын экспортын хэмжээний мэдээлэл зэрэгт үндэслэн тооцлоо.



Ирэх онд “Оюу Толгой” ХХК 764.8 мянган тонн, “Эрдэнэт Үйлдвэр” ХХК 601.2 мянган тонн зэсийн баяжмал, үүсмэл ордод үйл ажиллагаа явуулдаг компаниуд 7.1 мянган тонн цэвэр зэс экспортлохоор төсвийн төсөлд тооцсон бөгөөд зэсийн салбараас нийт 1,004.6 тэрбум төгрөг, үүнээс 436.4 тэрбум төгрөгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо. Үнийн төсөөлөл гаргадаг олон улсын шинжээчдийн таамаглалд үндэслэн 2018 онд зэсийн зах зээлийн үнийг тонн тутамд 6,429.9 ам.доллар байхаар төсөөллөө.

Монголбанк, арилжааны банкнуудад тушаасан алтны хэмжээ 2016 онд 16.6 тонн байсан бол 2017 онд 17 тоннд хүрэх төлөвтэй байна. Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд ирэх жил 21.0 тонн алт тушаахаар төсөвт тооцов.

Түүнчлэн, “Оюу Толгой” ХХК-ийн экспортлох зэсийн баяжмалд нийт 8.8 тн алт агуулагдахаар тооцсон болно. Улмаар олон улсын шинжээчдийн таамаглалд үндэслэн 2018 онд нэг унци алтны үнийг 1,291.0 ам.доллар байхаар тооцлоо.

Ирэх оны төсөвт баяжуулсан коксжих нүүрсний үнийг тонн тутам 100.0 ам.доллар, боловсруулаагүй коксжих нүүрсний үнийг 60.0 ам.доллар байна гэж тооцлоо. Харин нүүрсний экспортын хэмжээг 32.2 сая тоннд хүрэхээр төсөөлсөн болно.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоор 2018 онд нийт 807.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр, үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 64.8 тэрбум төгрөг, Улсын төсөвт 264.7 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 477.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Агаарын бохирдлын төлбөр

Агаарын бохирдлын төлбөрийн орлогын дийлэнх буюу 90-ээс дээш хувийг нүүрсний үйлдвэрлэлээс бүрдүүлдэг. Иймд агаарын бохирдлын төлбөрийн орлогын өсөлт, бууралт нь манай улсын нүүрсний олборлолттой шууд хамааралтай байдаг. Ирэх оны төсвийн төсөлд агаарын бохирдлын төлбөрөөр 34.2 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо. Үүнээс нүүрсний үйлдвэрлэлд 32.2 тэрбум төгрөгийн, авто тээвэр, өөрөө явагч хэрэгсэлд 1.9 тэрбум төгрөгийн, органик бодис болон томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодист 0.1 тэрбум төгрөгийн агаарын бохирдлын төлбөр ногдуулахаар тооцлоо.

Гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамжийн орлого

Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлдэг хураамжийн орлогын 90 орчим хувь нь уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортоос, үлдсэн хувь нь бусад бараа бүтээгдэхүүнээс бүрдэж байна. Экспортлохоор төлөвлөж буй эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээ, бусад барааны хураамжийн өсөлтөд үндэслэн 2018 онд гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний хураамжийн орлого 62.5 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоохоор хуульчилсан бөгөөд 2018 онд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоор 18.0 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөхөөр байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөр

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хүрээнд 2018 онд тус орлогоор нийт 47.6 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөхөөр тооцсон. Үүний 90 орчим хувь буюу 41.6 тэрбум төгрөг нь ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөр, 3.8 тэрбум төгрөг нь ойн нөөц ашигласны төлбөрөөр, 0.3 тэрбум төгрөг нь байгалийн ургамал ашигласны төлбөрөөр, 1.9 тэрбум төгрөг нь ан амьтны нөөц ашигласны төлбөрөөр тус тус төвлөрүүлэхээр тооцлоо.


Усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг усны экологи, эдийн засгийн үнэлгээ, усны ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр болон усны төлбөрийн хувь хэмжээнд үндэслэн тооцсон болно.

Ан амьтан, ой мод, ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн саналд үндэслэж тооцлоо.

Газрын төлбөрийн орлого

Өнгөрсөн 2016 оны байдлаар газрын нэгдмэл санд бүртгэлтэй газрын нийт хэмжээ 156.4 сая га байсан бөгөөд үүний 73.4 хувь нь хөдөө аж ахуйн газар, 16.1 хувь нь тусгай хэрэгцээний газар, 9.1 хувь нь ойн сан бүхий газар, үлдсэн нь хот тосгон бусад суурин, зам шугам сүлжээ болон усны сан бүхий газар байна. Газрын төлбөрийн орлогын хэмжээ сүүлийн 10 жилд дунджаар 14.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График № 26. Газрын төлбөрийн орлого



Газрын төлбөрийн орлого 2006-2012 онд тогтмол өсөж байсан бөгөөд 2013 онд Нийслэл хотын газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын орлого 24.5 тэрбум төгрөгт хүрч огцом өссөн нь газрын төлбөрийн орлого 49 хувиар өсөхөд голлох нөлөөллийг үзүүлсэн байна. Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/307, А/309 дүгээр захирамжийн дагуу 2003 оноос хойш нийслэлийн нутаг дэвсгэрт дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалтын бус аргаар олгогдсон газрын эрх эзэмшигчдээс дуудлага худалдааны анхны үнийг нөхөн авах, хууль бусаар олгогдсон газрын эрхийг хүчингүй болгох замаар тухайн

газрыг дахин дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалтаар олгох нэг удаагийн шинж чанартай ажлыг зохион байгуулж, 2013 онд газрын дуудлага худалдаагаар 24.5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Харин 2014 оноос, Нийслэлийн газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын орлого тогтмол буурсан нь өнгөрсөн 3 жилийн орлогын бууралтад голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Ирэх онд улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоор 2018 онд нийт 53.9 тэрбум төгрөг төсөвт төвлөрөхөөс үндсэн газрын төлбөрийн орлогоор 52.7 тэрбум төгрөг төвлөрнө гэж тооцлоо.

4.7. Татварын бус орлого

Татварын бус орлого 2018 онд 922.9 тэрбум төгрөгт хүрнэ гэж тооцлоо. Үүнээс нийтлэг татварын бус орлогоор 812.5 тэрбум төгрөг, хөрөнгийн орлогоор 0.5 тэрбум төгрөг, тусламжийн орлогоор 110.0 тэрбум төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлэхээр байна.

Татварын бус орлого нь ирэх онд энэ оны тодотголын хэмжээнээс 47.2 тэрбум төгрөг буюу 5.4 хувиар өсөхөөр байна.

4.7.1. Хувьцааны ногдол ашиг

Төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн менежментийг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх замаар ногдол ашгийн орлогоор 79.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тусгалаа. Үүнээс 11.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт, 20.3 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт, 47.8 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв сангийн төсөвт тус тус төвлөрүүлэхээр байна. Ирээдүйн өв санд төвлөрүүлэх 47.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-аас төвлөрнө гэж тооцсон болно.

4.7.2. Газрын тосны орлого


Монгол Улсын хэмжээнд нийт 326.6 мянган километр квадрат талбайд 24 блок дээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан, газрын тосны хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байна. Үүнээс зөвхөн БНХАУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд болох “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Доншен газрын тос Монгол” ХХК-тай гэрээ байгуулсан “Тосон-Уул 19”, “Тамсаг 21”, “Зүүнбаян 97” зэрэг 3 талбай дээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт № 29. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд

№	Гэрээлэгч компани	БХГ-т талбай	Байршил
Олборлолтын талбай			
1	Петрочайна Дачин Тамсаг	Тосон-уул XIX	Дорнод
2	Петрочайна Дачин Тамсаг	Тамсаг XXI	
3	Доншен газрын тос Монгол	БХГ-97	Дорноговь
Хайгуулын талбай			
4	Монголиа Гладвилл Увс Петролиум	Увс I	Увс
5	Ренова илч	Хар-ус II	Ховд
6	Капкорп Монголиа	Богд IV	Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай
7	Капкорп Монголиа	Онги V	Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь
8	Импайр газ монголиа	Борзон VII	Өмнөговь
9	Өмнөд монголын газар нутгийн тос	Номгон IX	
10	Сансрын геологи хайгуул	Төхөм X /хойд/	Дундговь, Дорноговь
11	Монголын алт	Төхөм X /урд/	Дундговь, Дорноговь, Өмнөговь
12	Зон хэн юу тиан	Галба XI	Дорноговь, Өмнөговь
13	Гоби энерги партнерс	Цагаан-элс XIII	Дорноговь
14	Гоби энерги партнерс	Зүүнбаян XIV	Дорноговь
15	Голденсий петролеум	Тариач XV	Дорноговь, Сүхбаатар
16	Шэйман	Нялга XVI	Төв, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь
17	Магнай трейд	Баянтүмэн XVII	Дорнод
18	Эн Пи Ай	Хөхнуур XVIII	Дорнод
19	Петро Матад	Матад XX	Дорнод, Сүхбаатар
20	Шунхлай энерги	Сулинхээр XXIII	Дорноговь
21	Монголиа Шин Ий Энержи	Дарьганга XXIV	Сүхбаатар
22	Сансрын геологи хайгуул	Цайдам XXVI	Төв, Хэнтий, Улаанбаатар
23	Вульф петролеум	Сүхбаатар XXVII	Дорнод, Сүхбаатар, Хэнтий
24	Хонгконг Веллек Индастриал	Хэрлэнтохой XXVIII	Дорнод


Газрын тосны нийт экспортын 95.6% нь “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийнх байна, үлдсэн 4.4% нь “Доншен газрын тос” (Монгол) ХХК-ийн БХГ-97 талбайд байна.

График № 27. Газрын тосны экспорт 2006-2018



Гадаад зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалж, газрын тосны үнэ сүүлийн 3 жилийн хугацаанд тасралтгүй буурч, энэ оны эхний 8 сарын байдлаар нэг баррель түүхий тосны үнэ 45.3 ам.долларт хэлбэлзэж байна.

График № 28. Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ, түүний өсөлт, бууралт /2013.01-2017.07/



Ирэх онд газрын тосны нийт экспортын хэмжээг 8.1 сая баррель, нэг баррель газрын тосны үнэ 50 ам.доллараас доошгүй байна гэж төсөөлж, газрын тосны орлогоор улсын төсөвт нийт 223.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцлоо.

4.7.3. Навигацийн орлого

Навигацийн орлого нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөх дотоодын болон олон улсын агаарын хөлөгт үзүүлсэн аэро-навигацийн үйлчилгээний орлого, буулт, хөөрөлтийн орлого, зорчигч үйлчилгээний орлого болон онгоцны буудлын хоолойн үйлчилгээ, онгоц зогсолт зэрэг орлогуудаас бүрддэг болно.

График № 29. Нислэгийн тоо, навигацийн орлого 2006-2018



Манай улсын нутаг дэвсгэр дээгүүр жилд дунджаар дотоодын 20, олон улсын 380 гаруй авиа компанийн агаарын хөлгүүд ойролцоогоор 90 мянган удаа нисэж өнгөрдөг бөгөөд тэдгээрт үзүүлэх навигацийн үйлчилгээнээс олох орлого нь нийт навигацийн орлогын 90 гаруй хувийг дангаараа бүрдүүлдэг байна.

Манай улс PBN буюу үзүүлэлтэд суурилсан навигаци бүхий агаарын замыг нэвтрүүлэх ажлын хүрээнд энэ оны гуравдагуур сард агаарын замаа шинэчилсэн. Энэхүү агаарын зам нь нислэгийн компаниудад газартай холбогдон нэг цэгээс нөгөө цэг рүү нисэх шаардлагагүйгээр илүү шулуун шугамаар нисэх боломжийг олгож байгаа юм. Ингэснээр агаарын хөлгүүдийн туулах зам богиносч байгаа учир энэ хирээр төсөвт төвлөрүүлэх орлого багасах магадлалтай. Гэвч нөгөө талаас Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны А/266 дугаар тушаалаар гадаадын авиа компаниудын агаарын хөлгөөс авах навигацийн үйлчилгээний үнэлгээг агаарын хөлгийн хөөрөлтийн хүндийн жингээс хамааруулан шинэчлэн тогтоож, энэ оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа нь орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой байна.

Ирэх онд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өсөлт, дотоодын болон олон улсын нислэгийн өнгөрөлтийн тоо болон зардлын өсөлтөөс хамаарсан эрсдэлийг тооцож, навигацийн орлогоор нийт 167.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлнэ гэж тооцлоо.

4.7.4. Төсөвт байгууллагын өөрийн орлого

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГЫН 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Монгол Улсын 2018 оны төсвийн төсөлд төсөвт байгууллагын өөрийн орлогоор нийт 285.4 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо. Үүнээс 266.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт, 18.6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлэхээр байна. Төсөвт байгууллагын өөрийн орлогын задаргааг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хүснэгтлэн харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/тэрбум төгрөг/	
<i>Улсын төсөв</i>	266.8
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	75.1
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	52.7
Батлан хамгаалахын сайд	45.2
Эрүүл мэндийн сайд	29.4
Сангийн сайд	15.9
Хууль зүй, дотоод хэргийн сайд	15.5
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	15.0
Монгол Улсын Шадар сайд	4.8
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	4.7
Монгол Улсын Ерөнхий сайд	3.5
Зам, тээврийн хөгжлийн сайд	2.1
Гадаад харилцааны сайд	1.6
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	0.8

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	0.3
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	0.1
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	0.1
Үндэсний статистикийн хорооны дарга	0.0
<i>Орон нутгийн төсөв</i>	<i>18.6</i>
Нийт	285.4

4.7.5. Өмч хувьчлалын орлого

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах эрхийг Улсын Их Хурал, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт батлах бүрэн эрхийг Засгийн газарт олгосон.

Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах үндсэн чиглэл Улсын Их Хурлаар батлагдаагүй байгаа бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирэх онд дараах аж ахуйн нэгжүүдийг хувьчлах саналыг ирүүлсэн. Үүнд:

1. “Төрийн банк” ХХК;
2. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК;
3. “Арилжааны төлбөр тооцоо” ТӨХХК;
4. “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК;
5. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс салгаж, бие даасан хуулийн этгээд болгон хувьчлах;
6. “Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нийт хувьцааны 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;
7. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дулааны шугам сүлжээг салган түгээх сүлжээг хувьчлах.

“Төрийн банк” ХХК: Тус компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 78.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 2,091.6 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд компанийн эздийн өмч 180.5 тэрбум төгрөг, өр төлбөр, (хадгаламж, харилцах, бусад эх үүсвэр) 1,911.1 тэрбум төгрөг байна.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК: Тус компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 2.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 4.8 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд компанийн эздийн өмч 3.6 тэрбум төгрөг, (эздийн өмчийг бүрдүүлэх хувьцаа, хөрөнгийн дахин үнэлгээ, бусад хэсэг нь 22.4 тэрбум төгрөг, харин хуримтлагдсан алдагдал нь 18.8 тэрбум төгрөг) өр төлбөр 1.2 тэрбум төгрөг, авлага 157.5 сая төгрөг байна.

“Арилжааны төлбөр тооцоо” ТӨХК: Тус компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 60.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 992.7 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд компанийн эздийн өмч 900.6 сая төгрөг, өр төлбөр 92 сая төгрөг байна.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК: Тус компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 117.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 137.5 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд компанийн эздийн өмч 120.2 тэрбум төгрөг, өр төлбөр 17.4 тэрбум төгрөг, авлага 13.8 тэрбум төгрөг байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК: Тус компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 178.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 218.6 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд компанийн эздийн өмч 160.4 тэрбум төгрөг, өр төлбөр 58.2 тэрбум төгрөг, авлага 21.3 тэрбум төгрөг байна.

“Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК: Тус компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 39.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 43.2 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд компанийн эздийн өмч 40.7 тэрбум төгрөг, өр төлбөр 2.5 тэрбум төгрөг, авлага 1.9 тэрбум төгрөг байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК: Тус компани нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 57.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 60.2 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй бөгөөд үүнээс эздийн өмч 42.8 тэрбум төгрөг, өр төлбөр 17.4 тэрбум төгрөг, авлага 1.2 тэрбум төгрөг байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах үйл явц нь хугацаа шаарддаг тул ирэх онд дээрх аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд аудит хийх, хувьчлагдах хөрөнгийг бүртгэх, үнэлэх, хувьцааны доод үнийг тогтоох зэрэг бэлтгэл ажлыг хангаж ажиллахаар тооцов. Ирэх 2018 оны төсөвт өмч хувьчлалын орлогоор 31.2 тэрбум төгрөгөөс доошгүй орлогыг төвлөрүүлэхээр тооцлоо. Өмч хувьчлал амжилттай явагдаж нэмэгдэл орлого орсон тохиолдолд Засгийн газрын өрийн ачааллыг бууруулах, төсвийн хуримтлал үүсгэхэд ашиглана.

4.8.Тусламжийн орлого

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн төсөлд гадаад тусламжийн орлогоор нийт 110.0 тэрбум төгрөгийг эрүүл мэнд, боловсрол, хилийн боомтын нэвтрэх чадавхийг нэмэгдүүлэх, байгаль орчин, нийгмийн хамгааллын салбаруудад хэрэгжих төсөл хөтөлбөрийг гадаад орон, олон улсын байгууллагаас авч ашиглахаар тооцлоо. Тухайлбал, Монгол-Японы сургалтын эмнэлэг барих төсөл, БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр ерөнхий боловсролын сургууль барих төсөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

4.9. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ гэж заасан ба одоогийн байдлаар 250 гаруй төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Татварын зарлагын хэмжээ

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2015 онд 656.8 тэрбум төгрөг буюу нийт татварын орлогын 12.8 хувьтай тэнцэж байсан бол 2016 онд 908.3 тэрбум төгрөг буюу нийт татварын орлогын 18.3 хувьд хүрсэн байна. Энэ үзүүлэлт 2017 оны эхний хагас жилийн байдлаар 380.2 тэрбум төгрөг буюу нийт татварын орлогын 13.5 хувьд хүрээд байна.

Хүснэгт № 30. Татварын орлого, зарлагын харьцаа /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 оны эхний хагас жил	2017 ХБГ	2018 ТӨС
Нийт татварын орлого	5,121.3	4,951.0	2,817.1	5,646.3	6,295.0
Нийт татварын зардлын хэмжээ	656.8	908.3	380.2	874.0	826.0
<i>Нийт татварын зарлагын татварын орлогод эзлэх хувь</i>	12.8%	18.3%	13.5%	15.5%	13.1%

Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Валютын Сантай хэрэгжүүлж буй Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, цаашид үе шаттайгаар бууруулахаар ажиллаж байгаа билээ.

Уг зорилтын хүрээнд төрөөс тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээд байна. Тухайлбал, 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталж, ХХОАТ-ын тухай хуулийн 16.1.16 дахь заалт буюу иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогыг татвараас чөлөөлөх заалтыг 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосон. Мөн Онцгой албан татварын тухай хуулийн 7.1.5-7.1.7 дахь заалт буюу хос тэжээлт, цахилгаан тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашиныг онцгой албан татвараас чөлөөлөх заалтыг хүчингүй болгож, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 50 хувиар хөнгөлөхөөр болсон.

Дээрх хуулийн өөрчлөлтүүд нь татварын зарлагын хэмжээг бууруулж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ 2017 онд 874.0 тэрбум төгрөг, 2018 онд 826.0 тэрбум төгрөгт хүрч улмаар 2019 онд 617.8 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Татварын зарлагын хэмжээг татварын хууль тус бүрээр хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт № 31. Татварын зарлагын хэмжээ 2015-2019 /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 ХБГ	2018 ТӨС	2019 ТӨС
НИЙТ ТАТВАРЫН ЗАРЛАГЫН ХЭМЖЭЭ	656.8	908.3	874.0	826.0	617.8
1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	59.0	296.6	313.4	329.1	122.7
<i>Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь</i>	<i>7.0%</i>	<i>32.7%</i>	<i>35.9%</i>	<i>39.8%</i>	<i>19.9%</i>
2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	313.2	251.0	204.0	213.1	219.5
<i>Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь</i>	<i>37.2%</i>	<i>27.6%</i>	<i>23.3%</i>	<i>25.8%</i>	<i>35.5%</i>
3 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	47.2	45.7	47.7	49.4	46.5
<i>Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь</i>	<i>5.6%</i>	<i>5.0%</i>	<i>5.5%</i>	<i>6.0%</i>	<i>7.5%</i>
4 Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	102.7	121.3	120.4	125.2	137.4
<i>Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь</i>	<i>12.2%</i>	<i>13.4%</i>	<i>13.8%</i>	<i>15.2%</i>	<i>22.2%</i>
5 Онцгой албан татварын тухай хууль	134.5	193.7	188.5	109.2	91.7
<i>Хөнгөлөлт, чөлөөлөлтөд эзлэх хувь</i>	<i>16.0%</i>	<i>21.3%</i>	<i>21.6%</i>	<i>13.2%</i>	<i>14.8%</i>

Ирэх онд татварын хөнгөлөлт чөлөөлтийг бууруулах бодлого баримталж ажиллана.

4.10. Монгол Улсын 2018 оны төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэл

Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн хэлбэлзэл төсөөлсөн хэмжээнээс хэт бага, эсхүл өндөр байх нь төсвийн орлого бүрдүүлэлтэд материаллаг нөлөө үзүүлнэ. Үнийн төсөөллөөс гадна гадаад болон дотоод зах зээлийн болон зах зээлийн бус нөхцөл байдлаас шалтгаалж уул уурхайн бүтээгдэхүүний экспортын болон үйлдвэрлэлийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл байна. Түүнчлэн, макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүд төлөвлөсөн хэмжээнээс хэт зөрүүтэй байх, гадаад тусламжийн орлого төлөвлөсөн хуваарийн дагуу төсөвт төвлөрөхгүй байх эрсдэл байгаа болно.

4.10.1. Уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ, үнэ

Зэс. Энэ 2017 оны эхний 8 сарын байдлаар нэг тонн цэвэр зэсийн үнэ Лондонгийн металлын бирж дээр 5,867.8 ам.долларт хэлбэлзсэн. Томоохон зэсийн уурхайд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдоноос үүдэн энэ оны эхний улиралд зэсийн үнэ тонн тутамд 5,833.1 ам.долларт хэлбэлзэж байсан бол зэсийн эрэлт буурсан, зэсийн нөөцийн хэмжээ өссөн зэргээс шалтгаалж зэсийн үнэ энэ оны 2 дугаар улиралд ялимгүй буурч, 5,661.8 ам.долларт хэлбэлзсэн. Гэвч ам.долларын ханшийн хэлбэлзэл, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, зэсийн нөөцийн бууралт зэргээс шалтгаалж зэсийн үнэ 2017 оны 7 дугаар сараас эхлэн дахин өсөж эхлээд байна.

Ирэх 2018 онд дэлхийн нийт цэвэр зэсийн үйлдвэрлэл 24.4 сая тонн, хэрэглээ 24.2 сая тонн байна гэж Австрали Улсын Аж үйлдвэр, инноваци, шинжлэх ухааны газраас нийтэлсэн

хэвлэлд тусгасан байна. Харин Олон Улсын Зэс Судлалын Групп 2018 онд дэлхийн зэсийн үйлдвэрлэл 24.2 сая тонн, зэсийн хэрэглээ 24.3 сая тонн байна гэж төсөөлсөн байна. Эдгээр төсөөллөөс харахад 2018 онд цэвэр зэсийн үйлдвэрлэл болон хэрэглээ харьцангуй тогтвортой, их хэмжээний илүүдэл, эсхүл хомсдол үүсэхгүй байх төсөөлөлтэй байна. Дэлхийн зэсийн нийлүүлэлтийн доголдол, зэсийн нөөцийн хэмжээний хөдөлгөөн, БНХАУ болон БНЭУ-ын эдийн засгийн өсөлт болон ам.долларын ханшийн хэлбэлзлээс зэсийн үнэ хамаарах төлөвтэй байна. Зэсийн үнийн төсөөлөл хийдэг олон улсын банк, санхүүгийн байгууллагууд зах зээл дээрх нөхцөл байдал, өөрчлөлттэй уялдуулан өөрийн боловсруулсан үнийн төсөөллийг тогтмол өөрчилж байгаа болно.

Нүүрс. Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй баяжуулсан коксжих нүүрсний дундаж үнэ тонн тутамд 2017 оны эхний 8 сарын байдлаар 140.8 ам.долларт хэлбэлзсэн.

Энэ 2017 оны эхэнд Австрали Улсын Квинсленд мужид цаг агаарын байдал муудсан, экспортын боомт хүрдэг төмөр замын тээвэр саатсан зэргээс үүдэн коксжих нүүрсний үнэ 4 дүгээр сард тонн тутам нь 314.0 ам.долларт хүрсэн. Үүнээс хойш коксжих нүүрсний олборлолтын хэмжээнээс хамаарч нүүрсний үнэ буурч эхэлсэн бөгөөд 2017 оны 7 дугаар сарын 3-ны өдөр 149.8 ам.долларт хүрсэн. Гэвч энэ оны 7 дугаар сараас эхлэн БНХАУ-ын гангийн эрэлт нэмэгдсэн, Австрали Улсын нүүрсний тээвэр удааширсан, БНХАУ-ын эрх баригчид үр ашиг багатай нүүрсний уурхайнуудыг хаасан зэргээс шалтгаалж, коксжих нүүрсний үнэ дахин өсөж эхлээд байна. Гэвч бүтээгдэхүүний үнийн төсөөллийг хийдэг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын төсөөллөөс харахад коксжих нүүрсний үнэ ирэх саруудад буурахаар байна.

Түүнчлэн ирэх онд дэлхийн гангийн хэрэглээ 1,665 сая тонн, үйлдвэрлэл 1,666 сая тонн хүрнэ гэж Австрали Улсын Аж үйлдвэр, инноваци, шинжлэх ухааны газраас нийтэлсэн хэвлэлд тусгасан байна. Нөгөөтгээгүүр, тус хэвлэлд БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийг 2018 онд 800 орчим сая тонн болж, энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 5.0 орчим сая тонноор буурна гэж төсөөлсөн байна. Ийнхүү БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл буурах эрсдэл байгаа нь коксжих нүүрсний үнэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Хэрэв коксжих нүүрсний үнэ төлөвлөсөн хэмжээнээс 10 ам.доллараар буурвал 11.4 тэрбум төгрөгөөр, экспортын хэмжээ 1 сая тонноор буурвал төсвийн орлого 10.6 орчим тэрбум төгрөгөөр тус тус ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого буурах эрсдэлтэй байна.

Хүснэгт № 32. Төсвийн орлогод үзүүлэх нөлөөллийн тооцоо/тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	Болзошгүй бууралт
1	Нүүрсний үнэ 10 ам.доллараар буурах /АМНАТ/	11.4
2	Нүүрсний экспорт 1 сая тонноор буурах /АМНАТ/	10.6
3	Зэсийн үнэ 100 ам.доллараар буурах /АМНАТ/	7.6
4	Зэсийн баяжмалын хэмжээ 100,000 тонноор буурах /АМНАТ/	7.3

4.10.2. Импортын хэмжээ

Монгол Улсын төсвийн нийт орлогын 25 орчим хувь нь импортоос шууд хамааралтай байдаг. Сүүлийн жилүүдэд нийт импорт, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралтаас хамаарсан хүнд машин, механизм, тоног төхөөрөмжийн импорт эрс багассан нь төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд сөргөөр нөлөөлж ирсэн. Түүнчлэн, валютын ханш, инфляцын өсөлттэй холбогдуулан дотоодын хэрэглээ хумигдах нь импортоос хамаарсан орлого буурах эрсдэлийг дагуулдаг. Харин энэ онд эдийн засгийн идэвхжил, уул уурхайн салбар, түүнийг дагасан бусад салбарын үйл ажиллагаа өссөнтэй холбогдуулан импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар нэмэгдсэн байна. Импортын хэмжээ ийнхүү нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүний импорт 183.7 сая ам.доллар, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 55.5 сая ам.доллар, машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 116.3 сая ам.доллар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги 92.6 сая ам.доллараар өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Хэрэв импортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс буурах тохиолдолд 100 сая ам.доллар тутамд дунджаар 33.6 тэрбум төгрөгөөр төсвийн орлого тасрах эрсдэлтэй байна.


5. ТӨСВИЙН ЗАРЛАГА

5.1. 2018 оны нэгдсэн төсвийн зарлага

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн зарлагын төслийг боловсруулахад ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр, хууль тогтоомж, статистик хүн ам зүй, үнэ ханшны зэрэг өөрчлөлтүүд, түүнчлэн төрийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусгах чиглэл баримталлаа.

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 9,828.8 тэрбум төгрөгт хүрч 2017 оны эхний тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулбал 1,078.7 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар, 2017 оны 2 дахь тодотголын саналтай¹ харьцуулбал 580.2 тэрбум төгрөгөөр буюу 6.3 хувиар тус тус нэмэгдүүлж тооцлоо.

График № 30. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /их наяд төгрөг/




Төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2018 онд 32.4 хувьд буюу 2017 оны анх батлагдсан түвшинтэй ойролцоо байна. Энэ үзүүлэлт 2011 онд ДНБ-ий 46.1 хувьд хүрснээс хойш төсвийн зарлага 2015 он хүртэл буурсан үзүүлэлттэй боловч тухайн үед төсвөөс гадуур хэрэгжсэн зарлага, санхүүжилтийг оруулан тооцвол 2012-2016 онд жилд дунджаар ДНБ-ий 41-42 хувьтай тэнцэх хэмжээний зарцуулалт хийгдсэн байна. Засгийн газраас төсвийн нэгдмэл байдал, сахилга батыг хангах чиглэлийг баримталж дунд хугацааны төсвийн хүрээ болон холбогдох бодлогын өөрчлөлтүүд хийсний үр дүнд 2017 онд нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 32-33 хувьд хүрч буурсан бөгөөд 2018 онд уг үзүүлэлт 32.4 хувьтай байхаар төсөвлөж байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын өмнөх онтой харьцуулсан өсөлтийг сүүлийн 10 жилээр буюу 2005-2015 онд авч үзвэл жилд дунджаар 25-26 хувийн өсөлттэй, үүнээс 19

¹ Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн төслийг боловсруулах хугацаанд 2017 оны төсвийн 2 дахь тодотголын төслийн санал боловсруулах үйл явц давхцаж байгаа бөгөөд хоёрдох тодотголын дүнг 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл (ХБГ) гэж тооцсон болно.

хувийн өсөлт нь урсгал зардал өөрчлөгдсөнөөс, 6 хувийн өсөлт нь хөрөнгийн зардлын өөрчлөлтөөс тус тус шалтгаалсан байна. Харин 2016 оны сүүлийн хагас жилд төсвөөс гадуур хэрэгжиж байсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг нэгдсэн төсөвт тусгах бодлогын өөрчлөлт хийгдсэний улмаас тухайн онд нийт зарлагын өсөлт 33 хувьд хүрсэн байна.

График № 31. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтөд урсгал ба хөрөнгийн зардлын нөлөөлөл /хувиар/



Харин 2018 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлага 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 6.3 хувиар буюу 580.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэх ба үүнээс 5.5 хувь нь урсгал зардлын өөрчлөлтөөс, 2.3 хувь нь хөрөнгө оруулалтын зардлын өсөлтөөс, харин дамжуулан зээлийн эргэн төлөлт болон бусад шалтгаанаар эргэж төлөгдөх цэвэр зээл буурсантай холбоотойгоор -1.5 хувиар нийт өсөлтөд нөлөөлж байна.

Хүснэгт №33. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл, /тэрбум төгрөг/

Зардлын томсгосон бүлэг	2016 Гүйц	2017 Бат	2017 Тод 1	2017 Тод 2	2018 Төл	Зөрүү (2017 ХБГ-2018 Төл)	
						грб.төг	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,519.9	8,569.1	8,750.1	9,248.6	9,828.8	580.2	6.3%
А. УРСГАЛ ЗАРЛАГА	6,713.7	6,948.0	6,843.6	6,948.8	7,457.8	509.0	7.3%
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,304.6	1,483.9	1,579.7	1,887.8	2,102.3	214.5	11.4%
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	501.6	137.2	326.7	411.9	268.6	-143.3	-34.8%

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн өөрчлөлийг төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар авч үзвэл хөрөнгийн зардал 214.5 тэрбум төгрөгөөр, зээлийн хүүгийн зардал 124.0 тэрбум төгрөгөөр, татаас ба шилжүүлгийн зардал 203.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, харин эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 143.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

5.2. Төсвийн урсгал зарлага

Нэгдсэн төсвийн урсгал зардлын нийт хэмжээг 2018 онд 7,457.8 тэрбум төгрөг буюу 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулбал 509.0 тэрбум төгрөгөөр буюу 7.3 хувиар нэмэгдэхээр тооцож төслийг боловсруулав.

Хүснэгт № 34. Нэгдсэн төсвийн урсгал зардал /тэрбум төгрөг/

	2016 Гүйц	2017 Бат	2017 Тод 1	2017 Тод 2	2018 Төл	Зөрүү /2017ХБГ-2018Төл/	
						дүн	хувиар
А. УРСГАЛ ЗАРЛАГА	6,613.8	6,948.0	6,843.7	6,948.8	7,457.8	509.0	7.3%
1. Бараа, үйлчилгээний зардал	3,133.3	3,045.1	3,068.2	3,091.2	3,273.6	182.4	5.9%
1.1 Цалин, хөлс	1,746.8	1,744.9	1,746.3	1,764.4	1,790.2	25.8	1.5%
1.2 БҮ-ний бусад зардал	1,386.5	1,300.2	1,321.8	1,326.8	1,483.3	156.6	11.8%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	986.1	1,345.7	1,210.6	1,156.7	1,280.7	124.0	10.7%
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,494.4	2,557.2	2,564.9	2,700.9	2,903.5	202.6	7.5%

Ирэх онд зээлийн хүүгийн зардал 124.0 тэрбум төгрөгөөр буюу 10.7 хувиар, бараа үйлчилгээний зардал 182.4 тэрбум төгрөгөөр буюу 5.9 хувиар, татаас ба урсгал шилжүүлэг 202.6 тэрбум төгрөгөөр буюу 7.5 хувиар тус тус өссөн нь нийт урсгал зардлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Хүснэгт № 35. Урсгал зардлын өөрчлөлт, арга хэмжээ ба эдийн засгийн ангиллаар /тэрбум төгрөг/

Урсгал зардал	Үүнээс:					Урсгал шилж
	Цалин хөлс, НДШ	БҮБЗ	Хүү	Татаас	Урсгал шилж	
Урсгал зардлын өөрчлөлт	509.0	25.8	156.6	124.0	30.0	172.6
1. Тэтгэвэр нэмэгдүүлэх /халамж ба НДС-ийн тэтгэвэр/	136.9					136.9
2. Цалинтай ээж хөтөлбөр	72.8					72.8
3. Зээлийн хүүгийн зардал	124.1			124.1		
4. НДС-ийн тэтгэвэр авагчдын тооны өсөлтөөр нэмэгдэх	50.3					50.3
5. БСШУС-ын салбарын урсгал зардал	71.6	26.0	53.3		16.7	(22.8)
6. ЭМ-ийн салбарын урсгал зардал	36.1	4.8	29.7			1.7
7. Зорилтот бүлгийн өрхөд хүнсний талон, халамж	34.1					34.1
8. Нийслэлийн хот тохижилтын зардал	36.0		36.0			
9. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ	13.0		4.8		8.3	
10. Орон нутагт төрийн үйлчилгээг хүргэх, өвөлжилтийн эрсдэлийг бууруулах нөөц хөрөнгө	11.1		11.1			
11. Байр ашиглалтын тогтмол зардлууд нэмэгдсэн	8.4		8.4			
12. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа	15.8		15.8			
13. Өрх, сумын ЭМТ-өөс иргэдэд үзүүлэх үйлчилгээ	5.2					5.2
14. ЭМД-ийн сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлт	4.6					4.6
15. Үндэсний брэндийн зөвлөл	10.6		10.6			
16. Бусад урсгал зардлын өөрчлөлт	(121.6)	(5.0)	(13.1)	-	5.0	(110.2)

Нэгдсэн төсвийн урсгал зардлын нийт өөрчлөлтийн 26.9 хувь нь тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээнээс, 31.1 хувь нь хүн амын бүтцэд орж буй өөрчлөлт, хэрэгцээ шаардлагаар нийгмийн даатгал, боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын үр дүнд төвлөрсөн халаалтын системд холбогдсон, үнэ тариф өөрчлөгдсөн зэрэг шалтгааны улмаас зардал нэмэгдэж байна. Мөн зээлийн хүүгийн зардал өмнөх оны гүйцэтгэлээс нэмэгдэх, Олон улсын валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж орлого багатай эмзэг бүлгийг хамгаалах, гадаад зээл тусламжаас санхүүжих болон бусад нэг удаагийн

шинжтэй урсгал зардал буурсан зэрэг хүчин зүйлсээс нийт зарлагын өөрчлөлтийн 32 орчим хувь нь шалтгаалсан байна.

Хүснэгт № 36. Урсгал зардлын бүтэц: 2010-2018 оны төсөл /тэрбум төгрөг, урсгал зардалд эзлэх хувиар/

№	Зардлын төмсгөсөн ангилал	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
		гүйц	гүйц	гүйц	гүйц	гүйц	гүйц	гүйц	ХБГ	төсөл
	Урсгал зарлага	2,256.7	3,236.4	4,428.1	4,552.6	5,293.3	5,718.4	6,613.8	6,948.8	7,457.8
	1. Цалин хөлс	28.7%	24.8%	27.0%	30.8%	30.0%	29.9%	26.4%	25.4%	24.0%
	2. Бараа, үйлчилгээний бусад	23.0%	21.7%	19.3%	21.7%	20.1%	19.1%	20.9%	19.1%	19.9%
	3. Зээлийн хүү	1.9%	1.2%	2.8%	5.9%	9.5%	12.8%	14.9%	16.6%	17.2%
	4. Татаас, шилжүүлэг	46.4%	52.4%	50.8%	41.5%	40.4%	38.2%	37.7%	38.9%	38.9%

Нийт урсгал зардлыг бүтцийн хувьд авч үзвэл 2018 оны төсвийн төсөлд цалин хөлс 24 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 19.9 хувь, зээлийн хүүгийн зардал 17.2 хувь, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 38.9 хувьтай байна. Энэ нь 2010 оны гүйцэтгэлийн түвшинтэй харьцуулбал цалин хөлс ба бараа үйлчилгээний бусад зардал 4.0 орчим пунктээр, татаас ба шилжүүлгийн нийт зардал 7.5 пунктээр тус тус буурсан бол Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ өндөр байснаас шалтгаалж зээлийн үйлчилгээний төлбөр мөн хугацаанд 15.3 пунктээр өссөн байна.

Нэг. ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр

Нэн ядуу, эмзэгт бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасан хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгаанд хамрагдсан, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай буюу хамгийн бага орлоготой 27,0 мянган өрхийн 148.6 мянган иргэн хамрагдаж, жилд 17.9 тэрбум төгрөг /сард том хүн 13000 төгрөг, хүүхэд 6500 төгрөг/ зарцуулж байна.

Олон Улсын валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн эхний шатны үнэлгээний хүрээнд 2017 оны 3 дугаар улирлаас эхлэн Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээг 2 дахин, хүнсний дэмжлэгт сар тутам олгох мөнгөн дүнгийн хэмжээг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэхээр тохирсны дагуу нэмж шаардагдах хөрөнгийг хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хэмнэлтээс шилжүүлэхээр тооцлоо.

Орлого багатай эмзэг бүлэгт чиглэсэн халамжийн үйлчилгээг дан ганц хүнсний хангамжийн хөтөлбөрөөр хязгаарлахгүйгээр бусад үйлчилгээг хамтад нь хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж нийт 17.8 тэрбум төгрөгийг мөн дээрх зарчмаар тусгахаар тооцсон болно. Тухайлбал, Нийгмийн халамжийн тухай хуульд 2012 онд тусгасан боловч төсвөөс санхүүжилт хуваарилаагүйн улмаас өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу иргэдэд тэтгэмж олгох, тэнэмэл орон гэргүй иргэдэд Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.2.2-д заасан халуун хоол, цайгаар үйлчлэх зардлыг тусгав. Ингэхдээ олон улсын нийтлэг жишгээр энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны иргэд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих

арга хэмжээнд хамрагдсан байх, сургуулийн насны хүүхдүүдээ сургуульд бүрэн хамруулсан байх нөхцөлийг тавьж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт № 37. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд нэмж шаардагдах хөрөнгө

№	Тэтгэмж, тусламжийн төрөл	Шинээр нэмэгдэх хүний тоо /мян.хүн/	Сард олгох тэтгэмж болон дэмжлэг /төг/	Нэмж зарцуулах хөрөнгө /тэрб.төг/
НИЙТ		623.2	-	51.2
1	Хүнсний эрхийн бичиг /Хамрах хүрээг 2 дахин, мөнгөн дүнг 20 хүртэлх % нэмэгдүүлэх/	288.8	том хүн 16,000 хүүхэд 8,000	24.2
2	Хүнс тэжээлийн дэмжлэг авч байгаа нэн ядуу өрх, иргэдэд нөхцөлт мөнгөн тусламж олгох	73.6	15,000	16.6
3	Тэнэмэл, орон гэргүй иргэдэд халуун хоол, цайны зардал	0.8	9,500	1.2
4	Төрөөс ЭМД-ын шимтгэлийг нь хариуцах	160.0	4800	9.2

Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.7-д нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний шимтгэлийг улсын төсвөөс сар бүр санхүүжүүлнэ гэж заасан. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох босго оноог 360.1783 оноогоор шинэчлэн тогтоосноор 260.4 мянган хүний ЭМД-ын шимтгэлийг төр хариуцах шаардлагатай болох тул 9.2 тэрбум төгрөгийн зардлыг төсөлд нэмж тусгав.

Гол нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоог хэрэгжүүлж эхэлнэ.

Монгол Улсын Засгийн газар болон Олон улсын валютын сангийн хооронд 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т 2018 оноос эхлэн нийт эмийн 10 хувьд төвлөрсөн худалдан авалт хийх замаар эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 15 хувиар бууруулах боломжтой гэж үзсэн. Түүнчлэн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолд эм, эмнэлгийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоог бий болгох замаар үр ашгийг нэмэгдүүлэхийг даалгасан.

ЭМЯ-аас гаргасан судалгаагаар 2016 онд тендерээр худалдан авсан нийт эм, эмнэлгийн хэрэгслийн дүнд 53 орчим хувь нь эм, 23.5 хувь нь эмнэлгийн хэрэгсэл 23.5 хувь нь оношлуур эзэлж байна. Эрүүл мэндийн яам, АХБ-ны “Улсын эмнэлэгт боломжийн үнэтэй эмийн хүртээмжийг сайжруулах техникийн туслалцааны төсөл”-ийн дэмжлэгтэйгээр зарим нэр төрлийн нийтлэг хэрэглэгддэг эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалт хийх тогтолцоог нэвтрүүлэх бөгөөд ирэх жилд 8.3 тэрбум

төгрөгийн нийт өртөг бүхий 53 нэр төрлийн эмийг 7 шалгуур үзүүлэлтээр сонгож нэгдсэн худалдан авалт зарлахаар бэлтгэж байна².

Эдгээр сонгосон нэр төрлийн эмийн худалдан авалтаар анх 15 хувь буурах зорилт тавьж байгаа боловч импортоор авч буй эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас жил тутамд нэмэгдүүлэх хэрэгцээ сүүлийн жилүүдэд үүсэж байсан. Иймд 2018 оны төсөлд эдгээр эмийн зардлыг нэмэгдүүлэхгүйгээр 2016 оны суурь түвшинд байхаар тооцов.

Эмийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоо бий болгосноор эрүүл мэндийн салбарт зайлшгүй нийтлэг хэрэглэгддэг эм, эмнэлгийн хэрэгслийг чанартай, олон улсын зах зээлийн жишиг үнэд нийцсэн худалдан авалтыг улсын хэмжээнд ил тодоор хийх, үр ашиг нэмэгдэх, төсвийн зардлын өсөлтийг цаашид зохистой түвшинд хязгаарлах нөхцөл бүрдэх ач холбогдолтой байна.

Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг зорилтот бүлэгт чиглүүлнэ.

УИХ-ын 2016 оны 63 дугаар тогтоолын 1.1-т “*Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур эрэмбэлэгдсэн³ өрхийн хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгө олгох*” гэж, мөн УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолд “*хүүхдийн мөнгөн тэтгэмжийг байнгын зорилтот бүлэгт чиглүүлэх замаар нийт өрхийн 40 хувийг хамруулах, гарах хэмнэлтийг хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээ, багцын нэр төрлийг өргөжүүлэх, эмзэг бүлгийн орлого багатай өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд зарцуулах*” гэж тус тус заасан.

Засгийн газраас ОУВС-тай 2016 оны 5 дугаар сард анх тохирсон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт “хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг 2017 онд нийт хүүхдийн 60 хувьд олгох, 2018 оны 1 сарын 1-ээс эхлэн хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэн нийт өрхийн 40 хувьд⁴ олгох, 2019 онд нөхөж олгохоор урьд гаргасан УИХ, ЗГ-ын шийдвэрүүдийг хүчингүй болгох саналыг боловсруулан УИХ-аар 2017 оны төсвийн эхний тодотголын хамт шийдвэрлүүлсэн.

Харин Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн нийт өрхийн хүүхэд бүрд олгохоор тогтсон. Ингэхдээ 2017 оны 1 дүгээр сараас эхлэн тооцох, хүүдийн мөнгө аваагүй 40 хувьд эхний 6 сард ногдох мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох, харин 7 дугаар сараас бүх хүүхдэд олгохоор шийдвэрлэсэн.

ОУВС-аас 2017 оны 8 дугаар сард Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээг хийж 2018 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 60 хувийг

² Эрүүл мэндийн сайдын “Ерөнхий гэрээгээр эмийн худалдан авалтыг зохион байгуулах тухай” 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/319 дугаар тушаал батлагдсан

³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/152 дугаар тушаалын 1-т “Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр бэлэн мөнгө хэлбэрээр хүүхдийн мөнгө олгох босго оноог амьжиргааны түвшиний үнэлгээний 502,567 болон түүнээс доош оноогоор тогтоосугай” гэж заасан байна.

⁴ Энэ нийт хүүхдийн 50 орчим хувь болдог

хамруулахаар тохирсны дагуу ирэх жилд нийт 684.0 мянган хүүхдэд олгохоор тооцож 164.2 тэрбум төгрөг тусгав.

Сул орон тоонд нөхөн томилгоо хийхэд баримтлах горимыг үргэлжлүүлнэ.

ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд тохирсны дагуу 2017 оны 2 дугаар хагасаас эхлэн хөтөлбөрт дуусах хүртэл хугацаанд орон тооны хязгаарлалтын горим хэрэгжүүлж байна. Дээрх хугацаанд зөвхөн эрүүл мэнд, боловсрол, онцгой, цагдаагийн албанаас хоёр албан хаагч чөлөөлөгдсөн тохиолдолд нэг албан хаагчийг (2:1) нөхөн томилох, бусад бүх салбарт нөхөн томилгоо хийхгүй байх зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Энэхүү горимыг хэрэгжүүлж эхэлснээр 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр цалингийн сан 1.9 тэрбум төгрөгөөр буурч, 1,193 орон тоонд нөхөн томилгоог хязгаарлахаар байна. Эдгээр орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байснаар 2018 оны төсвийн жилд хамгийн багадаа 3.6 тэрбум төгрөгийн цалингийн сан хэмнэгдэхээр тооцов.

Судалгаагаар төрийн албанаас 2018 онд өндөр насны тэтгэвэрт гарах 4,079 албан хаагч байгаа бөгөөд тэдгээрт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид нийт 76.8 тэрбум төгрөг зарцуулахаар байна. Орон тооны хязгаарлалтын горимыг 2018 оны төсвийн жилд үргэлжлүүлснээр тухайн жилд тэтгэвэрт гарах төрийн албан хаагчийн суларсан орон тоонд нөхөн томилгоо хийхгүй (зарим салбарт 2:1 харьцаагаар нөхөн томило) гэж тооцвол нийт цалингийн сан 2018 онд 7.2 тэрбум төгрөгөөр, 2019 онд дунджаар 14.4 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

Хүснэгт № 37. Төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмж, хэмнэгдэх цалингийн зардал /тэрбум төгрөг/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Тэтгэмжид зарцуулах хөрөнгө	Хэмнэгдэх цалингийн сан	Нийт тэтгэвэрт гарах хүн	Үүнээс				
					Төрийн алба	Боловсрол	Эрүүл мэнд	Цэргийн	бусад
	НИЙТ	76.8	10.8	4,079	474	811	877	980	937
1	БСШУС-ын сайд	17.1	4.3	1,335	18	796	-	-	521
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	14.5	1.7	466	37	-	5	406	18
3	Орон нутгийн засаг захиргаа	2.6	0.9	241	147	-	-	-	94
4	Эрүүл мэндийн сайд	15.2	1.0	924	11	-	854	-	59
5	Монгол улсын ерөнхий сайд*	-	0.3	-	-	-	-	-	-
6	Монгол улсын шадар сайд	10.1	0.4	321	35	-	-	275	11
7	Сангийн сайд	0.7	0.3	62	59	-	-	-	3
8	Гадаад харилцааны сайд	0.5	0.2	19	15	-	-	-	4
9	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1.1	0.2	18	15	-	-	-	3
10	БУСАД ТЕЗ-д	15	1.5	693	137	15	18	299	224

Хөтөлбөрийн хугацаанд дээрх горимыг хэрэгжүүлэхдээ 1/ төрийн албан хаагчийг бүтцийн өөрчлөлтөөр олноор халахгүй байх, 2/төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөөлөгдсөн бол дээрх хугацаанд нөхөн томилгоо хийхгүйгээр ажил, үүргийн хуваарийг шинэчлэх, оновчтой тогтоох замаар ачааллыг нягтруулах, 3/хэрэв зайлшгүй шаардлагатай орон тоог нөхөн томилох

шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад дахин зохион байгуулалт хийх замаар хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

Төсвийн хяналт, сахилга батыг сайжруулахад чиглэсэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ОУВС-ын Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт заасны дагуу төсвийн хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор нийт төсвийн бодлого тодорхойлох, дунд болон урт хугацааны төсөөлөл хийх, аливаа төсөвт нөлөөлөх бодлогын томоохон шийдвэрүүдэд хараат бус төсвийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр УИХ-ын дэргэд байгуулна. Зөвлөлийн үйл ажиллагаанд жилд шаардагдах зардалд нийт 265.6 сая төгрөгийг нэмж төсөлд тусгалаа.

Мөн төсвийн сахилга батыг сайжруулахад чиглэсэн төсвийн шинэчлэл хийх зорилгоор төсөв хэлэлцэн батлах процесст зарчмын томоохон өөрчлөлт хийхээр ОУВС-ын ӨСХ-т тусгагдсан. Тухайлбал, Улсын Их Хурал нь Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж Засгийн газрын өргөн мэдүүлсэн жилийн төсөв, түүний тодотголыг хэлэлцэн батлахдаа нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, хэрэв тодорхой хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсвийн зардлыг нэмэгдүүлэх бол бусад хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлаас мөн хэмжээгээр бууруулдаг байх зарчмын өөрчлөлтийг холбогдох хуулиудад нэмэлт оруулж шийдвэрлэнэ.

Хоёр. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан онцлох арга хэмжээ

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр өмнөх жилүүдэд эхлүүлсэн арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газраас төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах, алдагдлыг үе шаттай бууруулж өрийн дарамтыг арилгах, макро тэнцвэрийг хадгалах чиглэлээр төсөв, санхүүгийн бодлого баримталж байгаа боловч Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан зорилтуудыг төсөв, санхүүгийн боломжтой уялдуулан үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг 2016 оноос хойш төсөвт тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүснэгт № 38. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан бөгөөд урсгал зардал шаардагдах зарим томоохон арга хэмжээний хэрэгжилт ба төсөөлөл 2016-2018 он /тэрбум төгрөг/

Д/д	Арга хэмжээ	ЗГҮАМХ- н дугаар	2016		2017		2018
			Бат	Гүйц	Бат	ХБГ	Төсөл
НИЙТ ДҮН			397.8	368.9	419.6	558.4	686.1
2016 онд хэрэгжиж эхэлсэн арга хэмжээ			397.8	368.9	374.5	464.5	416.1
1	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	3.3.12	223.2	218.8	161.5	266.0	164.2
2	Боловсролын зээлийн сан байгуулах	3.2.20	89.2	89.2	116.1	86.1	119.2
3	Өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээ болон оношилгоо шинжилгээний зардал	3.1.17	27.4	25.5	29.7	38.0	44.6
4	Элэг бүтэн Монгол хөтөлбөр	3.1.3	23.4	1.5	23.4	27.1	23.4
5	Геологийн хайгуул судалгааны ажил	2.59	9.3	9.3	13.3	13.3	13.3
6	Вакцинжуулалт	3.1.12	6.9	6.9	7.2	7.2	8.9
7	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт	4.1.5	5.0	4.3	5.0	5.0	16.9

8	Өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлэх	3.2.21	4.0	4.0	4.0	4.0	4.0
9	Соёл, урлаг хөгжүүлэх сан	3.2.50	1.0	1.0	1.0	1.0	1.0
10	Спортыг дэмжих сан	3.2.55	1.0	1.0	1.0	1.0	1.0
11	Ойжуулалт	4.2.7	2.8	2.8	5.8	9.3	10.3
12	Бусад		4.6	4.6	6.5	6.5	9.2
	2017 онд хэрэгжиж эхэлсэн арга хэмжээ		-	-	45.0	93.9	43.4
13	Насны хишиг	3.3.22			20.5	20.5	20.5
14	ЭМД сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ	3.1.2			10.2	10.2	10.2
15	Эрүүл мэндийг дэмжих сан	3.1.5			3.0	3.0	5.0
16	Улс, орон нутгийн өвс тэжээлийн аюулгүй нөөц	2.34				8.9	
17	Малын тэжээл бэлтгэхэд зээлийн дэмжлэг үзүүлэх	2.34				40.0	
18	Хилийн заставуудыг сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөр хангах; Гашуунсухайтын боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх	5.4.14			7.7	7.7	2.5
19	Бусад				3.6	3.6	6.7
	2018 онд хэрэгжиж эхлэх арга хэмжээ		-	-	-	-	226.6
20	Тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх	3.3.23					136.9
21	Цалинтай ээж хөтөлбөр	3.3.13-14, 3.3.32-34					72.9
22	Бусад						16.9

Тухайлбал 2016 оноос эхэлсэн бөгөөд он дамжин хэрэгжиж байгаа арга хэмжээнд 2018 оны төсөлд нийт 421.1 тэрбум төгрөг хуваарилагдсан бөгөөд үүнд боловсролын зээлийн санг байгуулж, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, соёл урлагийг хөгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг дэмжих зорилгоор байгуулагдсан Эрүүл мэндийг дэмжих сан, Спортыг дэмжих сан, Соёл, урлагийг хөгжүүлэн сангийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлж санхүүжилтийг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд шаардагдах хөрөнгийг төсвийн боломжтой уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээг эх орондоо авах боломжийг бүрдүүлж, тэдэнд учрах санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэг ажлууд амжилтай хэрэгжиж байна.

Харин 2017 оны төсвийн жилээс эхлэн хэрэгжсэн ахмад настай азай буурлууддаа насны хишиг олгох арга хэмжээг үргэлжлүүлэхэд 20.5 тэрбум төгрөг, иргэд болон даатгуулагчдыг өвчний эрсдэлээс сэргийлэх, эрт оношлох нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор ЭМД-ийн сангаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо шинжилгээг үргэлжлүүлэхэд 10.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар 2018 оны төсөлд тусгалаа.

Цаашид төсвийн боломжтой уялдуулан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан бодлогын зорилтуудыг хангах ажлыг үе шаттай нэмэгдүүлэх чиглэл баримталж байна.

Тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан индексжүүлж нэмэгдүүлнэ.

Нийгмийн хамгааллын тогтолцооноос тэтгэвэр авдаг нийт 460.8 мянган хүн байгаагийн 86.5 хувь нь нийгмийн даатгалын тогтолцоонд хамаарч байна. Өнөөдөр нийгмийн даатгалын өндөр насны дундаж тэтгэвэр 313.8 мянган төгрөг байгаа бол цэргийн алба хаасны тэтгэвэр 523.0 мянган төгрөг харин халамжийн тэтгэвэр 140.0

мянган төгрөг байгаа ба хамгийн сүүлд 2016 оны 6 дугаар сард тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2017-2018 оны гурван талт Улсын хэлэлцээрийн нэмэлт хэлэлцээрийг эхлүүлсэн ба энэ хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгож буй бүх төрлийн тэтгэврийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхээр хэлэлцэж байна.

Хүснэгт № 39. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол

Тэтгэврийн төрөл	Хамрагдах хүн /мян. хүн/	Дундаж тэтгэвэр /мян.төг/		Нэмж шаардагдах /тэрбум төг/
		2017 онд	2018 онд	
НИЙТ	465.5	277.8	300.0	136.9
1 Нийгмийн даатгалын тэтгэвэр	385.6	295.1	318.7	111.0
1.1 -Өндөр насны тэтгэвэр	290.7	314.0	339.1	88.6
1.2 -Тахир дутуугийн тэтгэвэр	74.3	233.0	251.6	17.5
1.3 -Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	20.6	243.0	262.4	4.9
2 Цэргийн алба хаасны тэтгэвэр	17.2	523.0	564.8	8.6
3 Нийгмийн халамжийн тэтгэвэр	62.7	140.0	151.2	17.3
3.1 -Өндөр насны тэтгэвэр	2.1	140.0	151.2	0.6
3.2 -Тахир дутуугийн тэтгэвэр	44.8	140.0	151.2	12.4
3.3 -Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	15.8	140.0	151.2	4.3

Нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр авагч нийт 393.6 мянган хүний авч байгаа тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд нийт 119.5 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов. Түүнчлэн нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авдаг 62.7 мянган хүний авч байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд 17.4 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар тооцлоо.

“Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.

Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 3.3.14-т “гурав хүртэлх насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөр, Өрх толгойлсон эх/эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль” батлагдаж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжинэ.

Хүснэгт № 40. Цалинтай ээж хөтөлбөрийн хамрах хүрээ, зарцуулах хөрөнгө /мянган хүн, тэрбум төгрөгөөр/

Хуулийн заалт	Тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Зарцуулах хөрөнгө	Тайлбар
НИЙТ		249.6	142.2	-
5.1.1.	Жирэмсэн эхийн тэтгэмж	98.0	19.8*	Одоо олгож байгаа
5.1.2.	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	135.0	81.0	Шинээр олгоно
5.1.3.	Ихэр хүүхдийн тэтгэмж	0.1	1.7	Одоо олгож байгаа
5.1.4.	Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	16.5	15.8	Шинээр олгоно

**Нийгмийн халамжийн тухай хуулиар энэ зардалд 2017 оны төсөвт 43.7 тэрбум төгрөг зарцуулагдаж байна.*

Шинээр батлагдсан дээрх хуулийн дагуу 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр, түүнчлэн 0-18 насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр тэтгэмж⁵ олгох ба тэтгэмжийн хэмжээг хүүхдээ асарч байгаа эхэд сарын 50.0 мянган төгрөг буюу улиралд 150.0 мянган төгрөг, өрх толгойлсон эх/эцэгт улиралд 240.0 мянган төгрөгөөр буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нийт 96.8 тэрбум төгрөг олгохоор байна. Харин шинэ хуулийн дагуу халамжийн сангаас олгох жирэмсэн эхийн тэтгэмж 2017 онтой харьцуулбал ирэх онд 23.9 тэрбум төгрөгөөр буурах тул цалинтай ээж хөтөлбөрт нэмж шаардагдах зардлын цэвэр өөрчлөлтийг нийт 72.8 тэрбум төгрөг байхаар төсөвлөв.

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардлыг нэмэгдүүлнэ. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2018 оны төсвийн төсөлд урсгал зардал 17.5 тэрбум төгрөг байхаар төсөвлөсөн нь 2017 оны түвшинтэй харьцуулбал 3.5 дахин нэмэгдэхээр байна.

Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд “Өнөөгийн байдал, боломжууд, агаарын бохирдлыг бууруулах шийдлүүд” гэсэн судалгааг Азийн хөгжлийн банкны төслийн ажлын хэсгээс хийсэн байна. Уг судалгааг Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, тэдгээрийн хэрэгжилтийн талаар нийслэлийн 6 дүүргийн 26 хорооны 780 айл өрхийн дунд явуулж, дараах санал зөвлөмжийг урьдчилсан байдлаар ирүүлээд байна. Үүнд:

1. Өрхийн амьжиргааны түвшин, газар зүйн байршил, дэд бүтцийн хүртээмж зэрэг нөхцөл байдлыг харгалзан богино болон дунд хугацаанд хэрэгжих боломжтой арга хэмжээнүүдийн хувилбарыг боловсруулж санал болгох;

2. Цахилгаан халаагуур нэвтрүүлэх, орон сууцаар хангах, сайжруулсан зуух болон утаа багатай түлшээр хангах зэрэг бусад арга хэрэгслүүд нь тус бүрдээ орлогын ялгаатай түвшин бүхий айл өрхүүдийн хэрэгцээнд таарсан, худалдан авах чадварт нийцсэн боломжит сонголтуудтай байхаар хэрэгжилтийг зохион байгуулах;

3. Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээ болон иргэдийн оролцоо, хүрэх үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр тогтмол хүргэдэг тогтолцоог бий болгох;

4. Иргэд, хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон орон нутаг, төр захиргааны аливаа байгууллагаас гаргаж буй үр дүнтэй санал санаачилгуудыг урт хугацаанд тогтвортой дэмжих;

5. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр санал болгож буй шийдлүүдэд иргэд нэг удаагийн их хэмжээний төлбөр хийхээс илүү дунд болон урт хугацаанд үе шаттай төлбөр хийх хувилбарыг илүүд үзэж байгаа нь судалгаагаар тогтоогдсон тул энэхүү хэрэгцээнд тохирсон хөнгөлөлттэй зээл, эсвэл түрээсийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх г.м.

Дээрх зөвлөмжийн хүрээнд АХБ-ны судалгааны багаас Засгийн газраас өнгөрсөн хугацаанд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын арга

⁵ Хүүхдийн тоонд төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг хамааруулна

хэмжээнээс айл өрхийг цахилгаан халаагуурт шилжихийг урамшуулах, сайжруулсан зуух буюу хагас коксжих боловсруулсан түлш хэрэглэдэг гэр хорооллын айл өрхийн тоог нэмэгдүүлж, шаардагдах зардлыг төсөвт тусгах нь богино болон дунд хугацаанд агаарын бохирдлыг бууруулахад хамгийн өндөр үр дүнтэй гэсэн үнэлгээ, дүгнэлтийг гаргасан байна.

Ялангуяа, цахилгаан халаагуур бүхий айл өрхийн тоо хязгаарлагдмал байгаа, мөн ердийн зуухнаас цахилгаан халаагуурт шилжих айл өрхийг нэмэгдүүлэх арга хэмжээ нь тодорхой хугацаа шаардагдах тул одоогийн нөхцөлд шөнийн тарифыг тэглэхээс илүүтэйгээр гэр хорооллын айл өрхийн ердийн зууханд ашиглагдах боломжтой сайжруулсан буюу хагас коксжих түлшний хэрэглээг нэмэгдүүлж, түүхий нүүрсний хэрэглээг бууруулах нь богино хугацаанд агаарын бохирдлыг бууруулах боломжит хувилбарын нэг байна.

Харин урт хугацаанд гэр хорооллын айл өрхийг нэгдсэн халаалтын системд холбох, цахилгаан халаагуур хэрэглэх айл өрхийн тоог нэмэгдүүлэх, орон сууцны зээлд хамрагдах шалгуур үзүүлэлтийг бууруулж гэр хорооллын өрхийг хамруулах нөхцөл, боломжийг бий болгох, хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Иймд дээрх судалгаа, зөвлөмжид нийцүүлэн Байгаль орчин аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яамнаас гаргасан саналыг үндэслэн 2017-2018 оны өвлийн улиралд агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн дараах арга хэмжээг урсгал төсвийн хүрээнд хэрэгжүүлэхээр тооцож төсөлд тусгалаа.

Хүснэгт № 40. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах урсгал зардал/тэрбум төгрөг/

№	Арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэмэгдэх төсөв
1	Шөнийн цахилгааны үнийн урамшуулал /айл өрх/	110,000	8.3
2	Сайжруулсан зуух	570	0.2
3	ЦДАШ-г шинэчлэх хүчин чадлыг өргөтгөх	15	2.1
4	Хэт ачаалагдсан дэд станц хүчин чадлыг нэмэгдүүлэх	36	0.8
5	Цахилгаан халаагуур /ширхэг/	5000	1.0
6	Боловсруулсан түлш /тонн/	1000	0.2
7	Хагас коксжсон түлшний үнийн хөнгөлөлт /тонн/	80,000	3.7
8	Сургалт, сурталчилгаа	3	0.1
9	Стандарт нормыг боловсруулж мөрдүүлэх	1	0.1
10	Мэдээлэл, сурталчилгааны төв байгуулах	4	0.4
11	Пенимикок дархлаажуулалтын вакцин /хамрагдах хүүхдийн тоо/-ЭМЯ	35,000	1.0
НИЙТ			17.5

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг тэлэх, цахилгааны шөнийн үнийн тарифыг хөнгөлөх арга хэмжээнд илүү олон өрх хамруулах зорилгоор шөнийн цахилгааны үнийн урамшуулалд Улаанбаатар хотын гэр хорооллын 110 мянган өрхийг хамруулахад 8.3 тэрбум төгрөг төсөвлөв.

Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот айл өрхөд 5000 ширхэг цахилгаан халаагуур, 570 ширхэг сайжруулсан зуух, 1000 тонн боловсруулсан түлш олгоход 1.4

тэрбум төгрөг, агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах гэр хорооллын 110 мянган айл өрхийг цахилгаанаар халаахад Сонгино-Хайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн 15 трансформаторын дэд өртөө, хэт ачаалагдсан 36 дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх, хүчин чадлыг өргөтгөх ажлыг гүйцэтгэхэд 2.9 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар тооцлоо.

Мөн АХБ-аас өгсөн зөвлөмжийн дагуу Засгийн газраас нийслэлийн гэр хорооллын айл өрхийг 80,000 тонн хагас коксжсон шахмал түлшийг хөнгөлөлттэй үнээр хангах, үүнтэй холбогдуулан түүхий нүүрс болон хагас боловсруулсан түлшний үнийн зөрүүний татаасанд 3,750.0 сая төгрөгийг зарцуулахаар тооцлоо.

Хүснэгт № 41. Гэр хорооллын айл өрхөд сайжруулсан түлшний үнийн хөнгөлөлт олгох

	Түлшний төрөл	1 тонн үнэ /мян төг/	Нийт үнэ /тэрб.төг/
1	Түүхий нүүрс /80 мян.тонн/	125.0	12.3
2	Хагас коксжсон шахмал нүүрс /80 мян.тонн/	200.0	16.0
3	ЗГ-аас олгох үнийн зөрүү /80 мян.тонн/	75.0	3.7

Мөн Төв суурин газрын агаарын бохирдол нь нэн түрүүнд хүүхдийн эрүүл мэндэд уушгины хатгааны өвчлөл, хүндрэл хэлбэрээр илэрч байна. Иймээс дэлхийн бусад оронд хэрэгжүүлж байгаа үр дүнтэй арга болох пенемикок дархлаажуулалтын товллолд үе шаттайгаар нэвтрүүлэх зорилгоор нийслэлийн 9 дүүргийн шинээр төрсөн 35.0 мянган хүүхдийг вакцинд хамруулахад шаардагдах 985.0 сая төгрөгийн зардлыг Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн төсөлд тусгалаа.

Гурав. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх болон зардалд нөлөөлж буй бусад арга хэмжээний талаар

Төсвийн урсгал зардлын өсөлтөд төрөөс үзүүлж байгаа эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо, төрийн үйлчилгээний хамрах хүрээний өргөжилт голлох нөлөөлөл үзүүлж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өргөжилт

Хот суурин газрын хүн амын өсөлт, нягтаршил, эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ялангуяа өндөр өртөг бүхий тусламж үйлчилгээний эрэлт жил бүр өсөн нэмэгдэж байна. Иймд дараах үндэслэлээр Эрүүл мэндийн сайдын багцын 2018 оны төсвийн төсөлд урсгал зардлыг 2017 оны тодотголын түвшинтэй харьцуулахад 51,899.4 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар нэмэгдүүлж төсөвлөлөө.

Хүснэгт № 42. ЭМС-ын багцын урсгал зардлыг нэмэгдүүлж буй арга хэмжээ /сая төгрөг/

№	Зардал нэмэгдүүлж буй шалтгаан, үндэслэл	Өөрчлөгдөх дүн	Нийт өсөлтөд эзлэх хувь
	Нийт нэмэгдэх урсгал зардал	51,899.4	100.0%
1	Өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	14,866.6	28.6%
2	Даатгуулагч иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээ нэмэгдэх	9,702.9	18.7%

3	Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардал /цусны хавдар, сүрьеэ, эрхтэн шилжүүлэх, дархлаа дарангуйлах, гемодиализ, уушгины хатгалгааны вакцин г.м/	9,967.6	19.2%
4	Шинээр ашиглалтад орж буй эмнэлэг, эмнэлгийн өргөтгөлийн улмаас нэмэгдэх үйл ажиллагааны зардал	6,386.1	12.3%
5	Өрх, сумын ЭМТ-ийн тарифын өөрчлөлт, тогтмол зардал	4,432.6	8.5%
6	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах урсгал зардал	2,500.0	4.8%
7	Эрүүл мэндийг дэмжих сан ба бусад	2,030.0	3.9%
8	Бусад	2,013.6	4.0%

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8-дахь хэсэгт зааснаар даатгуулагчдад үзүүлэх өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлөхөөр зохицуулагдсан. Үүний 2016 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн "Жагсаалт, журам батлах тухай" 07 дугаартай тогтоолоор 484 нэр төрлийн тусламж үйлчилгээг санхүүжүүлж эхэлсэн.


График № 32. Өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээний тоо хэмжээ, зардал



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

Өндөр өртөгтэй мэс заслын эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, даатгуулагч иргэдийн хамрагдах боломжоор тэгш хангах нь иргэдэд учирч байгаа санхүү, төлбөрийн дарамтыг бууруулах, гадагш чиглэж байгаа эрүүл мэндийн төлбөрийн урсгалыг бууруулах, улмаар дотоодын эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх ач холбогдолтой байна.

График № 33. Хэвтүүлэн эмчлэх болон оношилгоо, шинжилгээний тоо хэмжээ, зардал



Түүнчлэн төрөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний нэр төрөл, цар хүрээний өргөжилт, хүн амын өсөлт, манай оронд оношилж эмчлэхэд хүндрэлтэй байгаа зарим өвчнийг оношлох, эмчлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн зэргээс шалтгаалж, эмнэлгийн тусламж үйлчилгээний тоо нэмэгдэх хандлагатай байна.

Боловсролын салбарын урсгал зардлын өөрчлөлт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт ирэх онд хүн ам, статистикийн өөрчлөлт, шинэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор 81.5 тэрбум төгрөг нэмэгдэхээр байна.

Хүснэгт № 43. Боловсрол, соёл, ШУ, спортын арга хэмжээний зардлын өөрчлөлт /тэрбум төгрөг/

Байгууллага/арга хэмжээ	2017 Тод	2018 Төсөл	Өөрчлөлт
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН СПОРТ	963.10	1,045.90	81.5
Орон нутгийн төсөв /Тусгай зориулалтын шилжүүлэг/	919.9	968.5	47.4
1. Ерөнхий боловсролын сургууль	589.7	613.9	19.7
2. Хүүхдийн цэцэрлэг	276.2	296.1	23.4
3. Соёл урлагийн байгууллагууд	43.2	45.6	2.3
4. Биеийн тамир спортын газар	10.8	12.8	2.0
Улсын төсөв	43.2	77.4	34.1
1. Хүүхэд харах үйлчилгээ	0.0	6.5	6.5
2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10.3	15.3	5.0
3. Улсын шигшээ багийн бэлтгэл цугларалт, ү/а-ны зардал	9.0	13.1	4.0
4. Зарим суралцагч (нэн ядуу, малчин, 3 суралцагч)-дад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг	8.6	12.6	4.0
5. АШУҮИС-ийн харьяа эмнэлэг	0.0	3.2	3.2
6. Холбооны суваг ашигласны хөлс	1.3	4.2	3.0
7. Тусгай хэрэгцээт 116, 29 дугаар сургууль	0.0	2.8	2.8
8. Төрийн өмчит их, дээд сургуулиудын тогтмол зардлыг санхүүжүүлэх	6.7	8.9	2.2
9. Өрсөлдөөнт тэтгэлэг хөтөлбөр хэрэгжүүлэх	0.0	1.5	1.5
10. Шинээр ашиглалтад орсон объектын байр ашиглалтын зардал	0.5	1.3	0.8
11. Боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх	0.9	1.2	0.3
12. ЗГ-ын гэрээгээр гадаадад, гадаадаас МУ-д суралцагчийн тэтгэмж	4.5	4.8	0.3
13. Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдын урамшуулал	1.4	1.6	0.2
14. БСШУСЯ-ны харьяа бусад байгууллагуудын ү/а-ны зардал		0.5	0.5

Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж байгаатай тул боловсролын үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж байна. Ирэх 2018 онд төрийн өмчийн цэцэрлэгт 7.8 мянган хүүхэд, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд суралцагч хүүхдийн тоо нийт 30.7 мянгаар нэмэгдэхээр байгааг харгалзан нэг хүүхдээр тооцсон хувьсах зардлыг нийт 21.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцов.

Хувийн хэвшлийн сургуульд 5.9 мянга, цэцэрлэгт 9.0 мянган хүүхэд суралцаж байна. Төрөөс иргэдэд зайлшгүй үзүүлэх шаардлагатай сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж байгаа хувийн хэвшлийн боловсролын

байгууллагуудад хууль тогтоомжид заасны дагуу олгох хувьсах зардлыг нийт 13.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсөлд тооцлоо.

Аймаг, орон нутагт шинээр ашиглалтад орж байгаа 4 усан спорт цогцолбор, мөн шинээр ашиглалтад орж байгаа 2 аймгийн театр, 1 сумын соёлын төв, 1 орон нутгийн музей, шинжлэх ухааны 1 хүрээлэн, лабораторийн цогцолборын урсгал зардал болон зарим байгууллагад өмнө нь үүссэн өр төлбөр зэрийг барагдуулахад зориулж 6.5 тэрбум төгрөг төсөвлөв.

Шинээр ашиглалтад орж байгаа 49 ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, дотуур байр, спорт заал, өргөтгөлтэй холбоотойгоор 22.5 тэрбум төгрөг, шинэ 26 хүүхдийн цэцэрлэг, өргөтгөлтэй холбоотойгоор 2.8 тэрбум төгрөг тус тус төсвийн төсөлд нэмэгдүүлэн тусгалаа.

МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ШУ-ны эрдэм, шинжилгээнд төсвөөс зарцуулж байгаа зардлыг 3 дахин нэмэгдүүлнэ гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны төсвийн тодотголын түвшингээс 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тусгав.

Шинэ зууны боловсрол төслийн хөрөнгө оруулалтаар төрийн болон орон нутгийн өмчийн нийт 800 орчим сургууль 1200 цэцэрлэгийг сумын төв дотор шилэн кабелиар холбож, боловсролын салбарын нэгдсэн мэдээллийн системийг бий болгоод байна. Уг мэдээллийн системийн УБ-аймаг-сум хооронд мэдээдэл дамжуулахтай холбоотойгоор гарах сувагчлалтай холбоотой зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон НББСШУ-ны Байнгын хорооны 2017 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өрсөлдөөнт тэтгэлэг хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэхэд зориулж 1.5 тэрбум төгрөг тусгалаа.

Мөн хүүхэд харах үйлчилгээг боловсролын байгууллагад хариуцуулах хууль эрх зүйн зохицуулалтыг боловсруулж, хүүхэд харах үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай 6.5 тэрбум төгрөгийн зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад шилжүүлэх зохицуулалтыг төсөлд тусгав.

Япон улсын буцалтгүй тусламжаар Монгол Японы сургалтын эмнэлгийг барих 181.4 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжиж олон улсын өндөр стандартын эмнэлгийн тусламж үйлчилгээг их сургууль дээр суурилан ард иргэдэд хүргэх боломжтой болж байгаа бөгөөд мөн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь анх удаа эмнэл зүйн сургалт, судалгааг явуулах бааз эмнэлэгтэй болж өндөр түвшний боловсон хүчнийг бэлтгэх боломж бүрдээд байна. Эмнэлэг нь амбулаториор өдөрт 600 жилд 192 мянган хүнд, хэвтэн эмчлүүлэхээр 4300 орчим хүнд үйлчилж ойролцоогоор 2300 орчим мэс засал, 10 гаруй мянган дүрс оношилгооны ажилбарыг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Иймд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дэргэдэх сургалтын эмнэлгийн үйл ажиллагааг 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлэхээр тооцож 3,178.0 сая төгрөгийн урсгал зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

Статистик, хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн зардлын өөрчлөлт

Нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдаж үр ашгийг нь хүртэгчдийн тоо жил бүр нэмэгдэж байна. Ирэх онд эрүүл мэндийн даатгалыг тооцохгүйгээр 1,058.5 мянган хүн нийгмийн даатгалд хамрагдахаар байгаа нь 2017 онтой харьцуулахад 15.4 мянгаар нэмэгдэхээр байна. Энэ нь улсын хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байгаа иргэдийн 90.7 орчим хувь нь болж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тооны цэвэр өсөлт 9.8 мянгад хүрэхээр байгаа нь тэтгэврийн зардал 35.1 тэрбумаар нэмэгдэхэд нөлөөлж байна. Мөн улсын хэмжээний цалин хөлсний өсөлтөөс⁶ шалтгаалж тэтгэврийн зардал 18.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Хэдийгээр нийгмийн даатгалд хамрагдах хүний тоо, шимтгэлийн орлого жил бүр нэмэгдэж байгаа боловч хүн амын насжилттай холбоотойгоор тэтгэврийн зардал хурдацтайгаар нэмэгдэж байна. Дэлхийн хүн амын дундаж насжилт 1950 оноос хойш 10 жил тутамд 3-аас дээш насаар нэмэгдсэн байна⁷. Статистик судалгаанаас үзэхэд хүн амын тоо сүүлийн 10 жилд 16.1 хувиар өссөн бол мөн хугацаанд ахмад настны тоо 21.9 хувиар өссөн байна.

Хөдөө аж ахуйн салбарын урсгал зардлын өөрчлөлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын улсын төсвөөс санхүүжих урсгал зардал өмнөх оны түвшинтэй харьцуулахад 16.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 44. Хөдөө аж ахуй /тэрбум төгрөг/

Зардал нэмэгдүүлж буй арга хэмжээ	2017 Тод	2018 Төс	Өөрчлөлт
1. Малын халдварт, архаг болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	20.3	23.5	3.2
2. Малын өвчний лабораторийн оношилгоо шинжилгээ	0.7	1.4	0.7
3. Жимс, жимсгэний тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	-	3.0	3.0
4. Мах сүүний анхдугаар аян хөтөлбөр	-	2.0	2.0
5. Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилт	-	2.0	2.0
6. ХАА-н бусад хөтөлбөр, арга хэмжээ /хоршоо, үйлчилгээ, үйлдвэрлэл, ноолуур г.м/	1.3	4.6	3.3
7. Зээлийн хүүгийн татаас	4.5	6.5	1.9
НИЙТ ДҮН			16.1

Мал амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, лабораторийн оношилгоо шинжилгээний зардлыг нийт 3.9 тэрбум төгрөгөөр өмнөх онтой харьцуулбал нэмэгдүүлж тооцов.

Өвөлжилт хүндэрч болзошгүй нөхцөл байдлын улмаас малчид дотоодын зах зээлд махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нөхцөлд Мах боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгжүүд 2017 оны намар, өвлийн улиралд мах худалдан авахад шаардлагатай эх үүсвэрийг арилжааны банкнаас зээл авах хэлбэрээр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

⁶ Улсын хэмжээнд аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2016 онд 6.6 хувиар өссөн байна. ҮСХ 2016

⁷ Эрүүл мэндийн үзүүлэлт -2016 тайлан. ЭМХТ 2016.

зорилгоор улсын төсвөөс зээлийн хүүний хөнгөлөлт, татаас олгохоор тооцож 2018 оны төсвийн жилд 6.5 тэрбум төгрөг төсөвлөв. Энэ нь 2017 оны түвшинтэй харьцуулбал 1.9 орчим тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөтөлбөр арга хэмжээний зардлыг 6.5 тэрбум төгрөгөөр нэмж тооцсон. Үүнээс Мах сүүний анхдугаар аяныг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2.0 тэрбум төгрөг, Жимс, жимсгэнэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1.0 тэрбум төгрөг, Малын генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2.0 тэрбум төгрөг, Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр болон Ноолуур хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд 1.0 тэрбум төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарт бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд 500.0 сая төгрөгийг тус тус тусгасан.

Байр ашиглалтын тогтмол зардал

Урсгал зардлын өсөлтөд нөлөөлж байгаа өөр нэг хүчин зүйл бол зах зээл дэх бараа, ажил үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлтөөс үүдэлтэй төсвийн байгууллагуудын байр ашиглалтын тогтмол зардлын өсөлт юм. Тухайлбал, ирэх онд төрийн байгууллагуудын тогтмол зардлын өсөлт 37.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаагаас боловсролын салбарт 26.3 тэрбум буюу нийт өсөлтийн 70.0 хувь нь оногдож байна.

Хүснэгт № 45. Байр ашиглалтын тогтмол зардлын өсөлт /тэрбум төгрөгөөр/

Зардлын төрөл	Нийт өсөлт		Үүнээс:					
			Боловсрол		Эрүүл мэнд		Бусад	
	дүн	%	дүн	%	дүн	%	дүн	%
НИЙТ	37.8	100%	26.3	100%	3.1	100%	8.3	100%
1. Гэрэл, цахилгаан	5.9	16%	2.8	11%	0.4	16%	2.6	31%
2. Түлш, халаалт	28.2	75%	21.6	82%	2.0	68%	4.5	54%
3. Цэвэр, бохир ус	3.4	9%	2.0	8%	0.54	17%	0.87	10%
4. Байрны түрээс	0.2	1%	-0.1	-0.5%	-0.02	-1%	0.4	4%

Зардлын төрлөөр нь авч үзвэл нийт өсөлтийн 75 хувийг түлш халаалтын зардал эзэлж байгаа бол байрны түрээсийн зардал харьцангуй тогтвортой буюу нийт зардлын 1.0 хувийг эзэлж байна.

Түлш халаалтын зардал өсөхөд нөлөөлж байгаа гол шалтгаан нь сум, орон нутагт төвлөрсөн дулаан хангамжтай болсноор сумын төвийн төсвийн байгууллага болох сургууль, эмнэлэг, цэцэрлэг, соёлын төв, сумын ЗДТГ болон ИТХ-ын түлш, халаалтын зардал нэмэгдэж байна.

Орон тоо, хүний нөөцийн зардал

Нэгдсэн төсвийн урсгал зардалд ирэх онд нийт 4,053 орон тоог санхүүжүүлэхэд нийт 53.7 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон ба нийт нэмэгдэх зардлын 76 хувь нь цалин хөлс, үлдэх хэсэг нь үйл ажиллагааны бусад зардалд ногдож байна.

Хүснэгт № 46. Орон тооны өөрчлөлтийн судалгаа /тэрбум төгрөг/

Шалтгаан, хүчин зүйлс	Орон тоо	Урсгал зардал	Үүнээс	
			Цалин	ҮА-ны зардал
Нийт:	4,053	53.5	42.6	13.6

1.	Шинээр байгуулагдсан, өргөтгөл хийгдсэн эмнэлэг	1,198	15.6	7.5	8.1
2.	Шинээр ашиглалтанд орж байгаа сургууль, цэцэрлэг болон хүүхдийн тооны өсөлтөөс нэмэгдэх анги, бүлэг	2,283	26.8	25.1	1.7
3.	Шинэ байгуулагдах гал унтраах анги, эрэн хайх, аврах бүлэг	280	4.3	3.2	1.1
4.	Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудал болон хилийн зарим боомтын үйл ажиллагааг өргөжүүлэх	292	4.1	4.1	2.5

Орон тоо нэмэгдэхэд нөлөөлж буй гол шалтгаан нь сургууль, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо өссөн болон шинэ хөрөнгө оруулалтын улмаас боловсролын салбарт нэмэгдэж буй багш, ажиллагсдын тооноос 56.1 хувь, шинээр байгуулагдсан эмнэлэг, өргөтгөл ашиглалтад орсны улмаас 30.0 хувь, хүн ам ихээр төвлөрсөн зарим аймгийн сумдад ой хээрийн болон ахуйн гал түймэр, аюул ослоос аврах, гал унтраах анги шинээр байгуулсантай холбогдуулан 7.0 орчим хувь, шинээр ашиглалтад орох болон одоо үйл ажиллагаа явуулж буй зарим боомтын хүчин чадлыг сайжруулахтай холбогдуулан 7.2 хувиар тус тус нөлөөлсөн байна.

Хүснэгт № 47. Орон тооны өсөлт /Төсвийн ерөнхийлөн захиргагчдаар/

Төсвийн ерөнхийлөн захирагч	Албан тушаалын зэрэглэл					Нийт
	ТТ	ТЗ	ТҮ	ТҮБД	ТҮЭМ	
Нийт:	605	64	260	2,036	1,088	4,053
Батлан хамгаалахын сайд	-	-	-	-	239	239
Монгол улсын шадар сайд	280	64	-	-	-	344
Сангийн сайд	99	-	-	-	-	99
Хууль зүй, дотоод хэргийн сайд	226	-	-	-	-	226
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	-	-	13	-	-	13
Эрүүл мэндийн сайд	-	-	-	-	849	849
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	-	-	247	2,036	-	2,283

Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд прокуроруудад захиргааны зөрчил болон эрүүгийн хэргүүдэд хяналт тавих ачаалал нэмэгдэж байгаатай холбоотойгоор зөрчлийн асуудлаар дагнасан аймаг, нийслэлийн прокурорын газарт 20 прокурорын орон тоо, цалингийн зард 700.0 сая төгрөг, Эрүүгийн болон зөрчлийн хуулийн дагуу эрүү, захиргааны хэргийн шүүхийн ачаалал нэмэгдэхтэй холбоотойгоор эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 34 шүүгч, захиргааны хэргийн шүүхийн шүүгч 7 шүүгч, 41 шүүгчийн туслах, 21 нарийн бичгийн даргын орон тоо, цалингийн зардал 2,020.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр

Монгол Улсын Засгийн газар гадаад орон, олон улсын байгууллагаас авч ашигласан арилжааны, хөтөлбөрийн, хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээл, Засгийн газрын зүгээс олон улс болон дотоодын зах зээлд гаргасан үнэт цаас, Засгийн газрын хийсэн бусад зээллэгтэй холбогдолтой хүүгийн төлбөр, холбогдох бусад төлбөрийн үүргийг гэрээнд заасан хуваарийн дагуу эргэн төлөх үйл ажиллагаанд 2018 онд нийт 1,280.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар байна. Зээлийн үйлчилгээний төлбөрийн

дүнг 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл буюу 2 дахь тодотголын саналтай харьцуулахад **124.1 тэрбум** төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Орон нутгийн төсвийн суурь зарлага

Энэ онд буюу 2017 оны 2 дугаар улирлын байдлаар нийт нутгийн 43 хувь нь гандуу, 34 хувь нь гантай байсны улмаас газар тариалангийн салбарт ургац алдах, мөн бэлчээрийн гарц багатайгаас шалтгаалж мал өвөлжилт хүндэрч болзошгүй, мөн 2016-2017 онд мал амьтын гоц халдварт өвчин зарим нутгаар гарсан нь өвчний эрдслийг нэмэгдүүлж байгаа тул 2017-2018 онд шилжих өвөл, хаврын улиралд орон нутгийн нөөц хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Иймд орон нутгийн төсөвт дэмжлэг үзүүлэх зорилгоор тухайн аймаг орон нутгийн хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, байршил, малын тоо толгой зэргийг харгалзан аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн хэмжээг индексжүүлж орон нутгийн суурь зардлын хэмжээг 3,270.0 сая төгрөгөөр буюу нэг аймагт дунджаар 155.7 сая төгрөг нэмж хуваарилахаар төсвийн төсөлд тусгав.

Хүснэгт № 48. Нэмж хуваарилсан орон нутгийн нөөц хөрөнгө /аймгаар, сая төгрөг/

Аймаг	Сумын тоо	Хүн ам /мян.хүн/	Газар нутаг /мян.км2/	Хүн амын нягтшил	Малын тоо /мян.толгой/	Нэмж хуваарилсан дүн
'01 Архангай	19	90,183.0	55.3	1.7	5,009.6	184.9
'02 Баян-Өлгий	13	97,043.0	45.7	2.2	2,167.4	126.1
'03 Баянхонгор	20	83,603.0	116.0	0.7	4,236.3	198.0
'04 Булган	17	59,199.0	48.7	1.2	3,485.6	149.5
'05 Говь-Алтай	20	56,018.0	141.4	0.4	3,497.5	190.5
'06 Дорноговь	14	60,825.0	109.5	0.6	1,752.9	135.5
'07 Дорнод	14	76,388.0	123.6	0.6	1,722.9	143.6
'08 Дундговь	15	44,178.0	74.7	0.6	3,059.9	138.7
'09 Завхан	24	69,916.0	82.5	0.9	3,406.2	196.5
'10 Өвөрхангай	19	109,289.0	62.9	1.8	5,208.6	194.3
'11 Өмнөговь	15	61,367.0	165.4	0.4	2,314.0	162.3
'12 Сүхбаатар	13	58,792.0	82.3	0.7	3,030.4	134.7
'13 Сэлэнгэ	17	104,775.0	41.2	2.6	1,599.8	141.4
'14 Төв	27	89,771.0	74.0	1.2	4,705.9	227.2
'15 Увс	19	80,294.0	69.6	1.2	2,784.1	164.5
'16 Ховд	17	83,111.0	76.1	1.1	3,280.6	162.0
'17 Хөвсгөл	24	127,256.0	100.6	1.3	5,089.4	234.0
'18 Хэнтий	18	72,390.0	80.3	0.9	3,903.6	171.4
'19 Дархан-уул	4	97,691.0	3.3	30.9	324.2	101.0
'21 Орхон	2	98,750.0	0.8	127.2	134.2	88.7
'22 Говь сүмбэр	3	16,358.0	5.5	3.1	397.9	25.0
НИЙТ:	334	1,637,197.0	1,559.4		61,110.9	3,270.0

Сүүлийн жилүүдэд тэвчиж болох урсгал зардлыг 10-30 хувиар жил дараалан бууруулах арга хэмжээ авсан нь дунджаар багийн Засаг дарга сар тутамд тээвэр шатахууны зардалд 20 мянган төгрөг, бичиг хэрэг, шуудан холбооны зардалд сар тутамд 13-15 мянган төгрөг ногдох хэмжээнд хүрч буурсан байна. Иймд сумдын Засаг даргын Тамгын газар, баг, хорооны Засаг дарга, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардагдах тээвэр шатахуун, бичиг хэрэг, урсгал засвар, дотоод албан томилолтын зардлыг урьд онуудын гүйцэтгэл, орон нутгаас ирүүлсэн саналыг харгалзан сумын болон багийн Засаг дарга

нарын үйл ажиллагаанд 1 суманд дунджаар жилд 3.7 сая төгрөг, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 2.0 сая төгрөг нэмэгдэхээр тооцож 2018 оны орон нутгийн төсвийн суурь зардалд нийт 2,125.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж тооцов.

Мөн Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт газрын асуудал эрхэлсэн алба, сумдад газрын даамалтай байна” гэж заасан, үүнд нийцүүлэн гаргасан Засгийн газрын 2017 оны 253 дугаар тогтоолд үндэслэн сумдын Засаг даргын тамгын газарт харьяалагдаж байгаа газрын даамлуудын нийт 353 орон тоо, 2,582.3 сая төгрөгийн зардлыг аймгын газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт шилжүүлэх зохицуулалтыг төсөлд тусгалаа.

Бусад урсгал зардал

Хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх Олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад орохтой холбогдуулан хилийн шалган нэвтрүүлэх хяналтыг сайжруулах, хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд зориулж хил хамгаалах, онцгой, гааль, татвар, цаг уур, гадаадын иргэн харьяатын асуудал хариуцсан байгууллагад шаардагдах урсгал зардлыг 6.7 тэрбумаар нэмэгдүүлнэ

Хүснэгт № 49. Боомтын хүчин чадлыг сайжруулахад шаардагдах хөрөнгө /сая төгрөг/

№	Байг/лага	НИЙТ		"Шивээ хүрэн"		"Гашуун сухайт"		"Хөшигтийн хөндий"		"Бургастай"	
		Орон тоо	Урсгал зардал	Орон тоо	Урсгал зардал	Орон тоо	Урсгал зардал	Орон тоо	Урсгал зардал	Орон тоо	Урсгал зардал
1	ХХЕГ	110	1,881.3	-	-	60.0	994.2	50.0	887.1	-	-
2	МХЕГ	64	2,300.4	-	-	-	946.9	64.0	1,499.9	-	-
3	ГЕГ	99	2,031.9	-	-	-	549.2	99.0	1,378.1	-	104.6
4	УЦУОШГ	13	238.1	-	-	-	-	13.0	238.1	-	-
5	ЭМЯ	6	83.8	3.0	41.9	3.0	41.9	-	-	-	-
6	ГИХГ	-	120.0	-	-	-	-	-	120.0	-	-
Нийт дүн		292	6,655.5	3	41.9	63	2,532.1	226	4,123.2	-	104.6

Гал унтраах ангиудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Засгийн газрын 2016 оны 12 сарын 14-ний өдрийн 183 дугаар тогтоол, 2017 оны 192 дугаар тогтоолоор Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл, Ховд, Дундговь аймгуудын хүн ам төвлөрөл ихтэй, ахуйн болон ой хээрийн түймрийн эрсдэл өндөр зарим сумдад гал унтраах 4 дүгээр зэрэглэлийн 6 анги, эрэн хайх, аврах 3 бүлэг байгуулах зардалд зориулж 4.3 тэрбум төгрөг төсөвлөв.

Хүснэгт № 50. Гал унтраах ангиудын хүчин чадлыг сайжруулахад шаардагдах хөрөнгө

№	Гал унтраах анги, бүлгүүд	Орон тоо	Зардал, тэрб.төг
А	ЗГ-ын 2016 /183 -р тогтоолоор байгуулагдах	128	1874.2
1	Дорнод аймаг, Халхгол сум ГУА 62-р анги	40	592.8
2	Өмнөговь аймаг, Ханбогд сум ГУА 66-р анги	40	592.8
3	Өмнөговь аймаг, Гурвантэс сум ГУА 67-р анги	40	592.8
4	Сүхбаатар аймаг, Түмэнцогт сум Эрэн хайх, аврах бүлэг	8	95.8
Б	ЗГ-ын 2017 / 192-р тогтоолоор шинээр байгуулагдах	152	2161.7
1	Орхон аймаг, Баян-Өндөр сум ГУА 68-р анги	40	592.8
2	Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум Хатгал тосгон ГУА 69-р анги	40	592.8
3	Ховд аймаг, Зэрэг сум ГУА 70-р анги	40	592.8
4	Ховд аймаг, Манхан сум Эрэн хайх, аврах бүлэг	8	95.8
5	Дундговь аймаг, Эрдэнэдалай сум Эрэн хайх, аврах салбар	24	287.5

В	Шинэ барилгын ашиглалтын зардал	-	585.6
1	Дархан-Уул ОБГ-ын ГУА ангийн барилга	-	99.1
2	Архангай ОБГ-ын ГУА ангийн барилга	-	98.0
3	Сэлэнгэ ОБГ-ын ГУА ангийн барилга	-	99.1
4	Завхан ОБГ-ын ГУА ангийн барилга	-	98.0
5	Говьсүмбэр ОБГ-ын ГУА ангийн барилга	-	98.0
6	Хэнтий ОБГ-ын ГУА ангийн барилга	-	93.4
Нийт дүн		280	4,325.1

Дөрөв. Урсгал зардлын төсвийн төсөлтэй холбогдуулан өөрчлөлт оруулах хуулиуд

1. Төсвийн зөвлөл байгуулж, төсвийн хяналтыг эрчимжүүлнэ. ОУВС-ын Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт заасны дагуу төсвийн тогтвортой байдлын үндсэн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөмж боловсруулах үүрэг бүхий хараат бус, бие даасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр УИХ-ын Төсвийн байнгын хорооны дэргэд байгуулахаар тооцож Төсвийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

2. Төсөв хэлэлцэн батлах тогтолцоог боловсронгуй болгоно. Эдийн засгийн мөчлөг дагасан төсвийн бодлогыг халах, төсвийн сахилга батыг сайжруулахад чиглэсэн төсвийн шинэчлэл хийх зорилгоор төсөв хэлэлцэн батлах процесст зарчмын томоохон өөрчлөлт хийхээр ОУВС-ын ӨСХ-т тусгагдсан. Улсын Их Хурал нь Засгийн газрын өргөн мэдүүлсэн жилийн төсөв, түүний тодотголыг Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж хэлэлцэн батлахдаа нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, хэрэв тодорхой хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төслийг нэмэгдүүлэх бол бусад хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлаас мөн хэмжээгээр бууруулдаг байх зарчмын өөрчлөлтийг Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан болно.

3. Төсвийн зарлагыг их хэмжээгээр нэмэгдүүлэх зарим хуулийг хүчингүй болгоно. УИХ-аас 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр нийгмийн хамгааллын салбарын 2 хуулийг шинээр баталж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан малчны тэтгэвэрт гарах насыг 5 насаар урагшлуулах, малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил зургаан сараар шимтгэл төлж ажилласан хугацаанд тооцох, эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг төсвөөс хариуцан төлөх зэрэг зохицуулалтын улмаас 2018 онд зардал 103.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Түүнчлэн Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын санд 178.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 2018 онд 26.7 тэрбум төгрөгийн зардал гарах боломж цаашид нэмэгдэх зардлын хэмжээ 2019 онд 66.8 тэрбум төгрөг, 2020 онд 120.3 тэрбум төгрөг

болж байна. Өөрөөр хэлбэл тогтворгүй богино хугацааны орлогод үндэслэж урт хугацаанд байнгын шинжтэй өсөн нэмэгдэх зардлыг санхүүжүүлэх үр дагавартай байна.

Эдгээр хуулиуд нь богино болон дунд хугацаанд төсөвт ихээхэн хэмжээний дарамт учруулж ОУВС-тай тохирсон зардлын зорилтот түвшинг алдагдуулахаар байгаа тул хөтөлбөрийн хүрээнд энэхүү 2 хуулийг эргэн авч үзэж хүчингүй болгох нөхцөл тавигдааж байна.

4. Хүүхэд харах үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтыг боловсролын салбарт хариуцуулна. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль хэрэгжээд 2 жил болж байгаа боловч уг үйлчилгээг боловсролын мэргэжил арга зүй, удирдлагаар хангах асуудал учир дутагдалтай явж ирсэн байна. Иймд хуулийн хэрэгжилтийн зохицуулалтыг илүү оновчтой болгох үүднээс удирдлага зохион байгуулалт, санхүүжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад шилжүүлэхээр тооцож хуулийн төслийг боловсруулав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцын 2018 оны нийт зардал 5,226.3 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгасан бөгөөд үүнээс урсгал зардал 4,455.6 сая төгрөгөөр тооцож төсөвлөв. Төсвийн төслийг боловсруулахдаа Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн ТГ/493 тоот албан бичгээр ирүүлсэн 2018 оны төсвийн төслийн саналыг үндэслэн тооцов.

Хүснэгт № 51. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Хөтөлбөрүүдийн нийт дүн	3,618.5	4,546.7	5,226.3
1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа	3,556.6	4,461.7	4,387.4
2. Ерөнхийлөгчийн судалгаа шинжилгээ	61.9	85.0	68.2
3. Ангилалдаагүй бусад (хөрөнгө оруулалт)	0.0	0.0	770.7

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцын хөрөнгийн зардал нь 770.7 сая төгрөгөөр нэмэгдсэн бол урсгал зардал нь 2017 оны түвшинд төсөвлөгдсөн байна.

Хүснэгт № 52: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	Нийт Зарлага ба цэвэр зээл	Урсгал зардал	Үүнээс			Хөрөнгийн зардал
			Цалин, НДШ	Бараа үйлч. бусад	Татаас	
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН НИЙТ ДҮН	5,226.3	4,455.6	1,102.6	3,166.5	186.6	770.7
1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа	4,387.4	4,387.4	1,050.4	3,150.5	186.6	0.0
2. Ерөнхийлөгчийн судалгаа шинжилгээ	68.2	68.2	52.2	16.0	0.0	0.0
3. Ангилалдаагүй бусад (хөрөнгө оруулалт)	770.7	0.0	0.0	0.0	0.0	770.7

Хөтөлбөр 1. Монгол Улсын ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийг боловсруулахдаа үйл ажиллагааг хэвийн явуулах, төсвийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх, төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг бүрэн гүйцэтгэх зарчмыг баримталж нийт 4,387.4 сая төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт № 53. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /зориулалт ба арга хэмжээгээр, сая төгрөг/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа (70101)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	3,556.6	4,461.7	4,387.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,312.3	2,641.6	2,644.8
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	13.6	0.0	0.0
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	150.0	0.0	0.0
80310 Төрийн шагнал, одон, медаль	294.8	393.0	393.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	108.0	174.1	96.6
80814 Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг	90.0	90.0	90.0
81518 Мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх	526.5	1,163.0	1,163.0
82802 Улсын ой тэмдэглэх	56.4	0.0	0.0
82808 Бусад баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээ	5.0	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	3,556.6	4,461.7	4,387.4
31 Улсын төсвөөс санхүүжих	3,556.6	4,461.7	4,387.4
Орон тоо	56	56	56
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	3,556.6	4,461.7	4,387.4
00003 Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв	2,173.0	2,996.6	2,996.6
00004 Ерөнхийлөгчийн Тамгын газар	1,383.6	1,465.1	1,390.8

Хөтөлбөр 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн судалгаа шинжилгээ

Монгол хэл, бичиг үсгийг хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх, энэ чиглэлээр хийгдэх сургалт судалгааг өргөжүүлэх, дэмжих чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа чиглэгдэж байна.

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 68.2 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 16.8 сая төгрөгөөр буурч байгаа нь 2017 онд тэтгэвэрт гарсан ажилтанд олгосон нэг удаагийн тэтгэмжийн зардал буурсантай холбоотой байна.

Хүснэгт № 54. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлагын судалгаа шинжилгээ (70104)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	61.9	85.0	68.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	61.3	65.2	68.2
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	0.6	0.0	0.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.0	19.8	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	61.9	85.0	68.2
31 Улсын төсвөөс санхүүжих	61.9	85.0	68.2
Орон тоо	4	4	4
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	61.9	85.0	68.2
10577 Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба	61.9	85.0	68.2

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2018 оны нийт зардлыг 32,553.9 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгалаа. Үүнээс урсгал зардлыг 30,640.5 сая төгрөгөөр тооцож төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 10% буюу 2,872.2 сая төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Хүснэгт № 55. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Хөтөлбөрүүдийн нийт дүн	19,123.2	26,080.4	32,553.9
Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих (70102)	16,686.0	23,362.6	27,955.6
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	2,437.2	2,717.8	2,684.9
Ангилалдаагүй бусад буюу хөрөнгийн зардал (72301)	0.0	0.0	1,913.3

Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах, УИХ-ын хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд хүрэлцэхүйц байх, Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зардлыг Улсын Их Хурлын 2008 оны 28 дугаар тогтоолоор баталсан хэмжээгээр бүрэн тооцох, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлгийн ажлын албаны зардлыг 2017 оны түвшинд байхаар тооцлоо.

Хүснэгт № 56: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	Нийт зарлага ба цэвэр зээл	Урсгал зардал	Үүнээс:			Хөрөнгийн зардал
			Цалин НДШ	Бараа үйлч. бусад	Татаас шилжүүлэг	
ТЕЗ-ын хөтөлбөрүүдийн нийт дүн	32,553.9	30,640.5	9,789.7	20,512.4	311.4	1,913.3
Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих	27,955.6	27,955.6	9,789.7	17,854.5	311.4	0.0
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	2,684.9	2,684.9	0.0	2,684.9	0.0	0.0
Ангилалдаагүй бусад буюу хөрөнгө оруулалт	1,913.3	0.0	0.0	0.0	0.0	1,913.3

Хөтөлбөр . Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих хөтөлбөрийн хүрээнд 2018 онд Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангах, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсын Их Хуралд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхэд чиглэсэн багц үйл ажиллагаа хамаарна.

Хөтөлбөрийн төсвийн төслийг боловсруулахдаа 2017 онд хэрэгжүүлсэн нэг удаагийн арга хэмжээний зардлыг бууруулж, зайлшгүй шаардлагатай зарим арга хэмжээний зардлыг шинээр нэмж тусгасан болно. Тухайлбал, Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт заасны дагуу төсвийн хяналтыг эрчимжүүлэх зорилгоор нийт төсвийн хүрээнд хараат бус төсвийн хяналтыг хэрэгжүүлэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр УИХ-ын дэргэд байгуулагдаж байгаатай холбоотойгоор тус Зөвлөлийн үйл ажиллагааны зардал 265.6 сая төгрөг, Улсын Их Хурлын гадаад харилцаа өргөжиж байгаа, Улсын Их Хурлын гишүүд орон нутагт ажиллахтай холбоотой үйл ажиллагааны урсгал зардлыг зохих түвшинд тусгалаа.

Хүснэгт № 57. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /зориулалт ба арга хэмжээгээр, сая төгрөг/

Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих (70102)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	16,686.0	23,362.6	27,955.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	10,842.0	11,929.5	12,391.0
80108 УИХ-ын гишүүний төсөв	4,587.2	9,810.6	14,370.6
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	371.0	571.1	597.0
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	24.6	20.0	20.0
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	24.8	43.1	43.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	341.1	418.9	148.9
80813 Хуульд заасан үндэслэлээр олгох нөхөн олговор	53.7	100.0	100.0
80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний нөхөн олговор	305.5	450.0	0.0
80820 Бусад тусламж, дэмжлэг	11.4	19.5	19.5
82808 Бусад баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээ	124.8	0.0	0.0
83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	0.0	0.0	265.6
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	16,686.0	23,362.6	27,955.6
31 Улсын төсвөөс санхүүжих	16,686.0	23,362.6	27,955.6
Орон тоо	626	626	622
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	16,686.0	23,362.6	27,955.6
00001 Улсын Их Хурал	16,686.0	23,362.6	27,955.6

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА

Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын төсвийн багцын 2018 оны урсгал зардлыг 1,130.6 сая төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 14,622.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт № 58. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Хөтөлбөрүүдийн нийт дүн	28,594.6	15,752.6	1,130.6
1.Бүх шатны сонгууль зохион байгуулах	28,594.6	15,752.6	1,130.6

Төсвийн зардал буурч байгаа нь 2017 онд зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардал 2018 онд буурсантай холбоотой байна. Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны урсгал зардал нь 1,130.6 сая төгрөг бөгөөд үүнээс Цалин, НДШ-ийн зардал 480.7 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардал 617.0 сая төгрөг, шилжүүлгийн зардал 32.9 сая төгрөг байна.

Хүснэгт № 59: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	Урсгал зардал	Үүнээс:		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
ТЕЗ-ын хөтөлбөрүүдийн нийт дүн	1,130.6	480.7	617.0	32.9
Бүх шатны сонгууль зохион байгуулах	1,130.6	480.7	617.0	32.9

Хөтөлбөр : Бүх шатны сонгууль зохион байгуулах

Сонгуулийн тухай хуулиар аливаа сонгуулийн саналыг тоолохдоо санал тоолох төхөөрөмжөөр тоолж үр дүнг гаргадаг зохицуулалт бий болсон. Иймд хууль тогтоомжид заасан ээлжит сонгууль явуулахаас бусад жилүүдэд зохион байгуулагдах нөхөн болон дахин сонгуулийг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн 2018 онд нийт 220.1 сая төгрөгөөр тооцож төсвийн төсөлд тусгалаа. Мөн нөхөн болон дахин сонгуульд санал тоолох төхөөрөмж ашиглах болсонтой холбогдуулан гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 44.6 сая төгрөгөөр тусгалаа.

Хүснэгт № 60. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

Бүх шатны сонгууль зохион байгуулах (70403)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	28,594.6	15,752.6	1,130.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	521.2	574.0	616.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	0.0	0.0	44.6
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	0.2	0.1
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	19.0	32.3	32.3
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	152.4	159.2	184.7
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	2.5	26.1	26.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1.2	6.7	6.7
81501 Ерөнхийлөгчийн сонгууль	0.0	14,954.1	0.0
81502 УИХ-ын сонгууль	14,516.5	0.0	0.0
81503 Орон нутгийн сонгууль	12,166.2	0.0	0.0
81504 УИХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг	1,215.5	0.0	0.0
81555 Нөхөн болон дахин сонгууль	0.0	0.0	220.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	28,594.6	15,752.6	1,130.6
31 Улсын төсвөөс санхүүжих	28,594.6	15,752.6	1,130.6
Орон тоо	30	30	30
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	28,594.6	15,752.6	1,130.6
00079 Сонгуулийн ерөнхий хороо	28,333.2	15,471.5	852.9
10074 Мэдээллийн технологийн төв	261.4	281.0	277.7

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын 2018 оны төсвийн урсгал зардалд 3,974.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 100.0 сая төгрөг, нийт **4,074.9** сая төгрөг тусгав. Үүнээс, урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 77.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 61. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц.	2017 тод.	2018 төсөл
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	3,334.8	4,051.9	4,074.9
Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа (70702)	3,334.8	4,051.9	3,974.9
Хөрөнгийн зардал	0.0	0.0	100.0

Урсгал зардлын өөрчлөлтөд тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардал 2017 оны тодотгосон төсвөөс 436.9 сая төгрөгөөр, тэтгэвэрт гарсан хүний оронд томилгоо хийхгүйгээр цалингийн зардал 28.9 сая төгрөгөөр тус тус буурсан, байр ашиглалтын тогтмол зардалд 47.8 сая төгрөгөөр, Улсын Дээд шүүхийн 2-р байрны хэрэгцээний халуун усны бойлорт ялтаст дулаан солилцуур угсрах засварын ажил, газрын төлбөрийн зардалд

50.8 сая төгрөгөөр, Улсын дээд шүүх болон Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын хооронд 2017 оны 6 дугаар сард байгуулсан “Улсын бүртгэлийн мэдээлэл солилцох тухай” гэрээний дагуу төрийн байгууллага хооронд мэдээллийг цахим хэлбэрээр солилцох ажлын хүрээнд сувгийн түрээс, байр талбайн төхөөрөмж, холболтын хураамжийн зардалд 130.0 сая төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах, зарим орон нутгийн шүүхэд сургалт зохион байгуулахад дотоод томилолтын зардалд 78.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төсөвт тусгасан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт № 62. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	НИЙТ ДҮН	Урсгал зардал	Үүнээс:			Хөрөнгө оруулалт
			Цалин, НДШ	Бараа үйлчилгээ-ний бусад	Татаас шилжүүлэг	
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	4,074.9	3,974.9	2,869.1	1,071.3	34.6	100.0
Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа	3,974.9	3,974.9	2,869.1	1,071.3	34.6	0.0
Хөрөнгийн зардал	100.0	0.0	0.0	0.0	0.0	100.0

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2018 оны төсвийн төсөлд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дэх зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нийт 25 шүүгчийн амь насны даатгалын зардалд 72.3 сая төгрөгийг 2017 оны тодотгосон төсвийн төвшинд, шүүгчийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардалд 29.6 сая төгрөг тус тус нэмж тусгав.

Хүснэгт № 63. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа (70702)	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	3,334.8	4,051.9	3,974.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3,105.0	3,566.7	3,926.5
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	9.9	9.9
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	3.9	3.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	229.8	471.4	34.6
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	3,334.8	4,051.9	3,974.9
31 Улсын төсвөөс санхүүжих	3,334.8	4,051.9	3,974.9
Орон тоо	129	129	129
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	3,334.8	4,051.9	3,974.9
00115 Улсын дээд шүүх	3,334.8	4,051.9	3,974.9

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР

Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын 2018 оны төсвийн урсгал зардалд 28,377.6 сая төгрөг, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардалд 300.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 162.0 сая төгрөг, нийт 28,839.8 сая төгрөг тусгав. Үүнээс, урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 2,386.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 64. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	17,656.0	26,967.2	28,839.8
Прокурорын хяналт (70703)	16,167.8	25,991.3	28,377.6
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	0.0	887.6	300.2
Хөрөнгийн зардал	1,488.2	88.3	162.0

Төсвийн урсгал зардлын өсөлтөд Өвөрхангай аймгийн Прокурорын газар, Баянзүрх дүүргийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Улсын ерөнхий прокурорын газрын тамгын газрын 2-р байрны ашиглалтын тогтмол зардал болон шинэчлэн батлагдсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа үйлчилгээний зардлыг тооцон нэмэгдүүлсэн, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн зардал 587.4 сая төгрөгөөр буурсан нь голлох нөлөөлөл үзүүлж байна.

Хүснэгт № 65. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	НИЙТ ДҮН	Урсгал зардал	Үүнээс:			Зээл, тусламж	Хөрөнгө оруулалт
			Цалин, НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг		
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	28,839.8	28,377.6	24,124.3	3,833.1	420.1	300.2	162.0
Прокурорын хяналт	28,377.6	28,377.6	24,124.3	3,833.1	420.1	0.0	0.0
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	300.2	0.0	0.0	0.0	0.0	300.2	0.0
Хөрөнгийн зардал	162.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	162.0

Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардал дараах үндэслэл, шалтгааны улмаас нэмэгдсэн байна. Үүнд:

1.Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд прокуроруудад захиргааны зөрчил болон эрүүгийн хэргүүдэд хяналт тавих ачаалал нэмэгдэж байгаатай холбоотойгоор аймаг, нийслэлийн прокурорын газарт зөрчлийн асуудлаар дагнасан 20 прокурорын орон тооны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 707.9 сая төгрөг нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгав.

1.1.Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавихдаа зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан эсэх, холбогдох хуулийг зөв хэрэглэсэн эсэх, уг ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангасан эсэхийг хянах, зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох чиг үүргийг хэрэгжүүлэхээр Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуульд заасан. Статистик мэдээллээс үзэхэд, хуулийн шинэ орчинд нэг жилд 11179 улсын байцаагчийн шалгах 1168000 зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд прокурорын хяналт тавихаар байгаа нь нэг сард 97333, хоногт 4424 хэргийн материалыг хянан шийдвэрлэхээр байгаа юм. Иймд Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын хяналт тавих зөрчлийн болон эрүүгийн хэргийн тоо нэмэгдэхтэй холбоотойгоор прокурорын тогтоол, прокурорын хариу мэдэгдэх хуудас,

прокурорын мэдэгдэл, шаардлага, шүүхэд дүгнэлт бичих бичиг хэргийн зардал болон шуудан харилцааны холбооны зардлыг 377.9 сая төгрөгөөр нэмж тусгав.

1.2.Түүнчлэн Прокурорын тухай хууль болон шинээр хэрэгжиж буй дээр дурдсан хуулиуд, эдгээр хуульд нийцүүлэн Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар шинэчлэн баталсан журам, заавруудыг прокурорууд болон цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, шүүхийн шинжилгээний алба хаагч нарт таниулж сургалт явуулах, ном хэвлэл, тараах материал, товхимол, хуулийн тайлбарууд хэвлэн нийтлэхэд 181.6 сая төгрөгийг нэмж тусгав.

1.3.Улсын хэмжээнд 2016 онд 8942 албан тушаалтан 665,379 хэрэгт хэрэг бүртгэл явуулж шийдвэрлэсэн бөгөөд прокурорын байгууллага захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа, түүнд тавьсан хяналтын ажлын чиглэлээр 377 удаагийн шалгалтаар 56691 хэрэгт шалгалт хийсэн. Дээрх статистик тооноос үзэхэд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын хяналтыг хэрэгжүүлэх шалгалтын тоо 11.7 дахин нэмэгдэхээр байгаа тул дотоод томилолтын зардлыг 42.0 сая төгрөгөөр, эд мөрийн баримтыг хадгалах, шинжлүүлэх зардал, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал, хэргийн газрын үзлэг хийхэд оролцох, экскумаци хийх зэрэг байцаан шийтгэх ажиллагааны зардлыг 164.7 сая төгрөгөөр нэмж тусгав.

2.Прокурорын тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан “Прокурорын дүрэмт хувцасны загвар”-ын дагуу прокуроруудад тавьж олгосон дүрэмт хувцасны эдэлгээний хугацаа 2016 онд дууссан тул уг зардалд 315.8 сая төгрөгийг төсөлд тусгав.

3.Татаас шилжүүлгийн зардалд 6 прокурор, 2 төрийн үйлчилгээний албан хаагчид олгох тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын 403.8 сая төгрөгийг тусгасан нь өмнөх оны төвшнөөс 28.9 сая төгрөгөөр өссөн байна.

Тэтгэвэрт гарах албан хаагчийн оронд томилгоо хийхгүйгээр тооцож, 48.1 сая төгрөгийг цалингийн сангаас бууруулав.

Хүснэгт № 66. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Прокурорын хяналт (70703)	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	16,167.8	25,991.3	28,377.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	15,881.0	25,451.0	27,632.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	223.7	401.7	420.1
80811 Нүүлгэн шилжүүлэх зардал	0.0	7.0	28.4
82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ⁸	63.1	131.5	0.0
82315 Байцаан шийтгэх ажиллагаа	0.0	0.0	1004
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	16,167.8	25,991.3	28,377.6
31 Улсын төсвөөс санхүүжих	16,167.6	25,991.3	28,377.6

⁸ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” гэсэн зориулалтад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын хяналтыг хэрэгжүүлэхэд гарах байцаан шийтгэх ажиллагааны зардлыг өмнөх онуудад тусгаж төлөвлөсөн бөгөөд 2018 оны төсвийн төсөлд прокурор, хууль сахиулах салбарын зарим байгууллагын байцаан шийтгэх ажиллагааны зардлыг нэг зориулалтаар тусгахаар төлөвлөж, “Байцаан шийтгэх ажиллагаа” гэсэн шинэ зориулалтад зардлыг шилжүүлэн тусгасан болно.

35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.2	0.0	0.0
Орон тоо	984	984	984
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	16,167.8	25,991.3	28,377.6
Улсын ерөнхий прокурорын газар	2,916.3	4,618.8	7,277.3
Аймаг, дүүрэг дэх Прокурорын газар	12,684.1	20,470.6	20,235.9
Бусад харьяа нэгж, байгууллагууд	567.4	901.9	864.4

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцын 2018 оны төсвийн урсгал зардалд 1,683.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 340.0 сая төгрөг, нийт **2,023.4** сая төгрөг тусгав. Үүнээс, урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 98.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 67. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц.	2017 тод.	2018 төсөл
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	790.3	1,585.4	2,023.4
Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих (70404)	790.3	1,585.4	1,683.4
Хөрөнгийн зардал	0.0	0.0	340.0

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Цэцийн шийдвэрийн товч агуулгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд нэн даруй мэдээлнэ. Түүнчлэн Цэцийн нээлттэй хуралдааны шийдвэрийг бүрэн эхээр нь “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтэлнэ” гэж заасны дагуу мэдээлэл, сурталчилгааны зардалд 8.0 сая төгрөг, цэцийн шийдвэрийг хэвлэн нийтлэх зардалд 23.3 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 326.9 сая төгрөгийг тус тус хянаж тусгав.

Хүснэгт № 68. ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	НИЙТ ДҮН	Урсгал зардал	Үүнээс:			Хөрөнгө оруулалт
			Цалин, НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг	
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	2,023.4	1,683.4	1,055.8	294.8	332.8	340.0
Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих	1,683.4	1,683.4	1,055.8	294.8	332.8	0.0
Хөрөнгийн зардал	340.0	0.0	0.0	0.0	0.0	340.0

Үндсэн хуулийн цэцийн байрны аюулгүй байдлыг хангах зорилгоор хяналтын камер, дэлгэцийн зардалд 3.8 сая төгрөг, Үндсэн хуулийн шүүхүүдийн Дэлхий дахины бага хурлын болон Азийн үндсэн хуулийн шүүхүүдийн нийгэмлэгийн хурал, зөвлөгөөнд оролцох томилот, зочны зардалд 12.2 сая төгрөг нэмж тусгав.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зардалд 2017 оны төсөвт тусгагдсан нэг удаагийн шинж чанартай арга хэмжээний 79.5 сая төгрөгийн зардлыг бууруулав.

Хүснэгт № 69. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих (70404)	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	790.3	1,585.4	1,683.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	788.3	1,375.3	1,341.2
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	7.9	7.9
80305 Биений тамирын уралдаан, тэмцээн	1.0	1.5	1.5
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	0.0	2.8	2.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1.0	197.9	329.9
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	790.3	1,585.4	1,683.4
31 Улсын төсвөөс санхүүжих	790.3	1,585.4	1,683.4
Орон тоо	41	41	41
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	790.3	1,585.4	1,683.4
00112 Үндсэн хуулийн цэц	790.3	1,585.4	1,683.4

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын 2018 оны төсвийн урсгал зардалд 50,672.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 750.0 сая төгрөг, нийт **51,422.4** сая төгрөг тусгав. Үүнээс, урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 4,377.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 70. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	47,859.8	46,295.1	51,422.4
Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах (70701)	47,859.8	46,295.1	50,672.4
Хөрөнгийн зардал	0.0	0.0	750.0

Хүснэгт № 71. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	НИЙТ ДҮН	Урсгал зардал	Үүнээс:			Хөрөнгө оруулалт
			Цалин, НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг	
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	51,422.4	50,672.4	40,201.8	9,274.4	1,196.2	750.0
Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах	50,672.4	50,672.4	40,201.8	9,274.4	1,196.2	0.0
Хөрөнгийн зардал	750.0	0.0	0.0	0.0	0.0	750.0

Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардал дараах үндэслэл, шалтгааны улмаас нэмэгдсэн байна. Үүнд:

1. Байрны түрээсийн зардлыг Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн байр дуудлага худалдаанд орох болсонтой холбогдуулан 60.0 сая төгрөгөөр, шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргаан сүүлийн 4 жилийн хугацаанд 44.2 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан бичиг хэрэг, шуудан, холбооны зардлыг 437.4 сая төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинээр батлагдсан хуулиудын сургалтыг бүх шатны шүүхийн шүүгч нарт зохион байгуулах зорилгоор 345.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төсвийн төслийг боловсруулав.

2.Татаас шилжүүлгийн зардалд 11 шүүгч, 7 захиргааны болон үйлчилгээний ажилтны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын 1,196.2 сая төгрөгийг тусгасан нь өмнөх оны төвшнөөс 10.9 сая төгрөгөөр өссөн байна.

3.Эрүүгийн болон зөрчлийн хуулийн дагуу эрүү, захиргааны хэргийн шүүхийн ачаалал нэмэгдэхтэй холбоотойгоор эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 34 шүүгч, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 7 шүүгч, 41 шүүгчийн туслах, 21 нарийн бичгийн даргын орон тоог нэмэгдүүлж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2,020.2 сая төгрөгийг төсвийн төсөлд нэмж тусгав.

3.1.Шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргаан сүүлийн 4 жилийн хугацаанд 44.2 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан бичиг хэрэг, шуудан, холбооны зардлыг 437.4 сая төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинээр батлагдсан хуулиудын сургалтыг бүх шатны шүүгч нарт зохион байгуулахад 385.7 сая төгрөг тус тус нэмэгдүүлэн төсвийн төслийг боловсрууллаа.

3.2.Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын хэрэгжилтийг 2017 оны орон тоонд багтаан хэрэгжүүлэхээр тооцож, шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй аймгийн шүүх зэргэлдээ аймгийн шүүхээс шүүгч томилолтоор ажиллуулахад дотоод томилолт, тээвэр шатахууны зардалд 469.3 сая төгрөгийг нэмж тусгав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны төсөвт Ажлын албаны орон тоог бууруулсны улмаас ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд олгох тэтгэмжийн зардалд 125.0 сая төгрөг тусгагдсаныг 2018 оны төсвийн төсөлд бууруулав.

Хүснэгт № 72. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах (70701)	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	47,859.8	46,295.1	50,672.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	45,960.8	44,320.4	48,663.3
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	49.1	50.7	50.7
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил ⁹	12.3	139.0	0.0
80220 Холбооны суваг ашигласны хөлс	213.3	166.1	228.0
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	91.4	167.6	167.6
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	36.3	42.6
80228 Цахим хуудасны бүртгэлийн хураамж	6.7	10.0	10.0
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	40.5	30.0
80312 Сургалт семинар	0.0	54.3	95.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,373.6	1,185.3	1,196.2
80811 Нүүлгэн шилжүүлэх зардал	23.8	0.0	50.0
80812 Бүтцийн өөрчлөлтийн тэтгэмж	128.7	125.0	0.0
82321 Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал	0.0	0.0	90.0

⁹ “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил” гэсэн зориулалтад шүүхийн үйл ажиллагаатай холбоотойгоор процессын хуулийн дагуу гарах шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчийн зардал зэргийг нэгтгэн өмнөх онуудад тусгаж байсныг 2018 оны төсвийн төсөлд “Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал”, “Гэрчийн зардал”, “Процессын хуульд заасан бусад зардал” гэсэн зориулалтаар салган төлөвлөж, зардлыг шилжүүлэн тусгасан болно.

82322	Гэрчийн зардал	0.0	0.0	30.0
82323	Процессын хуульд заасан бусад зардал	0.0	0.0	19.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		47,859.8	46,295.1	50,672.4
31	Улсын төсвөөс санхүүжих	47,825.8	46,235.1	50,612.4
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	34.0	60.0	60.0
Орон тоо		1960	1960	2063
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		47,859.8	46,295.1	50,672.4
Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба		3,001.3	2,248.1	4,291.7
Шүүхийн ерөнхий зөвлөл		4,543.3	4,056.8	4,073.9
Аймаг, дүүрэг дэх Шүүхийн тамгын газар		40,315.2	39,990.2	42,306.8

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн багцын 2018 оны төсвийн урсгал зардалд 14,598.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 195.6 сая төгрөг, нийт **14,793.9** сая төгрөг тусгав. Үүнээс, урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 6,203.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 73. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	8,770.7	9,351.6	14,793.9
Авлигатай тэмцэх (70408)	8,675.1	8,394.4	14,598.3
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	95.6	105.8	0.0
Хөрөнгийн зардал	0.0	851.4	195.6

Төсвийн урсгал зардлын өсөлтөд Улсын Их Хурлаас 2016 онд баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зардал, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор нэмж шаардагдах бараа үйлчилгээний зардлыг тус тус нэмэгдүүлсэн, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн зардал 105.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 655.8 сая төгрөгөөр өмнөх оноос тус тус буурсан нь голлох нөлөөлөл үзүүлж байна.

Хүснэгт № 74. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй зардлын тойм /Зардлын эдийн засгийн төмсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	НИЙТ ДҮН	Урсгал зардал	Үүнээс:			Хөрөнгө оруулалт
			Цалин, НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг	
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	14,793.9	14,598.3	3,904.7	10,515.0	178.6	195.6
Авлигатай тэмцэх	14,598.3	14,598.3	3,904.7	10,515.0	178.6	0.0
Хөрөнгийн зардал	195.6	0.0	0.0	0.0	0.0	195.6

Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан. Иймд уг хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хянаж, авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг төрийн албан хаагчид, эрэн сурвалжлах сэтгүүлч, төрийн бус байгууллага, олон нийтийн дэд зөвлөлийн гишүүдэд зориулан зохион байгуулах, сургалт

явуулахад 800.0 сая төгрөг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн сан бий болгох, мэдүүлгийг цахим хэлбэрээр авах тогтолцоонд бүрэн шилжүүлэхэд 230.0 сая төгрөг, хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулахад 20.0 сая төгрөг, Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулахад 930.0 сая төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардалд 20.0 сая төгрөг, нийт 2,000.0 сая төгрөгийг тусгав.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Авлигатай тэмцэх газрын албан хаагчдад нэмэгдэж буй ачааллыг харгалзан үзэж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, томилолтын зардлыг 115.6 сая төгрөгөөр, санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын шинжээчээр шинжилгээ хийлгэх, хавтаст хэргийн материалын гадаад хэлнээс орчуулга хийлгэх, хэлмэрчийн зардал, гэрч хохирогчийг хамгаалах зэрэг байцаан шийтгэх ажиллагааны зардлыг 250.0 сая төгрөгөөр нэмж тусгав.

Татаас шилжүүлгийн зардалд 3 албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын 128.4 сая төгрөгийг тусгасан нь өмнөх оны төвшнөөс 29.7 сая төгрөгөөр өссөн байна. Тэтгэвэрт гарах албан хаагчийн оронд томилгоо хийхгүйгээр тооцож, 26.2 сая төгрөгийг цалингийн сангаас бууруулав.

Хүснэгт № 75. Авлигатай тэмцэх хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Авлигатай тэмцэх (70408)	2016 гүйц.	2017 тод.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	8,675.1	8,394.4	14,598.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	4,514.5	4,490.6	4,914.8
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ ¹⁰	411.5	112.6	0.0
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	75.8	42.7	42.7
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	3,489.0	3,597.5	7,097.5
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	1.7	2.1	2.1
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	40.0	45.2	45.2
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	142.7	103.7	133.4
82313 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	0.0	0.0	2,000.0
82315 Байцаан шийтгэх ажиллагаа	0.0	0.0	362.6
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	8,675.1	8,394.4	14,598.2
31 Улсын төсвөөс санхүүжих	8,675.0	8,394.4	14,598.2
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.1	0.0	0.0
Орон тоо	172	172	172
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	8,675.1	8,394.4	14,598.2
09697 Авлигатай тэмцэх газар	8,675.1	8,394.4	14,598.2

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын төсвийн багцын 2018 оны урсгал зардлын төсөвт нийт **2,027.7** сая төгрөг тусгав. Энэ нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 43.4 сая төгрөгөөр өссөн байна.

¹⁰ “Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ” гэсэн зориулалтад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу гарах байцаан шийтгэх ажиллагааны зардлыг өмнөх онуудад тусгаж төлөвлөсөн бөгөөд 2018 оны төсвийн төсөлд прокурор, хууль сахиулах салбарын зарим байгууллагын байцаан шийтгэх ажиллагааны зардлыг нэг зориулалтаар тусгахаар төлөвлөж, “Байцаан шийтгэх ажиллагаа” гэсэн шинэ зориулалтад зардлыг шилжүүлэн тусгасан болно.

Хүснэгт № 76. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц	2017 год.	2018 төсөл
УАБЗ-ийн НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	1,940.2	1,984.3	2,027.7
Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах (70706)	1,940.2	1,984.3	2,027.7

Хүснэгт № 77. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	Нийт урсгал зардал	Үүнээс:		
		Цалин, НДШ	БҮ-ний бусад	Татаас шилжүүлэг
УАБЗ-ийн НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	2,027.7	1,129.3	694.0	204.4
Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах	2,027.7	1,129.3	694.0	204.4

Татаас шилжүүлгийн зардалд 5 албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын 198.7 сая төгрөгийг тусгасан нь өмнөх оны төвшнөөс 72.2 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Түүнчлэн тэтгэвэрт гарах албан хаагчийн оронд томилгоо хийхгүйгээр тооцож, 44.5 сая төгрөгийн зардлыг цалингийн сангаас бууруулав.

Үндсэн үйл ажиллагааны зардал 32.1 сая төгрөгөөр буурсан байгаа нь тэтгэвэрт гарах хүний оронд нөхөн томилгоо хийхгүйгээр тооцож бууруулсан цалингийн зардал болон бусад бараа үйлчилгээний зарим зардал нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт № 78. Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах (70706)	2016 гүйц	2017 год.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	1,940.2	1,984.3	2,027.7
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,330.0	1,289.8	1,257.6
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	505.9	508.2	507.2
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	47.8	55.7
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	1.5	2.9	2.8
80312 Сургалт семинар	0.0	2.6	0.0
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	5.7	6.5	5.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	28.7	126.5	198.7
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	68.4	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,940.2	1,984.3	2,027.7
31 Улсын төсвөөс санхүүжих	1,940.2	1,984.3	2,027.7
Орон тоо	95	95	95
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,940.2	1,984.3	2,027.7
08610 Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	1,248.3	1,338.8	1,362.7
09680 Стратеги судалгааны хүрээлэн	692.0	645.6	665.0

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Монгол Улсын ерөнхий аудиторын төсвийн багцын 2018 оны нийт зардлыг 11,187.6 сая төгрөг байхаар тооцсоноос гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зардалд 87.9, хөрөнгө оруулалтын зардалд 500.0 сая төгрөг, урсгал зардалд 10,600.0 сая төгрөгийг төсөвлөв. Энэ нь 2017 оны тодотгосон төсвөөс 1,287.5 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хүснэгт № 79. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	9,333.4	9,312.5	11,187.6
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	0.0	549.1	87.6
Төрийн аудитын үйлчилгээ	9,333.4	8,763.4	11,100.0

Монгол Улсаас гадаад оронд суугаа 26 дипломат төлөөлөгчийн газруудын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх томилолтын зардал, мөн Австри, Дани, Япон улсад болох аудитын олон улсын хурал, уулзалтад оролцох зардлыг 168.3 сая төгрөгөөр тооцон тусгасан.

Хүснэгт № 80. ТЕЗ-ын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

ТЕЗ / Хөтөлбөр	Нийт зардал	Урсгал зардал	Үүнээс			Зээл тусламж	Хөрөнгө оруулалт
			Цалин НДШ	БҮБ Зардал	Татаас шил-лэг		
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	11,187.6	10,600.0	7,106.3	3,168.1	325.5	87.6	500.0
Төрийн аудитын үйлчилгээ	11,187.6	10,600.0	7,106.3	3,168.1	325.5	87.6	500.0

Баянхонгор, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Нийслэлийн аудитын газруудад байр, ашиглалтын болон түрээсийн зардалд 128.1 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 140.3 сая төгрөг байхаар тусгалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т “төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, чадавхыг бэхжүүлэн аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлж авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг хангахад дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний зардал болон Концессын хөрөнгө оруулалтад аудит хийх зардалд 466.5 сая төгрөгийг тусгалаа.

Хүснэгт № 81. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	8,860.0	8,763.4	10,600.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	8,074.2	8,135.8	9,382.7
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.8	0.0	0.0
80220 Холбооны суваг ашигласны хөлс	237.0	79.1	79.1
80221 Гэрээт ажиллагсдын зардал	169.2	156.6	156.6
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	149.5	39.7	186.8
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	5.3	2.8	2.8
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүн/ хур	2.5	3.4	3.4
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	212.5	314.3	290.4
80803 Төрийн албан хаагчдын гэр бүлд олгох дэмжлэг	6.6	31.8	31.8
80809 Эмчилгээний төлбөр	2.2	0.0	0.0
82313 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	0.0	0.0	466.5
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	8,860.0	8,763.4	10,600.0
31 Улсын төсвөөс санхүүжих	8,854.3	8,763.4	10,600.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5.6	0.0	0.0
Орон тоо - Албан тушаалаар	0	389	389
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	8,860.0	8,763.4	10,600.0
00009 Монгол улсын Аудитын газар	2,927.8	3,061.7	5,041.5
00027 Аймаг, нийслэлийн Аудитын газар	5,932.1	5,701.7	5,558.5

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн багцын 2018 оны урсгал зардлыг 726.0 сая төгрөг байхаар тооцов.

Хүснэгт № 82. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	498.0	725.8	726.0
Төрийн нийтлэг бусад үйлчилгээ, үйл ажиллагаа (70400)	498.0	725.8	726.0
Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт (70401)	498.0	725.8	726.0

Төрийн албаны эрх зүйн шинэтгэлийн бодлого, стратегийг боловсруулан батлуулах, стандарт хэм хэмжээг боловсронгуй болгох, Төрийн захиргааны байгууллагыг хөгжлийн бодлого, стандартын удирдлагаар хангах, салбар зөвлөлийг чадавхжуулах, идэвхжүүлэх, Төрийн албаны тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, бүртгэл мэдээлэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний нэгдсэн тогтолцоог бий болгох, Төрийн байгууллага, албан хаагчийг гүйцэтгэлийн удирдлагаар хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиг үүргийг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршиж байна.

Хүснэгт № 83. ТЭЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

ТЭЗ / Хөтөлбөр	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	БҮБ Зардал	Татаас шилжүүлэг
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	726.0	333.2	392.7	0.0
Төрийн нийтлэг бусад үйлчилгээ, үйл ажиллагаа	726.0	333.2	392.7	0.0
Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт (726.0	333.2	392.7	0.0

Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэнцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх 6 арга хэмжээний зардалд 165.0 сая төгрөг тусгав.

Хүснэгт № 84. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	498.0	725.8	726.0
Төрийн нийтлэг бусад үйлчилгээ, үйл ажиллагаа	498.0	725.8	726.0
Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт	498.0	725.8	726.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	424.6	585.4	629.3
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.4	1.2	1.2
80224 Зөвлөл, хороо, комиссын ажлын хөлс	2.9	2.9	4.9
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	69.0	74.2	87.2
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	1.1	3.4	3.4
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	0.0	58.8	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	498.0	725.8	726.0
31 Улсын төсвөөс санхүүжих	498.0	725.8	726.0
Орон тоо - Албан тушаалаар	0	19	19.0
420001 Удирдах ажилтан	0	3	3.0
420002 Гүйцэтгэх ажилтан	0	15	15.0
420003 Үйлчлэх ажилтан	0	1	1.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	498.0	725.8	726.0
00015 Төрийн албаны зөвлөл	498.0	725.8	726.0

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн багцын 2018 оны нийт зардлыг 9,392.3 сая төгрөгөөр тусгасан бөгөөд урсгал зардал нь 9,367.9 сая төгрөг, гадаад зээл тусламжаар 24.4 сая төгрөг байна. 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 1,803.3 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хүснэгт № 85. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	2,437.0	7,564.6	9,392.3
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	0.0	589.7	24.4
Албан ёсны статистик	2,437.0	6,974.9	9,367.9

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн “е” заалтын дагуу Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 5 жил тутам зохион байгуулна гэсэн заалтын дагуу 2018 онд уг судалгааг явуулах ба судалгааны зардалд нийт 1,475.0 сая төгрөг тусгав.

Мөн 2018 онд Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8.2-т Тооллогын товыг ээлжит тооллого явуулах хугацаанаас хоёроос доошгүй жилийн өмнө Улсын Их Хурал зарлана гэж заасны дагуу 2020 оны тооллогыг Улсын их хурлын тогтоолоор батлан тооллогын бэлтгэл ажлыг хангах, туршилтын тооллого явуулахад 567.1 сая төгрөг тусгалаа.

Хүснэгт № 86. ТЕЗ-ын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

ТЕЗ / Хөтөлбөр	Нийт зардал	Урсгал зардал	Үүнээс			Гадаад зээл
			Цалин НДШ	БҮБ Зардал	Татаас шил-лэг	
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	9,392.3	9,367.9	3,796.3	5,485.2	86.4	24.4
Албан ёсны статистик (70405)	9,392.3	9,367.9	3,796.3	5,485.2	86.4	24.4

Байр ашиглалтын зардлыг 215.9 сая төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 86.4 сая төгрөг байхаар тусгалаа. Харин сумдын статистик хариуцсан ажилтнуудын орон тоо тэдгээрт зарцуулагдах цалин хөлсөнд 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр ирүүлсэн саналыг УИХ, ЗГ-аас баримталж байгаа зарчмын дагуу нэмэгдүүлэх боломжгүй тул тусгаагүй болно.

Хүснэгт № 87. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	2,437.0	6,974.9	9,367.9
Зориулалт арга хэмжээгээр	2,437.0	6,974.9	9,367.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,481.4	4,346.2	4,468.8
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	1.0	30.7	30.7
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	121.3	20.9	20.9
80220 Холбооны суваг ашигласны хөлс	60.0	128.1	144.1
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.0	6.9	6.9
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	74.3	187.8	433.7
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	5.0	5.0
80509 олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	0.0	18.6	18.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	57.0	264.1	67.8
80803 Төрийн албан хаагчдын гэр бүлд олгох дэмжлэг	43.4	0.0	0.0
80811 Нүүлгэн шилжүүлэх зардал	0.0	2.4	2.4
81510 Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	458.3	1,116.1	1,845.8
81512 Ардчилсан засаглалын судалгаа	0.0	2.0	2.0

81513	Мал, тэжээвэр амьтдын тооллого	20.0	30.9	30.9
81514	Хэрэглээний үнийн судалгаа	0.0	0.3	0.3
81515	Барилгын салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа	0.0	1.0	1.0
81517	Статистикийн бусад тооллого, судалгаа	0.0	361.2	1,836.2
81526	Хагас жилийн мал тооллого	0.0	248.5	248.5
81527	Байгалийн нөөцөд суурилсан эдийн засгийн судалгаа	17.0	40.7	40.7
81529	Аж үйлдвэрийн салбарын үнийн судалгаа	0.0	1.5	1.5
81531	Гадаад худалдааны үнийн судалгаа	0.0	2.7	2.7
81532	Бөөний болон жижиглэнгийн үнийн судалгаа	0.0	4.6	4.6
81534	Тээврийн салбарын индекс тооцох үнийн судалгаа	0.0	2.6	2.6
81535	Ногоон эдийн засгийн судалгаа	0.0	21.8	21.8
81536	Байгаль орчин, эдийн засгийн нэгдсэн дансны судалгаа	0.0	25.2	25.2
81537	Хөрөнгө оруулалтын судалгаа	0.0	9.1	9.1
81541	Нөөц ашиглалт, салбар хоорондын тэнцлийн судалгаа	83.3	18.7	18.7
81543	Далд эдийн засгийн судалгаа /өрхөд суурилсан/	20.0	76.2	76.2
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		2,437.0	6,974.9	9,367.9
31	Улсын төсвөөс санхүүжих	2,429.8	6,968.9	9,367.9
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7.2	6.0	0.0
Орон тоо - Албан тушаалаар		0	320	320
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		2,437.0	6,974.9	9,367.9
00063	Үндэсний Статистикийн хороо	1,455.9	4,598.2	6,981.8
00065	Үндэсний Статистикийн хорооны орон нутгийн салбар	666.3	2,376.6	2,386.1

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА

Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн багцын 2018 оны урсгал зардлыг 826.8 сая төгрөгөөр тусгасан. Энэ нь Засгийн газрын баталсан хязгаараас 9.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь нийгмийн даатгалын шимтгэл болон гадаад болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн татвар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 88. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	731.6	791.8	826.8
Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих (70409)	731.6	791.8	826.8

Хүснэгт № 89. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ТЕЗ / Хөтөлбөр	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	БУБ зардал	Татаас шиллэг
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	826.8	571.2	235.0	20.6
Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих	826.8	571.2	235.0	20.6

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны бусад зардлыг 2017 оны түвшинд байхаар төсвийн төсөлд тусгалаа.

Хүснэгт № 90. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	731.6	791.8	826.8
Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих (70409)	731.6	791.8	826.8
Зориулалт арга хэмжээгээр	731.6	791.8	826.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	691.4	675.3	682.8
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	23.6	48.8	123.4
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	16.6	19.1	20.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.0	48.6	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	731.6	791.8	826.8
31 Улсын төсвөөс санхүүжих	731.6	791.8	826.8
Орон тоо - Албан тушаалаар	0	49	49
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	731.6	791.8	826.8
08647 Хүний эрхийн үндэсний комисс	731.6	791.8	826.8

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын 2018 оны урсгал зардлыг 644.3 сая төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотгосон төсвөөс 183.1 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хүснэгт № 91. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ЦАУЗБ КОМИССЫН ДАРГА	463.4	461.2	644.3
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	463.4	461.2	644.3
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа	463.4	461.2	644.3

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс нь 2018 онд Тагнуулын ерөнхий газрын Тусгай архив болон орон нутгийн архивуудад хадгалагдаж байгаа шалгагдаагүй 1352 хэргийг шалгаж, цагаатгах эсэхийг эцэслэн шийдвэрлэх улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатган нэр төрийг нь сэргээх ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна.

Хүснэгт № 92. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ТЕЗ / Хөтөлбөр	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	БҮБ зардал	Татаас шилжүүлэг
ЦАУЗБ КОМИССЫН ДАРГА	644.3	157.4	198.7	288.1
УТ хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа	644.3	157.4	198.7	288.1

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах байгууллага Тагнуулын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран өмнөх жилүүдэд хийсэн ажлын тайлан, үр дүнг нэгтгэн гаргах ажлыг зохион байгуулах тул 2018 оны төсвийн төслийг орон нутгаас материал татуулах ажлыг зохион байгуулахад 89.0 сая төгрөг, ахмад дайчдад олгох орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 90 сая төгрөг төсөвлөв.

Хүснэгт № 93. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ЦАУЗБ КОМИССЫН ДАРГА	463.4	461.2	644.3
Зориулалт арга хэмжээгээр	463.4	461.2	644.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	245.1	254.4	347.5
80716 Ахмад дайчдад үзүүлэх орон сууцны дэмжлэг	120.0	120.0	210.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	45.5	20.3	20.3
80818 Хэлмэгдэгсэд тэдний ар гэрт олгох тэтгэмж	51.6	57.8	57.8
81908 Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	1.3	8.6	8.6
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	463.4	461.2	644.3
31 Улсын төсвөөс санхүүжих	463.4	461.2	644.3
Орон тоо - Албан тушаалаар	0	11	11.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	463.4	461.2	644.3
00081 Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс	463.4	461.2	644.3

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын 2018 оны урсгал зардлыг 3,792.4 сая төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотгосон төсвөөс 1,277.7 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хүснэгт № 94. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	2,675.7	2,514.7	3,792.4
Санхүүгийн зах зээлийн зохицуулалт	2,503.1	2,514.7	3,792.4
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	172.6	0.0	0.0

Санхүүгийн хороо нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу уг үйл ажиллагааг хянаж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй боловч төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс энэ ажил хойш тавигдан Ази, номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгээс/FATF/ хийж буй харилцан үнэлгээний тайлангийн эхний төслөөр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоо “хангалтгүй” үнэлгээ авч, “Хар саарал жагсаалт”-д орох эрсдэл үүссэн тул тус байгууллагын программ хангамжийн эрсдэлийг арилгах ажлын хүрээнд 735.7 сая төгрөгийг тусгалаа.

Хүснэгт № 95. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ТЭЗ / Хөтөлбөр	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	БҮБ Зардал	Тагаас шилжүүлэг
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	3,792.4	1,896.4	1,492.8	403.1
Санхүүгийн зах зээлийн зохицуулалт (3,792.4	1,896.4	1,492.8	403.1

Тагнуулын ерөнхий газрын дүгнэлтээр санхүүгийн зах зээлийн мэдээ, мэдээллийн аюулгүй байдлын түвшин маш эрсдэлтэй гэж дүгнэгдсэний дагуу санхүүгийн мэдээллийн кибер аюулгүй байдлыг хангах Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24.1 Хороо нь энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Хорооны шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, шалгалт хийх шаардлага гарсан тул 455.4 сая төгрөгийг төсөлд тусгав.

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 66.3 сая төгрөг байхаар тусгалаа.

Хүснэгт № 96. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	2,675.7	2,514.7	3,792.4
Ерөнхий төлөвлөлт, санхүү төсвийн харилцаа (70200)	2,675.7	2,514.7	3,792.4
Санхүүгийн зах зээлийн зохицуулалт (70204)	2,503.1	2,514.7	3,792.4
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	172.6	0.0	0.0
Зориулалт арга хэмжээгээр	2,503.1	2,514.7	3,792.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,134.4	2,056.7	2,505.1
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	1.8	1.8
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	151.4	126.4	146.6
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	142.7	284.1	279.2
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	41.9	45.7	123.9
80812 Бүтцийн өөрчлөлтийн олгох тэтгэмж	32.7	0.0	0.0
83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	0.0	0.0	735.7
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	2,503.1	2,514.7	3,792.4
31 Улсын төсвөөс санхүүжих	1,310.2	1,692.3	2,970.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,192.9	822.4	822.4
Орон тоо - Албан тушаалаар	0	144	144.0
420001 Удирдах ажилтан	0	19	20.0
420002 Гүйцэтгэх ажилтан	0	115	116.0
420003 Үйлчлэх ажилтан	0	10	8.0
Орон тоо - Төрийн албаны ангиллаар	0	144	144.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	2,503.1	2,514.7	3,792.4
00013 Санхүүгийн зохицуулах хороо	2,503.1	2,514.7	3,792.4

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2018 оны төсвийн нийт зардлыг 259,622.8 сая төгрөгөөр тооцож төсвийн төсөлд тусгалаа. Үүнээс улсын төсвөөс санхүүжих урсгал зардал нь 110,728.1 сая төгрөг, харин гадаадын зээл, тусламжын эх үүсвэрээс санхүүжих урсгал зардал нь 15,761.4 төгрөг байхаар тооцож төсвийн төсөлд тусгав. Төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр, мөн нэг удаагийн арга хэмжээний зардлыг бууруулж, зайлшгүй шаардлагатай зарим арга хэмжээний зардлыг төсөлд тусгав.

Хүснэгт № 97. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Хөтөлбөрүүдийн нийт дүн	127,035.8	165,710.9	259,622.8
Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт (70201)	71,445.3	1,283.5	139,061.7
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	13,655.2	0.0	15,761.4
Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа (70424)	1,308.8	1,277.6	1,389.1
Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх (70426)	134.0	1,281.2	1,923.4
Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц (71302)	11,780.8	12,312.6	14,419.9
Ангилалдаагүй бусад (72301)	1,318.0	1,322.0	8,520.8

Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөрт концессын эргэн төлөлтийн төлбөрт шаардагдах хөрөнгө тусгагдсан нь нийт зардлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Хүснэгт № 98: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	УРСГАЛ ЗАРДАЛ	Үүнээс			ХӨРӨНГИЙ Н ЗАРДАЛ
			Цалин, НДШ	Бусад бараа үйлч.	Хүү, татаас, шилж	
Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	139,061.7	12,548.2	870.2	11,656.7	21.3	126,513.5
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл	15,761.4	0.0	0.0	0.0	0.0	15,761.4
Дотоод, гадаад шуурхай мэдээллийн ү/а	1,389.1	1,389.1	1,087.4	299.7	2.0	0.0
Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	1,923.4	1,923.4	860.6	1056.0	6.8	0.0
Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц	14,419.9	14,419.9	1,939.6	3,267.4	9,212.9	0.0
Ангилалдаагүй бусад	8,520.8	1,900.9	443.5	969.3	488.1	6,619.8

Хөтөлбөр 1. Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 12,548.2 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 11,264.7 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь Үндэсний брэндийн зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон тус зөвлөлийн Монгол улсыг гадаадад сурталчлах ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ авах зардал 10,554.1 төгрөгөөр төсөвлөгдсөн, хөгжлийн бодлого төлөвлөлт, тогтвортой хөгжлийн зорилтын төлөвлөлтийн суурь судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг татах, улс орноо сурталчлах форум, уулзалтуудыг зохион байгуулах арга хэмжээнд 711.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 99. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт (70201)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	740.3	1,283.5	12,548.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	671.1	1,051.3	2,518.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	0.0	0.0	9,089.2
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	10.2	13.6	34.3
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	0.0	0.0	386.0
80218 Улс орноо гадаад сурталчлах	1.6	12.9	52.9
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	36.8	97.0	105.6
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.3	1.0	1.0
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	0.0	7.7	7.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.0	45.6	13.6
81520 Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	20.4	54.5	340.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	740.3	1,283.5	12,554.4
31 Улсын төсвөөс санхүүжих	740.3	1,283.5	12,548.2
Орон тоо	70	70	70
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	740.3	1,283.5	12,554.4
10485 Эдийн засгийн үндэсний хорооны Ажлын Алба	200.6	295.8	292.4
10700 Үндэсний хөгжлийн газар	301.7	987.8	1,707.7
10831 Үндэсний брэндийн зөвлөл	0.0	0.0	10,554.1

Хөтөлбөр 2. Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 1,389.1 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 111.5 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь үйл ажиллагааны онцлогтой уялдан зарим урсгал зардлууд нэмэгдэнтэй холбоотой.

Хүснэгт № 100. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа (70424)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	1,308.8	1,277.6	1,389.1
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,164.6	1,192.3	1,321.4
80219 Харуул, хамгаалалтын зардал	45.0	44.6	44.6
80220 Холбооны суваг ашигласны хөлс	47.6	29.6	16.2
80312 Сургалт семинар	1.0	1.0	5.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	50.5	10.1	2.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,308.8	1,277.6	1,389.1
31 Улсын төсвөөс санхүүжих	1,142.5	1,092.6	1,204.1
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	166.3	185.0	185.0
Орон тоо	108	108	108
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,308.8	1,277.6	1,389.1
10172 МОНЦАМЭ агентлаг	1,308.8	1,277.6	1,389.1

Хөтөлбөр 3: Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 1,923.4 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 576.3 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу “Төрийн болон орон нутгийн өмчит

хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх” ажлыг зохион байгуулах зардлыг 403.3 сая төгрөг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр №51-117.832.8-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн цахим худалдан авах ажиллагааны системийн үйл ажиллагааг сайжруулахад зориулж 157.8 сая төгрөгийг төсвийн төсөлд шинээр тусгасантай холбоотой.

Хүснэгт № 101. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх (70426)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	134.0	1,281.2	1,923.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	134.0	1,014.5	1040.1
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	59.4	59.4
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.0	14.9	40.6
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	185.7	215.4
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.0	6.8	6.8
81548 Төрийн болон орон нутгийн өмчийн дахин үнэлгээ	0.0	0.0	403.3
81551 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	0.0	0.0	157.8
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	134.0	1,281.2	1,923.4
31 Улсын төсвөөс санхүүжих	134.0	1,281.2	1,923.4
Орон тоо	75	75	75
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	134.0	1,281.2	1,923.4
00011 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	134.0	1,281.2	1,923.4

Хөтөлбөр 4. Мэдээллийн нэгдсэн тогтолцооны бүтэц

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 14,419.9 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 1,946.6 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Энэ нь Монгол улсын нутаг дэвсгэрт олон сувгийн радио телевизийн өргөн нэвтрүүлгийг технологийн горимын түвшинд дамжуулан хүргэх, сүлжээний техникийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахтай холбоотойгоор “Радио телевизийн сүлжээ” төрийн өмчит үйлдвэрийн газарт улсын төсвөөс олгодог татаасыг 1,489.9 сая төгрөгөөр, ухаалаг засаглал төслийн хүрээнд Дархан хотод байгуулагдаж байгаа нөөц дата төвийн үйл ажиллагааны урсгал зардал зардал 244.8 сая төгрөгөөр нэмэгдэж байгаатай холбоотой байна. Мөн “Төрийн үйлчилгээний цахим машин”-ны үйлчилгээний цар хүрээ өргөжиж байгаатай холбоотойгоор шаардагдах урсгал зардлыг өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тусгасан болно.

Хүснэгт № 102. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц (71302)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	10,376.1	12,312.6	14,419.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,600.6	3,779.0	4,962.2
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	939.2	888.3	0.0
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.5	2.6	2.6
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10.0	0.0	0.0
80220 Холбооны суваг ашигласны хөлс	70.8	70.7	134.7
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	0.5	0.5
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	747.2	842.9	842.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	12.3	15.6	2.5
80809 Эмчилгээний төлбөр	1.2	0.0	0.0

81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	0.0	0.0	107.1
81538	Алслагдсан орон нутагт хүргэх шуудан, харилцаа холбоо	2,159.4	2,192.0	2,347.5
82402	INTELSAT ба REUTERS-ийн суваг ашигласны төлбөр	1,590.0	1,590.0	1,590.0
82403	Радио шугам, хиймэл дагуул, VPN ашиглалт	2,244.9	2,931.1	4,430.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		10,376.1	12,312.6	14,419.9
31	Улсын төсвөөс санхүүжих	8,902.5	10,684.0	12,586.1
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,473.6	1,628.7	1,833.8
Орон тоо		103	103	103
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		10,376.1	12,312.6	14,419.9
09522	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар	5,127.7	5,911.0	7,612.8
09774	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	2,307.8	2,339.3	2,500.0
09839	Үндэсний дата төв	2,940.5	4,062.3	4,307.1

Хөтөлбөр 5: Ангилагдаагүй бусад

Хөтөлбөрийн хүрээнд 2018 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн төлсөн татвар, төлбөр болон Засгийн газар тэдгээр компаниудаас улсын болон орон нутгийн төсвөөр дамжуулан хүлээн авсан татвар, төлбөрийн орлогын тайланг нэгтгэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитор тодруулга хийж, баталгаажуулан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санхүүгийн 12 дэх удаагийн буюу 2017 оны тайланг гаргана.
2. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглахтай холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, цацраг идэвхт ашигт малтмалын судалгааг хөгжүүлэх, цөмийн технологийн энхийн хэрэглээг хөгжүүлэх, нэвтрүүлэх цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, эрдэм, шинжилгээ, туршилт судалгааны ажлыг өргөжүүлэх, хүний нөөц бэлтгэх, салбарын удирдлага зохион байгуулалтын тогтолцоог оновчтой бүрдүүлж УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 1,901.0 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 579.0 сая төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн энергийн комиссын дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, цөмийн энергийн чиглэлээрх эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэх, улсын онц чухал объект болох Изотоп конторын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулах, төрийн албан хаагчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулах, хүн ам ба хүрээлэн байгаа орчныг цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг хэвийн явуулахад чиглэгдсэн зардлуудыг нэмэгдүүлж тусгасантай холбоотой.

Хүснэгт № 103. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Ангилалдаагүй бусад (72301)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	1,318.0	1,322.0	1,901.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	725.6	805.5	1,233.5
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	253.8	0.0	94.2
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	330.3	478.5	478.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	8.2	38.0	9.6
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,318.0	1,322.0	1,901.0
31 Улсын төсвөөс санхүүжих	1,300.1	1,322.0	1,901.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	17.9	0.0	0.0
Орон тоо	43	43	43
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,318.0	1,322.0	1,901.0
09926 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	152.5	214.4	254.4
10491 Цөмийн энергийн комисс	1,165.5	1,107.6	1,646.5

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2018 оны нийт зардлыг 133,304.1 сая төгрөгөөр тооцсон бөгөөд урсгал зардалд 109,266.1 сая төгрөг, гадаад зээл тусламжийн зардалд 9,439.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 5,196.7 сая төгрөг, стратегийн нөөц хөрөнгийн зардалд 9,172.5 сая төгрөгийг төсөвлөсөн байна. Энэ нь өмнөх он буюу 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 15,501.3 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хүснэгт № 104. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	110,065.6	115,840.9	133,304.1
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	9,157.1	10,606.2	9,439.7
Стандартчилал, хэмжил зүй (70407)	4,872.8	5,111.9	5,769.7
Зах зээлийн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт (70410)	673.2	769.1	942.3
Мэргэжлийн хяналт (70417)	25,402.9	26,543.1	28,949.5
Гамшигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх (70708)	67,572.9	71,404.5	83,604.7
Чөлөөт бүсийг хөгжүүлэх (71201)	1,661.6	1,281.3	1,329.4
Ангилалдаагүй бусад (72301)	0.0	0.0	3,268.8

Шадар сайдын багцын 2018 оны Гамшигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөрт урсгал зардалд 73,497.1 сая төгрөг, стратегийн хөрөнгийн зардалд 8,079.7 сая төгрөгийн зардал нийлээд 79,576.8 сая төгрөг, Стандартчилал, хэмжил зүй хөтөлбөрт 5,791.5 сая төгрөг, Зах зээлийн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт хөтөлбөрт 942.3 сая төгрөг, Мэргэжлийн хяналт хөтөлбөрт 28,949.5 сая төгрөг, Чөлөөт бүсийг хөгжүүлэх хөтөлбөрт 1,329.4 сая төгрөгийг тус тус тусгасан байна.

Хүснэгт № 105. ТЕЗ-ын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

ТЕЗ / Хөтөлбөр	Нийт зардал	Урсгал зардал	Үүнээс			Хөрөнгө оруулалт	Гадаад зээл тусламж
			Цалин НДШ	БҮБ зардал	Татаас шилжүүлэг		
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	133,304.1	110,488.0	74,071.60	25,465.60	11,070.40	13,376.40	9,439.70

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	9,439.7	0	0	0	0	9,439.7
Стандартчилал, хэмжил зүй (70407)	5,769.7	5,769.7	3,647.9	1,784.3	337.5	0
Зах зээлийн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт (70410)	942.3	942.3	496.4	402.4	43.6	0
Мэргэжлийн хяналт (70417)	28,949.5	28,949.5	21,408.90	6,800.2	740.4	0
Гамшигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх (70708)	83,604.7	73,497.1	47,559.50	16,051.6	9,886.0	10,107.6
Чөлөөт бүсийг хөгжүүлэх (71201)	1,329.4	1,329.40	959	307.5	62.9	0
Ангилалдаагүй бусад (72301)	3,268.8					3,268.8

Хөтөлбөр 1. Гамшигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх

Онцгой байдлын салбар нийт 4169 хүний бие бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаагаас төрийн тусгай албан хаагч 3740, төрийн үйлчилгээний албан хаагч 207, гэрээт албан хаагч 222 ажиллаж байна. Гамшигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөрийн хүрээнд 79,576.8 сая төгрөгийг 2018 онд зарцуулахаар төсөвлөөд байна.

Хүснэгт № 106. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Год	2018 Төсөл
ХӨТӨЛБӨР: Гамшигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх (70708)	67,572.9	71,404.5	83,604.7
Зориулалт арга хэмжээгээр	67,572.9	71,404.5	83,604.7
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	51,536.5	53,744.9	54,298.5
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	114.6	136.1	136.1
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	3.3	3.3	3.3
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	4.7	0.0	0.0
80220 Холбооны суваг ашигласны хөлс	145.5	140.8	140.8
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	5.6	5.5	5.5
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	39.0	84.0	86.0
80509 Гадаадын, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	49.5	55.6	55.6
80703 Өндөр настан, ахмад дайчдад олгох хөнгөлөлт	2.3	4.5	4.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4,354.9	2,669.0	9,622.4
80803 Төрийн албан хаагчдын гэр бүлд олгох дэмжлэг	0.0	3.5	3.5
80813 Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	200.0	200.0	200.0
80918 Бусад	2,274.3	4,667.2	2,027.9
80920 Векселээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	2,332.2	0.0	0.0
81301 Хүнс барааны нөөц	715.9	1,477.4	1,477.4
81302 Шатахууны нөөц	0.0	1,880.6	1,880.6
81303 Машин техникийн нөөц	1,207.0	1,250.0	1,250.0
81305 Өвс, тэжээлийн нөөц	1,920.0	1,920.0	1,920.0
81308 Үрийн нөөц	872.4	1,551.7	1,551.7
81310 Улсын нөөцийн барааны сэлгэлт, бүрдүүлэлт	865.5	1,092.7	1,092.7
81520 Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	0.0	0.0	2,000.0
81554 Онцгой байдлын бэлтгэл хангах	0.0	0.0	4,894.3
81560 МУЗН-ээр гэрээгээр гүйцэтгүүлэх	0.0	0.0	431.1
82310 Гамшигаас сэргийлэх сургалт, сурталчилгаа	930.0	517.7	522.7
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	67,572.9	71,404.5	83,604.7
31 Улсын төсвөөс санхүүжих	66,091.4	66,768.4	78,968.6
Орон тоо - Албан тушаалаар	0	4,281	4,561

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж 2017 онд ашиглалтад орсон Гал унтраах, аврах ангийн барилгуудын ашиглалтын зардал болох гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг 585.7 сая төгрөгийг тусгав.

“Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлах тухай УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоол, “Монгол Улсад 2016-2018 онд зохион байгуулах олон улсын томоохон хурал, чуулган, арга хэмжээний жагсаалт батлах тухай”

Засгийн газрын 2016 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын II дугаар бага хурлыг 2018 онд Монгол Улсад зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны зардалд 2.0 тэрбум төгрөг төсөлд тусгав.

Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоол "Салбар нэгжийг шинэчлэн байгуулах тухай", Засгийн газрын 2016 оны 183, 2017 оны 192 дугаар тогтоол "Тогтоолд нэмэлт оруулах тухай" -ын дагуу Дорнод аймгийн Халхгол суманд ГУА 4-р зэрэглэлийн 62 дугаар анги, Өмнөговь аймгийн Ханбогд суманд ГУА 4-р зэрэглэлийн 66 дугаар анги, Гурвантэс суманд ГУА 4-р зэрэглэлийн 67 дугаар анги, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд Эрэн хайх, аврах бүлэг, Орхон аймгийн Баян-Өндөр суманд ГУА 4-р зэрэглэлийн 68 дугаар анги, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгонд ГУА 4-р зэрэглэлийн 69 дүгээр анги, Ховд аймгийн Зэрэг суманд ГУА 4-р зэрэглэлийн 70 дугаар анги, Ховд аймгийн Манхан сумын Эрэн хайх, аврах бүлэг, Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд Эрэн хайх, аврах салбарыг тус тус байгуулахад шаардагдах 280 албан хаагчийн цалин, тогтмол зардлыг 4,039.5 сая төгрөг байхаар төсвийн төсөлд тусгалаа.

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 2016, 2017 онд тэтгэвэрт гарсан болон 2017-2018 онуудад тэтгэвэрт гарах нийт 304 албан хаагчид олгох 9,369.9 сая төгрөг төсөвлөв.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Улсын нөөцийн газарт 2018 онд стратегийн нөөц хөрөнгө болох хүнсний барааны нөөцөд 1,477.4 сая төгрөг, шатахууны нөөцөд 1,880.6 сая төгрөг, машин техникийн нөөцөд 1,250.0 сая төгрөг, өвс, тэжээлийн нөөцөд 1,920.0 сая төгрөг, үрийн нөөц бүрдүүлэхэд 1,551.7 сая төгрөг, улсын нөөцийн барааны сэлгэлт, бүрдүүлэлтийн зардалд 1,092.7 сая төгрөг нийт 9,172.5 сая төгрөгийг тусгалаа.

Хүснэгт № 107. Нөөцийн зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
81300 Нөөц хөрөнгийн зориулалт	5,580.7	9,172.5	9,172.5
81301 Хүнс барааны нөөц	715.9	1,477.4	1,477.4
81302 Шатахууны нөөц	0.0	1,880.6	1,880.6
81303 Машин техникийн нөөц	1,207.0	1,250.0	1,250.0
81305 Өвс, тэжээлийн нөөц	1,920.0	1,920.0	1,920.0
81308 Үрийн нөөц	872.4	1,551.7	1,551.7
81310 Улсын нөөцийн барааны сэлгэлт, бүрдүүлэлт	865.5	1,092.7	1,092.7

Хөтөлбөр 2: Мэргэжлийн хяналт

Мэргэжлийн хяналтын хөтөлбөрийн 2018 оны урсгал зардлыг 29,036.6 сая төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотгосон төсвөөс 2,988.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэв.

Хүснэгт № 108. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
ХӨТӨЛБӨР: Мэргэжлийн хяналт (70417)	25,402.9	26,543.1	28,949.5
Зориулалт арга хэмжээгээр	25,402.9	26,543.1	28,949.5
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	23,681.9	24,655.4	26,238.4
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.6	4.7	4.7
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	89.3	101.9	1,879.7
80227 Лабораторийн итгэмжлэл	42.7	67.6	86.2
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	773.1	1,089.9	612.7
80803 Төрийн албан хаагчдын гэр бүлд олгох дэмжлэг	75.2	128.4	127.7

80900 Хөрөнгийн зардлын зориулалт	740.1	495.2	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	25,402.9	26,543.1	28,949.5
31 Улсын төсвөөс санхүүжих	25,249.8	26,390.1	28,796.5
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	153.1	153.0	153.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	25,402.9	26,543.1	28,949.5
00667 Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын алба	18,017.0	18,566.4	18,469.2
09048 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2,771.0	3,171.0	5,705.0
09650 ХМХА-МХЕГ-ын хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори	1,612.4	1,734.4	1,733.3
09656 ХМХА-Сэлэнгэ Сүхбаатар Боомт	693.6	745.2	694.3
09657 ХМХА-Буянт-Ухаа	620.7	712.7	1,237.9
09666 ХМХА-Дорноговь Замын Үүд Боомт	948.1	1,118.2	1,109.7

Дээрх зардлуудыг нэмэгдүүлэхдээ дараах арга хэмжээний зардлуудыг 2018 оны төсвийн төсөлд тусгасан байна. Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн “Хөрөнгө шийдвэрлэх тухай” 180 дугаар тогтоолын дагуу Гашуунсухайт боомт дахь төрийн байгууллага болон Төрийн өмчит үйлдвэрийн газрын албан хаагчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны болон ахуйн хэрэглээний цэвэр усаар хангах зорилгоор Автоцистерн худалдаж авах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд цаашид ашиглалтын зардалд 259.3 сая төгрөг;

Монгол Улсын цөмийн болон бусад цацраг идэвхт материалын экспорт, импортыг хянах техникийн чадавхыг сайжруулах талаар АНУ-ын Эрчим хүчний яам, Цөмийн аюулгүй байдлын газраас хэрэгжүүлэх, Цахим хяналтын системийн үйл ажиллагааг шинэчлэн сайжруулж Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.1.17-д “Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэхэд 240.2 сая төгрөг;

Гашуунсухайт боомтын үйл ажиллагааг өргөжүүлэн бие даасан алба болгох, Улсын их хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 6.1.1 дэх заалт “Шинээр барих олон улсын нисэх буудлыг Хойд Азийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа болгон тус нисэх буудлын нутаг дэвсгэрийг оролцуулан эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зардалд 2,446.7 сая төгрөг;

Буянт-Ухаа боомт дахь Хилийн Мэргэжлийн хяналтын албаны ажлын байрны зориулалтаар түрээсэлж буй байрны түрээсийн зардал, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтад “байгаль орчин, хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах” гэж заасныг үндэслэн, Урвалж бодисын үнэ сүүлийн жилүүдэд валютын ханшийн өсөлттэй холбоотой байнга нэмэгдэх болсон, түүнчлэн аж ахуй нэгжийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсэнтэй холбоотойгоор шинжилгээнд өгөх бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж байгаа байгаатай холбогдох 628.5 сая төгрөгийг тусгасан байна. 2018 онд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 612.7 сая төгрөг байхаар төсвийн төсөлд тусгалаа.

Хөтөлбөр 3. Стандартчилал Хэмжил зүй

Стандартчилал хэмжил зүй хөтөлбөрийн зардлыг 5,791.5 сая төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 679.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Стандарт, хэмжил зүйн газар нь 20 аймагт салбар хэлтэстэйгээр “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай”, “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай”, “Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай”, “Хүнсний тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай” зэрэг бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг Монгол Улсын хэмжээнд хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт № 108. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Год	2018 Төсөл
ХӨТӨЛБӨР: Стандартчилал, хэмжил зүй (70407)	4,872.8	5,111.9	5,769.7
Зориулалт арга хэмжээгээр	4,872.8	5,111.9	5,769.7
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	4,394.5	4,505.4	4,772.0
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	0.7	0.7
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	32.0	31.7	31.7
80219 Харуул, хамгаалалтын зардал	33.4	30.9	22.9
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	11.0	20.2	20.2
80509 Олон улсын байгууллагын гишүүн хураамж	141.8	159.2	221.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	260.1	319.1	115.8
81304 Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц	0.0	44.6	584.6
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	4,872.8	5,111.9	5,769.7
31 Улсын төсвөөс санхүүжих	4,872.7	5,111.9	5,769.7
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.1	0.0	0.0
Орон тоо - Албан тушаалаар	0	383	383
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	4,872.8	5,111.9	5,769.7
00665 Стандартчилал, хэмжил зүйн газар	4,872.8	5,111.9	5,769.7

Стандартчилал хэмжил зүйн газар нь 2017 оны эхний хагас жилийн байдлаар аймгуудад тогтмол зардлын өр үүссэн мөн Монгол улсын хэмжээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, бүтээгдэхүүн, хүнсний аюулгүй байдлыг тохирлын үнэлгээгээр дамжуулан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хавар, намар нийслэлийн бүх дүүрэг, аймгийн төв, бүх сумдад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн бүх төрлийн хэмжих хэрэгсэлд ээлжит баталгаажуулалт хийх, үйлчилгээ үзүүлдэг бүх төрлийн дэлгүүр, супер маркет, үсчин, халуун ус, зочид буудал, хүнсний бүх төрлийн үйлдвэр гэх мэт аж ахуйн нэгж, байгууллагуудад тохирлын үнэлгээ хийгдэх зардалд 525.2 сая төгрөгийг төсөвлөв. 2018 онд системийн хэмжээнд 8 хүн тэтгэвэрт гарах бөгөөд нэг удаагийн тэтгэмжийн зардалд 154.4 сая төгрөг тусгалаа.

Хөтөлбөр 4 Зах зээлийн өрсөлдөөн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийн хамгаалалт хөтөлбөрийн зардлыг 2018 онд 946.4 сая төгрөг байхаар тооцов.

Хүснэгт № 109. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Год	2018 Төсөл
ХӨТӨЛБӨР: Зах зээлийн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт (70410)	673.2	769.1	942.3
Зориулалт арга хэмжээгээр	673.2	769.1	942.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	570.6	614.0	643.1
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	22.0	5.0	5.0
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	51.5	50.7	250.7
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	0.0	1.4	1.4
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	29.1	97.9	42.2
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	673.2	769.1	942.3
31 Улсын төсвөөс санхүүжих	672.8	769.1	942.3
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.4	0.0	0.0
Орон тоо - Албан тушаалаар	0	36	36
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	673.2	769.1	942.3
09523 Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	673.2	769.1	942.3

Энэ нь шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийн хамгаалалт хөтөлбөрийн 2018 оны төсвийн төслийг 2017 оны батлагдсан хязгаарын түвшинд тооцож тусгасан болно.

Хөтөлбөр-5. Чөлөөт бүс хөгжүүлэх

Чөлөөт бүс хөгжүүлэх хөтөлбөрийн урсгал зардлыг 2018 онд 1,329.4 сая төгрөг байхаар тооцсон нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 48.1 сая төгрөгөөр нэмэгдэж.

Хүснэгт № 110. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Чөлөөт бүсийг хөгжүүлэх (71201)	1,271.2	1,281.3	1,329.4
Зориулалт арга хэмжээгээр	1,271.2	1,281.3	1,329.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,210.1	1,196.0	1,219.5
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	1.2	0.6	1.4
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	52.2	54.7	41.3
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5.2	24.7	62.9
81307 Хангамжийн материалын нөөц	0.5	0.0	1.0
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх	2.1	5.3	3.3
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,271.2	1,281.3	1,329.4
31 Улсын төсвөөс санхүүжих	995.4	1,281.3	1,329.4
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	275.8	0.0	0.0
Орон тоо - Албан тушаалаар	0	101	101
420001 Удирдах ажилтан	0	14	14.0
420002 Гүйцэтгэх ажилтан	0	72	72.0
420003 Үйлчлэх ажилтан	0	15	15.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,271.2	1,281.3	1,329.4
09052 "Алтанбулаг" чөлөөт бүс	553.2	560.8	572.1
09300 "Замын үүд" чөлөөт бүс	444.2	476.3	456.6
09302 "Цагааннуур" чөлөөт бүс	273.8	244.2	300.5

2018 оны төсвийн төсөлд Алтанбулаг чөлөөт бүсийн урсгал зардалд 572.2 сая төгрөг, Замын-Үүд чөлөөт бүс 456.7 сая төгрөг, Цагааннуур чөлөөт бүсийн зардалд 300.5 сая төгрөгийг төсөвлөсөн нь уг хөтөлбөрүүдийг 2017 онд хэрэгжүүлсэн төсвийн түвшинд тооцож тусгалаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2018 нийт зарлага цэвэр зээлийн дүн нь 40,312.5 сая төгрөг бөгөөд үүнээс улсын төсвөөс санхүүжих урсгал зардлыг 13,470.0 сая төгрөгөөр тооцож төсвийн төсөлд тусгасан.

Хүснэгт № 111. Хөтөлбөрийн зардлын хураангуй дунд хугацаагаар /сая төгрөг/

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН НИЙТ ДҮН	12,412.0	21,590.3	40,312.5
Гүйцэтгэх засаглалын удирдлага (70103)	5,409.7	6,258.5	7,694.0
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	2,115.8	6,097.0	8,027.7
Төр, засгийн аж ахуйн үйлчилгээ (70413)	4,886.6	9,234.9	24,590.8

Багцын нийт зарлагад хөрөнгө оруулалтын зардал 17,814.8 сая төгрөгөөр, гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал 8,027.7 сая төгрөг, төсвөөс санхүүжих урсгал зардал 13,470.0 сая төгрөгөөр тооцож төсөвлөсөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт № 112: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм / сая төгрөг/

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	Нийт зарлага	Урсгал зардал	Үүнээс			Хөрөнгийн зардал
			Цалин НДШ	Бараа үйлч. Бусад	Татаас	
ТЕЗ-ын хөтөлбөрүүдийн нийт дүн	40,312.5	21,497.7	6,553.9	14,132.5	811.3	18,814.8
Гүйцэтгэх засаглалын удирдлага (70103)	7,694.0	7,694.0	2,036.4	4,891.1	766.5	0.0
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	8,027.7	8,027.7	0.0	8,027.7	0.0	0.0
Төр, засгийн аж ахуйн үйлчилгээ (70413)	24,590.8	5,776.0	4,517.5	1,213.7	44.8	18,814.8

Багцын төсвийн төслийг боловсруулахдаа 2017 онд хэрэгжүүлсэн нэг удаагийн арга хэмжээний зардлыг бууруулж, зайлшгүй шаардлагатай зарим арга хэмжээний зардлыг нэмж тусгасан болно. Тухайлбал, 2017 онд хэрэгжсэн Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор ард нийтийн санал асуулга авах зардал 250 сая төгрөгийг бууруулж, “Тэргүүний сум шалгаруулах болзол батлах тухай” Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолын дагуу шагналд зарцуулагдах 400.0 сая төгрөг, Засгийн газрын захиалгат сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний зардал болон байр ашиглалтын тогтмол зардлыг 137.9 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлж төсөлд тусгасан.

Хөтөлбөр 1. Гүйцэтгэх засаглалын удирдлага, тэдгээрийн ажлын алба

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 7,694.0 сая төгрөгөөр төсөвлөлөө. Төсвийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн нөхцөл байдал, засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан зайлшгүй шаардлагатай зарим арга хэмжээний зардлыг тусгасан болно.

Хөтөлбөрийн хүрээнд 2018 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлогыг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын орчныг бүрдүүлж Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр шуурхай ханган, Засгийн газрын тасралтгүй, хэвийн, үр ашигтай ажиллагааны зохистой орчин бүрдүүлж, Засгийн газрын шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, шийдвэрийн биелэлтийн гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг нэгтгэн, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг зохицуулахад дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Хүснэгт № 113. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Гүйцэтгэх засаглалын удирдлага (70103)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	5,409.7	6,258.5	7,694.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3,212.0	4,006.3	4,613.8
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	35.0	31.6	521.6
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	26.2	29.5	29.5
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	7.1	9.9	9.9
80312 Сургалт семинар	200.0	297.0	297.0
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	0.0	0.7	0.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	193.0	135.1	179.8
81506 Төрийн байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах	523.8	150.0	550.0
81518 Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээ	44.8	150.0	150.0
81519 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	1,032.4	1,097.4	1,240.6
81539 Бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр	101.9	0.0	0.0

81546	Санал асуулга зохион байгуулах	0.0	250.0	0.0
81829	Урамшууллын тэтгэлэг	33.4	36.0	36.0
83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	0.0	65.0	65.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		5,409.7	6,258.5	7,694.0
31	Улсын төсвөөс санхүүжих	5,409.7	6,258.5	7,694.0
Орон тоо		123	123	123
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		5,409.7	6,258.5	7,694.0
00005	Монгол Улсын Ерөнхий сайдын төсөв	792.3	1,465.3	2,205.3
09515	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	4,452.3	4,566.5	5,201.5
09837	Шадар сайдын ажлын алба -1	165.1	226.7	287.2

Хөтөлбөр 2: Төр, засгийн аж ахуйн үйлчилгээ

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 5,776.0 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 399.0 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Энэ нь Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын үйл ажиллагааны дутагдаж байгаа зардлыг нэмэгдүүлж төсвийн төсөлд тусгасантай холбоотой.

Хүснэгт № 114. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт /төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Төр, засгийн аж ахуйн үйлчилгээ (70413)		2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр		4,847.3	5,377.0	5,776.0
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,810.3	5,253.1	5,559.7
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	18.8	0.0	0.0
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	68.5	68.5
80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	1.5	1.5
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	18.2	53.9	44.8
80834	Ерөнхийлөгч асанд хуулийн дагуу олгох цалин	0.0	0.0	101.5
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		4,847.3	5,377.0	5,776.0
31	Улсын төсвөөс санхүүжих	4,733.0	5,234.5	5,633.5
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	114.4	142.5	142.5
Орон тоо		443	443	443
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		4,847.3	5,377.0	5,787.1
09983	Төр засгийн үйлчилгээ авто бааз	1,668.5	2,328.7	2,349.7
10111	ТЗҮЭААГ (шинэ)	2,994.1	2,839.3	3,155.1
10151	Төрийн түүхийн музей шинэ	184.7	208.9	271.2

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Гадаад харилцааны сайдын төсвийн багцын 2018 оны урсгал зардлыг 69,259.3 сая төгрөгөөр тооцсоны 68,109.3 сая төгрөгийг урсгалд зардалд, 1,150.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалт, их засварын ажилд зарцуулахаар төсвийн төсөлд тусгасан байна. Энэ нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 5,662.6 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хүснэгт № 115. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	70,592.8	63,596.8	69,259.3
Гадаад харилцаа (70300)	70,552.1	63,596.8	69,259.3
Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа	45,423.8	53,275.0	56,555.3
Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх	155.7	1,109.4	1,133.8
Гадаад улс оронд байгаа монгол иргэдэд туслах	222.8	224.0	224.0
Гадаад харилцааны бодлого, удирдлага	24,749.7	8,983.9	11,346.1

Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа, Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Гадаад улс оронд байгаа Монгол иргэдэд туслах, Гадаад харилцааны бодлого, удирдлага, Юниско, Мянганы сорилтын корпорацийн үндэсний ажлын албаны хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа ха.

Хүснэгт № 116. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

ТЭЗ / Хөтөлбөр	Нийт зардал	Үүнээс				Хөрөнгө оруулалт
		Урсгал зардал	Цалин НДШ	БҮБ зардал	Татаас шилжүүлэг	
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	69,259.4	68,109.4	26,910.8	37,262.1	3,936.3	1,150.0
Гадаад харилцаа	69,259.4	68,109.3	26,910.8	37,262.1	3,936.3	-
Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа	56,555.3	56,555.3	24,680.0	31,535.5	339.8	-
Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх	1,133.8	1,133.8	98.4	1,035.4	0.0	-
Гадаад улс оронд байгаа монгол иргэдэд туслах	224.0	224.0	0.0	0.0	224.0	-
Гадаад харилцааны бодлого, удирдлага	11,346.1	10,196.1	2,132.4	4,691.2	3,372.5	-
Гадаад харилцааны хөрөнгө оруулалт, их засвар	-	-	-	-	-	1,150.0

Хөтөлбөр 1. Гадаад харилцааны бодлого удирдлага, үйл ажиллагаа

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 11,346.1 төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотгосон төсвөөс 1,917.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Далайд гарцгүй орнуудын олон улсын судалгааны төв, Мянганы сорилтын корпорацийн усан хангамжийг сайжруулах төслийн ажлын алба шинээр байгуулагдсантай холбоотой зардлуудыг тусгасантай холбоотой байна.

Хүснэгт № 117. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ХӨТӨЛБӨР: Гадаад харилцааны бодлого, удирдлага (70305)	24,749.7	8,983.9	10,196.1
Зориулалт арга хэмжээгээр	24,749.7	8,983.9	10,196.1
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,977.1	4,326.6	4,392.9
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	7.0	13.6	13.6
80218 Улс орноо гадаадад сурталчлах	0.0	297.0	297.0
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2.2	5.0	5.0
80509 Олон улсын байгууллагын гишүүнчлэл хур.	1,131.9	3,223.7	3,223.7
80510 Гадаад орнуудад өгөх урсгал шилжүүлэг	540.0	0.0	0.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	89.5	126.1	148.8
80812 Бүтцийн өөрчлөлтийн тэтгэмж	4.0	0.0	0.0
81520 Олон улсын хурал, зөвлөгөөн	19,268.7	0.0	254.1
81552 МСК усан хангамжийг сайжруулах	0.0	0.0	1,169.2
81553 Далайд гарцгүй орнуудын ОУ судалгаа	0.0	0.0	400.0
82905 Засгийн газар хоорондын комисс	128.1	291.9	291.9
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	24,749.7	8,983.9	10,786.1
31 Улсын төсвөөс санхүүжих	24,118.7	8,423.9	10,786.1
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	24,749.7	8,983.9	10,196.1
00049 Гадаад харилцааны яам /шинэ/	24,148.5	8,283.9	10,196.1

Мянганы сорилтын корпорациас Монгол улсын засгийн газартай байгуулсан хэлэлцээрийн дагуу Компакт гэрээ 2-ыг байгуулах ажлын хүрээнд байгуулсан ажлын алба нь 2 жил тус корпорациас санхүүжигдсэн бөгөөд үлдсэн 1 жилийн санхүүжилтийг Монголын талаас хариуцах зардлыг 1,169.2 сая төгрөг байхаар тусгасан.

Монгол Улс Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийг Улаанбаатарт байгуулах санаачилга 2006 онд гаргаснаас хойш НҮБ болон далайд

гарцгүй бусад орны дэмжлэг авах ажлыг идэвхтэй зохион байгуулсны дүнд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр тус Төвийн шавыг тавьж, Монгол Улсын Засгийн газраас ОУСТ-ийг үүсгэн байгуулах тухай Олон талт хэлэлцээрийг 2010 онд ДГХБО-ын Гадаад хэргийн сайд нарын хурлаар батлуулсан. Ингэснээр Монгол Улсад төвтэй анхны Засгийн газар хоорондын олон улсын байгууллага болж, 2018 оноос албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхлэх тул санаачлагч болон хүлээн авагч орны хувьд Монгол Улсын Засгийн газраас ДГХБО-ын ОУСТ-ийн Удирдах зөвлөлд нөлөөтэй байх үүднээс тэргүүлэх байр сууриа хадгалан тодорхой хэмжээний санхүүгийн хандив өгөх хэрэгтэй гэж үзэж байгаа тул 2018 оны төсөвт 400.0 сая төгрөг суулгах шаардлагатай байна.

Гадаад харилцааны яамны ёслол хүндэтгэлийн өргөө шинээр 2018 онд ашиглалтад орж байгаатай холбогдуулан халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны байр ашиглалтын тогтмол зардалд 245.9 сая төгрөгийг тусгасан байна.

Улаанбаатарын хэлэлцээр олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах зардалд 200 сая, Сонгууль ажиллагчдын олон улсын сургалтын төвийн зардалд 54.1 сая төгрөг байхаар төсвийн төсөлд тусгалаа.

Хөтөлбөр.2 Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа /70301/

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 56,566.0 сая төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 3,291.0 сая төгрөгөөр нэмэгдсэн төсөв байна.

Хүснэгт № 118. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ХӨТӨЛБӨР: Гадаад улс орнууд дахь дипломат үйл ажиллагаа	45,423.8	53,275.0	56,555.3
Зориулалт арга хэмжээгээр	45,423.8	53,275.0	56,555.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	45,217.4	51,878.8	55,138.3
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	0.0	7.3	7.3
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	8.5	0.0	0.0
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	1,066.0	1,066.0
80312 Сургалт семинар	2.1	3.9	3.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	73.5	319.1	339.8
82808 Бусад баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээ	122.3	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	45,423.8	53,275.0	56,555.3
31 Улсын төсвөөс санхүүжих	44,083.6	53,275.0	56,555.3
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,340.2	0.0	0.0
Орон гоо - Албан тушаалаар	0	490	490.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	45,423.8	53,275.0	56,555.3
00051 Дипломат төлөөлөгчийн газар	45,423.8	53,275.0	56,555.3

Дипломат албаны хуульд орсон 2017 оны 1 сарын 26-ны өдрийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа ажилтануудын хүүхдүүдийг цэцэрлэгт хамрагдуулах зорилгоор “Суугаа орны сургуулийн өмнөх боловсролын сургалт төлбөртэй бол хүүхдийнх сургалтын төлбөрийг тухайн сургалтын дундажийн 70 хувиар тооцон олгоно” гэсэн заалт орсонтой холбогдуулан 2018 оны төсөвт Астана, Анкара, Бангкок, Будапешт, Бээжин, Варшав, Вашингтон, Вьентьян, Кайр, Лондон, Оттава, Прага, Пхеньян, Сингапур, Софи, Сеул, Токио, Канберра, Стокгольм, Эль-Кувейт, Ром, Нью-Йорк, Женев, Эрхүү, Улаан-Үд, Эрэн, Гонгконг, Бусан, Сан-Франциско, Бишкек, Истанбулд суугаа нийт 31 дипломат төлөөлөгчийн газрын

ажилтануудын 92 хүүхдийн цэцэрлэгт хамрагдахад зориулан 2,987.2 сая төгрөг байхаар тусгалаа.

Хөтөлбөр 3: Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх /70303/

Хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 143.8 сая төгрөгөөр төсөвт тусгасан нь 2017 оны төсвийн тодотголын түвшинд байна.

Хүснэгт № 119. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	155.7	1,109.4	1,133.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	116.1	115.4	126.7
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	0.7	1.5	14.6
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.1	0.1	0.1
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	22.0	0.0	0.0
80220 Холбооны суваг ашигласны хөлс	2.5	2.5	2.5
82902 Гадаад харилцааг эдийн засагжуулах	14.2	990.0	990.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	155.7	1,109.4	1,133.8
31 Улсын төсвөөс санхүүжих	141.5	119.4	143.8
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	14.2	990.0	990.0
Орон тоо - Албан түшаалаар	0	9	9.0

Хөтөлбөр 4. Гадаад улс оронд байгаа Монгол иргэдэд туслах /70304/

Сангийн урсгал зардлыг нийт 224.0 сая төгрөгөөр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд 2017 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нас барсан иргэдийн шарил, чандрыг эх оронд буцаах болон тухайн улсад нутаглуулах;
2. Амь насанд нь аюул учирсан иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлж эх оронд нь буцаах;
3. Ял эдэлж байгаад суллагдсан болон төлбөрийн чадваргүй болсон иргэдийг эх оронд нь буцаах;
4. Хилийн чанадад ял эдэлж байгаа иргэдийг эргэх;
5. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд хилийн чанадад хүний наймааны хохирогч болсон иргэдийг түр хамгаалах байраар хангах, үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаахтай холбогдсон бүхий л арга хэмжээг авах;
6. Гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн байгуулсан сайн дурын холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаар төлөвлөсөн;

Хүснэгт № 120. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	222.8	224.0	224.0
80820 Бусад тусламж, дэмжлэг	222.8	224.0	224.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	222.8	224.0	224.0
31 Улсын төсвөөс санхүүжих	222.8	224.0	224.0

Хөтөлбөр 5. Олон улсын хамтын ажиллагаа

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалыг мөрдлөг болгон өөрийн орны ардчилсан үйл явцын туршлагаас хуваалцах, олон улсын тавцанд нэр хүнд, байр сууриа бэхжүүлэх, гадаадын зарим улстай хоёр талын хамтын

ажиллагааг өргөжүүлэх зорилтыг дипломат үйл ажиллагааны зөөлөн хүчний бодлогоор дамжуулан хэрэгжүүлэхийг зорьж ажиллана.

Хүснэгт № 121. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	14.2	990.0	990.0
82902 Гадаад харилцааг эдийн засагжуулах	14.2	990.0	990.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	14.2	990.0	990.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	14.2	990.0	990.0

Олон улсын хамтын ажиллагааны сангийн зардлаар ардчилал, хүний эрх, сайн засаглалын чиглэлээрх олон улсын байгууллага, механизмд үндэсний экспертүүдийг ажиллуулахад сангийн урсгал зардал 990.0 сая төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр тооцож төсвийн төсөлд тусгасан.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцын 2018 оны төсвийн төслийн урсгал зардалд 420,357.9 сая төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлд 20,600.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 37,990.0 сая төгрөг, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төслийн зардалд 26,270.9 сая төгрөг, нийт **464,018.1** сая төгрөгөөр төсөвлөлөө. Үүнээс, урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 5,349.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багц нь төрийн нийтлэг бусад үйлчилгээ, үйл ажиллагаа гэсэн хөтөлбөрийн хүрээнд 4 дэд хөтөлбөр, батлан хамгаалах хөтөлбөрийн хүрээнд 1 дэд хөтөлбөр, эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдал хөтөлбөрийн хүрээнд 7 дэд хөтөлбөр, эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд 1 дэд хөтөлбөрт хуваагдаж байна. Төсвийн хуваарилалтыг хөтөлбөрөөр үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 122. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц.	2017 тод.	2018 төсөл
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	304,034.8	422,080.2	464,018.1
Бүх шатны сонгууль зохион байгуулах (70403)	3,480.2	2,178.0	0.0
Албан ёсны статистик (70405)	4,511.8	0.0	0.0
Улсын бүртгэл, мэдээлэл (70406)	20,521.3	21,254.5	23,804.4
Төрийн архив, албан хэрэг хөтлөлт (70411)	3,326.2	3,568.0	3,308.0
Цагаачлал, гадаадын иргэдийн бүртгэлийн үйлчилгээ (70420)	9,571.3	5,645.1	6,395.8
Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт (70428)	196.2	384.9	388.0
Хил хамгаалах (70602)	5,826.0	116,956.8	114,857.5
Цагдаа (70704)	149,802.8	154,537.1	158,486.2
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл (70705)	59,033.3	46,699.4	46,035.7
Шүүхийн шинжилгээ (70707)	8,563.2	9,864.8	9,879.6
Төлбөрийн чадваргүй яллагдагч, сэжигтэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх (70710)	840.5	870.5	885.8
Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах (70711)	8,057.4	6,617.0	6,622.4
Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт (70712)	3,843.8	9,329.3	9,508.7
Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа шинжилгээ (70713)	11,101.2	11,731.0	12,093.5
Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	0.0	4,766.5	7,491.5
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	0.0	14.1	26,270.9
Хөрөнгийн зардал	15,359.5	27,663.2	37,990.0

Төсвийн урсгал зардлын өсөлтөд шинээр батлагдсан Эрүүгийн хууль, Эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулиудыг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл зэрэг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, 2017 онд бий болсон шинэ хөрөнгө оруулалтын ашиглалтын улмаас шаардагдах зардал, түүнчлэн гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардал, хөрөнгийн зардлыг нэмэгдүүлсэн нь гол нөлөөлөл үзүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрээр нь авч үзвэл, улсын төсвөөс 437,365.8 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 5,481.4 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 15,500.8 сая төгрөг, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс 26,270.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд эргэж төлөгдөх цэвэр зээлд 20,600.7 сая төгрөгийн авлагыг тусгалаа.

Улсын Их Хурлаас 2007 онд баталсан “Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай” хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу 2007 онд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон хадгаламж, зээлийн хоршооны хохирогчдын хохирлын төлбөр болох 36,150.7 сая төгрөгөөс 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 15,550.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 2017 оны байдлаар 20,600.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт № 123. ТЕЗ-ийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	Нийт урсгал зардал	Үүнээс:				Зээл, тусламж	Хөрөнгө оруулалт
		Цалин, НДШ	Бараа үйлчил-гээний бусад	Татаас шилжүүлэг	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл		
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	464,018.1	265,596.3	127,874.3	26,887.2	-20,600.7	26,270.9	37,990.0
Улсын бүртгэл, мэдээлэл	23,804.4	13,553.8	9,575.1	675.5			
Төрийн архив, албан хэрэг хөтлөлт	3,307.9	2,211.6	1,035.2	61.1			
Цагаачлал, гадаадын иргэдийн бүртгэлийн үйлчилгээ	6,395.8	3,883.0	2,147.6	365.2			
Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт	388.0	346.9	41.1	0.0			
Хил хамгаалах	114,857.5	73,660.8	27,433.1	13,763.6			
Цагдаа	158,486.2	112,265.9	38,423.7	7,796.5			
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	66,636.5	34,609.5	28,248.6	3,778.4			
Шүүхийн шинжилгээ	9,879.6	7,026.6	2,636.1	216.9			
Төлбөрийн чадваргүй яллагдагч, сэжигтэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх	885.8	736.5	140.5	8.7			
Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах	6,622.4	4,829.4	1,793.0	0.0			
Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт	9,508.8	1,522.5	7,974.9	11.3			
Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа шинжилгээ	12,093.5	7,044.5	4,872.6	176.5			
Эмнэлгийн тусламж үйлчилгээ	7,491.5	3,905.3	3,552.8	33.5			
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	26,270.90	0	0	0		26,270.9	
Хөрөнгийн зардал	37,990.0	0	0	0			37,990.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-20,600.7	0	0	0	-20,600.7		

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны төсвийн төслийг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад нэмэгдсэн зардлыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл, цалин, нэмэгдэл урамшлын зардлыг 5,330.2 сая төгрөгөөр, байр ашиглалтын тогтмол

зардлыг 1,983.9 сая төгрөгөөр, нормативт зардлыг 5,400.7 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1,335.5 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 244.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд тус багцын хүрээнд нийт 466 албан хаагчийн 14,580.5 сая төгрөг тусгасан нь өмнөх оны төвшнөөс 1,733.8 сая төгрөгөөр буурч, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжийн зардалд Монгол Улсын хилийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 9,477.9 сая төгрөгийг тусгасан нь 2017 оны тодотгосон төсвөөс 1,988.3 сая төгрөгөөр өссөн байна.

Харин 2017 онд нэг удаагийн шинж чанартай хэрэгжиж дууссан хилийн заставуудыг сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөр хангах, Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлыг тус тус бууруулсан.

Хөтөлбөр 1. Цагдаа

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны урсгал зардлыг Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, байцаан шийтгэх ажиллагааны зардал, орон нутгийн 327 сумын цагдаагийн кабоны тогтмол зардлыг шийдвэрлэх зорилгоор 160,355.6 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотгосон төсвөөс 4,225.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж байна. Үүнээс цагдаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 155,702.2 сая төгрөгийн урсгал зардлыг төсөвлөв.

Үүнд, цагдаагийн байгууллагад АSEM-ийн хурлыг зохион байгуулахад аюулгүй байдлыг хангах зорилгоор орон тооны нөхөн хангалт хийснээр бий болсон цалингийн зардлын өглөгт 2,402.2 сая төгрөг, байр ашиглалтын тогтмол зардалд 188.2 сая төгрөгөөр, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу шийдвэрлэх хэргийн тоо хэмжээний өсөлтийг тооцон бичиг хэрэг, цагдаагийн автомашины тээвэр шатахууны зардлыг 269.5 сая төгрөгөөр нэмж тусгав.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардлыг 2017 оны тодотгосон төсвөөс 786.1 сая төгрөгөөр нэмж тусгав. Мөн орон нутгийн цагдаагийн 327 кобаны гэрэл цахилгаан, түлш халаалтын зардалд 765.2 сая төгрөг төсөлд тусгав. Тэтгэвэрт гарахад олгох 151 хүний нэг удаагийн тэтгэмжийн зардалд 5,218.1 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 2,238.4 сая төгрөг тусгав.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2018 оны урсгал төсвийн зардлыг 2,783.9 сая төгрөгөөр төсөлд тусгасан нь БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр 2010 онд хэрэгжүүлсэн “Холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ” төслийн хүрээнд гудамж талбайд суурилуулсан хэв журмын хяналтын камерын хяналт хийх шуурхай удирдлагын төвийн дуудлага, хүлээн авах нэгдсэн танхимд байрлах ханын 70 инчийн 10

дэлгэцийн 3 ширхэг проекторыг солихоор 2017 оны төсөвт нэмж тусгасан нэг удаагийн шинжтэй 284.0 сая төгрөгөөр бууруулж, татаас шилжүүлгийн зардлыг 113,6 сая төгрөгөөр буюу 46 хувиар нэмэгдүүлж 2017 оны тодотгосон төсвөөс 137.2 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт № 124. Цагдаа хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Цагдаа (70704)	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	149,802.8	154,537.1	158,486.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	132,130.5	134,364.5	137,753.4
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	8,322.8	10,579.8	10,579.8
80219 Харуул, хамгаалалтын зардал	1,121.3	1,119.5	1,119.5
80220 Холбооны суваг ашигласны хөлс	106.0	90.0	90.0
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	7.1	19.8	19.8
80312 Сургалт семинар	9.2	15.6	15.6
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	37.2	48.1	48.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	7,505.4	7,619.2	7,748.4
81501 Ерөнхийлөгчийн сонгууль	0.0	355.1	0.0
81503 Орон нутгийн сонгууль	285.4	0.0	0.0
82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	277.7	325.5	84.5
82315 Байцаан шийтгэх ажиллагаа ¹¹	0.0	0.0	1,027.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	149,802.8	154,537.1	158,486.2
31 Улсын төсвөөс санхүүжих	140,944.3	145,455.1	149,404.2
33 Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	121.0	120.5	120.5
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	8,737.5	8,961.6	8,961.6
Орон тоо - Албан тушаалаар	9621	9,621	9,621
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	149,802.8	154,537.1	158,486.2
Цагдаагийн ерөнхий газар	24,333.5	24,259.3	26,642.7
Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтэс	87,438.2	82,529.9	83,812.0
Мэдээлэл шуурхай удирдлагын төв	2,635.2	2,921.2	2,784.0
ЦЕГ-ын бусад харьяа нэгж ⁸ байгууллагууд	35,395.9	44,826.7	45,247.5

Хөтөлбөр 2. Хил хамгаалах

Хил хамгаалах хөтөлбөрийн 2018 оны төсвийн төслийг нийт 114,857.5 сая төгрөгөөр төсөвлөв. Хил хамгаалах хөтөлбөрийн 2018 оны урсгал зардлыг 2017 оны төсвийн тодотголын төвшинтэй харьцуулахад 2,099.3 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд, үндсэн үйл ажиллагааны зардлыг 3,719.9 сая төгрөгөөр бууруулж, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 41.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хугацаат цэргийн албан хаагчийн цолны цалинг 47.9 сая төгрөгөөр бууруулж, хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговрын зардлыг 923.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна.

Олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орохтой холбогдуулан

¹¹ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” гэсэн зориулалтад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу гарах байцаан шийтгэх ажиллагааны зардлыг өмнөх онуудад тусгаж төлөвлөсөн бөгөөд 2018 оны төсвийн төсөлд прокурор, хууль сахиулах салбарын зарим байгууллагын байцаан шийтгэх ажиллагааны зардлыг нэг зориулалтаар тусгахаар төлөвлөж, “Байцаан шийтгэх ажиллагаа” гэсэн шинэ зориулалтад зардлыг шилжүүлэн тусгасан болно.

шалган нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагчдын орон тоог 50-аар нэмэгдүүлэх урсгал зардалд 887.1 сая төгрөг, Гашуун сухайтын боомтын хилийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд 60 орон тоо нэмэгдүүлэхэд шаардагдах урсгал зардалд 976.2 сая төгрөг тус тус нэмэгдүүлэн тусгалаа.

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд нийт 153 албан хаагчийн 4,753.6 сая төгрөг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь заалтад заасны дагуу улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа 305 офицер, ахлагчид олгох мөнгөн урамшлын зардалд 6,931.4 сая төгрөг тусгалаа.

Хүснэгт № 124. Хил хамгаалах хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот айл өрхөд 5000 ширхэг цахилгаан халаагуур, 570 ширхэг сайжруулсан зуух, 1000 тонн боловсруулсан түлш олгоход 1.4 тэрбум төгрөг, агаар, орчны бохирдлыг бууруулах техник, технологийг олон нийтэд сурталчлах, таниулах, борлуулах, зээл олгох үйлчилгээг явуулах мэдээллийн төв

байгуулах зардалд 400.0 сая төгрөг, сургалт сурталчилгаа, стандарт нормыг боловсруулах ажилд 200.0 сая төгрөг тус тус зарцуулахаар тооцлоо.

Агаарын чанарыг сайжруулах бүсэд байрлах гэр хорооллын айл өрхийг цахилгаанаар халаахад Сонгино-Хайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн 15 трансформаторын дэд өртөө, хэт ачаалагдсан 36 дэд станц, ЦДАШ-г шинэчлэх, хүчин чадлыг өргөтгөх ажилд 2.9 тэрбум төгрөгийг төсөвлөв.

Мөн АХБ-аас өгсөн зөвлөмжийн дагуу Засгийн газраас нийслэлийн гэр хорооллын айл өрхийг 80,000 тонн хагас коксжсон шахмал түлшийг хөнгөлөлттэй үнээр хангах, үүнтэй холбогдуулан түүхий нүүрс болон хагас боловсруулсан түлшний үнийн зөрүүний татаасанд 3,750.0 сая төгрөгийг зарцуулахаар тооцлоо.

Хүснэгт № 41. Гэр хорооллын айл өрхөд сайжруулсан түлшний үнийн хөнгөлөлт олгох

	Түлшний төрөл	1 тонн үнэ /мян төг/	Нийт үнэ /тэрб.төг/
1	Түүхий нүүрс /80 мян.тонн/	125.0	12.3
2	Хагас коксжсон шахмал нүүрс /80 мян.тонн/	200.0	16.0
3	ЗГ-аас олгох үнийн зөрүү /80 мян.тонн/	75.0	3.7

Хөтөлбөр 6: Ус цаг уур, орчны шинжилгээ

Ус цаг уур, орчны шинжилгээ салбарт 26 байгууллага 1893 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар тооцож, 21,838.9 сая төгрөг төсөвлөгдсөнөөс цалин, НДШ-ийн зардал 17,457.8 сая төгрөг буюу 79.9 хувийг эзэлж байна.

2018 оны төсвийн төсөлд даатгалд төлөх шимтгэлийн зардалд 165.2 сая төгрөг, цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх борооны пуужин 1000 ширхэг, газрын генераторын түлш 500 ширхгийг худалдаж авах зардалд 420.0 сая төгрөг, Хөшигтийн хөндийн шинэ нисэх буудал ашиглалтад орохтой холбогдуулан Нислэгийн цаг уурын төвийг 13 орон тоогоор нэмэгдүүлж, холбогдох урсгал зардалд 238.1 сая төгрөгийг нэмж, тэтгэвэрт гарах хүний тоо буурч байгаатай холбоотойгоор тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 477.0 сая төгрөг, харъя байгууллагуудын урсгал зардлыг 6.7 сая төгрөгөөр тус тус бууруулж тооцсон.

Хүснэгт № 149. Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр: Ус цаг уур, орчны шинжилгээ (71408)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр	20,729.8	21,499.3	21,838.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	19,297.3	19,402.9	20,219.4
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	139.1	0.0	0.0
80219 Харуул, хамгаалалтын зардал	5.2	6.0	6.0
80220 Холбооны суваг ашигласны хөлс	306.3	585.4	585.4
80312 Сургалт семинар	12.0	29.5	29.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	223.4	644.5	167.6
81710 Ус цаг уурын судалгаа, шинжилгээ	746.5	831.1	831.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	20,729.8	21,499.3	21,838.9
31 Улсын төсвөөс санхүүжих	20,618.4	21,429.4	21,768.9
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	111.4	69.9	69.9
Орон тоо	1,880	1,880	1,880

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид	Байгууллагын тоо	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Ус цаг уур, орчны төвүүд	26	20,729.8	21,499.3	21,838.9

Хөтөлбөр 7: Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр

2018 оны төсвийн төсөлд хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн үйл ажиллагааны урсгал зардлыг 4,772.1 сая төгрөгөөр төсөвлөсөн. 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад тэтгэвэрт гарч буй ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн зардал 152.2 сая төгрөгөөр буурч, байр ашиглалтын үйлчилгээний зардал 33.0 сая төгрөг, валютын ханшийн зөрүү 7.0 сая төгрөг тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт № 150. Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр: Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага (71411)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр	5,043.0	4,882.5	4,772.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,202.2	2,322.9	2,317.7
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	22.1	9.8	9.8
80221 Гэрээт ажиллагсдын зардал	4.9	4.9	4.9
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	115.1	114.0	147.0
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	160.2	180.8	187.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	143.0	157.5	5.3
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	72.1	0.0	0.0
81519 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	5.0	0.0	0.0
81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2,091.3	2,092.7	2,099.7
82808 Бусад баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээ	2.1	0.0	0.0
82903 Монгол улсыг гадаадад сурталчлах	179.0	0.0	0.0
83105 Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах	46.0	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	5,043.0	4,882.5	4,772.0
31 Улсын төсвөөс санхүүжих	5,043.0	4,882.5	4,772.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2.3	0.0	0.0
Орон тоо	121	121	121

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
08691 Байгаль хамгаалах сан	1,882.7	1,880.4	1,881.4
10097 Байгаль орчин, аялал жуулчлалын яам	3,160.2	3,002.1	2,890.6

Хөтөлбөр 8: Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хөтөлбөр

2018 оны төсвийн төсөлд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 1,436.0 сая төгрөгийг төсөвлөсөн.

Хүснэгт № 151. Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр: Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ (71412)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр	0.0	986.0	1,436.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	0.0	0.0	0.0
81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	0.0	986.0	1,436.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	0.0	986.0	1,436.0
31 Улсын төсвөөс санхүүжих	0.0	986.0	1,436.0
Орон тоо	0	0	0

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид		2016 Гүйц	2017 Год	2018 Төсөв
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		0.0	986.0	1,436.0
10097 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам		0.0	986.0	1,436.0

2018 онд хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

Хүснэгт № 152. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө /сая төгрөг/

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Төсөв
1	Ус намгархаг газрын шувуудын амьдрах орчныг сайжруулах	Ховд, Хөвсгөл, Булган, Дорнод, Хэнтий, Өмнөговь, Баянхонгор, Завхан аймагт хөв цөөрөм байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна.	250.0
2	Биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоосноор шинжлэх ухааны үндэстэй тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх	Ашиглалтад хэт өртөмтгий 5 зүйл /Урал чихэр өвс, эгэл бавран, жинхэнэ онгол, элсний сулхир, монгол хунчир/ ургамлын биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоосноор шинжлэх ухааны үндэстэй тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулсан байна	336.0
3	Уул уурхайн улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрын тооллого хийх, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Уул уурхайн улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрын тооллого хийж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажилд нуггийн иргэдийн оролцоог хангаж, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг 300 га-гаар нэмэгдүүлж, нөхөн сэргээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд байгаль орчны аудит хийсэн байна	400.0
4	Доройтолд орсон, талхлагдсан газар нутгийг хамгаалах, нөхөн сэргээх	Цөлжилт болон элсний нүүлтийг бууруулах зорилгоор 100 га талбайд мод бут, сөөг, олон наст ургамал тарьж нөхөн сэргээж хамгаалах арга хэмжээ авсан байна.	250.0
5	Биологийн нөөц, ашиглалтын нөөцийг тогтоож тогтвортой ашиглах, хамгаалах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах	Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Сэлэнгийн сав газарт спорт агнуурын шувуудын биологийн нөөц, ашиглалтын нөөцийг тогтоож тогтвортой ашиглах, хамгаалах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж 3 загвар төсөл хэрэгжүүлсэн байна	200.0
6	Нийт зардал		1,436.0

Хөтөлбөр 9: Аялал жуулчлал

2018 оны төсвийн төсөлд аялал жуулчлал хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 1,330.6 сая төгрөгийг төсөвлөсөн. Улаанбаатар хот орчмын бүс нутагт явган аяллын маршрутыг тохижуулж, тэмдэг тэмдэглэгээг 2 байрлалд байршуулахад шаардагдах 150.0 сая төгрөгийг 2018 оны төсвийн төсөлд нэмж тусгасан.

Хүснэгт № 153. Аялал жуулчлал хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр: Аялал жуулчлал (71703)		2016 Гүйц	2017 Год	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр		240.0	1,180.6	1,330.6
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	150.0	940.5	1,090.5
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	70.0	141.1	141.1
80218	Улс орноо гадаадад сурталчлах	20.0	99.0	99.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		240.0	1,180.6	1,330.6
31	Улсын төсвөөс санхүүжих	240.0	1,180.6	1,330.6

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	240.0	1,180.6	1,330.6
10097 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	240.0	1,180.6	1,330.6

Монгол улсад дотоодын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудыг бэхжүүлэх, боловсон хүчнийг чадваржуулах, гадаадын жуулчдыг татах талаар судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлж сургалт, сурталчилгааг тогтмолжуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

Хүснэгт № 154. Аялал жуулчлалын салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардал /сая төгрөг/

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэн үр дүн	Төсөв
1	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлуудын хүрээнд аялал жуулчлалын 18 эвент арга хэмжээ, 3 үзэсгэлэн зохион байгуулна.	200.0
2	Гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлж, голлох зах зээлийг эрчимжүүлэх замаар эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх хүрээнд гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, олон улсын үзэсгэлэнд Монгол Улсыг нэгдсэн зохион байгуулалттай сурталчилна.	390.0
3	Аялал жуулчлалыг хөгжүүлэх судалгаа	Аялал жуулчлалыг хөгжүүлэх судалгааг 5 бүсэд, хил орчмын нутгуудад, мөн 5 аймагт нөөц даацын судалгаа зохион байгуулна.	140.0
4	Монгол, Хятад, Орос 3 улсын аялал жуулчлалын 3 дугаар уулзалтыг зохион байгуулах	Монгол, Хятад, Орос 3 улсын аялал жуулчлалын сайд нарын 3 дугаар уулзалтыг Монгол Улсад зохион байгуулна	100.0
5	Олон улсын байгууллагуудын ээлжит чуулга уулзалт, хурал зөвлөгөөнд оролцох	Гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх, ДАЖБ, бусад олон улсын байгууллагуудын ээлжит чуулга уулзалт, хурал зөвлөгөөнд оролцож, сургалтад хамрагдана.	60.0
6	Төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах	Цайны зам, Их түмэн гол болон бусад төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана	55.0
7	Сургалтыг зохион байгуулах	Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэгдсэн бүсчилсэн болон сэдэвчилсэн нийт 12 сургалтыг зохион байгуулах	140.0
8	Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх	Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	95.6
9	Явган аяллын маршрутыг тохижуулах	Улаанбаатар хот орчмын бүс нутагт явган аяллын маршрутыг тохижуулж, тэмдэг тэмдэглэгээг 2 байрлалд байршуулна.	150.0
НИЙТ ДҮН			1,330.6

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД

Монгол Улсын төсвөөс 2018 оны төсвийн жилд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсөв зарцуулах нийт эрх 1,617,678.1 сая төгрөг байхаар, үүнээс урсгал

зардал 1,128,765.1 сая төгрөг, дотоод эх үүсвэрээс олгох зээл 97,126.9 сая төгрөг, гадаад зээл тусламжаас санхүүжих зардал 136,286.4 сая төгрөг харин хөрөнгийн зардалд 255,499.7 сая төгрөг тус тус төсөвлөлөө.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багц нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, биеийн тамир, спорт, боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага, насан туршийн боловсролын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 9 хөтөлбөртэй байна. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг дараах байдлаар төсөвлөлөө. Үүнд:

Хүснэгт № 155. Хөтөлбөрүүдийн зардлын хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	1,229,043.0	1,357,294.9	1,617,678.1
Биеийн тамир спорт (71701)	22,904.8	23,761.4	30,022.4
Соёл урлаг (71702)	57,776.2	60,072.4	62,857.0
Сургуулийн өмнөх боловсрол (71801)	267,024.8	279,434.6	306,722.0
Ерөнхий боловсрол (71802)	562,343.0	599,631.2	634,068.8
Дээд боловсрол (71803)	97,476.6	125,536.0	135,804.2
<i>Үүнээс: Урсгал зардал</i>	<i>66,831.1</i>	<i>28,409.1</i>	<i>38,677.3</i>
<i>Дотоод эх үүсвэрээс олгох зээл</i>	<i>30,645.6</i>	<i>97,126.9</i>	<i>97,126.9</i>
Шинжлэх ухаан, технологи (71805)	31,794.2	32,217.6	38,246.5
Насан туршын болон албан бус боловсрол (71806)	4,110.9	3,449.4	3,358.4
Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага (71808)	18,119.5	12,621.6	13,005.6
Өмнөх жилүүдэд хэрэгжиж байсан хөтөлбөрүүд (71704, 71807)	4,428.0	5,913.3	-
Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр (70207)	35,396.7	110,521.2	138,093.3
<i>Үүнээс: Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</i>	<i>34,545.7</i>	<i>108,787.7</i>	<i>136,286.4</i>
<i>Улсын төсвөөс санхүүжих зардал</i>	<i>851.0</i>	<i>1,733.5</i>	<i>1,806.9</i>
Хөрөнгийн зардал	127,668.3	104,136.2	255,499.7

Ирэх 2018 онд нийт зардлын 39.3 хувийг ерөнхий боловсролын, 19.0 хувийг сургуулийн өмнөх боловсролын, 8.4 хувийг дээд боловсролын, 3.9 хувийг соёл урлагийн, харин үлдэх 29.3 хувийг бусад 5 хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын зардалд тус тус зарцуулагдахаар төсөвлөгдсөн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны төсвийн төсөл туссан зардлыг 2017 оны тодотгосон төсвийн түвшинтэй харьцуулбал урсгал зардал 81,521.1 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар, хөрөнгийн зардал 151,363.5 сая төгрөгөөр буюу 146.3 хувиар, гадаад зээл тусламжаас санхүүжих зардал 27,498.7 сая төгрөг буюу 26.5 хувиар тус тус өссөн байна. Харин дотоод эх үүсвэрээс олгох зээл 2017 оны тодотгосон төсвийн түвшинд байхаар тооцлоо.

Хүснэгт №156. Нэмэгдэж байгаа урсгал зардлын арга хэмжээний хураангуй /сая төгрөг/

Арга хэмжээ	2017 Тод	2018 Төсөл	ЗӨРҮҮ
НИЙТ ДҮН	953,419.2	1,034,940.3	81,521.1
Хүүхдийн тооны өсөлттэй холбоотой	549,826.5	591,141.8	41,315.3
Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн хувьсах зардал	443,127.6	464,752.3	21,624.7
Хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн хувьсах зардал	30,814.9	44,547.2	13,732.3
Төрийн өмчийн сургууль цэцэрлэгийн үдийн цай, хүүхдийн хоол	75,884.0	81,842.3	5,958.3
Шинэ хөрөнгө оруулалттай холбоотой	313,710.2	354,154.9	40,444.7
Боловсролын салбарын шинээр ашиглалтад орсон, төвлөрсөн халаалтад холбогдсон сургууль цэцэрлэг	250,204.1	276,935.2	26,731.1
Соёл, биеийн тамир салбарын шинээр ашиглалтад орсон, төвлөрсөн	54,042.6	58,359.8	4,317.2

халаалтад холбогдсон байгууллагууд			
Холбооны суваг ашигласны хөлс, боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх	2,218.5	5,478.9	3,260.4
АШУҮИС-ийн харьяа сургалтын эмнэлэг		3,174.4	3,174.4
Төрийн өмчийн их, дээд сургуулийн тогтмол зардал	6,708.4	8,864.8	2,156.4
Шинээр ашиглалтад орсон шинжлэх ухааны салбар болон захиргаа удирдлагын бусад байгууллага	536.6	1,341.8	805.2
ЗГҮАМХ-ийн хэрэгжилтийг хангахтай холбоотой	23,338.2	34,075.5	10,737.3
Өрсөлдөөнт тэтгэлэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх	0.0	1,500.0	1,500.0
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,307.3	15,267.4	4,960.1
Их, дээд сургуульд суралцаж байгаа нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай оюутанд олгох тэтгэмж	13,030.9	17,308.1	4,277.2
Бусад ТЕЗ-ийн багцаас шилжиж байгаа	0.0	9,272.3	9,272.3
Хүүхэд харах үйлчилгээ		6,516.8	6,516.8
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 115, 29 дугаар тусгай сургууль		2,755.5	2,755.5
ТЕЗ-ийн санал, бусад тулгамдсан асуудалтай холбоотой	66,544.3	46,295.8	-20,248.5
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, Хөдөө орон нутгийн нэмэгдэл	56,104.9	31,154.6	-24,950.3
БСШУССайдын багцын бусад байгууллагын ү/а-ны зардал		466.6	466.6
Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих, олимп, ДАШТ-с медаль хүртсэн тамирчдын сар бүр олгох урамшуулал	10,439.4	14,674.6	4,235.2

Урсгал зардлын нэмэгдсэн дүнг хөтөлбөрөөр нь авч үзвэл ерөнхий боловсрол 34,437.7 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсрол 27,287.4 сая төгрөг, дээд боловсрол 10,268.3 сая төгрөг, биеийн тамир спорт 6,261.1 сая төгрөг, шинжлэх ухаан, технологи 6,028.9 сая төгрөг, соёл урлаг 2,784.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Хүснэгт № 157: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн хураангуй зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөгөөр/

ТЕЗ / Хөтөлбөр	НИЙТ ДҮН	УРСГАЛ ЗАРДАЛ	Үүнээс			Дотоод эх үүсвэрээс олгох зээл	Гадаад З/Т санхүүжих зардал
			Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас, шилж.		
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	1,617,678.1	1,128,765.1	49,859.1	81,094.1	997,812.0	97,126.9	136,286.4
Биеийн тамир спорт	30,022.4	30,022.4	1,984.8	12,013.4	16,024.2		
Соёл урлаг	62,857.0	62,857.0	10,689.9	6,327.7	45,839.4		
Сургуулийн өмнөх боловсрол	306,722.0	306,722.0		6,516.8	300,205.3		
Ерөнхий боловсрол	634,068.8	634,068.8	7,743.1	16,319.6	610,006.1		
Дээд боловсрол	135,804.2	38,677.3	2,287.3	14,567.9	21,822.2	97,126.9	
Шинжлэх ухаан, технологи	38,246.5	38,246.5	18,238.8	19,575.6	432.1		
Насан туршын болон албан бус боловсрол	3,358.4	3,358.4			3,358.4		
Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	13,005.6	13,005.6	8,399.5	4,481.8	124.2		
Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр	138,093.3	1,806.9	515.8	1,291.1			136,286.4
Хөрөнгийн зардал	255,499.7						

Дээрх хүснэгтээс харахад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын урсгал зардал нийт 1,128,765.1 сая төгрөгөөс 997,812.0 сая төгрөг нь татаас, шилжүүлэг байна. Үүнээс 967,336.2 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасан орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, нийтийн биеийн тамирын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгийн зардалд төсөвлөв.

Хөтөлбөр 1. Биеийн тамир, спорт

Биеийн тамир, спортын салбарт 2018 оны төсвийн жилд орон тоо, бүтцийн хувьд өмнөх жилийн түвшинд буюу 536 орон тоотой, аймаг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих нийслэл, дүүргийн 31 байгууллагатай, улсын төсвөөс санхүүжих 1 агентлагтай үйл ажиллагаа явуулахаар тооцож нийт 30,022.4 сая төгрөгийн төсөвтэй байхаар 2018 оны төсвийн төсөлд тусгалаа.

Салбарын хэмжээнд 2017 оны төсвийн жилд шинээр төвлөрсөн халаалтад холбогдсон болон шинээр ашиглалтад орж байгаа усан бассейн, спорт цогцолборын зөвхөн байр ашиглалттай холбоотой зардалд 2,025.9 сая төгрөг, Монгол Улсын шигшээ багийн тамирчдын бэлтгэл, цугларалт, олон улсын тэмцээн уралдаанд оролцох зардалд 4,019.2 сая төгрөг, 2017 онд шинээр дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчдад олгох урамшуулалд 216.0 сая төгрөгийг тус тус 2018 оны төсвийн төсөлд нэмж тусгав.

Хүснэгт № 158. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Биеийн тамир спорт (71701)	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	22,904.8	23,761.4	30,022.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	808.2	799.3	768.5
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	170.9	186.4
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	237.6	0.0
80502 Тусгай зориулалтын шилжүүлэг	10,366.4	10,822.0	12,847.9
82101 Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	7,018.1	4,786.3	7,170.5
82102 Олон улсын тэмцээн, уралдаанд оролцох	3,058.7	1,782.0	3,432.0
82103 Олон улсын бусад тэмцээн уралдааны шагнал	832.9	1,500.0	1,500.0
82104 Дотоодод тэмцээн уралдаан зохион байгуулах	150.0	1,185.6	1,185.6
82105 Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдын урамшуулал	630.5	1,404.0	1,620.0
82106 Нийтийн биеийн тамир	0.0	250.0	487.6
82107 Өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг дэмжих	0.0	250.0	250.0
82108 Үндэсний уламжлалт спортыг дэмжих	0.0	250.0	250.0
82109 Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих	0.0	250.0	250.0
Бусад зориулалт, арга хэмжээ (80219, 80509, 80802, 80812)	40	73.7	74.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	22,904.8	23,761.4	30,022.4
31 Улсын төсвөөс санхүүжих	22,808.7	23,670.9	29,932.4
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	96.2	90.5	90.0
Орон тоо	536	536	536

Хүснэгт № 159. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Биеийн тамир спорт (71701)	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
Нийт дүн	22,904.8	23,761.4	30,022.4
10090 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /шинэ/	1,463.4	2,904.0	3,120.0
10113 Биеийн тамир, спортын газар	11,075.1	9,035.4	13,054.6
10159 Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг	10,366.4	10,822.0	12,847.9
10701 Спортыг дэмжих сан	0.0	1,000.0	1,000.0

Хөтөлбөр 2: Соёл урлаг

Соёл урлагийн салбарт 2018 оны төсвийн жилд 433 байгууллага, 5496 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар тооцож 62,857.0 сая төгрөг төсөвлөлөө. Үүнийг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад бүтэц, орон тоо нэмэгдээгүй харин төсвийн

зарлага 2,784.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон барилга, байгууламж, спорт заал болон шинээр ашиглалтад орж байгаа барилга, объектын зөвхөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2018 оны төсвийн төсөлд нэмж тусгасантай холбоотой байна.

Хүснэгт № 160. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Соёл урлаг (71702)		2016	2017	2018
		Гүйц	ХБГ	Төсөл
Зориулалт арга хэмжээгээр		57,776.2	60,072.4	62,857.0
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	11,816.2	12,073.0	12,436.7
80214	Уран бүтээл хийлгэх	683.0	1,252.8	1,028.3
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	125.2	187.9	188.4
80219	Харуул, хамгаалалтын зардал	125.0	122.6	124.4
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	9.7	95.9	579.9
80312	Сургалт семинар	0.0	50.7	49.5
80502	Тусгай зориулалтын шилжүүлэг	43,182.5	43,220.7	45,512.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	71.5	254.8	93.4
81901	Соёл урлаг хөгжүүлэх	251.9	585.6	585.6
81905	Музейн үзмэр худалдан авах	284.0	285.9	285.9
81907	Түүхийн хүрд баримтат кино бүтээх	110.0	108.9	108.9
81908	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	505.8	321.1	340.5
81909	Музей, түүх, соёлын өвийн сэргээн засварлалт	4.6	26.1	6.4
81910	Номын сангийн фондыг шилдэг ном, бүтээлээр баяжуулах	0.0	442.6	442.6
81911	Сонгодог урлаг хөтөлбөр	201.9	355.5	355.5
81912	Хүүхдэд зориулсан уран бүтээл хийлгэх	98.0	49.5	49.5
81914	Хөгжмийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	0.0	39.6	39.6
81916	Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах	45.0	44.6	44.6
81918	Олон улсын тэмцээнд тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийг шагнах	73.0	203.1	203.1
81919	Оны шилдэг уран бүтээлчдийг шагнах	29.5	30.0	30.0
81922	Гадаад дотоодод зохиогдох соёл урлагийн арга хэмжээ	44.6	49.5	49.5
Бусад зориулалт, арга хэмжээ (80205, 80218, 80220, 80303, 80305, 80509, 80812, 81917, 81927, 81928)		114.8	272	302.7
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		57,776.2	60,072.4	62,857.0
31	Улсын төсвөөс санхүүжих	55,982.6	58,250.3	61,224.2
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,793.5	1,822.1	1,632.8
Орон тоо		5,479	5,479	5,496

Соёл урлаг хөтөлбөрт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын дараах байгууллагууд хамрагдаж байна. Үүнд:

Хүснэгт № 161. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Соёл урлаг (71702)		2016	2017	2018
		Гүйц	ХБГ	Төсөл
Нийт дүн		57,776.2	60,072.4	62,857.0
00463	Үндэсний түүхийн музей	774.3	779.1	788.8
00467	Байгалийн түүхийн музей	279.0	327.1	327.8
00469	Театрын музей	136.0	149.4	148.6
00471	Дүрслэх урлагийн музей	342.8	363.9	365.9
00473	Уран зургийн галлерей	271.8	294.4	305.9
00477	Үндэсний номын сан	980.3	967.0	1,275.6
00481	Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	2,806.4	2,848.8	3,147.4
00483	Улсын драмын эрдмийн театр	1,252.9	1,421.8	1,319.9
00485	Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга	1,698.5	1,898.3	1,752.7
00489	Улсын хүүхэддэйн театр	308.8	318.1	322.6
00491	Улсын филармони	1,551.7	1,576.1	1,573.1
00507	Соёл, урлаг хөгжүүлэх сан	0.0	1,000.0	1,000.0

00509	Соёлын өвийн төв	368.1	423.5	440.4
08632	Богд хааны ордон музей	332.8	364.7	394.5
08633	Чойжин ламын сүм музей	241.6	232.8	235.2
09527	Хүүхдийн номын ордон	468.5	485.3	500.1
09835	Хархорин музей	302.1	315.2	338.1
09874	Хөшөө цайдам музей	151.5	152.9	156.3
09922	Дэлхийн Өв Орхоны соёлын дурсгалт газар	186.7	197.1	186.2
10090	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /шинэ/	1,730.9	1,998.9	1,998.9
10156	Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	43,182.5	43,220.7	45,512.0
10228	Үлэг гүрвэлийн төв музей	409.0	432.6	445.3
10668	Соёл урлагийн газар	0.0	304.9	321.7

Хөтөлбөр 3. Сургуулийн өмнөх боловсрол

Хөтөлбөрийн хүрээнд 2018 онд төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгт нийт 246759 суралцагч суралцахаар, хамран сургалтын бохир жин 80.1 хувьд хүргэхээр тооцож нийт 306,722.0 сая төгрөг төсөвлөлөө.

Хүснэгт № 162. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Сургуулийн өмнөх боловсрол (71801)	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	267,024.8	279,434.6	306,722.0
80231 Хүүхэд харах үйлчилгээ	0.0	0.0	6,516.8
80502 Тусгай зориулалтын шилжүүлэг	263,733.8	275,190.6	295,924.2
81821 Төмөр замын цэцэрлэгийн үйлчилгээ	3,291.0	4,244.0	4,281.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	267,024.8	279,434.6	306,722.0
31 Улсын төсвөөс санхүүжих	267,024.8	279,434.6	306,722.0
Байгууллагын тоо, суралцагчдын тоо			
41 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	1,287	1,371	1,473
431 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчид	220,237	229,470	246,759
Орон тоо - Төрийн албаны ангиллаар	19,272	19,986	20,597

Энэ нь 2017 оны төсвийн тодотголын түвшнээс суралцагчийн тоо 17,289-оор, санхүүжилт 27,287.1 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн 2018 онд 295,924.2 сая төгрөг төсөвлөгдөж 2017 оны тодотгосон төсвөөс 19,731.4 сая төгрөгөө нэмэгдсэн байна. Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн зардлын өсөлтийн үндсэн шалтгаан тусгай зориулалтын шилжүүлгийн өссөн дүнг шалтгаанаар нь авч үзвэл: 2017-2018 онд улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар шинээр ашиглалтад орж байгаа цэцэрлэгийн зориулалттай 29 барилга байгууламжийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2,762.6 сая төгрөг, хүүхдийн тооны өсөлттэй холбоотойгоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 2,349.1 сая төгрөг, төрийн болон хувийн өмчийн ердийн сургалттай цэцэрлэгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардалд 14,882.0 сая төгрөг тус тус нэмж төсөвлөлөө. Түүнчлэн сувиллын болон тусгай цэцэрлэгт 488 суралцагч хамрагдахаар тооцож 1,311.9 сая төгрөг төсөвлөлөө.

Харин 2018 оны төсвийн жилд нэмэгдэж байгаа ердийн сургалттай цэцэрлэгт нэмэгдэж байгаа 16886 суралцагчийн хувьсах зардал болох 14,882.0 сая төгрөгийг хүүхдийн цэцэрлэгийн өмчийн хэлбэрээр нь авч үзвэл: хувийн өмчийн цэцэрлэгт

нэмэгдэж байгаа 9,020 суралцагчтай холбоотой 7,773.6 сая төгрөг, харин төрийн өмчийн цэцэрлэгийн суудлын тоо 7886-аар нэмэгдэж байгаатай холбоотойгоор 7,108.4 сая төгрөг нэмэгдэхээр байна.

Хүснэгт № 163. Сургуулийн өмнөх боловсролын суралцагчдын хамрагдалт /мянган хүүхэд/

Үзүүлэлт	2015	2016	2017 ХБГ	2018 Төсөл
Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо*	211.8	220.7	229.5	246.8
Цэцэрлэгийн насны хүүхдийн тоо**	256.5	260.3	271.2	304.5
Цэцэрлэгийн хамрагдалт	83%	85%	84.6%	80.1%

Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Дээрх хүснэгтээс харахад цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог 2015-2016 оны хичээлийн жилд 8.9 мянга, 2016-2017 оны хичээлийн жилд 8.8 мянгаар тус тус нэмэгдүүлж харин 2018 онд 17.3 мянгаар нэмэгдүүлэхээр тооцож байна. Гэвч цэцэрлэгт хамрагдах насны хүүхдийн тоо 2016 онд 3.8 мянга, 2017 онд 10.9 мянгаар нэмэгдэж 2018 онд 33.3 мянгаар нэмэгдэх төлөвтэй байгаа нь өсөн нэмэгдэж байгаа цэцэрлэгийн эрэлт, хэрэгцээний өсөлт нь шинээр төсвийн хөрөнгөөр барьж байгуулж байгаа цэцэрлэгийн хүчин чадлын өсөлтөөс хэт өндөр байгааг харуулж байна. Иймд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2-т хувийн хэвшлийн болон байгууллагын цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхээр заасныг үндэслэн 2018 оны төсвийн жилд стандартын шаардлага хангасан хувийн өмчийн байгууллагын цэцэрлэгийн цэцэрлэгийн хамрагдах хүүхдийн тоог 9020-оор нэмэгдүүлэхээр тооцож төсөвлөлөө.

Хүснэгт № 164. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой нормативт зардал

№	Байршил, шалгуур	Хэмжих нэгж	Зардлын хэмжээ
1	СӨБ эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал (ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоол)		
1.1	Аймгийн төвөөс бусад сумын	Мянган төгрөг	998.2
1.2	Аймгийн төвийн	Мянган төгрөг	812.3
1.3	Нийслэлийн	Мянган төгрөг	807.8
2	Цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардал (ЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоол)		
2.1	8-10 цагаар ажилдаг цэцэрлэг	Төгрөг	1650
2.2	24 цагаар ажилдаг цэцэрлэг	Төгрөг	2400
2.3	Сувиллын болон тусгай цэцэрлэг	Төгрөг	2400

Түүнчлэн тэтгэвэрт гарах хүний тоо буурч байгаатай холбоотойгоор тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 1,576.3 сая төгрөгөөр буурч, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилсан төрийн албан хаагчид олгох дэмжлэгийн хэмжээ 1,041.5 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Мөн хүүхэд харах үйлчилгээний тухай хууль хэрэгжээд 2 жил болж байгаа боловч уг үйлчилгээг боловсролын мэргэжил арга зүй, удирдлагаар хангахад зохион байгуулалтын хувьд оновчтой бус байна. Иймд хуулийн хэрэгжилтийн зохицуулалтыг илүү оновчтой болгох үүднээс удирдлага зохион байгуулалт, санхүүжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх чиглэлийг Засгийн газраас санаачлан холбогдох хууль эрх зүйн өөрчлөлтийн төслийг боловсруулж, нийт 6,516.8 сая төгрөгийн зардлыг нэмж тусгалаа.

Хөтөлбөр 4: Ерөнхий боловсрол

2018 оны төсвийн жилд ерөнхий боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 634,068.8 сая төгрөг төсөвлөгдөж, 844 сургууль хамрагдахаар тооцлоо. Үүнд: тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх орон нутгийн өмчийн 679, хувийн өмчийн 158 сургууль, улсын төсвөөс шууд санхүүжигдэх Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай 3 сургууль, хөгжим бүжгийн сургалттай 2 сургууль, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургалттай 2 сургууль тус тус хамрагдаж байна.

Хүснэгт № 165. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Ерөнхий боловсрол (71802)	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	562,343.0	599,631.2	634,068.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	6,428.6	6,570.9	6,700.4
80219 Харуул, хамгаалалтын зардал	48.6	53.5	53.5
80220 Холбооны суваг ашигласны хөлс	833.9	1,009.8	3,790.7
80502 Тусгай зориулалтын шилжүүлэг	550,249.6	581,330.5	609,693.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	202.5	194.1	182.5
81801 Үдийн цай хөтөлбөр	25.0	32.1	129.9
81804 Олимпиад зохион байгуулах	188.7	194.4	250.0
81806 Дотуур байрны үйлчилгээ	120.7	139.2	284.0
81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	477.4	495.0	495.0
81817 ЕБС-ийг сурах бичгээр хангах	1,527.1	4,168.8	4,168.8
81823 Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	1,039.8	2,360.7	2,400.7
81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	116.3	2,151.6	2,151.6
81841 Боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх	891.6	930.7	1,230.7
81847 Тусгай хэрэгцээт боловсрол	0.0	0.0	2,537.4
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	562,343.0	599,631.2	634,068.8
31 Улсын төсвөөс санхүүжих	561,944.7	599,230.6	633,609.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	398.3	400.6	459.8
Байгууллагын тоо, суралцагчдын тоо			
41 Ерөнхий боловсролын байгууллага	807	808	844
431 Ерөнхий боловсролын байгууллагад суралцагчид	535,100	559,255	599,414
Орон тоо - Төрийн албаны ангиллаар	42839	42850	44828

Төсвийн төсөлд ерөнхий боловсрол хөтөлбөрт төсөвлөгдсөн зардлын хэмжээг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 34,437.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тоо нийт 599,414 болж 2017 оны төсвийн жилээс 40159-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт № 166. 2016-2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид



Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Дээрх графикаас харахад сүүлийн жилүүдэд хүүхдийн төрөлт огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургуульд элсэн орж байгаа хүүхэд болон сургууль төгсөж байгаа хүүхдийн тооны зөрүү ирэх 5 жилд жил бүр дунджаар 30 мянган хүүхэд байхаар байгаа нь суралцагчийн тоо их хэмжээгээр нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.

Хүснэгт № 167. Ерөнхий боловсролын суралцагчдын хамрагдалт /мянган хүүхэд/

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо	506.8	535.1	552.0	599.4
Насан туршийн боловсролд хамрагдсан хүүхдийн тоо	10.1	10.2	9.1	10.1
Сургуулийн насны хүүхдийн тоо	538.6	559.7	576.8	625.7
Сургуулийн хамрагдалт	94.1%	95.6%	95.7%	95.8%

Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн зардал 2018 онд 609,693.7 сая төгрөг буюу 2017 оны тодотгосон төсвөөс 28,363.2 сая төгрөгөөр нэмэгдэж байгаа нь хөтөлбөрийн зардлын өсөлтийн үндсэн шалтгаан болж байна. Тусгай зориулалтын шилжүүлгийг шалтгаанаар нь авч үзвэл: шинээр ашиглалтад орж байгаа сургуулийн зориулалттай 15 барилга байгууламжийн үйл ажиллагааны зардал болон төвлөрсөн халаалтын системд холбогдсон, эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэн сумдын сургуулийн тогтмол зардалд 22,466.6 сая төгрөг, хүүхдийн тооны өсөлттэй холбоотойгоор үдийн цай хөтөлбөрийн зардалд 3,609.3 сая төгрөг, дотуур байрны зардалд 1,501.7 төрийн болон хувийн өмчийн сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардалд 20,512.2 сая төгрөг тус тус нэмж тусгалаа. Харин тэтгэвэр тогтоолгох насны болзолд өөрчлөлт орсон, хөдөө орон нутгийн нэмэгдэлд хамрагдах хүний давтамж буурсантай холбоотойгоор тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилсан төрийн албан хаагчид олгох дэмжлэг өмнөх онтой харьцуулахад 24,747.5 сая төгрөгөөр буурч байна.

Хүснэгт № 168. Ерөнхий боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой нормативт зардал

№	Байршил, шалгуур	Хэмжих нэгж	Зардлын хэмжээ /дундажаар/
1	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал (ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоол)		
1.1	Аймгийн төвөөс бусад сумын	Мянган төгрөг	486.2
1.2	Аймгийн төвийн	Мянган төгрөг	407.9
1.3	Нийслэлийн	Мянган төгрөг	374.0
2	Хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал (ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоол)		
2.1	Төлбөргүй болон 5.0 сая хүртэлх төлбөртэй	Мянган төгрөг	392.4
2.2	5.0 саяас 10.0 сая хүртэлх төлбөртэй	Мянган төгрөг	235.5
2.3	10.0 сая төгрөгөөс дээш төлбөртэй	Мянган төгрөг	117.2
3	Дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардал (ЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоол)		
3.1	6 настай хүүхэд амьдардаг дотуур байр	Мянган төгрөг	462.2
3.2	Дотуур байр	Мянган төгрөг	312.7
4	Хүүхдийн нэг өдрийн үдийн цай, хоолны зардал (ЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоол)		
4.1	Бага ангийн үдийн цай	Төгрөг	400
4.2	Тусгай сургуулийн үдийн хоол	Төгрөг	2400
4.3	Дотуур байрны хоол	Төгрөг	2315

Түүнчлэн 2018 оны төсвийн жилд тусгай хэрэгцээт сургуулийн үйл ажиллагааны зардалд 7,448.5 сая төгрөг, үүнээс Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас

шууд санхүүжих сонголын болон харааны бэрхшээлтэй хүүхдийн 116, 29 дүгээр тусгай сургуульд 2,537.4 сая төгрөг, үлдэх 4,911.1 сая төгрөгийг аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэхээр төсөвлөлөө.

Азийн хөгжлийн банкны зээл, тусламжийн эх үүсвэрээр боловсролын мэдээллийн системийг улсын хэмжээнд нэвтрүүлэхэд шаардлагатай сервер, тоног төхөөрөмжийг суурилуулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дэргэдэх Шинэ зууны боловсрол төслийн хүрээнд мэдээллийн системийн сүлжээг ашиглалтад оруулаад байна. Үүнтэй холбоотойгоор цаашид боловсролын нэгдсэн сүлжээ байгуулах, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг интернет үйлчилгээгээр хангах ажлын хүрээнд орон нутгийн тоон урсгал түрээслэх, тоног төхөөрөмж байршуулах, виртуал хувийн сүлжээ үүсгэх, интернет үйлчилгээ авах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Уг ажлыг гүйцэтгэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Монголын цахилгаан холбоо ХК-тай хийсэн санамж бичиг байгуулаад байна. Иймд бүх шатны боловсролын салбарын санхүү, хүний нөөц, суралцагчдын талаарх статистик үзүүлэлтийг шилжилт хөдөлгөөн, давхцал, хийдэл гэх мэт нарийвчлалтайгаар өмнөх жилүүдийн болон тухайн цаг хугацааны нэгдсэн мэдээллээр хангах боломжтой боловсролын нэгдсэн мэдээллийн системд бүх шатны боловсролын байгууллагыг бүрэн хамруулахтай холбоотойгоор 2,780.9 сая төгрөг нэмж тусгалаа.

Хүснэгт № 169. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Ерөнхий боловсрол (71802)		2016	2017	2018
		Гүйц	ХБГ	Төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		562,343.0	599,631.2	634,068.8
00139	116 дугаар сургууль	0.0	0.0	793.9
00219	Завханы Хөгжим бүжгийн сургууль	1,170.5	1,209.2	1,246.9
00231	Улаанбаатарын Хөгжим бүжгийн сургууль	3,701.7	3,499.3	3,576.7
08592	29 дүгээр тусгай сургууль	0.0	0.0	1,961.6
09963	Шинэ эрин - Төрийн Өмчит ЕБС	799.1	854.5	849.0
09976	Шинэ эхлэл - Төрийн Өмчит ЕБС	771.5	827.6	789.9
09977	Монгол тэмүүлэл - Төрийн Өмчит ЕБС	575.8	599.1	669.6
10090	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	5,074.8	11,311.0	14,487.5
10155	Ерөнхий боловсролын сургуулиуд	550,249.6	581,330.5	609,693.7

Хөтөлбөр 5. Дээд боловсрол

2018 оны төсвийн төсөлд дээд боловсрол хөтөлбөрт нийт 135,804.2 сая төгрөг тусгалаа. Үүнд: Дээд боловсролын салбарын хүрээнд оюутан, суралцагчид зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Боловсролын зээлийн сан”-аас нийт 21,660.2 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж, урамшуулал, дотоод эх үүсвэрээс олгох зээл 97,126.9 сая төгрөг, үүнээс оюутны сургалтын төлбөрийн зээлд 75,326.9 сая төгрөг, зэрэглэлээрээ дэлхийн шилдэг 100 их сургуульд тэнцсэн суралцагчийн сургалтын төлбөрийн зээлд 14,500.0 сая төгрөг тус тус төсөвлөлөө. Энэ нь 2017 оны тодотгосон төсвөөс 10,268.3 сая төгрөгөөс өссөн дүн юм. Харин Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны зардалд 301.5 сая төгрөг тус тус тусгалаа.

Зарлагын өсөлтийн үндсэн шалтгаан нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.20 дэх заалтаар оюутан,

суралцагчид олгох буцалтгүй тусламжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр 3.2.21-д өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр заасан, мөн тэтгэмж урамшуулалд хамрагдах хүсэлтэй шаардлага хангасан оюутан суралцагчдын хүсэлт нэмэгдсэн зэргийг тус тус үндэслэн буцалтгүй тусламжийн зардлыг 4,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Нөгөөтгээгүүр Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт заасны дагуу их дээд сургуулийн тогтмол зардлыг төсвөөс санхүүжүүлэх зорилгоор шинээр ашиглалтад орсон салбар сургуулиудын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг 2,156.4 сая төгрөгийг нэмж тусгалаа. Түүнчлэн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.18 дахь заалтад их дээд сургуулийн бие даасан байдлыг нь хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхээр заасан энэ байдаг. Энэ зорилтыг хангах зорилготой “Өрсөлдөөнт тэтгэлэг хөтөлбөр”-ийг шинээр хэрэгжүүлэхээр 1,500.0 сая төгрөг тусгалаа.

Япон улсын буцалтгүй тусламжаар Монгол Японы сургалтын эмнэлгийг барих 181.4 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжиж олон улсын өндөр стандартын эмнэлгийн тусламж үйлчилгээг их сургууль дээр суурилан ард иргэдэд хүргэх боломжтой болж байгаа бөгөөд мөн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь анх удаа эмнэл зүйн сургалт, судалгааг явуулах бааз эмнэлэгтэй болж өндөр түвшний боловсон хүчнийг бэлтгэх боломж бүрдээд байна. Эмнэлэг нь амбулаториор өдөрт 600 жилд 192 мянган хүнд, хэвтэн эмчлүүлэхээр 4300 орчим хүнд үйлчилж ойролцоогоор 2300 орчим мэс засал, 10 гаруй мянган дүрс оношилгооны ажилбарыг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Иймд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дэргэдэх сургалтын эмнэлгийн үйл ажиллагааг 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлүүлэхээр тооцож 3,178.0 сая төгрөгийн урсгал зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

Хүснэгт № 170. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Дээд боловсрол (71803)	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	97,476.6	125,536.0	135,804.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,322.9	2,682.9	5,884.2
81846 Оюутны сургалтын төлбөрийн зээл	8,000.0	75,326.9	75,326.9
80805 Төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөр	203.4	206.5	147.4
81813 Зарим суралцагчдад олгох санхүүгийн дэмжлэг	6,991.3	8,553.8	12,553.8
81814 Орон нутгаас суралцаж буй оюутнуудын замын зардлын хөнгөлөлт	1,085.9	1,033.4	1,033.4
81826 Багш мэргэжлээр суралцагчдад олгох сургалтын төлбөр	1,000.0	3,189.0	2,783.7
81828 Орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг	535.0	1,204.7	535.0
81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	70.0	149.4	250.0
81838 Дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөр	16,612.9	14,500.0	14,500.0
81824 Төрийн өмчит их, дээд сургуулиудын тогтмол зардлыг санхүүжүүлэх	6,062.8	6,708.4	8,864.8
81812 ЗГ-ын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг	453.9	734.7	867.0
81839 Өрсөлдөөнт тэтгэлэг хөтөлбөр хэрэгжүүлэх	0.0	0.0	1,500.0
81811 Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох зээл	5,464.4	7,300.0	7,300.0
81822 Гадаад суралцагсдын зардал	2,842.4	3,742.4	3,887.3
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	97,476.6	125,536.0	135,804.2

31	Улсын төсвөөс санхүүжих	97,110.2	124,834.9	135,145.1
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	366.4	701.1	659.1
Орон тоо		90	90	90

Хүснэгт № 171. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Дээд боловсрол (71803)		2016	2017	2018
		Гүйц	ХБГ	Төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		97,476.6	125,536.0	135,804.2
00295	Боловсролын зээлийн сан	89,198.0	116,112.6	119,236.0
09925	Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа	226.3	201.2	251.2
10090	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /шинэ/	6,132.8	6,939.0	10,614.8
10238	Монгол Германы хамтарсан технологийн дээд сургууль	1,919.5	2,283.2	2,524.2
10783	АШУҮИС-ийн харьяа түшиц эмнэлэг	0.0	0.0	3,178.0

Хөтөлбөр 6. Шинжлэх ухаан, технологи

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцын 2018 оны төсвийн төсөлд шинжлэх ухаан, технологи хөтөлбөрт 38,246.5 сая төгрөг төсөвлөлөө.

Зардлын өсөлтийн үндсэн шалтгаан нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.19 дэх заалтад эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлнэ гэж заасны дагуу эрдэм шинжилгээ судалгааны зардлыг 2017 оны тодотгосон төсвөөс 4,959.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2018 оны төсвийн төсөлд 15,079.0 сая төгрөг байхаар төсөвлөсөнтэй холбоотой байна.

Хүснэгт № 172. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Шинжлэх ухаан, технологи (71805)		2016	2017	2018
		Гүйц	ХБГ	Төсөл
Зориулалт арга хэмжээгээр		31,794.2	33,282.9	38,246.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	20,829.2	20,199.4	20,427.2
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	246.2	300.0	300.0
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	8,378.0	10,119.4	15,079.0
80219	Харуул, хамгаалалтын зардал	165.0	196.8	261.6
80220	Холбооны суваг ашигласны хөлс	183.0	276.7	457.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	263.8	156.2	425.6
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	821.4	437.6	437.6
81920	Монгол судлалын үйл ажиллагааг дэмжих	829.6	522.0	852.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		31,794.2	33,282.9	38,246.5
31	Улсын төсвөөс санхүүжих	31,263.7	32,597.4	37,561.0
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	530.5	685.5	685.5
Орон тоо		1,897	1,897	1,897

Шинжлэх ухаан, технологи хөтөлбөрт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын дараах байгууллагууд хамрагдаж байна. Үүнд:

Хүснэгт № 173. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Шинжлэх ухаан, технологи (71805)		2016	2017	2018
		Гүйц	ХБГ	Төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		31,794.2	33,282.9	38,246.5
00059	Академи - Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар	1,287.7	1,189.1	1,492.5
00221	ШУТСан - Ургамал, газар тариалангийн хүрээлэн	1,400.8	1,199.0	1,110.3
08710	ШУТСан - Шинжлэх ухаан, технологийн сан	6,461.8	10,266.4	15,491.5
09258	Академи - Философийн хүрээлэн	562.0	572.0	568.6
09259	Академи - Түүх, археологийн хүрээлэн	1,427.1	1,059.1	1,080.5
09261	Академи - Хэл зохиолын хүрээлэн	599.3	545.2	544.8
09262	Академи - Физик технологийн хүрээлэн	1,862.5	1,355.1	1,499.2
09264	Академи - Одон орон, геофизикийн хүрээлэн	2,553.9	2,434.4	2,660.6
09265	Академи - Хими, хими технологийн хүрээлэн	1,800.6	1,435.9	1,541.5
09266	Академи - Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн	1,834.5	1,574.5	1,649.7
09268	Академи - Газарзүй, гео-экологийн хүрээлэн	1,638.2	1,541.4	1,561.6
09271	Академи - Палеонтологи, геологийн хүрээлэн	889.1	813.4	824.3
09274	ШУТСан - Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	421.4	401.5	378.2
09276	ШУТСан - Уул уурхайн хүрээлэн	247.3	238.7	240.5
09280	ШУТСан - МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн	1,366.7	1,227.8	1,147.8
09283	ШУТСан - Анагаах ухааны хүрээлэн	554.0	521.3	473.5
09284	ШУТСан - Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн	1,007.0	955.9	895.5
09882	Боловсролын хүрээлэн	1,459.8	1,146.0	1,101.7
09891	ШУТСан - Математикийн хүрээлэн	194.4	190.7	188.1
09910	ШУТСан - Мал эмнэлгийн хүрээлэн	1,163.2	1,113.2	963.4
09911	ШУТСан - Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	663.1	525.1	499.2
10090	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /шинэ/	829.6	0.0	0.0
10150	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн /шинэ/	140.2	132.9	139.1
10396	Монгол судлалыг дэмжих сан	0.0	522.0	852.0
10552	ШУТСан - Цөмийн физикийн судалгааны төв	254.1	231.3	229.3
10553	Академи - Олон улсын харилцааны хүрээлэн	443.8	415.0	414.0
10559	ШУТСан - Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	732.1	553.9	497.2
10767	Шинжлэх ухааны паркийн захиргаа	0.0	56.9	201.9
00059	Академи - Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар	1,287.7	1,189.1	1,492.5
00221	ШУТСан - Ургамал, газар тариалангийн хүрээлэн	1,400.8	1,199.0	1,110.3

Хөтөлбөр 7. Насан туршийн боловсрол

Хүн бүрийн хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, тэгш боломжтойгоор хөгжүүлэх, ялангуяа боловсролын үйлчилгээ шаардлагатай нийгмийн бүлгийг онцгой анхаарах зорилгоор 2018 оны төсвийн төсөлд ерөнхий боловсролын сургуулийг түшиглүүлэн ажиллуулдаг насан туршийн боловсролын хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, үзүүлэх үйлчилгээний төрөл зүйлүүдтэй уялдуулан улсын хэмжээнд 11,370 иргэн хамрагдахаар тооцож нийт 3,358.4 сая төгрөг төсөвлөлөө.

Хөтөлбөр 8. Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага

Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага хөтөлбөрт 2017 оны төсвийн төсөлд 13,005.6 тэрбум төгрөг төсөвлөлөө. Хөтөлбөрийн хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Аймаг, нийслэл, дүүргийн Боловсрол, соёлын газар, хэлтсүүд зэрэг 34 байгууллага хамрагдаж байна.

Хүснэгт № 174. Хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага (71808)	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	18,119.5	12,621.6	13,005.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	12,288.2	12,059.5	11,084.7
80102 Туслах үйл ажиллагааны зардал	124.4	87.5	87.5
80221 Гэрээт ажиллагсдын зардал	218.3	209.6	209.6
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	0.0	228.7	242.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	248.2	322.6	512.3
81803 Бүх шатны боловсролын мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээ	20.0	35.1	135.0
81818 Боловсролын заавар, журам, гарын авлага бэлтгэх, хэвлүүлэх	50.2	19.5	54.2
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	20.0	29.8	40.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	18,119.5	12,621.6	13,005.6
31 Улсын төсвөөс санхүүжих	16,902.7	11,348.0	11,806.3
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,216.7	1,273.6	1,199.3
Орон тоо	692	692	692

Хүснэгт № 175. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨР: Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага (71808)	2016 Гүйц	2017 ХБГ	2018 Төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	18,119.5	12,621.6	13,005.6
00299 Нийслэлийн боловсролын газар	636.2	781.6	735.3
00301 Боловсролын газар	5,746.2	5,522.0	5,734.5
09718 Боловсролын үнэлгээний төв	2,008.2	1,989.9	1,992.9
09719 Насан туршийн боловсролын үндэсний төв	142.6	180.5	181.9
10090 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /шинэ/	2,623.0	2,384.5	2,575.6
10120 Багшийн хөгжлийн институт	1,191.1	1,074.1	1,071.6
10533-10541 БХ – дүүргийн Боловсролын хэлтсүүд	661.2	689.0	713.9

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын 2018 оны төсвийн урсгал зардалд 221,719.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 3,899.5 сая төгрөг, нийт **225,618.9** сая төгрөг тусгав. Үүнээс, урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулбал 16,796.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 176. Хөтөлбөрүүдийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	70,252.8	207,615.7	225,618.9
Зэвсэгт хүчний үйл ажиллагаа (70601)	65,356.7	204,922.6	221,719.4
Хөрөнгийн зардал	4,896.1	2,693.1	3,899.5

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрээр нь авч үзвэл, улсын төсвөөс 173,824.8 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 6,593.4 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 45,200.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр тусгалаа.

Хүснэгт № 177. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 онд хэрэгжүүлэх хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөгөөр/

Хөтөлбөрийн нэр	НИЙТ ДҮН	Урсгал зардал	Үүнээс:			Хөрөнгө оруулалт
			Цалин, НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг	
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	225,618.9	221,719.4	133,512.0	74,228.3	13,979.1	3,899.5
Зэвсэгт хүчний үйл ажиллагаа	221,719.4	221,719.4	133,512.0	74,228.3	13,979.1	0.0
Хөрөнгийн зардал	3,899.5	0.0	0.0	0.0	0.0	3,899.5

Батлан хамгаалахын сайдын 2018 оны төсвийн төслийг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад нэмэгдсэн зардлыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл, цалин, нэмэгдэл урамшлын зардлыг 13,446.8 сая төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 1,045.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 221.0 сая төгрөгөөр, нормативт зардлыг 1,741.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 473.9 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 494.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд тус багцын хүрээнд нийт 444 цэргийн албан хаагчийн 10,636.6 сая төгрөг тусгасан нь өмнөх оны төвшнөөс 1,736.8 сая төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжийн зардалд Монгол Улсын хилийн тухай хуулийн дагуу нийт 1,121.2 сая төгрөгийг тусгасан нь 2017 оны тодотгосон төсвөөс 35.4 сая төгрөгөөр өсөж байна.

Нийт төсвийн зарлагын өөрчлөлтийг зориулалт, арга хэмжээгээр болон байгууллагаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Зэвсэгт хүчний жанжин штабын цалингийн зардалд 2013-2016 онуудад гадаад, дотоодын сургууль, дамжаа төгссөн төгссөн 1150 төгсөгчдийг ажилд томилсноор бий болсон өглөгийг тооцож, Зэвсэгт хүчний жанжин штабын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,802.5 сая төгрөгөөр, Цэргийн төв эмнэлгийн цалин, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн цалингийн зардлыг 2016 онд 10 хувиар бууруулснаас бий болсон цалингийн зардлыг тооцож, Цэргийн төв эмнэлгийн төсөвт 184.0 сая төгрөг, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн төсөвт 230.6 сая төгрөгийн зардлыг 2017 оны төсвийн 2 дахь тодотголын төсөл болон 2018 оны төсвийн төсөлд нэмж тусгав.

Батлан хамгаалах яамны захиалгаар ОХУ болон бусад гадаад орнуудад адьюнктур, магистрантур, бакалаврт суралцаж буй оюутнуудад олгох сургалтын тэтгэлгийг 2017 оны төвшинд төсөвт тусгаж, байр ахуйн болон замын зардлыг үнэ, ханшийн өсөлтийг тооцож, 2017 оны тодотгосон төвшнөөс 405.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 2,105.1 сая төгрөгийг төсөлд тусгав.

Засгийн газрын 2014 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Оюутан цэрэг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн 2018 онд хэрэгжүүлэхэд зориулж, сургалтыг явуулахад шаардагдах тээвэр шатахуун, хоол хүнс, бичиг хэрэг, түлш халаалт, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, нормын хувцас, урсгал засварын зардалд нийт 991.8 сая төгрөг тусгасан нь 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 176.9 сая төгрөгөөр өссөн байна.

Батлан хамгаалах салбарт шаардагдах нормын хувцасны зардлыг 757.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгав. Мөн хугацаат цэргийн албан хаагчийн төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардалд 241.6 сая төгрөгийг тусгасан нь хугацаат цэргийн алба хаагчийн тоотой уялдан 73.3 сая төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын тусгай сангийн хуулиар хэрэгжиж буй зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах, энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх, цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2018 оны төсвийн төслийг 40,000.0 сая төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь 2017 оны тодотгосон төсвөөс 4,611.1 сая төгрөгөөр буурч байгаа нь 2016-2017 онуудад эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай уялдуулан түр хугацаанд зэвсэгт хүчний хичээл үйлдвэрлэлийн дадлага, нормын хувцас, бага үнэтэй түргэн элэгдэх эд ахуйн зүйлсийн зардлыг тус сангийн орлогоос санхүүжүүлэхээр тусгаж байсныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасантай холбоотой байна.

Цэргийн төв эмнэлгийн 2018 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих зардлыг 5,034.6 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих зардлыг 6,593.4 сая төгрөгөөр, өөрийн орлогыг 700.0 сая төгрөгөөр төсөвлөж, Засгийн газрын 2016 оны 68 дугаар “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг байгуулах тухай” тогтоолын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн 239 эмч, үйлчилгээний ажилтны орон тоог нэмэгдүүлж, бүрэн орон тоогоор ажиллаж эмчилгээ, үйлчилгээгээр хангаж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж, шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 2018 оны төсвийн төсөлд Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалтад “Цэргийн сургуулийн оюутан суралцаж байх хугацаандаа цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, цэргийн мэргэжил эзэмшсэн бол түүнийг хугацаат цэргийн алба хаасанд тооцож, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ” гэсний дагуу тус сургуулийн сонсогчдыг хээрийн сургалтад хамруулахад шаардагдах эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол, хүнс, нормын хувцасны зардалд 786.5 сая төгрөгийг тусгасан болно.

Мөн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.16 дахь заалтын дагуу алслагдсан цэргийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор түүний гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц мөнгөн тусламжийг улиралд нэг удаа олгохоор тооцож 666.2 сая төгрөг Зэвсэгт хүчний жанжин штабын 2018 оны төсвийн төсөлд тусгасан болно.

Хүснэгт № 178. Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах хөтөлбөрийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Зэвсэгт хүчний үйл ажиллагаа (70601)	2016 гүйц.	2017 год.	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	65,356.7	204,922.6	221,719.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	57,921.4	190,180.7	196,996.6
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	3.1	6.0

80214	Уран бүтээл хийлгэх	16.8	49.5	49.5
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	54.1	0.0	33.7
80220	Холбооны суваг ашигласны хөлс	75.1	74.4	74.4
80221	Гэрээт ажиллагсдын зардал	0.7	1.5	1.5
80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	3.5	34.8	34.8
80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	6.7	7.5	17.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,639.4	9,985.6	11,793.8
80811	Нүүлгэн шилжүүлэх зардал	0.0	5.0	8.0
80813	Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	150.1	200.0	200.0
80820	Бусад тусламж, дэмжлэг	50.6	62.2	0.0
80821	Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн хураамж	7.2	314.9	241.6
81601	Өндөр өртөгтэй мэс заслын зардал	0.0	237.0	855.8
81613	ЭМД-ын сангаас санхүүжих арга хэмжээ	0.0	618.8	5,738.8
81822	Гадаад суралцагсдын зардал	0.0	0.0	2,105.1
81905	Музейн үзмэр худалдан авах	10.0	14.9	15.0
82307	Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хөтөлбөр	4,605.1	0.0	0.0
82308	Зэвсэгт хүчний сургалт	16.0	2,317.8	0.0
82312	Оюутан цэрэг хөтөлбөр	800.0	815.0	991.8
82314	Хугацаат цэргийн цолны цалин	0.0	0.0	1,889.4
82320	Алслагдсан цэргийн анги-нийгмийн баталгаа	0.0	0.0	666.2
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		65,356.7	204,922.6	221,719.4
31	Улсын төсвөөс санхүүжих	16,580.9	145,916.7	169,925.3
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,085.8	4,871.5	6,593.4
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	43,690.0	54,134.5	45,200.7
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		65,356.7	204,922.6	221,719.4
00083	Зэвсэгт хүчний жанжин штаб	12,840.3	134,544.8	150,040.0
00089	Батлан хамгаалах яам	3,570.7	7,104.9	5,205.4
00097	Монгол цэргийн музей	354.5	377.7	379.1
00323	Цэргийн төв эмнэлэг	10,916.3	6,341.9	12,327.9
00497	Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга	1,581.6	1,602.8	1,613.2
03811	Үндэсний батлан хамгаалахын их сургууль	8,909.1	8,593.9	10,291.9
09703	Батлан хамгаалахын төв архив	286.7	289.2	399.7
09704	Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг	188.1	302.2	194.4
09842	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	26,709.4	44,611.1	40,000.0
10757	Алдар спорт хороо	0.0	1,020.5	1,057.1
10758	Тусгаар тогтнол сонин "Соёмбо"	0.0	133.5	210.7

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын 2018 оны төсвийн нийт зардал 1,159,013.3 сая төгрөг үүнээс урсгал зардалд 1,095,805.7 сая төгрөг, дотоод эх үүсвэрээс олгох зээлд 22,900.0 сая төгрөг, гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт 25,647.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 14,660.0 сая төгрөгийг төсвийн төсөлд тусгасан.

Хүснэгт № 178. Хөтөлбөрийн хураангуй /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	702,502.3	1,072,409.4	1,159,013.3
Мэргэжлийн боловсрол (71804)	61,073.1	55,271.9	53,622.2
Нийгмийн даатгал (71901)	497,267.3	587,257.2	531,202.3
Нийгмийн халамж (71902)	72,677.4	298,727.6	446,884.6
Нийгмийн хамгааллын бодлого удирдлага (71903)	1,638.5	2,936.8	6,268.4
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (72102)	35,513.1	62,024.4	65,877.1
<i>Үүнээс: Дотоод эх үүсвэрээс олгох зээл</i>	<i>0.0</i>	<i>20,000.0</i>	<i>22,900.0</i>

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага (72104)	1,291.0	2,031.4	2,455.2
Хүчирхийлэлд өртөгсөд үзүүлэх тусламж, дэмжлэг (72203)	0.0	242.0	246.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал (72206)	2,177.9	2,428.7	2,676.8
Хүүхдийн хөгжил, хамгаалал (72207)	10,928.0	14,204.7	7,961.1
Ахмад настны хөгжил хамгаалал (72208)	62.6	148.7	148.7
Залуучууд болон оюутнууд (72209)	0.0	0.0	1,177.1
Гэр бүлийн хөгжил, хамгаалал (72212)	0.0	0.0	186.0
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	4,065.2	39,456.8	25,647.8
Хөрөнгийн зардал	15,808.2	7,679.1	14,660.0

Урсгал зардлыг 2017 оны тодотголтой харьцуулбал 90,532.1 сая төгрөгөөр буюу 9.0 хувиар нэмэгдэж байна. Урсгал зардлын өөрчлөлтийн нөлөөлөл нь Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Цалинтай ээж” хөтөлбөр, “Өрх толгойлсон эх/эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай” хуулийг баталснаар халамжийн сангаас уг тэтгэмжийн зардалд 96,840.0 сая төгрөг, ядуу өрхийн гишүүдэд олгох тэтгэмжид 16,594.5 сая төгрөг, тэнэмэл, орон гэргүй иргэдэд халуун хоол, цай олгоход 1,176.9 сая төгрөг, төрөөс хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлыг 9,222.2 сая төгрөгөөр, нийгмийн халамжийн тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан ойролцоогоор 8 хувь нэмэгдүүлэхэд 17,381.9 сая төгрөг тус тус нэмэгдүүлсэн, мөн нийгмийн даатгалын сангийн алдагдал сайжирсантай холбоотойгоор нийгмийн даатгалын санд олгох татаасны хэмжээг 531,202.3 сая төгрөгөөр тусгасан нь 2017 оноос 56,054.9 сая төгрөгөөр буурсан, хүүхэд харах үйлчилгээний зардлыг БСШУССайдын багцад шилжүүлснээр 5,800.0 сая төгрөг буурсан зэрэг томоохон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Мөн 2018 онд тус сайдын харьяа байгууллагуудаас нийт 112 хүн тэтгэвэрт гарч нэг удаагийн тэтгэмжийн зардалд 1,499.6 сая төгрөг тусгасан бөгөөд үүнээс 1,123.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 376.1 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас олгохоор төсөвлөөд байна. УИХ-н 2017 оны 29 дугаар тогтоолд “Эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдлын салбараас 2017-2019 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 төрийн албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилох, энэ хугацаанд бусад салбарт төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх” гэж заасны дагуу 2017, 2018 оны төсвийн жилд тэтгэвэрт гарсан албан хаагчдын цалингийн зардал 200.8 сая төгрөгийг бууруулан тооцсон.

Хүснэгт № 179. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, зардлын эдийн засгийн ангиллаар /сая төгрөг/

ТӨЗ / Хөтөлбөр	Үүнээс					Догоод эх үүсвэрээс олгох зээл	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр
	НИЙТ ЗАРДАЛ	Урсгал зардал	Цалин НДШ	БҮ-ний бусад	Татаас шилжүүлэг		
НИЙТ	1,159,013.3	1,095,805.7	51,973.8	41,309.7	1,002,522.2	22,900.0	25,647.8
Мэргэжлийн боловсрол	53,622.2	53,622.2	28,153.0	23,439.2	2,030.0	-	-
Нийгмийн даатгал	531,202.3	531,202.3	0.0	0.0	531,202.3	-	-
Нийгмийн халамж	446,884.6	446,884.6	17,782.4	9,108.3	419,993.9	-	-

Нийгмийн хамгааллын бодлого удирдлага	6,268.3	6,268.3	2,459.9	3,561.3	247.1	-	-
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	65,877.1	65,877.1	470.2	257.0	42,250.0	22,900.0	
Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага	2,455.2	2,455.2	962.8	1,458.8	33.6	-	-
Хүчирхийлэлд өртөгсдөд тусламж	246.0	246.0	164.2	81.8	0.0	-	-
ХБИ-н хөгжил, хамгаалал	2,676.9	2,676.9	1,494.9	1,163.7	18.2	-	-
Хүүхдийн хөгжил, хамгаалал	7,961.2	7,961.2	486.4	1,473.8	6,001.0	-	-
Ахмад настны хөгжил хамгаалал	148.7	148.7	0.0	148.7	0.0	-	-
Залуучууд болон оюутнууд	1,177.1	1,177.1	0.0	431.0	746.1	-	-
Гэр бүлийн хөгжил, хамгаалал	186.0	186.0	0.0	186.0	0.0	-	-
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	25,647.8	-	-	-	-	-	25,647.8
Хөрөнгийн зардал	14,660.0	-	-	-	-	-	-

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгалын үйлчилгээ, нийгмийн хамгааллын бодлого, хөдөлмөр, эрхлэлтийн бодлого, удирдлага, мэргэжлийн боловсрол, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, ахмад настны, гэр бүлийн хөгжил, хамгаалал, залуучууд болон оюутнууд, хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж, дэмжлэг гэсэн үндсэн 12 хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.

Хөтөлбөр 1: Мэргэжлийн боловсрол

Мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд хувийн болон төрийн өмчит мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад олгох хувьсах зардал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа төрийн өмчит 37 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд, мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн урсгал зардлыг тусгасан.

Засгийн газраас сүүлийн жилүүдэд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд үндэсний хэмжээний томоохон ажиллах хүчин бэлтгэх, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх өндөр ур чадвартай ажиллагсдын эгнээг өргөтгөх чиглэлд ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдыг дэмжин дотуур байранд хамруулах, дадлагажуулах, төгсөөд ажлын байраар хангагдах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

2018 онд Мэргэжлийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 53,568.3 сая төгрөг төсөвлөсөн нь 2017 оны тодотголоос 1,703.6 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан. Энэ нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017 оны тодотголоор батлагдсан төсөвт нэг удаагийн арга хэмжээний зардал буюу хувийн болон төрийн өмчит мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад олгох хувьсах зардлын 2016 оны өглөг 1,900.0 сая төгрөг тусган баталсан байсныг 2018 оны төсөвт бууруулсантай холбоотой байна.

Хүснэгт № 180. Төрийн болон хувийн МСҮТ суралцагчдын тоо, төсвөөс олгож буй нийт зардал

	Суралцагчдын тоо	Нийт зардал /сая төг/
Төрийн өмчит МСҮТ /37/	26,908	46,569.7
Хувийн МСҮТ /41/	16,031	6,821.9

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарын зорилго нь барилга, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зам тээвэр, үйлчилгээ зэрэг тэргүүлэх салбарын мэргэжилтэй ажилтныг бэлтгэж, ажиллах хүчний эрэлт хэрэгцээг хангах явдал юм.

Одоогоор улсын болон хувийн хэвшлийн 81 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж, жилд дунджаар 42.0-45.2 мянган оюутан суралцан төгсөж, нийт төгсөгчдийн 50-55% нь ажлын байранд шууд зуучлан, 8-10% нь дараагийн шатны сургалтад буюу их, дээд сургуульд шатлан суралцаж байна.¹²

Мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн 2018 оны төсвийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19.3-д мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш нь 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас нь олгоно гэж заасан. Энэхүү тэтгэмжийг 2010 оноос эхлэн олгож эхэлсэн бөгөөд 2018 онд нийт 37 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 239 багшид 1,413.8 сая төгрөгийн тэтгэмжийг төсөвт тусгалаа.

2. Орон нутагт түлш, халаалтын үнэ, тариф нэмэгдсэн болон нэгдсэн шугам, сүлжээнд холбогдоогүй байсан зарим сургуулиуд цэвэр, бохир усны болон дулааны нэгдсэн шугам, сүлжээнд холбогдсоноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 867.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 9,055.8 сая төгрөгөөр төлөвлөв.

3. Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд УИХ-н 29 дүгээр тогтоолоор эрүүл мэнд, боловсрол, онцгой, цагдаагийн албанаас хоёр албан хаагч чөлөөлөгдсөн тохиолдолд нэг албан хаагчийг нөхөн томилох, бусад бүх салбарт нөхөн томилгоо хийхгүй байх гэж заасны дагуу тэтгэвэрт гарах 30 албан хаагчийн цалин 95.8 сая төгрөгийг бууруулж тооцсон, мөн үндсэн цалинг байгууллагуудын цалингийн цэстэй тулган, бодитоор авч буй үндсэн цалинг ангилал, шатлалаар хянаж тусгасан.

4. Орхон аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 235 ортой дотуур байрыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж 2017 оны IV улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Иймд 2018 оны төсөвт тус дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 147.3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 44.7 сая төгрөгийг тус тус нэмж төсөвлөсөн.

5. Иргэний мэргэжлийн ур чадварыг үнэлж, мэргэшлийн түвшнийг тогтоох, салбарын хүний нөөц, үнэлгээний ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, судалгаа шинжилгээ хийх, чадамжид суурилсан сургалтын үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг бүхий “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв” –ийн 2018 оны урсгал зардалд нийт 230.5 сая төгрөг

¹² Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн мэдээ- 2016

төлөвлөсөн.

Тус байгууллагын өөрийн орлого олох хууль, эрх зүйн үндэслэлтэй холбогдох хууль, дүрэм, журмуудад өөрчлөлт оруулахаар бэлтгэсэн төслүүдийг хэлэлцэх асуудал хойшлогдон, төвийн өөрийн үйл ажиллагаанаас олох орлого 2018 онд зардлаа нөхөх хэмжээнд төвлөрөхгүй болоод байгаа тул нийт зардлын 53.5 хувийг буюу 123.2 сая төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос, 46.5 хувь буюу 107.2 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөлөө.

Хүснэгт № 181. Мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	61,073.1	55,271.9	53,622.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	45,283.8	49,850.3	48,219.5
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	2.0	2.0
80219 Харуул, хамгаалалтын зардал	463.8	431.0	431.0
80307 Шүүхийн шийдвэрийн дагуу олгох төлбөр	35.2	0.0	0.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,166.2	2,061.8	1,844.2
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөний тэтгэмж	15.2	0.0	0.0
80813 Албан хаагчид олгох нөхөн олговор	639.2	229.1	185.8
81806 Дотуур байрны үйлчилгээ	2,330.8	2,697.7	2,939.8
81808 МСҮТ-д суралцагсад сар тутам олгох тэтгэлэг	10,139.0	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	61,073.1	55,271.9	53,622.2
31 Улсын төсвөөс санхүүжих	49,797.9	53,793.8	52,378.2
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	11,275.2	1,478.1	1,244.0
Орон гоо	2,972	2,972	2,972
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	61,073.1	55,271.9	53,622.2
----- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд /37/	45,394.3	46,091.6	46,569.7
09924 Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан	15,586.5	8,954.5	6,821.9
10666 Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээллийн төв	92.3	225.8	230.5

Хөтөлбөр 2: Нийгмийн даатгал /татаас/

Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаасны хэмжээг 531,202.3 сая төгрөгөөр буюу 2017 оны тодотголоос 56,054.9 сая төгрөгөөр буурахаар тооцсон. Үүнээс төр хариуцах буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 202,637.8 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 107,871.5 сая төгрөг, тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд 220,693.0 сая төгрөг улсын төсвөөс олгохоор тооцов.

Хүснэгт № 182. Нийгмийн даатгал хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
80408 Тэтгэврийн санд олгох татаас	494,879.0	587,257.2	531,202.3
Санхүүжүүлэх эх үүсвэрээр			
31 Улсын төсвөөс санхүүжих	494,879.0	587,257.2	531,202.3

Хөтөлбөр 3: Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн үйлчилгээ хөтөлбөрийн урсгал зардлыг 2018 онд 446,884.6 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотголоос 148,157.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлж байна:

1. Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 3.3.14-т “гурав хүртэлх насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж”

хөтөлбөр, Өрх толгойлсон эх/эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ“ гэж заасны дагуу УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль” батлагдаж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

Хүснэгт № 183. Цалинтай ээж хөтөлбөрийн хамрах хүрээ, зарцуулах хөрөнгө /мян. хүн, тэрбум төгрөг/

Хуулийн заалт	Тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Зарцуулах хөрөнгө
НИЙТ		151.5	96.8
1	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	135.0	81.0
2	Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	16.5	15.8

Энэхүү хуулийн дагуу 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр, түүнчлэн гурав болон түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр тэтгэмж¹³ олгох ба тэтгэмжийн хэмжээг хүүхдээ асарч байгаа эхэд сарын 50.0 мянган төгрөг буюу улиралд 150.0 мянган төгрөг, өрх толгойлсон эх/эцэгт улиралд 240.0 мянган төгрөгөөр буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нийт 96,840.0 сая төгрөг төсөвлөв.

Уг хуулийн хүрээнд Орон нутгийн халамжийн сангаас жирэмсэн эхийн тэтгэмжийн зардал 23,958.6 сая төгрөгөөр буурах ба хуулийн зардлын цэвэр нөлөөлөл 72,881.4 сая төгрөг байна.

Хүснэгт № 184. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд нэмж шаардагдах хөрөнгө

№	Тэтгэмж, тусламжийн төрөл	Шинээр нэмэгдэх хүний тоо /мян.хүн/	Сард олгох тэтгэмж болон дэмжлэг /төг/	Нэмж зарцуулах хөрөнгө /тэрб.төг/
НИЙТ		234.4	-	27.0
1	Хүнс гэжээлийн дэмжлэг авч байгаа нэн ядуу өрх, иргэдэд нөхцөлт мөнгөн тусламж олгох	73.6	15,000	16.6
2	Тэнэмэл, орон гэргүй иргэдэд халуун хоол, цайны зардал	0.8	9,500	1.2
3	Төрөөс ЭМД-ын шимтгэлийг нь хариуцах	160.0	4800	9.2

2. Олон Улсын валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу иргэдэд олгох тэтгэмж дэмжлэгийг нэмэгдүүлэхээр заасны дагуу орлого багатай эмзэг бүлэгт чиглэсэн үйлчилгээг дан ганц хүнсний хангамжийн хөтөлбөрөөр хязгаарлахгүйгээр бусад үйлчилгээг хамтад нь хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж нийт 17,771.4 сая төгрөгийг тусгасан. Нийгмийн халамжийн тухай хуульд 2012 онд тусгасан боловч төсвөөс санхүүжилт хуваарилаагүйн улмаас өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу иргэдэд тэтгэмж олгох, тэнэмэл орон гэргүй иргэдэд Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.2.2-д заасан халуун хоол, цайгаар үйлчлэх зардлыг тусгав. Ингэхдээ олон улсын нийтлэг жишгээр энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны иргэд хөдөлмөр

¹³ Хүүхдийн тоонд төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг хамааруулна

эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан байх, сургуулийн насны хүүхдүүдээ сургуульд бүрэн хамруулсан байх нөхцөлийг тавьж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.7-д нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний шимтгэлийг улсын төсвөөс сар бүр санхүүжүүлнэ гэж заасан. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох босго оноог 360.1783 оноогоор шинэчлэн тогтоосноор 260.4 мянган хүний ЭМД-ын шимтгэлийг төр хариуцахаар болсон нь өмнөх оноос 9,222.2 сая төгрөгөөр зардал нэмэгдэж нийт 66,970.6 сая төгрөгөөр тооцож тусгав.

4. Халамжийн тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан индексжүүлнэ.

2018 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөлд тус сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 8.0 орчим хувиар нэмэгдүүлэхээр тооцож холбогдох зардлыг тусгасан. Иймд нийгмийн халамжийн сангаас олгох халамжийн тэтгэврийг мөн адил зарчмаар нэмэгдүүлэхээр тооцоход халамжийн тэтгэвэр авах 62.7 мянган хүний авч байгаа тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 8.0 орчим хувиар нэмэгдүүлэхэд 17,381.9 сая төгрөг нэмж зарцуулахаар тооцов. Тус зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгаж халамжийн тэтгэвэр нэмэгдүүлэх Засгийн газрын шийдвэр гарсны дараа холбогдох төсөв буюу орон нутгийн төсөвт хуваарилахаар төлөвлөв.

Хүснэгт № 185. Халамжийн тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол

Тэтгэврийн төрөл	Хамрагдах хүн /мян. хүн/	Дундаж тэтгэвэр /мян.төг/		Нэмж шаардагдах /тэрбум төг/
		2017 онд	2018 онд	
1 Нийгмийн халамжийн тэтгэвэр	62.7	140.0	151.2	17.3
1.1 -Өндөр насны тэтгэвэр	2.1	140.0	151.2	0.6
1.2 -Тахир дутуугийн тэтгэвэр	44.8	140.0	151.2	12.4
1.3 -Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	15.8	140.0	151.2	4.3

5. ОУВС-аас 2017 оны 8 дугаар сард Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээг хийж 2018 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 60 хувийг хамруулахаар тохирсны дагуу ирэх жилд нийт 684.0 мянган хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохоор тооцож 164,160.0 сая төгрөгийг тэтгэмжийн зардалд тусгав.

6. Нийгмийн даатгалын тухай хуульд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр Цаа буга маллан амьдарч байгаа цаатан иргэнийг тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалд төрөөс даатгуулна гэж заасан. Цаа буга маллан тайгад амьдарч буй иргэдээс хөдөлмөрийн насны 172 иргэний нийгмийн даатгалын шимтгэлд 2017 онд 2.1 сая төгрөгийг нэмж буюу 54.1 сая төгрөгөөр төсөвлөсөн.

7. Өнөр бүл хүүхдийн төв нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага бөгөөд бүтэн болон хагас өнчин, эцэг эх байх эрх нь хуулиар хязгаарлагдсан, эцэг эх нь хорих ангид хүмүүжиж байгаа, сэтгэцийн өвчтэй нь эмчийн дүгнэлтээр батлагдсан, 70 ба

түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн 2-18 хүртэлх насны 200 орчим хүүхдийг хүлээн авч асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Тус төв нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа учраас 2018 оны төсвийн жилээс уг төвийн төсвийг нийслэлийн тусгай зориулалтын шилжүүлгээс хасаж улсын төсөвт шилжүүлэн нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулан 1,735.1 сая төгрөгийг төсөвлөөд байна.¹⁴

Хүснэгт № 185. Нийгмийн халамж хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	72,677.4	298,727.6	446,884.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	10,451.1	19,713.3	21,950.1
80102 Туслах үйл ажиллагааны зардал	411.2	1,267.9	1,313.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	289.6	1,191.7	1,604.1
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	0.6	0.6
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	328.3	466.2	466.2
80218 Улс орноо гадаадад сурталчлах	0.0	3.0	3.0
80220 Холбооны суваг ашигласны хөлс	132.2	292.7	302.7
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	26.5	72.4	72.4
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	0.0	0.9
80307 Шүүхийн шийдвэрийн дагуу олгох төлбөр	4.6	5.7	0.0
80312 Сургалт семинар	0.0	0.7	0.7
80504 Нөхөн олговор авагсдын шимтгэл	0.0	0.3	0.0
80611 Тэтгэврийн нөхөн олговор	5.0	2.6	0.0
80701 Халамжийн тэтгэвэр	0.0	0.0	17,381.9
80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж	4,744.9	6,000.0	6,428.4
80705 Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж	28,513.6	29,449.0	29,449.0
80706 Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	0.0	161,520.0	164,160.0
80710 Асрамжийн үйлчилгээ	130.0	138.3	138.3
80714 Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	0.0	0.0	1,125.0
80717 Нийгмийн халамжийн бусад тэтгэмж, хөнгөлөлт	0.0	0.0	96,840.0
80718 Насны хишиг	0.0	20,500.0	20,500.0
80719 Халуун хоол цайгаар үйлчлэх	0.0	0.0	1,176.9
80720 Ядуу өрхийн тэтгэмж	0.0	0.0	16,594.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	233.5	302.9	352.1
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөний тэтгэмж	1,478.9	0.0	0.0
80821 Төрөөс ЭМД-г нь хариуцах иргэдийн хураамж	25,886.4	57,748.4	66,970.6
80831 Цаатан иргэдийн НДШ	41.6	52.0	54.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	72,677.4	298,727.6	446,884.6
31 Улсын төсвөөс санхүүжих	72,308.2	297,016.7	444,722.6
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	369.2	1,710.9	2,162.0
Орон тоо	1,751	1,751	1,854
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	72,677.4	298,727.6	446,884.6
00412 Хүүхэд асран хүмүүжүүлэх төв	0.0	0.0	1,735.1
00415 Ахмад настны асрамжийн үндэсний төв	1,635.1	2,134.9	2,307.1
00771 Тэтгэврийн нөхөн олговор	5.0	2.6	0.0
08572 Нийгмийн халамжийн сан	33,901.6	218,540.1	354,726.8
08573 Тэтгэврийн нөхөн олговор авагсдын нийгмийн даатгалын шимтгэл	0.0	0.3	0.0
10166 БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	407.7	996.6	1,055.4
10669 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	25,928.0	57,800.4	67,024.7

¹⁴ ХНХСайдын 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 1/2189 “Өнөр бүл хүүхдийн төвийн төсвийг шилжүүлэх тухай” албан бичиг

10670	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар	754.9	1,573.4	1,663.4
10671	ХХҮХ - Аймаг нийслэлийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс	10,045.2	17,679.5	18,372.1

Хөтөлбөр 4: Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага

Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага хөтөлбөрийн хүрээнд салбарын ерөнхий удирдлага, нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны зардлыг тусгасан бөгөөд 2018 онд 6,268.4 сая төгрөг тусгахаар төсөвлөсөн нь 2017 оны тодотголоос 3,331.6 сая төгрөгөөр өсөж байна. Зардал нэмэгдэхэд дараах гол зүчин зүйлс нөлөөлж байна.

1. Япон Улсад ажиллаж байгаа монгол иргэдийн тоо жил бүр өсөж 6 мянгад хүрсэн, Япон Улсын парламентаас “Гадаад иргэдийн ур чадварын дадлагажигчийн хөтөлбөрийг зүй зохистой хэрэгжүүлэх болон эрх ашгийг хамгаалах тухай” хууль баталсны дагуу Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яам болон манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд Ур чадварын дадлагажигчийн хөтөлбөр хэрэгжүүлэх тухай гэрээ байгуулагдан ажиллаж байна. Цаашид Япон Улсад ажиллах иргэдийн тоо нэмэгдэх тул тэдний эрх ашгийг хамгаалах, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг хариуцах шаардлагыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны төсөвт 2,201.8 сая төгрөг;
2. Монголын улаан загалмайн нийгэмлэгийн 2018 онд хүмүүнлэгийн чиглэлээр Засгийн Газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд нэмэлт хүч болж ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн саналын дагуу нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төсөвт 86.0 сая төгрөг;
3. "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2016 оны 10-р сарын 26-ны өдрийн 121-р тогтоолын хавсралтаар батлагдсан Үндэсний хөтөлбөрүүд, Засгийн газрын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд төсвийн хамт тусгагдсан зарим ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлуудад 870.0 сая төгрөг;
4. УИХ-н 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 25.0 сая төгрөгийг тус тус нэмж тусгасан.

Хүснэгт № 186. Нийгмийн хамгааллын бодлого, удирдлага хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	1,638.5	2,936.8	6,268.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	897.1	2,028.7	2,033.2
80102 Туслах үйл ажиллагааны зардал	0.0	0.0	2,201.8
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	11.8	123.1	0.0
80218 Улс орноо гадаадад сурталчлах	61.9	194.0	462.2
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	76.5	0.0	0.0
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	236.7	343.1	343.1
80509 ОУ-н байгууллагын гишүүнчлэлийн хураамж	62.1	171.6	171.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	18.8	26.3	25.5
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөний тэтгэмж	251.9	0.0	0.0

80824	Цэргийн алба хааж байсан иргэдийн НДШ	21.7	50.0	50.0
81518	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг	0.0	0.0	870.0
81560	МУЗН-ээр гэрээгээр гүйцэтгүүлэх	0.0	0.0	86.0
82313	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	0.0	0.0	25.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		1,638.5	2,936.8	6,268.4
31	Улсын төсвөөс санхүүжих	1,638.5	2,936.8	6,268.4
Орон тоо		117	117	117
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		1,638.5	2,936.8	6,268.4
10669	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	1,638.5	2,936.8	6,268.4

Хөтөлбөр 5: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2018 онд нийт 65,877.1 сая төгрөгийг тусгахаар төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 3,852.7 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр ажилгүй иргэдийг ажилд зуучлах, ажлын байртай болгох, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэдийг дэмжих, жижиг үйлдвэрлэл үйлчилгээг дэмжин ажлын байрыг бий болгох, нийтийг хамарсан ажил зохион байгуулж ажилгүй иргэдийг ажлын түр байраар хангах, ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилд зуучлан оруулахад санхүүгийн дорвитой дэмжлэг үзүүлэх, урамшуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэгт үйл ажиллагаа чиглүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн 2018 оны төсвийн төсөлд дараах арга хэмжээний зардлыг тусгасан. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийт зарлагыг 65,348.0 сая төгрөгөөр төсөвлөснөөс 22,900.0 сая төгрөг нь эргэж төлөгдөх цэвэр зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх ажиллагаанд 42,250.0 сая төгрөгийг, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагаанд 198.0 сая төгрөгийг төсөвлөсөн. Тус сан нь 2018 онд гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэний ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр зэрэг өөрийн орлогын эх үүсвэрээс 48,384.0 сая төгрөг, 2017 оны үлдэгдлээс 2,114.0 сая төгрөг, Капитал болон Төрийн банкаар дамжуулан олгосон жижиг зээлийн эргэн төвлөрүүлэлт 11,000.0 сая төгрөг, улсын төсвөөс 3,850.0 сая төгрөгөөр тус тус санхүүжихээр төлөвлөсөн.
2. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал болон хүн амын хөгжлийн бодлогын суурь судалгаа, шинжилгээ, хэтийн болон ойрын төлөвлөлт, тооцоолол хийж, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2018 оны урсгал зардлыг 529.1 сая төгрөгөөр төлөвлөсөн. Тус байгууллага нь 2018 онд жил бүр тогтмол хийгддэг цалин хөлсний бүтцийн, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн, барометрийн зэрэг томоохон судалгаануудыг хийхээс гадна албан бус хөдөлмөр эрхлэлтийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн, таамаглал загварчлалын, хөдөлмөр эрхлэх сонирхолтой ахмад настны төлөв байдлын болон бусад судалгаануудыг хийхээр төлөвлөөд байна.

Хүснэгт № 187. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 тод	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	35,513.1	62,024.4	65,877.1
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	496.2	526.4	529.1
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.0	198.0	198.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5.0	0.0	0.0
80812 Бүтцийн өөрчлөлтийн тэтгэмж	8.6	0.0	0.0
80820 Бусад тусламж, дэмжлэг	10,149.3	0.0	0.0
81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	0.0	20,000.0	22,900.0
82614 Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа хөтөлбөр	86.6	0.0	0.0
82616 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр,			
төсөл	24,767.4	41,300.0	42,250.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	35,513.1	62,024.4	65,877.1
31 Улсын төсвөөс санхүүжих	4,593.4	526.4	4,379.1
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	30,919.6	61,498.0	50,498.0
37 Бусад эх үүсвэр	0.0	0.0	11,000.0
Орон тоо	40	40	40
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	35,513.1	62,024.4	65,877.1
08657 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	34,916.7	49,539.0	65,348.0
10166 БНСУ хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	274.6	0.0	0.0
10669 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	86.6	0.0	0.0
10681 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт	235.2	526.4	529.1

Хөтөлбөр 6: Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага

Монгол Улсын Засгийн газраас хөдөлмөрийн талаар баримталж байгаа бодлого зорилтыг хэрэгжүүлэх зорилго бүхий тус хөтөлбөр нь иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, мэргэжлийн боловсрол, сургалтыг олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг.

2018 онд тус хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн урсгал зардал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа хөтөлбөрийн зардалд нийт 2,455.2 сая төгрөгийн зардлыг төлөвлөн оруулсан.

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагуудын ажлын байранд хөдөлмөрийн болон эрүүл ахуйн нөхцөлийг судлах, үнэлгээ хийх, ажлын байрны аюултай хортой хүчин зүйлсийг багасгах, арилгах арга хэмжээний зөвлөгөө зөвлөмж өгөх, ажилчдад эрүүл аюулгүй зан үйлийг төлөвшүүлэх мэргэжлээс шалтгаалсан өвчнийг /МШӨ/ эрт илрүүлэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан /ХЧА/ иргэдэд хөдөлмөр зохицуулалтын магадлал хийх холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага болох Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн зардлыг 1,536.4

сая төгрөгөөс 1,720.1 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн нь уг байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний тухай, Хөдөлмөрийн тухай хуулиудын шинэчилсэн найруулгын сургалт, сурталчилгаа зохион байгуулах, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны үйл ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээнд зарцуулагдах зардлыг 735.0 сая төгрөгөөр төсөвлөсөн.

Хүснэгт № 188. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	1,291.1	2,031.4	2,455.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,177.5	1,493.8	1,661.5
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.0	17.5	25.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	97.2	25.1	33.6
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөний тэтгэмж	16.4	0.0	0.0
82614 Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа хөтөлбөр	0.0	495.0	735.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,291.1	2,031.4	2,455.2
31 Улсын төсвөөс санхүүжих	938.7	1,360.4	1,634.2
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	352.4	671.0	821.0
Орон тоо	96	96	96
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,291.1	2,031.4	2,455.2
10153 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	1,291.1	1,536.4	1,720.2
10669 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0.0	495.0	735.0

Хөтөлбөр 7: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрт нийт 2,676.8 сая төгрөг төсөвлөсний 2,181.2 сая төгрөг нь Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв, 325.2 сая төгрөг нь Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт үйлдвэр, 170.6 сая төгрөг нь зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардал байна.

Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа өргөжиж эмнэлгийн 6 давхар барилга ашиглалтад орох, мөн Эрүүл мэндийн сайдын 2017 оны 6-р сарын 7-ны өдрийн "Улсын хэмжээнд 2018-2019 онд ашиглах эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг батлах тухай" А/234-р тушаалаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын ор болон хүчин чадал нь нэмэгдэж байгаатай холбоотойгоор тус эмнэлгийн ор хуучин 45 байсан нь 60 болж нэмэгдсэнээр нормативт зардлууд болох эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнсний зардалд 176.5 сая төгрөгийг нэмж төсөвлөсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох чиг үүрэг бүхий нарийн мэргэжлийн эмч, боловсролын болон нийгмийн хамгааллын салбарын төлөөллөөс бүрдсэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс ажиллахаар заасан. Үүний дагуу 2014 оны Хүн амын хөгжил, нийгмийн

хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А05/А14/А16 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссыг 21 аймаг, 9 дүүрэгт салбар комисстойгоор зохион байгуулахаар заасан. Энэхүү үйл ажиллагаанд зориулсан зардалд 170.5 сая төгрөг тусгасан.

Хүснэгт № 189. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	2,177.9	2,428.7	2,676.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,068.7	2,198.9	2,437.4
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	31.5	31.2	37.8
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	3.0	0.0	0.0
80219 Харуул, хамгаалалтын зардал	9.5	12.8	12.8
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.0	170.6	170.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	11.8	15.2	18.2
80812 Бүтцийн өөрчлөлтийн тэтгэмж	21.6	0.0	0.0
80820 Бусад тусламж, дэмжлэг	15.1	0.0	0.0
81820 Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг	16.6	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	2,177.9	2,428.7	2,676.8
31 Улсын төсвөөс санхүүжих	1,660.4	1,801.5	1,915.7
33 Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	368.0	527.2	631.1
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	149.5	100.0	130.0
Орон тоо	129	129	129
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	2,177.9	2,428.7	2,676.8
00427 Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэр	290.0	288.9	325.2
08588 Сэргээн засалтын үндэсний төв	1,887.9	1,969.2	2,181.2
10669 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0.0	170.6	170.6

Хөтөлбөр 8: Хүүхдийн хөгжил, хамгаалал

Хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрууд, Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар зэрэг байгууллагын зардалд нийт 7,961.1 сая төгрөгийг 2018 оны төсөвт тусгасан нь 2017 онтой харьцуулахад 6,243.6 сая төгрөгөөр буурч байна. Зардал буурсан гол шалтгаан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад байсан Хүүхэд харах үйлчилгээний зардлыг 2018 оны төсвөөс Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцад тусгахаар тооцож холбогдох зардлыг шилжүүлсэн.¹⁵ Мөн 2017 онд тус хөтөлбөр дээр байсан Өнөр бүл хүүхдийн төвийн төсвийг 2018 оноос нийгмийн халамжийн хөтөлбөрт шилжүүлэн улсын төсвийн байгууллага болгон өөрчилсөн.¹⁶

Хүснэгт № 190. Хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрөөс шилжсэн зардлын тухай /сая төгрөг/

¹⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 1/2253 дугаар албан бичиг

¹⁶ ХНХСайдын 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 1/2189 “Өнөр бүл хүүхдийн төвийн төсвийг шилжүүлэх тухай” албан бичиг

Д/д	Арга хэмжээ	2017 год	2018 төсөл	Тайлбар
1	Хүүхэд харах үйлчилгээ	5,800.0	0	БСШУССайдын багцад шилжсэн
2	Өнөр бүл төв	1,750.8	1,735.1	Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөрөөс Нийгмийн хамгааллын хөтөлбөрт шилжүүлсэнээр 2018 оноос улсын төсвийн байгууллага болно.
3	Бусад	6,653.9	7,961.1	Хүүхдийн байгууллага, хүүхэд хамгааллын чиглэлээрх бусад зардал

Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт дараах арга хэмжээний зардлыг тусгаад байна. Үүнд:

1. Хүүхдийн тусламж үйлчилгээний 108 утасны зардалд 261.7 сая төгрөг, Хүүхэд хамгааллын тухай хууль (2016), Хүүхдийн эрхийн тухай хууль (2016), Монгол Улсын Их хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020)-ын 3.4.4-3.4.7 дэх заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлуудад 1,054.4 сая төгрөгийг тусгасан нь 2017 оны тодотголоос 658.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
2. Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь 2016 онд 2,947.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 3,952.1 сая төгрөгийн зардал гарган ажилласан. Тус төв нь 2016 оноос аж ахуйн тооцоонд гарч өөрийн орлогоор бүрэн санхүүжих тогтолцоонд шилжин ажиллаж байна. Шилжилтийн хугацаанд улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 онд 2017 оны түвшнээр буюу 497.0 сая төгрөгийн татаас олгохоор тусгав.
3. Гэр бүл, хүүхэд залуучуудын салбарт шинээр ашиглалтад орсон дараах барилгын урсгал зардалд нийт 831.8 сая төгрөгийн зардал тусгасан.
 1. Төв аймгийн Залуус хөгжлийн төв
 2. Дархан-Уул аймгийн Хүүхдийн ордон
 3. Хэнтий аймгийн Хүүхдийн ордон
 4. Өмнөговь аймгийн Хүүхдийн ордон
 5. Увс аймгийн Түр хамгаалах байр
 6. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Хүүхэд, залуучуудын төв
 7. Говь-Алтай аймгийн “Хүүхэд, залуучуудын ордон”
 8. Булган аймгийн “Хүүхэд, залуучуудын ордон”
 9. Өвөрхангай аймгийн Хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах байр
 10. Баянхонгор аймгийн Түр хамгаалах байр

Хүснэгт № 191. Хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

	Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр		10,928.0	14,204.7	7,961.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	739.4	584.3	598.6
80102	Туслах үйл ажиллагааны зардал	0.0	261.7	261.7
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	43.6	43.1	45.5
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.9	0.0	0.0
80231	Хүүхэд харах үйлчилгээ	3,800.4	5,800.0	0.0

80502	Тусгай зориулалтын шилжүүлэг	5,966.0	6,118.3	5,503.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал,	16.2	0.0	0.0
80812	Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөний тэтгэмж	97.5	0.0	0.0
81518	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээ	264.0	504.2	0.0
83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	0.0	893.0	1,551.4
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		10,928.0	14,204.7	7,961.1
31	Улсын төсвөөс санхүүжих	10,928.0	14,204.7	7,961.1
Орон тоо		35	35	41*
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		10,928.0	14,204.7	7,961.1
00603	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	4,962.0	7,589.4	1,960.2
10157	Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний ТЗШ	5,966.0	6,118.3	5,503.9
10669	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0.0	497.0	497.0

*Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын орон тоог харьяа хэлтсээс шилжүүлэн зохицуулалт хийж нэмэгдүүлсэн

Хөтөлбөр 9: Гэр бүлийн хөгжил, хамгаалал

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020) болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” –ийг батлуулахаар ажиллаж байна. Иймд 2018 оны төсвийн төсөлд гэр бүлийн хөгжил, хамгаалал хөтөлбөрт зардал төсөвлөж Монгол улсын хэмжээнд 2016 оны статистик мэдээгээр бүртгэлтэй 869,849 өрхөөс зорилтот гэр бүл буюу 40%-д нь хандсан ажлыг зохион байгуулахад 186.0 сая төгрөг тусгасан.

Хүснэгт № 192. Гэр бүлийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Гэр бүлийн хөгжил, хамгаалал (72212)		2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр		0.0	186.0
83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	0.0	186.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		0.0	186.0
31	Улсын төсвөөс санхүүжих	0.0	186.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		0.0	186.0
00603	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	0.0	186.0

Хөтөлбөр 10: Залуучууд ба оюутнууд

2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020)-г туссан залуучуудын чиглэлээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлуудад нийт 1,177.1 сая төгрөгийг төсөвлөсөн. Үүнд, Монгол улсын хэмжээнд 2016 оны статистик тоон мэдээгээр 1,1 сая өсвөр үе, залуучууд байна. 2018 онд нийт залуучуудын 40%-д хандсан сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын төсөвт 431.0 сая төгрөгийг төсөвлөсөн.

Мөн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн “20.3.Залуучуудын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх залуучуудын хөгжлийн төвтэй байна.” гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд одоогоор 11 аймгийн 13 сум, 3 дүүрэгт Залуучуудын хөгжлийн төв нь 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр, НҮБХАС-аас дэмжлэг авч ажиллаж байна. 11 аймаг, 3 дүүргийн Залуучууд хөгжлийн төвөөр 2017 оны эхний хагас жилийн байдлаар 11,957 хүн үйлчлүүлсэн байна. 2018 онд үлдсэн аймаг, дүүрэгт төвийг байгуулахаар тооцон нийт тус төвүүдийн урсгал зардалд 746.1 сая төгрөгийг төсөвлөв.

Хүснэгт № 193. Залуучууд буюу оюутнууд хөтөлбөрийн зардал зориулалтаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Залуучууд буюу оюутнууд (72209)	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	0.0	1,177.1
83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	0.0	431.0
80502 Тусгай зориулалтын шилжүүлэг	0.0	746.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	0.0	1,177.1
31 Улсын төсвөөс санхүүжих	0.0	1,177.1
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	0.0	1,177.1
00603 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	0.0	431.0
10157 Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний ТЗШ	0.0	746.1

Хөтөлбөр 11: Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж, дэмжлэг

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Хүүхдийн эрхийн болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 231 дүгээр тогтоолоор Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий "Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр", хүүхэд, залуучуудын чиглэлээр судалгаа хийх, нийгмийн ажилтны чадавхыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий "Сургалт, судалгаа мэдээллийн төв"-ийг байгуулан, батлагдсан төсвийн багцдаа багтаан зохицуулалт хийхээр шийдвэрлэсний дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2017 оны батлагдсан төсөв, орон тооноос шилжүүлэн зохицуулалт хийж 242.0 сая төгрөгийн төсөвтэйгөөр ажиллуулж байна. 2018 онд тус түр хамгаалах байр, мэдээллийн төвийн зардалд 246.0 сая төгрөг төсөвлөсөн.

Хүснэгт № 194. Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж, дэмжлэг хөтөлбөрийн зардал /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж, дэмжлэг (72203)	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	242.0	246.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	242.0	246.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	242.0	246.0
31 Улсын төсвөөс санхүүжих	242.0	246.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	242.0	246.0
00603 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	242.0	246.0

Хөтөлбөр 12: Ахмад настны хөгжил, хамгаалал

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 9.1-д ахмад настны олонхын нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах төв байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр

заасан байдаг. Ахмадын байгууллагад 2018 онд олгох санхүүжилтийг 2017 оны түвшнээр буюу 148.7 сая төгрөгөөр төсөвлөөд байна.

Хүснэгт № 195. Ахмад настны хөгжил, хамгаалал хөтөлбөрийн зардал /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Ахмад настны хөгжил хамгаалал (72208)	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	62.6	148.7	148.7
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	62.6	148.7	148.7
Санхүүжүүлэх эх үүсвэрээр			
31 Улсын төсвөөс санхүүжих	62.6	148.7	148.7
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	62.6	148.7	148.7
10669 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	62.6	148.7	148.7

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Эрүүл мэндийн сайдын багцын 2018 оны төсвийг 770,708.7 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 80.7 хувь буюу 621,683.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 7.8 хувь буюу 60,190.2 сая төгрөг, гадаад зээл тусламжийн үйл ажиллагаатай холбоотой зардалд 11.5 хувь буюу 88,834.6 сая төгрөг зарцуулахаар тооцож төслийг боловсруулав.

Хүснэгт № 196. Хөтөлбөрүүдийн хураангуй дунд хугацаагаар /нийт зардал/ /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР	2016 Гүйц	2017 Год	2018 төсөл
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	647,787.4	673,530.3	770,708.7
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	64,746.3	55,375.4	90,823.9
<i>Үүнээс: Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</i>	<i>64,146.5</i>	<i>54,323.7</i>	<i>88,834.6</i>
<i>Улсын төсвөөс санхүүжих зардал</i>	<i>599.7</i>	<i>1,051.7</i>	<i>1,989.3</i>
Нийгмийн эрүүл мэнд (71601)	49,586.8	54,690.5	60,918.5
Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	446,179.2	467,696.0	513,096.2
Эрүүл мэндийн бодлого, удирдлага (71603)	84,221.7	95,768.5	105,870.1
<i>Үүнээс: Хөрөнгийн зардал</i>	<i>46,103.5</i>	<i>49,422.1</i>	<i>60,190.2</i>
Соёл, урлаг, спорт, аялал жуулчлал (71700)	3,053.4	-	-

Эрүүл мэндийн сайдын багцын нийт зарлагын өөрчлөлтөд Нийгмийн эрүүл мэнд хөтөлбөрийн зардал 6,228.0 сая төгрөгөөр, Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн зардал 45,400.2 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн бодлого, удирдлага хөтөлбөрийн 10,101.7 сая төгрөгөөр, гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийн зардал 35,448.5 сая төгрөгөөр тус тус өмнөх оны түвшнээс нэмэгдсэн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын зардал 10,768.1 сая төгрөг, гадаад зээл, тусламжийн санхүүжилттэй зардал 34,510.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт № 197. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн хураангуй зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

ТЕЗ / Хөтөлбөр	Нийт дүн	Урсгал зардал	Үүнээс			Гадад зээл тусламжаас санхүүжих зардал	Хөрөнгийн зардал
			Цалин НДШ	Бараа үйлчилгээ ний бусад	Татаас, шилжүүлэг		
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	770,708.7	621,683.9	245,485.1	234,402.9	141,795.9	88,834.6	60,190.2
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	90,823.9	1,989.3	622.6	1,366.7	0.0	88,834.6	
Эрүүл мэнд	619,694.6	619,694.6	244,862.5	233,036.0	141,795.9		
Нийгмийн эрүүл	60,918.5	60,918.5	14,014.3	16,873.4	30,030.8		
Эмнэлгийн тусламж үйлчилгээ	513,096.2	513,096.2	220,069.0	208,380.6	84,646.6		
Эрүүл мэндийн бодлого, удирдлага	45,679.9	45,679.9	10,779.2	7,782.2	27,118.5		

Эрүүл мэндийн сайдын багцад 2018 оны төсөвт тусган хэрэгжүүлэх томоохон хөтөлбөрүүдийн бүтцийг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 621,683.9 сая төгрөг буюу 80.7 хувь нь урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 245,485.1 сая төгрөг буюу 39.4 хувь нь цалин хөлс ба нийгмийн даатгалын шимтгэлд, 234,402.9 сая төгрөг буюу 37.8 хувь нь бараа, үйлчилгээний бусад зардалд, 141,795.9 сая төгрөг буюу 22.8 хувь нь татаас, урсгал шилжүүлгийн зардалд хамаарч байна.

Эрүүл мэндийн сайдын багцын 2018 оны төсвийн төсөлд тусгасан урсгал зардлыг 2017 оны тодотголтой харьцуулахад 51,899.4 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт № 198. Хөтөлбөрүүдийн хураангуй дунд хугацаагаар /урсгал зардал/ /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Нийгмийн эрүүл мэнд (71601)	2016 Гүйц	2017 Тод	2018 оны төсөл
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	537,537.3	569,784.5	621,683.9
Ерөнхий төлөвлөлт, санхүү төсвийн харилцаа (70200)	599.7	1,051.7	1,989.3
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	599.7	1,051.7	1,989.3
Эрүүл мэнд (71600)	533,884.2	568,732.9	619,694.6
Нийгмийн эрүүл мэнд (71601)	49,586.8	54,690.5	60,918.5
Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	446,179.2	467,696.0	513,096.2
Эрүүл мэндийн бодлого, удирдлага (71603)	38,118.2	46,346.4	45,679.9
Соёл урлаг, спорт, аялал жуулчлал (71700)	3,053.4	0	0
Биеийн тамир спорт (71701)	3,053.4	0	0

Нийт урсгал зардлын өсөлтийн 28.6 хувь нь өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, 18.7 хувь нь амбулаторийн тусламж үйлчилгээ нэмэгдэж байгаа, мөн эмнэлгүүдийн дундаж ор хоногийн ашиглалт сайжирсан, зарим эмнэлгүүдийн хүчин чадал өргөжсөний улмаас хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдэж улмаар Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих урсгал зардал өссөн байна. Харин нийт зардлын 19.2 хувь нь буюу 9,967.6 сая төгрөг нь цусны хавдар, сүрьеэ, гемодиализ болон уушгины эм, хатгалгааны эсрэг вакцин зэрэг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг төрөөс худалдан авах зориулалтаар нэмэгдсэн байна.

Хүснэгт № 199. ЭМС-ын урсгал зардал нэмэгдүүлж буй шалтгаан /сая төгрөг/

№	Зардал нэмэгдүүлж буй шалтгаан, үндэслэл	Дүн, сая төгрөгөөр	Нийт өсөлтөд эзлэх хувь
	Нийт нэмэгдэх урсгал зардал	51,899.4	100.0%
1	Өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	14,866.6	28.6%
2	Даатгуулагч иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээ нэмэгдэх	9,702.9	18.7%
3	Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардал /цусны хавдар, сүрьеэ, эрхтэн шилжүүлэх, дархлаа дарангуйлах, гемодиализ, уушгины хатгалгааны вакцин,	9,967.6	19.2%
4	Шинээр ашиглалтад орж буй эмнэлэг, эмнэлгийн өргөтгөлийн улмаас нэмэгдэх үйл ажиллагааны зардал	6,386.1	12.3%
5	Өрх, сумын ЭМТ-ийн тарифын өөрчлөлт, тогтмол зардал	4,432.6	8.5%
6	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах урсгал зардал	2,500.0	4.8%
7	Эрүүл мэндийг дэмжих сан ба бусад	2,030.0	3.9%

Төсвийн урсгал зардлын өсөлтөд 2017-2018 онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй эмнэлгийн шинэ барилга, барилгын өргөтгөл ашиглалтад орсон, төрөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний нэр төрөл, цар хүрээний өргөжилт, хүн амын өсөлттэй уялдуулан нэмэгдэх урсгал зардал, зарим өвчнийг оношлох, эмчлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зардал, Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг хүн амын өсөлттэй уялдуулан нэг иргэнд ногдох зардлаар тооцон нэмэгдүүлсэн зэрэг нь голлох нөлөөлөл үзүүлж байна.

Хүснэгт № 200. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын зарим үзүүлэлтүүд, эмнэлгийн төрлөөр

д/д	Үзүүлэлт	2014	2015	2016
1	Дундаж ор хоног	7.9	7.7	7.3
	Өрхийн ЭМТ, сум дундын эмнэлэг, сум/тосгоны ЭМТ	7.2	6.9	6.7
	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, БОЭТ	7.3	7.3	7.2
	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	9.4	8.9	8.7
2	Орны тоо	13,725	14,196	14,807
	Өрхийн ЭМТ, сум дундын эмнэлэг, сум/тосгоны ЭМТ	3,220	3,385	3,550
	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, БОЭТ	6,687	6,974	7,320
	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	3,818	3,837	3,937
3	Эмчийн тоо	5,291	5,373	5,493
	Өрхийн ЭМТ, сум дундын эмнэлэг, сум/тосгоны ЭМТ	1,813	1,878	1,943
	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, БОЭТ	2,249	2,274	2,333
	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	1,229	1,221	1,217
4	Сувилагчийн тоо	7,683	7,838	7,866
	Өрхийн ЭМТ, сум дундын эмнэлэг, сум/тосгоны ЭМТ	2,578	2,604	2,631
	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, БОЭТ	3,226	3,322	3,318
	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	1,879	1,912	1,917

Эх сурвалж: ЭМЯ

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан Эрүүл мэндийн үзүүлэлт-2016 статистик тайланд дурдсанаар Монгол Улсын хүн амын 10000 хүнд улсын дунджаар 32.4 их эмч ногдож байгаа бол 10000 хүн амд ногдох сувилагч мэргэжилтэн 37.2 байна. Энэ нь их эмчийн тоогоор олон улсын дунджаас харьцангуй өндөр байгааг холбогдох судалгаагаар¹⁷ харуулсан байна.

Хүснэгт № 201. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд /2016 оны байдлаар/

Үзүүлэлт	хүн амын тоо	10.000 хүн амд ногдох					Эмнэлгийн нэг оронд ногдох хүний тоо	Нэг их эмчид ногдох хүний тоо	Нэг их эмчид ногдох дунд мэргэжилтэн	Жилд нэг иргэний үзүүлсэн дундаж тоо	1000 хүнд ногдох		
		Орны тоо	Хүний их эмч	Сувилагч	Бусад ажилтан	Бүх ажиллагсад					Төрөлт	Нас баралт	Цэвэр өсөлт
Аймгийн дундаж	1,679,488	66.6	24.0	33.4	29.9	137.2	150.2	416.2	1.2	4.1	22.5	5.5	17.0
Улаанбаатар	1,440,447	83.4	42.2	41.6	17.1	178.0	119.8	236.9	0.4	7.2	28.7	5.0	23.7

¹⁷ Эрүүл мэндийн хөгжлийн төв – http://www.chd.mohs.mn/2017/smta/2016_еруул_мендин_узуулелт.pdf

Улсын дундаж	3,119,935	74.3	32.4	37.2	24.0	156.0	134.5	308.9	0.7	5.5	25.3	5.2	20.1
--------------	-----------	------	------	------	------	-------	-------	-------	-----	-----	------	-----	------

Эх сурвалж: ЭМЯ

Эрүүл мэндийн салбарын 2018 оны төсвийн төсөлд тусгасан урсгал зардлыг эх үүсвэрээр нь авч үзвэл улсын төсвийн санхүүжилт нийт 390,514.5 сая төгрөг буюу 62.8 хувь, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 201,802.0 сая төгрөг буюу 32.4 хувь, үндсэн болон туслах үйлчилгээний бусад орлого 29,367.4 сая төгрөг буюу 4.8 хувь байна. Өмнөх оны түвшинтэй харьцуулбал эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 25,005.6 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 4,694.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэхээр тооцож төслийг боловсрууллаа.

Хүснэгт № 202. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 Тод	2018 Төсөл
ЭМД-ийн санхүүжилт	164,431.50	176,796.40	201,802.10
Нийгмийн эрүүл мэнд (71601)	2,107.40	2,280.00	2,437.30
Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	162,324.10	174,516.40	199,364.80

Эрүүл мэндийн даатгалын сангаас нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрүүдэд санхүүжилт олгож байна. Тус сангаас төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад олгох санхүүжилт нэмэгдэж байгаа нь өндөр өртөг бүхий мэс заслын тусламж, үйлчилгээнд шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, протезын зардлын 75 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгохоор төсөвлөн эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг 11,200.0 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу бүх шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй ЭМД-аас санхүүжих тусламж үйлчилгээний багцын санхүүжилтийг нийт 13,805.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 203. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн хураангуй зардлын тойм /Зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Нийгмийн эрүүл мэнд (71601)	Үүнээс			
	Урсгал зардал	Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	621,683.90	245,485.10	234,402.90	141,795.90
Эрүүл мэнд (71600)				
Нийгмийн эрүүл мэнд (71601)	60,918.5	14,014.30	16,873.40	30,030.80
Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	513,096.2	220,069.00	208,380.60	84,646.60
Эрүүл мэндийн бодлого, удирдлага (71603)	45,679.9	10,779.20	7,782.20	27,118.50
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн дотоод урсгал зардал (70207)	1,989.3	622.6	1,366.7	-

Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн нийт урсгал зардал 621,683.9 сая төгрөг буюу хөтөлбөр тус бүрээр авч үзвэл (I) нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн зардалд 60,918.5 сая төгрөг, (II) эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн зардалд 513,096.2 сая төгрөг, (III) эрүүл мэндийн бодлого, удирдлага хөтөлбөрийн зардалд 45,679.9 сая төгрөг болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн улсын төсвөөс санхүүжих дотоод урсгал зардалд 1,989.3 сая төгрөг зарцуулахаар төсвийн төсөлд тусгагдсан болно.

Хөтөлбөр 1: Нийгмийн эрүүл мэнд

Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд 2018 онд Эрүүл мэндийн сайдын урсгал төсвийн багцыг нийт 60,918.5 сая төгрөг байхаар тооцлоо.

Хүснэгт № 204. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт/төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Нийгмийн эрүүл мэнд (71601)	2016 Гүйц	2017 Тод	2018 оны төсөл
ХӨТӨЛБӨР: Нийгмийн эрүүл мэнд (71601)	49,586.8	54,690.5	60,918.5
Зориулалт арга хэмжээгээр	49,586.8	54,690.5	60,918.5
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	19,084.2	21,620.5	22,949.0
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	3.7	3.6	5.2
80219 Харуул, хамгаалалтын зардал	153.3	173.2	166.2
80502 Тусгай зориулалтын шилжүүлэг	26,239.4	27,450.0	29,336.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	245.6	184.1	194.2
80809 Эмчилгээний төлбөр	315.7	500.0	500.0
81602 Анхан шатны тусламж үйлчилгээ	304.6	306.9	302.3
81605 Эрүүл мэндийг дэмжих	1,686.9	2,970.0	5,000.0
81609 Эрүүл мэндийн үндэсний бусад хөтөлбөрүүд	59.7	0.0	0.0
81611 Төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,440.0	1,425.6	2,404.2
83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	53.7	56.4	60.8
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	49,586.8	54,690.5	60,918.5
31 Улсын төсвөөс санхүүжих	45,750.8	50,469.1	56,508.2
33 Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,107.4	2,280.0	2,437.3
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,728.6	1,941.3	1,972.9
Орон тоо	1,153	1,153	1,205

Өрхийн эрүүл мэндийн төв: Өрхийн эрүүл мэндийн нийт 223 төвд 2,117.9 мянган иргэн анхан шатны тусламж үйлчилгээнд хамрагдахаар тооцож, 2018 оны төсөлд 29,336.6 сая төгрөг төсөвлөлөө. Өрхийн эрүүл мэндийн төвд улсын төсвөөс олгох санхүүжилтийг тооцохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн өсөлт, эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ханшийн өөрчлөлтийн нөлөөллийн улмаас нэг иргэнд ногдох суурь тарифыг 2015 оны түвшинтэй¹⁸ харьцуулж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1 хувиар, тогтмол зардал 15 хувиар, бусад зардал 32 хувиар нэмэгдүүлж, төсвийн төслийг 1,886.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тусгалаа.

Эрүүл мэндийг дэмжих сан: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд “Эрүүл мэндийг дэмжих сан”-г 2017 онд байгуулж, Монгол Улсын “Засгийн газрын тусгай сан”-ийн хуулийн 21⁸ дүгээр зүйлийн дагуу хүн амын өвчлөл, эндэгдлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилгоор архи, согтууруулах ундааны онцгой албан татвар, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар, тамхины онцгой албан татварын тодорхой хувийг тус санд хуваарилахаар хуульчилсан.

Тус сангийн хөрөнгийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэндийн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлж ирсэн бөгөөд 2018

¹⁸ Өрхийн эрүүл мэндийн төвд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг олгох тарифыг “Журам, зардлын хэмжээ батлах тухай” Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 4-р сарын 09-ний өдрийн 136/77 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн тогтоосон.

оны төсөлд өмнөх оны батлагдсан төсвөөс 2,030.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт төсвийг 5,000.0 сая төгрөг байхаар тооцож боловсрууллаа.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв: Манай улсад цус гоожимтгой байдлаар илэрдэг удамшлын эмгэгийн нэг хэлбэр болох гемофил өвчтөнүүдийн 8 фактор буюу лимфони эмчилгээг үр дүнтэй тохирсон тунгаар хэрэглэхэд одоогийн хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай тул 2018 оны төсвийн төсөлд тус эмчилгээний эмийн төсвийг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөв. Түүнчлэн Түргэн тусламжийн төвийн салбарын барилга орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 оны 10 дугаар сард ашиглалтад орсонтой холбоотой зардал 499.5 сая төгрөг, үнэ тарифын өөрчлөлтөөс шалтгаалсан тогтмол зардлын өсөлт, эм эмнэлгийн хэрэгслийн зардал зэрэг нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаатай холбоотой бусад зардлыг 811.7 сая төгрөгөөр төсөвлөн тусгасан.

Хүснэгт № 205. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Нийгмийн эрүүл мэнд (71601)	2016 Гүйц	2017 Тод	2018 оны төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	49,586.8	54,690.5	60,918.5
00347 Уламжлалт анагаах ухааны төв	3,181.0	3,485.8	3,529.4
00361 Рашаан сувиллын төв	265.2	461.3	474.2
00364 Түргэн тусламжийн төв	6,663.4	7,044.1	7,579.7
00370 Зоонозын өвчин судлалын төв	4,922.3	5,011.9	5,159.3
00756 Цус сэлбэлт судлалын үндэсний төв	4,561.1	4,884.1	5,834.7
08589 Эмгэг судлалын үндэсний төв	1,213.5	1,169.1	1,257.1
08618 Эрүүл мэндийн яам	2,540.9	2,214.1	2,747.3
08686 Эрүүл мэндийг дэмжих сан	0.0	2,970.0	5,000.0
10160 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний ТЗШ	26,239.4	27,450.0	29,336.6

Хөтөлбөр 2: Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хөтөлбөрт 2018 онд Эрүүл мэндийн сайдын урсгал төсвийн багцад нийт 513,096.4 сая төгрөгийг зарцуулахаар тооцож, төсвийн төсөлд тусгасан нь өмнөх оны түвшинтэй харьцуулбал 45,400.4 сая төгрөг буюу 9.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт № 206. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт/төсвийн ангиллуудаар, сая төгрөг/


ХӨТӨЛБӨР: Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	2016 Гүйц	2017 Тод	2018 оны төсөл
ХӨТӨЛБӨР: Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	446,179.2	467,696.0	513,096.4
Зориулалт арга хэмжээгээр	446,179.2	467,696.0	513,096.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	325,435.3	332,548.2	350,247.0
80219 Харуул, хамгаалалтын зардал	571.6	712.7	795.2
80221 Гэрээт ажиллагсдын зардал	198.8	198.0	198.0
80307 Шүүхийн шийдвэрийн дагуу олгох төлбөр	10.2	0.0	0.0
80502 Тусгай зориулалтын шилжүүлэг	80,091.4	79,780.7	82,161.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,522.6	2,936.9	2,485.3
80829 Шүүхийн шийдвэрийн дагуу иргэдэд олгох төлбөр	23.4	0.0	0.0
81601 Өндөр өртөгтэй мэс заслын зардал	19,183.5	29,743.4	44,610.0
81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	43.9	43.5	73.5
81609 Эрүүл мэндийн үндэсний бусад хөтөлбөрүүд	1,480.8	0.0	0.0
81611 Төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ	8,300.5	13,179.1	21,897.8
81612 Вакцинжуулалт	6,779.2	7,169.3	7,952.7
81707 Агаарын бохирдлыг бууруулах	0.0	0.0	985.0
83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	1,538.1	1,384.1	1,690.2
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	446,179.2	467,696.0	513,096.4

31	Улсын төсвөөс санхүүжих	267,213.9	271,324.5	287,217.9
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	162,324.1	174,516.4	199,364.8
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	16,641.3	21,855.0	26,513.7
Орон тоо		18,009	18,009	18,806

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын өөрчлөлтөд дор дурдсан хүчин зүйлс, арга хэмжээ нөлөөлсөн байна. Үүнд:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цар хүрээний өргөжилт: Хот суурин газрын хүн амын өсөлт, нягтаршил, үнэ ханшийн өөрчлөлт, эрүүл мэндийн даатгалын хүртээмж нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ялангуяа өндөр өртөг бүхий тусламж үйлчилгээний эрэлт жил бүр өсөн нэмэгдэж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний голлох үзүүлэлт болох хэвтүүлэн эмчлүүлэгчийн тоо, оношилгоо, эмчилгээний тооны 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэгчийн тоо 8.3 хувиар, оношилгоо шинжилгээний тоо 16.3 хувиар нэмэгдсэн байна.


График № 34. Хэвтүүлэн эмчлэх болон оношилгоо, шинжилгээний тоо хэмжээ, зардал



Эх сурвалж: ЭМЯ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8-дахь хэсэгт зааснаар даатгуулагчдад үзүүлэх өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлж байна. Хуульд заасны дагуу Эрүүл мэнд спортын сайд Сангийн сайд, Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын “Журам жагсаалт батлах тухай” 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 248/161/A88 тоот хамтарсан тушаалаар энэхүү үйл ажиллагааг зохион байгуулах жагсаал, журмыг батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хамтарсан тушаалаар анх 107 нэр төрлийн хэрэгслийг даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг байсныг 2016 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн "Жагсаалт, журам батлах тухай" 07 дугаартай тогтоолоор 2016 оны батлагдсан төсвийн хүрээнд 484 нэр төрөл болгон нэмэгдүүлсэн.

График № 35 . Өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээний тоо хэмжээ, зардал



Эх сурвалж: ЭМЯ

Өндөр өртөгтэй мэс заслын эмчилгээний хүрээг өргөжүүлж, иргэдийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, иргэдэд учирч байгаа төлбөрийн дарамтыг бууруулах, гадагш чиглэж байгаа эрүүл мэндийн төлбөрийн урсгалыг бууруулах зорилгоор зарим тусламж үйлчилгээний эмнэлгийн хэрэгслийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зардлыг 14,866.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцлоо.

Түүнчлэн төрөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний нэр төрөл, цар хүрээний өргөжилт, хүн амын өсөлт, манай оронд оношилж эмчлэхэд хүндрэлтэй байгаа зарим өвчнийг оношлох, эмчлэх дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн зэргээс шалтгаалж, эмнэлгийн тусламж үйлчилгээний тоо нэмэгдсэн байна.

Хүснэгт № 207. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрагдалт /давхардсан тоогоор, мянган хүн/

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2015 Гүйц	2016 Гүйц	2017 ХБГ	2018 төсөл
1.Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	294.9	309.5	335.9	349.6
2.Өдрийн эмчилгээ	21.0	21.4	26.3	30.3
3.Амбулаторийн тусламж, үйлчилгээ	1,924.6	2,165.6	2,166.3	2,297.9
4.Оношилгоо, шинжилгээ	943.6	1,051.5	1,016.8	1,127.4
6.Уламжлалт эмчилгээ	6.4	7.1	8.0	8.4
7.Сэргээн засах тусламж, үйлчилгээ	1.8	2.3	4.7	2.3
8.Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	0.2	2.3	2.7	2.8
9.Хорт хавдрын тусламж, үйлчилгээ	-	2.9	3.6	3.8

Эх сурвалж: ЭМЯ

Сумын эрүүл мэндийн төв: Сумын эрүүл мэндийн төвийн төсвийг иргэдэд үзүүлж буй анхан шатны тусламж үйлчилгээний чадавх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2016 оны 498/345 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Сум тосгоны Эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн аргачлалын дагуу тооцож, төсвийн төслийг боловсруулсан.

Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны төсөв 2,546.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сум, тосгоны 42 эрүүл мэндийн төв шинээр нэгдсэн халаалтад холбогдсон, 5 суманд шинэ барилга ашиглалтад орсон, түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын өсөлт зэргээс шалтгаалсан байна.

Вакцинжуулалт: “Монгол Улсын дархлаажуулалтын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор хүн амын өсөлт, нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт зардлыг 8,937.7 сая төгрөгөөр төлөвлөн эм, вакциныг хангахаар төсвийн төсөлд тусгалаа.

Хүснэгт № 208. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, хувиар 2016 он

Үзүүлэлт	1 хүртэлх насны хүүхэд		5 хүртэлх насны хүүхэд	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	54.3	63.9	57.5	68.8
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	9.9	9.7	8.9	12.6
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	7.9	3.7	4	2.3
Гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэг	1.9	0.7	7	1.9
Халдварт ба шимэгчит зарим өвчин	12.6	7.9	7.6	3.3
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	4.9	3.7	9.6	4.8

Эх сурвалж: ЭМЯ

Эрүүл мэндийн хөгжлийн газрын гаргасан эрүүл мэндийн статистик судалгаанаас үзэхэд “нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн өвчлөлд амьсгалын тогтолцооны өвчин хот хөдөөд адил тэргүүлэх шалтгаан болж байна. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдох амьсгалын замын тогтолцооны өвчлөлийн улмаас уушгины хатгалгаа 27.5 хувь, амьсгалын дээд замын халдвар 18.2 хувь, томуу, томуу төст өвчлөл 11.6 хувийг эзэлж байна” гэсэн үзүүлэлттэй байна.

Иймд агаарын бохирдол хамгийн ихтэй Улаанбаатар хотын 5 дүүргийн хүүхдүүдэд 2018 оноос уушгины хатгалгаа өвчний эсрэг пенимикокын вакциныг дархлаажуулалтын товллолд шинээр нэвтрүүлэхэд 985.0 сая төгрөг, бусад вакцинтай холбоотой валютын ханшийн өөрчлөлтөд 858.0 сая төгрөгийг тус тус төсөвлөв.

Хүснэгт № 209. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Нийгмийн эрүүл мэнд (71601)	2016 Гүйц	2017 Тод	2018 оны төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	446,179.2	467,696.0	513,096.4
00317 Улсын нэгдүгээр төв эмнэлэг	25,394.9	26,502.2	33,425.7
00319 Улсын хоёрдугаар төв эмнэлэг	9,150.5	10,491.1	10,936.3
00321 Улсын гуравдугаар төв эмнэлэг	24,106.2	25,017.7	31,958.8
00327 Аймгийн нэгдсэн эмнэлэг	116,698.9	118,106.0	125,830.6
00754 Хавдар судлалын үндэсний төв	14,087.1	17,672.2	20,055.4
00769 Гэмтэл, согог судлалын үндэсний төв	18,156.1	23,359.1	28,618.6
05105 Арьсны өвчин судлалын үндэсний төв	2,760.7	2,871.0	3,029.2
08586 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	9,496.6	9,655.7	9,881.9
08587 Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	26,023.4	26,710.0	27,994.7
08590 Хүүхдийн төв сувилал	1,683.4	1,792.0	1,889.4
08618 Эрүүл мэндийн яам	6,823.1	9,838.7	12,085.7
08650 Халдварт өвчин судлалын үндэсний төв	17,313.9	17,482.6	19,346.1
09584 Геронтологийн төв	525.7	590.4	585.9
10018 Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв	7,227.6	7,978.4	8,925.8
10019 Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв	2,977.8	3,099.3	3,489.4
10020 Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв	3,126.8	3,585.0	3,670.7
10021 Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	5,825.1	6,062.6	6,129.1
10022 Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв	3,405.9	3,778.2	3,927.5
10023 Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв	5,872.4	5,878.8	6,846.2
10024 Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв	4,788.0	4,879.4	4,942.5
10025 Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв	4,906.5	4,862.9	5,695.9
10026 Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг	4,170.2	4,376.9	4,579.3
10027 Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг	2,379.4	2,640.6	2,650.5
10028 Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг	2,431.7	2,707.8	3,154.4
10029 Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв	370.0	385.1	405.2
10034 Өргөө амаржих газар (1)	7,645.3	7,563.3	8,566.0
10035 Хүрээ амаржих газар (2)	3,341.4	3,087.7	3,144.5

10036	Амгалан амаржих газар (3)	3,944.1	4,452.1	5,189.5
10037	Наркологийн эмнэлэг	665.8	724.4	709.8
10038	Шүд Эрүү Нүүрний төв	1,607.1	1,657.8	1,861.2
10039	Энэрэл эмнэлэг	1,450.3	1,492.1	1,547.7
10040	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв	2,124.3	2,226.0	2,180.9
10160	Аанхан шатны тусламж үйлчилгээний ТЗШ	80,091.4	79,780.7	82,161.5
-----	Хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүд	9,780.9	10,224.9	10,843.9
-----	Сум дундын эмнэлгүүд	15,826.7	16,163.4	16,836.6

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2018 онд шинээр буюу өргөтгөлөөр баригдаж байгаа төрөлжсөн болон аймаг, хотын нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдэд барилга ашиглалтад орохтой холбоотойгоор орон тоо, холбогдох урсгал зардлыг нэмэгдүүлэхээр тусгасан. Үүнтэй уялдаж эмнэлгийн тусламжийн үйлчилгээний хүрээнд гол өөрчлөлт орж байгаа зардал, арга хэмжээг авч үзвэл:

- Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.7-д "удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал"-ыг төр хариуцна гэсний дагуу Монгол улсад одоогийн байдлаар эрхтэн шилжүүлэн суулгасан 201 хүн элэг хамгаалах эм, 215 хүн бөөр хамгаалах эм ууж нийт 416 хүн энэ арга хэмжээнд хамрагдаж байна. 2013-2017 онд гадаад улс оронд эрхтэн шилжүүлэн суулгасан 77 хүн, 2018 онд Монголд эрхтэн шилжүүлэн суулгах 62 хүн нийт 139 хүн нэмж хамрагдахаар тооцон 1,051.0 сая төгрөгийг төсвийн төсөлд тусгалаа.
- Улсын хэмжээнд 123 гемодиализын аппарат ажиллаж байгаа бөгөөд үүний 52 нь орон нутагт, 71 нь Улаанбаатар хотод ажиллаж байна. 2017-2018 онд 12 аппарат 6 аймагт шинээр суурилагдан 20 аймагт бөөрний архаг дутагдал өвчлөлтэй хүмүүс орон нутагтаа тусламж үйлчилгээг авах боломжтой болсон байна. Бөөрний архаг дутагдал өвчлөлтэй гемодиализын аппаратад орж буй 714 хүн 2018 онд хамрагдахаар тооцон холбогдох зардлыг 800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэв.
- Олон эмийн дасалтай сүрьеэгийн эмийн санхүүжилтийг шат дараалалтай улсын төсөвт шилжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар болон Олон Улсын Глобал сангийн хооронд байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу 1,200.0 сая төгрөг төсөлд тусгалаа.
- Уламжлалт болон орчин үеийн хими эмчилгээ, хавдрын үе шат, хүндрэлээс шалтгаалан хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний зардлыг холбогдох хуулийн дагуу төсвөөс санхүүжүүлэхэд шаардагдах эмийн зардлыг нийт 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Эрүүл мэндийн яамнаас гаргасан судалгаа тайлангаас харахад Монгол Улсын нялхсын эндэгдлийн 66.4 хувийг нярайн эндэгдэл, нярайн эндэгдлийн 76.3 хувийг нярайн эрт үеийн эндэгдэл эзэлдэг байна. Төрсний дараах 28 хоногт нас барсан хүүхдийн 66.9 хувийг дутуу нярай эзэлж байгаа тул дутуу төрөлтийг бууруулах, дутуу нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор нярайн эрт үеийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болсон амьсгалын дистресс хам шинжийн эмчилгээний /Сурфактант/ зааврыг шинээр баталж, аймгийн нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн амаржих газруудад тусламж үйлчилгээг үзүүлэхэд

шаардагдах зардлыг 2016 оны нярайн эрт үеийн эндэгдлийн статистик тоонд үндэслэн тооцож, энэ зориулалтаар 744.0 сая төгрөгийг төсөв тусгасан.

- Улсын нэгдүгээр төв эмнэлэгт “Бөөр шилжүүлэн суулгах баг” 1996 оноос хойш нийт 136 бөөр шилжүүлэн суулгах мэс засал, 2011 оноос өнөөг хүртэл нийт 32 том хүн, 3 хүүхдэд амьд донороос, 1 хүнд цогцсын донороос элэг дахин шилжүүлэх мэс заслыг, үүнээс 9 хүнд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг хийсэн байна. Улсын нэгдүгээр төв эмнэлэг болон Хавдар судлалын үндэсний төвд 2018 онд 63 хүнд эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаанд шаардагдах 2,829.6 сая төгрөгийг төсвийн төсөлд нэмж тусгав.
- Улсын нэгдүгээр төв эмнэлэгт манай улсад шинээр нэвтэрсэн эрхтэн шилжүүлэн суулгах төвийн 40 орон тоо болон урсгал зардалд 484.9 сая төгрөг, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуун сухайт боомтын салбар, Ноён сум дундын эмнэлгийн Шивээ хүрэн боомтын салбарт 6 орон тоо болон урсгал зардалд 83.8 сая төгрөг, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Хан-уул дүүргийн Нэгдсэн эмнэлгүүдэд 25 ортой мэс заслын тасгуудыг тус тус шинээр байгуулсантай холбоотой 28 орон тоо болон урсгал зардалд 416.2 сая төгрөг, Архангай, Завхан, Хөвсгөл, Дундговь, Увс, Төв аймгуудад гемодиализын аппараттай болж тусламж үйлчилгээ өргөжсөнөөс 24 орон тоо болон урсгал зардалд 282.5 сая төгрөг нийт 1,267.4 сая төгрөг тусгалаа.
- Орон нутгийн болон нийслэлийн эрүүл мэндийн 123 байгууллагын хүн амын дунд өвчлөл нэмэгдэж, тусламж үйлчилгээний цар хүрээ өссөн, үнэ ханшийн өөрчлөлттэй холбоотой 5,750.0 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэхээр нэмэгдүүлж тусгасан.
- Монгол Улсын хүн ам сүүлийн 50 жилд 3.6 дахин буюу 2.2 сая хүнээр нэмэгдсэн байна. Хүн амын 46 хувь нь буюу 1.4 сая хүн Улаанбаатар хотод амьдарч байна. Монгол улсын хэмжээнд жилд дунджаар 80,000-81,000 мянган эх төрж байгаагаас 51-52% нь нийслэлд төрж байна. Монгол улсад төрөлт нэмэгдсэн, түүний дотор дутуу төрөлт, бага жинтэй нярай хүүхэд, эрхтэн тогтолцооны төрөлхийн гаж хөгжилтэй болон хүнд эмгэгтэй хүүхдийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор эх хүүхдийн тусламж үйлчилгээний зардлыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Амгалан, Өргөө, Хүрээ амаржих газруудад төсвийг 2,040.2 сая төгрөгөөр нэмж тусгасан.
- Эрүүл мэндийн салбарт сүүлийн жилүүдэд орчин үеийн техник технологийг тусламж үйлчилгээнд нэвтрүүлснээр өндөр үнэтэй, нарийн бүтэцтэй эмнэлгийн тоног төхөөрөмжүүд (томограф, ангиограф, MRI) ашиглагдаж байна. Өндөр үнэтэй, нарийн бүтэцтэй эмнэлгийн аппарат тоног төхөөрөмжийн хугацаат засвар, бусад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, шинээр нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмж зэрэгтэй уялдуулан салбарын тоног төхөөрөмжийн урсгал засварын зардлыг 2,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөлөө.

- Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу эмч, эмнэлгийн ажилчдын цалинг үе шаттай нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан ангиллын дагуу халдварын өндөр эрсдэлтэй ажлын байрны бүлэгт сүрьеэгийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулж, Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 275 дугаартай тогтоолын дагуу сүрьеэгийн эмч, мэргэжилтнүүдийн онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах 1,076.5 сая төгрөгийг тооцон төсвийн төслийг боловсруулсан.

Улс, орон нутгийн хөрөнгө, тусламжаар баригдаж буй шинэ барилга, барилгын өргөтгөл: Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2017-2018 онд шинээр буюу өргөтгөлөөр баригдаж байгаа дараах төрөлжсөн болон аймаг, хотын нэгдсэн эмнэлгийн барилга ашиглалтад орохтой холбоотойгоор урсгал зардлыг нийт 6,386.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тусгав. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийн барилга, Өмнөговь аймгийн Говийн БОЭТ-ийн барилга, Орхон аймагт БОЭТ-ийн хүүхдийн эмнэлгийн барилга, Ховд аймгийн Булган сумын сум дундын эмнэлгийн барилга;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар БГД-ийн ЭМТ-ийн хүүхдийн болон ахмадын эмнэлгийн барилга, БЗД-ийн ЭМТ-ийн өргөтгөл, Налайх дүүргийн ЭМТ-ийн хүүхдийн эмнэлгийн барилга, ЧД-ийн ЭМТ-ийн салбар амбулаторийн барилга;
- Кувейтын сангийн хөрөнгө оруулалтаар ГССҮТ-ийн харьяа Түлэнхийн төвийн барилга;

Хүснэгт № 210: Шинээр ашиглалтад орох эмнэлгийн барилга, барилгын өргөтгөл / мянган төгрөг/

Байршил	Ашиглалтад орсон хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл					Нийт урсгал зардал
	Байгууллагын нэр	ХО-ын эх үүсвэр	Хүчин чадал	Объектын эзлэхүүн	Ашиглалтад орох хугацаа	
Нийт урсгал зардлын дүн						6,386,104.5
Улаанбаатар	Түлэнхийн төвийн барилга	Тусламж	250 ортой	64256	2018.07.01	1,538,943.5
Улаанбаатар	Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийн барилга	УТ	50 ортой	80000	2017.09.15	626,314.6
Өмнөговь	Өмнөговь Говийн БОЭТ барилга	УТ	50 ортой	20000	2018.01.01	611,988.5
Ховд	Ховд эмнэлгийн барилга	УТ	50 ортой	4634	2018.07.01	202,978.0
Орхон	Орхон Хүүхдийн эмнэлгийн барилга	УТ	50 ортой	7920	2017.09.01	436,000.0
Улаанбаатар	БГД-ийн Эрүүл мэндийн төвийн хүүхэд, ахмадын эмнэлгийн барилга	ОН	50 ортой	27144	2017.05.15	857,145.5
Улаанбаатар	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөл	ОН	50 ортой	2080	2017.10.01	299,859.6
Улаанбаатар	Налайх дүүргийн Хүүхдийн 50 ортой эмнэлгийн барилга	ОН	50 ортой	6912	2017.10.01	652,283.7
Улаанбаатар	ЧД-ийн ЭМТ-ийн салбар амбулаторийн барилга	ОН	50 ортой	5184	2017.10.01	661,144.0
Улаанбаатар	Түргэн тусламжийн төвийн салбар	ОН	50 ортой	3600	2017.10.01	499,447.0

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийн санхүүжилтээр шинэ эмнэлэг болон эмнэлгийн өргөтгөл ашиглалтад орсноор эрүүл мэндийн ажиллагсдын орон тоо 484-өөр,

эмнэлгийн орны тоо 700-аар нэмэгдэж, иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх юм.

Ерөнхий гэрээгээр төвлөрүүлэн худалдан авах эмийн талаар:Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сангийн хооронд 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулж, зардал хэмнэхээр тусгагдсан.

Түүнчлэн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолд эм, эмнэлгийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоог бий болгох замаар төсвийн хэмнэлт гаргахаар заасны дагуу эмийн төвлөрсөн худалдан авалтыг зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн яамнаас гаргасан судалгаагаар эрүүл мэндийн 9 байгууллагын нийтлэг хэрэгцээтэй байгаа зарим нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг нэгтгэн зохион байгуулан худалдан авалтын тендер шалгаруулалтыг 2015 оны 11 дүгээр сард зарлаж, зохион байгуулсан худалдан авалтаар авсан эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн дүнгийн 53 орчим хувь нь эм, 23.5 хувь нь эмнэлгийн хэрэгсэл 23.5 хувь нь оношлуур эзэлж байна.

Эмийн худалдан авалтыг сайжруулах, төсөв хэмнэх зорилгоор хэрэгцээг нэгтгэн худалдан авалтын тендер зохион байгуулсан энэхүү үйл ажиллагаанд “Улсын эмнэлгүүдийн боломжит үнийн эмийн хүртээмжийг сайжруулах” төслийн зөвлөх баг дүн шинжилгээ хийж, худалдан авалтыг зохион байгуулснаар эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах үйл ажиллагааны шинэчлэлд нэвтрүүлэх чухал туршлага болсон, хамгийн зохистой дараагийн арга зам болох ерөнхий гэрээний журмын дагуу зохион байгуулахад чиглэсэн чухал алхам болсон гэж дүгнэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/202 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын хэсэг”-ийн хуралдаанууд, 2015 болон 2016 оны эмийн худалдан авалтын тайлан, “Улсын эмнэлгүүдийн боломжит үнийн эмийн хүртээмжийг сайжруулах” төслийн гадаад, дотоодын зөвлөхийн санал болгосны дагуу 2018 онд хэрэгжүүлэх нэгдсэн худалдан авалт хийх эмийг сонгохдоо мэдээллийг нэгтгэн судалж, шалгуур үзүүлэлт боловсруулсан. Үүнд:

1. Ерөнхий нэршлийн эм байх;
2. Жилийн нийлүүлэлт өндөр байх /50 сая төгрөгөөс дээш/;
3. Зайлшгүй шаардлагатай эм байх;
4. Нийтлэг хэрэглэдэг байх /18-аас дээш эмнэлэгт хэрэглэдэг/;
5. Нийлүүлэгч олон байх /3-аас дээш/;
6. Олон улсын жишиг үнэтэй харьцуулахад ашиг гаргах боломжтой байх;
7. Тасалдлын эрсдэлийг тооцох /өөр эмээр орлуулах боломжтой/;

Дээрх 7 шалгуур үзүүлэлтийн дагуу сонгосон эм нь 23 нэрийн 4.7 тэрбум төгрөг болсон бөгөөд эдгээр эмийн хэлбэр, эм судлалын ангиллын дагуу авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 211 . Нэгдсэн худалдан авалтаар хэрэгжүүлэх эмийн хэлбэр, зориулалт

Ангилал	Тоо	Хувь
Эмийн хэлбэр	23	100%
Шахмал	10	43%
Тарилга	7	30%
Тарилгын шингэн	4	17%
Лаа	1	4%
Ингиляц буюу амьсгалаар хэрэглэх	1	4%
Зориулалт	23	100%
Цусны даралт бууруулах	5	22%
Давс, ус, хүчил шүлтийн тэнцвэрт нөлөөлөх эм	4	17%
Инсулин ба чихрийн шижин эмчлэх эм	3	13%
Өвдөлт намдаах, үрэвслийн эсрэг эм	3	13%
Халдварын эсрэг эм /антибиотик/	2	9%
Шээлгэх эм	1	4%
Бөөлжихийн эсрэг эм	1	4%
Хэсгийн мэдээгүйжүүлэх эм	1	4%
Ерөнхий мэдээгүйжүүлэх бэлдмэл	1	4%
Булчин сулруулах буюу холиностеразын эсрэг эм	1	4%
Ходоодны хүчлийг багасгах эм	1	4%

Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд эмийн худалдан авалтыг нэгтгэн зохион байгуулахад эмийн төсвийн 10 хувь буюу 9,1 тэрбум төгрөгт эмийн худалдан авалтыг нэгтгэн зохион байгуулахаар тооцоолж, ирэх жилд 8.3 тэрбум төгрөгийн өртөг бүхий 53 нэр төрлийн эмийг сонгож, хэрэгцээг нэгтгэн нэгдсэн худалдан зохион байгуулахаар төлөвлөж байна.

Эдгээр сонгосон нэр төрлийн эмийн худалдан авалтаар анх тооцоолж байсан хувилбараар 15 хувь буурах зорилт тавьж байгаа боловч импортоор авч буй эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд гадаад валютын ханшийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлээс хамаарч жил тутамд нэмэгдүүлэх хэрэгцээ үүсэж байна. Иймд 2018 оны төсөлд эдгээр эмийн зардлыг нэмэгдүүлэхгүйгээр 2016 оны суурь түвшинд байхаар тооцов.

Хөтөлбөр 3: Эрүүл мэндийн бодлого, удирдлага

Эрүүл мэндийн сайдын урсгал төсвийн төслийн 2018 оны багцад эрүүл мэндийн бодлого, удирдлага хөтөлбөрийн үйл ажиллагаанд 45,679.9 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн нь 2017 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 666.5 сая төгрөгөөр буурсан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2014 оны 405, 2015 оны 338 дугаар тогтоолыг үндэслэн 2017-2018 онд тэтгэвэр тогтоолгож, мөнгөн тэтгэмж авах эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 15,204.2 сая төгрөгийг 924 ажилтанд, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн албан хаагчид олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 14,552.2 сая төгрөгийг 4165 хүнд олгохоор төсөвлөж, өмнөх оноос 2,163.6 сая төгрөгөөр бууруулсан нь урсгал зардлын бууралтад нөлөөлсөн байна.

Хүснэгт № 212. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт/төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Эрүүл мэндийн бодлого, удирдлага (71603)	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
ХӨТӨЛБӨР: Эрүүл мэндийн бодлого, удирдлага (71603)	38,118.2	46,346.4	45,679.9
Зориулалт арга хэмжээгээр	38,118.2	46,346.4	45,679.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	15,173.1	16,442.8	17,041.2
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	22.6	83.2	83.2
80219 Харуул, хамгаалалтын зардал	79.1	91.7	99.1
80221 Гэрээт ажиллагсдын зардал	166.0	180.9	180.9
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	180.4	185.6	262.4
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2.9	15.8	15.8
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	28.0	41.6	41.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	22,055.6	28,799.0	27,076.9
80829 Шүүхийн шийдвэрийн дагуу иргэдэд олгох төлбөр	41.3	17.7	0.0
81560 Монголын улаан загалмай нийгэмлэгээр гэрээгээр гүйцэтгүүлэх	0.0	0.0	121.0
81605 Эрүүл мэндийг дэмжих			200.0
81611 Төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ	70.6	69.9	70.6
83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	298.7	418.3	487.2
31 Улсын төсвөөс санхүүжих	37,046.4	45,470.2	44,799.2
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,071.8	876.2	880.7
Орон тоо	972	972	972

Резидент эмч бэлдэх сургалт: Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.1 дэх заалтын дагуу төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургаалтанд 2016-2017 оны хичээлийн жил 675 суралцагч суралцаж байгаа бөгөөд 2018 онд 756 резидент сургахаар тооцож, сургалтын зардлыг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгалаа.

Хүснэгт № 213. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Эмнэлгийн тусламж үйлчилгээ (71602)	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	38,118.2	46,346.4	45,679.9
00333 Эрүүл мэндийн газар	27,359.1	34,367.3	32,644.9
00387 Нийслэлийн эрүүл мэндийн газар	5,489.9	5,800.2	6,035.8
08618 Эрүүл мэндийн яам	2,031.3	2,146.7	2,602.5
10114 Эрүүл мэндийн хөгжлийн төв	3,237.9	4,032.2	4,396.6

Хөтөлбөр 4: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр

Эрүүл мэндийн сайдын багцад хамаарах гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөрт Цахим эрүүл мэнд төслийн нэгж, Эрүүл мэндийн салбарын хөтөлбөр-4, Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5, Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төслүүдэд 2018 оны төсөлд нийт 1,989.3 сая төгрөг төсөвлөлөө.

Хүснэгт № 214. Хөтөлбөрийн зардлын хуваарилалт/төсвийн ангиллуудаар, сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Эрүүл мэндийн бодлого, удирдлага (71603)	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
Зардлын эдийн засгийн зүйлсээр	599.7	1,051.7	1,989.3
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	352.4	512.3	494.2
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38.0	106.4	128.4
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	2.5	3.3
2104 Хангамж, бараа материалын зардал	11.1	17.2	31.0
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	0.0	25.0
2107 Томилолт, зочны зардал	28.9	34.5	49.1
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169.4	283.7	1,050.7

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн улсын төсвөөс санхүүжих дотоод урсгал зардлыг Засгийн газар хоорондын гэрээний дагуу хянаж, 1,989.3 сая төгрөг зарцуулахаар төсвийн төсөлд тусгасан нь өмнөх онтой харьцуулахад 937.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 215. Хөтөлбөрт хамрагдах төсвийн захирагчид /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	599.7	1,051.7	1,989.3
10004 Цахим эрүүл мэнд төслийн нэгж /Дэлхийн банк/	0.0	0.0	32.7
10065 Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4	0.0	137.3	52.0
10126 Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл /БНСУ/	599.7	896.3	1,887.5
10128 Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 5 төсөл /АХБ/	0.0	18.1	17.1

Зардлын өсөлтөд МУ-ын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хоорондын гэрээний дагуу Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, баригдаж буй оношилгоо, эмчилгээний төвийн барилгыг энэ оны 10 дугаар сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байгаатай уялдаж, 896.3 сая төгрөгийн урсгал зардлыг 2018 оны төсвийн төсөлд нэмж тусгасан нь голлох нөлөөлөл үзүүлсэн байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын 2018 оны төсвийн нийт зардал 378,203.8 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 9,152.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 89,957.4 сая төгрөг, гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зардалд 279,093.9 сая төгрөгийг төсвийн төсөлд тусгалаа.

Хүснэгт № 216. Хөтөлбөрүүдийн хураангуй дунд хугацаагаар /сая төгрөг/

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Хөтөлбөр	981,488.2	466,133.5	378,203.8
Авто зам (71101)	1,630.5	1,900.8	2,150.0
Төмөр зам (71103)	519.3	516.1	705.1
Агаарын тээвэр (71104)	8,407.2	3,132.5	3,119.0
Зам тээврийн бодлого удирдлага (71107)	470,324.0	137,274.8	93,135.8
<i>Үүнээс: Урсгал зардал</i>	<i>3,545.3</i>	<i>3,292.3</i>	<i>3,178.4</i>
<i>Хөрөнгө оруулалт</i>	<i>466,778.7</i>	<i>133,982.5</i>	<i>89,957.4</i>
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	500,607.2	323,309.4	279,093.9
<i>Үүнээс: Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</i>	<i>500,537.1</i>	<i>322,615.2</i>	<i>279,093.9</i>
<i>Улсын төсвөөс санхүүжих зардал</i>	<i>70.1</i>	<i>694.2</i>	<i>0.0</i>

2018 оны төсвийн төсөлд урсгал зардал 383.3 сая төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгийн зардал 44,025.1 сая төгрөг, гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн зардал 43,521.3 сая төгрөгөөр тус тус буурч 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад нийт 87,929.7 сая төгрөгөөр буюу 18.9 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан.

Хүснэгт № 217: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн хураангуй зардлын тойм / Урсгал зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар сая төгрөг/

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	Нийт Дүн	Урсгал зардал	Үүнээс			Гадаад зээл тусламжаас санхүүжих зардал	Хөрөнгийн зардал
			Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг		
НИЙТ:	378,203.8	9,152.4	5,219.4	3,628.7	304.4	279,093.9	89,957.4
1. Авто зам	2,150.0	2,150.0	0.0	2,150.0	0.0	-	-
2.Төмөр зам	705.1	705.1	367.9	334.6	2.7	-	-
3.Агаарын тээвэр	3,119.0	3,119.0	2,582.0	360.6	176.3	-	-
4.Зам тээврийн бодлого	3,178.4	3,178.4	2,269.5	783.5	125.4	-	-
5.Гадаад зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр	279,093.9	-	-	-	-	279,093.9	-
6.Хөрөнгийн зардал	89,957.4	-	-	-	-	-	89,957.4

2018 оны төсвийн төслийн урсгал зардлыг 9,152.4 сая төгрөгөөр төсөвлөснөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 5,219.4 сая төгрөг буюу 57.0 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 3,628.7 сая төгрөг буюу 39.6 хувь, татаас шилжүүлгийн зардал 304.4 сая төгрөг буюу 3.3 хувийг эзэлж байна.

2016 оны 5 дугаар сарын 18-ны өдөр БНХАУ-н хөнгөлөлттэй зээлийн гүйцэтгэгч компани болох “Туанжоу Ванан Констракшн Сүпервишн ХХК”-тай хийсэн зөвлөх үйлчилгээний гэрээнд (гэрээний дугаар №127128129) “Аймгуудын хөдөө аж ахуй бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, ядуурлыг бууруулах” төсөл хэрэгжүүлэх нэгжийн урсгал зардалд 1.1 сая ам долларыг гүйцэтгэгч компаниас гаргахаар заасан. 2018 оны төсвийн төсөлд гэрээг үндэслэн 2017 оны төсөвт тусгасан нэг удаагийн шинж чанартай арга хэмжээний зардал 694.2 сая төгрөгийг бууруулж тооцсон.

Хөтөлбөр 1. Авто зам

Авто зам хөтөлбөрийн 2018 оны урсгал зардлыг нийт 2,150.0 сая төгрөгөөр, 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 249.2 сая төгрөг буюу 13.1 хувиар нэмэгдүүлж төсөвлөв. Тус хөтөлбөрийн хүрээнд олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчсоны төлбөр хураах 19 цэгүүдийн үйл ажиллагааны урсгал зардлыг 2,150.0 сая төгрөгөөр төсөвлөж тусгалаа.

Хүснэгт № 218. Авто зам хөтөлбөр /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр	1,630.5	1,900.8	2,150.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,326.0	1,900.8	2,150.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	304.5	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,630.5	1,900.8	2,150.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,630.5	1,900.8	2,150.0
Орон тоо	0	111	0

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
09601 Улсын авто замын сан	1,630.5	1,900.8	2,150.0

Зам тээврийн сайдын баталсан "Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах цэгийн зохион байгуулалт, орлогыг төвлөрүүлэх, зарцуулах үйл ажиллагааны

журам"-аар төлбөр хураах цэгүүдийн үйл ажиллагааны урсгал зардлыг нийт төвлөрүүлж буй орлогын 40 хувиар санхүүжүүлэхээр заасан байдаг.

Үүний дагуу 2018 онд төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг 5,400.0 сая төгрөгөөр төсөвлөж төлбөр хураах цэгүүдийн үйл ажиллагааны урсгал зардлыг 2150.0 сая төгрөгөөр төсөвлөв.

Хөтөлбөр 2. Төмөр зам

Төмөр зам хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 705.1 сая төгрөгөөр, 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 189.0 сая төгрөгөөр буюу 36.6 хувиар нэмэгдүүлж тооцлоо.

Хүснэгт № 219. Төмөр зам хөтөлбөр /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр	519.3	516.1	705.1
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	505.5	511.3	699.0
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	0.9	0.0	2.5
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	1.0	1.0	1.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	11.9	3.8	2.7
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	519.3	516.1	705.1
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	516.3	516.1	705.1
Орон тоо	25	25	25

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
00583 Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	519.3	516.1	705.1

Монгол Улсын 2030 он хүртэл баримтлах тогтвортой хөгжлийн бодлого, ЗГ-ын 2016-2020 он хүртэл баримтлах үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3-д заасны дагуу шинээр бий болох 34 өртөө зөрлөгт шаардагдах 5000 гаруй боловсон хүчнийг бэлтгэх болон одоогийн төмөр замын байгууллагуудад ажиллаж байгаа 15000 гаруй албан хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, салбарын судалгаа шинжилгээний ажлыг эрхлэх чиг үүрэгтэйгээр “Хос зам” сургалтын төвийг байгуулахтай холбогдуулан үйл ажиллагааны урсгал зардал 187.0 сая төгрөгийг 2018 оны төсвийн төсөлд нэмж тусгалаа.

Хөтөлбөр 3. Агаарын тээвэр

Агаарын тээвэр хөтөлбөрийн урсгал зардлыг 2018 оны төсвийн төсөлд 3,119.0 сая төгрөгөөр тусгасан. 2018 оны төсвийн төсөл 2017 оны төсөвт тусгасан нэг удаагийн шинж чанартай арга хэмжээний зардал 50.0 сая төгрөг, тэтгэвэрт гарах хүний тоо буурч байгаатай холбоотойгоор тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 2.6 сая төгрөгөөр буурч, гадаад болон олон улсын гишүүнчлэлийн хураамж ханшийн зөрүүний улмаас 15.4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 23.0 сая төгрөгөөр тус тус өссөн нь 2017 оны төсвийн тодотголтой харьцуулахад 13.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн.

Хүснэгт № 220. Агаарын тээвэр хөтөлбөр /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр	3,063.4	3,132.5	3,119.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,864.2	2,936.9	2910.5
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	30.0	29.7	29.7
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2.5	2.5	2.5
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	138.2	155.9	171.3
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	23.4	7.6	5.0
80809 Эмчилгээний төлбөр	5.0	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	3,065.6	3,132.5	3,117.4
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3,065.6	3,132.5	3,117.4
Орон тоо - Албан тушаалаар	106	106	106

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
09578 Иргэний нисэхийн ерөнхий газар (агентлаг)	3,065.6	3,132.5	3,119.0

Хөтөлбөр 4. Зам тээврийн бодлого, удирдлага

Зам тээврийн бодлого, удирдлага хөтөлбөрийн 2018 оны урсгал зардлыг 3,178.4 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгасан. 2017 оны төсвийн тодотголоос 113.9 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан. Энэ нь 2018 оны төсвийн төсөлд тэтгэвэрт гарах хүний тоо буурч байгаатай холбоотойгоор тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 92.6 сая төгрөг, 2017 онд 4 албан хаагч тэтгэвэрт гарснаар цалингийн санд үүссэн хэмнэлт 28.9 сая төгрөгөөр тус тус бууруулж, нийгмийн даатгалын шимтгэлийг 7.5 сая төгрөгөөр нэмж тооцсонтой холбоотой.

Хүснэгт № 221. Зам тээврийн бодлого, удирдлага хөтөлбөр /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
Зориулалт арга хэмжээгээр	3,545.3	3,292.3	3,178.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,813.7	2,787.4	2,766.1
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	1.5	1.2	1.2
80220 Холбооны суваг ашигласны хөлс	44.8	0.0	0.0
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	274.8	283.2	283.2
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2.5	2.5	2.5
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	0.0	11.3	11.3
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	85.5	206.7	114.1
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	322.5	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	3,545.3	3,292.3	3,178.4
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3,545.3	3,292.3	3,178.4
Орон тоо - Албан тушаалаар	145	145	145

Хүснэгт. Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид

Төсвийн захирагчид	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөв
09578 Иргэний нисэхийн ерөнхий газар (агентлаг)	3,545.3	3,292.3	3,178.4

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД

Барилга, хот байгуулалтын сайдын төсвийн багцын 2018 оны нийт зардлыг 148,328.7 сая төгрөг байхаар төсвийн төсөлд тусгалаа. Үүнээс хөрөнгийн зардалд 110,147.8 сая төгрөг, урсгал зардалд 25,156.8 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 13,024.1 сая төгрөг тус тус тусгалаа. Барилга, хот байгуулалтын сайдын багцад туссан дараах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

Хүснэгт № 222. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн тойм /сая төгрөг/

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Хөтөлбөр	57,928.7	132,239.6	148,328.7
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	6,553.6	32,608.7	41,763.6
Газрын зураглал, кадастр (71504)	2,142.1	16,658.7	23,504.4
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага (71509)	1,616.4	1,678.2	1,541.3
Хөрөнгийн зардал	47,437.8	81,294.1	81,519.5

ТЕЗ-ийн багцын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн урсгал зардлыг эдийн засгийн ангиллаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 222. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн зардлын тойм /сая төгрөг/

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	Урсгал зардал	Цалин НДШ	Бараа үйлчилгээ ний бусад	Татаас шилжүү лэг
Нийт дүн:				
Газрын зураглал, кадастр	23,504.4	9,410.6	3,629.3	10,464.5
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага	1,541.3	1,150.2	313.3	77.8

Хөтөлбөр 1. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага

Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 1,541.3 сая төгрөгөөр төсөвлөлөө. Тус хөтөлбөрийн хүрээнд Хот байгуулалтын тухай, Хот суурины ногоон байгууламжийн тухай, Авто зогсоолын тухай, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тухай, Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон хуулиудтай холбогдон гарах дүрэм, журмыг боловруулна.

Хүснэгт № 223. Хөтөлбөрийн зардлын задаргаа /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага	2016 гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	1,795.4	1,678.2	1,541.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,124.1	1,244.8	1,366.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	0.0	104.8	0.0
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.8	1.5	1.5
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	30.6	0.0	0.0
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	75.3	82.7	82.7
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	3.5	3.5	3.5
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	150.9	126.7	77.8
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	7.5	0.0	0.0

81519 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	3.3	5.4	0.0
82405 Барилгын норм, норматив	350.0	99.0	0.0
82808 Бусад баяр ёслол, тэмдэглэлт арга хэмжээ	13.9	0.0	0.0
82809 Тухайлсан салбар, үйл ажиллагааг дэмжих жил, өдөр	29.0	9.9	9.9
82905 Засгийн газар хоорондын комисс	6.6	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,795.4	1,678.2	1,541.3
31 Улсын төсвөөс санхүүжих	1,795.4	1,678.2	1,541.3
Орон тоо - Албан тушаалаар	61	69	69
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,795.4	1,678.2	1,541.3
10092 Барилга, хот байгуулалтын яам	1,795.4	1,678.2	1,541.3

Хөтөлбөр 2. Газрын зураглал, кадастр

Газрын зураглал, кадастр хөтөлбөрийн урсгал зардлыг нийт 13,198.2 сая төгрөг байхаар тооцлоо. Үүнээс засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын үйл ажиллагааны урсгал зардалд 2,891.9 сая төгрөг, аймгуудын Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 10,306.2 сая төгрөг тус тус тусгалаа.

2018 оны төсвийн төсөлд аймаг, сумдын газрын даамлуудын урсгал зардлыг орон нутгийн төсвөөс улсын төсөв рүү шилжүүлж тооцсон, мөн Төрийн архивыг цахимжуулах үйл ажиллагааны зардлыг нэмж тусгасан.

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт газрын асуудал эрхэлсэн алба, сумдад газрын даамалтай байна” гэж заасан, үүнд нийцүүлэн гаргасан Засгийн газрын 2017 оны 253 дугаар тогтоолд үндэслэн сумдын Засаг даргын тамгын газарт харьяалагдаж байгаа газрын даамлуудын нийт 353 орон тоо, 2,582.3 сая төгрөгийн зардлыг аймгын газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт шилжүүлэх зохицуулалтыг төсөлд тусгалаа.

Тус хөтөлбөрийн хүрээнд Газрын тухай багц хуулиуд, Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулиудыг шинэчлэн боловсруулах болон хуулиудтай холбогдон гарах дүрэм, журмыг боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт № 224. Газрын зураглал, кадастр хөтөлбөрийн задаргаа /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Газрын зураглал, кадастр (71504)	2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	2,142.1	16,658.7	23,504.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,145.9	7,044.3	10,620.7
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	40.6	418.9	413.1
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.1	1.3	1.3
80211 Газрын зургийн зардал	246.2	272.3	298.1
80212 Газрын хянан баталгааны зардал	222.9	470.3	444.9
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	60.6	0.0	0.0
80219 Харуул хамгаалалтын зардал	0.0	5.8	5.8
80220 Холбооны суваг ашигласны хөлс	278.0	275.2	275.2
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	86.5	166.7	166.7
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	7.7	9.9	9.9
80502 Тусгай зориулалтын шилжүүлэг	0.0	6,961.8	10,306.2
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	1.7	1.9	1.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	46.0	303.1	156.4

81519 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	6.0	43.3	0.0
82404 Барилгын техник хяналт	0.0	683.9	804.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	2,142.1	16,658.7	23,504.4
31 Улсын төсвөөс санхүүжих	2,142.1	16,658.7	23,504.4
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	2,142.1	16,658.7	23,504.4
00545 Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	0.0	6,961.8	10,306.2
10158 Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг	0.0	6,961.8	10,306.2
10792 УТ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	2,142.1	2,735.1	2,891.9

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын нийт зардлыг 26,198.8 сая төгрөг байхаар тооцлоо. Үүнээс гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, Олборлолт, уул уурхай хөтөлбөр 9,002.9 сая төгрөг, Уул уурхайн судалгаа шинжилгээ хөтөлбөрт 13,335.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 4,580.0 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Хүснэгт № 224. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын ерөнхий тойм /сая төгрөг/

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	2016 Гүйц	2017 Тод 1	2018 Төсөл
Нийт	16,420.4	25,207.5	26,918.8
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	0.0	3,352.3	0.0
Олборлолт, уул уурхай (70905)	7,079.3	8,519.3	9,002.9
Хөрөнгийн зардал (70906)	0.0	0.0	4,580.0
Уул уурхайн судалгаа шинжилгээ (70907)	9,341.1	13,335.9	13,335.9

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын нийт урсгал зардлыг 2018 оны төсвийн төсөлд 9,002.9 сая төгрөг байхаар тооцсон ба үүнээс цалин, НДШ-ийн зардалд 3,395.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,901.1 сая төгрөг, татаас шилжүүлэгт 2,706.2 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Хүснэгт № 225. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт урсгал зардлын бүтэц /сая төгрөг/

Хөтөлбөр	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
Эрчим хүч, уул уурхай (70900)	9,002.9	3,395.5	2,901.1	2,706.2
Олборлолт, уул уурхай (70905)	9,002.9	3,395.5	2,901.1	2,706.2

Хөтөлбөр 1 : Уул уурхай судалгаа шинжилгээ (70907)

Геологийн хайгуулын судалгааны ажил

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн геологийн судалгаанд хамрагдсан түвшинг авч үзвэл 1:200000-ны масштабын геологийн зураглалаар 100 хувь, Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлаар 88 хувь, геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлаар 36.1 хувьд бүрэн, 5 хувьд ажил гүйцэтгэж байгаа бол геофизикийн хүндийн хүчний 1:200000-ны масштабын зураглалаар 20 хувь, агаарын соронзон судалгааны 1:200000-ны масштабын зураглалаар 60 хувь, 1:50000-1:25000-ны масштабын агаарын геофизикийн цогцолбор судалгааг 32 хувьд тус тус хийж гүйцэтгээд байна.

2018 оны төсвийн төсөлд үргэлжлэх 23 төсөл, шинээр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын 5 төсөл, сэдэвчилсэн судалгааны 2 төсөл, гадаад хамтын ажиллагааны 1 төсөл, нийтдээ 31 төслийн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор 13,335.9 сая төгрөгийн зардлыг тусгалаа.

Хүснэгт № 226: Уул уурхайн судалгаа шинжилгээ (70907) /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Уул уурхайн судалгаа шинжилгээ (70907)	2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	9,341.1	13,335.9	13,335.9
80914 Геологи хайгуул, судалгаа	9,341.1	13,335.9	13,335.9
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	9,341.1	13,335.9	13,335.9
31 Улсын төсвөөс санхүүжих	4,341.1	9,341.1	9,341.1
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5,000.0	3,994.8	3,994.8
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	9,341.1	13,335.9	13,335.9
00563 Геологийн байгууллага	9,341.1	13,335.9	13,335.9

Хөтөлбөр 2 : Олборлолт, уул уурхай

Олборлолт, уул уурхай хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 9,002.9 сая төгрөгийн зардлыг тооцож тусгалаа. Үүнээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн үйл ажиллагааны зардалд 4,051.2 сая төгрөг, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэгт 2,628.3 сая төгрөг, хөтөлбөр төслийн дотоод урсгал зардалд 1,001.2 сая төгрөг, бусад урсгал зардалд 1,322.2 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Хүснэгт № 226. Олборлолт, уул уурхай (70905) /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Олборлолт, уул уурхай (70905)	2016 Гүйц	2017 Тод 1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	7,079.3	8,519.3	9,002.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	4,644.1	4,174.4	4,051.2
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	39.8	0.0	0.0
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	17.4	12.8	12.8
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	29.0	459.2	459.2
80219 Харуул, хамгаалалтын зардал	66.3	71.7	71.7
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	16.4	10.0	10.0
80226 Байр ашиглалтын үйлчилгээ	671.7	690.5	690.5
80230 Нөөц хөрөнгийн хамгаалалт	0.0	0.0	0.0
80305 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	4.5	0.0	0.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	131.7	141.8	78.0
80809 Эмчилгээний төлбөр	6.6	0.0	0.0
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	137.5	0.0	0.0
81519 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	10.2	0.0	0.0
81820 Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг	1,209.1	1,957.8	2,628.3
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	0.0	0.0	0.0
83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	94.9	1,001.2	1,001.2
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	7,079.3	8,519.3	9,002.9
31 Улсын төсвөөс санхүүжих	5,870.2	5,556.4	5,519.4
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,209.1	2,963.0	3,483.5
Орон тоо - Албан тушаалаар	263	263	263
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	7,079.3	8,519.3	9,002.9
09810 Ашигт малтмалын газар	1,577.7	0.0	0.0
09811 Газрын тосны газар	1,835.2	0.0	0.0
10084 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	1,659.1	2,990.4	3,009.8
10640 Ашигт малтмал, газрын тосны газар	2,007.4	5,528.9	5,993.1

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын 2018 оны нийт зардлыг 124,165.8 сая төгрөгөөр тооцсон ба үүнээс урсгал зардалд 116,196.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 66,612.9 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд -58,643.3 сая төгрөгийг тус тус тусгалаа. 2017 оны батлагдсан тодотголын түвшинтэй харьцуулахад урсгал зардал 16,059.5 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 9,110.0 сая төгрөгөөр нэмэгдэхээр туссан байна. Харин эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 84,791.6 сая төгрөгөөр буурсан нь дотоод эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн авлагыг Тариаланг дэмжих сан болон Мал хамгаалах сангаас төсөвт буцаан төвлөрүүлэхээр тооцсонтой холбоотой байна.

2018 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас хэрэгжих үйл ажиллагаа нь Гадаад, зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, Мал аж ахуйг хөгжүүлэх, Газар тариалан хөгжүүлэх, Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх, Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого удирдлага, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зэрэг нийт 7 төрлийн хөтөлбөрөөс бүрдэж байна.

Хүснэгт № 227. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй зардлын тойм /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод 1	2018 Төсөл
Нийт	142,178.4	183,787.9	124,165.8
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	22,483.1	41,525.1	40,420.7
Мал аж ахуйг хөгжүүлэх (70801)	65,551.6	62,365.7	28,601.8
Газар тариалан хөгжүүлэх (70802)	16,602.0	38,366.3	21,599.1
Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх (70803)	14,615.1	4,888.5	8,836.6
Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх	0.0	432.3	1,495.0
Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого удирдлага (70805)	17,942.1	37,242.2	42,434.0
Хөдөө аж ахуй, газар тариалангийн судалгаа шинжилгээ (70806)	141.7	0.0	0.0
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих (72101)	4,842.7	-1,032.3	-19,221.4

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын 2018 оны нийт урсгал зардлыг 116,196.1 сая төгрөг байхаар тооцсон ба үүнээс цалин, НДШ-ийн зардалд 10,406.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 48,748.5 сая төгрөг, татааст 55,948.1, урсгал шилжүүлэгт 1,093.2 сая төгрөгийн зардлыг тус тус тусгалаа.

Хүснэгт № 227. ТЕЗ-ын 2018 оны нийт урсгал зардлын бүтэц /сая төгрөг/

Хөтөлбөр	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
Нийт	116,196.1	10,406.2	48,748.5	57,041.4
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	1,529.7	0.0	1,529.7	0.0
Мал аж ахуйг хөгжүүлэх (70801)	66,692.8	1,499.6	30,677.2	34,485.1
Газар тариалан хөгжүүлэх (70802)	24,599.1	1,568.6	8,067.5	14,963.0
Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх (70803)	8,836.6	0.0	2,336.6	6,500.0
Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх	1,495.0	0.0	1,495.0	0.0
Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого удирдлага (70805)	10,843.0	6,982.8	2,824.2	1,036.0
Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ	0.0	0.0	0.0	0.0

Тус сайдын багцын 2018 оны төсвийн төсөлд хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгох нийт урамшууллыг 55,948.1 сая төгрөгөөр тооцсон ба үүнээс улаан буудайн урамшуулалд 14,963.0 сая төгрөг, ноосны урамшуулалд 22,637.2 сая төгрөг, арьс, ширний урамшуулалд 11,847.9 сая төгрөг, мах бэлтгэх аж ахуйн нэгжүүдийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүний хөнгөлөлт үзүүлэхэд 6,500.0 сая төгрөгийг тус тус төсөвлөв.

Хөтөлбөр 1 : Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр

Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрт нийт 28,601.8 сая төгрөгийн зардлыг 2018 онд тооцлоо.

Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2018 онд дараах үндсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны халдварт, гоц, архаг халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 25,602.2 сая төгрөг;
2. Малын удмын санг хамгаалах, сайжруулах арга хэмжээнд 767.5 сая төгрөг;
3. Үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээнд 1,188.5 сая төгрөг;
4. Хөнөөлт царцаатай тэмцэх арга хэмжээнд 507.9 сая төгрөг;
5. Отрын бүс хамгаалах арга хэмжээний захиргаа, үйл ажиллагааны зардалд 264.4 сая төгрөг;
6. 2017 онд тэжээлийн нөөц бэлтгэх зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлт 40,000.0 сая төгрөг;
7. Ноос, арьс ширний урамшуулал олгох арга хэмжээнд 34,485.1 сая төгрөгийн зардлыг тус тус тооцож төсөлд тусгав.

Хүснэгт № 228. Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Мал аж ахуйг хөгжүүлэх (70801)	2017 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээ	65,551.6	62,365.7	28,601.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,649.1	1,716.9	1,842.4
80702 Туслах үйл ажиллагааны зардал	0.0	0.0	221.5
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	39.5	22.3	0.0
80219 Харуул, хамгаалалтын зардал	5.0	5.0	5.0
80227 Лабораторийн итгэмжлэл	4.9	3.9	3.9
80312 Сургалт семинар	100.0	0.0	0.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	35.7	47.1	28.8
81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	1,554.0	1,909.0	-38,091.0
81518 Мөрийн хөтөлбөрт туссан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	0.0	0.0	2,000.0
82504 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	4,462.3	3,097.5	3,677.5
82506 Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	18,330.6	11,506.1	14,553.1
82507 Малыг архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх	6,847.8	5,662.6	5,315.7
82508 Малын өвчний лабораторийн оношилгоо, шинжилгээ	701.7	708.4	1,051.7
82509 Малын өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгаа, судалгаа шинжилгээний ажил	7.0	6.9	330.2
82510 Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлт	449.9	673.9	673.9
82512 Малын ашиг шим, үр төлийн чанараар сонгон шалгаруулах	32.7	0.0	0.0
82513 Тоо толгой нь цөөрсөн малыг хамгаалах, үржүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих	10.6	0.0	0.0
82515 Өндөр ашиг шимтэй мал үржүүлэх	389.8	212.8	187.8

82517	Үлийн цагаан оготнотой тэмцэх	1,196.9	1,188.5	1,188.5
82518	Хөнөөлт царцаатай тэмцэх	515.6	507.9	507.9
82519	Отрын бүс байгуулах, хамгаалах	74.8	54.8	54.8
82537	Ноосны урамшуулал	0.0	22,637.2	22,637.2
82542	Монгол мал хөтөлбөр	516.2	557.1	564.8
82543	Арьс ширний урамшуулал	9,251.0	11,847.9	11,847.9
83118	Мах, улаан буудай, арьс шир, ноосны урамшуулал	19,376.4	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		65,551.6	62,365.7	28,601.8
31	Улсын төсвөөс санхүүжих	63,531.5	60,004.8	25,970.7
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2,020.1	2,360.9	2,631.1

Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа хамаарна.

Хүснэгт №229. Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрт хамаарах байгууллага /сая төгрөг/

Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрт хамаарах төсөвт байгууллага	2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	65,551.6	62,365.7	28,601.8
00543 Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	560.5	555.5	624.0
00547 Хөдөө аж ахуйн газар	516.2	522.6	493.1
09726 Отрын бүс нутгийн захиргаа	214.8	208.2	264.4
09729 Малын удмын сангийн үндэсний төв	405.4	550.5	767.5
09777 Мал хамгаалах сан	30,453.1	36,698.5	-3,314.5
09798 Мал эмнэлэг, үржлийн газар	30,799.4	21,655.4	25,602.2
10082 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2,602.1	2,175.1	4,165.1

Хөтөлбөр 2 : Газар тариалан хөгжүүлэх

Газар тариалан хөгжүүлэх хөтөлбөрт нийт 21,599.1 сая төгрөгийн зардлыг 2018 оны төсвийн төсөлд тооцсон ба улсын төсвөөс 18,101.6 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос 50,897.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлж, улсын төсөвт 47,400.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төсөвлөв.

Газар тариалан хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2018 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан хүнсний буудайн нөөц болон, буудайн үрийн нөөц бүрдүүлэх арга хэмжээнд 22,400 сая төгрөг;
2. Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны зардалд 3,798.6 сая төгрөг;
3. Ургацын төв комиссын үйл ажиллагааны зардалд 10.0 сая төгрөг;
4. Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас улсын төсөвт төвлөрүүлэх зээлийн эргэн төлөлтөд 47,400.0 сая төгрөг;
5. Улаан буудайн урамшуулал олгох арга хэмжээнд 14,963.0 сая төгрөг;
6. Тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг ТЭДС-аас дэмжих арга хэмжээнд 22,000.0 сая төгрөг;
7. Жимс, жимсгэнийн тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэхэд 3,000.0 сая төгрөгийн зардлыг тус тус тусгалаа.

Хүснэгт № 230. Газар тариалан хөгжүүлэх хөтөлбөр /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Газар тариалан хөгжүүлэх (70802)		2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээ		16,602.0	38,366.3	21,599.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	10.4	188.3	141.3
80102	Туслах үйл ажиллагааны зардал	0.0	0.0	696.9
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	2,727.4	2,805.0	2,960.4
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	68.6	0.0	0.0
81308	Үрийн нөөц	0.0	1,600.0	1,600.0
81309	Таваарын буудайн нөөц	6,241.3	20,800.0	20,800.0
81404	Дамжуулан зээлдүүлсэн зээл	0.0	22,000.0	22,000.0
81405	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	0.0	-24,000.0	-47,400.0
82521	Таримал тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих	886.9	0.0	0.0
82524	Хамгаалагдсан хөрсний тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	723.2	0.0	2,827.5
82525	Жимс, жимсгэнийн тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	117.2	0.0	3,000.0
82526	Өрхийн тариаланг дэмжих сургалт, сурталчилгаа	222.9	0.0	0.0
82528	Ургацын комисс, төв штаб, удирдлагын зардал	12.5	10.0	10.0
82536	Улаан буудайн урамшуулал	0.0	14,963.0	14,963.0
83118	Мах, улаан буудай, арьс шир, ноосны урамшуулал	5,591.5	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		16,602.0	38,366.3	21,599.1
31	Улсын төсвөөс санхүүжих	2,153.0	15,101.6	18,101.6
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	14,449.0	47,264.7	50,897.5
37	Бусад эх үүсвэр	0.0	-24,000.0	-47,400.0

Газар тариалан хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа хамаарна.

Хүснэгт № 231. Газар тариалан хөгжүүлэх хөтөлбөрт хамаарах төсөвт байгууллага /сая төгрөг/

Хөтөлбөрт хамаарах төсөвт байгууллага		2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		16,602.0	38,366.3	21,599.1
09725	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	14,016.6	36,797.6	16,826.6
10042	Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Сэлэнгэ	279.0	287.9	476.8
10043	Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Хархорин	168.2	166.3	166.6
10044	Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Булган	244.2	254.3	270.5
10045	Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Хөтөл	270.3	281.6	278.2
10082	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1,261.5	138.6	3,138.6
10418	Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Угтаал	225.0	253.9	263.3
10419	Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Дархан	137.1	186.1	178.5

Хөтөлбөр 3 : Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрт 8,836.6 сая төгрөгийн зардлыг 2018 оны төсвийн төсөлд тусгалаа. Үүнд:

1. Мах сүүний анхдугаар аяныг хэрэгжүүлэх арга хэмжээнд 2.0 тэрбум төгрөг;
2. Мал, мах бэлтгэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор олгосон зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 6,500.0 сая төгрөг;
3. Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаанд 336.6 сая төгрөгийг тус тус тооцлоо.

Хүснэгт № 232. Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх (70803) /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх (70803)		2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр		14,615.1	4,888.5	8,836.6
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	9.9	0.0	0.0
80312	Сургалт семинар	7.9	0.0	0.0
80405	Улаан буудай, махны нийлүүлэлтэд олгох татаас	14,496.6	0.0	0.0
80413	Зээлийн хүүгийн татаас	0.0	4,551.9	6,500.0
82529	Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаа	100.7	336.6	336.6
82545	Махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	0.0	0.0	2,000.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		14,615.1	4,888.5	8,836.6
31	Улсын төсвөөс санхүүжих	14,615.1	4,888.5	8,836.6
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		14,615.1	4,888.5	8,836.6
10082	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	14,615.1	4,888.5	8,836.6

Хөтөлбөр 4 : Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлага

Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлага хөтөлбөрийн 2018 оны нийт урсгал зардлыг 10,843.0 сая төгрөгөөр тооцлоо.

Тус хөтөлбөрийн хүрээнд 2018 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамжид 349.2 сая төгрөг;
2. Сайн малчны шагнал олгох арга хэмжээг зохион байгуулах зардалд 277.0 сая төгрөг;
3. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн дотоод урсгал зардалд 325.1 сая төгрөг;
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийслэлийн мал эмнэлгийн газар, аймгуудын Хөдөө аж ахуйн газрууд, Мал эмнэлгийн үржлийн газар болон Халх-гол бүтээн байгуулалтын бүсийн үйл ажиллагааны зардалд нийт 9,481.9 сая төгрөг;

Хүснэгт № 233. Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого удирдлага /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого удирдлага		2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр		16,931.2	10,257.6	10,843.0
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	8,534.8	8,322.8	8,567.1
80102	Туслах үйл ажиллагааны зардал	0.0	0.0	244.0
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	485.6	472.7	556.2
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	0.5	0.0
80227	Лабораторийн итгэмжлэл	13.8	14.1	15.1
80312	Сургалт семинар	55.0	49.5	99.5
80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	205.4	313.2	349.2
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	395.3	420.0	409.8
80812	Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	25.6	0.0	0.0
80920	Векселээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	6,610.2	0.0	0.0
82533	Сайн малчны шагнал	277.0	277.0	277.0
82539	Хөнгөн үйлдвэрийн үндэсний хөтөлбөрүүд	0.0	62.7	0.0
83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	328.4	325.1	325.1
83201	Ангилалдаагүй бусад зориулалт, арга хэмжээ	0.1	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		16,931.2	10,257.6	10,843.0
31	Улсын төсвөөс санхүүжих	16,746.6	10,086.4	10,676.3
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	184.6	171.2	166.7
Орон тоо - Төрийн албаны ангиллаар		706		

Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого удирдлага хөтөлбөрт дараах төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа хамаарна.

Хүснэгт № 234. Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого удирдлага хөтөлбөрт хамаарах төсөвт байгууллага /сая төгрөг/

Хөтөлбөрт хамаарах төсөвт байгууллага	2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	10,321.0	10,257.6	10,843.0
00539 Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар	512.6	500.6	615.0
00547 Хөдөө аж ахуйн газар	6,184.8	6,196.8	6,228.4
09798 Мал эмнэлэг, үржлийн газар	344.8	286.0	288.4
10082 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	3,278.9	2,884.2	3,295.0
10696 Халх-гол бүтээн байгуулалтын бүс	0.0	390.0	416.3

Хөтөлбөр 5 : Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх

Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 1,495.0 сая төгрөгийг зардлыг тооцож тусгалаа. Үүнээс Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр болон Ноолуур хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд 1.0 тэрбум төгрөг, Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах арга хэмжээнд 495.0 сая төгрөгийн зардлыг тус тус тооцлоо.

Хүснэгт № 235. Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Хөдөө аж ахуй, газар тариалангийн судалгаа шинжилгээ (70806)	2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	0.0	432.3	1,495.0
82539 Хөнгөн үйлдвэрийн үндэсний хөтөлбөрүүд	0.0	432.3	1,495.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	0.0	432.3	1,495.0
31 Улсын төсвөөс санхүүжих	0.0	432.3	1,495.0
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	0.0	432.3	1,495.0
10082 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	0.0	432.3	1,495.0

Хөтөлбөр 6 : Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих (72101)

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2018 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд;

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үндсэн үйл ажиллагааны зардалд 801.8 сая төгрөг;
2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээнд 614.5 сая төгрөг;
3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос санхүүжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 20,000.0 сая төгрөг, улсын төсвөөс санхүүжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт 10,578.7 сая төгрөг;
4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас улсын төсөвт буцаан төвлөрүүлэх дамжуулан зээлийн авлагад 52,000.0 сая төгрөг;
5. Бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлийг өргөтгөх зорилгоор “Монголд үйлдвэрлэв-Цагаан сар”, “Бүтээлч Монгол”, “Үндэсний нэрийн бүтээгдэхүүн шалгаруулах” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах арга хэмжээнд зориулж 198.0 сая төгрөг;

6. Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах, олон улсын үзэсгэлэнд оролцох арга хэмжээнд 180.0 сая төгрөг;
7. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн авлага барагдуулах арга хэмжээнд 325.6 сая төгрөг

Хүснэгт № 236. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих (72101)		2016 Гүйц	2017 Тод1	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр		4,842.7	-1,032.3	-19,221.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2.6	324.3	801.8
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	58.0	0.0	30.0
80218	Улс орноо гадаадад сурталчлах	54.2	49.5	180.0
80229	Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	0.0	0.0	325.6
80312	Сургалт семинар	50.0	0.0	50.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.0	46.6	0.0
80812	Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	58.5	0.0	0.0
81404	Дамжуулан зээлдүүлсэн зээл	-51,870.0	-52,000.0	-52,000.0
81405	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	55,700.0	49,800.0	30,578.7
82540	"Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн	149.9	198.0	198.0
82611	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	639.5	549.3	614.5
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		4,842.7	-1,032.3	-19,221.4
31	Улсын төсвөөс санхүүжих	-19,841.8	366.3	11,375.7
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	76,554.5	50,601.4	21,402.9
37	Бусад эх үүсвэр	-51,870.0	-52,000.0	-52,000.0
Орон тоо - Төрийн албаны ангиллаар		24		
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид		4,842.7	-1,032.3	-19,221.4
09728	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	56,712.7	50,601.4	31,981.6
09805	ЖДҮДСан ЗГ бонд, дамжуулан зээл	-51,870.0	-52,000.0	-52,000.0
10082	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	0.0	366.3	797.0

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

Эрчим хүчний сайдын багцын нийт зардлыг 184,058.5 сая төгрөгөөр тооцсон ба үүнээс Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт 123,886.4 сая төгрөг, Эрчим хүчний бодлого удирдлага хөтөлбөрт 19,470.1, хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрт 40,701.9 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Хүснэгт № 237. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	2016 Гүйц	2017 тод1	2018 төсөл
Нийт	128,995.5	149,527.0	184,058.5
Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	28,209.4	97,233.0	123,886.4
Эрчим хүчний бодлого удирдлага (70906)	19,641.5	19,855.1	19,470.1
Хөрөнгийн зардал	81,144.6	32,439.0	40,701.9

Эрчим хүчний сайдын багцын урсгал зардлыг 19,470.1 сая төгрөгөөр тооцсон ба үүнээс цалин, НДШ-ийн зардалд 1,244.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,032.8 сая төгрөг, татаас шилжүүлэгт 17,150.0 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Хүснэгт № 238. ТЕЗ-ын нийт урсгал зардлын бүтэц /сая төгрөг/

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
Эрчим хүчний бодлого, удирдлага (70906)	19,470.1	1,244.9	1,032.8	17,150.0

Хөтөлбөр. Эрчим хүчний бодлого, удирдлага

Эрчим хүчний бодлого удирдлага хөтөлбөрийн хүрээнд эрчим хүч, дулааны алдагдлын татаасыг 17,150.0 сая төгрөг байхаар тооцлоо. Үүнээс цахилгаан дамжуулах системийн алдагдалд 9,600.0 сая төгрөг, дулааны станцын алдагдалд 5,400.0 сая төгрөг, дизелийн станцын алдагдалд 2,150.0 сая төгрөгийн татаасны зардлыг тус тус тусгалаа.

Харин Эрчим хүчний яамны үндсэн үйл ажиллагааны зардалд 1,467.9 сая төгрөг, хөтөлбөр төслийн дотоод урсгал зардалд 809.8 сая төгрөг, бусад урсгал зардалд 42.4 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Хүснэгт № 239. Эрчим хүчний бодлого, удирдлага хөтөлбөр /сая төгрөг/


ХӨТӨЛБӨР: Эрчим хүчний бодлого, удирдлага (70906)	2016 Гүйц	2017 тод1	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	19,641.5	19,855.1	19,470.1
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,427.7	1,449.6	1,467.9
80213 Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	9.6	9.9	0.0
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	50.9	0.0	0.0
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4.7	9.9	0.0
80305 Биений тамирын уралдаан, тэмцээн	3.1	0.0	0.0
80312 Сургалт семинар	0.6	0.0	0.0
80401 Цахилгаан дамжуулах системийн алдагдалд олгох татаас	9,600.0	9,600.0	9,600.0
80402 Дулааны станцын алдагдалд олгох татаас	5,100.1	5,400.1	5,400.1
80411 Дизелийн станцын алдагдлын татаас	2,149.9	2,150.0	2,150.0
80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	3.1	4.5	4.4
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	126.2	46.0	38.0
80812 Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	15.4	0.0	0.0
83112 Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	1,150.3	1,185.1	809.8
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	19,641.5	19,855.1	19,470.1
31 Улсын төсвөөс санхүүжих	19,641.5	19,855.1	19,470.1
Орон тоо - Албан тушаалаар	95	95	95
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагч	19,641.5	19,855.1	19,470.1
10075 Эрчим хүчний яам	19,641.5	19,855.1	19,470.1

6. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ

6.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, цаашдын төсөөлөл

Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2010-2014 оны хооронд өмнөх онуудтай харьцуулахад хурдацтай нэмэгдсэн ба энэ үед жилд 300-900 төсөл, арга хэмжээ шинээр эхлүүлж байсан. Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд тохиролцсон тооцооллын дагуу ирэх онуудад хөрөнгийн зардлын хэмжээ ДНБ-ний 3-4 хувийг эзлэхээр байгаа тул цаашид төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой сонгох, тэдгээрийг үр ашигтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

График № 36. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2005-2016 оны гүйцэтгэл, 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2018-2022 оны төсөөлөл



6.2. Монгол улсын 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтад баримталж буй бодлого


“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол болон “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолд заасан төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгийн хүрэлцээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл нь төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зарчмыг хангахын зэрэгцээ ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд тохирсон макро

эдийн засгийн тооцоолол, төсвийн орлого, зарлага, алдагдлын хэмжээнд суурилсан болно.

Хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой, үр ашигтай болгох, салбарын тэргүүлэх чиглэлд санхүүжилтийг чиглүүлэх, ойрын болон дунд хугацаанд баримтлах хөгжлийн бодлого, стратегитай уялдуулан ач холбогдлын эрэмбийг баримтлах, өмнөх онуудад эхлүүлсэн төсөл, арга хэмжээг дуусгах, хэрэгжиж буй төслийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг оновчтой удирдах, концессын гэрээгээр хэрэгжиж буй төслүүдийн эргэн төлөлт зэргийг төсөвт тусгах нь нийгэм, эдийн засагт бодитой эерэг нөлөөлөл үзүүлнэ гэж тооцлоо.

График № 37. ТЕЗ-ын 2018 оны төсвийн багцын хэмжээ, бүтэц



Монгол Улсын 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 846.1 тэрбум төгрөг байхаар тооцож төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад 719.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ, концессын “барих-шилжүүлэх” гэрээний эргэн төлөлтөд 126.5 тэрбум төгрөг төлөвлөөд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын багцыг авч үзвэл 2018 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд болон Эрүүл мэндийн сайд нарын багцад шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нийт багцын 50 орчим хувийг эзэлж байна.

6.3. Салбарын хөрөнгө оруулалт


6.3.1. Нийгмийн салбар

Нэг. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд боловсролын салбарт дараах үндсэн зорилтыг тусгасан байна. Үүнд: *нэгдүгээрт*: боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, амьдралд нийцтэй болгох, “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгох, *хоёрдугаарт*: анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг

бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлэх, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах, *гуравдугаарт*: сургууль, цэцэрлэгийн 80 хувиас дээш гүйцэтгэлтэй дутуу барилгын санхүүжилтийг шийдвэрлэж, ашиглалтад оруулах талаар тус тус заажээ.

Дээрх бодлогын хүрээнд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт нийт 255.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тооцлоо. Үүнээс 196.0 тэрбум төгрөгийг боловсролын салбарт, 29.3 тэрбум төгрөгийг соёлын салбарт, 16.0 тэрбум төгрөгийг спортын салбарт, 0.5 тэрбум төгрөгийг шинжлэх ухааны салбарт, 13.7 тэрбум төгрөгийг тус салбарын их засвар, тоног төхөөрөмж, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулахад тус тус тусгаад байна.



Сургууль

Улсын хэмжээнд 2018 онд төсвийн хөрөнгөөр 41 сургуулийн барилга байгууламжийг шинээр эхлүүлж, 12 сургуулийн барилга, байгууламжийг 2018 онд багтаан ашиглалтад оруулахаар тооцож санхүүжилтийн эх үүсвэрийг тусгалаа.

№	Санхүүжих эх үүсвэр	Байршил		Үр дүн
		Нийслэл	Орон нутаг	
1.	Улсын төсвийн хөрөнгөөр	2	11	5818 суудал

Нийслэлд 2017-2018 оны хичээлийн жилд 27 сургуулийн 227 бүлгийн 9139 сурагч 3 ээлжээр хичээллэх тооцоо гарсныг харгалзан 3 ээлжээр хичээллэж буй 6 сургуулийн барилгын өргөтгөлийн ажлыг 2018 онд эхлүүлнэ. Үүнээс гадна Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 22-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд зааснаар ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд сургууль, цэцэрлэгийн зориулалт бүхий үл хөдлөх хөрөнгө худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахад 32.0 тэрбум төгрөг тусгалаа.

Цэцэрлэг

Улсын төсвийн хөрөнгөөр нийт 7275 ор бүхий 62 цэцэрлэгийн барилгыг 2018 онд эхлүүлж, байгууламжийн төсөл, арга хэмжээг 2018 онд эхлүүлж, ирэх онуудад ашиглалтад оруулна. Эдгээрээс 2018 онд улсын хэмжээнд 20 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, хүүхдийн ая тухтай сурч, боловсрох орчин, нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзлээ.

Түүнчлэн, 2018 онд концессын гэрээгээр 250 ор бүхий 2 цэцэрлэг ашиглалтад орох гэрээтэй ажиллаж байна.

№	Санхүүжих эх үүсвэр	Байршил		Үр дүн
		Нийслэл	Орон нутаг	
1.	Улсын төсвийн хөрөнгөөр	6	14	2570 ор
2.	Концессын гэрээгээр	-	2	250 ор
3.	Нийт	6	16	2820 ор

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжгүй 57448 хүүхдийн 56.9 хувь нь нийслэлд амьдардаг бөгөөд салбарын яамны судалгаагаар энэ онд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах сурагчийн тоо өмнөх оноос 9321 хүүхдээр нэмэгдэх төлөвтэй байна. 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн 6 дүүрэгт 200-280 хүүхдийн хүчин чадалтай 16 цэцэрлэгийн барилга, барилгын өргөтгөлийг 33.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан.

Дотуур байр

Улсын төсвийн хөрөнгөөр нийт 1645 хүүхдийн багтаамжтай 13 сургуулийн дотуур байрын барилгыг 2018 онд эхлүүлж ирэх онуудад ашиглалтад оруулахаар тооцлоо. Ингэснээр, 2018 онд орон нутагт 600 ор бүхий 5 дотуур байрын барилга ашиглалтад орно.

Улсын хэмжээнд 2018 онд шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэг, дотуур байрын нийт 39 барилга байгууламжийн санхүүжилтийг бүрэн тусгасан. Үүний үр дүнд 5818 суудал бүхий сургууль, 2820 ор бүхий цэцэрлэг болон 600 ор бүхий дотуур байрын барилга, байгууламжийг ашиглалтад оруулж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн ая тухтай сурч, боловсрох орчин, нөхцөлийг хангах боломжтой болох юм.

Соёл

2018 оны төсвийн жилд Ханхэнтий чуулгын барилга, Төв аймгийн 800 суудал бүхий Хөгжимт драмын театрын барилгыг ашиглалтад оруулахаар санхүүжилтийг тусгасан. Нийслэлд Үндэсний номын сангийн барилгын ажлыг үргэлжлүүлж, орон нутагт 25 сумын соёлын төвийн барилгыг шинээр эхлүүлэхэд 21.5 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгалаа.

Дээд боловсрол, шинжлэх ухаан

Япон Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дэргэдэх Монгол анагаах ухааны олон улсын

сургуулийн барилгыг 2018 онд багтаан ашиглалтад оруулна. Мөн Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн 2 дугаар байр, Говь-Алтай аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн барилга угсралтын ажлын санхүүжилтийг тусгасан.

Монгол Улсын 2018 оны хөрөнгө оруулалтад Шинжлэх ухааны академийн нэгдсэн байрын өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэхэд 500.0 сая төгрөг төлөвлөсөн.

Спорт

Монгол Улсын 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар спортын салбарт өмнөх онуудад эхлүүлсэн 6 төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэхэд 10.9 тэрбум төгрөг, шинээр 6 төсөл, арга хэмжээ эхлүүлэхэд 4.3 тэрбум төгрөг, их засварын ажилд 0.8 тэрбум төгрөг, нийт 16.0 тэрбум төгрөгийг тусгалаа.

Хоёр. Эрүүл мэнд

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх” зорилтыг тусгасан.

Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүртээмжтэй, шуурхай болгох зорилгоор эмчилгээ, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын барилга байгууламжаар хот, хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагуудыг ээлж дараалалтай хангахаар төлөвлөж байна.

Эрүүл мэндийн салбарт 2018 онд 60.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгалаа. Тухайлбал, 42.6 тэрбум төгрөгийг барилга байгууламж, 5.7 тэрбум төгрөгийг их засварт, 11.9 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар тусгасан.

Ирэх 2018 онд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэг, Үндэсний оношилгоо эмчилгээний төв ашиглалтад орох бөгөөд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лабораторийн барилга, Геронтологийн төвийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.

Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр”-ийн хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга болон Бельгийн Вант Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй "Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах" төсөлд улсын төсвөөс санхүүжилт олгохоор төлөвлөөд байна.

Дараа онд Дорноговь аймгийн Сайншанд сумын 50 ортой Төрөх эмнэлгийг ашиглалтад оруулж, Ховд аймгийн Булган сумын 50 ортой нэгдсэн эмнэлэг, Говийн бүсийн оношилгоо эмчилгээний төвийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ. Үүнээс гадна Дархан-Уул аймгийн Төрөх эмнэлгийн барилгын өргөтгөл, Булган аймгийн Халдварт, сүрьеэгийн 30 ортой эмнэлэг, Баянхонгор аймгийн 50 ортой Хүүхдийн эмнэлэг, Өвөрхангай аймгийн Зооноз өвчин судлалын төвийн барилгыг тус тус шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн.

Орон нутагт Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Говь-Алтай, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв аймгийн сумын эрүүл мэндийн төв болон нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Хан-Уул дүүргүүдийн эрүүл мэндийн төв ашиглалтад орно. Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт эрүүл мэндийн төвийн амбулаторийг эмчилгээ, оношилгооны төв болгон шинэчлэх ажлыг эхлүүлнэ. Ховд, Завхан, Сүхбаатар, Архангай аймгуудад сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлуудыг шинээр эхлүүлнэ.

Улсын томоохон эмнэлгүүд болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийг нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр ээлж дараалалтай хангах чиглэл баримтлан 2018 онд 11.9 тэрбум төгрөг төлөвлөсөн. Энэхүү арга хэмжээний хүрээнд Улсын 3 дугаар төв эмнэлгийн соронзон резонанст томограф, ангиографийн тоног төхөөрөмж, 2017 онд ашиглалтад орсон Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг тоног төхөөрөмжөөр хангана.

Гурав. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө хүн амын хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалт, эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн халамж, асрамжийн төрөлжсөн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй иж бүрнээр хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2018 онд 14.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тооцоноос 10.2 тэрбум төгрөгийг барилга байгууламж, 2.5 тэрбум төгрөгийг их засвар, 2.0 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зориулахаар тусгалаа.

Олон улсын хүүхдийн “Найрамдал” төвийн усан спорт цогцолборын ажил, Дорноговь аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилгыг үргэлжлүүлж, Ховд аймгийн Хөгжил политехник коллежийн хичээлийн байр, Дорнод аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төвийн барилга, Ховд аймгийн Хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүд, гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах хамгаалах төвийн барилга, Хэнтий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын иргэдэд үйлчлэх төвийн барилга, Завхан, Хөвсгөл аймгийн Ахмадын өргөө, амралт сувиллын байрын барилгыг тус тус эхлүүлэхээр төлөвлөж 2018 оны төсвийн төсөлд тусгаад байна.

6.3.2. Дэд бүтэц, бүтээн байгуулалт

Нэг. Авто зам

Зам, тээврийн салбарт 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын бодлого, холбогдох бусад хөтөлбөрт нийцүүлэн боловсрууллаа. Тус салбарт нийт 90.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 63 төсөл, арга хэмжээг хамруулсан. Тодруулбал, авто зам, гүүрний хөрөнгө оруулалт, их засварт 78.5 тэрбум төгрөг, тээврийн салбарт 11.5 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус олгогдохоор байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.111-д заасан “Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах” ажлын хүрээнд Ховд, Баян-Өлгий аймгийг холбох 189 км хатуу хучилттай авто зам болон “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн 103.3 км авто замын ажлын монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээнд 3.1 тэрбум төгрөг, өмнөх онуудад хэрэгжүүлсэн аймгийн төвүүдийг холбох 95 км авто замын шинэчлэлтэд 15.1 тэрбум төгрөг, авто замын засвар арчлалтад 10.0 тэрбум төгрөгийг тус тус тусгалаа.

Хоёр. Тээвэр

Монгол, Японы стратегийн түншлэлийн 2013-2017 оны дунд хугацааны хамтын ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хөшигтийн хөндийн Олон улсын нисэх онгоцны буудлын барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулахаар 10 тэрбум төгрөгийг тусгасан.

Энэ хүрээнд нисэх буудлын үйлчилгээний барилга, захиргааны барилга, дулааны станц, станцын авто зам, ачаа үйлчилгээний барилга, нисэх онгоцны буудлын үерийн далан, барилга, байгууламжийн зам талбайн тохижилт зэрэг төсөл, арга хэмжээнүүдийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэсэн. Мөн, нисэх онгоцны буудал дахь гаалийн хяналтын тоног төхөөрөмж болон хил, хяналтын байгууллагуудын байрын зураг төсөвт шаардагдах 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж нисэх онгоцны буудлын хэвийн үйл ажиллагааг хангах боломжийг бүрдүүллээ.

Түүнчлэн, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу орон нутгийн зорчигчдын тав тухтай байдлыг хангах, үйлчилгээг сайжруулах, тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд нийтийн тээврийн авто буудал, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвийг Завхан, Төв, Говьсүмбэр, Дорнод, Баянхонгор, Говь-Алтай аймгуудад үе шаттай барьж эхлүүлэхээр төлөвлөн 1.0 тэрбум төгрөгийг тусгалаа.

Гурав. Эрчим хүч

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, өсөн нэмэгдэж буй цахилгаан, дулааны эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 40.7 тэрбум төгрөгийг төлөвлөлөө.

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл, Улаанбаатар-Мандалговийн 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлын монголын талын хөрөнгө 6.4 тэрбум төгрөгийг тусгалаа.

Түүнчлэн, Улаанбаатар хотын дулааны эх үүсвэрийн найдвартай байдлыг хангах, эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж буй нийт 228 халаалтын зуухыг буулган шинэчлэхээс 68 халаалтын зуухыг төвлөрсөн дулаанд холбохоор 21.9 тэрбум төгрөгийг хуваариллаа.

УИХ-ын 2007 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем" хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийн эрчим хүчний хангамжийг найдваржуулах, эрчим хүчний шинэ эх үүсвэр болон цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэлт, сум, суурин газрыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлын хүрээнд нийт 12.3 тэрбум төгрөгийг тусгаж байна.

Дөрөв. Барилга, хот байгуулалт

Барилга, хот байгуулалтын салбарт 2018 онд 81.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгалаа. Тодруулбал, 74.6 тэрбум төгрөгийг барилга, байгууламж, 3.8 тэрбум төгрөгийг их засвар, 1.5 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулахаар тооцлоо.

Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд хот байгуулалтын салбарын бодлогын баримт бичгийг боловсруулах, аймаг, орон нутгийн орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлэх, үерийн далангийн өргөтгөл, шинэчлэлт, газрын харилцааны салбарын шинэтгэлийг эрчимжүүлэх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мөн 2018 онд Монгол Улсын хүн ам, нийгмийн ойрын ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцсэн улсын хөгжлийн зүй тогтлыг тодотгон төлөвлөж, нийгэм, эдийн засгийн хөгжлийн тогтвортой нөхцөлийг цаашид бүрдүүлэх зорилгоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон зарим аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хилийн боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлүүлэхээр холбогдох санхүүжилтийг тусгалаа.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын хувьд шинээр тавихаар төлөвлөж байгаа төмөр замын дагуу GPS-ийн сүлжээ байгуулах, 1:25000 масштабтай байр зүйн зураглал хийх ажлууд хэрэгжиж дуусна. Түүнчлэн, орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх, аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Ус” үндэсний хөтөлбөрийн 4.16-д "Ус хангамж, ариутгах татуургын тусгай зориулалтын машин механизм, тоног төхөөрөмжийн парк шинэчлэлтийг аймгийн төвүүдэд хийх" зорилтын хүрээнд зарим аймгуудад нийтийн аж ахуйн тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр 0.5 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгасан.

Түүнчлэн иргэдийн эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон төрлийн хог ангилах төвийг аймаг, нийслэлд барьж эхлүүлэхэд 2018 оны төсвийн төсөлд 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсөвлөсөн.

Тав. Хууль зүй

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад 2018 онд нийт 38.0 тэрбум төгрөгийн

хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаад байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд 2018 онд орон нутагт замын хөдөлгөөний байнгын пост барих, Хэнтий аймагт цагдаагийн газрын барилга, Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сум дундын цагдаагийн хэлтсийн барилгыг шинээр барих, нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт цагдаагийн 2 дугаар хэлтсийн байрын өргөтгөлийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Үүнээс гадна Цагдаагийн ерөнхий газарт тусгай зориулалтын тоног төхөөрөмж худалдан авах, бэлэн бус торгуулийн системийг нэвтрүүлэх, цагдаагийн байгууллагуудын автопарк, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн мэдээллийн сангийн тоног төхөөрөмжийн шинэчлэл зэрэг төслийг хэрэгжүүлэхэд 13.8 тэрбум төгрөг төсөвлөөд байна.

Хил хамгаалах ерөнхий газарт Ховд аймгийн хилийн ангийн заставын барилга, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хилийн цэргийн ангийн барилга барих, хилийн заставыг сэргээгдэх эрчим хүчээр хангах, хилийн цэргийн анги нэгтгэлүүдэд тоног төхөөрөмж худалдан авахад нийт 7.3 тэрбум төгрөгийг төсөвлөөд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт ялтныг ажлын байраар хангах хүрээнд Говьсүмбэр аймагт Ноос угаах үйлдвэр барих ажилд 2.1 тэрбум төгрөг, шийдвэр гүйцэтгэх албаны барилгын их засвар, тоног төхөөрөмж худалдан авахад 0.9 тэрбум төгрөг олгохоор тус тус төлөвлөсөн.

Зургаа. Агаарын бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт агаарын бохирдлыг бууруулах хүрээнд дараах бодлогын зорилт туссан байна. Үүнд: *нэгдүгээрт*: “Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга, байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, *хоёрдугаарт*: “Бүс нутгийн эрчим хүчний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ” гэж, *гуравдугаарт*: “Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Энэхүү бодлогын хүрээнд дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зарчим баримталлаа. Үүнд:

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 03-03 дугаар зөвлөмж, мөн Засгийн газрын “Нийслэлийн гэр хорооллын өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 214 дүгээр тогтоолын хүрээнд нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд цахилгаан дамжуулах сүлжээ, дэд станцын өргөтгөлд 15.0 тэрбум төгрөг, цахилгаан түгээх сүлжээ,

дэд станцын өргөтгөлд 24.5 тэрбум төгрөг, нийт 39.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн 20 мянган өрх айлыг эрчим хүчний найдвартай цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох ажил хэрэгжинэ.

Мөн Засгийн газрын 2017 оны 136 дугаар тогтоолын дагуу эрчим хүчний салбарын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд нийслэлд одоо ажиллаж байгаа 68 ширхэг халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг дулааны төвлөрсөн системд холбох ажлыг 22.9 тэрбум төгрөгөөр эхлүүлээд байна.

Дээрх шийдвэрүүдийн дагуу 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд нийт 62.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээр агаарын бохирдлыг бууруулах ажил үе шаттайгаар үргэлжилж байна.

Долоо. Атрын 3 дугаар аян, мах, сүүний анхдугаар аян

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Атрын 3 дугаар аян”-ыг үргэлжлүүлэх хүрээнд дараах үндсэн зорилтыг тусгасан байна. Үүнд: *нэгдүгээрт*: эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, жимс жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганын үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлэх, *хоёрдугаарт*: усны хайгуул, судалгаанд үндэслэн услалтын систем шинээр барьж, сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх, өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах, *гуравдугаарт*: Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Маж, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахаар тус тус заажээ.

Түүнчлэн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Атрын 3 дугаар аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр зоорины багтаамжийг нэмэгдүүлэх, усалгаатай талбайг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тус тус шат дараатай авч хэрэгжүүлэхээр заажээ.

Дээрх бодлогын баримт бичигт нийцүүлэн Атрын 3 дугаар аян, Мах сүүний анхдугаар аяныг үргэлжлүүлэх хүрээнд дараах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгалаа. Үүнд:

1. Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөлд 5.1 тэрбум төгрөг;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тариалангийн талбайн услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих төсөлд 2.1 тэрбум төгрөг;
3. Үрийн болон хүнсний ногоо, өвс тэжээлийн агуулах, хашаа саравч барих төсөлд 3.3 тэрбум төгрөг;

4. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, үйлдвэрлэлийн барилга, байгууламжид 5.6 тэрбум төгрөг;
5. Хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэлгийн салбарын тоног төхөөрөмжийн шинэчлэлд 4.8 тэрбум төгрөг зэрэг болно.

6.3.3. Их засвар

Өмнөх онуудын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, барилга, байгууламжийн насжилтыг уртасгах, төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор барилга, байгууламжийн их засварын ажилд нийт 74.9 тэрбум төгрөгийг төлөвлөөд байна. Тухайлбал:

Авто зам, гүүрний засвар

Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 49250 км бөгөөд үүнээс улсын чанартай авто зам 12640 км, орон нутгийн чанартай авто зам 36057 км, уул уурхайн зориулалттай авто зам 553 км, болон 12335.9 у/м гүүр байна. Үүнээс улсын чанартай 12640 км авто зам, 12335.9 у/м гүүрний ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах хүрээнд 10.0 тэрбум төгрөгийн засвар арчлалтын зардлыг тусгалаа. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын шинэчлэлд 2.9 тэрбум төгрөг, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн авто замын шинэчлэлд 2.9 тэрбум төгрөг, орон нутгийн чанартай авто зам болон аймаг, сумын төвийн авто замын засварт 9.3 тэрбум төгрөг, төмөр болон модон гүүрний засварт 1.3 тэрбум төгрөгийг тус тус тусгалаа.

Боловсрол

Ирэх онд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт нийт 19.7 тэрбум төгрөгийн их засварын ажил хийхээр төлөвлөснөөс сургууль, цэцэрлэгийн их засварын ажилд 12.0 тэрбум төгрөг, соёлын салбарын их засварт 1.9 тэрбум төгрөг, спортын салбарын их засварт 0.8 тэрбум төгрөг, нийт салбарын их засварт 5.0 тэрбум төгрөгийг тус тус тусгалаа.

Эрүүл мэнд

Улсын томоохон эмнэлгүүд болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум, дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн их засварт 5.7 тэрбум төгрөгийг тусгалаа.

Бусад

Төв, орон нутгийн төрийн болон төсөвт байгууллагын албан конторын барилгын ашиглалтын норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн дараах салбар, төсвийн ерөнхийлөн захирагч нарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах барилга байгууламжийн их засварын ажилд нийт 13.4 тэрбум төгрөг тусгалаа. Үүнд: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Монгол Улсын Шадар сайдын харьяа байгууллагууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Батлан хамгаалахын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг болно.

6.3.4. ТЭЗҮ, зураг төсөв

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, бэлтгэл ажлыг хангах, салбаруудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад нийт 31.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгалаа.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгаа, зураг төсөв хийхэд 4.5 тэрбум төгрөг төсөвлөсөн.

Монгол Улсын хэмжээнд 2018-2020 онуудад гадаад, дотоод эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, зураг төсөв боловсруулахад 16.0 тэрбум төгрөг, хилийн боомтуудын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, зураг төсөв боловсруулахад 5.0 тэрбум төгрөгийг тус тус тусгалаа.

Салбаруудын бодлогын судалгааны хүрээнд “Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийн төсөл”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, “Зүүн бүсийн холимог металлын ордод түшиглэн боловсруулах үйлдвэр” байгуулах техник эдийн засгийн үндэслэл болон Монгол орны цацраг идэвхт ашигт малтмалын хэтийн төлөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад нийт 2.3 тэрбум төгрөг тусгаад байна.

6.3.5. Концессын төсөл

Концессын гэрээний эргэн төлөлт

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар төрийн өмчийн концессын жагсаалтад тусгагдах “барих-шилжүүлэх” концессын 14 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд нийт 126.5 тэрбум төгрөгийг тусгалаа. Эдгээрээс 10 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь, 4 төсөл, арга хэмжээ 80-90 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2017 оны 4 дүгээр улиралд багтан барилга угсралтын ажил бүрэн дуусах гэрээтэй ажиллаж байна.

Концессын жагсаалт батлуулах

Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг Улсын Их Хурлаар батлуулахаар өргөн барилаа.

Уг жагсаалтад дээрх хуулийн өөрчлөлтөөс өмнө Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын дагуу эрх олгогдож гэрээ байгуулагдсан 36 төсөл, арга хэмжээг батлуулахаар тусгалаа.


Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, нэн ялангуяа 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудыг 2 ээлжид шилжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс Улаанбаатар хот болон зарим төв, суурин газруудын сургууль, цэцэрлэгийн барилга барьж ашиглалтад оруулах төсөл, арга хэмжээг шинээр нэмж тусгасан болно.

7. ТУСГАЙ САНГУУД

7.1. Засгийн газрын тусгай сангууд

Монгол Улсын 2018 оны төсвийн жилд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 3,030.1 тэрбум төгрөгийн зарлага санхүүжүүлэх бол үүний 69.3 хувь буюу 2,101.4 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгалын сангуудын зарлага, 30.7 хувь буюу 928.7 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

График № 38. Засгийн газрын зарим тусгай сангийн 2018 оны төсвийн зарлага, тэрбум.төг¹



Тусгай сангуудын нийт зардлын 36.9 хувь буюу 1,117.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 42.1 хувь буюу 1,912.6 тэрбум төгрөгийг хууль тогтоомжийн дагуу тусгай сангуудад төвлөрөх өөрийн орлого, бусад эх үүсвэрээс санхүүжихээр төсөлд тусгасан байна.

Хүснэгт №. 240. Засгийн газрын тусгай сангийн зардал, санхүүжүүлэх эх үүсвэр /тэрбум төгрөг/

№	Сангийн нэр	2016 Гүйц	2017 Тод	2018 төсөл	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
					Улсын төсөв	Өөрийн орлого	ЗГТС
1	Нийгмийн даатгалын сан	-	1,891.7	2,101.4	531.2		1,570.2
2	Нийгмийн халамжийн сан	-	472.1	609.9	354.7		255.2
3	Боловсролын зээлийн сан	89.5	116.1	119.2	119.1		
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	34.9	61.5	65.3	3.8	61.5	
5	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	26.7	44.6	40.0		40.0	
6	Мал хамгаалах сан	30.5	36.7	37.7	35.5	2.2	
7	Засгийн газрын нөөц сан	24.1	19.8	25.0	25.0		
8	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	56.7	50.6	22.8	1.4	21.4	
9	Тариаланг дэмжих сан	24.2	38.2	18.5	15.0	50.9	(47.4)
10	ШУТС	16.0	17.4	22.1	21.6	0.5	
11	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	15.6	9.0	6.8	6.8		
12	Эрүүл мэндийг дэмжих сан	-	3.0	5.0	5.0		
13	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	2.3	2.3	3.0	2.8	0.2	
14	Улсын авто замын сан	1.6	1.9	2.1		2.1	
15	Байгаль хамгаалах сан	1.9	1.9	1.9	1.9		
16	Соёл, урлаг хөгжүүлэх сан	-	1.0	1.0	1.0		

17	Олон улсын хамтын ажиллагааны сан	-	1.0	1.0		1.0
18	Спортыг дэмжих сан	-	1.0	1.0		1.0
19	Монгол судлалыг дэмжих сан	-	0.5	0.9		0.9
20	ШШГЕГ - Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	0.2	0.6	0.6		0.6
21	Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан	0.2	0.2	0.2		0.2
НИЙТ		348.9	2,379.9	3,030.1	1,116.5	179.9
Товчлол:				<i>БЗС</i>	<i>Боловсролын зээлийн сан</i>	
<i>НХС</i>	<i>Нийгмийн халамжийн сан</i>			<i>ХЭДС</i>	<i>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан</i>	
				<i>ЗХХС</i>	<i>Зэвсэгт хүчний хөгжлийн сан</i>	
<i>ЗГНС</i>	<i>Засгийн газрын нөөц сан</i>			<i>МХС</i>	<i>Мал хамгаалах сан</i>	
<i>ЖДҮХС</i>	<i>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан</i>			<i>МБСДС</i>	<i>Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан</i>	
<i>ТДС</i>	<i>Тариаланг дэмжих сан</i>			<i>ШУТС</i>	<i>Шинжлэх ухаан, технологийн сан</i>	

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу 2018 онд дараах 22 төрлийн тусгай сан үйл ажиллагаа явуулахаар тооцож төслийг боловсрууллаа.

Хүснэгт № 241. Засгийн газрын тусгай сангийн 2018 оны төсвийн зардал /сая төгрөг/

Сангийн нэр	Урсгал зардал	Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх цэвэр зээл	Нийт зардал ба цэвэр зээлийн дүн
Нийгмийн даатгалын сан	2,101,443.1			2,101,443.1
Нийгмийн халамжийн сан	609,926.0			609,926.0
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	42,448.0		22,900.0	65,348.0
Зэвсэгт хүчний хөгжлийн сан	40,000.0			40,000.0
Мал хамгаалах сан	35,776.5		(38,091.0)	(2,314.5)
Засгийн газрын нөөц сан	25,000.0			25,000.0
Боловсролын зээлийн сан	22,109.1		97,126.9	119,236.0
Тариаланг дэмжих сан	21,500.0	22,400.0	(25,400.0)	18,500.0
Шинжлэх ухаан, технологийн сан	22,114.4			22,114.4
Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	6,821.9			6,821.9
Эрүүл мэндийг дэмжих сан	5,000.0			5,000.0
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	2,500.0	500.0		3,000.0
Улсын авто замын сан	2,150.0			2,150.0
Байгаль хамгаалах сан	1,881.4			1,881.4
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	1,402.9		30,578.7	31,981.6
Соёл, урлаг хөгжүүлэх сан	1,000.0			1,000.0
Спортыг дэмжих сан	1,000.0			1,000.0
Олон улсын хамтын ажиллагааны сан	990.0			990.0
Монгол судлалыг дэмжих сан	852.0			852.0
ШШГЕГ - Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	594.0			594.0
Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан	224.0			224.0
НИЙТ	2,917,632.3	522.4	112,489.2	3,030,643.9

Засгийн газрын тусгай сангуудын нийт зарлагад хөрөнгийн буюу стратегийн зориулалтаар хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх зардалд 22.4 тэрбум төгрөг, засгийн газрын тусгай сангийн орлого болон дотоод эх үүсвэрээс олгох эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 112.5 тэрбум төгрөг, татаас шилжүүлэг болон бусад урсгал зардалд 2,917.6 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар байна.

Нийгмийн даатгалын сангийн талаарх танилцуулгыг 9 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй оруулсан тул энэ бүлэгт дэлгэрэнгүй танилцуулга оруулаагүй болно.

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2018 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 3,000.0 сая төгрөгөөр, татаас шилжүүлгийг 2,347.5 сая төгрөгөөр, урсгал зардлыг 152.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 500.0 сая төгрөгөөр тус тус тооцож төсвийн төсөлд тусгаад байна.

Хүснэгт № 242. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Бүх нийтийн үүргийн сан	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН	2,307.8	2,339.3	3,000.0
Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц (71302)	2,307.8	2,339.3	3,000.0

Хүснэгт № 243: ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

Бүх нийтийн үүргийн сан	Нийт зарлага	урсгал зардал	Үүнээс			Хөрөнгө оруулалт
			Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг	
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН	3,000.0	2,500.0	123.2	29.2	2,347.5	500.0
Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц	3,000.0	2,500.0	123.2	29.2	2,347.5	500.0

Харилцаа холбооны үйлчилгээг орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх, харилцаа холбооны сүлжээг өргөтгөх, шинэчлэх, шинээр байгуулах төсөл, хөтөлбөрүүдийг 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг 2018 онд нийт 25,000.0 сая төгрөгөөр тусгасан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу урьдчилан таамаглах, төлөвлөх боломжгүй гамшиг, осол, бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хохирлыг бууруулах, арилгах, төсөвт урьдчилан тусгах боломжгүй олон улсын гэрээ, шүүхийн шийдвэрийн улмаас төлөх төлбөр, хураамж зэрэг зайлшгүй зардлыг Засгийн газрын тогтоолыг үндэслэн санхүүжүүлэхэд тус сангийн хөрөнгийг зарцуулна.

Хүснэгт № 243. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

Засгийн газрын нөөц сан	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН	24,140.0	19,800.0	25,000.0
Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага (70202)	24,140.0	19,800.0	25,000.0

Хүснэгт № 244. ТЕЗ-ын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

Засгийн газрын нөөц сан	Нийт урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН	25,000.0	0.0	25,000.0	0.0
Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага (70202)	25,000.0	0.0	25,000.0	0.0

2017 оны төсөвт Засгийн газрын нөөц санг нийт 19.8 тэрбум төгрөг байхаар баталсан. Оны эхний 8 сарын байдлаар Засгийн газраас нийт 20.7 тэрбум төгрөгийн зардал арга хэмжээг санхүүжүүлэхээр шийдвэрлэж, үүнээс 16.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн гүйцэтгэл өндөр гарахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалтыг улс орон даяар зохион байгуулахад 7.2 тэрбум төгрөгийн санхүүжүүлсэн нь голлон нөлөөлсөн. Мөн оны эхний 8 сард

байгалийн аюулт үзэгдэл болох ой, хээрийн гал түймэр, үер, хүчтэй мөндөр болон салхи шуурга болон мал, амьтны гоц халдварт өвчний улмаас үүссэн хохирлыг барагдуулах, гамшгийн голомтод ажилласан иргэд, албан хаагчидад хууль тогтоомжид заасны дагуу томилолт, урамшууллын зардлыг нөхөн олгоход зориулж нийт 6.9 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэх шаардлага үүсээд байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн Засгийн газрын нөөц санг 14.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг төсвийн тодотголд тусгаж байгаа бөгөөд үүний 6.9 тэрбум төгрөг нь 2016-2017 онд гарсан гамшиг осол, малын гоц халдварт өвчний хохирол арилгахад, 7.2 тэрбум төгрөгийг он дуусталх хугацаанд учирч болзошгүй байгаль цаг агаарын болон бусад гэнэтийн эрсдэлийг даван туулахад зарцуулахаар төсөвлөсөн.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

Нийгмийн халамжийн сангийн зардалд нийт 609,926.0 сая төгрөг төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 137,866.9 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Үүнээс улсын төсвийн халамжийн сангийн зардалд 354,726.8 сая төгрөг, орон нутгийн халамжийн сангийн зардалд 255,199.2 сая төгрөг тусгалаа.

Нийгмийн халамжийн сан нь эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг явуулдаг.

Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцооноос үзүүлдэг асрамж, халамжийн үйлчилгээ нь хүн амын тодорхой бүлгүүдэд чиглэсэн хэлбэрээр хэрэгждэг. Өөрөөр хэлбэл халамж хүртэгчийн орлогын хэмжээг чухалчлахаас илүүтэйгээр түүний орлого олох чадварын эрсдэлээр нь, тухайлбал, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид болон хүүхэд, ял эдэлж байгаад суллагдсан иргэн, гэр оронгүй тэнэмэл иргэн гэх зэргээр ангилж хамруулдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 269 дүгээр тогтоолоор нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлох үүднээс өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох судалгааг улсын хэмжээнд зохион байгуулж, өрхүүдийг амьжиргааны түвшингээр нь хамгийн бага хэрэглээтэйгээс өндөр хэрэглээтэй гэж эрэмбэлэн “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-г байгуулсан. Энэхүү мэдээллийн санд үндэслэн хүнс тэжээлийн дэмжлэг хөтөлбөрийг амьжиргааны түвшин хамгийн бага хувийн өрхийн гишүүн иргэдэд олгож байна. Хүний хөгжил сангийн хууль хүчингүй болсонтой холбоотойгоор 2017 оноос хүүхдийн мөнгийг улсын төсвөөс олгох болсон ба өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгаанд хамрагдсан, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон босго онооноос доогуур оноотой өрхийн 0-18 хүртэлх насны хүүхдэд олгохоор төлөвлөж байна.

Цаашид Олон Улсын валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд үндэслэн нийгмийн зорилтот бүлэгт чиглүүлэх нь зүйтэй байна.

Нийгмийн халамжийн сан нь төсвөөс санхүүждэг бөгөөд 2013 оноос эхлэн зарим нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зардлыг орон нутгийн суурь зардалд тооцож орон нутгийн төсвөөс санхүүжих болсон.

Хүснэгт № 247. Сангийн эх үүсвэр: 2013-2018 төсөл /сая төгрөг/

Эх үүсвэр	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 год	2018 төсөл
Нийт халамжийн зардал	255,247.7	264,319.5	284,917.1	296,969.8	472,059.1	609,926.0
Улсын төсөв	37,943.6	35,945.9	36,729.5	35,630.6	218,540.1	354,726.8
Орон нутгийн төсөв	217,304.1	228,373.6	248,187.6	261,339.2	253,519.0	255,199.2

Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад тогтоол, журмуудын дагуу 2018 онд нийт 607,854.1 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгохоор тооцож төсөвлөсөн нь 2017 оны тодотголоос 137,838.7 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагааны бусад зардалд 2,071.9 сая төгрөг, нийт 609,926.0 сая төгрөг төлөвлөлөө. Нийгмийн халамжийн зардал нэмэгдэж буй үндсэн шалтгаан нь “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль”-ийн хүрээнд олгох тэтгэмж, мөн халамжийн тэтгэврийн нэмэгдэл, Олон Улсын валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээг 2 дахин, хүнсний талоны хэмжээг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх, нэн ядуу иргэдэд олгох тэтгэмж, халуун хоол, цайны үйлчилгээ зэрэг томоохон арга хэмжээ нөлөөлсөн байна.

Хүснэгт № 248 . Халамжийн сангийн зардлын тойм /эдийн засгийн ангилал ба арга хэмжээгээр, сая төгрөг/

Хөтөлбөр	2018 төсөл	Үүнээс	
		Бараа үйлч. бусад	Тагаас шилжүүлэг
ХАЛАМЖИЙН САН	609,926.0	2,071.8	607,854.1
Халамжийн сан	354,726.8	932.8	353,794.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	466.6	466.6	0
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	466.2	466.2	0
Халамжийн тэтгэвэр	17,381.9	0	17,381.9
Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөн/тус	6,428.4	0	6,428.4
Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж	29,449.0	0	29,449.0
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	164,160.0	0	164,160.0
Асрамжийн үйлчилгээ	138.3	0	138.3
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	1,125.0	0	1,125.0
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	96,840.0	0	96,840.0
Насны хишиг	20,500.0	0	20,500.0
Халуун хоол цайгаар үйлчлэх	1,176.9	0	1,176.9
Ядуу өрхийн тэтгэмж	16,594.5	0	16,594.5
Орон нутгийн халамжийн сан	255,199.2	1,139.0	254,060.1
Үндсэн үйл ажиллагааны зардал	428.7	428.7	0
Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	710.3	710.3	0
Халамжийн тэтгэвэр	96,493.5	0	96,493.5
Жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж	19,778.0	0	19,778.0
Нөхцөлт мөнгөн тусламж	35,181.7	0	35,181.7

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	3,330.5	0	3,330.5
Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж	23,080.3	0	23,080.3
Асрамжийн үйлчилгээ	42.5	0	42.5
Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг	42,228.6	0	42,228.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх халамжийн үйлчилгээ	12,340.7	0	12,340.7
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	21,129.9	0	21,129.9
Нийгмийн халамжийн бусад тэтгэмж, хөнгөлөлт	454.6	0	454.6

Халамжийн сан /Улсын төсөв/

Улсын төсвөөс санхүүжих нийгмийн халамжийн сангийн 2018 оны төсөвт нийт 354,726.8 сая төгрөг тусгалаа. Улсын төсвөөс алдарт эхийн одонтой эхчүүдийн тэтгэмжийн зардалд 29,449.0 сая төгрөг, ахмад дайчин, алдар цолтой ахмад настны хөнгөлөлт, урамшуулалд 6,428.4 сая төгрөг, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд 138.3 сая төгрөгийг тусгаад байна.

Ахмад дайчин, алдар цолтой ахмад настны хөнгөлөлт, урамшууллын зардал өнгөрсөн оноос 428.4 сая төгрөгөөр нэмэгдэж байгаа нь Улсын их хурлаар 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан “Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай” хуулийн 5.3.3-т “... Монгол улсын үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/, Ардын Их Хурлын депутат, Улсын бага хурлын гишүүнд сар бүр мөнгөн тусламж олгоно...” гэсэн заалт шинээр нэмэгдсэн бөгөөд уг мөнгөн тусламжийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс олгохоор заасан тул тус зардлыг тусгасан.

Халамжийн тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан индексжүүлнэ.

2018 оны нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөлд тус сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр тооцож холбогдох зардлыг тусгасан. Иймд нийгмийн халамжийн сангаас олгох халамжийн тэтгэврийг мөн адил зарчмаар нэмэгдүүлэхээр тооцоход халамжийн тэтгэвэр авах 62.7 мянган хүний авч байгаа тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд 17,381.9 сая төгрөг нэмж зарцуулахаар тооцов. Тус зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгаж халамжийн тэтгэвэр нэмэгдүүлэх ЗГ-н шийдвэр гарсны дараа холбогдох төсөв буюу орон нутгийн төсөвт хуваарилахаар төлөвлөв.

Хүснэгт № 249. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол

	Тэтгэврийн төрөл	Хамрагдах хүн /мян. хүн/	Дундаж тэтгэвэр /мян.төг/		Нэмж шаардагдах /тэрбум төг/
			2017 онд	2018 онд	
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	62.7	140.0	151.2	17.3
1.1	-Өндөр насны тэтгэвэр	2.1	140.0	151.2	0.6
1.2	-Тахир дутуугийн тэтгэвэр	44.8	140.0	151.2	12.4
1.3	-Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	15.8	140.0	151.2	4.3

Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг зорилтод бүлэгт чиглүүлнэ.

УИХ-ын 2016 оны 63 дугаар тогтоолын 1.1-т “Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур эрэмбэлэгдсэн² өрхийн хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгө олгох” гэж, мөн УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолд “хүүхдийн мөнгөн тэтгэмжийг байнгын зорилтод бүлэгт чиглүүлэх замаар нийт өрхийн 40 хувийг хамруулах, гарах хэмнэлтийг хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээ, багцын нэр төрлийг өргөжүүлэх, эмзэг бүлгийн орлого багатай өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд зарцуулах” гэж тус тус заасан.

Засгийн газраас ОУВС-тай 2016 оны 5 дугаар сард анх тохирсон Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт “хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг 2017 онд нийт хүүхдийн 60 хувьд олгох, 2018 оны 1 сарын 1-ээс эхлэн хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэн нийт өрхийн 40 хувьд³ олгох, 2019 онд нөхөж олгохоор урьд гаргасан УИХ, ЗГ-ын шийдвэрүүдийг хүчингүй болгох саналыг боловсруулан УИХ-аар 2017 оны төсвийн эхний тодотголын хамт шийдвэрлүүлсэн.

Харин Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн нийт өрхийн хүүхэд бүрд олгохоор тогтсон. Ингэхдээ 2017 оны 1 дүгээр сараас эхлэн тооцох, хүүхдийн мөнгө аваагүй 40 хувьд эхний 6 сард ногдох мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох, харин 7 дугаар сараас бүх хүүхдэд олгохоор шийдвэрлэсэн.

ОУВС-аас 2017 оны 8 дугаар сард Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээг хийж 2018 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 60 хувийг хамруулахаар тохирсны дагуу ирэх жилд нийт 684.0 мянган хүүхдэд олгохоор тооцож 164,160.0 сая төгрөг тусгав.

Хүснэгт № 250. 2018 онд олгох хүүхдийн мөнгөний зардлын тооцоолол

Он, сар	Хүүхдийн тоо	Олголт, сая төг
2018-01	668,820	13,376.40
2018-02	671,580	13,431.60
2018-03	674,340	13,486.8
2018-04	677,100	13,542.0
2018-05	679,860	13,597.2
2018-06	682,620	13,652.4
2018-07	685,380	13,707.6
2018-08	688,140	13,762.8
2018-09	690,900	13,818.0
2018-10	693,660	13,873.2
2018-11	696,420	13,928.4
2018-12	699,180	13,983.6
Нийт дүн	684,000	164,160.00

Нэн ядуу, эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийг нэмэгдүүлнэ.

Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу иргэдэд олгох

² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/152 дугаар тушаалын 1-т “Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр бэлэн мөнгө хэлбэрээр хүүхдийн мөнгө олгох босго оноог амьжиргааны түвшиний үнэлгээний 502,567 болон түүнээс доош оноогоор тогтоосугай” гэж заасан байна.

³ Энэ нийт хүүхдийн 50 орчим хувь болдог

тэтгэмж дэмжлэгийг нэмэгдүүлэхээр заасны дагуу зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээг дан ганц хүнсний хангамжийн хөтөлбөрөөр хязгаарлахгүйгээр бусад үйлчилгээг хамтад нь хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж нийт 17,771.4 сая төгрөгийг тусгасан.

Хүснэгт № 251. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэхэд нэмж шаардагдах хөрөнгө

№	Тэтгэмж, тусламжийн төрөл	Шинээр нэмэгдэх хүний тоо /мян.хүн/	Сард олгох тэтгэмж болон дэмжлэг /төг/	Нэмж зарцуулах хөрөнгө /тэрб.төг/
НИЙТ		74.4	-	17.8
1	Хүнс тэжээлийн дэмжлэг авч байгаа нэн ядуу өрх, иргэдэд нөхцөлт мөнгөн тусламж олгох	73.6	15,000	16.6
2	Тэнэмэл, орон гэргүй иргэдэд халуун хоол, цайны зардал	0.8	9,500	1.2

Нийгмийн халамжийн тухай хуульд 2012 онд тусгасан боловч санхүүжилтгүйн улмаас өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу иргэдэд тэтгэмж олгох, тэнэмэл орон гэргүй иргэдэд Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.2.2-д заасан халуун хоол, цайгаар үйлчлэх зардлыг тусгав. Ингэхдээ олон улсын нийтлэг жишгээр энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны иргэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан байх, сургуулийн насны хүүхдүүдээ сургуульд бүрэн хамруулсан байх нөхцөлийг тавьж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

“Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.

Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 3.3.14-т “гурав хүртэлх насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөр, Өрх толгойлсон эх/эцэг/-ийн нийгмийн хамгааллын хуулийг батлан хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль” батлагдаж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжинэ.

Хүснэгт № 252. Цалинтай ээж хөтөлбөрийн хамрах хүрээ, зарцуулах хөрөнгө /мян. хүн, тэрбум төгрөгөөр/

Хуулийн заалт	Тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Зарцуулах хөрөнгө	Тайлбар
НИЙТ		249.6	142.2	-
5.1.1.	Жирэмсэн эхийн тэтгэмж	98.0	19.8*	Одоо олгож байгаа /ОН/
5.1.2.	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	135.0	81.0	Шинээр олгоно /УТ/
5.1.3.	Ихэр хүүхдийн тэтгэмж	0.1	1.7	Одоо олгож байгаа/ОН/
5.1.4.	Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	16.5	15.8	Шинээр олгоно /УТ/

**Нийгмийн халамжийн тухай хуулиар энэ зардалд 2017 оны төсөвт 43.7 тэрбум төгрөг зарцуулагдаж байна.*

Шинээр батлагдсан дээрх хуулийн дагуу 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр, түүнчлэн гурав болон түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр тэтгэмж олгох ба тэтгэмжийн хэмжээг хүүхдээ асарч байгаа эхэд сарын 50.0 мянган төгрөг буюу улиралд 150.0 мянган төгрөг, өрх толгойлсон эх/эцэгт

улиралд 240.0 мянган төгрөгөөр буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нийт 96.8 тэрбум төгрөг олгохоор байна. Харин халамжийн сангаас олгох жирэмсэн эхийн тэтгэмж шинэ хуулийн дагуу 2017 онтой харьцуулбал ирэх онд 23.9 тэрбум төгрөгөөр буурах тул цалинтай ээж хөтөлбөрт нэмж шаардагдах зардлын цэвэр өөрчлөлт 72.8 тэрбум төгрөг байхаар төсөвлөв.

Ахмад настны насны хишиг

Монгол Улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, ахмад настны тоо сүүлийн 10 жилд 21.9 хувиар өссөн бөгөөд 20 жилийн дараа ахмад настны нийт хүн амд эзлэх хувь хэмжээ 2 дахин нэмэгдэхээр байна. Ахмад настны тоо нэмэгдэх хирээр насжилтад бэлтгэх, ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах шаардлага гарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрөөс ахмадын талаар баримтлах бодлого гаргаж, “Ач санах” хуулийг батлуулж, азай буурлууддаа “Насны хишиг” олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж заасан.

Иймд эдийн засаг, төсөв санхүүгийн хүндрэлтэй нөхцөлд байгаа хэдий ч ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний орлогын баталгааг хангах зорилгоор насны хишиг олгох эрх зүйн орчныг бүрдүүлж “Ахмад настны тухай хууль”-ийг батлуулан 2017 оноос хэрэгжилтийг амжилттай зохион байгуулж байна.

Энэхүү хуулийн хүрээнд 65 ба түүнээс дээш насны ахмад настанд жилд 2 удаа 50.0 мянгаас 250.0 мянга хүртэлх төгрөгийн насны хишгийг олгохоор тооцож нийт 20,500.0 сая төгрөг буюу өнгөрсөн оны түвшинд зардлыг тооцож тусгалаа.

Хүснэгт № 253 . Насны хишиг

Нас	Давтамж	Мөнгөн дүн /төг/	Хүний тоо /мян хүн/	Нийт зардал /тэрбум төгрөг/
65-69	Жилд 2 удаа	50,000	43.1	4.3
70-79		80,000	57.6	9.2
80-89		150,000	18.7	5.6
90+		250,000	2.5	1.4
Нийт			121.9	20.5

Дээрх хуулийн хүрээнд жил бүр хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдөр буюу цагаан сар болон Улсын их баяр наадмыг тохиолдуулан ахмад настай иргэдэд насны хишиг мөнгөн тэтгэмжийг жилд 2 удаа олгож байна.

Мөн хуулийн хүрээнд ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна тэдний хуримтлуулсан мэдлэг, ур чадвар, туршлагыг хойч үед нь өвлүүлэн үлдээх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор шинэ төрлийн үйлчилгээг хуульд шинээр оруулсан.

УИХ-ын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан “Ахмад настны тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зөвлөгөө өгөх, өдрийн, явуулын, сайн дурын зэрэг үйлчилгээг иргэн, аж ахуй нэгж, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэхээр тус хуульд шинээр тусгасан.

Дээрх хуулийн 13.3 дахь хэсэгт тус үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр заасан тул ахмад настны хөгжил оролцоог хангах

зорилгоор “Ахмад настны тухай” хуульд тусгасан шинэ төрлийн үйлчилгээг санхүүжүүлэхэд 1,125.0 сая төгрөгийн зардлыг тусгалаа.

Мөн халамжийн сангийн улсын мэдээллийн маягт хэвлэхэд 198.0 сая төгрөг, халамжийн мэргэжилтнүүдийн хичээл үйлдвэрлэлийн зардал 217.8 сая төгрөг, өрхийн мэдээллийн нэгдсэн системийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд зориулан 466.2 сая төгрөгийг тусгав.

Хүснэгт № 254. Улсын төсвөөс олгох халамжийн сангийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	33,901.6	218,540.1	354,726.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	184.7	466.6	466.6
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	328.3	466.2	466.2
80701 Халамжийн тэтгэвэр	0.0	0.0	17,381.9
80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад настны тус/хөнг	4,744.9	6,000.0	6,428.4
80705 Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж	28,513.6	29,449.0	29,449.0
80706 Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	0.0	161,520.0	164,160.0
80710 Асрамжийн үйлчилгээ	130.0	138.3	138.3
80714 Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	0.0	0.0	1,125.0
80717 Нийгмийн халамжийн бусад тэтгэмж, хөнгөлөлт	0.0	0.0	96,840.0
80718 Насны хишиг	0.0	20,500.0	20,500.0
80719 Халуун хоол цайгаар үйлчлэх	0.0	0.0	1,176.9
80720 Ядуу өрхийн тэтгэмж	0.0	0.0	16,594.5
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	33,901.6	218,540.1	354,726.8
31 Улсын төсвөөс санхүүжих	33,901.6	218,540.1	354,726.8
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	33,901.6	218,540.1	354,726.8
08572 Халамжийн сан	33,901.6	218,540.1	354,726.8

Орон нутгийн халамжийн сан

Орон нутгийн халамжийн сангийн 2018 оны төсвийг нийт 255,199.2 сая төгрөг байхаар тооцож төсвийн төсөлд тусгасан нь 2017 оны тодотголоос 1,680.2 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Орон нутгийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр, жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж, нөхцөлт мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ, хүнс тэжээлийн дэмжлэг, ХБИ-ийн тэтгэмж, ахмад настны тэтгэмж зэрэг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 2013 оноос эхлэн санхүүжүүлж байна.

2018 оны орон нутгийн халамжийн сангийн зардалд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь:

1. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх

Нийгмийн халамжийн тухай хуульд заасан хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай буюу хамгийн бага орлоготой 27,0 мянган өрхийн 148.6 мянган иргэн хамрагдаж, жилд 17.9 тэрбум төгрөг /сард том хүн 13000 төгрөг, хүүхэд 6500 төгрөг/ зарцуулж байна.

Олон Улсын валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн эхний шатны үнэлгээний хүрээнд 2017 оны 4 дүгээр улирлаас эхлэн Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээг 2 дахин, хүнсний талоны хэмжээг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэхээр тохирсны дагуу нэмж шаардагдах хөрөнгийг хүүхдийн мөнгө хөтөлбөрийн хэмнэлтээс шилжүүлэхээр тооцлоо.

Хүснэгт № 255. Хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд нэмж шаардагдах хөрөнгө

№	Тэтгэмж, тусламжийн төрөл	Шинээр нэмэгдэх хүний тоо /мян.хүн/	Сард олгох тэтгэмж болон дэмжлэг /төг/	Нэмж зарцуулах хөрөнгө /тэрб.төг/
1	Хүнсний эрхийн бичиг /Хамрах хүрээг 2 дахин, мөнгөн дүнг 20 хүртэлх % нэмэгдүүлэх/	288.8	том хүн 16,000 хүүхэд 8,000	24.2

2. Жирэмсэн эхийн тэтгэмж

Хүснэгт № 256. Цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийн халамжийн сангаас хасагдах хөрөнгө /сая төгрөгөөр/

№	Тэтгэмж, тусламжийн төрөл	2017 батлагдсан		2018 төлөвлөгөө		Нийт хасагдах
		Хүний тоо	Нийт төсөв	Хүний тоо	Нийт төсөв	
1	Жирэмсэн эхийн тэтгэмж	98,309	43,736.6	98,890	19,778.0	23,958.6

Жирэмсэн эхийн тэтгэмжийг 2018 оны төсөвт 19,778.0 сая төгрөгөөр тусгасан нь өнгөрсөн оноос 23,958.6 сая төгрөгөөр буурч байна. Зардал буурсан нь УИХ-ын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль” батлагдаж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбоотой байна. Хуулийн 6.1.Жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эх сар бүр тэтгэмж авах эрхтэй болсон тул хуучин хуулийн дагуу төрснөөс хойш олгож байсан 7 сарын тэтгэмжийн зардал хасагдаж байна.

Хүснэгт № 257. Орон нутгийн халамжийн сангийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	7,755.1	253,519.0	255,199.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3.6	402.4	428.7
80224 Зөвлөл, хороо, комиссын ажлын хөлс	34.5	742.4	710.3
80701 Халамжийн тэтгэвэр	3,939.3	101,819.8	96,493.5
80702 Жирэмсэн болон хөхүүд эхийн тэтгэмж	1,063.1	43,736.6	19,778.0
80707 Нөхцөлт мөнгөн тусламж	867.1	34,215.7	35,181.7
80708 Олон нийтийн оролцоо	27.7	1,907.5	3,330.5
80709 Амьжиргааг дэмжих	700.8	21,854.0	23,080.3
80710 Асрамжийн үйлчилгээ	0.0	42.5	42.5
80711 Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг	409.6	17,980.5	42,228.5
80713 ХБИ-д үзүүлэх нийгмийн халамж	214.5	11,731.8	12,340.7
80714 Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	494.8	18,631.3	21,129.9
80717 Нийгмийн халамжийн бусад	0.0	454.6	454.6

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

2018 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийт зарлагыг 65,348.0 сая төгрөгөөр үүнээс зөвлөл хороо комиссын зардалд 198.0 сая төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлд 22,900.0 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 42,250.0 сая төгрөг тусгалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2017 онд 61,498.0 сая төгрөг төвлөрөхөөс оны эхний 8 сарын байдлаар гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрөөс 14,024.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 545.7 сая төгрөг, малчин, хувиараа бизнес эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд олгосон жижиг зээлийн эх үүсвэрээс 17,000.0 сая төгрөг, 2016 оны жилийн эцсийн үлдэгдлээс 40,908.1 сая төгрөг, Өмнөговь аймгийн орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хуваарилсан 214.0 сая төгрөг, 2016 онд хэрэгжсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй

санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 2,248,9 сая төгрөг болон бусад эх үүсвэрээс 50.5 сая төгрөг нийт 74,992.1 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрөөд байна.

Иймд 2017 оны орлогын хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн 2018 онд тус санд 61,498.0 сая төгрөг төвлөрүүлж, улсын төсвөөс олгох санхүүжилтийг 3,850.0 сая төгрөгөөр төлөвлөлөө. Орлогын төлөвлөгөөнд гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрөөс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуримтлуулах орлогыг 45,184.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 400.0 сая төгрөг, 2017 онд хэрэгжсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг 2,800.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлийг 2,114.0 сая төгрөг, 2015 онд Төрийн банк болон Капитал банкаар дамжуулан малчин, хувиараа бизнес эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд олгосон жижиг зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт 11,000.0 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Хүснэгт № 258. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны эх үүсвэр /сая төгрөг/

№	Эх үүсвэр	2018 төсөл
1	Оны эхний үлдэгдэл	2,114.0
2	Гадаадын иргэнийг ажиллуулсан төлбөрийн орлого	45,184.0
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр	400.0
4	Жижиг зээлийн эргэн төлөлт	11,000.0
5	Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	2,800.0
6	Улсын төсвийн санхүүжилт	3,850.0
Нийт эх үүсвэрийн дүн		65,348.0

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2016 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн №04 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 240,0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн.

Энэхүү тогтоолын хүрээнд гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогоор санхүүждэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хувьд гадаадын ажиллах хүчний тоо буурч байгаа боловч орлого буурахгүй байх үндэс болж байна. Учир нь “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай” хуулийн дагуу аж ахуй нэгж, байгууллагууд гадаадын иргэн авч ажиллуулсныхаа 1 сарын хөлсөнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлдөг. Иймд 2018 онд гадаадаас ажиллах ажиллагсдын ажлын байрны төлбөрийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр буюу 480.0 мянган төгрөгөөр, ажиллах дундаж хугацааг 4 сараар тооцсон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарлага

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор 2017, 2018 онд хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байрыг дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх 5 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан. Эдгээр 5 хөтөлбөрөөс гадна ажилгүй иргэдийг ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгон, ажлын байртай болгох, нийтийг хамарсан ажил зохион байгуулж ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах, хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих бусад шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр нийт 42,250.0 сая төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлд 22,900.0 сая төгрөгийг төлөвлөсөн.

Хүснэгт № 259. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зардал зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (72102)	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	34,916.7	61,498.0	65,348.0
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.0	198.0	198.0
80820 Бусад тусламж, дэмжлэг	10,149.3	0.0	0.0
81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	0.0	20,000.0	22,900.0
82616 ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл	24,767.4	41,300.0	42,250.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	34,916.7	61,498.0	65,348.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	34,916.7	61,498.0	61,498.0
31 Улсын төсвөөс санхүүжих	0.0	0.0	3,850.0

Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 40.0 мянгаас доошгүй ажлын байрны болон ажил хайгчдын захиалгын мэдээллийг шинээр нэмж байршуулан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох болон зөвлөгөө өгөх үйлчилгээнд давхардсан тоогоор 80.0 мянган иргэн, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход нь туслах зэрэг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд нийт 8.0 мянган иргэн, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 9.4 мянган иргэн хамруулж, банкнуудаар дамжуулан бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт 9.0 мянган иргэн, 300 аж ахуй нэгжид 20,000.0 сая төгрөгийн зээлийг гаргаж, давхардсан тоогоор ажил олоход хүндрэлтэй 5.0 мянган иргэнийг хөтөлбөрт хамруулан, 40.0 мянга гаруй ажилгүй иргэнийг байнгын ажлын байраар, 10.0 мянган иргэнийг түр ажлын байраар хангана.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САН

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих санд 2018 онд 6,821.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 2,132.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь хүүхдийн тооны бууралт болон 2016 оны хувьсах зардлын өглөг 1,900.0 сая төгрөг 2017 оны төсөвт нэмж тусгагдсан байсантай холбоотой.

Хүснэгт № 260. Төрийн болон хувийн МСҮТ суралцагчдын тоо, нийт зардал

Төрөл	Суралцагчдын тоо	Нийт зардал (сая төг)
Төрийн өмчит МСҮТ /37/	26,908	46,569.6
Хувийн МСҮТ /43/	16,031	6,821.9

Тус сангаар дамжуулан санхүүжүүлэх хичээл үйлдвэрлэл, дадлагын зардлыг төлөвлөхдөө төрийн өмчийн бус политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд, их, дээд сургуулиудын харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад суралцаж байгаа суралцагчдын тоог үндэслэв. Мэргэжлийн боловсрол сургалтыг байгууллагаас ирүүлсэн 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан элсэлтийн хяналтын тоонд үндэслэн тухайн жилийн элсэлт, төгсөлтийн тоо, төсвийн жилд суралцах суралцагчийн дундаж тоог гаргаснаар нийт 41 хувийн сургуульд 16,031 суралцагчтай байхаар тооцож хувьсах зардлыг төлөвлөв.

Хүснэгт № 261. МБСДС-ийн зардал, зориулалтаар /сая төгрөг/

Хөтөлбөр: Мэргэжлийн боловсрол (71804)	2016 гүйц	2017 год	2018 төсөл
Зориулалт арга хэмжээгээр	15,586.5	8,954.5	6,821.9

80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,447.5	8,954.5	6,821.9
81808	МСҮТ-д суралцагсад сар тутам олгох тэтгэлэг	10,139.0	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		15,586.5	8,954.5	6,821.9
31	Улсын төсвөөс санхүүжих	5,447.5	8,954.5	6,821.9
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	10,139.0	0.0	0.0

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН

Байгаль хамгаалах сан нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Үндэсний хөгжлийн цогц бодлого, салбарын дунд хугацааны стратегийн зорилттой уялдуулан байгаль орчны үндэсний хөтөлбөрүүдэд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээхтэй холбоотой зорилт, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг тогтворжуулах, байгалийн баялаг, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлдэг.

“Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 2 дэх заалтын дагуу Байгаль хамгаалах сан нь байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах, байгаль орчныг хамгаалах, хянах, судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэмжих багаж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

Хүснэгт № 262. Байгаль хамгаалах сангийн 2012-2017 оны төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/

№	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	2012	5,910.3	4,912.9	83.1
2	2013	5,729.9	5,653.5	98.6
3	2014	6,129.9	4,829.9	78.6
4	2015	2,678.2	1,780.3	66.5
5	2016	1,896.0	1,882.7	99.3
6	2017 оны эхний 8 сар	1,880.4	538.8	28.7

Байгаль хамгаалах сангийн 2018 оны төсвийн төслийг 2017 оны төсвийн тодотголын түвшинд буюу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 1,650.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардалд 230.6 сая төгрөг нийт 1,881.4 сая төгрөг төлөвлөж, тусгалаа.

Хүснэгт № 263. (Байгаль хамгаалах сан) зардлын хуваарилалтын санал /сая төгрөг/

Код	ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН: Байгаль хамгаалах сан	2016	2017	2018
		Гүйцэтгэл	Тодотгол	Төсөл
Зардлын зориулалт-арга хэмжээ		1,882.7	1,880.4	1,881.4
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	216.1	229.6	230.6
817000	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	1,666.6	1,650.8	1,650.8
Санхүүжүүлэх эх үүсвэр		1,882.7	1,880.4	1,881.4
31	Улсын төсвөөс санхүүжих	1,882.7	1,880.4	1,881.4

Хүснэгт № 264. ТЕЗ-ын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлын тойм /сая төгрөг/

Засгийн газрын нөөц сан	Нийт урсгал	Үүнээс
-------------------------	-------------	--------

	зардал	Цалин НДШ бусад	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН	1,881.4	230.6	1,650.8	0.0
Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага (70202)	1,881.4	230.6	1,650.8	0.0

Байгаль хамгаалах сангаас 2018 онд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

ЗГҮАМХ-ийн Зорилт	Үндэслэл/ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний заалт	Төсөв
4.2.4	Усны нөөцийг хамгаалж, хомсдоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулж ус хангамжийг нэмэгдүүлнэ.	580.8
4.2.6	Доройтолд орж талхлагдсан, уул уурхайн олборлолтын улмаас нөхөн сэргээгдээгүй орхигдсон /эвдрэлд орсон, бохирдсон/ газрыг нөхөн сэргээнэ.	670.0
4.1.7	“Тогтвортой хөгжлийн боловсрол” олгох ажлын хүрээнд эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгож, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.	300.0
4.1.6	Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ /УБ, аймгийн төвүүд, хүн ам төвлөрөн суурьшсан газрууд/.	100.0
НИЙТ ДҮН		1,650.8

АВТО ЗАМЫН САН

“Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчигч тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс авто зам ашигласны төлбөр хураах цэгийн үйл ажиллагаанд мөрдөх журам”-ыг мөрдөн хяналт тавьж 19 цэгт үйл ажиллагааг зохион байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгсэл эзэмшигчид болон төлбөр хураах цэгийн төлбөр хураагч нарын аюулгүй байдлыг ханган ”Авто замын тухай” хуульд зааснаар улсын авто замын санд орлого төвлөрүүлэн ажилладаг.

Замын сангийн орлого, эх үүсвэр


Замын сангийн орлого нь Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчсоны төлбөр хураах 19 цэгийн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.

Хүснэгт № 265. Сангийн үйл ажиллагааны орлого /сая төгрөг/

Замын сан	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017 ХБГ
Батлагдсан төлөвлөгөө	884.0	896.9	1,076.2	1,410.0	2,350.0	2,900.0	3,000.0	5,300.0
Гүйцэтгэл	1,094.1	1,418.8	2,205.0	2,300.4	2,901.5	3,057.8	4,464.7	5,300.0

2016 онд Засгийн газрын 103 дугаар тогтоолоор олон улсын болон улсын чанартай зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон нь 2016 оны гүйцэтгэл болон 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл нь өмнө жилүүдийн гүйцэтгэлээс эрс өссөн үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн.

График № 39: Сангийн үйл ажиллагааны орлого / сая төгрөг/



Замын сангийн зарлага

Авто зам хөтөлбөрийн 2018 оны урсгал зардлыг 2017 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 249.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 2,150.0 сая төгрөгөөр төсөвлөсөн.

Хүснэгт № 266: Замын сангийн зардал /сая төгрөг/

ХӨТӨЛБӨР: Авто зам (71101)	2016 Тод	2017 Тод	2018 төсөл
Зориулалт, арга хэмжээгээр	1,630.5	1,900.8	2,150.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,630.5	1,900.8	2,150.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,630.5	1,900.8	2,150.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,630.5	1,900.8	2,150.0

Зам тээврийн сайдын баталсан "Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах цэгийн зохион байгуулалт, орлогыг төвлөрүүлэх, зарцуулах үйл ажиллагааны журам"-аар төлбөр хураах цэгүүдийн үйл ажиллагааны урсгал зардлыг нийт төвлөрүүлж буй орлогын 40 хувиар санхүүжүүлэхээр заасан байдаг.

Үүний дагуу 2018 онд төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг 5,400.0 сая төгрөгөөр төсөвлөж төлбөр хураах цэгүүдийн үйл ажиллагааны урсгал зардлыг 2,150.0 сая төгрөгөөр тусгасан.

Хүснэгт № 267: Замын сангийн зардлын тойм /сая төгрөг/

ЗАМЫН САН	Урсгал зардал	Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
НИЙТ:	2,150.0	0.0	2,150.0	0.0
Авто зам (71101)	2,150.0	0.0	2,150.0	0.0

ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.16, 26.3-г заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 19-ны 110 дугаар тогтоолоор баталсан Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж Монгол иргэд хилийн чанадад ямар нэг гэмт хэрэгт холбогдох, өртөх, хохирох тохиолдлыг багасгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг

өргөжүүлэх замаар гэмт хэрэг, зөрчилд холбогдох Монгол Улсын иргэдийн тоог багасахыг зорьж ажиллана.

Хүснэгт № 268. Сангийн төсөв /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц	2017 Тод	2018 СЯ Хянасан
ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН	222.8	224.0	224.0
Гадаад улс оронд байгаа монгол иргэдэд туслах (70304)	222.8	224.0	224.0
80820 Бусад тусламж, дэмжлэг	222.8	224.0	224.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	222.8	224.0	224.0
31 Улсын төсвөөс санхүүжих	222.8	224.0	224.0

Сангийн урсгал зардлыг нийт 224.0 сая төгрөгөөр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд 2017 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Амь насанд нь аюул учирсан иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлж эх оронд нь буцаах;
- Ял эдэлж байгаад суллагдсан болон төлбөрийн чадваргүй болсон иргэдийг эх оронд нь буцаах;
- Хилийн чанадад ял эдэлж байгаа иргэдийг эргэх;
- Нас барсан иргэдийн шарил, чандрыг эх оронд буцаах болон тухайн улсад нутаглуулах;
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд хилийн чанадад хүний наймааны хохирогч болсон иргэдийг түр хамгаалах байраар хангах, үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаахтай холбогдсон бүхий л арга хэмжээг авах;
- Гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн байгуулсан сайн дурын холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаар төлөвлөөд байна.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САН

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалыг мөрдлөг болгон өөрийн орны ардчилсан үйл явцын туршлагаас хуваалцах, олон улсын тавцанд нэр хүнд, байр сууриа бэхжүүлэх, гадаадын зарим улстай хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтыг дипломат үйл ажиллагааны зөөлөн хүчний бодлогоор дамжуулан хэрэгжүүлэхийг зорьж ажиллана.

Хүснэгт № 269. Сангийн төсөв /сая төгрөг/

Хөтөлбөр	2016 Гүйц УТ ОН	2017 Тод 8 сар хуваарь	2018 СЯ Хянасан
Зориулалт арга хэмжээгээр	14.2	990.0	990.0
82902 Гадаад харилцааг эдийн засагжуулах	14.2	990.0	990.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	14.2	990.0	990.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	14.2	990.0	990.0

Олон улсын хамтын ажиллагааны сангийн урсгал зардал 1,000.0 сая төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос дараах нийгмийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Үүнд:

- Олон улсын хамтын ажиллагааны сангийн зардлаар ардчилал, хүний эрх, сайн засаглалын чиглэлээрх олон улсын байгууллага, механизмд үндэсний экспертүүдийг ажиллуулна.
- Сангийн хөрөнгөний эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс буцалтгүй тусламж, хандив авах ажлыг зохион байгуулна.

- Төсвөөс гадна гадаад, дотоодын хандивлагч нарын «клуб» бий болгож, Сангийн үйл ажиллагааг улам далайцтай болгох санхүүгийн нэмэлт эх үүсвэртэй болно.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САН

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.2.19 дэх заалтад эрдэм шинжилгээ, судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлэхээр заасныг харгалзан тус сангийн эрдэм шинжилгээний зардлыг 2018 оны төсөвт 15.0 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө.

Шинжлэх ухаан, технологийн сан нь онолын суурь судалгаа, шинжлэх ухаан, технологийн төслийг хэрэгжүүлэх, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах зарцуулж, хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

Түүнчлэн “Төсвийн төвлөрүүлэн захирагчийг батлах тухай” Засгийн газрын 207 дугаар тогтоолын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын зарим эрдэм шинжилгээний байгууллагуудын төвлөрүүлэн захирагч байхаар заасны дагуу эдгээр байгууллагуудын эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг “Шинжлэх ухаан, технологийн сангийн тухай” Засгийн газрын 1993 оны 192 дугаар тогтоолын хавсралтаар баталсан шинжлэх ухаан, технологийн сангийн дүрмийн хүрээнд санхүүжүүлж байна.

Хүснэгт № 270. Хөтөлбөрийн зардлын хураангуй /сая төгрөг/

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САН	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	16,008.7	17,424.7	22,114.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	7,171.7	6,900.3	6,701.9
80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	8,375.8	10,119.4	15,000.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	246.2	300.0	300.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	215.0	105.0	112.5
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	16,008.7	17,424.7	22,114.4
31 Улсын төсвөөс санхүүжих	15,662.9	16,965.9	21,655.3
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	345.8	459.1	459.1

Шинжлэх ухаан, технологийн сангийн зардлын өсөлтийн үндсэн шалтгаан нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.19 дэх заалтад эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлнэ гэж заасны дагуу эрдэм шинжилгээ судалгааны зардлыг 2017 оны тодотгосон төсвөөс 4,880.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2018 оны төсвийн төсөлд 15,000.0 сая төгрөг байхаар төсөвлөсөнтэй холбоотой байна.

Шинжлэх ухаан технологийн сангаас 2014 оны гүйцэтгэлээр 191 төслийн 10.6 тэрбум төгрөг, 2015 оны гүйцэтгэлээр 154 төслийн 5.6 тэрбум, 2016 оны гүйцэтгэлээр 188 төслийн 8.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САН

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталснаар Боловсролын зээлийн санг байгуулсан. Тус сангийн хөрөнгө, эх үүсвэрээр оюутан суралцагчид олгох

сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулахаар хууль тогтоомжоор зохицуулсан байна.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.2.20 дахь заалтад “Боловсролын зээлийн сан” байгуулж, оюутан, суралцагчид зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээг үзүүлэх тогтолцоог ил тод, нээлттэй болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж заасныг үндэслэн 2017 оны төсвийн төсөлд нийт 119.2 тэрбум төгрөгийг тооцож төсөвлөлөө. Үүнд:

1. Төрийн албан хаагчдын нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцах тухай Засгийн газрын 2000 оны 201 дугаар тогтоолын дагуу 164 суралцагчид олгох сургалтын төлбөрт 147.4 сая төгрөг;
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 78 тоот зарлиг, Засгийн газрын 2013 оны 271 дугаар тогтоолоор дэлхийн шилдэг 100 их сургуульд тэнцсэн 295 суралцагчийн сургалтын төлбөрийн зээлд 14.5 тэрбум төгрөг;
3. Засгийн газрын 2012 оны 19 дугаар тогтоолын дагуу дотоодын их дээд сургуульд суралцдаг нэг өрхийн 3 хүүхэд нь их, дээд сургуульд суралцдаг өрхийн нэг, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эх нь хөгжлийн бэрхшээлтэй болон 6999 суралцагчдад олгох буцалтгүй тусламж 12,553.8 сая төгрөг;
4. Багш мэргэжлээр бэлтгэдэг төрийн өмчийн их дээд сургуульд 650-750 оноотой элсэгчийн сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноотой элсэгчийн сургалтын төлбөрийг 100 хувь олгохоор заасны дагуу 2208 суралцагчид 2,783.7 сая төгрөг;
5. Засгийн газрын 2011 оны 102 дугаар тогтоолын дагуу хөдөө орон нутагт байх гэртээ өвлийн амралтаараа ирж очих 10922 оюутны замын зардалд 1,033.4 сая төгрөг;
6. Багш мэргэжлээр бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа хөдөө орон нутагт багшлах дадлага хийх суралцагчдад 1762 суралцагчид олгох багшлах дадлагын тэтгэмжид 535.0 сая төгрөг;
7. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 175/108 тоот тушаалаар батлагдсан гадаадаас монголын их дээд сургуульд суралцаж байгаа 174 суралцагчдын амьжиргааны тэтгэлэгт 867.0 сая төгрөг;
8. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын болон гадаадын их, дээд сургуульд суралцагсад болон Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд нийт 75,326.9 сая төгрөг;
9. Боловсролын зээлийн сангийн захиргааны төсвийг 2018 онд 287.0 сая төгрөг байхаар тус тус төсөвлөлөө.

Хүснэгт № 271. Сангийн зардлын хураангуй /сая төгрөг/

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САН	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Боловсрол, шинжлэх ухаан (71800)	89,198.0	116,112.6	119,236.0
Дээд боловсрол (71803)	89,198.0	116,112.6	119,236.0
Зориулалт арга хэмжээгээр	89,198.0	116,112.6	119,236.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	223.6	306.6	287.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	0.0	14.6	14.5
80805 Төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөр	203.4	206.5	147.4
81811 Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох зээл	5,464.4	7,300.0	7,300.0
81812 Гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг	453.9	734.7	867.0
81813 Нэн ядуу, малчин, 3 хүртэл-тэтгэлэг	6,991.3	8,553.8	12,553.8
81814 ОН-с суралцаж буй оюутнуудын замын зардлын хөнгөлөлт	1,085.9	1,033.4	1,033.4
81822 Гадаад суралцагсдын зардал	2,842.4	3,742.4	3,887.3
81826 Багш мэргэжлээр суралцагсдад олгох тэтгэлэг	1,000.0	3,189.0	2,783.7
81828 Орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг	535.0	1,204.7	535.0

81838	Дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын тэтгэлэг	16,612.9	14,500.0	14,500.0
81846	Оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл	8,000.0	75,326.9	75,326.9
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		89,198.0	116,112.6	119,236.0
31	Улсын төсвөөс санхүүжих	89,198.0	116,112.6	119,236.0

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН САН

“Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-гийн зорилго нь батлан хамгаалах салбарын санхүүгийн нөөц, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны орлогуудыг нэгтгэн төвлөрүүлж, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах, энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх, цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2018 оны төсвийн төслийг 40,000.0 сая төгрөгөөр төсөвлөлөө.

Хүснэгт № 272. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй зардлын тойм / зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	Нийт урсгал зардал	Үүнээс:		
		Цалин, НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН САН	40,000.0		40,000.0	
Зэвсэгт хүчний үйл ажиллагаа хөтөлбөр	40,000.0		40,000.0	

Зэвсэгт хүчний хөгжлийн санд 2012-2016 онд нийт 157,444.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл 110,484.6 сая төгрөг болж, 70.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 2016 онд 40,000.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 39,249.9 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 98.1 хувьтай байна.

Орлогын эх үүсвэрийг 2016 онд бүрдүүлсэн байдлыг авч үзвэл, нийт дүнд энхийг дэмжих ажиллагааны орлого 37,761.5 сая төгрөг буюу 96.2 хувиар, олон улсын хамтарсан сургалт дадлагын нөхөн төлбөрийн орлого 1,192.1 сая төгрөг буюу 3.0 хувиар, олон улсын цэргийн ажиллагааны орлого, бүтээн байгуулалтын ажилд цэргийн анги, салбар оролцуулсны орлого, актлагдсан зарим техникийг худалдан борлуулсны орлого 296.3 сая төгрөг буюу 0.8 хувиар бүрдүүлжээ.

Хүснэгт № 273. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2012-2016 оны зарлагын гүйцэтгэл (сая төгрөг)

№	Аргахэмжээ	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
1	Энхийг дэмжих ажиллагаа	4,687.4	7,787.9	4,235.1	3,920.6	5,812.5
2	Олон улсын хамтарсан сургалт, дадлага	782.5	1,505.9	1,985.3	3,173.3	3,229.8
3	Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэх	2,058.5	193.3	2,296.9	3,041.5	35.0
4	Зэвсэгт хүчний зэвсэглэл техникийг сэргээн сайжруулах, шинэчлэх сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх	2,198.6	1,390.0	8,202.4	12,759.5	14,740.9
5	Офицер, ахлагч, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах	1,432.1	269.1	3,919.0	5,931.1	2,890.2
Дүн		11,159.1	11,146.2	20,638.7	28,826	26,708.4

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ САН

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлийн 21^{3.2} дахь хэсэгт зааснаар Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөр олгоход зарцуулахаар заасан. Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ыг баталж, энэхүү журмын дагуу уг сангийн хөрөнгийг нөхөн төлбөрийн зардалд зарцуулж байна.

Хүснэгт № 274. Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох сангийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хураангуй зардлын тойм /зардлын эдийн засгийн томсгосон ангиллаар, сая төгрөг/

Хөтөлбөрийн нэр	Нийт урсгал зардал	Үүнээс		
		Цалин, НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ САН	594.0	0.0	594.0	0.0
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөр	594.0	0.0	594.0	0.0

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлийн 21^{3.2} дахь заалтад хамрагдах зарим төрлийн гэмт хэрэгт хорих ялаар шийтгэгдсэн ялтны учруулсан хохирол олгоход 2018 онд нийт 594.0 сая төгрөгөөр төлөвлөсөн.

Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох сангийн оны эхний үлдэгдэл 2016 онд 688.0 сая төгрөг байсан ба тайлант хугацаанд 20.3 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Хууль зүйн сайд 2015 онд 99 иргэнд 372,6 сая төгрөг, 2016 онд 61 иргэнд 237,2 сая төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн сайд 2017 оны эхний хагас жилд 18 иргэнд 76.5 сая төгрөгийг хохирогчдод олгосон байна.

Сангийн эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгөөс гадна шүүхээс ноогдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувь, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчилд ногдуулсан захиргааны торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр дээр заасан гэмт хэрэгт буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөрөөс бүрдүүлж байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САН

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлсэн сан нь экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр бий болгох зорилгоор жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхыг сайжруулах, бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг ба өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг засгийн газрын тусгай сан юм.

Хүснэгт № 275. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн нийт зардал /сая төгрөг/

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САН	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих (72101)	56,712.7	50,601.4	31,981.6

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн нийт урсгал зардлыг 2018 оны төсвийн төсөлд 1,402.9 сая төгрөг байхаар тооцсон ба үүнээс цалин, НДШ-ийн зардалд 355.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,021.3 сая төгрөг, татаас шилжүүлэгт 26.4 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Хүснэгт № 276. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн урсгал зардлын бүтэц /сая төгрөг/

2018 оны төсвийн төсөл	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	1,402.9	355.2	1,021.3	26.4

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн нийт зардлыг 2018 оны төсвийн төсөлд 31,981.6 сая төгрөг байхаар тооцлоо. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих арга хэмжээнд 614.5 сая төгрөг;
2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээлд 30,578.7 сая төгрөг;
3. Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах, олон улсын үзэсгэлэнд оролцох арга хэмжээнд зориулж 180.0 сая төгрөг;
4. Бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлийг өргөтгөх зорилгоор “Монголд үйлдвэрлэв-Цагаан сар” үзэсгэлэн худалдаа, “Бүтээлч Монгол” үзэсгэлэн худалдаа, “Үндэсний нэрийн бүтээгдэхүүн шалгаруулах” үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад зориулж 198.0 сая төгрөг.
5. Бусад арга хэмжээнд 410.2 сая төгрөгийн зардлыг тус тус тусгалаа.

Хүснэгт № 277. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зардлын хураангуй /сая төгрөг/

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	56,712.7	50,601.4	31,981.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2.6	4.6	4.8
80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	58.0	0.0	30.0
80218 Улс орноо гадаадад сурталчлах	54.2	49.5	180.0
80229 Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	0.0	0.0	325.6
80312 Сургалт семинар	50.0	0.0	50.0
80812 Бүтцийн өөрчлөлтийн тэтгэмж	58.5	0.0	0.0
81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	55,700.0	49,800.0	30,578.7
82540 "Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн	149.9	198.0	198.0
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	639.5	549.3	614.5
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	56,712.7	50,601.4	31,981.6
31 Улсын төсвөөс санхүүжих	-19,841.8	0.0	10,578.7
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	76,554.5	50,601.4	21,402.9
Орон тоо - Албан тушаалаар	24	24	24
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	56,712.7	50,601.4	31,981.6
09728 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	76,554.5	50,601.4	21,402.9

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь Засгийн газрын бондын эргэн төлөлт болох 52,000.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Хүснэгт № 278. Засгийн газрын бондын эргэн төлөлт /сая төгрөг/

	2015 Гүйц.	2016 Гүйц.	2017 Тод.	2018 Төсөл
ЖДҮХС-гаас төлөх Засгийн газрын бондын эргэн төлөлт	52,445.8	51,870.0	52,000.0	52,000.0

МАЛ ХАМГААЛАХ САН

Засгийн газрын 2001 оны 246 дугаар тогтоолоор “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Мал хамгаалах санг байгуулсан. Тус сан нь эрчимжсэн мал аж ахуйг дэмжих зорилтын хүрээнд хөнгөлөлттэй зээл олгодог бөгөөд өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг засгийн газрын тусгай сан юм.

Мал хамгаалах сангийн урсгал зардлыг 34,776.5 сая төгрөг, эргэж төлөгдөх зээлийг -38,091.0 сая төгрөгөөр тус тус тооцсон ба ингэснээр цэвэр өөрчлөлт -3,314.5 сая төгрөг болохоор байна.

Хүснэгт № 279. Мал хамгаалах сангийн нийт зардал /сая төгрөг/

Мал хамгаалах сан	2016 Гүйц	2017 Тод	2018 Төсөл
Мал аж ахуйг хөгжүүлэх (70801)	30,453.1	36,698.5	-3,314.5

Мал хамгаалах сангийн 2018 оны нийт урсгал зардлыг 34,776.5 сая төгрөгөөр төсөвлөсөн ба үүнээс цалин хөлс ба НДШ-ийн зардалд 189.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 95.6 сая төгрөг, татаас шилжүүлэгт 34,458.1 сая төгрөгийг тус тус тусгалаа.

2017 онд малын тэжээлийн нөөцийг бэлтгэх зорилгоор 40,000.0 сая төгрөгийг зээлийг олгосон ба 2018 онд төсөвт төвлөрүүлэх зээлийн эргэн төлөлтөд 40,000.0 сая төгрөгийг тооцож тусгав.

Хүснэгт № 280. Мал хамгаалах сангийн нийт урсгал зардал /сая төгрөг/

Мал хамгаалах сан	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
Мал аж ахуйг хөгжүүлэх (70801)	35,776.5	189.8	95.6	34,458.1

Мал хамгаалах сан нь 2018 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

Үүнд:

1. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор сүү, мах, малын таримал тэжээл, малын үржил, мал эмнэлгийн чиглэлээр хөнгөлөлттэй зээл олгоход 1,909.0 сая төгрөг зарцуулна;
2. 2017 онд өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хүрээнд малын тэжээлийн нөөц бэлтгэх зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлт болох 40,000.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.
3. Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай” журмын дагуу 2017 онд хонь, тэмээний ноосны урамшуулал олгох ажлыг зохион байгуулахад 22,637.2 сая төгрөг тусгалаа;
4. Монгол Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2017 онд арьс, ширний урамшуулал олгох ажилд 11,847.9 сая төгрөг зарцуулна;

5. Мал хамгаалах сангийн үндсэн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлыг 285.4 сая төгрөгөөр тооцож тусгалаа.

Хүснэгт № 281. Мал хамгаалах сангийн зардлын тойм /сая төгрөг/

Мал хамгаалах сан	2016	2017	2018
	Гүйц	Тод	Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	30,453.1	36,698.5	-2,314.5
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	259.9	298.4	285.4
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	11.8	6.0	6.0
81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	1,554.0	1,909.0	-38,091.0
82537 Ноосны урамшуулал	0.0	22,637.2	23,637.2
82543 Арьс ширний урамшуулал	9,251.0	11,847.9	11,847.9
83118 Мах, улаан буудай, арьс шир, ноосны урамшуулал	19,376.4	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	30,453.1	36,698.5	-2,314.5
31 Улсын төсвөөс санхүүжих	28,618.1	34,485.1	-4,514.9
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,835.0	2,213.4	2,200.4
Орон тоо - Албан тушаалаар	12	12	12
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	30,453.1	36,698.5	-2,314.5
09777 Мал хамгаалах сан	30,453.1	36,698.5	-2,314.5

ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тариалангийн газрыг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах, таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх, тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдээс стандартын шаардлага хангасан буудай худалдан авах арга хэмжээг зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын тусгай сан юм. Тус сан нь өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүждэг ба хөдөө орон нутагт 6 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт № 282. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нийт урсгал зардал /сая төгрөг/

2018 төсвийн төсөл	Урсгал зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
Тариалан эрхлэлтийг дэмжих сан	21,460.5	1,568.6	4,928.9	14,963.0

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нийт урсгал зардлыг 2018 оны төсвийн төсөлд 21,460.5 сая төгрөг байхаар тооцсон ба үүнээс цалин, НДШ-ийн зардалд 1,568.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,928.9 сая төгрөг, татаас шилжүүлэгт 14,963.0 сая төгрөгийг тус тус тусгалаа.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нийт зардлыг 2018 оны төсвийн төсөлд 18,460.5 сая төгрөг байхаар тооцсон ба үүнээс буудайн нөөц бүрдүүлэхэд 22,400.0 сая төгрөг, улаан буудайн урамшуулал олгох арга хэмжээнд 14,963.0 сая төгрөг, сангийн үндсэн болон гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардал 2,960.4 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх зээлийн эргэн төлөлтөд 47,400.0 сая төгрөгийг тооцож тусгав.

2017 онд үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор 23,400.0 сая төгрөгийг зээлийг олгосон ба 2018 онд төсөвт төвлөрүүлэх зээлийн эргэн төлөлтөд 23,400.0 сая төгрөгийг тооцож тусгав.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн төв салбарын нийт зардлыг 2018 оны төсвийн төсөлд 16,826.6 сая төгрөг байхаар тооцлоо.

Хүснэгт № 283. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, төв салбарын зардлын тойм /сая төгрөг/

Тариалан эрхлэлтийг дэмжих сан төв салбар	2016 гүйц	2017 год	2018 Төсөл
Нийт хөтөлбөр	22,925.2	36,797.6	16,826.6
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр (70207)	8,908.6	0.0	0.0
Газар тариалан хөгжүүлэх (70802)	14,016.6	36,797.6	16,826.6

Хүснэгт № 284. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, төв салбар /сая төгрөг/

Тариалан эрхлэлтийг дэмжих сан төв салбар	2016 гүйц	2017 год	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	14,016.6	36,797.6	16,826.6
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	0.0	51.3	4.3
80102 Туслах үйл ажиллагааны зардал	0.0	0.0	696.9
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	1,410.0	1,383.3	1,334.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	62.7	0.0	0.0
81308 Үрийн нөөц	0.0	1,600.0	1,600.0
81309 Таваарын буудайн нөөц	6,241.3	20,800.0	20,800.0
81404 Дамжуулан зээлдүүлсэн зээл	0.0	22,000.0	22,000.0
81405 Дотоод эх үүсвэрээс олгох зээл	0.0	-24,000.0	-47,400.0
82524 Хамгаалагдсан хөрсний тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	711.2	0.0	2,827.5
82536 Улаан буудайн урамшуулал	0.0	14,963.0	14,963.0
83118 Мах, улаан буудай, арьс шир, ноосны урамшуулал	5,591.5	0.0	0.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	14,016.6	36,797.6	16,826.6
31 Улсын төсвөөс санхүүжих	-412.0	14,963.0	14,963.0
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	14,428.6	45,834.6	49,263.6
37 Бусад эх үүсвэр	0.0	-24,000.0	-47,400.0
Орон тоо - Албан тушаалаар	53	46	46
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	14,016.6	36,797.6	16,826.6
09725 Тариалан эрхлэлтийг дэмжих сан	14,016.6	36,797.6	16,826.6

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь орон нутагт нийт 6 салбартай ба салбаруудын нийт зардлыг 2018 оны төсвийн төсөлд 1,633.9 сая төгрөг байхаар тооцож тусгалаа.

Хүснэгт № 285. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн салбарууд /сая төгрөг/

Тариалан эрхлэлтийг дэмжих сан салбарууд	2015 год	2016 год	2017 Төсөл
Нийт салбаруудын зардал	1,323.8	1,430.1	1,633.9
Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Сэлэнгэ	279.0	287.9	476.8
Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Хархорин	168.2	166.3	166.6
Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Булган	244.2	254.3	270.5
Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Хөтөл	270.3	281.6	278.2
Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Угтаал	225.0	253.9	263.3
Тариалан эрхлэлтийг дэмжих сан - Дархан	137.1	186.1	178.5

СОЁЛ, УРЛАГИЙГ ДЭМЖИХ САН

Соёл, урлагийг дэмжих сангийн төсөв 2018 онд 1.0 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Уг сан нь Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.2.50 дахь заалтаар Соёл, урлагийг дэмжих сан байгуулахаар заасны дагуу шинэчлэн зохион байгуулагдсан сан юм.

Хүснэгт № 286. Соёл, урлагийг дэмжих сангийн зардлын хураангуй /сая төгрөг/

СОЁЛ, УРЛАГИЙГ ДЭМЖИХ САН	2017 Год	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр	1,000.0	1,000.0
80214 Уран бүтээл хийлгэх	250.0	250.0
81901 Соёл урлаг хөгжүүлэх	300.0	300.0
81911 Сонгодог урлаг хөтөлбөр	200.0	200.0
81929 Монгол уран бүтээл	250.0	250.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,000.0	1,000.0

СПОРТЫГ ДЭМЖИХ САН

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.2.55 дэх заалтад “Спортыг дэмжих сан” байгуулахаар заасны дагуу Спортыг дэмжих сангийн зардлыг 2018 оны төсөвт 1.0 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө.

Хүснэгт № 287. Спортыг дэмжих сангийн зардлын хураангуй /сая төгрөг/

СПОРТЫГ ДЭМЖИХ САН		2017 Тод	2018 Төсөл
Зориулалт арга хэмжээгээр		1,000.0	1,000.0
82106	Нийтийн биеийн тамир	250.0	250.0
82107	Өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагч дэмжих	250.0	250.0
82108	Үндэсний уламжлалт спортыг дэмжих	250.0	250.0
82109	Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих	250.0	250.0
Санхүүжүүлэх эх үүсвэрээр		1,000.0	1,000.0
31	Улсын төсвөөс санхүүжих	1,000.0	1,000.0

Нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд 250.0 сая төгрөг төсөвлөлөө. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, өсвөр үеийнхнийг нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх төсөл, арга хэмжээг дэмжинэ. Ингэхдээ биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хамрагддаггүй иргэдийг татан оролцуулах, тэднийг эрүүл зөв амьдралын дадал хэвшилтэй болгоход чухал нөлөө үзүүлнэ.

Өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг спортын шинжлэх ухааны дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн ололтод тулгуурлан бэлтгэх, хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхэд 250.0 сая төгрөгийг төсөвлөлөө. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр өндөр зэрэглэлийн тамирчныг үе шаттай бэлтгэх, дасгалжуулагчийг мэргэшүүлж хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, судалгаа-шинжилгээний ажил, гадаадаас өндөр зэрэглэлийн дасгалжуулагчийг ажиллуулах, сургалт дасгалжуулалтын шинэ технологийг нэвтрүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэн өндөр зэрэглэлийн мэргэшсэн дасгалжуулагчийг бэлтгэж, тамирчдын залгамж халааг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэнэ.

Үндэсний уламжлалт спортын төрлүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд 250.0 сая төгрөгийг төсөвлөлөө. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд үндэсний уламжлалт спортын төрлүүдийн өв соёлыг хамгаалан хадгалж, орчин үеийн спортын жишигт нийцүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн үндэсний спортын төрлийн холбоодын төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлснээр хүүхэд залуучуудын дунд дэлгэрүүлж, олон улсад сурталчлан хөгжүүлнэ.

Үндэсний хэмжээний тэмцээн, наадмын допингийн эсрэг хяналтыг хэрэгжүүлэх, допингийн эсрэг үйл ажиллагааны сургалт, сурталчилгааг зохион байгуулахад 250.0 сая төгрөг төсөвлөлөө. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд үндэсний хэмжээний спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогч тамирчдаас допингийн шинжилгээ авдаг болно. Үүний үр дүнд тамирчдыг допингийн хор нөлөөнөөс сэргийлэх, шударга өрсөлдөх нөхцөл бүрдэнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САН

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд “Эрүүл мэндийг дэмжих сан”-г байгуулж, Монгол Улсын “Засгийн газрын тусгай сан”-гийн хуулийн 21⁸ дүгээр зүйлийн дагуу хүн амын өвчлөл, эндэгдлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилгоор архи, согтууруулах ундааны онцгой албан татвар, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар, тамхины онцгой албан татварын тодорхой хувийг тус санд хуваарилах, сангийн хөрөнгийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэндийн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.

Сангийн хөрөнгийг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа буюу хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгож, мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөн ирэх оны төсвийг **2,030.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэн тусгалаа.

Хүснэгт № 288. Эрүүл мэндийг дэмжих сангийн урсгал зардал /сая төгрөг/

Байгууллага	2016 Гүйц	2017 Тод	2018 оны төсөл
Эрүүл мэндийг дэмжих сан		2,970.0	5,000.0

Эрүүл мэндийг дэмжих сан 2018 онд 3 зорилт 7 дэд зорилтын хүрээнд арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт № 289. Эрүүл мэндийг дэмжих сангийн нийт урсгал зардал/сая төгрөг/

Эрүүл мэндийг	Нийт зардал	Үүнээс		
		Цалин НДШ	Бараа үйлчилгээний бусад	Татаас шилжүүлэг
Эрүүл мэндийг дэмжих сан	5,000.0	0.0	5,000.0	0

2018 онд Эрүүл мэндийг дэмжих сангаас үзүүлэх дэмжлэгийг дараахь чиглэлээр санхүүжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

- Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 1,400.0 сая төгрөг буюу 35.0 хувийг;
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 800.0 сая төгрөг буюу 20.0 хувийг;
- Орчны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 400.0 сая төгрөг буюу 10.0 хувийг;
- Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 600.0 сая төгрөг буюу 15.0 хувийг;
- Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга

нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж 400.0 сая төгрөг буюу 10.0 хувийг;

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгох чиглэлээр хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн төр, төрийн бус байгууллага, сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгж байгууллагын үр дүнтэй санаачлага, төсөл, хөтөлбөрийг дэмжих, урамшуулах үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаанд зориулж 400.0 сая төгрөг буюу 10.0 хувийг;
- Эмийн захисгүй хэрэглээний чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, хяналт, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах үйл ажиллагааг дэмжихэд зориулж 400.0 сая төгрөг буюу 8.0 хувийг;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах дэмжих арга хэмжээнүүдэд зориулж 100.0 сая төгрөг буюу 2.0 хувийг;

Нийгмийн эрүүл мэнд, анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих арга хэмжээнд 10 хувь буюу 500.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгалаа.


8. ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН БОЛОН ИРЭЭДҮЙН ӨВ САН

8.1. Тогтворжуулалтын сан

8.1.1. Төсвийн тогтворжуулалтын санд шилжүүлсэн эрдэс баялгийн орлого, сангийн зарлага.

Төсвийн тогтворжуулалтын санд эрдэс баялгийн орлогоос 2011 онд 241.0 тэрбум төгрөг, 2012 онд 94.7 тэрбум төгрөг, 2013 онд 46.9 тэрбум төгрөг, 2013 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр сангийн үлдэгдэл 383.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин 2014 онд тогтворжуулалтын санд эрдэс баялгийн орлогоос 39.9 тэрбум төгрөг төвлөрсөн боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2014 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүүг нөхөх зорилгоор “Төсвийн тогтворжуулалтын сангийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 396 дугаар тогтоолоор Төсвийн тогтворжуулсан сангийн хуримтлагдсан хөрөнгөөс 118.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлсэн.

График № 40. ТТС-нд шилжүүлсэн эрдэс баялгийн орлого, сангийн зарлага, хуримтлал, /тэрбум төгрөг/



Монгол Улсын эдийн засаг болон төсвийн орлогыг бүрдүүлэгч гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ өндөр байсан онуудад (2011 онд 241.0 тэрбум, 2012 онд 94.7 тэрбум төгрөг) тус сангийн орлого хамгийн их байсан боловч жилээс жилд буурсан ба 2017 оны хувьд ТТС-д 242.4 тэрбум төгрөг, 2018 онд 64.8 тэрбум төгрөгийн орлого тус тус төвлөрөхөөр тооцож байна. 2017 онд 572.1 тэрбум төгрөгийг авч ашиглахаар тодотголын төсөлд тусгаад буй.

8.1.2. Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлага.

Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлагатай холбогдох харилцаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагдах ба тус хуульд 2015 оны 6 дугаар сард өөрчлөлт оруулснаар сангийн хөрөнгийг хуульд заасан зориулалтаар санхүүжилт хийхэд байнга хөрвөх чадвартай байлгах, эрсдэлээс хамгаалах, олон улсын санхүүгийн зах зээлд үр ашигтай хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн санхүүгийн нөөцийн удирдлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тогтоосон. Мөн тус сангийн хөрөнгийг хүүгийн хувь хэмжээ нь арилжааны банкны тухайн жилийн хадгаламжийн хүүгийн түвшнээс багагүй байх санхүүгийн хэрэгсэлд байршуулахаар хуульчилсан.

Үүний дагуу 2015-2016 онд ТТС-ийн санхүүгийн хөрөнгөөс дотоодын банкнуудад хугацаагүй хадгаламж хэлбэрээр жилийн 7-9 хувийн хүүтэйгээр буюу хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан байдлаар байршуулсан. Тус санд 2015 онд 3.2 тэрбум, 2016 онд 10.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлого тус тус төвлөрсөн байна.

2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.2 хэсэгт “Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас доошгүй байна” гэж заасныг хүчингүй болгосон бөгөөд ТТС-ийн хуримтлалыг 2023 оны төсвийн жилийг дуустал төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар ашиглахаар тооцож байна.

8.2. Ирээдүйн өв сан

8.2.1. Ирээдүйн өв сангийн орлогын эх үүсвэр

Хүний хөгжил санг хуримтлалын сангийн хэлбэрт шилжүүлэн өөрчлөн зохион байгуулах, Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ирээдүйн өв сангийн тухай хуулийг санаачлан Сангийн яамны дэмжлэгтэйгээр боловсруулсан бөгөөд урт хугацааны хуримтлалын сан байгуулах эрх зүй, институцийн тогтолцооны асуудлыг олон улсын туршлагад тулгуурлан тусгасан уг хуулийг Монгол Улсын Их Хурал 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа баталсан ба уг хууль болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхлээд байна.

Ирээдүйн өв сан нь нөхөн сэргээгдэхгүй баялгийн олборлолтоос орж байгаа орлогын тодорхой хэсгийг ирээдүй үедээ өвлүүлэх үүрэг гүйцэтгэх бөгөөд тус сангийн орлогын үндсэн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг юм.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д тус сангийн эх үүсвэрийг тооцож санд төвлөрүүлэх аргачлалыг Сангийн сайд батлахаар заасан бөгөөд уг аргачлалыг Сангийн сайдын 2017 оны 10 дугаар тушаалаар батлан мөрдүүлж байна.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д санд төвлөрүүлэх хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батална гэж заасан бөгөөд эрдэс баялгийн орлогоос 2017 онд 333.3 тэрбум төгрөг, 2018 онд 525.7 тэрбум төгрөг хуваарилагдахаар байна.

Хүснэгт № 290. Ирээдүйн өв сангийн орлого /тэрбум төгрөг/

	2017 год-2	2018 он төсөл
2.1 Орлого	333.3	525.7
АМНАТ-ын 65 хувь	333.3	477.8
Ногдол ашиг	-----	47.8

8.2.2. Ирээдүйн өв сангийн эх үүсвэрийн зарцуулалт, өрийн төлбөр

Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байхаар байгуулагдсан бөгөөд Хүний хөгжил сангийн тухай хууль 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсон. Хүний хөгжил санг Ирээдүйн өв санд шилжүүлж байгаатай холбоотойгоор Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг УИХ-аас баталсан ба уг хуулиар дараах асуудлыг зохицуулсан. Үүнд:

- Ирээдүйн өв сангийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Хүний хөгжил санд хуримтлагдсан өрийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон улсын төсөвт өглөгөөр бүртгэж улсын төсвөөс барагдуулах ба улсын төсөв тухайн шилжүүлэн авсан дүнгээр Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэнэ;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1, 7.1.2-т заасны дагуу бүрдүүлсэн сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2017 онд 160 тэрбум төгрөг, 2018 онд 100 тэрбум төгрөг, 2019 онд 50 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус шилжүүлнэ;
- Улсын төсөвт өгөх шилжүүлэг болон Корпорацийн зардлыг шилжүүлсний дараа үлдэх эх үүсвэрээр энэ хуулийн улсын төсөвт өгөх Ирээдүйн өв сангийн өглөгийг төлж барагдуулна.

Сангийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгож тооцсон Хүний хөгжил сангийн нийт 1,071.9 тэрбум төгрөгийн өр улсын төсөвт шилжиж, Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэгдсэн байна. Уг өрийн мэдээллийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт № 291. Хүний хөгжил сангаас улсын төсөвт шилжсэн өр, төлбөрүүд, /сая төгрөг/

Зээлдэгч	Зээллэгийн төрөл	Үндсэн өр	Хуримтлагдсан хүү
Улсын төсөв	ХХС-д авч ашигласан урьдчилгаа төлбөрт суутгагдсан улсын төсвийн орлогын хэмжээгээр үүссэн өглөг (цэвэр дүнгээр)	399,761.2	-
Худалдаа хөгжлийн банк	Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)	125,000.0	7,209.87
Нийгмийн даатгалын сан	ЗГҮЦ	57,000.0	137.36
Хаан банк	ЗГҮЦ	62,956.4	4,729.92
Хаан банк	ЗГҮЦ	149,371.8	1,938.97

Хас банк	ЗГҮЦ	13,309.7	582.02
Хас банк	ЗГҮЦ	87,133.6	1,424.57
Төрийн банк	ЗГҮЦ	87,133.6	715.65
Голомт банк	ЗГҮЦ	13,611.0	589.88
Капитрон банк	ЗГҮЦ	1,834.7	79.28
Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	Эрдэнэс таван толгой ХК-ийн хувьцаа борлуулсан орлогоос үлдсэн орлого, түүнийг банканд байршуулсан хүүгийн орлого	7,948.8	-
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	УИХ-ын 2015.11.13-ний өдрийн 103 дугаар тогтоолын 2.2-т заасны дагуу 2019 оноос нөхөж олгох хүүхдийн мөнгө	49,423.2	-
Нийт		1,054,483.83	17,407.53
НИЙТ ӨР, ТӨЛБӨР		1,071,891.36	

Ирээдүйн өв санд хуваарилагдсан хөрөнгөөс Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу 2017 онд 160.0 тэрбум төгрөг, 2018 онд 100.0 тэрбум төгрөгийг шууд төсвийн шилжүүлэг байдлаар олгох бөгөөд үлдэх хэсгээр Хүний хөгжил сангаас үлдсэн өрийг барагдуулахад зориулахаар тооцож байна. Хүний хөгжил сангаас үлдсэн өрийг барагдуулахад 2017 онд 173.3 тэрбум төгрөг, 2018 онд 425.7 тэрбум төгрөг зарцуулагдах ба эдгээр нь улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд ашиглагдахаар байна.

Хүснэгт № 292. Ирээдүйн өв сангийн орлого, зарлагын төсөөлөл /тэрбум төгрөг/

	2017 год-2	2018 төл
ИӨС-гийн нийт орлого	333.3	525.7
Нийт, зарлага, санхүүжилт	333.3	525.7
Улсын төсөвт хийх шилжүүлэг	160.0	100.0
Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт	173.3	425.7
ИӨС корпорацийн үйл ажиллагааны зардал	0.0	0.0

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу урьдчилсан тооцоогоор Ирээдүйн өв сангийн 2020 он хүртэлх хугацааны орлого улсын төсөвт шууд өгөх шилжүүлэг болон Хүний Хөгжил сангаас шилжсэн өрийн төлбөрт ашиглагдах тооцоотой байна. Хэрэв гадаад зах зээлд уул, уурхайн бүтээгдэхүүний үнэ өсөж, төсөвт төвлөрөх эрдэс баялгийн орлого нэмэгдсэн тохиолдолд Ирээдүйн өв санд хуримтлал 2020 оноос өмнө үүсэх боломжийг нэмэгдүүлэх юм.

9.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны орлогыг 1,689.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2017 оны тодотголтой харьцуулахад 276.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Тус сангаас 2018 онд тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд давхардсан тоогоор 4.5 сая иргэдэд нийт 2,101.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 209.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулах зорилгоор 2018 онд дараах зохицуулалтыг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар ажил олгогч болон даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг аажмаар буюу 3 жилийн хугацаанд тус бүр 2.5 пунктээр, нийт 5.0 пунктээр нэмэгдүүлэхээр баталсан. Хууль хэрэгжиж эхлэх эхний жил буюу 2018 онд тэтгэврийн даатгалын шимтгэл ажил олгогч, даатгуулагч тус бүр 1 хувиар нэмэгдэж байгаа тул Нийгмийн даатгалын сангийн орлогыг 123.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцов.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт гарах насыг жилд 6 сараар нэмэгдүүлэх шийдвэр гарсан. Энэ дагуу 2018 оноос эхлэн эрэгтэйчүүд 60 нас 6 сараар эмэгтэйчүүд 55 нас 6 сартайдаа тэтгэвэрт гарах эрх үүсэх бөгөөд даатгуулагч өөрөө хүсвэл 60 настайдаа тэтгэвэрт гарах эрхтэй болж байна. Ингэснээр шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо нийт 8,958 хүнээр багасаж, үүний үр дүнд тэтгэврийн даатгалын сангийн ачаалал 34.6 тэрбум төгрөгөөр буурч байна.

3. Тэтгэврийн даатгалын зарим параметрийг өөрчилсөнтэй холбоотойгоор тэтгэврийн сангийн алдагдал буурч байна. Иймээс нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 2017 оны түвшнээс 56.1 тэрбум төгрөгөөр бууруулж нийт 531.2 тэрбум төгрөг байхаар тооцсон. Үүнээс төр хариуцах буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 202.6 тэрбум төгрөг, цэргийн тэтгэвэрт 107.9 тэрбум төгрөг, тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд 220.6 тэрбум төгрөг улсын төсвөөс олгохоор тооцов.

4. Тэтгэврийн даатгалын сан алдагдалтай байгааг харгалзан нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны зардлыг ашигтай байгаа тэтгэмж, ҮОМШӨ, ажилгүйдэл, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тооцов.

Хүснэгт № 293. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016 Гүйц	2017 Бат	2017 Тод	2018 Төс
САНГУУДЫН ОРЛОГО	1,315.0	1,390.8	1,412.6	1,689.4
1 Шимтгэлийн орлого	1,240.7	1,340.4	1,341.9	1,589.6
2 Бусад орлого	74.4	50.4	70.7	99.9
САНГУУДЫН ЗАРЛАГА	1,720.6	1,887.4	1,891.8	2,101.4
1. Тэтгэврийн даатгалын сан	1,305.3	1,404.4	1,404.4	1,575.0
2. Тэтгэмжийн даатгалын сан	92.4	109.2	109.2	102.4


3. ҮОМШӨ-ний даатгалын сан	29.4	31.5	31.5	31.7
4. Ажилгүйдлийн даатгалын сан	31.6	29.7	29.7	35.4
5. Эрүүл мэндийн даатгалын сан	238.9	293.1	297.4	337.3
6. Бусад зарлага	3.2	0.1	0.2	0.2
7. Ажиллагааны зардал	19.8	19.4	19.4	19.4
САНГУУДЫН НИЙТ ТЭНЦЭЛ:	-88.9	-90.7	-108.1	-153.2
<i>Улсын төсвөөс олгох татаас</i>	<i>494.9</i>	<i>587.3</i>	<i>587.3</i>	<i>531.2</i>

Ирэх онд Тэтгэврийн даатгалын сан 565.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин Тэтгэмжийн даатгалын сан, ҮОМШӨ-ний даатгалын сан, Ажилгүйдлийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан нийлээд 153.2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, нийт тэнцэл 412.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар байна. Нийт алдагдал 2017 оны тодотголоос 67.0 тэрбум төгрөгөөр буурч байна.

9.1.Нийгмийн даатгалын сангийн орлого

Ирэх 2018 онд 48.9 мянган аж ахуйн нэгж байгууллагын 820.8 мянга гаруй ажиллагч албан журмын даатгалд хамрагдахаар байгаа нь 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 10.7 мянгаар нэмэгдэхээр байна. Харин сайн дурын даатгалд даатгуулж албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа 320.0 гаруй мянган иргэдийн 74.3 хувь буюу 237.7 орчим мянган хүн хамрагдахаар тооцов. Мөн эдийн засаг идэвхжиж байгааг харгалзан 2.5 мянган аж ахуйн нэгж шинээр нийгмийн даатгалд хамрагдахаар тооцсон нь 2017 оноос 5.4 хувиар нэмэгдэж байна.

График № 41. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын тоо



Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх боломжит эх үүсвэрүүд, эдийн засгийн өсөлт, даатгуулагчдын тоо болон цалин хөлс, орлогын өсөлтийг нэмэгдүүлснээр 2018 онд нийгмийн даатгалын 5 төрлийн санд шимтгэлийн орлогоос 1,589.6 тэрбум төгрөг, хадгаламж болон үнэт цаасны хүүгийн орлогоос 99.9 тэрбум төгрөг, улсын төсвөөс олгох санхүүжилт 531.2 тэрбум төгрөг байхаар тооцов.

Тэтгэврийн даатгалын шимтгэл 2018 онд ажил олгогч, даатгуулагч тус бүр 8.0 хувь, 2019 онд 8.5 хувь, 2020 онд 9.5 хувь, сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 2018 онд 11.0 хувиас, 2019 онд 11.5 хувиас, 2020 онд

12.5 хувиас багагүй байхаар хуулиар тогтоосон. Үүнтэй холбоотойгоор тэтгэврийн даатгалын сангийн орлого ирэх онд 123.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

Хүснэгт № 294. НДШ-ийн хувь хэмжээний өөрчлөлт

Үзүүлэлт	Одоо мөрдөгдөж байгаа хувь хэмжээ			2018 он +2.0%			Нэмэгдэх хувь /тухайн жилд/
	Даатгуулагч	Ажил олгогч	Нийт	Даатгуулагч	Ажил олгогч	Нийт	
Тэтгэвэр	7.0	7.0	14.0	8.0	8.0	16.0	2.0
Тэтгэмж	0.8	1.0	1.8	0.8	1.0	1.8	-
Ажилгүйдэл	0.2	0.2	0.4	0.2	0.2	0.4	-
Эрүүл мэнд	2.0	2.0	4.0	2.0	2.0	4.0	-
ҮОМШӨ		0.8-2.8	0.8-2.8		0.8-2.8	0.8-2.8	
Нийт дүн	10.0	11-13	21-23	11.0	12-14	23-25	2.0

Өмнөх жилүүдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшинг харгалзан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, төр шимтгэлийг хариуцан төлөх иргэдийн шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /240000 төг/-ний 2.0 хувиар буюу жилийн 57600 төгрөгөөр, оюутан суралцагчдын шимтгэлийн хэмжээг мөн хөлсний 1.0 хувиар буюу жилийн 28800 төгрөгөөр тус тус тооцож нийт 26.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох босго оноог 360.1783 оноогоор шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 260.4 мянган хүний ЭМД-ын шимтгэлийг төрөөс нэмж хариуцахаар болсон нь ЭМД-ын сангийн орлогыг 9.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 2017 онд 57.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд Төв банкны үнэт цаас худалдан авсан. 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр бонд, үнэт цаасны хүүгийн орлогоос 4.4 тэрбум төгрөг, сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн хүүгийн орлогоос 67.1 тэрбум төгрөг тус тус НДС-д төвлөрөхөөр байна.

Хүснэгт № 295. Сангийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулсны болон үнэт цаасны арилжаанаас орсон орлогын тооцоо /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 он			2016 он			2017 он ХБГ			2018 он		
	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах	ЗГ-ын бонд банк уудал байр шуул ах				
Байршуулах хөрөнгө	140	470	57	510	57	570	57	740				
Хүүгийн орлого	10.8	51.8	4.4	55.5	4.4	67.1	16.7	83.2				

Хадгаламж, бондын хүүгийн орлогоор 2018 онд 99.9 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2017 оноос 29.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Хүүгийн орлого нэмэгдсэн шалтгаан нь Нийгмийн даатгалын сангийн хуримтлалаас арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 200.0 тэрбумаар нэмэгдүүлж 740.0 тэрбум төгрөг болсонтой холбоотой байна.

9.2.Нийгмийн даатгалын сангийн зарлага

Хүснэгт № 296. Нийгмийн даатгалын сангийн зардал /тэрбум төгрөг/


Зориулалт арга хэмжээгээр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
НИЙТ ДҮН	1,720.3	1,891.8	2,101.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	18.2	18.2	18.2
80205 Мэдээлэл, сургалчилгааны зардал	0.0	0.0	0.0
80213 Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	0.0	0.0	0.0
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.7	0.7	0.7
80229 Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	0.1	0.1	0.1
80312 Сургалт семинар	0.0	0.1	0.1
80407 ЭМД-ын сангаас санхүүжих эмийн үнийн хөнгөлөлт	27.3	41.4	47.5
80505 ЭМД-ын сангаас улсын эмнэлгүүдэд өгөх шилжүүлэг	170.9	186.3	214.5
80512 ЭМД-ын хувийн эмнэлгүүдэд өгөх шилжүүлэг	40.3	68.0	75.0
80601 Өндөр насны тэтгэвэр	973.7	1,055.9	1,182.4
80602 Тахир дутуугийн тэтгэвэр	174.8	185.6	211.8
80603 Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	57.5	58.0	63.3
80604 Цэргийн тэтгэвэр	97.8	103.8	116.5
80605 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	12.8	16.7	17.2
80606 Оршуулгын тэтгэмж	11.1	13.4	13.4
80607 Жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж	68.4	79.0	71.7
80608 ҮО мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж	27.8	28.3	28.5
80609 Ажилгүйдлийн тэтгэмж	31.6	29.6	35.3
80610 НДШ-ийн илүү төлөлтийн буцаан олголт	1.2	1.2	1.2
80613 ҮОМШӨ-ний эмчилгээ сувилгаа	1.1	2.1	2.1
80614 ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	0.4	1.1	1.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг	0.4	0.6	0.2
80806 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.7	0.6	0.4
80812 Бүтцийн өөрчлөлтийн тэтгэмж	-	-	-
80813 Албан хаагчид олгох нөхөн олговор	0.1	0.1	0.1
80820 Бусад тусламж, дэмжлэг	0.1	0.1	0.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,720.3	1,891.8	2,101.4
31 Улсын төсвөөс санхүүжих	494.9	587.3	531.2
33 Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,225.3	1,304.4	1,570.2
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.1	0.1	0.1
Орон тоо	1526	1526	1526
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,720.3	1,891.8	2,101.4
00389 Нийгмийн даатгалын сан	1,462.2	1,574.9	1,744.7
00407 ЭМНДЕГ-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	13.6	13.6	13.6
08571 Эмийн сан, хувийн эмнэлгүүд	67.6	109.6	122.8
09746 Эрүүл мэндийн даатгалын сан	170.9	184.0	214.5
09968 ЭМНДЕГ-Мэдээлэл тооцоолол сургалтын төв	0.7	0.7	0.7
09969 ЭМНДЕГ-Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	0.2	0.2	0.2
ЭМНДХэлтсүүд	5.1	5.1	4.9

9.2.1. Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэврийн даатгалын сангийн зардлын 75.1 хувийг өндөр насны тэтгэвэр, 13.4 хувийг тахир дутуугийн тэтгэвэр, 4 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 7.4 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.


Тэтгэврийн даатгалын сангаас 2018 онд өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр авагч нийт 398.2 мянган хүний тэтгэвэрт 1,574.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 170.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлыг 1,575.1 тэрбум төгрөгөөр, орлогыг 1,009.8 тэрбум төгрөгөөр тооцов.

График № 42. Тэтгэврийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 292 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн илтгэлцүүрийг шинэчлэн баталсан бөгөөд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 230.0 мянган төгрөгөөс 251.0 мянган төгрөгт хүрч 109.1 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 195.0 мянган төгрөгөөс 216.0 мянган төгрөгт хүрч 110.8 хувиар тус тус нэмэгдсэн байна.

График № 43. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ, төгрөг



Ирэх онд эрэгтэй болон эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэрт гарах насыг тус тус жилд 6 сараар нэмэгдүүлснээр 8,958 хүний тэтгэвэрт гарах нас хойшлох бөгөөд тэтгэврийн сангийн зардлын ачаалал 34.7 тэрбум төгрөгөөр буурч байна. Түүнчлэн хуульд орсон өөрчлөлтийн дагуу даатгуулагч өөрөө хүсвэл 60 настайдаа тэтгэвэрт гарах боломжтой болсон бөгөөд харин шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 20 жил дээр жил бүр 3 сар нэмж байхаар заасан. Одоогоор шимтгэл төлсөн дундаж хугацаа 30 жил байгаа нь нас нэмэгдүүлсэн арга хэмжээ эрэгтэйчүүдэд бага нөлөөлөхөөр байна. Тухайлбал тэтгэвэрт гарах нас нь хойшилсон 8.958 хүний 600 гаруй нь эрэгтэйчүүд байна.

Хүснэгт № 297. Тэтгэврийн нас нэмэгдсэнээр өөрчлөгдөх тэтгэвэр авагчдын тоо

Үзүүлэлт	2018 он			
	Хүн амын тоо /хэтийн тооцоогоор/	Шинээр тэтгэвэр тогтоолгох /хуучин хуулиар эр 60, эм 55 нас/	Тэтгэврийн насыг нэмэгдүүлснээр хойшлох иргэдийн тоо	Тэтгэврийн насыг нэмэгдүүлснээр шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо
Эрэгтэй /60 нас/	10,158	8,954	620	8,334
Эмэгтэй /55 нас/	16,176	9,071	4,536	4,536
Эмэгтэй /50 нас, 4 дээш хүүхэдтэй/	18,520	4,319	2,160	2,160
Нөхцлөөр		3,285	1,643	1,643
Нийт өндөр насны	44,854	25,629	8,958	16,672

Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч байгаа эрэгтэй (60 нас) 10.2 мянга, эмэгтэй (55 нас) 16.2 мянган хүн байна. Тэтгэврийн даатгалын сангаас 2018 онд тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлснээр 16.5 орчим мянган хүн шинээр тэтгэвэр тогтоолгож, 9.5 орчим мянган хүний тэтгэвэр зогсоогдон өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагчдын нийт цэвэр өсөлт 9.8 мянган хүн болохоор байна.

Тэтгэвэр авагчдын тооны өөрчлөлт, дундаж тэтгэврийн хэмжээ, өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн 2018 оны тэтгэвэрт зарцуулах хөрөнгийг 1,574.0 тэрбум төгрөг байхаар тооцсон нь 2017 онтой харьцуулахад 12.2 хувиар буюу 170.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Тэтгэврийн даатгалын сангийн зарлага хүний тооны өсөлт, дундаж тэтгэврийн өсөлтөөс шалтгаалж 53.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.


Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Улсын хэлэлцээр (2017-2018 он)-ийн хүрээнд хийж байгаа нэмэлт хэлэлцээрээр Нийгмийн даатгалын сангаас олгож буй бүх төрлийн тэтгэврийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд 119.5 тэрбум төгрөг улсын төсвөөс нэмж шаардагдана.

Хүснэгт № 298. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол

Тэтгэврийн төрөл	Хамрагдах хүн /мян. хүн/	Дундаж тэтгэвэр /мян.төг/		Нэмж шаардагдах /тэрбум төг/
		2017 онд	2018 онд	
НИЙТ	402.8	818.1	883.5	119.5
1 Нийгмийн даатгалын тэтгэвэр	385.6	295.1	318.7	111.0
1.1 -Өндөр насны тэтгэвэр	290.7	314.0	339.1	88.6

1.2	-Тахир дутуугийн тэтгэвэр	74.3	233.0	251.6	17.5
1.3	-Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	20.6	243.0	262.4	4.9
2	Цэргийн алба хаасны тэтгэвэр	17.2	523.0	564.8	8.5

График № 43. Тэтгэвэр авагчдын тоо



Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн албан хаагчийн тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд 2018 онд нийт 17.2 мянган иргэд цэргийн тэтгэвэр авахаар тооцсон нь өмнөх оноос 257 иргэнээр нэмэгдэхээр байна. Түүнчлэн, 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн зардлыг төрөөс хариуцдаг бөгөөд 2018 онд нийт тэтгэвэр авагчдын 15.1 орчим хувь нь буюу 61.5 мянган иргэд байгаа ба эдгээр иргэдийн тоо жилд дунджаар 3.2 мянган хүнээр буурч байна.


Ирэх 2018 онд тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаасны хэмжээг 531.2 тэрбум төгрөгөөр, үүнээс цэргийн болон 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт 310.5 тэрбум төгрөг, тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний эх үүсвэр 117.5 тэрбум төгрөг, улсын төсвөөс нийгмийн даатгалын сангийн алдагдалд өгөх татаасны хэмжээг 103.2 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.

Хүснэгт № 299. Улсын төсөв, НДС-ийн өглөг, авлагын талаар /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	2006-2013	2014	2015	2016	2017	2018
1. Оны эхний өглөг, авлага С1	-262.0	-82.1	-111.7	-128.3	34.9	291.3
2. Улсын төсвийн татаас	-	253.3	292.6	494.9	587.3	531.2
Үүнээс:	-	-	-	-	-	-
2.1. Цэргийн тэтгэвэр	-	80.3	91.2	100.0	103.8	107.9
2.2. 1995 оноос өмнөх	-	202.6	218.0	231.8	227.0	202.6
2.3. НДС-н алдагдалд	-	-29.6	-16.6	163.1	256.5	220.6
3. Улсын төсвийн өглөг, авлага С2	-82.09	-111.7	-128.3	34.9	291.3	511.9

Тэтгэврийн даатгалын сангийн цаашдын чиг хандлага: Хэдийгээр нийгмийн даатгалын хамралт жил тутам өсөж, 2016 оны эцсийн байдлаар 1.0 сая орчим даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдаж, тэтгэврийн даатгалын сангийн орлого жил бүр нэмэгдэж байгаа боловч хүн амын насжилт, нийт хүн амд ахмад настны эзлэх хувийн жингийн өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн зардал хурдацтайгаар нэмэгдэж байна.

Тэтгэврийн тогтолцоо хэвээр байсан бол алдагдал ДНБ-ны 10-16 хувьд хүрэх байсан.




Эх сурвалж: Дэлхийн банкны PROST загвараар хийсэн тооцоолол

Дэлхийн хүн амын дундаж наслалт 1950 оноос хойш 1990-ээд оныг эс тооцвол арван жил тутамд 3-аас дээш жилээр нэмэгдэж байна. Манай орны хувьд 2016 оны байдлаар төрөлтөөс тооцсон дундаж наслалт эмэгтэйчүүд 75.1, эрэгтэйчүүдийнх 65.58 болсон байна. Монгол улсад эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 9.52 жилээр илүү байна.¹

Статистик судалгаанаас үзэхэд Монгол улсын хүн амын тоо сүүлийн 10 жилд 16.1 хувиар өссөн бол мөн хугацаанд ахмад настны тоо 21.9 хувиар буюу илүү хурдацтай өссөн байна. Нийт хүн амд ахмад настны эзлэх хувийн жин 8.6 байгаа бол 2040 онд энэ үзүүлэлт 20 орчим хувьд хүрэхээр байна. Түүнчлэн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2013 онд 4 хүн, 2020 он гэхэд 5 хүн, 2040 онд 8 хүн болох урьдчилсан тооцоололтой байна.

График № 44. Монгол Улсын нийт хүн амд 65 ба түүнээс дээш настай иргэдийн эзлэх хувь, хэмжээ




Эх сурвалж: НУБ-ийн Хүн ам зүйн хэлтэс.

Дэлхийн банкны 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн “Төсвийн зарлагын дүн шинжилгээ” тайланд Монгол Улсын нийт хүн амд эзлэх ахмад настны тоо нэмэгдэхийн

¹ Эрүүл мэндийн үзүүлэлт 2016 /Эрүүл мэндийн хөгжлийн төв, ДЭМБ/

хэрээр тэтгэврийн даатгалын сангийн алдагдал жил бүр нэмэгдэж уг санд улсын төсвөөс олгох татаасны хэмжээ 2016 онд ДНБ-ний 2.0 хувь байсан бол 2030 онд ДНБ-ний 6.0 хувьд, 2050 онд 11.0 хувьд хүрэхээр байна. Энэ нь 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлогын талтай тэнцэх хэмжээтэй байна. Дээрх нөхцөл байдлын улмаас ОУВСангийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн өөрчлөлтийн дагуу тэтгэврийн даатгалын санд олгох татаасны хэмжээ 2030 онд ДНБ-ний 2.0 хувьд хүргэх зорилттой байна. Гэвч эдгээр өөрчлөлт нь сангийн урт хугацаанд тогтвортой байх байдлыг хангахад хангалтгүй тул цаашид параметрийн өөрчлөлтүүдийг нэмж хийх шаардлагатай байна.

График № 45. Монгол Улсын хүн амын тооны төсөөлөл /насны бүлгээр, мян хүн/



Эх сурвалж: НУБ-ийн Хүн амын сангийн тооцоолол-2016 он

9.2.2. Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын санд 2018 онд 113.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 103.9 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсэн, амаржсан эхийн болон оршуулгын тэтгэмжид зарцуулахаар байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хөлсний 50-75 хувиар олгодог бол жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийг 4 сарын хугацаагаар хөдөлмөрийн хөлсний 100 хувиар (сайн дурын даатгуулагчид 70 хувь) олгож байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолд нэг даатгуулагчид олгох оршуулгын тэтгэмжийг 1.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу олгож байна.

Хүснэгт № 300. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мян хүн, тэрбум төгрөг/

Тэтгэмж	2017 оны ХБГ		2018 он төсөл		Өөрчлөлт	
	Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн
1 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	116.1	16.7	117.2	17.2	1.2	0.5
2 Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	61.0	71.7	61.0	71.7	0.0	0.0
3 Оршуулгын тэтгэмж	13.4	13.4	13.4	13.4	0.0	0.0
Нийт дүн	190.5	101.9	191.7	102.4	1.2	0.5

Нийгмийн даатгалын сангийн урд жилүүдийн гүйцэтгэл, холбогдох мэдээлэлд үндэслэн хийсэн тооцоо, судалгаанаас үзэхэд тэтгэмжийн даатгалын сан 2015 онд 8.3 тэрбум, 2016 онд 7.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан боловч 2017 онд тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2 пунктээр нэмэгдүүлснээр 2017 оны ХБГ 1.1

тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж сангийн үйл ажиллагаа тогтворжиж 2018 онд 10.0 тэрбум төгрөгийн ашигтай байх тооцоо гарч байна.

9.2.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин (ҮОМШӨ)-ий даатгалын сан

ҮОМШӨ-ний даатгалын санд 2018 онд 140.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сувиллын хувьсах зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон иргэдийн шимтгэлийн зардалд 45.9 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

Тус сангаас тахир дутуу, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 4.8 мянган иргэнд 26.6 тэрбум төгрөг, тэтгэвэр авагчдын банкны үйлчилгээний хөлсөнд 6.0 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.0 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 1.1 тэрбум төгрөгөөр тус тус зарцуулахаар тооцсон.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийн зардал тэтгэвэр авагчдын тоо буурснаас шалтгаалан өнгөрсөн оноос 839.1 сая төгрөгөөр буурч байна.

9.2.4. Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 2018 онд 37.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж ажилгүйдлийн тэтгэмж болон мэргэжил олгох давтан сургалтын зардалд 35.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Уг сангаас 2018 онд ажилгүйдлийн тэтгэмж авах 25.1 мянган иргэнд 35.3 тэрбум төгрөг, мэргэжил олгох давтан сургалтын зардалд /Улсын хэмжээнд мэргэжил олгох сургалт, дамжаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, сургалтын төвүүдийн нэг хүний сургалтын төлбөрийг үндэслэсэн/ 96.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2017 оны төсвөөс 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Зардал нэмэгдсэн гол шалтгаан нь нийгмийн даатгалын сангийн санхүүгийн жилийн эцсийн тайлан, сарын мэдээ, эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн санал, судалгаанаас үзэхэд ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжид 2017 онд 29.6 тэрбум төгрөг зарцуулахаас эхний 6 сарын байдлаар 63.5 хувийг зарцуулаад байна.

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, байдалтай холбоотойгоор ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 2015 онд 18.7 мянга байсан бол 2016 онд 23.2 мянгад хүрсэн, 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24.3 мянгад хүрэх төлөвтэй байна. Иймд ажилгүйдлийн тэтгэмжийн зардлыг 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тусгасан.

9.2.5. Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2018 онд 388.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2017 оны тодотголтой харьцуулахад 42.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2018 оны төсвийн төслийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн 1,113 эрүүл мэндийн байгууллага, эмийн сан (улсын төв, тусгай мэргэжлийн төв, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв зэрэг 51 эмнэлэг; хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 5; орон нутгийн уламжлалт анагаах ухааны төв 6; сум дундын 35 эмнэлэг; хувийн хэвшлийн 181 эмнэлэг; рашаан сувилал 52; эмийн сан 783)-гийн даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээг худалдан авахаар тооцон 340.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 39.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын өмчийн эмнэлэгт олгох зардлын төсвийн төслийн талаар:

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны “Төлбөрийн хэмжээ, жагсаалт, өртгийн жин, журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор баталсан хувьсах зардлын хэмжээ, оношны бүлэг, өртгийн жин, эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлт зэргийг үндэслэн төрийн өмчийн эмнэлгүүдээс худалдан авах тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг 2018 онд 214.5 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотголоос 28.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна.

а) Төрийн өмчийн эмнэлгийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний зардал:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1 дэх хэсгийн дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг олгож байна. 2018 онд 180.2 тэрбум төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь 2017 оны төсвөөс 16.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Төрийн өмчийн эмнэлгүүдийн ачаалал ихсэж уртасгасан цагаар ажиллах, тоног төхөөрөмж нэмэгдэх, ор болон өргөтгөл байшин барилга ашиглалтад орохтой холбоотой зардлууд нэмэгдсэн. Зардлыг тооцохдоо урд оны гүйцэтгэл, төрийн өмчийн эмнэлгүүд болон ЭМНДХэлтсээс ирсэн тооцоо судалгааг үндэслэн боловсруулсан.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Улсын хэмжээнд 2018-2019 онд ашиглах эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг батлах тухай” А/234 тушаалаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын ор болон хүчин чадал нь нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт мөн нэмэгдэж байна.

б) Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн зардал:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8-дахь хэсэгт зааснаар даатгуулагчдад үзүүлэх өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлж байна. Хуульд заасны дагуу Эрүүл мэнд спортын сайд Сангийн сайд, Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын “Журам жагсаалт батлах тухай” 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 248/161/А88 тоот хамтарсан тушаалаар жагсаалт, журмыг баталсан. Энэхүү хамтарсан тушаалаар анх 107 нэр төрлийн хэрэгслийг даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг байсныг 2016 оны 3 дугаар сарын 26-ны Нийгмийн

даатгалын үндэсний зөвлөлийн "Жагсаалт, журам батлах тухай" 07 дугаар тогтоолоор 2016 оны батлагдсан төсвийн хүрээнд 484 нэр төрөл болгон нэмэгдүүлсэн.

2017 оны эхний хагас жилийн байдлаар өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 6 эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэл батлагдсан сарын хуваариас хоёр дахин их гарсан байна.

Иймд өмнөх оны гүйцэтгэл, энэ оны ХБГ-д үндэслэн уг зардлыг 2018 онд 34.3 тэрбум төгрөг тооцож төлөвлөсөн нь 2017 оны батлагдсан төсвөөс 11.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн сан, хувийн хэвшлийн эмнэлэгт олгох зардлын төсвийн төслийн талаар:

а) Рашаан, сувилалд олгох эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийн талаар:

Рашаан сувиллуудад олгох нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний зардлын төсвийн төслийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/234 тушаал, нийгмийн даатгалын байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн 50 рашаан сувиллын даатгуулагчдад үзүүлэх нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний зардлын 2018 оны төсвийг 12.7 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотголоос 1.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Зардал нэмэгдсэн гол шалтгаан нь рашаан сувиллын орны тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

б) Хувийн хэвшлийн эмнэлэгт олгох эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийн талаар:

1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн хувийн хэвшлийн 5742 ор бүхий 182 эмнэлгийн даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/234 дугаар тушаалаар баталсан орны тоог үндэслэн 2018 онд 249.3 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд 42.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон.

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх хэсэгт “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ”-г эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцна гэж заасан. Иймд 2018 онд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 5.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2-т “Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах...”, 3.1.3-т “Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлнэ”, 3.3.20-д “Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний салбарт төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшруулан...” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн сүүлийн 5 жилийн судалгаанаас авч үзэхэд амьсгалын, хоол боловсруулах, шээс бэлгийн, зүрх судасны тогтолцооны мөн гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэг нь хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан болж байна. Мөн зүрх судас, гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэг, хоол боловсруулах, амьсгалын тогтолцооны болон хавдрын өвчлөл нь хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд орж байгаа судалгаа гарч байна.

Иймд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлолт хугацаанд дээрх 5 төрлөөр хамруулахаар 2018 онд 249.3 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд 10.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

Мөн Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд элэгний С вирусийг илрүүлэх оношилгоо, шинжилгээний лабораторид 2018 онд 19.5 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд 4.9 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

Хүснэгт № 301. ЭМДСангаас олгох Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн зардал /тэрбум төгрөг/

Д/д	Элэг бүтэн Монгол хөтөлбөр	2016	2017		2018
		Бат	Тод	ХБГ	Төсөл
1	Элэгний С вирусийн эмийн үнийн хөнгөлөлт	18.4	18.4	18.4	18.4
2	Элэгний С вирусийг илрүүлэх оношилгоо, шинжилгээ	4.9	4.9	8.7	4.9
НИЙТ ДҮН		23.4	23.4	27.1	23.4

в) Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийн төслийн талаар:

Эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийг боловсруулахдаа эрүүл мэндийн даатгалтай гэрээ бүхий эмийн сангуудаас 2018 оны төсвийн төслийн санал мөн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс эмийн сангийн саналыг авч боловсруулсан. Эмийн сангийн төсөв 5-7 хоногийн дотор дуусаж байгаа нь даатгуулагчийн эрэлт хэрэгцээ ихээр нэмэгдэж байгаатай холбоотой байна. Иймд 2018 оны төсвийн төсөлд зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтөд 47.5 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон нь 2017 оны төсвөөс 4.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3-т "Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох "Элэг бүтэн Монгол" хөтөлбөр хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 2017 оны тодотголоос эхлэн элэгний С вирусийн эмийн үнийн хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгож эхэлсэн. Иймд 2018 оны төсөвт нийт 18.4 тэрбум төгрөгийг элэгний С вирусийн эмийн үнийн хөнгөлөлтөд зарцуулахаар тусгав.

10. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТУХАЙ

Орон нутгийн төсвийн нийт орлогын дийлэнх хувийг хувь хүний орлогын албан татварын орлого бүрдүүлдэг бөгөөд “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн өөрчлөлтийн хүрээнд цалин хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 10-25 хувиар 4 шатлал бүхий татвар ногдуулах болон иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогын татвартай холбоотойгоор орон нутгийн төсвийн суурь орлого 2017 оны түвшнээс 128.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийтдээ 993.0 тэрбум төгрөг болохоор байна.

ОУВС-ын өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр, хууль тогтоомж, статистик хүн ам зүй, үнэ ханшны зэрэг өөрчлөлтүүд, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлэхэд шаардагдах зардал, мөн түүнчлэн 2017-2018 онд өвөлжилт хүндэрч болзошгүй нөхцөл байдал, малын халдварт өвчний гаралт, тархалт нэмэгдэж байгаа зэрэгтэй холбоотойгоор 2018 оны орон нутгийн суурь зарлага өмнөх оны түвшнээс 46.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 667.2 тэрбум болсон бөгөөд орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын дээрх өөрчлөлтийн улмаас аймгуудад олгох санхүүгийн дэмжлэг өмнөх оноос нийтдээ 17.0 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

Хүснэгт № 302. Улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг /сая төгрөг/

№	Аймгийн нэр	2017 он тод-2	2018 он	Зөрүү
1	Архангай	12,501.8	11,473.2	-1,028.6
2	Баян-Өлгий	11,934.4	11,614.1	-320.3
3	Баянхонгор	12,027.3	10,853.5	-1,173.9
4	Говь-Алтай	8,877.5	8,135.9	-741.6
5	Дорнод	3,009.4	1,008.8	-2,000.6
6	Дундговь	6,138.1	5,298.6	-839.4
7	Завхан	10,369.2	9,683.6	-685.6
8	Өвөрхангай	12,214.7	9,736.0	-2,478.7
9	Сүхбаатар	5,658.7	4,437.5	-1,221.2
10	Сэлэнгэ	3,612.9	2,999.1	-613.8
11	Төв	8,529.4	6,615.1	-1,914.3
12	Увс	12,148.2	11,830.3	-317.9
13	Ховд	8,517.2	7,848.3	-668.8
14	Хөвсгөл	18,341.5	15,732.6	-2,608.9
15	Хэнтий	9,097.0	8,706.4	-390.5
	Нийт	142,977.3	125,973.2	-17,004.1

Мөн Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу үндсэн тэнцлийн ашигтай аймгуудын хувьд үндсэн тэнцлийн ашгаасаа Улсын төсөвт төвлөрүүлэх дүн нь дээрх суурь орлого, зарлагын өөрчлөлтийн улмаас 107.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж орон нутгаас 305.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тус тус тооцлоо.

Хүснэгт № 303. Орон нутгийн төсвөөс Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөг/

№	Аймгийн нэр	2017 он тод-2	2018 он	Зөрүү
1	Булган	367.8	1,058.7	690.9
2	Дорноговь	889.4	3,907.0	3,017.6
3	Өмнөговь	29,493.3	69,312.9	39,819.7

4	Дархан-Уул	328.5	2,360.4	2,031.9
5	Улаанбаатар	153,089.7	211,784.3	58,694.7
6	Орхон	13,632.3	17,020.0	3,387.7
7	Говьсүмбэр	176.9	375.2	198.2
	Нийт	197,977.9	305,818.5	107,840.7

2018 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг өмнөх оноос 35.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж нийт 88.6 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлгийг аймаг, нийслэлд олгохоор төлөвлөөд байна.

Хүснэгт № 304. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийн хэмжээ /сая төгрөг/

№	Аймгийн нэр	Дотоодын НӨАТ-5 хувь	Газрын тосны нөөц ашигласны төлбөр /30 хувь/	АМНАТ /5 хувь/	Олон Улсын байгууллагаас сумдын ОНХС-д олгох урамшуулал	Олон Улсын байгууллагаас сумдын ОНХС-д олгох дэмжлэг	Орлогын шилжүүлгийн нийт дүн
1	Архангай	806.4	380.0	1,541.7	26.2	845.1	3,599.4
2	Баян-Өлгий	1,140.5	537.5	2,180.3	11.7	1,073.2	4,943.1
3	Баянхонгор	871.9	410.9	1,666.8	22.5	825.4	3,797.6
4	Булган	512.3	241.4	979.4	47.8	532.3	2,313.3
5	Говь-Алтай	781.0	368.1	1,493.1	32.0	726.8	3,401.0
6	Дорноговь	728.9	343.5	1,393.4	104.6	706.8	3,277.2
7	Дорнод	829.5	390.9	1,585.7	28.2	818.0	3,652.2
8	Дундговь	457.6	215.6	874.8	70.3	457.9	2,076.2
9	Завхан	792.8	373.6	1,515.5	20.2	771.0	3,472.9
10	Өвөрхангай	980.2	461.9	1,873.7	33.7	1,026.9	4,376.4
11	Өмнөговь	747.0	352.0	1,428.0	137.3	725.0	3,389.3
12	Сүхбаатар	604.1	284.7	1,154.8	49.1	574.7	2,667.4
13	Сэлэнгэ	861.6	406.0	1,647.1	31.1	894.6	3,840.5
14	Төв	715.1	337.0	1,367.1	37.2	757.0	3,213.4
15	Увс	971.1	457.6	1,856.5	17.5	927.0	4,229.8
16	Ховд	1,013.9	477.8	1,938.2	16.8	978.6	4,425.3
17	Хөвсгөл	1,232.4	580.7	2,355.8	45.1	1,244.0	5,458.0
18	Хэнтий	696.2	328.1	1,330.9	53.7	703.2	3,112.1
19	Дархан-Уул	654.9	308.6	1,252.0	8.9	710.2	2,934.6
20	Улаанбаатар	4,809.1	2,266.3	9,193.4	0.0	0.0	16,268.8
21	Орхон	778.2	366.7	1,487.7	49.1	824.9	3,506.6
22	Говь-Сүмбэр	131.2	61.8	250.7	60.8	140.5	644.9
	Нийт	21,116.0	9,950.7	40,366.6	903.7	16,263.0	88,600.0

Дээрх тооцооллоос харахад дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын өсөлтөөс үүдэн Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилах эх үүсвэр 25.6 тэрбум төгрөгөөр, Олон Улсын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал дэмжлэг 17.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Хүснэгт № 305. Орон нутгийн хөгжлийн сангийн нийт эх үүсвэр /тэрбум төгрөг/

Эх үүсвэр:	2017 он тод-2	2018 он	Зөрүү
1. Дот НӨАТ*(5%)	20.7	21.1	0.4
2. АМНАТ*5 хувь	16.5	40.4	23.9
3. Газрын тосны НАТ*30 хувь	8.6	10.0	1.3
4. Тогтвортой амьжиргаа-3 төслийн нийт эх үүсвэр. Үүнээс:	7.2	17.2	10.0

<i>а) Урамшуулал</i>	7.2	0.9	-6.2
<i>б) Дэмжлэг</i>	0.0	16.3	16.3
Нийт	53.0	88.6	35.6

Монгол Улсын засгийн газар болон Олон Улсын хөгжлийн ассоциацитай хамтран байгуулсан санхүүгийн хэлэлцээрийн дагуу Тогтвортой Амьжиргаа-3 төслийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, ОНХС-ийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох зорилгоор төслийн зүгээс 2018 онд сумдын ОНХС-д 17.2 тэрбум төгрөгийн урамшуулал, дэмжлэгийг олгохоор төлөвлөсөн. 2018 онд олгох урамшууллыг тооцохдоо 2016-2017 оны сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн шаардлага хангасан 165 сумдад 903.7 сая төгрөг олгохоор тооцлоо. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн итгэлцүүрт үндэслэн 330 суманд нийт 16.3 тэрбум төгрөгийн дэмжлэгийг олгохоор төсвийн төсөлд тусгалаа.

11. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР 2018 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

11.1. Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаар ерөнхий танилцуулга

Монгол Улсын Засгийн газар гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагаас 1991-2016 он хүртэлх хугацаанд нийт 3.6 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласан байна.

Үүнээс 2016 онд зээлийн ашиглалт 1,350.1 тэрбум төгрөг буюу 632.6 сая ам.доллар, 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Азийн хөгжлийн банкнаас ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд авсан төсвийн дэмжлэгийн зориулалтаар олгосон 100.0 сая ам.долларыг оруулсан дүнгээр 705.7 тэрбум төгрөгийн гадаад зээлийн ашиглалт гарсан байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2017 онд гадаад төслийн зээлийн ашиглалт 878.6 тэрбум төгрөг, гадаад тусламжийн ашиглалт 75.7 тэрбум төгрөг гарахаар байна.

11.2. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй болон шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй танилцуулга

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд нийт 127 төсөл, арга хэмжээнд ойролцоогоор 1.1 их наяд төгрөгийг эдийн засгийн үр ашигтай төслүүд болох эрчим хүч, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн салбарын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашиглахаар төлөвлөж байгаа юм. Тухайлбал, БНХАУ-ын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл”, “УБ-мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл”, БНСУ-ын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 10 аймгийн дулааны цахилгаан станцын төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, барих, БНПУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих, Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барьж буй Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулах, БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Газрын тос боловсруулах үйлдвэрийг барих” зэрэг төслүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих, хилийн боомтуудын нэвтрэх чадавхыг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банк, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах, хилийн боомтуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, дэд бүтцийг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилго бүхий төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нэн тэргүүний ач холбогдолтой боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөгжлийн багц төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, техник эдийн засгийн судалгааг 2017, 2018 оны төсвийн жилд багтаан эхлүүлэх, зураг төсвийг боловсруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг авч ашиглана. Тухайлбал, БНСУ-ын Засгийн газраас авах 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, АХБ-ны зээл, БНХАУ-ын 1 тэрбум ам.долларын зээлийн үлдэгдэл хөрөнгөөр эмнэлэг, сургууль, цэцэрлэг, дотуур байр зэрэг нийгмийн ач холбогдолтой эрүүл мэнд, боловсролын салбарын багц төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт № 306. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	Гадаад зээл		Гадаад тусламж	
	Тоо	Дүн /сая төгрөг/	Тоо	Дүн /сая төгрөг/
01. Монгол Улсын Их Хурлын дарга			1	2,684.9
Хэрэгжиж байгаа			1	2,684.9
02. Монгол Улсын Ерөнхий сайд	1	15,761.4		
Шинээр хэрэгжих	1	15,761.4		
03. Монгол Улсын Шадар сайд	2	7,433.7	1	2,006.0
Хэрэгжиж байгаа	1	2,800.0	1	2,006.0
Шинээр хэрэгжих	1	4,633.7		
04. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	1	7,762.5	1	265.2
Хэрэгжиж байгаа	1	7,762.5	1	265.2
05. Барилга, хот байгуулалтын сайд	7	41,420.4	1	343.2
Хэрэгжиж байгаа	2	13,024.1	1	343.2
Шинээр хэрэгжих	5	28,396.3		
06. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	87.6	7	9,979.4
Хэрэгжиж байгаа			6	9,604.1
Шинээр хэрэгжих	1	87.6	1	375.3
07. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	8	79,317.3	4	56,969.1
Хэрэгжиж байгаа	6	63,993.7	2	36,610.3
Шинээр хэрэгжих	2	15,323.6	2	20,358.8
08. Сангийн сайд	16	201,103.8	3	10,916.7
Хэрэгжиж байгаа	8	104,298.3	2	2,011.9
Шинээр хэрэгжих	8	96,805.4	1	8,904.8
09. Зам, тээврийн хөгжлийн сайд	12	278,173.5	1	920.4
Хэрэгжиж байгаа	8	251,584.5	1	920.4
Шинээр хэрэгжих	4	26,589.0		
10. Хууль зүй, дотоод хэргийн сайд	3	25,645.5	1	625.5
Хэрэгжиж байгаа	3	25,645.5	1	625.5
11. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	4	39,006.0	2	1,414.6
Хэрэгжиж байгаа			1	1,039.4
Шинээр хэрэгжих	4	39,006.0	1	375.3
12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4	16,134.1	2	9,513.7
Хэрэгжиж байгаа	2	5,600.0	1	1,858.1
Шинээр хэрэгжих	2	10,534.1	1	7,655.5
13. Эрүүл мэндийн сайд	8	80,565.1	3	8,269.5
Хэрэгжиж байгаа	7	73,395.5	2	2,015.0
Шинээр хэрэгжих	1	7,169.6	1	6,254.5
14. Эрчим хүчний сайд	9	119,870.4	3	4,016.0
Хэрэгжиж байгаа	2	27,102.9	1	850.0
Шинээр хэрэгжих	7	92,767.5	2	3,166.0
15. Монгол Улсын ерөнхий прокурор			1	300.2
Шинээр хэрэгжих			1	300.2
16. Монгол Улсын ерөнхий аудитор			1	87.6
Хэрэгжиж байгаа			1	87.6
17. Үндэсний статистикийн газрын дарга			1	24.4
Хэрэгжиж байгаа			1	24.4
18. Нийслэлийн Засаг дарга	13	89,418.7	3	1,663.6
Хэрэгжиж байгаа	9	64,830.3	2	1,538.5
Шинээр хэрэгжих	4	24,588.4	1	125.1
19. Дархан-Уул аймгийн Засаг дарга	2	4,200.0		
Хэрэгжиж байгаа	2	4,200.0		
НИЙТ ДҮН	91	1,005,900.0	36	110,000.0

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг Төсвийн ерөнхийлөн захирагч, санхүүжүүлэгч тус бүрээр дэлгэрэнгүй авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

11.2.1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

11.2.1.1. Монгол Улс дахь төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.8 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,684.9 сая төгрөг

Иргэдийн төлөөллийн байгууллага, нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, чадавхыг бэхжүүлэхэд оршино.

11.2.2. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

11.2.2.1. Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	21.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	15,761.4 сая төгрөг

Үндэсний радио долгионы хяналт харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, Монгол Улсын төрийн өмчийн шилэн кабелийн үндсэн сүлжээний хүртээмж, чанарыг сайжруулах бөгөөд төслийн хүрээнд тоног, төхөөрөмжүүд, радио долгион хяналтын станцууд нийлүүлэгдэнэ.

11.2.3. МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

11.2.3.1. Зудын болон ой сав, тал газарт гарах гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,006.0 сая төгрөг

Иргэдийн бүлгүүдийг байгуулж, орон нутагт суурилсан гамшгийн эрсдэлийн удирдлага (ОНСГЭУ)-ын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх механизмуудыг туршин нэвтрүүлэх замаар орон нутгийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх, сэргээн босгох чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдэнэ. Төслийн үйл ажиллагаа нь ядуурлыг бууруулахад чиглэсэн, оролцооны зарчимд тулгуурлана.

Төсөл нь сумын төвд оршин суудаг 2,500, тэр дундаа 250 өрх толгойлсон эмэгтэй өрхийн нийт 7,000 малчин байх бол шууд бус байдлаар олон нийтийг илүү өргөн хүрээгээр хамруулж, төсөл хэрэгжих зорилтот сумдын нийт 32,000 хүн амд хүрнэ. Энэхүү төсөл нь Монгол улсад гамшгийн эрсдэлийн удирдлага (ГЭУ)-д олон нийтийн оролцооны босоо чигийн зохион байгуулалттай механизмыг туршин нэвтрүүлэх анхны тохиолдол болно.

11.2.3.2. Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Мал, ургамлын эрүүл ахуйн хяналт шалгалтын тогтолцоог Дэлхийн Худалдааны Байгууллагын тавьдаг шаардлагын түвшинд хүргэх, мал, ургамлын гаралтай хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний импорт болон экспортыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд төслийн зорилго оршино.

11.2.3.3. Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНПУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,633.7 сая төгрөг

Төслийн зорилго нь Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах аврах, эрэн хайх зориулалтын автомашин техникийг олон улсын түвшинд хүргэх, гал түймэр унтраах аврах ангиудын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, аврах, эрэн хайх, гал түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулахад төслийн зорилго оршино.

11.2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

11.2.4.1. Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	450.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	265.2 сая төгрөг

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг (ОУИТБС) хэрэгжүүлж ажлыг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх ажлын хүрээнд Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоог тодорхойлж, олон нийтэд байгалийн нөөц баялгийн ашиглалтыг нээлттэй ил тод байдлыг бий болгоход чиглэгдэнэ.

11.2.4.2. Ухаалаг засаг төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.6 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,762.5 сая төгрөг

Цахим Засаг үндэсний хөтөлбөрийн хүрээнд Цахим Засгийг хөгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах, мэдээлэл технологийн дэд бүтцийг хөгжүүлэх, Засгийн газрын мэдээллийг цахимжуулах, иргэдэд төрийн үйлчилгээг онлайн хэлбэрээр хүргэх, иргэдийн технологийн хэрэглээний тэгш бус байдлыг багасгах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилготой.

11.2.5. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД

11.2.5.1. Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,000.0 сая төгрөг

Төслийн зорилго нь төсөлд хамрагдсан суурин газрын эдийн засгийн хөгжлийг дэмжих, үр ашигтай-зөв төлөвлөх, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх болон нийтийн ахуйн үйлчилгээний тогтвортой байгууллагыг бий болгоход чиглэж байна.

11.2.5.2. Зүүн өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төслийн нэмэлт санхүүжилт /Өмнөговь, Дорноговь/ MON-3388

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	21.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2010-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	343.2 сая төгрөг

Төслийн зорилго нь экологийн даацыг бууруулалгүй хотын иргэдийн тав тухтай амьдрах орчныг хангасан уул уурхай, барилга, барилгын материал, хүнсний үйлдвэрлэл, газрын тос боловсруулах үйлдвэр, эрчимжсэн ХАА, тээвэр ложистик, шинжлэх ухаан, боловсролын цогцолборт тулгуурласан төв болгон хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, цэвэрлэгдсэн бохирыг цаашид ногоон байгууламжийн усжуулалт, үйлдвэр болон технологийн хэрэглээнд ашиглах боломжийг бүрдүүлэх, мөн хэрэглээнээс гарсан бохир усыг үндэсний стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэх бүтээмж өндөртэй, эрчим хүчний хэмнэлттэй шинэ технологийн тоног төхөөрөмж бүхий бүрэн биологи цэвэрлэгээний байгууламжийг ашиглалтад оруулахад оршино.

11.2.5.3. Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	99.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,024.1 сая төгрөг

Улаанбаатар хотын VII дугаар хороолол, XIV дүгээр хороололд баригдах орон сууцны барилга, VII дугаар хороолол, МҮОНРТ-ийн орчимд баригдах орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Улаанбаатар хотын VII-р хороолол, Монголын Радио телевизийн хэрэг эрхлэх газрын орчмын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ, VII, XIV-р хороололд баригдах 2592 айлын орон сууцны барилга, инженерийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдэнэ.

11.2.5.4. Дэд бүтцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.0 сая евро

Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,021.1 сая төгрөг

Аймаг, нийслэлийн иргэдийн аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүн амын тоо өндөр, гэр хорооллын дэд бүтэц бага хөгжсөн Баянзүрх дүүрэг болон Дархан хотын алслагдсан хороод, Сэлэнгэ аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх, алслагдсан баг, хороодын гудамж талбайг камержуулах, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэнэ.

11.2.5.5. Дэд бүтцийн хөгжил-Сонгинохайрхан төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,169.6 сая төгрөг

Нийслэлийн иргэдийн аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүн амын тоо өндөр, гэр хорооллын дэд бүтэц бага хөгжсөн Сонгинохайрхан дүүргийн дэд бүтцийг хөгжүүлэх, алслагдсан хороодын гудамж талбайг камержуулах, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэнэ.

11.2.5.6. Тайшир-Алтай ус хангамж төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	14.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	10,339.2 сая төгрөг

Говь-Алтай аймгийн төв Алтай хотод 6000 орчим өрхөд 20000 гаруй хүн ам ажиллаж амьдарч байгаа бөгөөд Алтай хотын усан хангамжийн усны нөөцийн одоо ашиглаж байгаа эх үүсвэр нь хүн амын ундны усны стандартыг хангадаггүй, кальци, магнийн харьцаа алдагдсан, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаагаас гадна усны нөөцийн хэмжээ ус хэрэглээний өнөөдрийн хэрэгцээг хангаж чадахгүй болоод байна. Энэхүү төсөл нь Говь-Алтай аймгийн Алтай хотын 20 гаруй мянган хүн амын ундны усны хэрэгцээг хангах чухал холбогдолтой.

11.2.5.7. Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт - 2

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг

Төслийн зорилго нь төсөлд хамрагдсан хотуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих, үр ашигтай-зөв төлөвлөх, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх болон нийтийн ахуйн үйлчилгээний тогтвортой байгууллагыг бий болгоход чиглэж байна.

11.2.5.8. Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНПУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.9 сая евро

Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,691.3 сая төгрөг

Баян-Өлгий аймаг, Завхан аймгийн Улиастай сум, Сүхбаатар аймгийн Баруун урт, Говь-Сүмбэр аймгийн Чойр сум, Дорнод аймгийн Чойбалсан сум, Сэлэнгэ аймгийн Хөтөл сум, Дархан-Уул аймгийн Шарын гол сумдын 1970-1990 онуудад баригдсан элэгдэж хуучирсан бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, шинээр барьснаар иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

11.2.6. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

11.2.6.1. Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Нэгдсэн Үндэсний Байгууллага
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	112.4 сая төгрөг

Монгол орны олон янз экосистемийн нэгдмэл байдлыг хангаснаар дэлхийн хэмжээнд ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн оршин байх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

11.2.6.2. Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөр

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Нэгдсэн Үндэсний Байгууллага
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,480.5 сая төгрөг

Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөрийн ерөнхий зорилго нь Монгол Улсын Засгийн Газарт Үндэсний REDD-ийн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийг Варшавын тунхаглалын шаардлагуудтай нийцүүлэн REDD-ийн үр дүнд суурилсан урамшууллыг хүртэхэд туслалцаа үзүүлэх юм.

11.2.6.3. Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл – MON49113

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	555.5 сая төгрөг

Төслийн хэрэгжсэнээр гэр хорооллын бүсэд нийгмийн эрүүл мэндийн нөхцөл сайжирч, хөрсний бохирдол буурна. Төслөөс хүлээж буй үр дагаврын хувьд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг гэр хороололд нэвтрүүлэх болон хүний хаягдал ялгадсаас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах загвар үйл ажиллагаануудыг туршин хэрэгжүүлнэ.

11.2.6.4. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл 9183-MON

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019

2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт 1,033.0 сая төгрөг

Хөвсгөл нуур орчмын өрхийн амьжиргааг дээшлүүлэх, байгалийн баялгийн удирдлагыг сайжруулах, аялал жуулчлалыг дэмжих юм. Үүнд:

- Хатгал, Ханх сууринд нутгийн хүн амд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх,
- Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүс /Хатгал тосгон, Алаг-Эрдэнэ, Ханх, Рэнчинлхүмбэ, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/-ийн иргэдийн амьжиргааг сайжруулах,
- Мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээрийн менежмент сайжирч малчдын орлогыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх,
- Хөвсгөл нуур орчмын хог хаягдлын менежментийн загварыг бий болгох.

11.2.6.5. Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	15.3 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,051.0 сая төгрөг

Монгол Улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн систем(дэмжих бүс болон экологийн коридор)-ийг чадавхжуулах, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зөвлөмж гаргах, хөрөнгө оруулалт хийх, орон нутгийн хүн амын амьжиргааг дээшлүүлж тогтворжуулна. Уг төсөл нь уур амьсгалын нөлөөллийг харгалзаж үзэж биологийн төрөл зүйлийг хамгаалах, амьжиргааны түвшнийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа Монгол-Германы хамтарсан “Биологийн төрөл зүйл” хөтөлбөрийн зорилгыг биелүүлэх үндсэн үйл ажиллагаа юм.

11.2.6.6. Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Нэгдсэн Үндэсний Байгууллага
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	371.7 сая төгрөг

Монгол орны баруун бүсэд хөгжлийн сөрөг нөлөөлөл, газрын доройтлыг бууруулах үе шат, дүйцүүлэн хамгааллыг ландшафтын түвшний төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад төслийн зорилго оршино. Цаашид төслийн зорилтот сумдын доройтсон бэлчээрт худаг гаргах, булаг шанд тохижуулах, хөв цөөрөм байгуулах аргаар бэлчээрийн ургах чадварыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлнэ.

11.2.6.7. Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	38.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	87.6 сая төгрөг

Аялал жуулчлалыг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг шийдвэрлэх, нийгмийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино.

11.2.6.8. Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцөлийг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	375.3 сая төгрөг

Мазаалай баавгайг байгалийн нөхцөлд нь хамгаалахын тулд түүний амьдрах орчны таатай нөхцөлийг дэмжин тэтгэх замаар боломжтой орон зайг нь тэлэх, амьдрах орчны чанарыг илэрхийлэх түлхүүр хүчин зүйлийн (уст цэг, идэш тэжээлийн нөөц, нуугдах хоргодох боломжтой газар нутаг) нөлөөллийг нэмэгдүүлэхэд оршино.

11.2.7. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД

11.2.7.1. Баруун бүсийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөл – JFPR9182

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,316.7 сая төгрөг

Төслийн зорилго нь хүүхэд бүрт, ялангуяа малчин өрхийн хүүхдэд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмшүүлэх үүднээс баруун бүсийн 3 аймагт сургуулийн дотуур байрны материаллаг орчин, үйлчилгээг сайжруулах загвар тогтоож хэрэгжүүлэхэд оршино. Төсөл нь Говь-Алтай, Завхан, Увс аймгийн 20 сургуульд хэрэгжих бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилд суралцаж буй нийт 5526 бага ангийн сурагчид, эдгээр сургуулийн дотуур байранд амьдарч буй малчдын хүүхдүүдэд төслийн үр дүн шууд хүрнэ.

11.2.7.2. Дээд боловсролын шинэчлэл төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.6 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,820.5 сая төгрөг

Дээд боловсролын хөтөлбөрийн чанар, нийцэмж, дээд боловсролын засаглал, удирдлага, санхүүжилтийн үр өгөөж болон тэгш байдал, хүртээмжийг сайжруулах замаар Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйц дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай их, дээд сургууль төгсөгчдийн тоог нэмэгдүүлэхэд оршино.

11.2.7.3. Боловсролын чанарын шинэчлэл төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.5 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	10,392.4 сая төгрөг

Бага боловсролын эх хэл, байгалийн ухаан ба математикийн сургалтын чанар, үр дүнг сайжруулж, сургуулийн түвшинд төлөвлөлтийг бэхжүүлэх замаар бага боловсролын чанарыг сайжруулахад оршино.

11.2.7.4. Ухаалаг боловсрол

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.6 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	9,824.4 сая төгрөг

Төслийн зорилго нь уламжлалт сурах бичигтэй хослуулан төрөл бүрийн мультимедиа, интерактив контент ашиглах, анги танхимд багш төвтэй сургалт явагдах, мэдээллийн технологид суурилсан сургалтад үе шаттай шилжих боломж бүрдэхэд оршино. Төсөлд 150 төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудыг хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх, суурилуулах, төсөлд хамрагдаж буй багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгдэхэд ашиглагдах дижитал тоног төхөөрөмжийг эх хэл дээр ашиглах нөхцөл бололцоогоор хангана.

11.2.7.5. Шинэ зууны боловсрол төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	45.7 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	5,374.6 сая төгрөг

Төслийн хүрээнд нийслэлийн 97, аймгийн төвийн 55, сумын 473, нийт 625 сургуулийн шилэн кабель бүхий интернетийн үйлчилгээг хүртэх боломжтой болно. Түүнчлэн, боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох нөхцөл бүрдэх бөгөөд төслийн хүрээнд нийт 25 мянган компьютер нийлүүлж сургуулийн багш нарыг 100% зөөврийн компьютерээр хангаж, сурагч, багш нарын хооронд мэдээллийг түргэн шуурхай авах, E-контентыг хэрэглэх орчин бүрдэнэ.

11.2.7.6. Мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНЭУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,921.8 сая төгрөг

Олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийг байгуулж, улмаар мэдээллийн технологийн салбараар дамжуулан Монгол Улсын экспортыг дэмжихэд төслийн зорилго оршино.

11.2.7.7. Инженер технологийн дээд боловсрол төсөл MON-P11 /Япон/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар – ЯОУХААБ
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	6.8 тэрбум иен
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	25,660.1 сая төгрөг

Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулахад оршино.

11.2.7.8. Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	50.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,756.3 сая төгрөг

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулж 3 ээлжээр ажиллаж байгаа сургуулиудыг 2 ээлжид шилжүүлэх, сургуулиас өмнөх, бага болон дунд сургуулиудын боловсролын чанарыг сайжруулах юм.

11.2.7.9. Ерөнхий боловсролын сургууль барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	300.0 сая юань
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	20,233.7 сая төгрөг

Төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 6-р хороо, 25-р хороо, 26-р хороо, Баянзүрх дүүргийн 12-р хороо, 19-р хороо, Хан-Уул дүүргийн 15-р хорооны сургууль болон Архангай аймгийн цэцэрлэгийн барилгыг тус тус барина.

11.2.7.10. Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	23.7 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,567.3 сая төгрөг

МУИС-ийн шинэ номын сангийн барилгыг тавилгажуулж, орчин үеийн ухаалаг системээр бүрэн тоноглогдсон, сургалт-судалгаа-мэдээллийн цоо шинэ цогц орчныг бүрдүүлэх, одоо байгаа МУИС-ийн барилгад лабораторийн нарийн шаардлага, үзүүлэлтийг хангасан барилгын өргөтгөл барьж, тоноглоход төслийн санхүүжилт зарцуулагдана. Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ.

- "Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого"-оор төрөөс өгсөн даалгаврыг биелүүлэх нөхцөл бүрдэж, "МУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх суурь нь тавигдана.

- Улс орны хэмжээнд нээлттэй үйл ажиллагаа явуулах, дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжтэй лабораторитой болно.

- Монгол улсын сургалт, эрдэм шинжилгээ эрхэлдэг бусад их сургууль, судалгааны байгууллагын эрдэмтэдтэй хамтын судалгаа хийх нөхцөл бүрдэнэ.

- Судалгааны чанарыг илүү өндөр түвшинд гаргаж, МУИС-ийн эрдэмтдийн олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд хэвлүүлэх бүтээлийн тоо өснө.

- Оюутны суралцах орчин эрс сайжирч, "ухаалаг" боловсролын тогтолцоо бүрдэж, сургалтын чанар дээшилж, оюутны сэтгэл ханамж өснө.

- Азид өрсөлдөх чадвартай их сургуулийг цогцлуулах суурь нөхцөлийг бүрдүүлэхэд энэ төслийн ач холбогдол оршино.

11.2.7.11. Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	125.1 сая төгрөг

Улаанбаатар хотод өндөр чанартай бага дунд боловсролын сургалтын байрыг барьж, барилга байгууламжийн тоо хүрэлцээгүй байдлыг сайжруулах, боловсролын салбарыг хөгжүүлэх зорилготой. Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Налайх дүүргүүдэд Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөл, сургуулийн шинэ барилга барьж, сургалтын орчныг сайжруулна.

11.2.8. САНГИЙН САЙД

11.2.8.1. Бүс нутгийн хилийн үйлчилгээг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.4 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	15,290.8 сая төгрөг

Замын-Үүд, Алтанбулаг, Бичигт хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулж, гаалийн автоматжуулсан мэдээллийн системийг шинэчлэн сайжруулах, тус системийг Татварын ерөнхий газрын мэдээлэл, харилцаа холбооны системүүдтэй харилцан ажиллах чадвартай болгож, гадаад худалдааны цахим нэг цонхны системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана. Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

- Замын-Үүд, Алтанбулаг, Бичигтийн хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах,
- КАИС-ийг шинэчлэх, мэдээлэл технологийн системүүдийг харилцан ажиллах чадвартай болгох,
- Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах юм.

11.2.8.2. Зээлийн баталгааны системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	60.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,500.0 сая төгрөг

Жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж, уул уурхайн бус салбаруудын ажил эрхлэлтийг бий болгох замаар эдийн засгийг төрөлжүүлэхэд оршино.

11.2.8.3. Төлбөрийн системийн шинэчлэл төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
---------------------------------	---------------------

Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,000.0 сая төгрөг

Эдийн засаг дахь өсөн нэмэгдэж буй санхүүгийн зах зээлийн хэрэгцээг хангах, улс үндэстнийг бүхэлд нь хамарсан төлбөрийн цогц үйлчилгээг бий болгох, төлбөр түргэн гүйцэтгэх төлбөрийн найдвартай системтэй болох, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж байна. Төслийн хүрээнд төлбөрийн системийн шинэчлэлийг хийж, техник, тоног төхөөрөмжийг суурилуулах, төлбөрийн системийн дэд бүтцийг сайжруулна.

11.2.8.4. Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн нэмэлт-Тусгай

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	35.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	32,014.5 сая төгрөг

Агро бизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахад оршино.

11.2.8.5. Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн нэмэлт-Энгийн

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,860.9 сая төгрөг

Агро бизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулна.

11.2.8.6. Тогтвортой амьжиргаа төсөл III - 5487MOG

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	16.1 сая зээлжих тусгай эрх, 3.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	18,765.2 сая төгрөг гадаад зээл, 1,614.1 сая төгрөг буцалтгүй тусламж

Монгол Улсын хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулахад чиглэгдэнэ.

11.2.8.7. Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - 4888MOG

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	16.0 сая зээлжих тусгай эрх, 4.2 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,200.0 сая төгрөг гадаад зээл, 397.8 сая төгрөг буцалтгүй тусламж

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хөгжлийн зорилт нь санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийг

дэмжихийн тулд дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийхийг дэмжиж дэд бүтцийн төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх дотоод чадавхыг нэмэгдүүлнэ.

11.2.8.8. Экспортыг дэмжих төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	14.3 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,667.0 сая төгрөг

Төслийн зорилго нь уул уурхайн бус салбар дахь жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжийн (ЖДААН) экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлийг өргөжүүлэх зорилготой.

Монгол Улсын эдийн засгийн уул уурхайн салбараас хамааралтай байдлыг бууруулж эдийн засгаа төрөлжүүлэх, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлага бий болоод байгаа билээ. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд экспортлоход шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, туршлага судлах, экспортын даатгал гэх мэт санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүдийг бий болгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна тодорхой зорилтот зах зээлүүдэд нэвтрэх боломжийг нээх юм.

11.2.8.9. Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	25.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг

Төсвийн хөрөнгө оруулалт удирдлага, татварын мэдээллийн системийн дэд бүтэц, хяналтын системийг сайжруулахад оршино.

11.2.8.10. Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.0 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,155.9 сая төгрөг

Төсвийн болон санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, зарцуулалтын удирдлагын чанарыг сайжруулахад оршино.

11.2.8.11. БНСУ-ын 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх салбарын хөгжлийн хөрөнгө оруулалтын багц төсөл арга хэмжээ

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	500.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,000.0 сая төгрөг

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газраас авах 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр эрүүл мэнд, боловсрол, зам, тээвэр, дэд бүтэц, барилга

хот байгуулалт, эрчим хүч, хөдөө аж ахуй байгаль орчны салбарын багц төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

11.2.8.12. БНХАУ-ын 1 тэрбум ам.долларын үлдэгдэл хөрөнгөөс хэрэгжүүлэх салбарын хөгжлийн багц төсөл, арга хэмжээ

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	233.2 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	19,306.9 сая төгрөг

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас авах 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл хөрөнгөөс Дэд бүтэц, авто зам, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөгжлийн багц төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

11.2.8.13. БНХАУ-ын тусламжийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.0 болон 2.0 тэрбум юань
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,904.8 сая төгрөг

Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Хятадын талаас шинээр олгох 2 тэрбум юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүд байгуулах” төслийг хэрэгжүүлэх шийдвэр гарсан.

11.2.8.14. Дэд бүтэц төсөл - Нүхэн гарц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	38.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	19,964.5 сая төгрөг

Нийслэл хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах үндсэн зорилтын хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Баянгол дүүргүүдэд 9 байршилд авто-тээврийн хэрэгсэл зорчих нүхэн гарцын байгууламж, төмөр замын гармуудыг байгуулна.

11.2.8.15. Дэд бүтэц төсөл - Туул, Сэлбэ гол орчмыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	57.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	27,446.7 сая төгрөг

Ногоон Улаанбаатар 2030 хөтөлбөр, Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн зорилтын хүрээнд хотоор дайран урсах Туул, Сэлбэ голын дагуу иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эко, аюулгүй орчныг бий болгох юм. Үүний дагуу 40 км гаруй дугуйн зам, амралт зугаалгын бүс, Улаанбаатар хотын цэцэрлэгт хүрээлэнг 66 га-аар нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

11.2.8.16. Энэтхэг Улсын 1 тэрбум ам.долларын экспортын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНЭУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.0 тэрбум ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,756.3 сая төгрөг

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авах 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахаар төлөвлөж байна. Төслийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна.

11.2.8.17. Экспортын зээлийн шугам JBIC-CLA

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,000.0 сая төгрөг

Төслийн зорилго нь Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулах экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн төслийн хүрээнд зээлийн шугам нээж, зээлийн эх үүсвэрийг дотоодын арилжааны банкаар дамжуулан дотоодын үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжээс гаргасан төслийн хүсэлтэд үндэслэн тэдгээрийн бизнесийг өргөжүүлэхэд шаардлагатай экспортын зээл олгох замаар үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг сайжруулахад оршино.

11.2.9. ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

11.2.9.1. Баруун бүсийн босоо тэнхлэгийн автозамыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	125.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,000.0 сая төгрөг

Монгол Улсын баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын нийт урт нь БНХАУ-тай хил залгаа Ярантын хилийн боомтоос ОХУ-тай хил залгаа Улаанбайшинтын хилийн боомт хүртэл 743.1км бөгөөд энэхүү коридор нь Монгол Улсыг баруун бүсийн Ховд, Баян-Өлгий аймгаар БНХАУ-ын Шинжаань бүс, ОХУ-ын Сибирийн бүстэй холбох Азийн авто замын АН-4, CAREC-ийн коридор 4"а" чиглэлийн нэг хэсэг юм. Энэхүү коридорыг Монгол Улсын болон Азийн авто замын төлөвлөлтийн стандартыг хангахуйц асфальт бетон хучилттай авто замаар бүрэн холбосноор Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил, дотоодын зах зээлийг дэмжиж, улмаар дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн Монгол Улсын тээврийн стратегийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

11.2.9.2. Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	25.4 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2019

2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт 3,500.0 сая төгрөг гадаад зээл, 920.4 сая төгрөг буцалтгүй тусламж

Төслийн зорилго нь Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх, гадаадаас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэхэд оршино. Мөн Замын-Үүд боомтод үр ашигтай, өрсөлдөхүйц, найдвартай холимог тээврийн системийг хөгжүүлэх ложистикийн төвийг байгуулах зорилготой юм.

11.2.9.3. Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	59.8 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	44,136.2 сая төгрөг

Хөдөө аж ахуйд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлд нийлүүлэх чадварыг нэмэгдүүлэх замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм. Энэ хүрээнд Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам барих ажил хийгдэж, баруун бүсийн эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц үзүүлэх ач холбогдолтой юм.

11.2.9.4. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	44.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	39,287.4 сая төгрөг

Хөдөө аж ахуйд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлд нийлүүлэх чадварыг нэмэгдүүлэх замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм. Энэ хүрээнд Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам барих ажил хийгдэж, энэ нь баруун бүсийн эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц үзүүлэх ач холбогдолтой юм.

11.2.9.5. Улаанбаатар-Хөшигтийн хөндий шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	147.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	74,204.7 сая төгрөг барилга угсралт, 3,321.8 сая төгрөг зөвлөх

Улаанбаатар-Хөшигтийн хөндий олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орж байгаатай холбогдуулж, энэ чиглэлийн 32.5 м өргөн асфальт бетон хучилттай зорчих хэсэгтэй, 2 урсгал 6 эгнээтэй олон улсын стандартад нийцсэн хурдны авто замыг ашиглалт оруулж, авто замын сүлжээг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бий болгоход төслийн зорилго оршино.

11.2.9.6. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төсөл – нэмэлт санхүүжилт /MON-P12/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	35.3 тэрбум иен
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	48,584.5 сая төгрөг

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг барьж, улмаар Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудлын үйлчилгээнд тулгарч буй хүндрэлийг арилгах, агаарын тээврийн салбарын хөгжлийг эрчимжүүлэхэд төслийн зорилго оршино.

11.2.9.7. Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх, зам засварын төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	60.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,502.5 сая төгрөг

Зам засвар, шинэчлэлийн ажлыг хийж, замын аюулгүй байдлыг хангах, замын хөрөнгийн удирдлагын чадавх, хэрэгжилтийг сайжруулахад чиглэнэ.

11.2.9.8. Авто замын байгууламжийн нэмэлт материалын үйлдвэр байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Польш Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.1 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,477.3 сая төгрөг

Авто замын байгууламжийн “Дуосолид” нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах бөгөөд уг бүтээгдэхүүнийг шавар, холимог, хайрга болон холимог хөрсийг сайжруулж илүү тогтвортой болгох, Эрдэст-асфальт хучилтын доор шууд тавигдах, холимог хөрсөөр нэмэлт давхарга хийх, эх хөрсийг эсвэл ухмал хөрсийг сайжруулах, хүчитгэх, тогтворжуулах зориулалтаар төмөр замын суурь барих, мөн хамгаалалт аюулгүй байдлыг хангах элементүүдийг хүчитгэх, төмөр замын дээд хэсэгт хэрэглэгддэг хамгаалалтыг далдлах, хуучин замыг сэргээн засварлахад хуучин асфальт бетон хучилтыг хольж нийлүүлэн ашиглаж дахин суурийн давхарга хийж дээр нь шинэ эрдэст-асфальт бетон давхарга болгох зориулалттай төсөл юм.

11.2.9.9. Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ-2

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	30.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	24,549.9 сая төгрөг

Улс хот хоорондын нийтийн тээврийн паркийг шинэчлэхэд шаардагдах бараа, материал, тоног төхөөрөмж, автобус нийлүүлэгдэнэ.

11.2.9.10. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	380.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021

2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт 3,000.0 сая төгрөг

Төслийн зорилго нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 орчим км төмөр замын суурь бүтцийг байгуулна.

Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулснаар Тавантолгойн уурхайгаас коксжих нүүрсийг Монгол Улсын Гашуунсухайт, БНХАУ-ын Ганцмод хилийн боомтуудаар нэвтрүүлэн БНХАУ-руу экспортлох нүүрсний экспортын тээврийн зардал 1 тонн тутамд 10 орчим ам.доллараар буурах ба тус төмөр зам ашиглалтад орсноор жилд 30 сая тонн хүртэлх хэмжээний нүүрс экспортлох боломжтой болно.

Энэхүү төмөр замаар дамжуулан Хятадын нутаг, түүний далайн боомт, гуравдагч зах зээл рүү тээвэрлэлт хийх боломж бүрдэж Монгол Улсын уул уурхайн компаниуд хямд үнээр дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой болно.

Тус төмөр замыг барьж ашигласнаар орон нутагт ажлын байр нэмэгдэх, дэд бүтэц хөгжих бөгөөд Тавантолгой уурхайгаас авто-замаар тээвэрлэж буйгаас үүдсэн байгаль орчныг доройтуулах, орчны тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдол үлэмж хэмжээгээр багасч авто осол багасаж замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдана.

11.2.9.11. Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км автозам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	24.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	12,609.1 сая төгрөг

“Шинэ бүтээн байгуулалт, дунд хугацааны зорилтот хөтөлбөр” болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилтын дагуу Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

11.2.10. ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

11.2.10.1. Төрийн тусгай албан хаагчдыг нэгдсэн эмнэлэг төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,169.6 сая төгрөг

Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг (ТТАХНЭ)-ийн багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг бэлтгэх төсөл нь үйлчлэх хүрээний иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмч, мэргэжилтнийг чадавхжуулахад оршиж төслийн хүрээнд эмнэлгийн тоног, төхөөрөмж суурилуулагдаж, эмч, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлнэ.

11.2.10.2. Эрхзүйн шинэчлэл багц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
---------------------------------	------------------------------------

Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	44.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,502.5 сая төгрөг

Хууль сахиулах байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг зөрчилд тавих цахим хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, хууль зүйн салбарын материаллаг бааз, хүний нөөцийг бэхжүүлэхэд оршино.

11.2.10.3. Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	28.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,973.3 сая төгрөг

Төслийн зорилго нь иргэдийн аюулгүй, таатай орчинд амьдрах үндсэн зорилтын хүрээнд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төвүүдийн зам, гудамж, талбайн камерын хяналтын цэгийг нэмэгдүүлж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бүтээмжийг дээшлүүлэхэд оршино.

11.2.11. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

11.2.11.1. Хөдөө аж ахуйн маркетинг төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	11.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,039.4 сая төгрөг

Мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах, зах зээлтэй холбох, нэр төрлийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангахад оршино.

11.2.11.2. Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих замаар амьжиргааг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	375.3 сая төгрөг

Хүнсний ногоо болон үрийн аж ахуйн үр өгөөжийг сайжруулах замаар орлогын эх үүсвэрийг бий болгох, хүнсний нэр төрлийг нэмэгдүүлж хөдөөгийн хүн ам, ялангуяа 5 га хүртэлх газар эзэмшдэг жижиг фермерүүд болон хоршоологчдын амьжиргааг дэмжихэд оршино. Импортын хүнсний ногоо болон үрийн хэрэглээг бууруулах Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих юм.

11.2.11.3. Хөдөө аж ахуйн машин, трактор угсрах үйлдвэр байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНПУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	32.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021

2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт 10,110.1 сая төгрөг

Хөдөө аж ахуйн зориулалт бүхий Трактор угсрах үйлдвэр барих, дотооддоо трактор угсарч, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өртөг бууруулах, улс орны эдийн засагт дэмжлэг үзүүлэх, баялаг бүтээх, ажлын байр нэмэгдүүлэхэд төслийн зорилго оршино.

11.2.11.4. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл - нэмэлт санхүүжилт

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.1 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,378.2 сая төгрөг

Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх, Монгол Улсын Засгийн газрын Монгол мал хөтөлбөр, Хоршооллыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд төслийн зорилго оршино.

11.2.11.5. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	24.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	12,258.9 сая төгрөг

Төслийн хүрээнд худалдаж авах техник нь үр тариа, таримал тэжээлийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай байгаа дундаас дээш хүчин чадалтай трактор юм. Энэхүү техник, тоног төхөөрөмжийг тодорхой хувийг урьдчилгаатай, үлдэгдэл төлбөрийг урт хугацаатай зээлээр олгох нөхцөлөөр худалдан борлуулахаар төлөвлөж байна. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид техникээ шинэчлэхэд томоохон дэмжлэг үзүүлнэ.

11.2.11.6. Газар тариалангийн үйлдвэрлэлд хөрс хамгаалах, өндөр хүчин чадлын технологийг нэвтрүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	12,258.9 сая төгрөг

Дэвшилтэт техникийг газар тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлснээр атар газар эзэмшсэнээс хойш ашиглаж ирсэн хуучин технологийг халж, буруу ашиглалтаас болж жил бүр салхинд хийсгэж буй шим тэжээлт хөрсийг хамгаалж, бүтээмжийг нэмэгдүүлэн зардлыг бууруулж бүтээгдэхүүний гарцыг тогтмол болгох нь энэхүү төслийн зорилго болно. Төслийн хүрээнд дунд, том оврын трактор болон дунд, том оврын комбайн, өөрөө явагч хор цацагч тус тус нийлүүлэгдэнэ.

11.2.12. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

11.2.12.1. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	17.0 сая зээлжих тусгай эрх

Төсөл хэрэгжих хугацаа	2015-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх замаар хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг дээшлүүлэхэд оршино.

11.2.12.2. Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл-Нэмэлт санхүүжилт

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	13.0 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Төслийн зорилго нь төрийн бодлого, систем болон мэдээллийн технологийг бэхжүүлэх замаар нийгмийн халамжийн болон даатгалын үйлчилгээг үр ашигтай, ил тод байдлаар хүргэхэд оршино.

11.2.12.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	181.6 сая юань
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,858.1 сая төгрөг

Төслийн хүрээнд Баянгол дүүргийн 20 дугаар хороонд нийт 14990 м² талбайтай нөхөн сэргээлт хөгжлийн төв, туслах багажийн төв, цайны газар, ажлын өрөө, сургалтын өрөө болон стандарт эмчилгээний өрөө бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг барьж байгуулна.

11.2.12.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл /АХБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	25.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,378.2 сая төгрөг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл бие даах чадвар, нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оршино.

11.2.12.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	18.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,155.9 сая төгрөг

Ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх, төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, ил тод байдлыг сайжруулах замаар иргэдийн ажилд орох боломжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэхэд оршино.

11.2.12.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,655.5 сая төгрөг

Төслийн хүрээнд олон улсын стандартын шаардлага хангасан, физик эмчилгээний өрөө бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоног төхөөрөмжөөр бүрэн тоногдсон спорт цогцолборыг барьж байгуулна.

11.2.13. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

11.2.13.1. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл – MON0236

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	14.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,889.9 сая төгрөг

Эмнэлгийн салбарыг хөгжүүлэх, салбарын үр ашиг, засаглал, эмийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдэж байгаа бөгөөд төсөл дараах 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх,
- Хүний нөөцийн хөгжлийг сайжруулах,
- Эмийн аюулгүй байдлыг сайжруулах зэрэг болно.

11.2.13.2. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 нэмэлт санхүүжилт

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	16.2 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,507.4 сая төгрөг

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн эмнэлгийг Улаанбаатар хотдоо загвар болохуйц олон төрлийн тусламж, үйлчилгээтэй нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөх, ингэхдээ мэс засал, эхийн эрүүл мэндийн үйлчилгээг нэмэх, оношилгоо, лабораторийн хүчин чадлыг сайжруулах, амбулаторийн болоод хэвтэн эмчлүүлэх хэсгийн нэгдсэн удирдлага менежмент, сувилгааны загвар тусламж үйлчилгээ, эмнэлгийн хог хаягдлын боловсруулалт, халдвараас урьдчилан сэргийлэх, өвчтөн, санхүүгийн удирдлагад зориулсан технологийн хэрэгслүүд зэргийг боловсронгуй болгоход оршино.

11.2.13.3. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.5 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дэмжих, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, улсын хэмжээнд цусны аюулгүй байдлыг

бэхжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй, халдварын сэргийлэлт хяналтыг бэхжүүлэхэд оршино.

11.2.13.4. Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл - Бельги Улсын зээлийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Бельги Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	4.6 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,410.0 сая төгрөг

Бүс нутгийн эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвд дэвшилтэт оношилгооны тоног төхөөрөмжийг нийлүүлж, эмч мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, баруун бүсийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.

11.2.13.5. Цахим эрүүл мэнд төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	9,192.0 сая төгрөг

Эрүүл мэндийн байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаа, мэдээллийн урсгалын дүн шинжилгээ хийж эрүүл мэндийн мэдээллийн технологийн энтерпрайз архитектур бий болгон хөгжүүлнэ.

11.2.13.6. Түлэнхийн төв барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Кувейтийн Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	8.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	125.1 сая төгрөг

Монгол Улсын хэмжээнд түлэгдэлт, хөлдөлт, нөхөн сэргээх мэс заслын төрөлжсөн нарийн мэргэжлийн үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх, олон улсын чанар стандартад бүрэн нийцүүлэх, орчин үеийн оношилгоо эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглох, ард иргэдийн эрүүл мэндийг чандлан сахихад өндөр ач холбогдолтой.

11.2.13.7. Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	65.0 тэрбум вон
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	49,938.9 сая төгрөг

Төсөл нь хүн амын өсөлттэй холбогдон гарч буй бодит эрэлтэд тулгуурлан олон нийтэд эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээ, оношилгооны боломжит, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх, гадаадад эмчлүүлэхээр явж буй өвчтөнүүдийн тоо болон эрүүл мэндийн нийт зардлыг бууруулах, орон нутгийн болон эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтай газар илүү хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох, оношилгооны алдаанаас үүдэн гарах нас баралтын хэмжээг бууруулах зорилготой.

11.2.13.8. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн тусламж үйлчилгээг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНФУ-ын Засгийн газар – Натиксис банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	194.7 сая төгрөг

Улсын хэмжээнд осол гэмтлийн эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг төв эмнэлгийн хүлээн авах яаралтай тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт, чанарыг нэмэгдүүлж, улмаар нас баралт болон хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулахад чиглэгдэж байна.

11.2.13.9. Цахим эрүүл мэнд төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	18.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,352.5 сая төгрөг

Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчилж шаардлагатай тоног төхөөрөмжөөр болон программ хангамжийг нийлүүлнэ. Төслийн хүрээнд 14.8 сая ам долларын тоног төхөөрөмж (Үүнд: 7000 ширхэг компьютер, сервер, UPS, Diesel генератор, IT&IP төхөөрөмж, агааржуулагч, принтер, сканер болон принтер), 4.1 сая ам.долларын программ хангамж(үүнд: цахим-эмнэлэг програм хангамж, цахим-эмнэлэг цогц загвар, цахим-эмнэлэг програм хангамжийн инженерчлэл, сургалт)-ийн ажлууд хийгдэнэ. Эрүүл мэндийн яамны харьяа эмнэлэг-12, аймгийн нэгдсэн эмнэлэг-21, дүүргийн нэгдсэн эмнэлэг-9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-6 тус тус хамрагдах юм.

11.2.13.10. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх -2 шат” төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,169.6 сая төгрөг

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн оношилгоо, эмчилгээний чадавхыг бүрэн сайжруулснаар эх, эмэгтэйчүүд, хүүхдэд үзүүлж буй гуравдах шатлалын лавлагаа тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна. Төслийн хүрээнд оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж суурилуулах, эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ажилтнуудын чадавхыг сайжруулах, шинэ технологи ашиглахтай холбоотой сургалтуудыг зохион байгуулна.

11.2.13.11. Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	50.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,254.5 сая төгрөг

Өрх сумын эрүүл мэндийн төв лабораторийг сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, анхан шатны түргэн

тусламж үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой.

11.2.14. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

11.2.14.1. Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэл, нэмэлт санхүүжилт төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	4.5 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,193.8 сая төгрөг

Дархан-Уул аймгийн төв Дархан сумыг дулааны эрчим хүчээр найдвартай хангах, өсөн нэмэгдэж буй цахилгаан дулааны эрчим хүчний хэрэглээг хангахад оршино. Төслийн хүрээнд үйлдвэрлэгдэж нийлүүлэгдсэн үндсэн тоног төхөөрөмжүүдийг (ПТ-35/39-3,4/1,0 маркийн уурын турбин, Т-35-2У3 маркийн турбогенератор) угсарч суурилуулах, туршиж тохируулах, ажилд залгах, дутуу хийгдсэн барилга угсралтын ажлуудыг дуусгах, шинээр эргэлтийн усны шугам хоолой татах, цахилгаан хуваарилах байгууламж өргөтгөх, шинээр цахилгаан болон механик тоног төхөөрөмжүүдийг худалдан авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

11.2.14.2. Эрчим хүчний системийн үр ашиг төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	850.0 сая төгрөг

Эрчим хүчний үр ашгийг дэмжих замаар эрчим хүчний үйлдвэрлэл ба хэрэглээг эдийн засаг, экологийн хувьд тогтворжуулж, эрчим хүчний найдвартай хангамжийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм. Төслийн хүрээнд холбогдох хууль, дүрэм журмуудыг боловсруулах, шаардлагатай программ хангамж, мэдээллийн баазаар холбогдох байгууллагуудыг хангах зорилт тавин ажиллаж байна.

11.2.14.3. Улаанбаатар хотын Дөрөвдүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл, MON-P10 /JICA/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар - ЯОУХААБ
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	4.0 тэрбум иен
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	18,909.0 сая төгрөг

Эрчим хүч, дулаан үйлдвэрлэхэд шаардагдах нүүрс, дизель түлшний хэмжээг тодорхой түвшинд хэмнэх нөхцөлийг бүрдүүлэх, IV цахилгаан станцын дулааны болон эрчим хүчний үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, тулгамдаж буй эрчим хүчний дутагдлыг багасгах, иргэд болон аж ахуйн нэгжүүдийг тогтвортой, найдвартай эрчим хүчээр хангахад чухал хувь нэмэр оруулахад төслийн зорилго оршино.

11.2.14.4. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл

Санхүүжилтийн нийт хэмжээ	40.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	87.6 сая төгрөг

Монгол улсын Баруун бүсийн эрчим хүчний системд 25МВт нар, салхины эх үүсвэрийг суурилуулж алслагдсан бүс нутагт сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний зохицуулалтын хүрээнд боловсон хүчний чадамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан их чадлын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт оруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд оршино.

11.2.14.5. Дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл /ХБНГУ/ Дархан

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,048.5 сая төгрөг

Дархан хотыг дулааны эрчим хүчээр найдвартай тасралгүй хангах, өсөн нэмэгдэж буй дулааны эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор Дулааны цахилгаан станцад шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэхэд оршино. Энэхүү төсөл хэрэгжсэнээр Дархан хотын дулааны эрчим хүчний эх үүсвэр 25 жилийн хугацаанд найдвартай ажиллах юм.

11.2.14.6. Эрчим хүчний дамжуулах сүлжээний үр ашгийг дээшлүүлэх (дэд станцууд) /ХБНГУ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.4 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,189.1 сая төгрөг

Төвийн эрчим хүчний системийн 1960-1970 онд суурилуулсан 110, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцад суурилагдсан тоног төхөөрөмж, тоноглолыг шинэчилж төвийн эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах, алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх юм.

11.2.14.7. Сэргээгдэх эрчим хүчний төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,876.4 сая төгрөг

Төслийн зорилго нь Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжлийг эрчимжүүлэх, нэн ялангуяа сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрчим хүчний үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулахад оршино.

11.2.14.8. Эрчим хүчний салбарын төсөл - 2

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	30.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,455.9 сая төгрөг

Төслийн зорилго нь Монгол Улсын цахилгаан, эрчим хүчний үйлчилгээний найдвартай, тогтвортой байдлыг сайжруулна. Төсөл нь 3 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд эрчим хүчний түгээлтийн сүлжээг шинэчлэх, 10 МВт-ийн нарны эрчим хүчний эх үүсвэрийг байгуулах, эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхэд оршино.

11.2.14.9. 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	130.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг гадаад зээл, 1,289.7 сая төгрөг гадаад тусламж

Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говь Сүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв, Сүхбаатар аймгуудын төвийн дулааны станцтай төвлөрсөн дулаан хангамжийн системд шилжүүлэх, техник, технологийн шинэчлэлт хийх, оршин суугчдыг найдвартай халаалт, хэрэглээний халуун усаар тогтмол хангах, ая тухтай, эрүүл орчныг бүрдүүлэхэд оршино.

11.2.14.9. Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	113.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	78,811.4 сая төгрөг гадаад зээл

Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын овортой 2 хэлхээт 260 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 220 кВ-ын дэд станц барих бөгөөд төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсын нийгэм, эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулах томоохон ашигт малтмалын орд газрууд болох Тавантолгой, Оюутолгой болон Цагаансуваргын цахилгаан эрчим хүчний үе шатны хэрэглээг төвийн эрчим хүчний системээс найдвартай хангах, мөн Тавантолгой цахилгаан станц ашиглалтад ороход 2 талын эх үүсвэртэй бүс хоорондыг холбосон чухал ач холбогдолтой цахилгаан дамжуулах агаарын шугамыг бий болгох юм.

11.2.14.10. Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	49.2 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,000.0 сая төгрөг гадаад зээл

Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөж, эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахад оршино. Төслийн хүрээнд СС-50 турбогенератор шинээр суурилуулж, хими ус цэвэрлэгээний тоног төхөөрөмжийг шинэчилж, эсрэг осмосын технологид шилжүүлэх, сүлжээний групп бойлер шинээр суурилуулах, хөргөх цамхаг шинээр барих, 3 км агаарын шугам, ил, далд хуваарилах байгууламж, трансформатор, цахилгаан удирдлага, хамгаалалт, автоматик болон тоног, төхөөрөмжүүдийн хамт суурилуулна.

11.2.15. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР

11.2.15.1. Цахим сургалт төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	800.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	300.2 сая төгрөг

Прокурорын ерөнхий газрын нийт албан хаагчдад зориулсан сургалтын анги танхим, аудио хичээлийн тоног төхөөрөмжөөр хангахад төслийн зорилго оршино.

11.2.16. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

11.2.16.1. Үндэсний аудитын газрын чадавх бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	380.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	87.6 сая төгрөг

Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэж байгаа санхүүгийн аудитын арга зүй, стандартад үнэлгээ хийлгэх, төрийн аудитын ажилтнуудын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр боловсруулах болон хувийн аудитын компанитай гэрээлэх, тэдгээрт хяналтыг сайжруулах замаар төрийн аудитын чадавхыг бэхжүүлнэ.

11.2.17. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

11.2.17.1. Үндэсний статистикийн хорооны чадавхыг бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	480.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	24.4 сая төгрөг

Үндэсний статистик мэдээлэл тархалтын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Үндэсний статистикийн хороо, нэн ялангуяа орон нутгийн статистикийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх замаар үндэсний хэмжээний тоо, мэдээллийн чанарыг сайжруулах, улмаар олон улсын статистикийн стандарт, аргачлалыг нэвтрүүлж, үндэсний статистикийн хорооны чадавхыг бэхжүүлэхэд оршино.

11.2.18. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

11.2.18.1. Усны шугам сүлжээг шуудуу ухалгүйгээр сэргээн засварлах технологи нэвтрүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	12,172.4 сая төгрөг

Улаанбаатар хотын цэвэр, бохир усны шугам сүлжээ нь 1950-аад оноос эхлэн ашиглалтад орж 30-50 жилийн насжилттай учир хуучирч, их хэмжээний зэврэл үүссэн

ундны усны шугам сүлжээг дэлхийн олон оронд дэлгэрсэн бага зардлаар ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг сэргээн сайжруулах шинэ технологийг нэвтрүүлэх замаар шугам хоолойн насжилтыг уртасгах, шугам сүлжээнд гарах урсгал зардлын хэмжээг бууруулах, энэ чиглэлийн мэргэжлийн нэгж бий болгох, шинэ төрлийн мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх юм.

Зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Ус хангамжийн шугам сүлжээг шуудуу ухалгүйгээр сэргээн сайжруулах технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай иж бүрэн тоног төхөөрөмж, нийт 44 км шугам хоолой доторлох түүхий эд материал, технологи дамжуулах, мэргэжилтэн бэлтгэх сургалт зэргийг авах юм.

11.2.18.2. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	29.7 сая ам.доллар, 19.8 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,100.0 сая төгрөг гадаад зээл, 159.1 сая төгрөг тусламж

Улаанбаатар хотын босоо тэнхлэгийн дагуу 7.7 км замыг сайжруулах, Энхтайваны гүүрний өргөтгөлийн ажил, босоо тэнхлэгийн дагуу тусгай замын автобусны 14 км шугамын барилгын ажил, цахилгаан тээврийн хэрэгслийн 14 км замын дэд бүтцийг сайжруулах ажил, автобусны байршил тогтоох удирдлагын системийг нэвтрүүлэхэд оршино.

11.2.18.3. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	27.5 сая ам.доллар, 14.5 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,150.0 сая төгрөг гадаад зээл, 1,379.4 сая төгрөг тусламж

Улаанбаатар хотын хөрс агаарын бохирдлын үндсэн эх үүсвэрийг бий болгож буй хотын хойд хэсэгт байрлах Баянхошуу, Сэлбэ, 7 буудлыг сонгон авч инженерийн дэд бүтцээр бүрэн хангагдсан, амьдралын таатай орчныг бүрдүүлэх хотын дэд төвүүдийг бүтээн байгуулахад оршино.

11.2.18.4. Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,426.1 сая төгрөг

Төслийн зүгээс агаарын бохирдлыг бууруулах богино болон дунд хугацааны арга хэмжээг хэрэгжүүлж, боловсруулахад дараах гурван чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (а) гэр хорооллын орчинд нарийн ширхэгт тоосонцрын агууламжийг бууруулахын тулд сайжруулсан зуухны хөтөлбөр хэрэгжүүлэх; (б) Улаанбаатар хотын төвийн бүсэд нарийн ширхэгт тоосонцрын агууламжийг багасгах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх болон тэргүүлэх ач холбогдол бүхий бодлогын зөвлөмжүүд боловсруулах; (в) Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах зэрэг болно.

11.2.18.5. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл /Европын хөрөнгө оруулалтын банк/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Европын хөрөнгө оруулалтын банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	50.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,096.9 сая төгрөг

Улаанбаатар хотын хөрс агаарын бохирдлын үндсэн эх үүсвэрийг бий болгож буй хотын хойд хэсэгт байрлах Баянхошуу, Сэлбэ, 7 буудлыг сонгон авч инженерийн дэд бүтцээр бүрэн хангагдсан, амьдралын таатай орчныг бүрдүүлэх хотын дэд төвүүдийг бүтээн байгуулахад оршино. Азийн хөгжлийн банктай хамтарсан санхүүжилтийн хэлбэрээр хийгдэж байна.

11.2.18.6. Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	42.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	19,687.5 сая төгрөг

Улаанбаатар хотыг хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөж, замын хөдөлгөөний ачааллыг бууруулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахад оршино.

11.2.18.7. Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	30.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	21,197.3 сая төгрөг

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага баримт бичигт тусгагдсаны дагуу хөдөлгөөний эрчмийг сайжруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, олон улсын норм дүрэм, стандартад нийцүүлэн төлөвлөх, иргэдийг ая тухтай саадгүй зорчуулах, хотыг өнгө үзэмжтэй болгох, түгжрэлийг багасгах, хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд гол зорилготой.

11.2.18.8. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах, гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр–2 дугаар үе шат

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	37.1 сая ам.доллар, 21.6 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг

Олон шатлалт санхүүжилтийн хэрэгслийн 2 дугаар үе шатны хүрээнд: (i) хотын хойд хэсэг болох Дамбадаржаа болон Дэнжийн 1000 орчмын гэр хорооллыг дахин төлөвлөж, хотын дэд бүтцийг сайжруулан тэлж, 1 дүгээр үе шатанд хамрагдсан Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдэд нэмэлт хөрөнгө оруулалт хийх; (ii) нийгэм-эдийн засгийн байгууламжийн хүрэлцээг нэмэгдүүлэх; (iii) институцийг бэхжүүлэх болон чадавхыг бий болгох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

11.2.18.9. Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууц ба дахин төлөвлөлтийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	80.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	52.5 сая төгрөг

Төлбөрийн чадварт нийцсэн, байгаль орчинд ээлтэй орон сууцыг барих, гэр хорооллыг дахин төлөвлөх хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг бий болгох, ингэснээр агаар болон хөрсний бохирдлыг бууруулж, гэр хорооллын иргэдийн амьдрах орчныг сайжруулна. Мөн, хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, ажлын байрыг бий болгоно.

11.2.18.10. Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	125.1 сая төгрөг

Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах замаар иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хөрсний бохирдлыг багасгах зорилготой.

11.2.18.11. Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	36.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	19,065.1 сая төгрөг

Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэл хийх төслийн хүрээнд өмнө 1960-1970 онд баригдсан ашиглалтын хугацаа 50-с дээш жил болсон авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх, техник ашиглалтын түвшинг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бий болгоход төслийн зорилго оршино.

11.2.18.12. Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	21.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	5,295.7 сая төгрөг

Төслийн хүрээнд Улаанбаатар хотод шинээр баригдаж буй замын зорчих хэсэгтэй нийцүүлэн замын хөдөлгөөний шинэ урсгалыг бий болгох, дэд бүтцийг байгуулах зорилгоор гүүр барихад оршино.

Туул гол дээр шинээр барих Баянзүрхийн 288 у/м гүүрний бүтээн байгуулалтын хүрээнд Гачууртын уулзвараас Налайх, Чойрын уулзвар хүртэлх авто замын урсгал бүрийг

2 эгнээ болгон өргөтгөж, техник ашиглалтын түвшнийг нэмэгдүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, Гачууртын уулзвараас Баянзүрхийн товчоо хүртэлх замд нэг урсгалын 3 км авто замыг шинээр төлөвлөх юм. Мөн Туул гол дээр шинээр барих Сонсголонгийн 289.4 у/м гүүрний бүтээн байгуулалтын хүрээнд тус гүүртэй холбогдож буй авто замын гүүрний зорчих хэсгийг авто замын зорчих хэсэгтэй уялдуулан өргөтгөж, шинэчлэхээр ажил хийгдэж байна.

11.2.19. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

11.2.18.1. Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.4 сая ам.доллар, 6.2 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,200.0 сая төгрөг

Дархан хотын бохир усны менежмент сайжирч, бохир ус цэвэрлэх төв байгууламж (ТЦБ), ариутгах татуурга болон насосны станцын үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Мөн төслөөр Дарханы ус сувгийн байгууллагын удирдлагын чадавхыг бэхжүүлнэ.

12. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

12.1. Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2018-2020 оны төсөөллийн талаар

Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцааг 2016 оны төсвийн жилд 88.0 хувиас, 2017 оны төсвийн жилд 85.0 хувиас, 2018 оны төсвийн жилд 80.0 хувиас, 2019 оны төсвийн жилд 75.0 хувиас, 2020 оны төсвийн жилд 70.0 хувиас, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан. Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2018-2020 оны төсөөлөл дараах байдалтай байна.

Хүснэгт № 307. Төсвийн тусгай шаардлагын тооцоолол /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2016.12.31	2017 ХБГ	2018 төс	2019 төс	2020 төс
I. Засгийн газрын дотоод өр	6,464.9	5,369.3	5,418.9	5,441.2	4,855.2
1.1 Үнэт цаас	5,488.8	4,402.6	4,112.7	4,235.2	4,072.2
1.2 Концесс	668.9	966.7	1,306.2	1,206.0	783.0
II. Засгийн газрын гадаад өр	12,363.8	17,693.1	19,703.7	22,537.3	23,969.7
2.1 Үнэт цаас	5,380.5	8,565.6	7,149.2	7,444.0	7,772.4
2.2 Зээл	6,983.3	9,127.4	12,554.5	15,093.3	16,197.3
III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг	3,451.5	1,852.5	1,703.0	1,325.6	1,278.1
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,852.5	1,703.0	1,325.6	1,278.1
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	22,280.1	24,914.8	26,825.6	29,304.1	30,103.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	18,861.0	20,513.9	23,471.9	25,243.0	25,977.3
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	88.0%	85.0%	80.0%	75.0%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ - ХБГ	78.8%	74.8%	77.4%	74.1%	68.9%

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22,280.1 тэрбум төгрөг байгаа ба өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 78.8 хувьтай тэнцэж байгаа нь хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангаж байна.

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг тухайн жилийн нэрлэсэн ДНБ-д харьцуулсан харьцаа 2017 онд 74.8 хувь, 2018 онд 77.4 хувь, 2019 онд 74.1 хувь, 2020 онд 68.9 хувьд тус тус хүрэх төсөөлөлтэй байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагад тусгагдсан үзүүлэлтүүд нь тайлант хугацааны эцсийн төгрөгтэй харьцах гадаад валютын албан ханш, оны үнээр илэрхийлсэн ДНБ-ний хэмжээ, Засгийн газрын шинээр хийх зээллэг, зээллэгийн эргэн төлөлт болон өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч өөрчлөгдөх магадлалтай.

Засгийн газрын зээллэгийн хүү, гэрээнд заасан бусад шимтгэл хураамжийн төлбөрт 2017 оны батлагдсан төсвийн тодотголын хүрээнд 1,201.8 тэрбум төгрөг төлөгдөхөөр батлагдсан бол 2018 онд 1,280.7 тэрбум төгрөг төлөгдөх тооцоололтой байна.

Хүснэгт № 308. Засгийн газрын зээллэгийн үйлчилгээний төлбөрийн тооцоолол /тэрбум төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2017 тод 1	2018 төсөл
Засгийн газрын зээллэгийн үйлчилгээний төлбөр		1,201.8	1,280.7
1	Засгийн газрын гадаад зээллэгийн үйлчилгээний төлбөр	593.1	750.6
2	Засгийн газрын дотоод зээллэгийн үйлчилгээний төлбөр	608.7	530.1

Засгийн газрын богино хугацаат дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн хүүгийн хувь оны эхнээс 6-6.3 хувиар, дунд хугацаат үнэт цаасны анхдагч зах зээлийн хүүгийн хувь оны эхнээс 2.9-4.3 хувиар буурснаас шалтгаалан 2018 онд төлөгдөх дотоод үнэт цаасны хүү буурч 530.1 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөхөөр байна.

Засгийн газар 2017-2018 онд ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хоёр болон олон талт зээлдүүлэгчид (гадаад орон, олон улсын банк санхүүгийн байгууллага)-ээс төсвийн дэмжлэг хэлбэрээр 1.2 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, төслийн зээлийн хэлбэрээр 0,8 тэрбум ам.доллар, нийт 2.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг авч ашиглахаар байгаа бөгөөд мөн гадаад үнэт цаасны дахин санхүүжилтийн хүрээнд шинээр гадаад үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа зэргээс шалтгаалан гадаад зээллэгийн хүүгийн төлбөрт 750.6 тэрбум төгрөг төлөгдөхөөр байна.

12.1.1.Засгийн газрын өрийн удирдлагын хүрээнд авч хэрэгжүүлэх арга ХЭМЖЭЭ

Засгийн газраас дунд хугацаанд өрийн удирдлагын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Олон Улсын Валютын Сантай хамтарч хэрэгжүүлэх Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд бусад гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас хөнгөлөлттэй нөхцөлтэй төслийн болон хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийг түлхүү авч ашиглах, тэрхүү хэмжээгээр төсвийн алдагдлыг санхүүжүүлэх;
- Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүй болох, гадаад валютын нөөц багассанаас үүдэн төгрөгийн ханшийн огцом унах зэрэг эрсдэлүүдээс сэргийлэн Засгийн газрын гадаад үнэт цаасыг эргэн төлөгдөх хугацаанаас өмнө дахин санхүүжүүлэх;
- Дотоодын болон олон улсын зах зээлд гаргах үнэт цаасны арилжааг тогтмолжуулах замаар үнэт цаасны жишиг хүүгийн түвшинг тогтоох, тогтсон өгөөжийн муруйг бий болгох;
- Хөрөнгө оруулагч нарт тогтмол мэдээлэл хүргэж, хоорондын харилцааг идэвхжүүлэх замаар шинээр хийх зээллэгийн хүүгийн түвшинг бууруулан,

тогтвортой түвшинд барих, хөрөнгө оруулагчдын талаар мэдээллийн санг бүрдүүлэх;

- Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн шийдвэрийн дагуу Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулах;
- Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудыг мэдээллээр тогтмол хангаж, нягт хамтран ажиллах.

12.2. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээл

12.2.1. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл

Монгол Улсын Засгийн газар 1990-2017 оны хооронд түнш орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас нийт 1.5 тэрбум ам.долларын зээлийг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудад дамжуулан зээлдүүлснээс 2017 оны эхний хагас жилийн байдлаар дамжуулан зээлийн үлдэгдэл 0.8 тэрбум ам доллар буюу 1,729.8 тэрбум төгрөг байна. Үүнээс:

- Төрийн өмчит байгууллагуудад 75.3 хувь буюу 1,302.7 тэрбум төгрөг;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад 24.7 хувь буюу 426.9 тэрбум төгрөгийг тус тус олгосон.

Нийт дамжуулан зээлдүүлсэн зээлийг салбараар авч үзвэл 28.1 хувийг эрчим хүчний салбарт, 22.1 хувийг зам тээвэр, 15.3 хувийг орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт зээлдүүлсэн бол 21.2 хувийг санхүү, эдийн засаг, хөдөө аж ахуй, харилцаа холбоо, жижиг дунд үйлдвэрийн салбарт олгосон зээлийн үлдэгдэл, үлдсэн 13.3 хувийг гэрээ хэлцэлгүй, баримт материалын бүрдэл дутуу, зээлдэгч байгууллагын балансад бүртгэлгүйн улмаас найдваргүй авлагаар бүртгэгдсэн зээлүүд тус тус эзэлж байна.

12.2.2. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн 2018 оны эргэн төлөлтийн төлөвлөгөө

Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөд 2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр төсөвт 25.05 тэрбум төгрөгийг төвлөрүүлснээс үндсэн төлбөрт 17.95 тэрбум, хүүгийн төлбөрт 7.11 тэрбум төгрөг төлөгдсөн байна.

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүрээнд 2018 онд үндсэн төлбөрт 26.6 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 8.7 тэрбум төгрөг, нийт 35.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд зээлийн эргэн төлөлтийг салбараар авч үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт № 309. Дамжуулан зээлийн 2018 оны эргэн төлөлтийн төлөвлөгөө /тэрбум төгрөг/

	2018
Үндсэн төлбөр	26.56
Зам, тээврийн салбар	8.55
Санхүү, эдийн засгийн салбар	3.17
Харилцаа холбооны салбар	1.73
Хөдөө аж ахуйн салбар	0.18
Эрчим хүчний салбар	12.92
Хүүгийн төлбөр	8.77
Зам, тээврийн салбар	1.11
ОСНААҮ-ий салбар	0.43
Санхүү, эдийн засгийн салбар	0.23
Харилцаа холбооны салбар	1.81
Эрчим хүчний салбар	5.18
Нийт төлбөр	35.33

12.2.3.Эргэн төлөлтийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Эрчим хүч, банк, санхүүгийн салбарын эргэн төлөлтийг 2018 онд бүрэн төвлөрүүлэхээр тооцож, төлөвлөсөн бөгөөд эргэн төлөлт хангалттай хийгддэггүй бусад салбарын зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Төрийн өмчит болон төсөвт байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт олгосон зээл

Эргэн төлөлт хийгдэхгүй байгаа зам тээвэр, орон сууц, нийтийн аж ахуй, харилцаа холбооны салбарын зээлүүдийн хувьд:

- Эх үүсвэрийг тухайн байгууллагын төсөвт тусгах;
- Буцаан төлөлтийг хуваарийн дагуу хийлгэж, төлөвлөгөөг таслахгүйн үүднээс улсын төсвөөс олгох хөрөнгө оруулалт болгон шилжүүлэх боломж, арга замыг судалж, шийдвэрлэх,
- Төсөвт болон төрийн өмчит зарим байгууллагын төрийн сан, арилжааны банкны орлогын данснаас боломжит нөхцөлийг судалсны үндсэн дээр дамжуулан зээлдүүлсэн зээлийн өрийг суутган авах,
- Шаардлагатай тохиолдолд арилжааны банктай хамтын ажиллагааны гэрээ байгуулах, харилцан суутгал хийх замаар өр төлбөрийг барагдуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөж байна.

12.3. Засгийн газрын өрийн баталгаа

Өрийн удирдлагын тухай хуулийн 33.1-т Засгийн газар нь Хөгжлийн банк, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд, бусад дотоодын хөрөнгө оруулалт бүхий Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хийх зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болно гэж заасан. Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 02 дугаар сард батлагдахаас өмнө 2.7 их наяд төгрөгийн Засгийн газрын баталгаа буюу Монгол Улсын Хөгжлийн банкны дунд

хугацааны евро бонд, Самурай бонд, Кредит Свисс банкнаас авсан зээл, БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авсан зээл, МИАТ ХК-ийн агаарын хөлгийн зээлүүдэд гадаад талд, дотооддоо Багануур ХК-ийн баталгааг гаргасан. Мөн Засгийн газрын зүгээс 2016 онд Монгол Улсын Хөгжлийн банкны ОХУ-ын ВТБ банкнаас авсан зээллэг, Эрдэнэс Монгол ХХК-ий Азийн хөгжлийн банкнаас авах зээллэг болон Алт хөтөлбөрийн хүрээнд дотоодын компаниудад тус тус баталгаа гаргасан байна. Үүнд:

1. Хөгжлийн банкны дунд хугацааны евро бонд - Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7.1.4, 14.1, 16.2, 22.1.4, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.4, Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 6.3, “Зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2011 оны 14 дүгээр тогтоол, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргах тухай” Засгийн газрын 2011 оны 85 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 322 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 580.0 сая ам.долларын, жилийн 5.75 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, Засгийн газрын баталгаатай үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдөр олон улсын зах зээлд арилжаалсан. Бондын хугацаа 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдөр дуусгавар болсон бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банк бондын үндсэн төлбөрийг төлөх эх үүсвэргүй байсан тул Засгийн газрын зүгээс 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр олон улсын зах зээлд 600.0 сая ам.долларын бондыг гаргаж, Монгол Улсын хөгжлийн банкны гаргасан 580.0 сая ам.долларын евробондыг дахин санхүүжүүлсэн.

2. Самурай бонд - Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7.1.4, 14.1, 16.2, 22.1.4, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Хөгжлийн банкны 30.0 тэрбум иентэй тэнцэх хэмжээний 10 жилийн хугацаатай “Самурай” үнэт цаасыг Япон Улсын зах зээлд Японы хамтын ажиллагааны банкны баталгаатайгаар (JBIC) жилийн 1.52 хувийн хүүтэйгээр арилжаалсан. Хөрөнгө оруулагчидтай хийсэн бонд арилжаалах гэрээний дагуу үйл ажиллагааны зардал, шимтгэлийг хассан дүнгээр “Самурай” бондын эх үүсвэр 24.3 тэрбум иен 2014 оны 1 дүгээр сард Хөгжлийн банкны холбогдох дансанд шилжин орж ирсэн.

3. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл - БНХАУ-ын Хөгжлийн банк, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хоёр банкны хамтын ажиллагааг эрчимжүүлэх, БНХАУ-ын оролцоотой хэрэгжиж буй төслүүдийг санхүүжүүлэхэд хамтран ажиллах зорилготойгоор Засгийн газрын 2014 оны 116 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авах 162.0 сая ам.долларын зээлийн гэрээнд Монгол Улсын Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн хугацаа нь 8 жил, зээлийн хүү нь жилийн тогтмол 6 хувийн хүүтэй, зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс чөлөөлөх хугацаа 3 жил болно.

4. Кредит свисс банкны зээл - Засгийн газрын 2014 оны 117 дугаар тогтоолын дагуу Хөгжлийн банканд хямд эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор Кредит свисс банкнаас 300.0 сая ам.долларын зээл авахаар Засгийн газрын нэрийн өмнөөс Сангийн яам зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт баталгаа гаргасан. Энэхүү зээл нь 7 жилийн хугацаатай ба эхний 2 жилд үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс чөлөөлөгдөж, 2 жил 6 сарын дараа хагас жил тутам тэнцүү дүнгээр (30.0 сая ам.доллар) зээлийн үндсэн төлбөрийг төлнө. Ингэснээр зээлийн үндсэн хугацаа болох 4 жил 6 сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг төлөх үүргийг хүлээж байгаа болно. Зээлийн хүү 4.375% + 6 сарын LIBOR.

5. Боинг нисэх онгоц худалдан авах зээл - Засгийн газрын 2013 оны 319 дүгээр тогтоолын дагуу МИАТ /ТӨХК/-ийн Боинг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авахад зориулан нийт 121.4 сая ам.долларын баталгааг Монгол Улсын Засгийн газраас гаргасан бөгөөд дараах 3 дэд зээлд хуваагдсан болно. Үүнд: АНУ-ын Экспорт-Импорт банканд 77.4 сая ам.долларын зээлийн үндсэн дүнтэй, хүү нь жилийн тогтмол 2.52, 10 жилийн хугацаатай зээлд, ING CAPITAL LLC банканд 23.9 сая ам.долларын зээлийн үндсэн дүнтэй, хүү нь 5.3%+3 сарын LIBOR, 7 жилийн хугацаатай зээлд, ING CAPITAL LLC банканд 5 жилийн хугацаатай 20.0 сая ам.долларын, хүү нь 9.38+3 сарын LIBOR-той зээлд тус тус Засгийн газрын баталгаа гаргасан. Түүнчлэн, агаарын хөлөг худалдан авахад зориулж Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банкны хооронд 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан 136 2/538 дугаартай Батлан даалтын гэрээ, 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдөр өөрчлөлт оруулсан 14 тоот нэмэлт, өөрчлөлтийн гэрээний дагуу Сангийн яам, МИАТ /ТӨХК/-ийн өмнөөс зээлийн төлбөрийг батлан даасан.

6. ОХУ-аас авах газрын тосны бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх худалдааны зээлийн шугамд гаргах Засгийн газрын өрийн баталгаа - Засгийн газрын 2015 оны 93 дугаар тогтоолын дагуу ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүн импортлоход шаардагдах гадаад валютын урсгалыг тэнцвэржүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ) нь ОХУ-ын ВТБ банктай 300.0 сая ам.долларын 36 сарын хугацаатай зээлийн гэрээг Засгийн газрын баталгаатайгаар 2016 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан. Уг зээлийн гэрээний дагуу зээлийн шугамын эхний хэсэгчилсэн санхүүжилт 3 сарын Libor+5,75 хүүтэй, 65,430,000.0 ам.долларыг МУХБ авсан бөгөөд зээлийн баталгааны хугацаа 2016 оны 12 сарын 01-ний өдөр дуусгавар болсон.

7. Алт худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн арга хэмжээнд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа - УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний тухай хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, бодит салбарын хөгжлийг дэмжих, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алт худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн тогтолцоог оновчтой бүрдүүлэх арга хэмжээ авч, уг арга хэмжээний хүрээнд алт олборлох үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 256.0 тэрбум хүртэлх төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкаар дамжуулан 14 сарын хугацаатайгаар санхүүжүүлэх, дээрх эх үүсвэрийн 128 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилтэд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Энэ арга хэмжээний хүрээнд Засгийн газрын баталгаа гаргуулахаар 6 компани хүсэлт ирүүлснээр 2.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Алт худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн арга хэмжээ 2016 оны 12 дугаар сард дуусгавар

болох нөхцөлтэй байсан бөгөөд арга хэмжээ дуусахад Засгийн газрын гаргасан баталгаа дуусгавар болох тул он дамжих үлдэгдэл байхгүй, зээлийн эргэн төлөлт 2016 оны 12 дугаар сард төлөгдөж дуусгавар болсон.

8. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкнаас авах 35.0 сая ам.долларын, 12 жилийн хугацаатай техник туслалцааны зээлд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа

Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх нийт 42.0 сая ам.долларын санхүүжилттэй төслийн зээлийн 85 хувьд буюу Азийн хөгжлийн банкнаас авах 35.0 сая ам.долларын, 15 жилийн хугацаатай, LIBOR хүүтэй техник туслалцааны зээлд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолын хүрээнд Сангийн яам болон Азийн хөгжлийн банк хооронд “Засгийн газрын өрийн баталгааны гэрээ”-г 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулж Засгийн газрын өрийн баталгааг гаргасан. Энэхүү зээл нь эхний 3 жилд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс чөлөөлөгдөх ба 4 дэх жилээс буюу 2019 оны 09 дүгээр сарын 15-аас эхлэн зээлийн үндсэн төлбөрийг төлж эхлэх юм.

9. “Багануур” ХК-д гаргасан Засгийн газрын баталгаа - Эрчим хүчний тухай хуулийн 5.1.4, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1-д заасныг үндэслэн “Багануур” ХК-д техникийн шинэчлэл хийж үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах, 2012-2013 оны өвлийн их ачааллын үед дулааны цахилгаан станцуудад нүүрсний нөөц бүрдүүлэх зорилгоор тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах 18.6 тэрбум төгрөгийн зээлийн хөрөнгийг Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлж, Засгийн газрын баталгаа гаргасан болно. Төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй энэхүү зээлийн хүү нь жилийн 9.6 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай юм. Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Багануур” ХК-д олгосон дээрх зээлийн эх үүсвэр нь Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны дунд хугацааны евро бонд тул энэхүү дунд хугацааны евро бондод гаргасан Засгийн газрын баталгаа дотор хамрагдаж, өрийн үлдэгдэлд тооцогдож байгаа болно.

10. Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан бондод гаргасан Засгийн газрын өрийн баталгаа - Засгийн газрын 2015 оны 163 дугаар тогтоолын дагуу Худалдаа хөгжлийн банк Глобал үнэт цаасны хөтөлбөрийн хүрээнд олон улсын зах зээлд Засгийн газрын баталгаатайгаар 500.0 сая ам.долларын бондыг 2015 оны 05 дугаар сарын 13-ны өдөр амжилттай арилжаалсан. Энэ нь 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Өрийн удирдлагын тухай хууль батлагдсаны дараа гаргаж буй Засгийн газрын анхны өрийн баталгаа юм. Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т Баталгаа гаргуулагч нь гадаад зээллэгтэйгээ тэнцүү хэмжээгээр өөрийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасыг барьцаалсан буюу баталгаажуулсан тохиолдолд тухайн зээллэгийн нийт дүнд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болох бөгөөд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг баталгаа гаргуулагч этгээд хариуцахаар баталгааны гэрээнд тусгана гэж заасны дагуу ХХБ 2015 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 1.0 их наяд төгрөгийн нэрлэсэн дүн бүхий Засгийн газрын үнэт цаасыг эзэмшиж баталгаа

гаргуулсан болно. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй гэж заасан тул ХХБ-нд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа нь өрийн хязгаарт тооцогдохгүй болно.

Засгийн газрын баталгааны хязгаарыг өрийн удирдлагын зохицуулалтын үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын баталгаатай эх үүсвэрийн боломжит хэсгийг дахин хөрөнгөжүүлэх, хувийн хэвшлийн хийх зээллэгт нь дэмжлэг үзүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор баталгаа гаргуулагчид холбогдох журам, аргачлалд заасны дагуу эрсдэлийн үнэлгээ хийсний дүнд Засгийн газрын өрийн баталгааг гаргана.

13. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Монгол Улсын 2018 нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2017 оноос 680.9 тэрбум төгрөгөөр өсөж 7,218.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 580.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 9,828.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн нийт алдагдал 2,610.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -8.6 хувь болж 2017 оноос 100.7 тэрбум төгрөгөөр сайжрахаар байна.

Хүснэгт № 310. Монгол улсын 2017-2018 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

	2017			2018	Зөрүү
	Төл	Тод 1	Тод 2	Төсөл	
	.1.	.2.	.3.	.4.	.4-3.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	6,390.2	6,511.3	7,112.9	7,808.5	695.6
Тогтворжуулалтын сан	8.4	208.8	242.4	64.8	-177.6
Ирээдүйн өв сан	221.7	266.8	333.3	525.7	192.3
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,160.2	6,035.7	6,537.1	7,218.0	680.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,569.1	8,750.2	9,248.6	9,828.8	580.2
Урсгал зардал	6,948.0	6,843.7	6,948.8	7,457.8	509.0
Хөрөнгийн зардал	1,483.9	1,579.8	1,887.8	2,102.3	214.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	137.2	326.7	411.9	268.6	-143.3
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	-2,408.7	-2,714.4	-2,711.5	-2,610.8	100.7
ДНБ-д эзлэх хувь	-9.1%	-10.4%	-9.9%	-8.6%	1.3%
ДНБ	26,494.5	26,052.0	27,438.0	30,341.0	2,903.0

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9 дүгээр хэсгийн дагуу Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь ДНБ-ий -9.5 хувиас хэтрэх ёсгүй. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь 2017 оны тодотголоор ДНБ-ий -9.9 хувь байгаа бол 2018 онд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь ДНБ-ий -8.6 хувь болж төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагаас ДНБ-ий 0.9 хувь, 2017 оны төсвийн тодотголоос ДНБ-ий 1.3 хувиар сайжруулж ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах нөхцөлийг бүрэн хангаж байгаа болно.

14. ТӨСВИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дагалдах хуулиудын жагсаалт

- 1. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**
- 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**
- 3. МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН
ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**
- 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**
- 5. ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

o O o

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй.

1/ 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалт:

“6.2.6.Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа тодорхой төсөл хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх.”

2/ 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3, 9.4 дэх хэсэг:

“9.2.Энэ хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тухайн жилийн төсвийн төсөл, түүний тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон бусад хууль тогтоомжийн төслийн төсөвт нөлөөлөх байдалд хараат бус, бие даасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дэргэд ажиллах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2, Засгийн газрын 2, Монгол банкны 2, хараат бус, бие даасан 3 гишүүний төлөөллийг оролцуулна.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан зөвлөл нь гаргасан зөвлөмжөө тухай бүр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

9.4.Энэ хуулийн 9.2-т заасан зөвлөлийн дүрэм, зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, гишүүдийг томилох журмыг Төсвийн байнгын хороо батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.11, 25.12 дахь хэсэг нэмсүгэй:

“25.11.Байнгын хороо, дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед нам, эвслийн бүлэг, гишүүдийн гаргасан санал нь Төсвийн тухай хуулийн 6.2.6 дахь заалтад нийцсэн байна.

25.12.Хоёр дахь хэлэлцүүлгийн үед нам, эвслийн бүлэг, гишүүд, Ерөнхийлөгч тодорхой төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах саналыг хамтад нь гаргаж нэг саналын томьёолол болгон санал хураалт явуулна.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн “25.11, 25.12, 25.13, 25.14, 25.15, 25.16, 25.17” дахь хэсгийн дугаарыг “25.13, 25.14, 25.15, 25.16, 25.17, 25.18, 25.19” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Хүүхэд хамгааллын тухай,” гэсний дараа “Сургуулийн өмнөх боловсролын тухай, Боловсролын тухай,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын” гэснийг “Боловсролын” гэж, 10 дугаар зүйлийн 10.3. дахь хэсгийн “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн” гэснийг “боловсролын” гэж, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “хүүхэд, гэр бүлийн” гэснийг “боловсролын” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн” гэснийг “боловсролын асуудал хариуцсан” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай 8 дугаар зүйлийн 8.4.4-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх” гэж, 8.4.5-д “Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.4.8-д “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

Эдийн засгийн өсөлт 2017 он гарсаар эрчимжиж, эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрээд байна. Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн орлогыг тодотгох шаардлага үүсч байна. Тухайлбал 2018 онд тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1.0 пунктээр нэмэгдүүлж байгаагаас шалтгаалж, нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй харьцуулахад 20 орчим хувиар нэмэгдэхээр байна. Дараах хүчин зүйлс нь нийгмийн даатгалын сангийн зардлыг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байна:

1/ Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2017-2018 оны гурван талт Улсын хэлэлцээрийн нэмэлт хэлэлцээрийн хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгож буй бүх төрлийн тэтгэврийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхээр төлөвлөсөн;

2/ тэтгэврийн даатгалын сангаас 2018 онд 16.8 орчим мянган хүн шинээр тэтгэвэр тогтоолгож, 9.5 орчим мянган хүний тэтгэвэр зогсож, тэтгэвэр авагчдын цэвэр өсөлт 9.8 мянган хүн болохоор байна.

3/ нийгмийн даатгалын бусад сангуудаас олгох дундаж тэтгэмжийн хэмжээ болон тэтгэмж авагчдын тоо өмнөх онтой харьцуулахад мөн нэмэгдэж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, хоёрдугаар бүлэгт нийгмийн даатгалын санд 2018 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээ болон төсвийн ерөнхийлөн захирагчид зарцуулах төсвийн эрх, хэмжээг, Засгийн газрын урт хугацаат бонд худалдан авах хөрөнгийн дээд хэмжээг тогтоох тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2018 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

ОУВС-ын Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд дунд хугацаанд их хэмжээний зардал шаардагдах буюу төсвийн зорилтод үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх үр дагавар бүхий зарим хуулийг хүчингүй болгох хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулна. Үүнд Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтууд хамаарч байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,689,430.7
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	625,314.8
	1.2 Ажиллагсдаас төлөх шимтгэл	619,435.1
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	178,501.3
	1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	54.1
	1.5 Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	67,723.8
	1.6 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	66,870.7
	1.7 Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	27,600.1
	1.8 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	3,109.0
	1.9 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	948.7
	1.10 Бусад орлого	99,873.1
2	Сангийн сайд	531,202.3
	2.1 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	531,202.3
Нийт орлого		2,220,633.0

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	1,575,031.7
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	102,426.0
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	31,697.9
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	35,433.0
	1.5 Эрүүл мэндийн даатгалын сан	337,279.1
	1.6 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр	117.6
	1.7 Үйл ажиллагааны урсгал зардал	19,457.7
Нийт зарлага		2,101,443.1

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат / нэг жил болон түүнээс дээш/ бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 220,000.0 сая төгрөгөөр баталсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны орлогыг 1,689.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2017 оны тодотголтой харьцуулахад 276.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Тус сангаас 2018 онд тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд давхардсан тоогоор 4.5 сая иргэдэд нийт 2,101.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 209.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулах зорилгоор 2018 онд дараах зохицуулалтыг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар ажил олгогч болон даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг аажмаар буюу 3 жилийн хугацаанд тус бүр 2.5 пунктээр, нийт 5.0 пунктээр нэмэгдүүлэхээр баталсан. Хууль хэрэгжиж эхлэх эхний жил буюу 2018 онд тэтгэврийн даатгалын шимтгэл ажил олгогч, даатгуулагч тус бүр 1 хувиар нэмэгдэж байгаа тул Нийгмийн даатгалын сангийн орлогыг 123.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцов.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт гарах насыг жилд 6 сараар нэмэгдүүлэх шийдвэр гарсан. Энэ дагуу 2018 оноос эхлэн эрэгтэйчүүд 60 нас 6 сараар эмэгтэйчүүд 55 нас 6 сартайдаа тэтгэвэрт гарах эрх үүсэх бөгөөд даатгуулагч өөрөө хүсвэл 60 настайдаа тэтгэвэрт гарах эрхтэй болж байна. Ингэснээр шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо нийт 8,958 хүнээр багасаж, үүний үр дүнд тэтгэврийн даатгалын сангийн ачаалал 34.6 тэрбум төгрөгөөр буурч байна.

3. Тэтгэврийн даатгалын зарим параметрийг өөрчилсөнтэй холбоотойгоор тэтгэврийн сангийн алдагдал буурч байна. Иймээс нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 2017 оны түвшнээс 56.1 тэрбум төгрөгөөр бууруулж нийт 531.2 тэрбум төгрөг байхаар тооцсон. Үүнээс төр хариуцах буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 202.6 тэрбум төгрөг, цэргийн тэтгэвэрт 107.9 тэрбум төгрөг, тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд 220.6 тэрбум төгрөг улсын төсвөөс олгохоор тооцов.

4. Тэтгэврийн даатгалын сан алдагдалтай байгааг харгалзан нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны зардлыг ашигтай байгаа тэтгэмж, ҮОМШӨ, ажилгүйдэл, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тооцов.

Хүснэгт № 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016 Гүйц	2017 Бат	2017 Тод	2018 Төс
САНГУУДЫН ОРЛОГО	1,315.0	1,390.8	1,412.6	1,689.4
1 Шимтгэлийн орлого	1,240.7	1,340.4	1,341.9	1,589.6
2 Бусад орлого	74.4	50.4	70.7	99.9
САНГУУДЫН ЗАРЛАГА	1,720.6	1,887.4	1,891.8	2,101.4


1. Тэтгэврийн даатгалын сан	1,305.3	1,404.4	1,404.4	1,575.0
2. Тэтгэмжийн даатгалын сан	92.4	109.2	109.2	102.4
3. ҮОМШӨ-ний даатгалын сан	29.4	31.5	31.5	31.7
4. Ажилгүйдлийн даатгалын сан	31.6	29.7	29.7	35.4
5. Эрүүл мэндийн даатгалын сан	238.9	293.1	297.4	337.3
6. Бусад зарлага	3.2	0.1	0.2	0.2
7. Ажиллагааны зардал	19.8	19.4	19.4	19.4
САНГУУДЫН НИЙТ ТЭНЦЭЛ:	-88.9	-90.7	-108.1	-153.2
<i>Улсын төсвөөс олгох татаас</i>	<i>494.9</i>	<i>587.3</i>	<i>587.3</i>	<i>531.2</i>

Ирэх онд Тэтгэврийн даатгалын сан 565.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин Тэтгэмжийн даатгалын сан, ҮОМШӨ-ний даатгалын сан, Ажилгүйдлийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан нийлээд 153.2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, нийт тэнцэл 412.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар байна. Нийт алдагдал 2017 оны тодотголоос 67.0 тэрбум төгрөгөөр буурч байна.

1.1.Нийгмийн даатгалын сангийн орлого

Ирэх 2018 онд 48.9 мянган аж ахуйн нэгж байгууллагын 820.8 мянга гаруй ажиллагч албан журмын даатгалд хамрагдахаар байгаа нь 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 10.7 мянгаар нэмэгдэхээр байна. Харин сайн дурын даатгалд даатгуулж албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа 320.0 гаруй мянган иргэдийн 74.3 хувь буюу 237.7 орчим мянган хүн хамрагдахаар тооцов. Мөн эдийн засаг идэвхжиж байгааг харгалзан 2.5 мянган аж ахуйн нэгж шинээр нийгмийн даатгалд хамрагдахаар тооцсон нь 2017 оноос 5.4 хувиар нэмэгдэж байна.

График № 1. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын тоо



Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх боломжит эх үүсвэрүүд, эдийн засгийн өсөлт, даатгуулагчдын тоо болон цалин хөлс, орлогын өсөлтийг нэмэгдүүлснээр 2018 онд нийгмийн даатгалын 5 төрлийн санд шимтгэлийн орлогоос 1,589.6 тэрбум төгрөг, хадгаламж болон үнэт цаасны хүүгийн орлогоос 99.9 тэрбум төгрөг, улсын төсвөөс олгох санхүүжилт 531.2 тэрбум төгрөг байхаар тооцов.

Тэтгэврийн даатгалын шимтгэл 2018 онд ажил олгогч, даатгуулагч тус бүр 8.0 хувь, 2019 онд 8.5 хувь, 2020 онд 9.5 хувь, сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн

даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 2018 онд 11.0 хувиас, 2019 онд 11.5 хувиас, 2020 онд 12.5 хувиас багагүй байхаар хуулиар тогтоосон. Үүнтэй холбоотойгоор тэтгэврийн даатгалын сангийн орлого ирэх онд 123.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

Хүснэгт № 2. НДШ-ийн хувь хэмжээний өөрчлөлт

Үзүүлэлт	Одоо мөрдөгдөж байгаа хувь хэмжээ			2018 он +2.0%			Нэмэгдэх хувь /тухайн жилд/
	Даатгуулагч	Ажил олгогч	Нийт	Даатгуулагч	Ажил олгогч	Нийт	
Тэтгэвэр	7.0	7.0	14.0	8.0	8.0	16.0	2.0
Тэтгэмж	0.8	1.0	1.8	0.8	1.0	1.8	-
Ажилгүйдэл	0.2	0.2	0.4	0.2	0.2	0.4	-
Эрүүл мэнд	2.0	2.0	4.0	2.0	2.0	4.0	-
ҮОМШӨ		0.8-2.8	0.8-2.8		0.8-2.8	0.8-2.8	
Нийт дүн	10.0	11-13	21-23	11.0	12-14	23-25	2.0

Өмнөх жилүүдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшнийг харгалзан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, төр шимтгэлийг хариуцан төлөх иргэдийн шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /240000 төг/-ний 2.0 хувиар буюу жилийн 57600 төгрөгөөр, оюутан суралцагчдын шимтгэлийн хэмжээг мөн хөлсний 1.0 хувиар буюу жилийн 28800 төгрөгөөр тус тус тооцож нийт 26.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнийг тодорхойлох босго оноог 360.1783 оноогоор шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 260.4 мянган хүний ЭМД-ын шимтгэлийг төрөөс нэмж хариуцахаар болсон нь ЭМД-ын сангийн орлогыг 9.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 2017 онд 57.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд Төв банкны үнэт цаас худалдан авсан. 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр бонд, үнэт цаасны хүүгийн орлогоос 4.4 тэрбум төгрөг, сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн хүүгийн орлогоос 67.1 тэрбум төгрөг тус тус НДС-д төвлөрөхөөр байна.

Хүснэгт № 3. Сангийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулсны болон үнэт цаасны арилжаанаас орсон орлогын тооцоо /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2015 он				2016 он				2017 он ХБГ				2018 он				
	ЗГ-	ЫН	Бонд	Банк	ЗГ-	ЫН	Бонд	Банк	ЗГ-	ЫН	Бонд	Банк	ЗГ-	ЫН	Бонд	Банк	
Байршуулах хөрөнгө	140				57				57				57				740
Хүүгийн орлого	10.8				4.4				4.4				67.1				83.2

Хадгаламж, бондын хүүгийн орлогоор 2018 онд 99.9 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2017 оноос 29.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Хүүгийн орлого нэмэгдсэн шалтгаан нь Нийгмийн даатгалын сангийн хуримтлалаас арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 200.0 тэрбумаар нэмэгдүүлж 740.0 тэрбум төгрөг болсонтой холбоотой байна.

1.2.Нийгмийн даатгалын сангийн зарлага

Хүснэгт № 4. Нийгмийн даатгалын сангийн зардал /тэрбум төгрөг/


Зориулалт арга хэмжээгээр	2016 гүйц	2017 год	2018 төсөл
НИЙТ ДҮН	1,720.3	1,891.8	2,101.4
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	18.2	18.2	18.2
80205 Мэдээлэл, сургалчилгааны зардал	0.0	0.0	0.0
80213 Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	0.0	0.0	0.0
80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	0.7	0.7	0.7
80229 Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	0.1	0.1	0.1
80312 Сургалт семинар	0.0	0.1	0.1
80407 ЭМД-ын сангаас санхүүжих эмийн үнийн хөнгөлөлт	27.3	41.4	47.5
80505 ЭМД-ын сангаас улсын эмнэлгүүдэд өгөх шилжүүлэг	170.9	186.3	214.5
80512 ЭМД-ын хувийн эмнэлгүүдэд өгөх шилжүүлэг	40.3	68.0	75.0
80601 Өндөр насны тэтгэвэр	973.7	1,055.9	1,182.4
80602 Тахир дутуугийн тэтгэвэр	174.8	185.6	211.8
80603 Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	57.5	58.0	63.3
80604 Цэргийн тэтгэвэр	97.8	103.8	116.5
80605 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	12.8	16.7	17.2
80606 Оршуулгын тэтгэмж	11.1	13.4	13.4
80607 Жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж	68.4	79.0	71.7
80608 ҮО мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж	27.8	28.3	28.5
80609 Ажилгүйдлийн тэтгэмж	31.6	29.6	35.3
80610 НДШ-ийн илүү төлөлтийн буцаан олголт	1.2	1.2	1.2
80613 ҮОМШӨ-ний эмчилгээ сувилгаа	1.1	2.1	2.1
80614 ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	0.4	1.1	1.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг	0.4	0.6	0.2
80806 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.7	0.6	0.4
80812 Бүтцийн өөрчлөлтийн тэтгэмж	-	-	-
80813 Албан хаагчид олгох нөхөн олговор	0.1	0.1	0.1
80820 Бусад тусламж, дэмжлэг	0.1	0.1	0.1
Санхүүжүүлэх эх үүсвэрээр	1,720.3	1,891.8	2,101.4
31 Улсын төсвөөс санхүүжих	494.9	587.3	531.2
33 Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,225.3	1,304.4	1,570.2
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.1	0.1	0.1
Орон тоо	1526	1526	1526
Хөтөлбөрт хамаарах төсвийн захирагчид	1,720.3	1,891.8	2,101.4
00389 Нийгмийн даатгалын сан	1,462.2	1,574.9	1,744.7
00407 ЭМНДЕГ-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	13.6	13.6	13.6
08571 Эмийн сан, хувийн эмнэлгүүд	67.6	109.6	122.8
09746 Эрүүл мэндийн даатгалын сан	170.9	184.0	214.5
09968 ЭМНДЕГ-Мэдээлэл тооцоолол сургалтын төв	0.7	0.7	0.7
09969 ЭМНДЕГ-Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	0.2	0.2	0.2
ЭМНДХэлтсүүд	5.1	5.1	4.9

1.2.1. Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэврийн даатгалын сангийн зардлын 75.1 хувийг өндөр насны тэтгэвэр, 13.4 хувийг тахир дутуугийн тэтгэвэр, 4 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 7.4 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.


Тэтгэврийн даатгалын сангаас 2018 онд өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр авагч нийт 398.2 мянган хүний тэтгэвэрт 1,574.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 170.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлыг 1,575.1 тэрбум төгрөгөөр, орлогыг 1,009.8 тэрбум төгрөгөөр тооцов.

График № 2.Тэтгэврийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 292 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн илтгэлцүүрийг шинэчлэн баталсан бөгөөд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 230.0 мянган төгрөгөөс 251.0 мянган төгрөгт хүрч 109.1 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 195.0 мянган төгрөгөөс 216.0 мянган төгрөгт хүрч 110.8 хувиар тус тус нэмэгдсэн байна.

График № 3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ, төгрөг



Ирэх онд эрэгтэй болон эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэрт гарах насыг тус тус жилд 6 сараар нэмэгдүүлснээр 8,958 хүний тэтгэвэрт гарах нас хойшлох

бөгөөд тэтгэврийн сангийн зардлын ачаалал 34.7 тэрбум төгрөгөөр буурч байна. Түүнчлэн хуульд орсон өөрчлөлтийн дагуу даатгуулагч өөрөө хүсвэл 60 настайдаа тэтгэвэрт гарах боломжтой болсон бөгөөд харин шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 20 жил дээр жил бүр 3 сар нэмж байхаар заасан. Одоогоор шимтгэл төлсөн дундаж хугацаа 30 жил байгаа нь нас нэмэгдүүлсэн арга хэмжээ эрэгтэйчүүдэд бага нөлөөлөхөөр байна. Тухайлбал тэтгэвэрт гарах нас нь хойшилсон 8.958 хүний 600 гаруй нь эрэгтэйчүүд байна.

Хүснэгт № 5. Тэтгэврийн нас нэмэгдсэнээр өөрчлөгдөх тэтгэвэр авагчдын тоо

Үзүүлэлт	2018 он			
	Хүн амын тоо /хэтийн тооцоогоор/	Шинээр тэтгэвэр тогтоолгох /хуучин хуулиар эр 60, эм 55 нас/	Тэтгэврийн насыг нэмэгдүүлснээр хойшлох иргэдийн тоо	Тэтгэврийн насыг нэмэгдүүлснээр шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо
Эрэгтэй /60 нас/	10,158	8,954	620	8,334
Эмэгтэй /55 нас/	16,176	9,071	4,536	4,536
Эмэгтэй /50 нас, 4 дээш хүүхэдтэй/	18,520	4,319	2,160	2,160
Нөхцөлөөр		3,285	1,643	1,643
Нийт өндөр насны	44,854	25,629	8,958	16,672

Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар 2018 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч байгаа эрэгтэй (60 нас) 10.2 мянга, эмэгтэй (55 нас) 16.2 мянган хүн байна. Тэтгэврийн даатгалын сангаас 2018 онд тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлснээр 16.5 орчим мянган хүн шинээр тэтгэвэр тогтоолгож, 9.5 орчим мянган хүний тэтгэвэр зогсоогдон өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагчдын нийт цэвэр өсөлт 9.8 мянган хүн болохоор байна.

Тэтгэвэр авагчдын тооны өөрчлөлт, дундаж тэтгэврийн хэмжээ, өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн 2018 оны тэтгэвэрт зарцуулах хөрөнгийг 1,574.0 тэрбум төгрөг байхаар тооцсон нь 2017 онтой харьцуулахад 12.2 хувиар буюу 170.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Тэтгэврийн даатгалын сангийн зарлага хүний тооны өсөлт, дундаж тэтгэврийн өсөлтөөс шалтгаалж 53.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.


Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Улсын хэлэлцээр (2017-2018 он)-ийн хүрээнд хийж байгаа нэмэлт хэлэлцээрээр Нийгмийн даатгалын сангаас олгож буй бүх төрлийн тэтгэврийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд 119.5 тэрбум төгрөг улсын төсвөөс нэмж шаардагдана.

Хүснэгт № 6. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол

Тэтгэврийн төрөл	Хамрагдах хүн /мян. хүн/	Дундаж тэтгэвэр /мян.төг/		Нэмж шаардагдах /тэрбум төг/
		2017 онд	2018 онд	
НИЙТ	402.8	818.1	883.5	119.5
1 Нийгмийн даатгалын тэтгэвэр	385.6	295.1	318.7	111.0
1.1 -Өндөр насны тэтгэвэр	290.7	314.0	339.1	88.6
1.2 -Тахир дутуугийн тэтгэвэр	74.3	233.0	251.6	17.5
1.3 -Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	20.6	243.0	262.4	4.9

2	Цэргийн алба хаасны тэтгэвэр	17.2	523.0	564.8	8.5
---	------------------------------	------	-------	-------	-----

График № 4. Тэтгэвэр авагчдын тоо



Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн албан хаагчийн тэтгэврийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд 2018 онд нийт 17.2 мянган иргэд цэргийн тэтгэвэр авахаар тооцсон нь өмнөх оноос 257 иргэнээр нэмэгдэхээр байна. Түүнчлэн, 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн зардлыг төрөөс хариуцдаг бөгөөд 2018 онд нийт тэтгэвэр авагчдын 15.1 орчим хувь нь буюу 61.5 мянган иргэд байгаа ба эдгээр иргэдийн тоо жилд дунджаар 3.2 мянган хүнээр буурч байна.


Ирэх 2018 онд тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаасны хэмжээг 531.2 тэрбум төгрөгөөр, үүнээс цэргийн болон 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт 310.5 тэрбум төгрөг, тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний эх үүсвэр 117.5 тэрбум төгрөг, улсын төсвөөс нийгмийн даатгалын сангийн алдагдалд өгөх татаасны хэмжээг 103.2 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.

Хүснэгт № 6. Улсын төсөв, НДС-ийн өглөг, авлагын талаар /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	2006-2013	2014	2015	2016	2017	2018
1. Оны эхний өглөг, авлага С1	-262.0	-82.1	-111.7	-128.3	34.9	291.3
2. Улсын төсвийн татаас	-	253.3	292.6	494.9	587.3	531.2
Үүнээс:	-					
2.1. Цэргийн тэтгэвэр	-	80.3	91.2	100.0	103.8	107.9
2.2. 1995 оноос өмнөх	-	202.6	218.0	231.8	227.0	202.6
2.3. НДС-н алдагдалд	-	-29.6	-16.6	163.1	256.5	220.6
3. Улсын төсвийн өглөг, авлага С2	-82.09	-111.7	-128.3	34.9	291.3	511.9

Тэтгэврийн даатгалын сангийн цаашдын чиг хандлага: Хэдийгээр нийгмийн даатгалын хамралт жил тутам өсөж, 2016 оны эцсийн байдлаар 1.0 сая орчим даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдаж, тэтгэврийн даатгалын сангийн орлого жил бүр нэмэгдэж байгаа боловч хүн амын насжилт, нийт хүн амд ахмад настны эзлэх хувийн жингийн өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн зардал хурдацтайгаар нэмэгдэж байна.

Тэтгэврийн тогтолцоо хэвээр байсан бол алдагдал ДНБ-ны 10-16 хувьд хүрэх байсан.




Эх сурвалж: Дэлхийн банкны PROST загвараар хийсэн тооцоолол

Дэлхийн хүн амын дундаж наслалт 1950 оноос хойш 1990-ээд оныг эс тооцвол арван жил тутамд 3-аас дээш жилээр нэмэгдэж байна. Манай орны хувьд 2016 оны байдлаар төрөлтөөс тооцсон дундаж наслалт эмэгтэйчүүд 75.1, эрэгтэйчүүдийнх 65.58 болсон байна. Монгол улсад эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 9.52 жилээр илүү байна.¹

Статистик судалгаанаас үзэхэд Монгол улсын хүн амын тоо сүүлийн 10 жилд 16.1 хувиар өссөн бол мөн хугацаанд ахмад настны тоо 21.9 хувиар буюу илүү хурдацтай өссөн байна. Нийт хүн амд ахмад настны эзлэх хувийн жин 8.6 байгаа бол 2040 онд энэ үзүүлэлт 20 орчим хувьд хүрэхээр байна. Түүнчлэн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2013 онд 4 хүн, 2020 он гэхэд 5 хүн, 2040 онд 8 хүн болох урьдчилсан тооцоололтой байна.

График № 5. Монгол Улсын нийт хүн амд 65 ба түүнээс дээш настай иргэдийн эзлэх хувь, хэмжээ




Эх сурвалж: НУБ-ийн Хүн ам зүйн хэлтэс.

Дэлхийн банкны 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн “Төсвийн зарлагын дүн шинжилгээ” тайланд Монгол Улсын нийт хүн амд эзлэх ахмад настны тоо нэмэгдэхийн

¹ Эрүүл мэндийн үзүүлэлт 2016 /Эрүүл мэндийн хөгжлийн төв, ДЭМБ/

хэрээр тэтгэврийн даатгалын сангийн алдагдал жил бүр нэмэгдэж уг санд улсын төсвөөс олгох татаасны хэмжээ 2016 онд ДНБ-ний 2.0 хувь байсан бол 2030 онд ДНБ-ний 6.0 хувьд, 2050 онд 11.0 хувьд хүрэхээр байна. Энэ нь 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлогын талтай тэнцэх хэмжээтэй байна. Дээрх нөхцөл байдлын улмаас ОУВСангийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн өөрчлөлтийн дагуу тэтгэврийн даатгалын санд олгох татаасны хэмжээ 2030 онд ДНБ-ний 2.0 хувьд хүргэх зорилттой байна. Гэвч эдгээр өөрчлөлт нь сангийн урт хугацаанд тогтвортой байх байдлыг хангахад хангалтгүй тул цаашид параметрийн өөрчлөлтүүдийг нэмж хийх шаардлагатай байна.

График № 6. Монгол Улсын хүн амын тооны төсөөлөл /насны бүлгээр, мян хүн/



Эх сурвалж: НУБ-ийн Хүн амын сангийн тооцоолол-2016 он

1.2.2. Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын санд 2018 онд 113.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 103.9 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсэн, амаржсан эхийн болон оршуулгын тэтгэмжид зарцуулахаар байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хөлсний 50-75 хувиар олгодог бол жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийг 4 сарын хугацаагаар хөдөлмөрийн хөлсний 100 хувиар (сайн дурын даатгуулагчид 70 хувь) олгож байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолд нэг даатгуулагчид олгох оршуулгын тэтгэмжийг 1.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу олгож байна.

Хүснэгт № 7. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мян хүн, тэрбум төгрөг/

Тэтгэмж	2017 оны ХБГ		2018 он төсөл		Өөрчлөлт	
	Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн
1 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	116.1	16.7	117.2	17.2	1.2	0.5
2 Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	61.0	71.7	61.0	71.7	0.0	0.0
3 Оршуулгын тэтгэмж	13.4	13.4	13.4	13.4	0.0	0.0
Нийт дүн	190.5	101.9	191.7	102.4	1.2	0.5

Нийгмийн даатгалын сангийн урд жилүүдийн гүйцэтгэл, холбогдох мэдээлэлд үндэслэн хийсэн тооцоо, судалгаанаас үзэхэд тэтгэмжийн даатгалын сан 2015 онд 8.3 тэрбум, 2016 онд 7.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан боловч 2017 онд тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2 пунктээр нэмэгдүүлснээр 2017 оны ХБГ 1.1

тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж сангийн үйл ажиллагаа тогтворжиж 2018 онд 10.0 тэрбум төгрөгийн ашигтай байх тооцоо гарч байна.

1.2.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин (ҮОМШӨ)-ий даатгалын сан

ҮОМШӨ-ний даатгалын санд 2018 онд 140.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сувиллын хувьсах зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон иргэдийн шимтгэлийн зардалд 45.9 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

Тус сангаас тахир дутуу, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 4.8 мянган иргэнд 26.6 тэрбум төгрөг, тэтгэвэр авагчдын банкны үйлчилгээний хөлсөнд 6.0 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.0 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 1.1 тэрбум төгрөгөөр тус тус зарцуулахаар тооцсон.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийн зардал тэтгэвэр авагчдын тоо буурснаас шалтгаалан өнгөрсөн оноос 839.1 сая төгрөгөөр буурч байна.

1.2.4. Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 2018 онд 37.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж ажилгүйдлийн тэтгэмж болон мэргэжил олгох давтан сургалтын зардалд 35.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Уг сангаас 2018 онд ажилгүйдлийн тэтгэмж авах 25.1 мянган иргэнд 35.3 тэрбум төгрөг, мэргэжил олгох давтан сургалтын зардалд /Улсын хэмжээнд мэргэжил олгох сургалт, дамжаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, сургалтын төвүүдийн нэг хүний сургалтын төлбөрийг үндэслэсэн/ 96.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2017 оны төсвөөс 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Зардал нэмэгдсэн гол шалтгаан нь нийгмийн даатгалын сангийн санхүүгийн жилийн эцсийн тайлан, сарын мэдээ, эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн санал, судалгаанаас үзэхэд ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжид 2017 онд 29.6 тэрбум төгрөг зарцуулахаас эхний 6 сарын байдлаар 63.5 хувийг зарцуулаад байна.

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, байдалтай холбоотойгоор ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 2015 онд 18.7 мянга байсан бол 2016 онд 23.2 мянгад хүрсэн, 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24.3 мянгад хүрэх төлөвтэй байна. Иймд ажилгүйдлийн тэтгэмжийн зардлыг 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тусгасан.

1.2.5. Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 2018 онд 388.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2017 оны тодотголтой харьцуулахад 42.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2018 оны төсвийн төслийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн 1,113 эрүүл мэндийн байгууллага, эмийн сан (улсын төв, тусгай мэргэжлийн төв, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв зэрэг 51 эмнэлэг; хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 5; орон нутгийн уламжлалт анагаах ухааны төв 6; сум дундын 35 эмнэлэг; хувийн хэвшлийн 181 эмнэлэг; рашаан сувилал 52; эмийн сан 783)-гийн даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээг худалдан авахаар тооцон 340.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2017 оны тодотголоос 39.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын өмчийн эмнэлэгт олгох зардлын төсвийн төслийн талаар:

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны “Төлбөрийн хэмжээ, жагсаалт, өртгийн жин, журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор баталсан хувьсах зардлын хэмжээ, оношны бүлэг, өртгийн жин, эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлт зэргийг үндэслэн төрийн өмчийн эмнэлгүүдээс худалдан авах тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг 2018 онд 214.5 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2017 оны тодотголоос 28.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаад дараах хүчин зүйлс нөлөөлж байна.

а) Төрийн өмчийн эмнэлгийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний зардал:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1 дэх хэсгийн дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг олгож байна. 2018 онд 180.2 тэрбум төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь 2017 оны төсвөөс 16.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Төрийн өмчийн эмнэлгүүдийн ачаалал ихсэж уртасгасан цагаар ажиллах, тоног төхөөрөмж нэмэгдэх, ор болон өргөтгөл байшин барилга ашиглалтад орохтой холбоотой зардлууд нэмэгдсэн. Зардлыг тооцохдоо урд оны гүйцэтгэл, төрийн өмчийн эмнэлгүүд болон ЭМНДХэлтсээс ирсэн тооцоо судалгааг үндэслэн боловсруулсан.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Улсын хэмжээнд 2018-2019 онд ашиглах эмнэлгийн болон сувиллын орны дээд хязгаарыг батлах тухай” А/234 тушаалаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын ор болон хүчин чадал нь нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт мөн нэмэгдэж байна.

б) Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн зардал:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8-дахь хэсэгт зааснаар даатгуулагчдад үзүүлэх өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлж байна. Хуульд заасны дагуу Эрүүл мэнд спортын сайд Сангийн сайд, Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын “Журам жагсаалт батлах тухай” 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 248/161/А88 тоот хамтарсан тушаалаар жагсаалт, журмыг баталсан. Энэхүү хамтарсан тушаалаар анх 107 нэр төрлийн хэрэгслийг даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлдэг байсныг 2016 оны 3 дугаар сарын 26-ны Нийгмийн

даатгалын үндэсний зөвлөлийн "Жагсаалт, журам батлах тухай" 07 дугаар тогтоолоор 2016 оны батлагдсан төсвийн хүрээнд 484 нэр төрөл болгон нэмэгдүүлсэн.

2017 оны эхний хагас жилийн байдлаар өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 6 эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэл батлагдсан сарын хуваариас хоёр дахин их гарсан байна.

Иймд өмнөх оны гүйцэтгэл, энэ оны ХБГ-д үндэслэн уг зардлыг 2018 онд 34.3 тэрбум төгрөг тооцож төлөвлөсөн нь 2017 оны батлагдсан төсвөөс 11.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн сан, хувийн хэвшлийн эмнэлэгт олгох зардлын төсвийн төслийн талаар:

а) Рашаан, сувилалд олгох эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийн талаар:

Рашаан сувиллуудад олгох нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний зардлын төсвийн төслийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/234 тушаал, нийгмийн даатгалын байгууллагын сонгон шалгаруулалтад тэнцсэн 50 рашаан сувиллын даатгуулагчдад үзүүлэх нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний зардлын 2018 оны төсвийг 12.7 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн нь 2017 оны тодотголоос 1.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Зардал нэмэгдсэн гол шалтгаан нь рашаан сувиллын орны тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

б) Хувийн хэвшлийн эмнэлэгт олгох эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төслийн талаар:

1. Сонгон шалгаруулалтад тэнцсэн хувийн хэвшлийн 5742 ор бүхий 182 эмнэлгийн даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/234 дугаар тушаалаар баталсан орны тоог үндэслэн 2018 онд 249.3 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд 42.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон.

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх хэсэгт “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ”-г эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцна гэж заасан. Иймд 2018 онд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 5.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2-т “Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах...”, 3.1.3-т “Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлнэ”, 3.3.20-д “Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний салбарт төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшруулан...” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн сүүлийн 5 жилийн судалгаанаас авч үзэхэд амьсгалын, хоол боловсруулах, шээс бэлгийн, зүрх судасны тогтолцооны мөн гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэг нь хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан болж байна. Мөн зүрх судас, гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэг, хоол боловсруулах, амьсгалын тогтолцооны болон хавдрын өвчлөл нь хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд орж байгаа судалгаа гарч байна.

Иймд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлолт хугацаанд дээрх 5 төрлөөр хамруулахаар 2018 онд 249.3 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд 10.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

Мөн Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд элэгний С вирусийг илрүүлэх оношилгоо, шинжилгээний лабораторид 2018 онд 19.5 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд 4.9 тэрбум төгрөг зарцуулахаар тооцов.

Хүснэгт № 8. ЭМДСангаас олгох Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн зардал /тэрбум төгрөг/

Д/д	Элэг бүтэн Монгол хөтөлбөр	2016	2017		2018
		Бат	Тод	ХБГ	Төсөл
1	Элэгний С вирусийн эмийн үнийн хөнгөлөлт	18.4	18.4	18.4	18.4
2	Элэгний С вирусийг илрүүлэх оношилгоо, шинжилгээ	4.9	4.9	8.7	4.9
НИЙТ ДҮН		23.4	23.4	27.1	23.4

в) Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийн төслийн талаар:

Эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийг боловсруулахдаа эрүүл мэндийн даатгалтай гэрээ бүхий эмийн сангуудаас 2018 оны төсвийн төслийн санал мөн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс эмийн сангийн саналыг авч боловсруулсан. Эмийн сангийн төсөв 5-7 хоногийн дотор дуусаж байгаа нь даатгуулагчийн эрэлт хэрэгцээ ихээр нэмэгдэж байгаатай холбоотой байна. Иймд 2018 оны төсвийн төсөлд зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтөд 47.5 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон нь 2017 оны төсвөөс 4.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3-т "Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох "Элэг бүтэн Монгол" хөтөлбөр хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 2017 оны тодотголоос эхлэн элэгний С вирусийн эмийн үнийн хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгож эхэлсэн. Иймд 2018 оны төсөвт нийт 18.4 тэрбум төгрөгийг элэгний С вирусийн эмийн үнийн хөнгөлөлтөд зарцуулахаар тусгав.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр баталсан Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

4. ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	НДС	ОРОН НУТАГ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	25.7	19.1		
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	0.2	0.2		
ИРЭЭДҮЙН ӨВ САН	1.7	1.7		
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	23.8	17.2	7.3	7.9
1. Татварын орлого	20.7	12.7	5.6	3.3
1.1. Орлогын албан татвар	4.6	2.3	0.0	2.3
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	2.3	0.0	0.0	2.3
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	2.3	2.3	0.0	0.0
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	4.8	0.0	5.6	0.0
1.3. Хөрөнгийн албан татвар	0.4	0.0	0.0	0.4
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	5.0	5.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	2.3	2.3	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	1.8	1.8	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	1.9	1.4	0.0	0.6
2. Татварын бус орлого	3.0	4.4	1.8	4.6
2.1. Нийтлэг бус татварын орлого	2.7	2.4	0.0	0.3
2.2. Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	0.4	0.4	0.0	0.0
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1.7	1.8	4.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32.4	25.8	6.9	8.2
А. УРСГАЛ ЗАРЛАГА	24.6	19.5	6.9	6.8
1. Бараа, үйлчилгээний зардал	10.8	6.9	0.1	4.4
1.1. Цалин, хөлс	5.9	3.3	0.0	2.5
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.0	0.3	0.0	0.3
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	4.9	3.3	0.0	1.6
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	4.2	4.2	0.0	0.0
3. Татаас ба урсгал шилжүүлэг	9.6	8.4	6.9	2.4
3.1. Татаас	0.8	2.1	0.2	0.3
3.2. Урсгал шилжүүлэг	8.8	6.3	6.7	2.1
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6.9	5.5	0.0	1.4
1. Барилга байгууламж	3.9	3.6	0.0	0.3
2. Их засвар	0.2	0.2	0.0	0.0
3. Тоног төхөөрөмж	1.2	1.1	0.0	0.0
4. Бусад хөрөнгө	1.5	0.5	0.0	1.0
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.1	0.1	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	0.9	0.8	0.0	0.0
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	0.4	0.4	0.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.5	0.4	0.0	0.0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-8.6	-8.7	0.4	-0.3
ДНБ	30,341,000.0	30,341,000.0	30,341,000.0	30,341,000.0

	2017 Тод 2				Өөрчлөлт				2018 Төсөл				/сая төгрөг/
	Нэгдсэн	Улсын төсөв	НДС	Орон нутаг	Нэгдсэн	Улсын төсөв	НДС	Орон нутаг	Нэгдсэн	Улсын төсөв	НДС	Орон нутаг	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,112,872.2	5,305,390.6			695,586.2	491,848.8			7,808,468.5	5,797,239.4			
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	242,417.9	242,417.9			-177,601.6	-177,601.6			64,816.3	64,816.3			
ИРЭЭДҮЙН ӨВ САН	333,345.1	333,345.1			192,315.3	192,315.3			525,660.4	525,660.4			
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,537,109.3	4,729,627.7	2,038,146.8	2,197,155.3	680,882.6	477,135.1	182,486.2	201,212.6	7,217,991.8	5,206,762.7	2,220,633.0	2,398,367.9	
1. Татварын орлого	5,661,334.0	3,527,622.4	1,467,914.4	885,198.6	633,711.0	329,753.5	221,516.3	109,319.1	6,295,045.0	3,857,375.8	1,689,430.7	994,517.7	
1.1. Орлогын албан татвар	1,330,784.2	728,674.7	0.0	602,109.6	69,669.7	-40,355.0	0.0	110,024.7	1,400,453.9	688,319.7	0.0	712,134.2	
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	602,109.6	0.0	0.0	602,109.6	110,024.7	0.0	0.0	110,024.7	712,134.2	0.0	0.0	712,134.2	
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	728,674.7	728,674.7	0.0	0.0	-40,355.0	-40,355.0	0.0	0.0	688,319.7	688,319.7	0.0	0.0	
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,248,513.0	0.0	1,467,914.4	0.0	194,638.4	0.0	221,516.3	0.0	1,443,151.4	0.0	1,689,430.7	0.0	
1.3. Хөрөнгийн албан татвар	98,617.3	0.0	0.0	98,617.3	12,585.0	0.0	0.0	12,585.0	111,202.3	0.0	0.0	111,202.3	
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,448,504.9	1,448,504.9	0.0	0.0	68,813.5	68,813.5	0.0	0.0	1,517,318.4	1,517,318.4	0.0	0.0	
1.5. Онцгой албан татвар	511,577.7	511,577.7	0.0	0.0	172,737.3	172,737.3	0.0	0.0	684,315.0	684,315.0	0.0	0.0	
1.6. Тусгай зориулалтын орлого	11,941.1	11,941.1	0.0	0.0	116.1	116.1	0.0	0.0	12,057.2	12,057.2	0.0	0.0	
1.7. Гаалийн албан татвар	489,784.0	489,784.0	0.0	0.0	47,122.8	47,122.8	0.0	0.0	536,906.7	536,906.7	0.0	0.0	
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	521,611.7	337,140.0	0.0	184,471.7	68,028.2	81,318.8	0.0	-13,290.6	589,639.9	418,458.8	0.0	171,181.1	
2. Татварын бус орлого	875,775.3	1,202,005.3	570,232.4	1,311,956.7	47,171.6	147,381.6	-39,030.1	91,893.5	922,946.9	1,349,386.9	531,202.3	1,403,850.2	
2.1. Нийтлэг бус татварын орлого	799,687.6	731,645.8	0.0	68,041.8	12,779.7	-10,921.8	0.0	23,701.5	812,467.4	720,724.0	0.0	91,743.3	
2.2. Хөрөнгийн орлого	355.0	0.0	0.0	355.0	124.5	0.0	0.0	124.5	479.5	0.0	0.0	479.5	
2.3. Тусламжийн орлого	75,732.7	74,485.7	0.0	1,247.0	34,267.3	33,850.7	0.0	416.6	110,000.0	108,336.4	0.0	1,663.6	
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	395,873.7	570,232.4	1,242,312.9	0.0	124,452.7	-39,030.1	67,650.8	0.0	520,326.5	531,202.3	1,309,963.8	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	9,248,586.1	7,517,421.0	1,907,082.8	2,251,902.7	580,199.2	324,986.1	194,360.2	240,804.2	9,828,785.2	7,842,407.1	2,101,443.1	2,492,706.9	
А УРСГАЛ ЗАРЛАГА	6,948,808.0	5,613,216.3	1,907,082.8	1,856,329.3	509,016.6	295,360.5	194,360.2	199,247.2	7,457,824.6	5,908,576.8	2,101,443.1	2,055,576.6	
1. Бараа, үйлчилгээний зардал	3,091,194.6	2,004,836.4	20,443.7	1,226,583.1	182,392.3	87,102.7	-1,188.8	114,311.0	3,273,586.9	2,091,939.2	19,254.9	1,340,894.1	
1.1. Цалин, хөлс	1,764,410.9	1,013,156.8	13,630.9	737,623.2	25,789.9	183.9	-71.5	25,677.5	1,790,200.8	1,013,340.7	-13,559.4	763,300.6	
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	78,111.5	1,498.6	81,058.7	0.0	7,124.2	109.5	10,599.0	0.0	85,235.6	1,608.1	91,657.7	
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,326,783.7	913,568.1	5,314.3	407,901.2	156,602.4	79,794.7	-1,226.9	78,034.6	1,483,386.1	993,362.8	4,087.4	485,935.9	
